

олон улсын шилжин сурьшлын байгуулага

**ХУН худалдах гэмт хэргийн хохирогчдод  
үзүүлэх шууд тусlamжийн гарын авлага**



IOM International Organization for Migration

ОУШСБ нь хүмүүнлэг, зохион байгууллattай шилжин суурьшил нь нийгэм болон шилжин суурьшигчдад ашиг тустай гэдэг зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Олон улсын төрийн байгууллагын хувьд ОУШСБ нь бусад ОУ-ын түншүүдтэйгээ: шилжин суурьшлын үйл явцын тулгамдсан хүндрэлүүдийг зохицуулахад туслалцаа үзүүлэх, шилжин суурьшлын асуудлыг ойлгоход нөлөөлөх, шилжин суурьшлаар дамжуулан нийгэм болон эдийн засгийн хөгжлийг дэмжих, мөн түүнчлэн шилжин суурьшигчдын хувь хүний нэр хүндийг хамгаалах болон тэдний сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг.

Энэхүү номын бүлгүүдэд илэрхийлэгдсэн зохиогчийн санаа бодол ОУШСБ-ын зарчим, баримтлал биш болно.

Хэвлүүлэгч: ОУШСБ  
17, route des Morillons  
1211 Geneva 19  
Switzerland  
Tel: + 41 22 717 91 11  
Fax: + 41 22 798 61 50  
E-mail: hq@iom.int  
Internet: <http://www.iom.int>

ISBN 978 92 9068 371 1

© 2007 Олон улсын шилжин суурьшлын байгууллага (ОУШСБ)

Бүх эрх хамгаалагдсан болно. Энэхүү номын аливаа хэсгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулах, хайлтын системд байрлуулах, эсвэл электрон, механик, фото, бичлэг, эсвэл өөр ямар нэгэн хэлбэрээр зохиогчоос урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр тараах ёсгүй.

## Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын ХХГХ-тэй тэмцэх ажилтнуудын мөрдлөгө

Бид цагаачдыг бүх арга хэлбэрээр мөлжихийн эсрэг, ялангуяа ХХГХ-ийн хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцдэг. Бид өөрсдийн эрхэмлэн дээдэлдэг зарчим болоод олон улсын жишиг дээр тулгуурлан бид иргэний нийгмийн болоод төр засгийн байгууллагуудын түншүүийн ур чадварыг бэхжүүлж, тогтвортой үр дүнг хангахын тулд үйл ажиллагааны стандартыг тогтоон дараахь зорилгын төлөө ажиллаж байна.

- ХХГХ-ийн хохирогч болсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид хөвгүүдийг хамгаалах, нийгэмшүүлэх
- Энэ гэмт хэргийн талаарх мэдээлэл, мэдлэг олгох
- ХХГХ-ийн хохирогчдод шударга үнэнээр хандах.

ОЛОН УЛСЫН ШИЛЖИЛТ СУУРЬШЛЫН БАЙГУУЛЛАГА

## Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусlamжийн гарын авлага

АНУ-ын Хүн ам болон дүрвэгсэдийн асуудал эрхэлсэн Хэлтэс, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Хүйсийн тэгш эрхийн төвөөс орчуулан гаргав.



---

IOM International Organization for Migration



unicef

# Гарчиг

	Өмнөх үг	v
Бүлэг 1	Аюулгүйн хамгаалал болон хувийн аюулгүй байдал	1
Бүлэг 2	ХХГХ-ийн хохирогчдыг тодорхойлох	15
Бүлэг 3	Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах болон эргэн нийгэмшихэд туслалцаа үзүүлэх	57
Бүлэг 4	Хамгаалах байрны удирдамж	117
Бүлэг 5	Эрүүл мэнд болон ХХГХ	193
Бүлэг 6	Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах	295
	Хавсралт	333

# Өмнөх үг

## Зорилтууд

ОУШСБ нь 13 жилийн туршид хүн худалдах гэмт хэрэг (ХХГХ)-ийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа явуулж, дэлхийн өнцөг булан бүрт худалдагдсан 14,000 гаруй хохирогчдод туслалцаа үзүүлсэн болно. ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлж буй эсвэл үзүүлэхээр төлөвлөж буй байгууллагууд ялангуяа орон нутгийн ТББ-уудын тоо өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан ОУШСБ нь хуримтлуулсан туршлага болон туулж өнгөрүүлсэн бэрхшээлүүдээс хуваалцахыг хүсэж байна. Тус гарын авлагад тэрхүү туршлагыг системчлэн нэгтгэсэн болно. ОУШСБ нь хохирогч болгон тус бүрдээ онцлог бөгөөд тухай бүрийд өөр өөр туслалцаа үзүүлэх шаардлагатай, өөрсдөө ч тийм хүсэлтэй байдгийг хүлээн зөвшөөрдөг. ХХГХ нь дэлхийн өнцөг булан бүрт өөр хоорондоо харилцан адилгүй байдлаар үйлдэгддэг тул тухайн тохиолдол болгонд тохируулсан уян хатан арга барил шаарддаг. Тийм ч учраас энэхүү гарын авлагаар ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх нэгэн аргачлалыг санал болгож байгаа бус харин ОУШСБ-ын олон жилийн туршид энэ үйл ажиллагаа явуулахдаа суралцан, хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэсэн удирдамж, зөвлөмжийг санал болгож байгаа юм. Хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг бүхий л байгууллагуудад энэхүү гарын авлага тустай байх хэмээн итгэхийн хажуугаар, ялангуяа энэ талын үйл ажиллагаа, туслалцаа үзүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж эхэлж буй байгууллагуудад ОУШСБ-ын туршлагаас хуваалцах нь ашиг тустай гэж найдаж байна.

Энэхүү гарын авлага нь ХХГХ-ийн хохирогчидтой холбоо тогтоохоос эхлээд, дараа дараагийн шат болгоны бүхий л төрлийн туслалцааг хамгийн үр дүнтэй үзүүлэхэд шаардлагатай өргөн хүрээний зөвлөмж, болон удирдамжийг санал болгож байна. Тус гарын авлагад насанд хүрээгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх талаарх асуудлыг оруулсан боловч энэ асуудлаар ажиллах мэргэжилтнууд шаардлагатай нарийвлалыг НҮБ-ын

Хүүхдийн Сангийн ХХГХ-ийн Хохирогч Хүүхдийг Хамгаалах Удирдамж-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

## Гарын авлагын бүтэц

Гарын авлага нь бүхэлдээ уншигдахаар зохиогдсон. Гэхдээ зарим бүлгүүд нь тодорхой асуудлыг шийдвэрлэхэд дангаараа ашиглагдаж болно. Бүх бүлгүүд болон ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ШУУД ТУСЛАМЖ гарын авлагын хавсралтууд нь хоорондоо нарийн уялдаа холбоотой. Энэхүү цогц асуудлыг мэргэжлийн өндөр түвшинд шийдвэрлэхэд мөн цогц байдлаар хандах шаардлагатай. Тус гарын авлагыг бүрэн дүүрэн ашиглахын тулд уншигч бүх хэсгийг сайтар уншин тухайн агуулгын нэгдмэл утгыг сайтар ойлгохыг зөвлө.

Гарын авлага нь доор дурдсан 7 бүлгээс бүрдэнэ. Эдгээр 7 бүлэг нь үйлдлийн шатлалаар дараалсан байгаа билээ. Уншигчдад зөвлөхөд бүлэг тус бүрийг бүрэн эхээр нь системчлэн уншиж сайтар танилцан ойлгох нь зүйтэй. Гэхдээ тодорхой асуудал бүрт түүнийг шийдвэрлэх тодорхой удирдамж шаардлагатай тул бүлгүүдийг холбогдох асуудал тус бүрээр уншин ашиглаж болно.

Бүлэг 1	Аюулгүйн хамгаалал болон хувийн аюулгүй байдал
Бүлэг 2	ХХГХ-ийн хохирогчдыг тодорхойлох
Бүлэг 3	Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах болон эргэн нийгэмшихэд туслалцаа үзүүлэх
Бүлэг 4	Хамгаалах байрны удирдамж
Бүлэг 5	Эрүүл мэнд болон ХХГХ
Бүлэг 6	Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах
Хавсралт I	ХХГХ-т өртсөн хүмүүст халамж үзүүлэх болон ярилцлага хийх ёс зүйн зарчмууд
Хавсралт II	Ярилцлагын асуулгын жагсаалт
Хавсралт III	Нэр томъёоны тайлбар

Бүлгүүдэд тусгагдсан асуудал, гол сэдвүүд:

## **Бүлэг 1 Аюулгүй байдлын хамгаалал болон хувийн аюулгүй байдал**

Энэ бүлэг нь аюулгүй байдлын хамгаалал болон хувийн аюулгүй байдлын гол зарчмуудыг тайлбарлан, эрсдлийн тодорхойлолт, өндөр эрсдлийн тохиолдууд, эрсдлийн зохицуулалт, хувь хүний нууцын хамгаалал, аюулгүй байдлын хамгаалалтын процедурын сайн туршлагауд болон үйлчилгээ хүртэгсэд тэдэнд үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудын аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар өгүүлнэ.

Тус бүлгийн гол агуулга нь ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа, хамгаалал үзүүлэх явцад ажилтнуудад тохиолдож болох эрсдлийг танъж мэдэх, мөн тэрхүү эрсдлийг бууруулах, зохицуулах аюулгүй байдлын үндсэн стандарт, процедуруудыг нэвтрүүлэх, хангах талаар өгүүлнэ.

## **Бүлэг 2 ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох**

Энэхүү бүлэгт байгууллагуудад зориулан ХХГХ болон хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт үйлдлийг хооронд нь ялган танъж мэдэх зааварчилгаа, түүнчлэн ХХГХ-ийн хохирогчийн үүднээс туслалцаа эрж буй хүмүүсийг хохирогчоор тодорхойлон тогтоох аргачлалуудыг дурьдсан байгаа. Хамрах сэдвүүд нь хохирогчоор тогтоох талаарх холбогдох ОУ-ын хууль эрх зүйн стандартууд, тодорхойлон тогтоох процесс, тодорхойлох үзүүлэлтүүд болон тодорхойлолт нарийвчилсан тусгай асуултууд, хохирогчийн хариу хандлага болон түүнтэй харьцах асуудал, нэмэлт баталгаажуулах материалууд болон эцсийн шийдвэр гаргах процесс зэргийг тусгасан.

Бүлгийн гол зорилго нь байгууллагуудад хохирогчдын хэрэгцээг зөвөөр тодорхойлон цаашдын туслалцаа, хамгааллыг шаардлагатай хэмжээнд үзүүлэхийн тулд ХХГХ-ийн хохирогчийг зөв нямбай тодорхойлоход шаардлагатай удирдамжуудыг өгөхөд оршино.

## **Бүлэг 3 Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах ба эргэн нийгэмших туслалцаа үзүүлэх**

Гуравдугаар бүлэгт хохирогчийг өөр байгууллагад үйлчилгээ

авахаар хандуулах болон дэмжих арга хэмжээнээс эхлэн нөхөн сэргээх үйл ажиллагааг амжилттай явуулах бүхий л өргөн хүрээний үйл ажиллагааг хамарч байгаа юм. Хамрах сэдвүүд нь ХХГХ-ийн хохирогчдод тэдний сайн дураараа эх орондоо буцах үйл ажиллагааны бэлтгэл, тухайн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх болон хэрхэн эргэн нийгэмшүүлэх туслалцааг тодорхойлох, төлөвлөх түүнчлэн хэрэгжүүлэх талаар зөвлөнө.

Энэ бүлгийн гол зорилго нь ХХГХ-ийн хохирогчдод тохиолдол кейс болгоныг судалсны үндсэн дээр хэрэгцээг тодорхойлон, хэрхэн хүний жам ёсны эрхэнд тулгуурласан, үр дүнтэй, зүй зохистой туслалцаа, хамгаалал үзүүлэх талаар шаардлагатай нөхцлүүдээр хангах зэрэг асуудлыг дурьсан болно.

#### Бүлэг 4 Хамгаалах байрны удирдамж

Энэхүү бүлэг нь ХХГХ-ийн хохирогчдод зориулсан хамгаалах байр байгуулах, хамгаалах байрны менежмент, ажилтан ажиллуулах талаар болон хамгаалах байранд байрлагчдад туслалцаа, эмчилгээ үзүүлэх процедур, хамгаалах байрны үйлчилгээ болон туслалцааг хэрхэн явуулах талаар дэлгэрэнгүй удирдамж өгөх болно.

Энэ бүлгийн гол зорилго нь аюулгүй хамгаалах байр байгуулах, хамгаалах байрны хүрээнд ХХГХ-ийн хохирогчдод шаардлагатай, үр дүнтэй туслалцаа, хамгааллыг хэрхэн үзүүлэх талаар өгүүлэх юм.

#### Бүлэг 5 Эрүүл мэнд болон ХХГХ

Энэ бүлэгт эрүүл мэнд, хүний эрхийн асуудлууд үүн дотроо гол ухагдахууны ойлголт, ёс зүйн, аюулгүй байдлын зарчмууд, халамж болон эрүүл мэндийн тусгай асуудлууд, анагаахын хуулийн эрүүл мэндийн зүйл заалтууд, эмнэлгийн процедур болон менежмент, эрүүл мэндийн төлөвлөлт болон ажилтнуудын эрүүл мэндийн нарийн асуудлуудыг тал бүрээс нь тусгасан удирдамж болон зөвлөгөөг өгөх болно.

Бүлгийн гол агуулга нь ХХГХ-ийн хохирогчдын хэрэгцээнд тулгуурлан халамж болон эрүүл мэндийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх доод жишигийг боловсруулан тогтооход оршино. Энэ бүлэгт үйлчилгээг хүний эрхэнд тулгуурлан үзүүлэхээс гадна тухайн хүний эх орон, дамжуулагч улс эсвэл хүлээн авагч улсад баримтлах олон нийтийн эрүүл мэндийн бодлогод нийцүүлэхээр тусгасан.

## **Бүлэг 6 Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах нь**

Гарын авлагын сүүлчийн энэхүү бүлэгт ХХГХ-тэй тэмцэхэд хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах тэрхүү нарийн хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй зааварчилгаа, зөвлөгөөг тусгасан. Тус бүлэгт хамтын ажиллагааны үндэслэл, эрсдэл, зохистой байдлын талаар өгүүлэхээс гадна ХХГХ-ийн хохирогчдод хуулиар олгогдох эрх болон боломж, хууль хэрэгжүүлэгчидтэй ойлголцлын Меморандумд гарын үсэг зурах, цагдаагийн хэсгүүдтэй харилцан хамтран ажиллах, техникийн хамтын ажиллагаа болон чадвихижуулах, тагнуулын мэдээллийг хуваалцах болон эрүүгийн процедурын явцад гэрчийг шилжүүлэх зэрэг сэдвүүдийг авч үзнэ.

Бүлгийн гол сэдвүүд (1) ХХГХ-ийн хохирогчдод тэдэнд үйлдэгдсэн гэмт үйлдлийг хуулийн хүрээнд шударга шүүхээр шийдүүлэх боломжуудыг мэдээлж, тэдгээр боломжуудыг хэрэгжүүлэх нөхцөл байдлаар хангах (2) мөн эрүүгийн шүүн шийдвэрлэх системийн дагуу хохирогчийн эрхийг хамгаалахад үйлчилгээ үзүүлэгч болон хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын харилцан хоёр талын хамтын ажиллагааг ёс зүйн болон мэргэжлийн түвшинд хөгжүүлэх мөн түүнчлэн хүн худалдах гэмт хэрэг үйлдэгчдийн илрүүлэлт болон шүүхээр шийтгэгдсэн байдлыг нэмэгдүүлж гэмт этгээдүүдийн ял шийтгэлгүй үйл ажиллагааг эцэслэх зорилгоор дунд хугацааны стратеги боловсруулах талаар өгүүлнэ.

## Хавсралт I ХХГХ-т өртсөн хүмүүст халамж үзүүлэх болон ярилцлага хийх ёс зүйн зарчмууд

Хавсралт I-д ажилтнуудад ХХГХ-ийн хохирогчийг хувь хүний хувьд эрхийг нь хүндэтгэн түүнд тохиолдсон онцгой нөхцөл байдлыг харгалзан тохиромжтой байдлаар харьцах талаарх үндсэн зааварчилгааг өгнө.

## Хавсралт II Ярилцлагын асуулгын жагсаалт

Хавсралт 2 үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан болон ХХГХ-ийн хохирогчийн үүднээс туслалцаа эрж буй хүний хооронд явагдах ярилцлагын эхэн болгонд хэлэлцэгдэн, яригдах асуудлуудын жагсаалт юм.

## Хавсралт III Нэр томъёоны тайлбар

Үгсийн тайлбар нь уг гарын авлага болон ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлон тогтоох, туслалцаа, хамгаалал үзүүлэх явцад хэрэглэгддэг гол үгсийн нэр томъёоны тайлбарыг агуулна.

x

## Үндсэн зарчмууд

Энэ гарын авлагад санал болгож буй зааварчилгаа болон зөвлөгөөнүүд нь ХХГХ-тэй тэмцэх дараах үндсэн зарчим дээр тулгуурладаг.

- ХХГХ-ийг бууруулах, ХХГХ-т өртөж хохирогч болсон хүмүүсийн эрхийг хамгаалах мөн хохирогч хүмүүсийн хувь хүний нэр хүнд болон сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах.
- ХХГХ-т өртсөн болон өртөх магадлал бүхий хүмүүсийн хамгаалал, аюулгүй байдал болон хүний эрхийг хамгаалал нь бүхий л цаг үед мөрдлөг болгон дагах зарчмын удирдамж мөн.
- ХХГХ-ийн хохирогчдод үзүүлж буй бүхий л үйлчилгээнүүд нь хохирогчдод дэлгэрэнгүй мэдээлэгдсэн, мөн мэдээлэгдсэний улмаас зөвшөөрсөн зөвшөөрлийн үндсэн дээр явагдаж, мөн сайн дураар эх орондоо эргэн буцах хөтөлбөрийн туслалцааг

зөвхөн эх орондоо сайн дураар буцахаар хүссэн хохирогчдод үзүүлнэ.

- Тус гарын авлага нь НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протоколд-заагдсан олон улсын хэм хэмжээг тусгасан болно.
- Үүнд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Коммисариатаас гаргасан ХХГХ болон хүний Эрхийн зарчмууд болон Удирдамжуудыг тусгасан болно.
- Байгууллагууд нь ХХГХ-ийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэхдээ хүүхдийн сайн сайхан байдлыг дээдлэсэн үйл ажиллагаа явуулах ёстой.

## Үндсэн удирдамж

- **Гэм хор бүү хүргэ.** Хор бүү хүргэ гэдэг нь анагаахын ёс зүйн ихэнх зарчмуудын хамгийн эхнийх юм. ХХГХ-ийн өндөр эрсдэл, энэ гэмт хэргийн хохирогчдын туйлын эмзэг байдал болон гэмт хэргийн улмаас олсон байж болох гэмтэл цочроо /trauma/ даамжрах магадлал зэргийг харьцуулахад үндсэн дүрмийн ач холбогдлыш хэтрүүлэн хэрэглэх гэсэн асуудал байхгүй. Туслалцаа үзүүлж буй байгууллагууд өөрсдийн төлөвлөж буй үйл ажиллагааг ХХГХ-ийн хохирогчид хор нөлөө үзүүлэх магадлалтай эсэхийг урьдчилан тооцож, хэрвээ ярилцлага хийх эсвэл үзлэг шинжилгээнд оруулах нь хохирогчийг байдлыг тухайн үйлдлийн өмнөхөөс доройтуулах магадлалтай байх аваас төлөвлөсөн үйл ажиллагааг өөр тохиромжтой үед явуулахаар хойшлуулах нь ёс зүйн хувьд зөв болно.
- **Халамж, эмчилгээг хүн тус бүрт тусгайлан хүртээх.** Хэдийгээр ХХГХ-т өртсөн хохирогчдод тохиолдсон зүйлс зарим байдлаар хоорондоо ижил төстэй байх явдал элбэг тохиолддог ч байгууллага нь хохирогч болгон хувь хүн гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр аль болох хүн тус бүрт зориулсан халамж, туслалцаа үзүүлэхээр чармайх хэрэгтэй. Туслалцаа үзүүлэх процесийн явцад ажилтнууд хохирогч болгонд түүний хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон

найдвартай хамгаалал, туслалцаа, дэмжлэгийг үзүүлэхээр зорих ёстой.

- **Тал бүрийн цогц халамж болон түүний үргэлжлэх байдал.** Энэхүү гарын авлагын 3, 4-р бүлгүүдэд ХХГХ-ийн хохирогчдод төрөл бүрийн цогц үйлчилгээг тэдэнд нөхөн сэргээх зорилгоор үзүүлэхээр төлөвлөгдсөн байгаа. Тиймээс хохирогчийн биеийн, сэтгэл санааны, нийгмийн байдалд зохицсон цогц халамжийн туслалцааг үргэлжилсэн байдлаар санал болгоно.
- **Хохирогчоос ярилцлага авах ба бүрэн мэдээлэл өгсөний үндсэн дээр зөвшөөрөл авах.** Туслалцаа үзүүлэх үйл явцын бүхий л үе шатуудад буюу хамгийн эхний холбоо тогтоох дараагаар нь тодорхойлох түүнчлэн эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх бүхий л үе шат тус бурд ХХГХ-ийн хохирогч нар ярилцага өгөх болдог үүнд: хохирогчоор тодорхойлох эхний ярилцлага, болсон явдлыг ярих, туслалцаа үзүүлэх болон эрүүл мэндийн төрөл бүрийн ярилцлагууд мөн бусад процедуруудын үе шатууд байдаг бөгөөд тухай бүрт хохирогч өөрт тохиолдсон явдлыг дахин дахин ярих болдог. Түүнээс гадна, тэдгээр олон тооны зайлшгүй тулгардаг шаардлагатай ярилцлагын үед хохирогч шийдвэр гаргаж, дараа дараагийн үйл ажиллагаа, процедурыг зөвшөөрсөн гарын үсэг зурах шаардлагатай болдог. Ярилцлагын үеэр баримтлах хандлага болон хохирогчийн өгсөн мэдээллийг хэрхэн чанадлан хадгалах, нууцлалтай байлгах талаарх удирдамжийг Хавсралт 1, 2-т тусгасан. Ажилтнууд эдгээр хавсралтыг сайтар уншсанаар ярилцлагыг эзлдэг байдлаар, мэргэжлийн өндөр түвшинд, хохирогчийн хүний эрхийг хүндэтгэн хийх мэдлэгтэй болно. Ажилтнууд эдгээр хавсралтуудыг ярилцлага болгоны өмнө сайтар уншиж байх нь зүйтэй.
- **Өөрөө өөрийгөө тодорхойлох болон оролцох.** Хохирогч өөрөө шийдвэр гаргах, сонголт хийх эрхтэйг хүлээн зөвшөөрч, шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог аль болох дэмжих. Ажиллагсад нь хохирогчидтой хамтран ажиллах замаар хохирогчдын бие даасан байдлыг нөхөн сэргээх болон тэдэнд хамааралтай гарч буй шийдвэр, үйлдүүдэд өөрсдийг нь оролцуулж байхыг зорих. Энэ хамтын ажиллагаа нь хохирогч өөрийн амьдралд хамааралтай шийдвэрт хяналт хийх, дараа дараагийн үйлдлээ тодорхойлох болон

хувь хүний өөртөө итгэх итгэл зоригийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- **Ялгаварлан гадуурхахгүй байх.** ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэж буй ажилтнууд ямарваа нэгэн ялгаварлан гадуулхалтыг энд дурьдсан болон өөр бусад байдлаар гаргахгүй байх, үүнд: жендерийн үндсэн дээр, нас, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, нийгмийн анги давхарга, яс үндэс, шашин шүтлэг, хэл, улс төрийн итгэл болон статус.
- **Нууцлал болон хувийн нууцтай байх эрх.** Хохирогчид урьдчилан мэдээлсэний үндсэн дээр, түүнээс бичгээр өгсөн зөвшөөрөл үгүйгээр ХХГХ-ийн нууц тоо мэдээллийг задруулах ёсгүй. (Хүн худалдагч гэмт этгээдүүдийн эрхшээлд байгаа хохирогч эсвэл энэ гэмт хэрэгт өртөх магадлалтай байгаа хүмүүсийг аврахын тулд хууль хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд тус нэмэр болох үүднээс тоо мэдээллийг нээн, задлах талаар дэлгэрэнгүйг 5-р бүлэгт дурдсан хэсгээс олж үзнэ үү)

## Нэр томъёоны тэмдэглэгээ

“Хохирогч” гэдэг үг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлэцүүлэгт маш их шүүмж хэлэлцүүлж байсан. Маш олон хүмүүс энэ үг нь хохирогчийн нөхөн сэргээгдэх уян хатан чанар гэхээсээ илүүтэйгээр сул дорой гэсэн агуулгатай хэмээн үзэж энэ үгийг “даван туулагч” гэсэн үгээр орлуулсан билээ. Гэхдээ хүний эрх болон хамгааллын хүрээнд “хохирогч” гэсэн үг нь гэмт этгээдийн хариуцлага хүлээх ёстой тэрхүү үйлдлийн улмаас шударга бус явдалд өртсөн хүнийг нэрлэдэг. Энэ нь нэг эсвэл хэд хэдэн хүн хүний эрх зөрчигдсөн тохиолдолд тэр зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, туслалцаа дэмжлэг, нөхөн олговор авах эрхтэй хүн гэсэн үг юм (Billingset al., 2005). Уг хамгаалалт болон туслалцаа үзүүлэх тухай тайландаа бид “хохирогч” гэдэг үгийг хохирогчийн хамгаалуулах ёстой эрх түүнчлэн тэрхүү хамгаалалтыг үзүүлэх ёстой төр засгууд болон иргэний нийгмийн үүргийг тодотгож хэрэглэсэн байгаа.

Мөн “янхандалт” гэдэг үгийг “ашиг олох зорилгоор биеэ үнэлэх ажил хийх” гэдэг үгээр илэрхийлэх талаар олон тооны шүүмж

хэлэлцүүлэг байсан. Энэ мэтчилэн яригч этгээдийн үгийн сонголт нь тухайн асуудалд гаргаж буй үзэл санааны хандлагыг давхар илэрхийлдэг. Энэхүү гарын авлагын агуулгын хүрээнд бид бие үнэлэлт болон биеэ үнэлэгчдийн талаар ярилцана. ОУШСБ-ын сонгон хэрэглэж буй үгнүүд ямар нэгэн байдлаар үзэл суртлын агуулгатай биш бөгөөд “бие үнэлэлт” болон “биеэ үнэлэгч” гэсэн эдгээр үгс нь тухайн үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийг ямар нэгэн байдлаар буруутгасан утга агуулсан нь огт үгүй.

## Талархал

ОУШСБ нь энэхүү гэрын авлагыг зохион боловсруулахад оролцсон бүхий л хамтран ажиллагсад болон түншүүддээ талархаж байна. Онцгой талархлыг гарын авлаганы дотоод агуулгыг бичсэн хүмүүст илэрхийлье. Үүнд: 1, 2 болон 6-р бүлэг - Paul Holmes, 3-р бүлэг - Fred Larsson, 4-р бүлэг - Pamela Sumner-Coffey, 5-р бүлэг - Cathy Zimmerman болон хянан тохиолдуулах ажлыг уйгагүй, цаг хүчээ дайчлан гүйцэтгэж хэрэгцээтэй бүхий л шинэ тутам мэдээллийн олж, ерөнхий бичлэгийг олон нийтэд хүртээмжтэй болгосон Ruth Rosenberg нарт талархлаа ирэлхийлье. ОУШСБ нь Ruth-д ялангуяа энэхүү удаан хүлээгдэж байсан номыг ийнхүү бэлэн болгосонд талархаж байна. Ana Barbosa, Segundo dela Cruz Jr., Akram Eltom, Marco Gramegna, Dario Muhamudo, Helen Nilsson, Ilse Pinto, Caroline San Miguel, Rebecca Surtees, Theodora Suter, Katarina Tomolova, Krieng Triumphavong болон Shyla Vohra нар энэхүү номыг бүтээхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулцгаасан билээ. Sarah Stephen James, Jyothi Kanics, Karolina Lindholm-Billing, Denise Marshall болон Bandana Pattanaik нар санал, сэтгэгдлээсээ хуваалцан энэ үйл ажиллагаанд өөрийн үнэтэй цагаа зарцуулж байсныг дурдмаар байна.

### Richard Danziger

Захирал

ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ОУШСБ

**Аюулгүй байдлын  
хамгаалал болон  
хувийн аюулгүй  
байдал**

## Бүлгийн агуулга

### Гол зарчмууд

Аюулгүй байдлын хамгааллийн асуудал болон эрсдлийг үнэлэх нь

- 1.1 Эрсдлийн үнэлгээ
- 1.2 Хувь хүний нууцтай холбоотой болон ХХГХ-ийн талаарх бусад тоо мэдээллийн нууцыг чандлан хадгалах нь
  - 1.2.1 ХХГХ-ийн хохирогчдын хувь хүний нууц мэдээ, мэдээлэл
  - 1.2.2 Хувь хүний нууц мэдээ, мэдээлэл болон ХХГХ-ийн мэдээллийг ашиглах болон устгах
- 1.3 Аюулгүй байдлын хамгаалалтын шилдэг туршлагаас-Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан
  - 1.3.1 Сайн туршлага - хохирогчтой эхэлж холбоо тогтоох нь
  - 1.3.2 Сайн туршлага - хохирогчтой ярилцлага хийх
  - 1.3.3 Хувь хүний нууцын асуудал

2

Гарын авлагын энэ бүлгийн онцлог нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хохирогчид туслалцаа үзүүлэх үе шат бүрт урган гарч ирдэг хамгаалалтын асуудлаар удирдамж өгөхөд оршино. Эдгээр асуудлууд нь тал бүрийн, цогц байдлаар энэхүү нэг бүлэгт бичигдсэн. Үншигч энэ бүлэгт дурьдагдах зарим асуудлууд энэхүү гарын авлагны өөр хэсгүүдэд мөн дурьдагдах болно. Хамгаалалтын асуудлууд энэхүү гарын авлагын өөр хэсгүүдэд мөн давтагдах бөгөөд энэ нь аливаа аюулгүйн сайн хамгаалал хэзээд илүүддэггүйтэй холбоотой.

### Гол зарчмууд

- ХХГХ ихэнх тохиолдолд олон улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн сүлжээнүүдийн хяналтанд байдаг бөгөөд ХХГХ-ийн хохирогчийн болон түүнд туслалцаа, үйлчилгээ үзүүлэж буй ажилтны аль алины эрсдлийн түвшин өндөр тул хамгаалалтын асуудал хамгийн чухал асуудлын нэгд тооцогддог.
- Эрсдлийн түвшинг хэтрүүлэлгүйгээр хэлэхэд тэрхүү нөхцөл

байдлыг зохицуулах гол үндэс нь кейс болгоны аюулгүй байдлын тодорхойлолтыг нямбай зөв хийх, аюулгүй байдлын хамгааллын үндсэн процедурын сайн туршлагыг байнга, чанд даган мөрдөхөд оршино.

- Ямар ч тохиолдолд аюулгүй байдлын 100 хувийн хамгааллын баталгаа гаргах боломжгүй бөгөөд ихэнх тохиолдлуудад үйлчилгээ үзүүлэгч ажилтан ямар нэгэн эрсдэлд өртөхгүй байдаг ч аюулгүйн байдлын шилдэг туршлагын үндсэн зарчим нь кейс болгоныг эхнээс нь эрсдлийн магадлалтайд тооцож, аюулгүйн эрсдэл болон эрсдлийн үнэлгээ байнга хийж байх шаардлагатай.

## Аюулгүй байдлын хамгааллын асуудал ба эрсдлийг тооцохуй

ХХГХ-т өртсөн хүнд үйлчилгээ үзүүлэх нь эрсдэл бүхий ажил бөгөөд сүүлийн үеийн хамгийн боловсронгүй хамгааллийн систем, өндөр техник хэрэгслээр тоноглосон ч аливаа эрсдлийн элементийг үндсээр нь үгүй хийх боломжгүй юм. Гэмт этгээдүүд тэднээс оргон зугатаасан эсвэл өөрсдийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг өгсөн хүмүүст хэрхэн хамаг хүчээ дайчлан хариу арга хэмжээ авдаг талаар баримтууд бидэнд олон бий. Тийм ч учраас хүн худалдах гэмт этгээдүүдийн зүгээс хохирогчдод ирж болох эрсдлийг хэтрүүлэн үнэлнэ гэсэн ойлголт байхгүй юм.

ХХГХ-ийн хохирогчид байнга эрсдэлд байдаг ч тэдэнд үйлчилгээ үзүүлж буй хүмүүс мөн ижил хэмжээний эрсдэлд байдаг. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага туслалцаа үзүүлэн хохирогчийг мөлжигч этгээдээс оргуулах болон эсвэл хохирогч гэмт этгээдүүдийн эсрэг мэдүүлэг өгөх тохиолдлын тоо нэмэгдэх тутам тэрхүү эрсдэл даган өсөх магадлалтай.

Үйлчилгээ, хамгаалал авч буй хохирогч болон түүнд үйлчилгээ үзүүлэгч ажилтны аль аль нь өртөж болох эрсдлийн зэрэглэлийг туслалцаа үзүүлэх үе шатлал тутамд бодит байдалтай харьцуулан тооцож, эрсдэл үнэхээр найдвартай хяналтанд байж чадаж байгаа эсэхийг баталгаажуулж, аюулгүй байдлын хамгааллын арга хэмжээг зохицуулах ёстой. Гарын авлагын энэ бүлэгт дээр дурдсан тэдгээр үйл явц хэрхэн явагдах талаар тайлбарлах болно.

## 1.1 Эрсдлийн тодорхойлолт

Аливаа аюулыг сөрөх хамгийн эхний алхам бол эрсдлийн түвшинг тогтоох болон тодорхойлоход оршино. Үр дүнтэй эрсдлийн тодорхойлолтод тухайн улс дахь шалтгааны эрсдлийн тодорхойлолт, түүний байнгын эргэх хяналт болон онцлог үйл явдлуудаас даган бий болох онцлог эрсдлийн тодорхойлолт зэрэг орно. Энэхүү үйл явцыг зохицуулахад шаардлагатай эрсдлийн өргөн хүрээний үзүүлэлтүүдийг тохиолдол болгоноор тусгайлан бэлтгэн доор дурьдсан болно. Гэхдээ энэхүү жагсаалт нь эцсийн төгс хувилбар биш бөгөөд тухайн улс, тохиолдол болгоноос хамаараад өөр өөр эрсдэл, эрсдлийн үзүүлэлтүүд бий болох тул тухайн ажилтан өөрийн орны онцлогийг мэдэхийн хувьд ажил мэргэжлийнхээ туршлагад үндэслэн өөрийн эрсдлийн үнэлгээг хийнэ. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хууль хэрэгжүүлэгч эсвэл өөр бусад албадын хоорондын хамтын ажиллагаа нягт уялдаа холбоотой бол тухайн улсын эрсдлийн тодорхойлолтыг байгууллагууд зөвлөлдсөний үндсэн дээр хамтран хийвэл зохино.

## ЭРСДЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Эрсдлийг тооцох үнэлгээг тогтмол хугацаанд ХХГХ-ийн гэмт этгээдүүдийн үйлдэлд тулгуурлан байнга эргэн хянаж, шинэчилж байх шаардлагатай. Энд дурьдсан процесс нь эрсдлийг эхний үе шатаас эхлэн үнэлэхэд зориулан боловсруулагдсан. Эрсдлийн тодорхойлолтын эхний үе шат нь тухайн улс оронд давамгайлж байгаа нөхцөл байдлыг үнэлэхэд оршино. Тийм учраас дараах үзүүлэлтүүдийн анхааралдаа авах шаардлагатай:

### Эрсдлийн ерөнхий үнэлэх тодорхойлолтууд

- **Тухайн улс орон дахь ХХГХ-ийн цар хүрээ болон нелөө.**
- **Тухайн улс орон гаргагч, дамжуулагч, хүлээн авагч, эсвэл холимог гэдгээр тооцогддог уу?**
- **Хэдэн хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагын туслалцаа хэрэгцээтэй байж болох вэ?**
- **Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хянаж буй ХХГХ-ийн хэр хэмжээ.**
- **Гэмт этгээдүүдийн хохирогчид болон үйлчилгээ үзүүлэгч**

байгууллагын ажилтнуудаас авч болох өшөө авалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн тогтоогдсон болон мэдэгдэж байгаа хүчин чадал.

- Тухайн улсын дотоодын хууль хэрэгжүүлэгч хүчин чадал.
  - Тухайн улс оронд дахь авилгалын цар хэмжээ болон авилгал эрсдлийн хэмжээг нэмэгдүүлэх магадлалтай эсэх.
  - ХХГХ-ийг шүүхээр таслан шийтгэх болон тэмцэхэд үзүүлж буй Төр засгийн дэмжлэг.
- 

Тэмдэглэл: шинээр байгуулагдсан байгууллагууд эсвэл жижиг байгууллагуудад эрсдлийн ерөнхий үнэлгээг хийхэд шаардлагатай холбогдох мэдээллүүдийг цагдаа, орон нутгийн болон ОУ-ын, НҮБ-ын болон бусад улс хоорондын байгууллагууд, элчин сайдын яамд эсвэл өөр холбогдох газруудаас авч болно.

## ЭРСДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАЙНГА ЭРГЭН ХЯНАХ

Эрсдлийн ерөнхий тодорхойлолтын байнга үргэлжлах чанар нь түүний хамгийн чухал нөхцөл болдог. Тодорхойлолтыг нэг удаа хийгээд орхих нь хангалттай бус юм. Тодорхойлолт хийх тогтмол хугацааны давтамж хэд хэдэн хүчин зүйлсээр тогтоогдоно:

- Эрсдэл зохицуулах төлөвлөгөөг эрсдлийн тодорхойлолт хийх явцад давхар боловсруулах нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага болгоны хариуцлагатай холбоотой асуудал юм.
  - Эрсдлийн тодорхойлолт нь хамгийн багадаа сар болгон эргэн хянагдаж байх ёстой. Кейсийн онцлогоос хамааран өндөр эрсдлийн үед эрсдлийн тодорхойлолтыг тогтмол 7 хоног эсвэл өдөр тутамж хянаж байх шаардлагатай.
- 

## ТОДОРХОЙ ОНЦЛОГ ҮЙЛ ЯВДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЛИЙН ОНЦГОЙ ТОДОРХОЙЛОЛТ

Эрсдлийн тодорхойлолтын хамгийн гол хэсэг бол эрсдлийн ерөнхий, байнгын эргэн хяналт байдаг бол онцгой эргэн хяналт гэж тухайн үйл явдлын улмаас эрсдэл болон аюул занахийлэл өсөж байх тохиолдлыг тооцно. Кейс болгон өөр өөрийн онцлог асуудал, эрсдлийг бий болгож, тодруулах боломжтой мэдээлэл болон үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно.

Доор дурьдсан жагсаалт нь онцгой эрсдлийн үнэлгээг хийх шаардлагыг бий болгодог онцгой үйл явдлын хүрээг тодорхойлсон загвар тул төгс ухагдахуунууд гэж ойлгож болохгүй. Түүнээс гадна эдгээр жишээ болгонтой холбоотой түүнийг дагалдах дараах эрсдлийн үзүүлэлтүүд тодорхойлолтыг гаргах үзүүлэлт болох ёстой.

- Оргон ирсэн бүх хохирогчид хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажилласан болон хамтран ажиллаагүй гэдгээс үл хамааран гэмт этгээдүүдийн зүгээс өшөө авалтанд өртөх магадлалтай байж болно.
- Хохирогч хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллаж, гэмт этгээдүүдийн эсрэг мэдүүлэг өгөн тэдний эрх чөлөөнд заналхийлэл бий болгох хэрээр эрсдлийн түвшин огцом даган өснө.
- Гэмт этгээдүүд хохирогчийг хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах болсон эсвэл хамтран ажиллахаар төлөвлөж байгааг мэдэх тэр үеэс эхлэн эрсдлийн түвшин огцом өснө.

---

#### Эрсдэл үүсгэх онцгой үйл явдлуудын жагсаалт:

- Хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тусlamж эрэн хандаж очсон бол тэр мөчөөс эхлээд, ялангуяа хамгаалах байранд байрлуулах зэргээр тусlamж үзүүлэгдэх бол эсвэл хууль хэрэгжүүлэгч байгууллагтай хамтрах бол.
- Хохирогч хууль хэрэгжүүлэгч байгууллагад нотлох баримт гарган өгсөн бөгөөд гэмт этгээдүүд түүний энэ үйлдийн талаар мэдэж байж болзошгүй гэсэн таамгийн улмаас байршилыг шилжүүлэн нүүлгэсэн байх.
- Хамгаалах байранд хамгаалуулж байсан хохирогчдын хувьд-эмнэлэг, эрүүлийг хамгаалах газар эсвэл өөр бусад халамжийн болон нийгмийн үйлчилгээний газруудаар явах хуваарийн дагуу хамгаалах байрнаас гарч явахаар бол.
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хохирогч хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтарч байгаа бол тэрхүү хамтарч буй асуудлаар мэдүүлэг өгөх, эсвэл хэрэгтнийг таних, эсвэл цагдаагийн шүүх эмнэлгийн шинжилгээний асуудлаар гадагшаа гарах.
- Шүүхийн байранд явж очих үүнд: ялангуяа ХХГХ-нүүдийн талаар шүүхэд очиж мэдүүлэг өгөх төлөвлөсөн уулзалт гэмт этгээдүүд сэжигтэнд олгогддог эрхийн дагуу энэ талаар мэдээлэгдсэн байдаг тохиолдлууд.
- Хохирогч ХХГХ-ийн гэмт этгээдүүдийн эсрэг гэрчлэх зорилгоор

нэг улсаас нөгөө улсад зорчихоор хохирогчийн болон дагалдах ажилтны хөдөлгөөны үед эрсдлийн түвшин маш өндөр байна, яагаад гэвэл гэмт этгээдүүд хохирогчийн тухайн улсаас гарах эсвэл нөгөө улсад очих цаг хугацаа, явах маршрут улс тус бүрээр эсвэл хамтад нь урьдчилан тооцоолох боломжтой болно.

- Хохирогч болон дагалдах хүнийг айлган сүрдүүлэх зорилготой гэж ойлгож болох аливаа үйлдэл - үүнд утсаар айлган сүрдүүлэх, нэр хаяггүй ярих/дуудлага хийх, утсаар байн залган юу ч ярилгүйгээр харилцуураа тавих, эсвэл хамгаалах байрны гадаа танихгүй хүн эсвэл танихгүй машин унаа байнгын бөгөөд удаан хугацаатайгаар давтамжтайгаар ирж байрлах, эсвэл хохирогч болон түүнийг дагалах хүнийг алсуур зайнаас газраас танихгүй хүн эсвэл машин унаа дагалдах.

## ЭРСДЛИЙГ ШИЙДЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН БАРИМТЖУУЛАЛТ

Эрсдлийн тодорхойлолт болгоныг ерөнхий, эргэн хянасан эсвэл онцгой тохиодлын аль нь ч байсан тодорхойлогдсон эрсдлийг шийдвэрлэх телөвлөгөө хамт дагалдан боловсруулагдаж байх ёстай:

- Эрсдлийн тодорхойлолт нь түүнийг шийдвэрлэх телөвлөгөөтэй хамт хийгдэх ёстай. Уг телөвлөгөө нь эрсдлийн түвшинг үр дүнтэй хянаж, аюулгүй байдлын наад захын стандарт болон түүнд холбогдох процедурыг агуулж эрсдлийн түвшинг бууруулах баталгаат нөхцлийг бий болгох байх ёстай.
- Эрсдлийн тодорхойлолт нь байнга дахин шинэчлэгдэн боловсруулагдаж байх чанартай тул шинэ эрсдлийг шийдвэрлэх телөвлөгөө нь зөвхөн эрсдэл огцом өсөх төдийд эсвэл шинэ эрсдэл бий болоход нөхцөл байдлыг тодорхойлж, боловсруулах шаардлагыг даган хамт гарч ирнэ.
- Онцгой аюулын заналхийлэл эсвэл тодорхой үйл явцын улмаас эрсдлийн яаралтай тодорхойлолт хийх үед түүнийг даган шинэ эрсдлийг шийдвэрлэх телөвлөгөө боловсруулах шаардлага гарна.

Төлөвлөгөө нь бүрэн баримтжуулагдсан бөгөөд шинэ эрсдлийн тодорхойлолтыг агуулсан, түүнийг үр дүнтэй шийдвэрлэх аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төлөвлөгөө байх ёстай.

Эрсдлийн тодорхойлолт хийх болон эрсдлийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад үйлчилгээ авч буй хохирогч болон хохирогчтой ажиллаж буй ажилтныг хамгаалахад зайлшгүй хэрэгцээтэй юм. Бүхий л үйл явцууд цахим болон бусад байдлаар бүрэн хэмжээнд баримтжуулагдсан бөгөөд нууцын зэрэглэлтэйгээр хадгалагдаж доор өгүүлэгдэх хувь хүний болоод ХХГХ-ийн талаарх нууцыг хамгаалах, зохицуулах шилдэг туршлагын дагуу хамгаалагдах ёстой.

## 1.2 Хувь хүний болоод ХХГХ-ийн талаарх нууц тоо мэдээллийг хамгаалах, зохицуулах

Хохирогчтой хамаатай түүний хувийн нууц, ХХГХ-ийн процесс болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтаны нууцлалыг аюулгүй байдлын хамгааллын бүхий л шаардлага, дүрмийн дагуу чанадлан нууцлах нь нэн чухал:

- 
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХГХ-ийн хохирогч нарт тэдний талаарх мэдээллийг цуглувалж буйн учир шалтгаан, тэрхүү мэдээллийн хэрэглээ мөн түүнчлэн хохирогчид өөрсдөө тэдгээр мэдээлэлд нэвтрэх эрхийн талаар сайтар мэдсэн байх тал дээр анхаарал тавин ажиллах ёстой.
  - Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХГХ-ийн хохирогчид өөрсдийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр өгөхөөс нааш хохирогчдоос авсан ХХГХ-ийн талаарх болон хохирогчдын хувийн мэдээллийг ямар нэгэн байдлаар задлахгүй гэдгийг батламжлах ёстой.
  - ХХГХ-ийн хохирогч болон түүнтэй ажиллагч ажилтанд гэмт бүлэглэлүүдийн зүгээс бий болох эрсдэл нэмэгдсэнтэй холбогдуулж үйлчилгээ үзүүлэгч байгууллага хувийн чанартай нууц мэдээллийг зохицуулах болон байршуулах талаарх бүхий л хүчээ дайчлан арга хэмжээг авна.
- 

Хувийн болон ХХГХ-ийн холбогдолтой нууц мэдээллийн эмзэг байдал, тэрхүү мэдээллийг зохицуулалтыг хэрхэн зөв хийх талаар авч буй арга хэмжээнүүд хэзээ ч илүүдэнэ гэж байдаггүй. Хохирогчийн хавтаст мэдээлэл байнгын хамгаалал, нууцлал байх ёстой.

Доор дурьдагдах удирдамжууд нь хувийн нууцыг хамгаалах талаарх хамгийн наад захын үндсэн стандартууд юм. Үйлчилгээ

үзүүлэгч байгууллагууд тэрхүү хамгийн наад захын гэх томъёоллыг өөрсдөө бий болгон тэдгээр стандартыг даган мөрдөх талаар ажилтнууддаа үүрэг болгон биелүүлнэ үү хэмээн зөвлөмж болгож байна. Нэмэлт удирдамжийг Хувь Хүнийг Хамгаалах Европын Зөвлөлөөс Хувийн Мэдээллийг Автоматаар Боловсруулахтай холбогдуудан гаргасан баримт бичгээс авна уу<sup>1</sup>.

### 1.2.1 ХХГХ-ИЙН ХОХИРОГЧИЙН ХУВИЙН НУУЦ МЭДЭЭЛЭЛ

Дараах удирдамжийг өгөх үүднээс хохирогчийн хувийн нууц мэдээлэлд:

ХХГХ-ийн хохирогчийн байршил, тодорхойлолтыг агуулж болох аливаа хувийн мэдээлэл, эрүүл мэндийн бүртгэл тэмдэглэл эсвэл ХХГХ-ийн хохирогчийг эсвэл түүний байршилыг мэдэж болохуйц дүрслэл эсвэл байгууллагын халамжинд байгаа худалдагдсан хохирогчийн хувийн болоод хувь хүний талаарх нарийвчлал бүгд энд багтана.

### 1.2.2 ХУВИЙН БОЛОН ХХГХ-ИЙН ТАЛААРХ НУУЦ МЭДЭЭЛЛИЙГ ХАДГАЛАХ, АШИГЛАХ БОЛОН УСТГАХ

Энэхүү ажлын туйлын нарийн, онц ач холбогдолтой холбогдуулан тэмдэглэхэд ХХГХ-ийн хохирогчийн нууцыг хадгалах асуудлаас гадна хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ажиллагсад болон хувь хүний нууц мэдээллийг чандан нууцлахад шилдэг туршлагыг чанадлан баримтлах гь туйлын чухал.

Зөвлөмж болгон мөрдөх чухал зарчмууд:

- Хохирогч болон ХХГХ-ийн талаарх ерөнхий мэдээлэлийн нууцлал “Мэдэх шаардлага” гэдэг чандлан хадгалах гол зарчимд тулгуурлана. Энэ зарчмыг үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд аль ч тохиолдолд даган мөрдөх шаардлагатай бөгөөд мэдээллийг дотроо болон гадашгаа задлахдаа тэрхүү мэдээллийг хүлээн авах эрх болон хэрэгцээ нь батлагдсан тэр хүнд өгнө гэсэн дүрмийн дагуу задална.
- “Мэдэх шаардлага” нь тэрхүү үйчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны хүрээнээс хамаарна - үүнд, ямар ч нууц

мэдээллэл ХХГХ-тэй тэмцэх хэсгээс гадуур тархах ёсгүй, мөн аюулгүй байдлыг баталгаажуулах зарчмууд үйчилгээ үзүүлэгч байгууллагын дотоод хүрээнд болон хүрээнээс гадуур аль ч тохиолдолд чанд даган мөрдөгдөх ёстой.

- Ялангуяа, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХГХ-ийн хохирогчийн хувийн нууц мэдээллийг тухайн хохирогч өөрт нь мэдээлсний үндсэн дээр, бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнд ч задлах ёсгүй.
- Хохирогч бичгээр хувийн болон эсвэл ХХГХ-ийн холбогдолтой нууц мэдээллийг задлах талаар зөвшөөрсөн ч үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан задлахаар зөвшөөрсөн тухайн нууц мэдээлэл хохирогч болон түүний гэр бүлийнхэнд, өөр хохирогч болон бусад өөр хүмүүст мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтанд хор хохирол учруулахгүй талын үнэлгээ хийх ёстой. Хэрвээ боломжтой бол, мэдээллэл задарсанаас үүдэн хохирогч болон өөр этгээдийг эрсдэлтэй нөхцөл байдалд оруулж болзошгүй гэж үзвэл тэдний сонирхлыг хамгаалах үүднээс тухайн мэдээллийг задруулахгүй байх эрхийг өөртөө үлдээвэл зохистой.

### Нууц мэдээллийн цаасан хувь

Үйлчилгээ үзүүлэх явцад мэдээллийг цаасан дээр үлдээх болдог. Хувийн Нууц мэдээллэл болон ХХГХ-ийн талаарх нууц мэдээлэл заримдаа хэвлэгдэх шаардлага гардаг. Тэдгээр тохиолдолд ОУШСБ-аас доорх зөвлөмжүүдийг гаргаж байна:

- 
- Бүх хувиуд цоожтой шүүгээнд үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ажлын эсвэл хамгаалах байранд чанд нууцлан хадгалагдах ёстой.
  - Хэрэглэгдэх явцад цаасан дээрх хэвлэгдсэн нууц мэдээллүүд хэзээ ч эзэнгүй орхигдож эсвэл ширээнд дээр үлдээж эсвэл өөр хэн нэгэн олоод харах бололцоотой газар байж болохгүй.
  - Цаасан дээрх мэдээллүүд ашиглагдаж дууссаны дараа хайчлах эсвэл өөр ижил төстэй байдлаар устгагдах ёстой.
  - Энэ зорилгоор ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд цаас устгагч машинтай байж түүний найдвартай ажиллагааг байнга хянаж хангаж байх шаардлагатай.
-

## 1.3 Аюулгүй байдлын хамгааллын сайн туршлага - үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд

Дараах удирдамж нь ХХГХ-ийн хохирогчтой эхэлж холбоо тогтоон уулзахад хэрэглэгдэнэ. Энэ төрлийн үйл ажиллагаанд оролцогч бүхий л ажилтнууд урд нь хохирогчдод тусалцаа үзүүлэх хөтөлбөрт гаднаас нэвтрэх оролдлого гарч байсныг сайтар санаж, эрсдэл байгаа гэдгийг байнга тооцоолж байх хэрэгтэй.

---

**Ямар ч тохиолдолд хувийн нууц эсвэл ХХГХ-ийн нууц мэдээлэл утсаар болон хэн нь тодорхойлогдоогүй хүнд задлагдаж болохгүй.**

---

### 1.3.1 САЙН ТУРШЛАГА - ХОХИРОГЧТОЙ ЭХЭЛЖ ХОЛБОО ТОГТООХ

*Хохирогч утсаар шууд холбогдох нь*

- Хохирогчтой дараа хэрхэн холбогдох талаарх бүрэн мэдээллийг авах, холбогдох арга зохиох, тэдэнд танай байгууллагатай холбогдох утасны дугаарыг өгөх, гэхдээ өөрсдийн байршил, хаягийг өгч болохгүй.
- Хэрвээ хохирогч хамтран ажиллахаар болбол утасны дугаарыг нь авч тэр даруйдаа шалгах болон асуудлыг шийдвэрлэх талаар ярилцахаар буцаан залгаж утасдах
- Дуудлагын цаг болон дуудлага орж ирсэн дугаар болгоныг тэмдэглэн авах
- Утсаар ярилцах явцад өөр хэн нэгэн сонсож байж болзошгүйг анхааралдаа авах хэрэгтэй

*Үйлчилгээ үзүүлэгч өөр байгууллагуудаар дамжуулан хохирогчидтой холбоо тогтоох*

- Хохирогчийн талаарх болон түүнд тохиолдсон зүйлсийн талаар (кейс) дэлгэрэнгүй тодруулж авах
- Хохирогчтой ярилцаж дараагийн ярилцлага хийх талаар товлон тохиролц
- Дээр дурдсанчлан хохирогчид зөвхөн холбоо барих мэдээллийг өг.

- Мөн байгууллагынхаа ажилтнуудад дээр дурдсанаас өөр мэдээллийг өгч болохгүй гэдгийг сайтар сануулан хэлж өгөх.

### 1.3.2 САЙН ТУРШЛАГА - ХОХИРОГЧТОЙ ЯРИЛЦАХ

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд ХХГХ-ийн хохирогчтой ажлын байран дээрээ эсвэл өөр газар жишээлбэл цагдаагийн газар, хаяг тогтоох газар, хуулийн байгуулага болон өөр хaa нэгэнтээ уулзахаар тохирч болно. Энэ тохиолдолд дараах арга хэмжээнүүдийг зайлшгүй авах шаардлагатай:

Үйлчилгээ үзүүлэх байгууллага дээр ярилцлага хийх тохиолдолд:

- Танай ажлын газрыг аль болох цөөн хүнд мэдүүлэх, аюулгүй байдлын хамгааллын үүднээс ХХГХ-ийн хохирогчтой ажлын байрнаасаа өөр газар уулзсан нь дээр байдаг.
- Биечлэн ярилцлагыг урьдчилан тохиролцсоны үүднээс хийх нь тохиромжтой.
- Холбоо тогтоох ажиллагааг хамтрагч түнш байгууллага хийсэн бол мөн хохирогч тэр байгууллагын ажилтантай хамт ирж уулзахыг хүсч байвал тухайн байгууллага өөрийн ажилтныг мөн гэдгийг баталгаажуулсан байх ёстой.
- Оффист дээр ирэх явцад хохирогчийг орох хаалган дээр шалгаж эсвэл нууц камераар харж эсвэл хаалган дээрх харах нүдээр харж байж оруулах хэрэгтэй.
- Ярилцлага байгууллагын байран дахь тусгай өрөөнд хийгдэх ёстой. Түүнээс гадна тухайн өрөөнд тус байгууллагын ажилтан хохирогчтой ярилцлага хийж байгааг наад зах нь өөр нэг ажилтан мэдэж хэрэгцээтэй зүйлсээр туслах болон ярилцлагын явцыг хянах шаардлагатай.

Ярилцлагыг ажлын оффисоос өөр газар хийх тохиолдолд:

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас өөр газар ярилцлага явагдах үед аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн ярилцлагад хоёр ажилтан оролцох хэрэгтэй. Гэхдээ энэ нь тэр болгон боломжгүй байж болно, энэ тохиолдолд доорх удирдамжийг ашиглана уу:

- Хэрвээ хохирогч өөр нэгэн ТББ-аар дамжуулан үйлчилгээ тухайн үзүүлэгч байгууллагаас тусламж хүссэн бол уулзалтыг нөгөө байгууллагын байранд хийж болно.
- Ярилцлага үйлчилгээ авахаар хандсан байгууллагын байранд явагдах үед уулзалт амжилттай явагдах үүднээс тухайн байгууллагын наад зах нь нэг ажилтан уулзалтын үеэр хамт байлцах шаардлагатай.
- Хэрвээ ярилцлага цагдаагийн газар, хаяг тогтоох газар эсвэл төрийн өөр нэгэн байгууллага дээр явагдах бол тухайн байгууллагын наад зах нь нэг ажилтан ярилцлага дуустал байлцана. Хохирогч өөрөө л хүсээгүй бол тэнд өөр байгууллагын ажилтан дангаараа хохирогчтой үлдэж болохгүй.

#### **Уулзалт явуулж болох бусад газрууд**

- Ямар ч тохиолдолд ярилцлагыг хохирогчийн хүссэн газар хийх болохгүй.
- Уулзалт нь үйлчилгээ үзүүлэгч газрын тодорхойлсон дундын газар явагдах ёстой.

#### **1.3.3 ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Дараах зүйлсүүдийг тэмдэглэж авах шаардлагатай:

- Аюулгүй байдлын 100 хувийн хамгаалалт гэсэн ойлголт байхгүй.
- Эрсдлийн тодорхойлолт, эрсдлийг шийдвэрлэх төлөвлөгөө болон хувийн аюулгүй байдлын арга хэмжээг хослуулан хэрэглэсний үр дүнд хувийн аюулгүй байдлийг сайжруулж болно.
- Эрсдлийн түвшинг хэтрүүлэн тайлбарласанаар ажиллагсадын айдсыг нэмэгдүүлж болох ч ХХГХ-ийн хохирогчидтой тулан ажилладаг бүх ажиллагсад энэ ажлаас үүдэн гарах эрсдлийн талаар бүрэн мэдээлэлтэй байх шаардлагатай. Шинээр ажилд орж буй хүмүүст ажилд орсон даруйдаа ХХГХ-ийн талаар болон аюулгүй байдлын хамгааллын талаар дэлгэрэнгүй танилцуулах ёстой.
- Хувийн аюулгүй байдлын хамгааллын үүднээс ХХГХ-ийн хохирогчидтой ажилладаг ажилтнууд уулзалт болж буй

дундын газрын талаар болон ерөнхий нөхцөл байдлын талаар сайн мэдээлэлтэй байх шаардлагатай.

- ХХГХ-ийн кейсийн талаар ярих үедээ өөр хүнд сонсогдохгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авч, байнга болгоомжтой байх шаардлагатай.
- 

ХХГХ-ийн хохирогчид хамгаалах байраар үйлчлэхэд шаардлагатай аюулгүй байдлын хамгааллын асуудлууд, аргачлалын талаарх мэдээлэл болон сайн туршлагын талаар бүлэг 4 болон бүлэг 6-аас тодруулан уншина уу.

---

## Тэмдэглэгээ

<sup>1</sup> <http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/108.htm>

**ХХГХ-ийн  
хохирогчдыг  
танин  
тодорхойлох**

# Бүлгийн агуулга

## 2.1 Танилцуулга

2.1.1 Үйлчилгээ үзүүлэгч байгуулагатай холбож өгөх

2.1.2 Тодорхойлон, тогтоох зорилго

2.1.3 Тодорхойлон, тогтоох үйл явц дахь хязгаарлалт

2.1.4 ХХГХ-ийг ойлгох нь

2.1.4.1 Хуулийн агуулга

2.1.4.2 Гэмт хэрэгтэн

2.1.4.3 Хохирогч

2.1.4.4 ХХГХ-ийн үзэгдэл

## 2.2 Ярилцлагын өмнөх тодорхойлолтын үзүүлэлт

## 2.3 Тодорхойлон, тогтоох ярилцлага

2.3.1 Насанд хүрээгүй хүүхэдтэй ярилцлага хийхэд анхаарах онцлогууд

2.3.2 Хохирогчийн хариу хандлага болон түүнтэй харьцах

2.3.3 ХХГХ-т өртсөн хүмүүстэй ярилцлага хийх болон халамж үзүүлэхэд баримтлах ёс зүйн зарчмууд

2.3.4 Танин тодорхойлох ярилцлагын маягтыг ашиглах

2.3.4.1. Ярилцлагын асуумжууд

2.3.4.2. Тодорхойлон, тогтоох ярилцлагын маягтыг бөглөх

**Хавсралт I: Хохирогчоор тодорхойлон, тогтоох ярилцлагын маягт**

## 2.1 Танилцуулга

Энэхүү бүлэгт үйлчилгээ үзүүлэгч байгууллага туслалцаа шаардлагатай байгаа хүмүүсийг тодорхойлон, тогтоох стандарт системийг ашиглах замаар ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох болон туслалцаа үзүүлэхэд туслах зорилготой юм. Энэхүү удирдамж нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийн эх оронд, дамжуулагч улсад болон хүлээн авагч оронд байрлалтайгаас үл хамаараад хохирогчид шаардлагатай тусламж дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх бүхий л нэхцэл байдлыг хамарсан болно. Удирдамж нь тухайн хүний эмэгтэй, эрэгтэйгээс үл хамааран ХХГХ-ийн хохирогчийн хувьд туслалцаа хүсч буй хэнд боловч ялангуяа насанд хүрээгүй хүүхдэд хүүхдийн эмзэг байдал болон онцгой хэрэгцээнд тулгуурлан тэгш үйлчилнэ.

## 2.1.1 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБОЖ ӨГӨХ

ХХГХ-ийн хохирогчид дараах олон төрлийн байгууллагаар дамжин үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбогдож болно. Үүнд:

- Цагдаа, эрүүл мэнд болон нийгмийн үйчилгээ зэрэг төрийн байгууллага
- Түншлэгч Улс хоорондын байгууллага болон ТББ-ууд
- Элчин сайдын яамд, сүм хийд, сүмийн байгууллагууд, хүний эрхийн хуульчид
- Бусад хохирогчид, хохирогчийн найз нөхөд болон хамаатнууд
- Бэлгийн мөлжлэгийн зорилгоор худалдагдсан хүмүүсийн үйлчлүүлэгч нар

**Тэмдэглэл:** **Хэрвээ тухайн байгууллага ХХГХ-ийн хохирогчтой холбоо тогтоох мөн тэдэнд туслалцаа үзүүлэх боломжгүй бол эсвэл тэдэнд хэрэцээтэй зүйлсээр тусалж чадахгүй бол шаардлагатай туслалцааг үзүүлж чадах өөр байгууллагыг олж, тэдэнтэй заавал холбож өгөх талаар бүхий л арга хэмжээг авна.**

## 2.1.2 ХОХИРОГЧООР ТОДОРХОЙЛОН, ТОГТООХ ЗОРИЛГО

ХХГХ-ийн хохирогчийн үүднээс хандсан хүнийг ХХГХ-ийн хохирогчоор тодорхойлон, тогтоох маягтаар шалгаж үзэх нь чухал: Яагаад гэвэл тэр хүн Хууль бусаар хил нэвтрэх эсвэл өөр байдлаар цагаачилсан хүн байж болзошгүй эсвэл өөр төрлийн туслалцаа, хамгаалалт шаардлагатай хүчирхийлэл эсвэл эрсдэлтэй нөхцөлд орсон хүн байж болзошгүй. Түүнээс гадна хандсан уг хүн ХХГХ-ийн хохирогч биш, түүнд өөр төрлийн туслалцаа хэрэгтэй байж болохоос гадна үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг өөр зорилгоор ашиглах гэсэн бодолтой хүн байж болзошгүй гэдэг үүднээс зохих үнэлгээ явуулах шаардлагатай.

**ХХГХ-ийн хохирогч мөн гэж заавал нарийвчлан тодорхойлохын учир нь:**

- **Хүлээн авагч олон оронд ХХГХ-ийн хохирогчийг хууль бус цагаачлагч гэж ташаа ойлгож даруй тухайн улсаас албадан гаргадсан эсвэл сайтар тодорхойлогдолгүй хаяг тогтоох газарт хоригдож байж болно.**

- Ямарваа туслалцаа эрж буй олон хүмүүст шаардлагатай төрөл бүрийн туслалцаа, хамгаалал нь ХХГХ-ийн хохирогчдод шаардлагатай туслалцаанаас өөр байж болно.
- ХХГХ-ийн хохирогчид биеийн ба бэлгийн эрүүл мэндийн, сэтгэл санааны яаралтай үйлчилгээ шаардлагатай байхад хууль бусаар хил нэвтэрсэн болон өөр байдлаар хууль бусаар цагаачилсан хүмүүст энэ төрлийн үйлчилгээ тусlamжийн шаардлага ихэнх тохиолдолд илэрдэггүй байна.
- ХХГХ-ийн хохирогчид нь онц ноцтой гэмт хэргийн хохирогчид тул тэдэнд үйлчилгээ үзүүлж эхэлсэн цагаас эхлээд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнууд эрсдэлд орох тул юун түрүүнд аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээ, процедурууд бий болго шаардлагатай байдаг.
- Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь оргон зугатсан, эсвэл тэдний эсрэг мэдүүлэг өгсөн, эсвэл өгөх гэж байгаа хохирогчдын байгаа газрыг тогтоох оролдлого хийж ОУЫН төрийн байгууллага болон ТББ-аас үзүүлдэг дэмжлэг, туслалцаа болон дэмжих хөтөлбөрт нэвтрэн орж байсан тохиолдлууд байдаг.

ХХГХ-ийн хохирогчидтой ажиллах тухайд гэвэл, байгууллагуудад ХХГХ-ийн хохирогчдын талаар мэдээлэл авахаасаа илүүтэйгээр ХХГХ-ийн хохирогч биш ч бас тусламж шаардлагатай хүмүүсийн тухайлбал гэр булийн хүчирхийллийн эсвэл бэлгийн хүчирхийллийн хохирогч, жирэмсэлсэн өсвөр насынхан, эсвэл хууль бус цагаачдаас тусламж хүссэн хүсэлтүүд ирдэг. Хэрвээ үйлчилгээ үзүүлэгч байгууллага эдгээр хүмүүст тусалж чадахгүй бол тэдэнд шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг өөр бусад байгууллагуудтай холбож өгч болно. Тиймээс тэр талын зөвлөгөө, үйчилгээ үзүүлдэг байгууллагуудын жагсаалтыг байнга шинэчлэн, хадгалж байх шаардлагатай.

### 2.1.3 ТОДОРХОЙЛОН, ТОГТООХ ПРОЦЕССИЙН ХЯЗГААРЛАЛТ

Тодорхойлон, тогтоох процессийн талаар дэлгэрэнгүй ярилцахаас өмнө, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд дараах зүйлстэй танилцан тэдгээрийг мэдэж байх шаардлагатай:

- Уг процесс нь төгс төгөлдөр биш бөгөөд тийм байх ч боломжгүй юм, тиймээс ХХГХ-ийн хохирогчийн тодорхойлолт хийх явцад ямар ч алдаа гарахгүй гэдэгт баталгаа өгөх боломжгүй.

- Доор дурдсан процесс нь ХХГХ болон ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох ерөнхий хандлагад суурилсан болно.
- Үндэсний, бүсийн олон улсын түвшнээс хамаараад доор дурдагдах олон асуудлууд дээр үгүйсгэл, зөрчилдөөн гарах боловч тухайн асуудлуудыг үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрийн орон нутгийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөх нь чухал юм.
- Уг процесс нь тухайн орон нутгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрийн улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, ХХГХ-ийн хохирогчидтой ажилладаг арга туршлага, мэдлэгт тулгуурлан дэлгэрэнгүй болгон өөрчлөх шаардлагатай ерөнхий зохион бүтэц, загвар юм.
- Доорх маягт нь хамгийн төгс нөхцөлд хэрэглэх загвар маягт юм. Гэхдээ амьдрал дээрх туршлагаас харахад тэрхүү хамгийн төгс нөхцөл байдал ховорхон тохиолддог байна. Mash олон тохиолдолд тухайн хүн аливаа нэгэн болоод бүх асуултуудад хариулахыг хүсэхгүй эсвэл хариуцлах боломжгүй, мөн мэдээллийн нэмэлт эх үүвэр болгон ашиглах материал хангалтгүй байдгаас ярилцлагын өмнөх үнэлгээнд шаардлагатай мэдээллүүд хангалтгүй байдаг.
- ХХГХ-ийн хохирогчдыг танин тодорхойлох болон тогтоох нь тухайн орон нутгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтны туршлага, үзэл бодол болоод олж авах бололцоотой бүхий л мэдээллүүдээс тодорхойлолт гаргах чадвараас шууд хамаарна.

#### 2.1.4 ХХГХ-ИЙГ ОЙЛГОХ НЬ

Хохирогчдыг үр дүнтэй тодорхойлоход үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан тухайн хүнийг хууль бусаар хил нэвтрүүлэгчид, хүчирхийлэл үйлдэгч, эсвэл хүний эрхийг зөрчигчдийн (гэр булийн хүчирхийлэл) хохирогчдоос ялгаж чадах чадвартай байх ёстой. Эдгээр нь хэд хэдэн үзүүлэлтээр хоорондоо төсөөтэй байж болох ч эрүүгийн хуулийн өөр зүйл заалтаар шийтгэгддэг хоорондоо ялгаатай тохиолдлууд мөн. ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох болон тогтоон илрүүлэхэд бүхий л нөхцөл байдал, боломжтой мэдээллийг кейс болгон дээр цуглуулж, асуудалд дараах байдаар хандана:

- Хуулийн агуулга
- Оролцсон гэмт этгээдүүд
- Хохирогч

#### 2.1.4.1 Хуулийн агуулга

Тухайн хүн үнэхээр ХХГХ-ийн хохирогч мөн үү гэдгийг тодорхойлохын тулд хуулийн нэр томъёонд ХХГХ-ийг хэрхэн тодорхойлсон байдгийг сайтар мэдэх шаардлагатай. Танин тодорхойлох үйл явцад үйлчилгээ үзүүлэгч байгууллага НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоо ба шийтгэх тухай протоколын 3-р зүйлд дурьдсан тодорхойлолтыг сайтар мэдэх хэрэгтэй. Зарим бус нутаг өөрийн гэсэн Хүн худалдах Гэмт Хэргийн эсрэг Европын Зөвлөлтийн гаргасан конвенц-тэй адил төстэй тодорхойлолттой байж болох. Олон улс орон ХХГХ-тэй тэмцэх зорилгоор үндэсний хууль тогтоомж боловсруулан гаргасан билээ. Гэхдээ ХХГХ-ийн эсрэг боловсруулсан олон орны хууль тогтоомжууд НҮБ-ынхтай харьцуулбал үр дүнгийн хувьд аль нэг талаар дутуу байна. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд үйл ажиллагаа явуулахдаа өөрийн улс орны гаргасан хууль тогтоомжийг дагах нь тодорхой боловч тухайн улсын гаргасан хууль тогтоомж бол ХХГХ-т хандаж буй тухайн улсын төрийн эрх баригчдын хандлага мөн тул НҮБ-ын Протокол нь өөрсдийн гэсэн бүрэн дүүрэн ойлголт, баримтлалын бичиг баримтын хувьд чухал ач холбогдолтой юм. ХХГХ-ийн эсрэг үндэсний хууль тогтоомжгүй улс орны үйлчилгээ үзүүлэгч байгууллага НҮБ-ын Протоколыг үндсэн тодорхойлолт болгон ашиглаж болно. Ямар хууль журам үйлчилж байгаагас үл хамаараад гол зорилт нь кейс болгоныг судлан, хуулинд хэрхэн заасантай харьцуулахад оршино.

НҮБ-ын тодорхойлолын дагуу ХХГХ нь өөр хоорондоо хамаарал бүхий 3 элемент байж гэмт хэрэг үйлдэгдсэнд тооцогдоно гэжээ. Тэдгээр нь: (1) үйлдэл; (2) арга хэлбэр; (3) зорилго:

- **Үйлдэл нь** - элсүүлэлт, тээвэрлэлт, дамжуулалт, байрлуулалт эсвэл хүлээн авалт
- **Арга хэлбэр** - сүрдүүлэг, эсвэл хүч хэрэглэх, эсвэл хүнийг албадах, хулгайлах, залилах, хуурах, эрх мэдлээ ашиглах, эсвэл эмзэг байдлыг нь урвуулан ашиглах, эсвэл ямар нэгэн ашиг эсвэл мөнгө өгөх, авах улмаас нөгөө хүнийг эрхэндээ байлгаж буй хүний зөвшөөрлийг авах

- **Зорилго** - тус зүйл ангид дурьдсан байдлаар хүнийг мөлжлөгт өртүүлэх

Энэ З элементийн аль аль нь байж Протоколыг зөрчсөнд тооцогдоно: Үйлдэл нь аль нэг арга хэлбэрээр үйлдэгдсэн байж энэ хоёр зүйл хоёулаа мөлжлөг гэсэн нэг зорилгоор үйлдэгдсэн байх ёстой. Хэрвээ энэ З элементийн аль нэг нь байхгүй бол Палермо Протоколын 3-р зүйлд заасан гэмт үйлдлийн тодорхойлолттой нийцэхгүй байна гэсэн үг.

---

### **НҮБ-ЫН ХХГХ-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Үндэстэн Дамнасан Зохион Байгуулалттай Гэмт Хэргийн Эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн Нэмэлт Болох Хүн, Ялангуяа Эмэгтэйчүүд болон хүүхэд Худалдаалахаас Урьдилан Сэргийлэх, Taslan Зогсоо ба Шийтгэх Тухай Протокол, 2000 оны 1-р сард Сицилийн Палермо хот, 3-р зүйл: Нэр томъёо. Энэхүү Протоколын зорилгоор:

- (a) “хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтандaa байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Мөлжих гэдэгт наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно;
  - (b) энэхүү зүйлийн (a) дэд хэсэгт дурьдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах хэргийн хохирогч өөрийг нь (a) дэд хэсэгт дурдсанаар мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрсөнийг хэрэгсэхгүй;
  - (c) энэхүү зүйлийн (a) дэд хэсэгт дурьдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ.
  - (c) “Хүүхэд” гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.
-

Дараах тодорхойлолтууд ХХГХ-ийг Хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдлээс ялгаж ойлгоход тустай:

**Үйлдэл нь** - ХХГХ-нүүд болон Хууль бусаар хил давуулагч нар аль аль нь хүмүүсийг тээвэрлэж мөн дамжуулдаг - тиймээс энэ хоёр бүлгийн хүмүүс аль аль нь НҮБ-ын Протоколын эхэнд тодорхойлогдсон гэмт хэргийг үйлдэж байна.

**Арга барил** - хууль бусаар хил давуулагчид энгийн үед 3-р зүйлд заасан аргуудаас алийг нь ч хэрэглэдэггүй: энэ үйлдэлд хүний хүслийн эсрэг хүчээр, хууран мэхэлж, эсвэл эрх мэдлээр далайлгах байдлаар хийгддэг зүйл байхгүй. Тиймээс ХХГХ-ийн бүрэлдэхүүний нэг элемент нь үйлдэгдэгүй тул ХХГХ-ээс хууль бусаар хил давуулагчдын нэг ялгаа үүнд оршино

**Зорилго** - хэдийгээр Хууль бусаар хил давуулагчид өөрсдөөс нь хамааралтай болсон хүний эмзэг байдлыг ашиглан дарамтлах байдал гаргадаг ч тэд цагаачлагчдыг 3-р зүйлд заасан адил мөлжлэгт өртүүлэх зорилгоор үүнийгээ үйлддэг биш юм. Хууль бусаар хил давуулагчид болон хууль бусаар хил давагчдын хоорондын аль алиных нь харилцаа нь мөнгө төлөн нэг орноос гарч нөгөө оронд хүрэх. Цагаачлагч нөгөө улсад очоод цаашид хэрхэх нь Хууль бусаар хил давуулагчид огт хамаагүй бөгөөд үүгээрээ мөн ХХГХ-нээс ялгаатай.

**ХХГХ болон Хууль бусаар хил давуулах үйлдлийг хоорондын холбоос**

ХХГХ-ийн хохирогч ихэнх тохиолдолд уг үйлдэлд эхэндээ сайн дураараа оролцож байгаа мэт байдаг. Гэхдээ, хууль бусаар хил нэвтрүүлэгч ба хууль бусаар хил нэвтрэгч хоёрын харилцаа зорьсон улсдаа очсоноор хязгаарлагдалгүй хүрэх ёстай газраа очсоны дараа хууль бусаар хил давуулагч нь хууль бусаар бусаар цагаачлагчийг (эрэгтэй ба эмэгтэй аль ч тохиолдолд) дээр дурьдсан байдлаар мөлжлэгийн нөхцөлд байлгаж, албадан хөпөлмөр хийлгэвэл нөхцөл байдал Хууль бусаар хил давуулах асуудал биш харин ХХГХ болно. Хууль бусаар хил нэвтрэгчид нь тухайн орондоо очсоны дараа ихэнхдээ ХХГХ-т өртөмхий эмзэг байдаг. Хууль бусаар цагаачилагч тухайн улсад очсоныхoo дараа элсүүлэгдэж, тээвэрлэгдэж, түүнийг хууль бусаар хил нэвтрүүлсэнтэй огт хамааралгүй өөр хэн нэгэн түүнийг мөлжлэгт өртүүлж болно. Жишээлбэл: АНУ-д Мексикчууд маш ихээр хууль

**бусаар хил даван цагаачилж орж ирдэг бөгөөд дараа нь ХХГХ гэмт этээдүүд тэднийг эмзэг байдалд байхад нь олж авч элсүүлж, тус улсын өөр нэг хэсэг рүү худалдан албадан хөдөлмөр хийлгэдэг.**

---

ХХГХ болон Хууль бусаар хил нэвтрүүлэх хоёрын хоорондын цаашдын ялгааг хуулийн хүрээнд гаргахын тулд олон улсын хуульчдын боловсруулан гаргасан Хууль бусаар хил давуулагчдын Протоколыг судлаж болно. ХХГХ болон Хууль бусаар хил нэвтрүүлэгхийн эсрэг протоколын хоорондын гол ялгаа нь юуны түрүүнд гэмт этгээдүүдэд оногдох шүүхийн ялын хэмжээгээр тодорхойлогдсон байгаа. Хууль бусаар хил нэвтрүүлэгчдийн Протоколд гол анхаарал нь хохирогчид биш тухайн аль нэг Улсын Хилийг хууль бусаар зөрчсөн явдалд чиглэсэн байгаа. “Хохирогч” гэсэн үг энэ Протоколд хэрэглэгдээгүй бөгөөд тухайн тохиолдолд тухайн Улс өөрөө “хохирогч” тал болж байгаа. Үүнээс гадна ХХГХ нь Гадаад болон улс дотроо дотооддоо үйлдэгддэг бөгөөд хүмүүсийн нэг газраас нөгөө байрлалд шилжүүлсэн хөдөлгөөн нь хууль бус болон хуулийн дагуу аль ч байдаар үйлдэгдэж болно. Хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдэл нь харин эсрэгээрээ олон улсын хилийг хууль бусаар нэвтэрдэг байгаа..

---

### **НҮБ-ЫН ХУУЛЬ БУСААР ХИЛ НЭВТРҮҮЛЭХИЙН ЭСРЭГ Протокол**

**НҮБ-ЫН Цагаачдыг Газраар, Далай Тэнгисээр болон Агаараар Хууль бусаар хил нэвтрүүлэхийн эсрэг Протокол:**

- (a) **“Цагаачдыг хууль бусаар хил нэвтрүүлэх” нь шууд болон шууд бус санхүүгийн ашгийн улмаас хэн нэгэн хүнийг хууль бусаар тухайн хүн иргэн нь биш, мөн байнга амьдран суудаггүй Улсын хилээр нэвтрүүлэхийг хэлнэ.**
  - (b) **“Хууль бусаар хил нэвтрэх” гэдэгт хилээр хуулинд заасан дагуу хууль ёсны нэвтрэх шаардлагатай бичиг баримтгүйгээр нэвтрэхийг хэлнэ.**
- 

#### **2.1.4.2 Гэмт хэрэгтэн**

Хууль бусаар хил нэвтрүүлэгчийг ХХГХ-тнээс ялгах дараагийн ялгаа нь гэмт хэргийг гэмт хэрэгтний нүдээр харж: энэ гэмт хэргийн зорилго нь юу байв? гэж асуухад оршино. ХХГХ-тэн Хууль бусаар хүнийг хил нэвтрүүлэгчээс ялгагдах ялгаа нь тэд гуравдагч оронд эсвэл очиходор зорьж байсан газраа очсоныхоо дараа

хүнийг албадлагын дор аль болох удаан хугацаагаар, мөлжлөгт өртүүлэн тэр үйлдээсээ өөртөө ашиг олох явдал юм. Хууль бусаар хил нэвтрүүлэгчдийн тухайд гэвэл хууль бусаар хил нэвтрүүлэгч нь хууль бусаар хил нэвтрэгч хилийн зурvasыг хууль бусаар нэвтэрсний дараагаар, төлбөрөө авсанаар тэдний хоорондын харилцаа дуусгавар болдог. Албадлага бол энэ хоёр гэмт хэргийг хооронд нь ялгах нэг том түлхүүр үйлдэл бөгөөд ХХГХ-т өртсөн хохирогч ХХГХ үйлдэгчийн зүгээс ноцтой эрсдэлд өртөхгүйгээр өөрийн сайн дураар салан холдох эрхгүй байдагт оршино.

#### 2.1.4.3 Хохирогч

Гурав дахь асуудал бол энэ асуудлуудад хохирогчийн зүгээс хандаж түүнд ямар зүйл тулгарч, ямар хор хохирол учруулсаныг тооцох. Хууль бусаар хил нэвтэрсэн цагаачдын хувьд гэвэл тэд хууль бусаар хил нэвтрэх үед тохиолдож болзошгүй гэмтэл, бэртэл, дарамт тэр байтугай үхлийн эрсдэлтэй явдаг ч гэмт этгээдүүдийн хууль бус зорилгын улмаас албадсан, хуурсан ямар ч элемент байдаггүй<sup>2</sup>. Хууль бусаар хил нэвтрэх тээвэрлэлтийн үед цагаачид ноцтой хүндрэл, аюултай тулгардаг ч тэдэнд байнгын биеийн, бэлгийн болон сэтгэл зүйн хүчирхийлэл эсвэл эрх чөлөөгөө хасуулах болон удаан хугацааны туршид бэлгийн үйлдвэрлэлд эсвэл хууль бус хөдөлмөрийн зах зээлд ашиглагдан мөлжигдэх аюулд өртдөггүй. Гэхдээ эдгээр бүгд биш юмаа гэхэд ихэнх элементүүд нь ХХГХ-т үйлдэгддэг.

ХХГХ улс дотроо үйлдэгдэх тохиолдолд хуучны ёс заншил эсвэл орчин үеийн заншил гэдийг хооронд нь ялгахад бэрхтэй тул ХХГХ-тэн эсвэл хохирогчийг тодорхойлоход хундрэлтэй зүйлсүүд их байдаг. Жишээлбэл Афганистанд, эмэгтэйчүүд охидыг өрөнд өгөх эсвэл хоёр талын цусан өшөөг дуусгахад төлөөс болгон өгч болдог. Эмэгтэй эсвэл охин үгүй гэж хэлэхгүй бөгөөд шинэ нөхөр болон шинэ нөхрийн гэр бүлийн хяналтанд байж тухайн гэр бүлд гэрийн болон бэлгийн үйлчлэгч болдог. Индонезид арай баян хамаатныдаа хүүхдээ илгээж зарцуулдаг заншил байдаг. Тэдгээр хүүхдүүд<sup>3</sup> маш бага насных байдаг бөгөөд ажил олгогчоос хамаараад биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх, удаан цагаар ажиллах, маш бага эсвэл огт цалингүй ажиллах, чанаргүй хоол хүнс хэрэглэх, муу байранд байрлаж, боловсрол эзэмших болон тоглох ямар ч боломжгүй байдаг. Ихэнх

тохиолдолд эдгээр заншлын чанартай үйлдлүүд нийгэмд бат бэх суурьшсан байх бөгөөд түүнийг хэн ч зүй бус гэж тооцдоггүй. Эдгээр заншлуудыг хохирогчийн нүдээр, НҮБ-ын Протоколын хүрээнд авч хэлэлцэх ёстой. Тодорхой тохиолдол бүр тус бүрийг дүн шинжилгээнд хамруулж ХХГХ-ийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг тогтоох шаардлагатай.

#### **2.1.4.4 ХХГХ-ИЙН ҮЗЭГДЭЛ**

Хохирогчтой уулзан ярилцах хүн ХХГХ-ийн үндсэн ойлголттой байх шаардлагатай. Дараах зүйлсэд ХХГХ хэмээх хүнд гэмт хэргийн талаарх бүрэн ойлголт болон түүнтэй холбоотой хандлагыг тусгахаар зорьсон болно. Эдгээр хандлагууд бүсээс бүсэд болон улсаас улсад цаг хугацаанаас хамаараад өөрчлөгдөх хандлагатай байгаа нь энэ гэмт хэргийг үйлдэгчид баригдахгүйн тулд арга барилаа өөрчилснөөс үүссэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс, дараах нь - гэмт хэрэг гарах үндэслэлийн ерөнхий зураглал бөгөөд тэдгээрийг үйлчилгээ үзүүлэгч байгууллага тухайн орон нутгийн болон бүсийн онцлогт тохируулан өөрчлөн, ашиглах шаардлагатай.

#### **ХХГХ-ийн масштаб, хэмжээ**

Төрөл бүрийн оролцогч байгууллагуудын тодорхойлолтын ялгаа, мөлжлөг үйлдэгдэж байсан газруудад хийгдсэн мониторингийн хязгаарлагдмал байдал болон гэмт этгээдүүдийн нуугдах стратеги зэрэг шалтгаануудаас улбаалаад ХХГХ-ийг тодорхой хэмжээ, масштаб хэзээ ч нарийвчлагдан хэмжигдэж байгаагүй. Тэхээр хохирогчдын тоо мэдээ өөр өөрөөр бүртгэгдсэн гэсэн үг. Жишээлбэл: 2005 онд АНУ-ын ХХГХ-ийн албан ёсны тайландаа ойролцоогоор 600,000-800,000 хүн олон улсын хил дамнуулан жил бүр худаалдагдаж байна гэсэн тоо гарсан бол, (улс орнуудын дотооддоо үйлдэгдэх ХХГХ-ийг үл тооцон);<sup>4</sup> ЮНИСЕФ жил бүр 1,2 сая хүүхэд энэ гэмт хэрэгт өргөж байна гэжээ<sup>5</sup>, гэтэл ОУХБ 12,3 сая хүн дэлхий даяар албадан хөдөлмөр хийж байгаа бөгөөд тэдгээрийн 2,4 сая нь ХХГХ-ийн хохирогчид гэжээ.<sup>6</sup>

#### **Мөлжлөгийн хэлбэрүүд**

ХХГХ-ийн ихэнх хохирогчид бэлгийн эсвэл албадан хөдөлмөрийн

үйлчилгээний мөлжлөгийн аль нөхцөлд өртөн дуусч байгаа нь тодорхойгүй ч бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдэж буй ХХГХ одоогийн байдлаар хамгийн өргөн тархалттай байна гэж хүлээн зөвшөөрөгдсөн. Энэ нь ХХГХ-ийн гэмт этгээдүүдэд хамгийн ашиг орлоготой бөгөөд хохирогчийг өдөр болгон биеийн, бэлгийн болон сэтгэл санааны хувьд хүчирхийлэлд байлгадагийн үндсэн дээр биеийн болон бэлгийн байдлаар хамгийн их хор хохирол учруулдаг гэмт хэрэг юм.

ХХГХ-ийн мөлжлөгийн аль хэлбэр илүүтэй үйлдэгдэж байгааг хэлэхэд хүндрэлтэй бөгөөд байршилаас хамааран өөр өөр байна. Жишээ нь: одоогийн байдлаар Европын холбооны улсуудад ХХГХ бэлгийн мөлжлөгийн зориулалтаар үйлдэгдэх нь хамгийн элбэг тохиолдож байна. Дэлхийн бусад бүсүүдээр, яланагуяа Төв болон Зүүн-Өмнөд Азийн нутгаар, Өмнөд болон Баруун Африкаар, Өмнөд болон Төв Америкаар нөхцөл байдал тодорхой бус бөгөөд тэнд ХХГХ газар тариалан, үйлдвэрийн газар, эсвэл гудамжны гүйланчлах, эсвэл юм заруулах зорилгоор илүүтэйгээр үйлдэгдэж байна. Дотоод болон гадаадад үйлдэгдэж байгаа ХХГХ-ийг дэлхийн хэмжээнд авч үзвэл албадан хөдөлмөрлүүэх зорилгоор үйлдэгдэж байгаа ХХГХ бүхэлдээ нэг том зүйл болж байна гэж үзэж болно. Эдгээр үндэсний болон бусийн ялгаанууд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хохирогчийг тодорхойлох ажлыг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулах шаардлагыг бий болгож байна.

### ХХГХ-ийн хохирогчид

Мөн дээр дурдсанчлан энэ гэмт хэрэгт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль нь илүүтэйгээр өртсөнийг тодорхойлох боломжгүй юм. Хамгийн найдвартай хэмээн хэлж болох зүйл бол дэлхий даяар ХХГХ-ийн хохирогчид илүүтэйгээр эмэгтэйчүүд, хүүхдүүд өртөж байгаа ч зарим нэг улс орон, бус нутагт энэ байдал өөр байж залуу хөвгүүд, эрэгтэй хүүхдүүдийг хөдөлмөр эсвэл цэрэгт ашиглах зорилгоор энэ гэмт хэрэгт өртүүлдэг. Үндэсний болон бусийн ялгаанууд болон онцлогууд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад эдгээр ялгаануудыг анхааралдаа аван дор дурдсан хоёр үе шат бүхий хохирогч тодорхойлох үйл явцын эхнийх нь болох Ярилцлагын-Өмнөх Тодорхойлолт үзүүлэлтэнд авч үзэх хэрэгтэй.

## 2.2 Урьдчилсан-ярилцлаганы тодорхойлолтын үзүүлэлт

Хохирогчоор тодорхойлох үйл явц нь 2 шатаас бүрддэг:

- Тухайн хүнтэй ярилцлага хийхээс өмнө, урьдчилан хийгдсэн тодорхойлолтод хамрагдсан үзүүлэлтийн хүрээний тодорхойлолт.
- Тухайн хүнтэй хийх ярилцлага нь ХХГХ-т өртсөнийн дараах элсүүлэлт, тээвэрлэлт, болон мөлжлөг чиглэсэн багц асуултуудаас бүрдэнэ.

Тодорхойлох болон таних олон талын үйл явц нь тухайн хүнд ХХГХ-ийн талаарх тодорхой асуултууд тавьж эхлэхээс өмнө кейс болгоны нөхцөл байдлыг ажиглан судлахаас эхэлнэ. Дараах сэдвийн дагуух мэдээллүүд нь холбоо барьж уулзсан байгууллагаас эсвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тусламж хүсэн ирсэн хувь хүнээс өөрөөс нь урьдчилсан ерөнхий асуултуудаар авагдаж болно.

### Үзүүлэлтүүдтэй холбоотой зарим нэгэн сээрэмжлүүлгүүд

Доор дурдсан үзүүлэлтүүд нь тодорхойлолтын бүхий л үйл явцад шаардлагатай мэдээллийн туслалцаа үзүүлэх зориулалттай бөгөөд ерөнхий агууламжтай тул аль нь ч хасагдаж болно. Тухайн орон нутгийн онцлог, нөхцөл байдал, туршлага нь нэмэлт үзүүлэлтүүдийг бий болгох эсвэл үзүүлэлтүүдийг нөхцөл байдалд тохиуулах гэсэн зүй ёсны хэрэгцээ бий болгох магадлалтай. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд үйл явцыг нөхцөл байдалд хэрэгцээтэй байдлаар тохиуулах болон өргөтгөх нь зүйтэй. Бүхий л үзүүлэлтүүдийг багцаар нь бүхэлд нь авч үзэх шаардлагатай, яагаад гэвэл үзүүлэлтүүд дангаараа ямар ч үр дүн өгөхгүй.

Дараах үзүүлэлтүүдийг анхааралдаа авах шаардлагатай:

*Нас*

ХХГХ-т хүүхдүүд болон бага залуу өсвөр насынхан өртөх явдал өсөж байгааг бүхий л үзүүлэлтүүд харуулж байна. Ерөнхийд нь гэвэл хүний нас өсөх тусам ХХГХ-т өртөх магадлал буурна гэж үзэж магадлалтай.

Бэлгийн мөлжлөг эсвэл албадан хөдөлмөрийн зорилгоор үйлдэгдэх байгаа ХХГХ нь залуу хохирогч нарт илүүтэйгээр төвлөрч байгаа нь боолчлолын нөхцөлд хүнд хэцүү биеийн хөдөлмөрийг нас залуу, хяналтандaa байлгахад дөхөм хүмүүс л гүйцэтгэж чадна гэдгийг гэмт этгээдүүд болон тэдний хамсаатнууд мэддэгт оршино. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгддэг ХХГХ нь мөн дээрхтэй ижил төлөвтэй байна. Эрхтэнийг нь доноорт ашигладаг гэмт үйлдлийн тухайд гэвэл залуу болон тохиромжтой хүн байх тусамаа ХХГХ этгээдүүд болон тэдний худалдан авагчдад ашигтай байдаг байна. Түүнээс гадна залуу бага хүмүүс илүү амархан хууртагдаж, хүч албадлагад автан, хяналтанд байлгахад хялбар байдаг онцлогийг гэмт хэрэгтнүүд ашигладаг.

Гэхдээ насаар ахимаг хүмүүс мөн ХХГХ-т өртдөг, жишээлбэл: Зүүн-Өмнөд Азид арай ахимаг насны хохирогчид Тайландруу худалдагдан тэнд гудамжинд гуylanчилж байсан байна. Мөн эмэгтэйчүүдийн хийж чадах гэрийн үйлчлэгч, эсвэл оёдолчны ажилд нас харгалздаггүй байна.

ХХГХ-ийн олон үзүүлэлтийн нэг нь л нас байж болох ч хохирогчдын ихэнх нь залуу хүмүүс байсан хэвээр байна. ХХГХ-т өртөж буй насанд хүрээгүй хүүхдийн тоо жил ирэх тусам өсөж байна. Тэд энэ гэмт хэргийн олон хэлбэрт ашиглагдаж болох учраас өртөмхий хэвээр байна, үүнд: бэлгийн үйлдвэрлэл, хууль бус хөдөлмөрийн зах зээл, цэрэг дайны үйлчилгээ, хулгай дээрэм эсвэл бусад гэмт хэргийн үйлдлүүд, гэрийн үйлчлэгч болон эрхтэний донор зэрэг орно.

### Хүйс

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгддэг ХХГХ нь эмэгтэйчүүд, охидыг илүү өртүүлдэг нь гетеросексуаль биеэ үнэлэлт нь хамгийн их ашиг орлого олдог мөлжлөгийн төрөл хэлбэр хэвээр байгаад оршино. Гэхдээ эрэгтэй хүмүүсийг бэлгийн мөлжлөгт ашиглах, ХХГХ-т өртүүлэх нь ялангуяа өсвөр насны болон залуу хөвгүүдэд тохиолдох нь өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд энэ асуудал таслан зогсоодго ёстай билээ. Сүүлийн үеийн тагнуулын мэдээллээр бол педофил хүчирхийлэл, бэлгийн аялал, мөн ашгийн болон ашгийн бус зориулалтаар хүүхдийн

оролцоотой порнограф үйлдвэрлэлд эрэгтэй, эмэгтэй хүүхэд аль нь ч өртөж байгаа бөгөөд энэ зорилгоор ХХГХ улс орон дотроо болон гадаад үйлзгэдэх нь нэмэгдэх хандлагатай байна гэжээ. Албадан хөдөлмөрийн зорилгоор үйлэгдэх ХХГХ-ийн хувьд хүйсийн онцлог нь тухайн хийгдэх ажлаас хамаардаг бөгөөд уул уурхай, газар шорооны болон загасчлах зэрэгт илүүтэйгээр эрэгтэй хүмүүс өртдөг. Мөн эсрэгээрээ тухайн ажил арай хөнгөн ургац хураах, газар тариалангийн эсвэл үйлдвэрлэлийн эсвэл гэрийн үйлчлэгчийн ажил бол эмэгтэйчүүд илүүтэйгээр өртдөг. Бүхий л насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг тухайн бүс нутагт мөлжлэгт өртүүлдэг бөгөөд эрэгтэй хүн болон хүүхдүүдийг уул уурхай, загасчлах, ургац хураах хөдөлмөрт мөлждөг бол охид, эмэгтэйчүүдийг цаг наргүй үйлдвэрлэл болон гэрийн үйлчлэгчийн ажилд илүүтэйгээр ашигладаг байна.

### *Яс үндэс, үндэс угсаа*

Хохирогчдын нийтлэг байдал нь ихэвчлэн ядуурал, ялгаварлан гадуурхалт, болон хомс боломж зэрэг хүчин зүйлүүдэд байдаг. Мөн хөгжингүй, үйлдвэржсэн орноос энэ гэмт хэрэгт өртсөн хүн бас байдгийг үгүйсгэж болохгүй. Тийм тохиолдлууд байдаг. Ялангуяа АНУ гэх мэт хөгжингүй, үйлдвэржсэн улсад улс дотроо энэ гэмт хэрэг үйлдэгдсэн байсан нь хүүхдийг бэлгийн мөлжлэгийн зорилгоор энэ гэмт хэрэгт өртүүлсэн тохиолдол байдаг байна. Мөн түүнчлэн зарим нэг газар үндэсний цөөнх бусад бүлгүүдийг бодвол энэ гэмт хэрэгт өртөх магадлал илүү байдаг. Энэ тохиолдолд орон нутгийн, бусийн, үндэсний нэхцэл байдал болон тэнд үйлдэгддэг ХХГХ-ийн хандлагын талаар сайтар мэдэх нь чухал. Дотоодод болон бусийн хэмжээнд үйлдэгддэг ХХГХ нь улс доторх зарим хот болон зарим улс нөгөө бусдыгаа дарамтанд оруулах байдлыг бий болгодог. Эдийн засгийн хөгжил, үйлчлүүлэгчийн хүсэлт нь энэ чиглэл, цар хүрээ болон орон нутагт, бусэд болон олон улсын хэмжээнд энэ гэмт хэрэг өсөхөд нөлөөлөгч гол хүчин зүйл болдог.

### *Баримтжуулалт*

ХХГХ-ийн үйлдэгдэж байгаа газар зүйн байршил холбогдох бичиг баримтны хэрэглээнд чухал нөлөөтэй. Хэрвээ гэмт хэрэг улс дотроо үйлдэгдэж байгаа бол бичиг баримтны хэрэглээний

шаардлага гадаад улсад үйлдэгдэхээс хамаагүй бага байх нь тодорхой. Хэрвээ тухайн улс оронд биеийн байцаалт бичиг баримтыг байнга биедээ авч явах шаардлага тавигддагүй бол энэ нь гэмт этгээдүүдэд хохирогчийн бичиг баримтыг устган тэднийг эрхэндээ байгахад илүү дөхөм болгодог. Мөн бусийн хүрээнд жинхэнэ болон хуурамч бичиг баримт хэрэглэх шаардлага түгээмэл биш байж болно, яагаад гэвэл хохирогчид ялангуяа хүүхдүүд ямар нэгэн биеийн байцаалт авч явдаггүй, “ногоон” хилээр нууцаар тээвэрлэгддэг. Дахин хэлэхэд энэ нь тухайн улс орон болон бус нутгийн онцлог бөгөөд хилийн хяналтын бүхий л байдлаас үүдээд бичиг баримтыг хуурамчаар үйлдэхэд хялбар эсвэл хүндрэлтэй болгосон байдаг. Бичиг баримтны хэрэглээ ялангуяа тив хооронд үйлдэгдэх ХХГХ-ийн үед заавал шаардлагатай байдаг бөгөөд энэ нь онгоц, галт тэрэг, эсвэл усан онгоцоор зорчих болдогоос хамаараад хилээр нэвтрэхэд тухайн хүний хэн болохыг тодорохойлох бичиг баримт заавал шаарддагтай холбоотой. Бичиг баримтууд үнэхээр хохирогчийн хэн болохыг баталсан жинхэнэ байж болох ч гэмт этгээдүүд мөн хуурамчаар нэр болон яс үндэс заах мөн насанд хүрээгүй хүүхдийн насыг нуух зорилгоор нэмж бичсэн байх нь элбэг тохиолддог. Энэ тохиолдлуудад гэмт этгээдүүд хохирогчдод өөрийнх нь бичиг браимтыг хилийн шалган нэвтрүүлэх эсвэл цагдаагийн шалгалт өнгөртөл байлгаж байгаад дараа нь хураагаад авчишдаг. Бусийн болоод тив хооронд бэлгийн мөлжлийн зорилгоор ХХГХ үйлэгдэх үед гэмт этгээдүүд хохирогчийг хянах, айлан сүрдүүлэх болон албадах механизм болгон хэрэглэх зорилгоор бичиг баримтыг нь хураан авдаг бөгөөд энэ тохиолдолд хохирогч бичиг баримтгүй байх нь ХХГХ-ийн илрэлийн нэг том үзүүлэлт юм. Гэхдээ үүнд анхаарвал зохих бас нэг зүйл байдаг нь орогнол хүссэгчид болон зарим тохиолдолд хууль бусаар хил нэвтрэгчид байх бөгөөд кейс болгоныг нөхцөл байдалтай нь нарийн уялдуудан авч үзэх хэрэгтэй.

### Сүүлчийн байршил

Хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж ирэх үед байрлаж байсан, мөлжлөгт байсан сүүлийн байрлал нь чухал ач холбогдол бүхий үзүүлэлт болдог. Жишээлбэл: тухайн хүний уул уурхай, газар тариалан, үйлдвэрийн газар, ресторан хоолны газрын гол тогоо, загасчлалын онгоц, гэрийн үйлчилгээ, эсвэл бэлгийн мөлжлөгийн биеэ үнэлэлтийн газар, дуудлагаар охидоор

үйлчилдэг газар, баар, зочид буудал, болон түүнтэй ижил төстэй газруудаас хохирогч олдсон бол тэдгээр нь ХХГХ-ийн үйлдэлтэй байнга хаяалж байдаг учраас ХХГХ-ийн чухал үзүүлэлт болно.

### *Агуулга*

Хандах болсон шалтгаан мөн чухал үзүүлэлт болно. Хохирогчийг хандуулсан байгууллагаас тэдний талаар аль болох их мэдээлэл авахаар сайтар асуун лавлах хэрэгтэй. Жишээлбэл: биеэ үнэлэлтийн газраас цагдаа нар гаргаж ирсэн бол, эсвэл “үйлчлүүлэгч нь тусалсан” бол, эсвэл цагаачлал болон цагдаагийнхны шалгалтаар илэрсэн гэхчилэн. Түншлэгч бусад ТББ-үүд хохирогчийг суллаж эсвэл тодорхойлж ирүүлсэн бол хохирогчийг тодорхойлон тогтоох асуудалд улам дөхөмтэй.

### *Хүчирхийллийн ул мөр*

Биеийн хүчирхийллийн аливаа ул мөр нь ХХГХ-ийн хохирогч байх магадлалыг нэмэгдүүлэх үзүүлэлт мөн. Хүний худалдагч гэмт этгээдүүд хохирогчдыг биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд байнга өртүүлдэг нь Хууль бусаар хил нэвтрэгч хүмүүсээс ихэнхдээ илэрдэггүй. Тодорхойлох тэрхүү гол зүйл буюу хүчирхийллийн асуудлаар мэдээлэл болгон ашиглаж болох гол зүйл нь хүчирхийллийн үргэлжилсэн байдлын илрэл юм. Хууль бусаар хил нэвтэрсэн хүмүүс хүчирхийлэлд өтрөх, эрсдэлд орох мөн хэд хэдэн тохиодллоос хараход тээвэрлэлтийн явцад амь насаа алдах зэрэг тохиолдол байдаг ч ХХГХ болон Хууль бусаар хил нэвтэрсэн хоёрын аль тохиолдол вэ гэдгийг ялгахад хүчирхийлэл тэр тусамаа үргэлжилсэн хүчирхийллийн ул мөр болон шинэ газар ирсэнийхээ дараагаар гэмт этгээдүүд тэднийг албадсан, хууран мэхэлсэн, мөлжлөгт ашиглагдсан зэрэг ХХГХ гэмт этгээдүүдтэй харьцсан байх шинж тэмдгүүд юм.

### *Хандуулж ирсэн байгууллагын тодорхойлолт*

Энэ салбарт ажилладаг мэргэжлийн байгууллагын үүн дотроо хууль хэрэгжүүлэгч байгууллага, цагаачлалын байгууллага болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагудын тодорхойлолт болон үзэл хандлага нь тодорхойлон тогтоох үйл явцад хэрэгцээтэй бөгөөд ерөнхий тодорхойлолтын явцад тэд мөн оролцох шаардлагтай.

Үйлчилгээ үзүүлж буй байгууллагын мэдлэг, туршилага

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд дээр дурдсан бүхий л элементийг үнэлж, тэдний олж авсан мэдээлэл тухайн газар оронд үйлдэгддэг ХХГХ-ийн хандлага, арга барилтай нийцэж байгаа эсэхэд өөрсдийн ажлын туршилага, мэдлэгт тулгуурлан үнэлгээ хийх шаардлагатай.

---

Үзүүлэлт болгон нэг болон түүнээс дээш байдлаар тайлбарлагдаж болно. Тиймээс ч тодорхойлон тогтоох үйл явцад тэднийг цогцоор нь авч үзэх нь илүү ач холбогдолтой.

---

## 2.3 Тодорхойлон тогтоох ярилцлага

### 2.3.1 НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХЭДТЭЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХДЭЭ ОНЦГОЙЛОН АНХААРАХ ЗҮЙЛС<sup>7</sup>

Дараахи удирдамж нь насанд хүрээгүй хүүхэдтэй (18 нас хүрээгүй хүн болгон) ярилцлага хийхэд зориулсан болно. Ярилцлага хийх болон халамж үзүүлэх нэмэлт удирдамжийн талаар бүлэг 5 болон 6-аас уншина уу:

- Хүүхдийн эрх болон онцгой хэрэгцээний талаарх тусгай сургалтанд сургагдсан ажилтан хохирогч хүүхэдтэй ярилцлага хийнэ. Хэрвээ боломжтой бол хүүхэдтэй ижил хүйсийн хүн ярилцах нь зүйтэй.
- Ярилцлагаас өмнө хүүхдийн хэргийн/кейсийн талаар аль болох илүү мэдэж, хүүхдэд ойлгомжтой бөгөөд нөхөрсөг байдлаар ярилцах. (хүүхдэд танил, тэдний мэддэг зүйслийн талаар эхэлж ярилцаж эхэлж харилцаа тогтоох)
- Аюулгүй бөгөөд тохилог орон зайд бий болгох (харилцаа үүсгэх тоглоом, ном, г.м.)
- ХХГХ-тэй холбогдолгүй зүйслийн талаар эхэлж ярилцан харилцаа үүсгэх (хүүхдийн сайн мэддэг зүйс буюу жишээлбэл тоглоомын талаар ч юм уу).
- Ярилцахад тохиромжтой цагийг сонго, огцом сандруу байж болохгүй
- Ур амьсгалыг энгийн бөгөөд албан бус байдалтай байлгах

- хэрэгтэй, ж нь: асуултад хариулт нэхэн юмуу байцаалт авч байгаа шинжтэй байж болохгүй
- Хүүхдэд ойлгомжтой энгийн хэлээр ярилц (хүүхдийн хэрэглэдэг үг хэллэгийг ашигла)
  - Аливаа юмсыг хүүхэд ойлгоход дөхөм байдлаар тайлбарлаж өгөх хэрэгтэй (шаардлагатай үед харуулах үзүүлэнг хэрэглэх).
  - Асуултууд хүүхдийн нас, оюун ухааны хөгжилд тохирсон байх
  - Асуултаяа тодорхой нэг хариулт авахаар тавьж, хүүхдэд өөрийн санал бодлоор хариулах боломж олго. Чиглүүлэх ж нь: “Тэр хүн чамайг хүчирхийлсэн уу?” г.м. асуултнаас болох зайлсхийж, илүү нээлттэй “Тэр хүн чамайг яасан бэ?” гэж асуух.
  - Хүүхэд мэдэж байгаа зүйлээ нууж байгаа санагдсан ч нарийвчлан асуух, шалгаах хэрэггүй. Гэхдээ зөв асуулт тавьж чадахгүй бол хүүхэд үнэн хариултыг хэлэлгүй өөрийнх нь бодлоор асуулт тавигчийн сонсохыг хүсэж байна гэж санагдсан хариултыг хэлэх болно гэдгийг санах хэрэгтэй.
  - Насанд хүрээгүй хүүхэдтэй ярилцлага хийхдээ эцэг эхийг нь хамт байлцуулвал зүгээр. Эцэг эх нь байлцах боломжгүй тохиолдолд эсвэл эцэг эх нь сэжигтэн эсвэл гэр бүлийнхэн нь ХХГХ-т холбоотой гэж мэдэгдэх тохиолдолд тусгай сургагдсан асран хамгаалагч, сэтгэл зүйч, эсвэл нийгмийн ажилтанг байлцуулна.
  - Ярилцлага дуусах явцад хүүхдэд түүнийг зөв зүйл хийлээ, тэгээд үүнээс хойш хэрвээ ярилцах шаардлага гарвал өөрийгөө хэзээд бэлэн байж уулзана гэж төгсгөх.<sup>8</sup>

### 2.3.2 ХОХИРОГЧИЙН ХАРИУ ХАНДЛАГА БОЛОН ТҮҮНТЭЙ ХАРЬЦАХ

- 
- Тухайн хүн ХХГХ-ийн хохирогч, эсвэл Хууль бусаар хил нэвтрэгч эсвэл хууль бус цагаач аль нь ч байсан, мөлжлэгт өртсөн ч, хүчирхийлэгдсэн, эсвэл өөр ямар нэгэн байдлаар эмзэг байдалтай болсон хүн бол тухайн хүнд аливаа хүний эрхийг хүндэтгэх үүднээс түүнийг ойлгож тусалж, түүнтэй харьцах шаардлагатай.
  - ХХГХ-ийн хохирогчтой ярилцлага хийхдэд зөвлөмж удирдамж болгож гаргасан ХХГХ-т өртсөн хүнтэй ярилцлага хийх болон халамж үзүүлэх Ёс Зүйн Зарчмууд доор дурдагдсан байгаа.
-

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтанд хувь хүний өөрийн болгоомж, хэнд ч болтугай үл итгэх, мэдээллийг чанадлах чадварынхаа ачаар амь гаран зугатааж, оргож чадсан хохирогчтой тодорхойлон тогтоох ярилцлага хийхэд хүнд шалгур болж магадгүй. Тодорхойлох ярилцлагын явцад нөгөө хүн ярилцлага авагчтай цочролд орсон, дайсагнасан, үл итгэсэн, уур хилэнтэй, өөрийгөө хамгаалах байр сууринаас эсвэл эдгээрийн аль аль нь хосолсон байдлаар харьцах нь ХХГХ-ийн хохирогчийн хувьд түгээмэл тохиолддог. Энэ нь эхний ярилцлагын үед тухайн хүн үнэхээр ХХГХ-ийн хохирогч мөн эсэхийг тодруулах мэдээлэл авах үед тун хэцүү нөхцөл байдлыг бий болгодог.<sup>9</sup>

Тухайн хүн цочроо болон айдастай зүйлсийнхээ талаарх асуултанд хариулах болон ярилцага хийх дургүй эсвэл чадваргүй байж болно. Тиймэрхүү чадваргүй эсвэл дуугуй байдал нь цаанаа олон шалтгаантай байж болно. Өөртөө болон гэр булийнхэндээ тохиолдож болох болзошгүй үр дагавараас айх айdas дээр тэдний өөрсдийн туулж өнгөрүүлсэн зүйлс, цочролоосоо болоод үнэхээр ой санамжаа хэсэг эсвэл бүрэн байдлаар алдсан байж болно. Ой санамжаа алдах нь явдал нь “эхний цочролын” үед буюу тухайн хүн ямар төрлийн аюулд өртсөнөө мэдсэн даруйд авсан цочролоос болон тохиолддог бөгөөд гэтэл мэдээж тэрхүү үеийнх нь талаар албаны болон бусад хүмүүс мэдэхийг илүүтэйгээр хүсдэг. Гэтэл тухайн хүний хэлж ярьж чадахгүй эсвэл хүсэхгүй байгаа үйл явдлууд эсвэл тухайн хүн гарах гарцгүй болж байсан тэр үеийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авахаар шахалт үзүүлэх нь хохирогчийн айдсыг улам нэмэгдүүлж өөр бусад зүйлсийн талаарх мэдээлэл олж авахад тань улам хүндрэлтэй болгоно.

### Тодорхой нарийвчлалаас татгалздаг тухай

**ХХГХ-ийн хохирогчид ялангуяа эхний ярилцлагын үед ХХГХ-т өртөж байсан талаараа дэлгэрэнгүй ярихаас татгалзах зүй ёсны шалтгаантай байж болно. Тиймээс ч үйлчилгээ үзүүлэгчид тэвчээртэй байж хохирогчтой тэднийг ямар нэгэн байдлаар шүүмжилсэн байдлаар харьцвал зохих хэд хэдэн шалтгаанаас энд дурьдвал:**

- Гэмт этгээдүүдээс айх айdas. Хохирогч гэмт этгээдүүд өөрсдөд нь эсвэл гэр булийнхэнд нь муу юм хийж өшөө авахаас

### болгоомжилж байж болно.

- Хууль хэрэгжүүлэгчдээс айх айdas. Хохирогчид тухайн улс оронд хууль бусаар нэвтэрсэн, зөвшөөрөлгүй ажиллаж байсан, эсвэл ХХГХ-т өртсөний улмаас хууль бус үйлдлүүд (биээ үнэлэлт, хар тамхи хэрэглэх г.м.) үйлдэж байсан тул хууль хэрэгжүүлэгч нараас айх эмээж болно.
- Гэмт этгээдүүдэд сайнаар хандах. Хохирогчид өөрсдийг нь худалдсан гэмт этгээдтэй хувийн харилцаанд орсон байж болзошгүй. Хэрвээ тийм байдал нь мэдэгдвэл энэ нь тухайн хохирогч ХХГХ-ийн хохирогч байхаа болж байна эсвэл сайн дураар тэр үйлдэлд оролцож байсан гэсэн уг биш.
- Итгэлцэл хангалтгүй байх. ХХГХ-т өртөх явцад хохирогчийн итгэж байсан хүн итгэлийг нь эvdэх тохиолдол ихээр үйлдсэн тул өөрийгөө хамгаалах үүднээс бусдыг хардах байдлаар хандах болсоны улмаас үйлчилгээ үзүүлэгчийн зорилго сэдэлд итгэхгүй байх.
- Ой санамжaa алдах. Тэдэнд учирсан цочроо болон өөр ямар нэгэн шалтгааны улмаас (ж нь: хар тамхи эсвэл согтууруулах ундааны хэрэглээнээс болж) хохирогчид өөрсддөө юу тохиолдсон бүхнийг дэлгэрэнгүй санахгүй байж болно. Тэд маягтыг бөглөхийн тулд дэлгэрэнгүй деталийг санахаар хичээж болно. Хохирогчийн өгүүлсэн деталиуд өөрчлөгдөх нь ой санамжaa алдсан байдлаас нь улбаалж болох тул хохирогчийг санаатайгаар хамтран ажиллахгүй байна гэж үзэж болохгүй.

Хэрвээ тухайн хүн харваас илт аиж эмээж байвал ярилцлагаа бүр зогсоох эсвэл дараа боломжтой үед нь үргэлжлүүлэхээр хойшлуулах нь зүйтэй. Ярилцлагын явцад насанд хүрээгүй хүүхдэд үгэн бус хэлбэрээр айdas эсвэл болгоомжпол эсвэл ядарч туйлдсан байдал илт байвал энэ нь ноцтой шинж тэмдэг юм. Ярилцлага үргэлжлэхээс өмнө тухайн хүн хурц хэлбэрийн цочролд байгаа нь илт байвал сэтгэл зүйчийн туслалцаа үзүүлэхээс нааш үргэлжлүүлж болохгүй.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан ярилцагчтай ярилцлага явуулах дараах удирдамжийн дагуу түүнийг сайтар ойлгож байгаагаа илэрхийлэхийн хамт түүнтэй хийж буй ярилцлага болон авч буй мэдээллийн гол зорилго нь тухайн хүнийг өөрийг нь хамгаалах, хэрэгцээтэй туслалцаа үзүүлэх хамгийн зөв арга замыг олохын тулд хийгдэж байгаа бөгөөд энэ ажлыг зөвхөн хохирогчийн өөрийнх нь тусламжтайгаар хийж

болно гэдгийг тодорхой тайлбарлах хэрэгтэй. Тодорхойлон тогтоох ярилцлагын зорилго нь тухайн хүн ХХГХ-т үнэхээр өртсөн эсэхийг тодруулах явдал бөгөөд дор дурдсан асуултууд энэ асуултанд хариулахад тус болох зорилготой. Хохирогчийг энгийн, өөрийн нь тааваар байлгах үүднээс ярилцлагын өрөөг тохилог тавилгаар тохижуулан, тухлаг орчин бурдуулж, тухайн хүний энгийн, үндсэн бүх хэрэгцээ хангагдсан байхад анхаарал тавина. Үүнд, өлсөөгүй, цангаагүй, даараагүй мөн биеэ зассан байх хэрэгтэй. Эхний уулзалтын үеэр эмзэг магадгүй цочролд орсон байж болзошгүй хохирогчтой үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан уулзаж, асуулт тавих болно. Энэхүү хамгийн эхний ярилцлага хэрхэн явагдах нь ярилцлага хөтлөгч тухайн нөхцөл байдлыг хэрхэн үнэлсэн үнэлэлт, хариулагчийн байдал болон хариулах идэвхтэй шууд холбоотой. Мэдээж хэрэг шууд л анкетын асуулга гаргаад асуугаад бөглөж эхлэх нь ХХГХ-ийн хохирогчийн хувьд тохиромжгүй тул энэ байдлаас аль болох зайлсхийх шаардлагатай. Хэзээ, ямар асуулт нь илүү тохиромжтой байхыг хөтлөгч шийдэн түүнд тохируулан ярилцлагаа хөтөлнө. Тодорохойлон тогтоох үйл явцад ярилцлага өгч буй хүн юун тухай яригдаж байгааг сайтар ойлгох нь нэн чухал. Хэрвээ тухайн хүн ярилцлага болон яригдаж байгаа зүйлсийн талаар сайтар ойлгохгүй байгаа сэтгэгдэл төрвөл ярилцлага хаана явагдаж байгаагаас үл хамаараад орчуулагчийн туслалцаа авах шаардлагатай.

Ярилцлагын үед ашиглах асуултуудыг энэ хэсэгт хавсаргасан бөгөөд эдгээр нь тодорхойлон таних ярилцлагад тусlamж болох зорилгоор зохиогдсон тул хохирогчтой хийх ярилцлагын үеэр асуултуудын дарааллийг заавал нарийн баримтлах шаардлага байхгүй. Ярилцлагын хэлбэр хохирогчийн ерөнхий байдлаас хамаарч явагдана.

### **2.3.3 ХХГХ-ИЙН ХОХИРОГЧИД ХАЛАМЖ ҮЗҮҮЛЭХ БОЛОН ЯРИЛЦЛАГА ХИЙХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ЗАРЧМУУД**

**ХХГХ-ИЙН хохирогчид хамгаалал, туслалцаа үзүүлэх эсвэл ярилцлага хийхээс өмнө үйлчилгээ үзүүлэгч байгууллагын бүх ажилтнууд энэ номны “ХХГХ-ийн хохирогчдыг халамжлах болон Ярилцлага хийх Ёс Зүйн зарчмууд” Хавсралт 1 анхааралтай сайтар унших хэрэгтэй.**

## 2.3.4 ТОДОРХОЙЛОН ТОГТООХ ЯРИЛЦЛАГАНЫ МАЯГТЫГ АШИГЛАХ

Энэ бүлгийн эцэст хавсаргасан тодорхойлох Ярилцлагын Маягт нь (Хавсралт 1) ХХГХ-ийн хохирочийг тодорхойлоход ашиглах зорилготой. Энэ болон үүнтэй ижил төстэй маягтийг ХХГХ-ийн хохирогчоор ирүүлсэн хохирогчидтой ажилладаг байгууллагууд буюу өөр ТТБ эсвэл Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж болно. Хохирогчийг хандуулж ирүүлсэн байгууллагын хийсэн тодорхойлолтын үнэн зөвийг бататгах, хандаж ирсэн хүнд албан ёсоор хавтас нээхийн тулд өөрийн процедурыг дахин хийхэд ашиглана.

### 2.3.4.1 Ярилцлагад ашиглах асуумжийн жагсаалт

Дараахи асуулгийн жагсаалт нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудад зориулсан ярилцлагын төхникийн нэгдсэн удирдамж болно. ХХГХ-ийн хохирогчидтой ярилцлага хийх талаар “ХХГХ-ийн хохирогчдод Халамж үзүүлэх болон Ярилцлага хийх Ёс Зүйн зарчмууд” Хавсралт 1-д онцгойлон заасан бөгөөд эдгээр зарчмуудыг ярилцлага болгоны өмнө анхааралтай уншиж байх ёстой.

#### Ярилцлага явуулах нөхцлүүд:

- Ярилцлагыг аль болох хаалттай, хүний хөлөөс зайдуу газар өөр хүмүүс сонсох болон тасалдуудах боломжгүй нөхцөлд явуулах.
- Ярилцлагын үеэр байлцах эрх бүхий хүмүүст - хохирогч, ярилцлага авч буй хүн (хүмүүс), орчуулагч (шаардлагатай тохиолдолд), мэргэшсэн туслалцаа үзүүлэгч хүн (хүүхдийн асран хамгаалагч, хуулийн эсвэл сэтгэл зүйч зөвлөх) ордог.
- Хохирогч ярилцлага өгөх үед хэлний бэрхшээлтэй тулгарахаар байвал түүнд орчуулагч гаргаж өгөх талаар бүхий л арга хэмжээ авагдсан байна.
- Гар утсыг унтраасан байна.
- Хэрвээ хаалттай газар бол “садаа болохыг хориглоно” гэсэн тэмдэг эсвэл ижил төстэй тэмдгийг ярилцлага тасалдуулахаас урьдчилан сэргийлэх үүднээс хаалган дээр өлгөх шаардлагатай.
- Хэрвээ хаалттай, нууцлагдмал газар олох боломжгүй

бол ярилцлагыг хөндлөнгийн хүн чагнахааргүй байдлаар зохицуулах шаардлагатай.

- Ярилцлагыг үнэлэн дүгнэсэн болон асуусан байдлаар явуулахаас зайлсхийх хэрэгтэй.
- Тухайн хүнийг хүндэтгэж байгаа мэдрэмж төрүүлэн харилцаж үзэл бодолд нь итгэх ёстай хүнтэй харилцаж байна гэдэгт итгүүлэх хэрэгтэй.

### Танилцуулга

- Ярилцагч өөрийгөө тухайн хүнд танилцуулахдаа тус байгууллагад гүйцэтгэдэг үүргийнхээ талаар хэлж өгөх.
- Тухайн хүн нууц, аюулгүй орчинд байгаа гэдгийг итгүүлэх.
- Тухайн эрэгтэй эмэгтэй бие засах өрөөнд орох эсвэл жаахан юм идэх хүсэлтэй байгаа талаар лавлах.
- Тухайн хүний ямар нэг юм нь өвдсөн, ямар нэгэн зүйлээс айсан эсэхийг мэдэж эмнэлгийн яаралтай туслалцаа шаардлагатай эсэхийг тодруулах.
- Хэрвээ тухайн эрэгтэй эмэгтэй хүнд эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай байна гэвэл эмнэлгийн тусламж үзүүлэн, эмч үзэхээс нааш ярилцлага явагдах ёсгүй

### Тайлбар

- ХХГХ-ийн хохирогчдод тухайн байгууллагын үзүүлдэг туслалцааны талаар хэлж, ярилцлага нь энэ үйл явцын эхлэл болж байгааг тайлбарлах.
- Түүнээс авсан мэдээлэл хэрхэн яаж ашиглагдах талаар тайлбарлах.
- Тухайн хүнд юу тохиолдсон, болсон явдлын талаар зарим асуулт энэ ярилцлагад байж болно гэж хэлээд хүнд, эргэн санаад хэцүү зарим сэдвүүдийг алгасаж болно гэдгийг тайлбарлах.
- Асуултанд хариулахад бодох хугацаа авч болно мөн түүнчлэн дуртай цагтаа жаахан амарч амсхийж болно гэдгийг тайлбарлах.
- Ярилцлага нь сайн дурын үндсэн дээр явагдана гэдгийг хохирогчид ойлгуулах, мөн тухайн хүн асуусан асуулт болгонд заавал хариулах ёстай биш гэдгийг хэлэх. Түүнд аль болох сайн туслалцаа үзүүлэхийн тулд байгууллагад илүү

өргөн хүрээний, дэлгэрэнгүй мэдээлэл шаардагдах болно гэдгийг хэлэх. Байгууллагын зүгээс үзүүлэдэг туслалцааны тодорхой хязгаарлалтыг бас хэлж өгөх, үүнд: туслалцааг зөвхөн ХХГХ-ийн хохирогчдод, хууль бус цагаачлагчдад, хүүхдүүдэд г.м. үзүүлдэг гэхчилэн.

- Мөн хэрвээ байгууллага тухайн хүнд тухайн туслалцааг шууд үзүүлэх боломжгүй эсвэл тэр талын туслалцаа үзүүлэх чадвар дутмаг бол тэр туслалцааг үзүүлэх чадвар бүхий өөр байгууллага, хүмүүсийг олж өгнө гэж тайлбарлах.

### Ярилцлага эхлэхийн өмнө

- Тухайн хүнд түүний хэлэх бүхий л зүйлс болон хариултууд нууцлагдан хадгалагдах болно гэдгийг мэдээлэх. Үүн дотроо түүний өгсөн мэдээллийг цааш хэрхэх болон хэнтэй, хэрхэн хуваалцахийг тодорхой болгох.
- Тухайн эрэгтэй, эмэгтэйд тайлбарласан болон, хэлсэн зүйлсийн талаар дуртай цагтаа лавлан асуулт асууж болох бөгөөд асуултыг тодруулах эсвэл давтан хэлүүлэх эрхтэй гэж тайлбарлах.
- Тайлбарласан бүгдийг тухайн хүн сайтар ойлгосон эсэхийг лавлах.
- Түүнээс одоогийн байдлаар өөрт нь хэрэгтэй зүйл юу байна гэж асуух.
- Тухайн эрэгтэй, эмэгтэйгээс ярилцлага хийхийг зөвшөөрч байгаа эсэхийг лавлах.

### 2.3.4.2 Тодорхойлох ярилцлагын маягтыг бөглөх нь

Тодорхойлох ярилцлагын маягт (хавсралт 1-ийг харах) нь дараах 6 хэсэгт хуваагдана.

- Бүртгэлийн болон кейсийн он сар өдөр.
- Элсүүлэлтийн хэсэг
- Тээвэрлэлтийн хэсэг
- Мөлжлөгийн хэсэг
- Баталгаажуулах нэмэлт материал
- Гаргасан шийдвэр

Хэсэг бүр бүрэн бөглөгдсөн байх шаардлагатай ч энэ тухайн хүний ярилцлагад оролцох, хамтран ажиллах оролцооны түвшнээс бас хамаарна. Ярилцлага авагч хүмүүс хариултыг төрөл бүрийн байдлаар өгөх магадлалтайг бас санах хэрэгтэй, үүнд: илт дайсагнал эсвэл цочроо тиймээс ярилцлагын хэв маяг болон цаг хугацааг түүнд тохируулан өөрчлөх шаардлага гарч болзошгүй.

---

### **Ярилцлагад оролцохын өмнө тухайн хүнд дараах зүйлсийн талаар мэдээлэгдсэн байх шаардлагатай:**

- Бүх хариултууд үйлчилгээ үзүүлэгч байгууллагад чандлан нууцлагдах болно.
  - Үйлчилгээ үзүүлэгч байгууллага онцгой тохиолдолд ямар туслалцааг хэрхэн үзүүлэхээ шийдэхийн тулд асуултуудад заавал хариулах шаардлагатай байдаг.
  - Асуултанд хариулахгүй байх нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын туслалцааг зогсоож болзошгүй боловч уг туслалцааг авах эрх зөвхөн ХХГХ-ийн хохирогчдод цаашид хадгалагдан үлдэж болно.
  - Ярилцлагын эцэст тэдэнд ямар туслалцаа болон үйлчилгээ үзүүлэгдэж болох, туслалцаа үзүүлж чадах байгууллагуудын талаар мөн хэрвээ өөрсдөө хүсвэл хаана болон хэрхэн тэдний эсрэг үйлдэгдсэн гэмт үйлдлийн талаар мэдээлэх, болон ямар төрлийн хууль эрх зүйн туслалцаа эсвэл хамгаалал авч болох талаар сайтар мэдээлэгдсэн байна.
- 

Дараах асуултууд нь бүлгийн төгсгөл дэх Тодорхойлон тогтоох Ярилцлагын Маягтад байгаа асуултуудтай төстэй. Тайлбарууд нь ерөнхий утгаар хийгдсэн бөгөөд аль ч нь өөрчлөгдж, хасагдаж болно. Асуултуудын аль нэг нь асуудлыг дангаараа шийдвэрлэх нөлөө байхгүй, тэд бүгдээрээ дээр дурьдагдсан ярилцлагын өмнөх үнэлгээний үзүүлэлтүүдтэй хамт дүгнэгдэх ёстой.

### **Элсүүлэлтийн хэсэг**

1. элсүүлэгч тухайн хүнтэй эхний харилцааг хэрхэн тогтоосон бэ?

Элсүүлэгч нь хохирогчтой эхний харилцааг өөрийн сүлжээний хүмүүс, хохирогчийн гэр бүлээр дамжуулж тогтоохоос гадна хохирогчтой өөртэй нь шууд гадаадад ажиллуулах зарын дагуу тогтоодог. ХХГХ нь улс дотооддоо эсвэл тухайн бүсэд ялангуяа албадан хөдөлмөрийн зорилгоор үйлдэгдэх үед элсүүлэлт нь тухайн хүнтэй өөртэй нь шууд болон түүний гэр бүлээр дамжуулан хялбар байдлаар үйлдэгддэг. Насанд хүрээгүй хүүхэд энэ гэмт хэрэгт өртсөн тохиолдолд эцэг эх нь ядуурлын улмаас хүүхдээ худалдсан байж болно, эсвэл “элсүүлэгчтэй” хамт (элсүүлэгч нь ойрын эсвэл холын төрөл байж болно) хүүхдийн сайн сайхан ирээдүйн төлөө гэж итгээд явуулсан байж болно. Ихэнх тохиолдолд эцэг эх нь хүүхдээ жаахан мөнгө олоод эсвэл ямар нэг хэрэгтэй зүйл сураад ирнэ гэж бодож суудаг. Ярилцлага хөтлөгч нь үнэн хэрэг дээрээ хүүхэддээ маш их анхаарал халамж тавьдаг бөгөөд хүүхдээ хол газар явуулахаас өөр сонголт бага байсан эцэг эхийнх нь талаар хамаагүй буруутгасан өнгөөр ярьж болохгүй.

Зарим бүс нутагт албадан хөдөлмөрийн зорилгоор үйлдэгдэг ХХГХ нь удаан түүхийн улбаатай бөгөөд тэр нь тухайн орон нутгийн амьдарлын тогтсон хэв маягийн нэг болсон байдаг. Тиймээс тэр тохиолдлуудад элсүүлэлт нь тодорхой загвар, аргачлалаар үйлдэгдэх бус харин элсүүлэгчдийн сүлжээний бүлэглэлүүд хот, сууринаар явж улирлын чанартай жишээлбэл ургац хураалтад зориулан элсүүлэлтийг үйлдэж байж болно. Зарим ХХГХ-ийн албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор үйлэгдэж буй тохиолдолд элсүүлэлт нь аман байдлаар өгүүлэгдсэн ямар нэгэн боломжийн талаарх яриа төдий зүйл байж, тухайн хүн өөрийн хүслээр шилжилтэнд оролцсон байж болно. Өөр тохиолдлуудад хөдөлмөрийн зорилгоор шилжин суурьшилыг дэмжих зохион байгуулалттай механизм ажиллаж ХХГХ-ийн элсүүлэлт энэ аргыг сонгон нуугдмал байдлаар үйлдэгдэж болно.

ХХГХ бэлгийн мөлжлөгийн зорилгоор, үндэстэн дамнан үйлдэгдэх үед элсүүлэлт нь зарим тохиолдолд радио, ТВ, сонин болон интернэтээр явагддаг. Тэдгээр зарууд нь гадаад дахь өргөн сонголт бүхий боломжуудын талаар амласан байх бөгөөд ажил, хэлний сургалт, эсвэл аялал жуулчлалын саналууд байдаг. Мөн залуу эмэгтэйүүдийг элсүүлэхдээ залуу эрэгтэй бүсгүйн наиз залуу нь болж түүнийг ХХГХ-т өртүүлэх нь бас тохиолддог. Эрэгтэй болон эмэгтэй эслүүлэгч нар залуу эмэгтэйчүүд, охидын

найз нь болж, гэхдээ заавал найз залуу нь биш зүгээр туслахыг хүссэн сайн санаат найз нь болж хуурдаг. Үүнд: тэд хохирогчийн эдийн засгийн, эсвэл гэр бүлийн дотоод асуудлыг ашигладаг. Тэд хохирогчдод худал хуурмагаар хангалаун сайхан амьдарч байгаа мэт дүр үзүүлэн (хохирогчдод амалж байгаа ажлынхаа улмаас ийм хангалаун байна гэж итгүүлэх зорилгоор) тэд ч мөн адил ийм сайхан амьдарч болно гэж ойлгуулдаг.

2. Эх орондоо гэхдээ өөр газар эсвэл гадаадад ямар төрлийн ажил амласан болон хүлээгдэж байсан? Тухайн газраа очсоод ажил, цалин, амьдарлын нөхцөл ямар байна гэж амлаж байсан бэ?

ХХГХ нь мөлжлөгийн олон төрөл зорилгоор үйлдэгддэг тиймээс хохирогч ямар төрлийн ажил хөдөлмөр эрхлэх, ямар нөхцөлд ажиллах талаар мэдэж байсан эсэх нь тухайн нөхцөл байдал болон гэмт этгээдүүдийн үйл ажиллагаа явуулсан арга хэлбэрээс хамаарна. Гэхдээ хохирогч өөрийн хийх ажил эсвэл ажиллах нөхцөл байдал, эсвэл цалингийн хэмжээний талаар худлаа амлалтанд итгэсэн байдаг. ХХГХ-ийн хохирогчдод хийх ажлынх нь талаар хэсэгчлэн эсвэл огт худлаа мэдээлэл өгсөн байдаг. Жишээлбэл: тэд ямар ажил хийхээ мэдэж байж болох юм, гэхдээ ажиллах нөхцөл байдал, цалин төлбөрийн хэмжээг мэдэхгүй байсан байж болно, үүнд: эмэгтэйчүүд болон охидод зөөгч, бүжигчиний ажил хийнэ гэж амлаж байсан байж боловч түүнээс гадна үйлчлүүлэгч нараа “зугацуулах” ёстой гэж огтоос бодоогүй байдаг Ихэнхдээ ямар ажил хийх нь тодорхой ч боолчлолтой төстэй нөхцөлд, маш бага эсвэл ямар ч цалингүй ажиллах гэдэг нь нуугдмал байдаг.

Зарим тохиолдолд тухайн хүний эх орон дахь эсвэл хүлээн авагч аль аль улсын албаны хүмүүс эсвэл байгууллагууд ажлын амлалт болон эслүүлэлтийн стратегийн талаар мэддэг байдаг. Тухайн орны тагнуулын алба зарим ХХГХ-ийн сүлжээг таслан зогсоох, үйл ажиллагааг нь супруулахад тустай байж болно.

3. Элсүүлэгчид урьдчилгаа болгож мөнгө төлсөн эсэх?

Тухайн гэмт хэрэгт ихэнхдээ санхүүгийн асуудал тусгасан гэрээ үйлдэгддэг нь энэ гэмт хэргийн ашгийн улмаас үйлдэгддэг мөн

чанартай нь холбоотой. Гэхдээ ХХГХ дан ганц ашгийн сэдлээр үйлдэгддэггүй. Жишээлбэл: цэрэг дайны үйл ажиллагаанд, боолчлолын гэрлэлт, эсвэл гэрийн үйлчлэлд г.м. зорилгоор бас үйлдэгддэг.

ХХГХ нь хохирогчийг өрөнд оруулж, тухайн хүн түүнийг нь ямар нэгэн байдлаар төлөхөөс нааш эрх чөлөөгүй байх нөхцөлт байдлыг үүсгэдэг.

**4. Тухайн хүнийг мөлжлэгт ашиглах зорилгоор өөрийнх нь эх оронд дотоодод нь эсвэл хилийн чанадад албадан тээвэрлэсэн эсэх?**

Зарим тохиолдолд ХХГХ-ийн хохирогчид, ялангуяа хүүхдүүд эсвэл залуу өсвөр насныхныг хулгайлагдах тохиолдол элбэг гардаг. Хулгайлсан үйлдэл нь ХХГХ үйлдэгдсэний маш том үзүүлэлт юм.

### Тээвэрлэлтийн хэсэг

**5. Тээврийн зардлыг хэн төлсөн бэ?**

Мөн л ХХГХ-ийн маш олон тохиолдолд, бэлгийн болон албадан хөдөлмөрийн мөлжлэгийн аль аль тохиолдолд, хохирогчид нь амьдрал ядуу улмаас замын зардлын мөнгийг төлөх ч чадваргүй байдаг. Зарим тохиолдолд гэмт этгээдүүд эслүүлэлтийн нэг стратеги болгох үүндээс хохирогчдын замын зардлын мөнгийг төлдөг. Гэхдээ очих газраа хүрсэн хойноо хохирогчдыг тэрхүү мөнгө зардлаас улбаалан өрийн барьцаанд авч эрхэндээ оруулдаг. Иймэрхүү төрлийн өр, тооцоо нь ХХГХ-ийн тод үзүүлэлт болдог. Мөн Хууль бусаар хил нэвтрэх олон тохиолдолд хууль бусаар хил нэвтрүүлэгчид хүмүүсийн зардлыг төлдөг тул хууль бусаар хил нэвтэрсэн хүмүүс очих улсадаа очоод, хийсэн ажлаасаа олох орлогоор нөгөө хил нэвтрүүлэгч нарт мөнгө төлөх маш том өрөнд унадаг. Мөнгө эргүүлэн төлөх нөхцөл болон шилжигч ямар нөхцөлд тээвэрлэгдсэнээс хамаараад Хууль бусаар хил нэвтрэх үйлдэл үнэхээр ХХГХ-ийн тохиолдол байх нь “хууль бусаар хил нэвтрүүлэгч” шилжигчийг өрийн боолчлолд оруулж, тээвэрлэсэн улсдаа мөлжлэгт

ашиглаж эхлэх байдлаар илэрдэг. Мөн улс дотор үйлдэгдэх ХХГХ-т гэмт этгээдүүд хохирогчийн замын зардлыг төлсөн байх нь элбэг. Бусад тохиолдлуудад, ялангуяа дотооддоо болон бүсэд үйлдэгдэх тохиолдолд замын зардал өндөр эсвэл туулах зам хэцүү бол ХХГХ-ийн хохирогчид замын зардлыг өөрсдөө төлсөн байж болно, гэхдээ зорьсон газар нь ажил хүлээж байгаа гэх хуурамч амлалтанд итгэсэний үндсэн дээр үүнийг хийдэг байна. Очих газраа хүрсэний дараа гэмт этгээдүүд хохирогчдын эмзэг байдлыг ашиглан “элсүүлж”, хяналтандaa оруулж, улмаар мөлжлөгт өртүүлэх газраа албадан аваачдаг.

6. Аль нэг улсын хилийг давж зорчсон эсэх? Хэрвээ тийм бол хилийг нууцаар эсвэл хууль ёсны дагуу ямар байдлаар зорчсон бэ? Хилээр хуулийн дагуу нээлттэй ил байдлаар зорчсон бол ХХГХ-ийн хохирогч өөрийн бичиг баримтыг ашигласан эсвэл хуурамч бичиг баримт, хуурамч визээр зорчсон эсэх?

ХХГХ-ийн олон хохирогчид хилээр унаатай эсвэл явган аль нэг байдлаар хууль бусаар зорчдог. Мөн олон хохирогчид хуулийн дагуу бүрдүүлсэн бичиг баримтаар хуурамч болон жинхэнэ визтэй зорчиж мөн заримдаа хуурамч эсвэл хулгайн бичиг баримтаар зорчдог.

ХХГХ-ийн хэлбэр болон үйлдэгдэх байршлаас шалтгаалан ямар тээврийн хэрэгслээр зорчих нь хамаардаг. Хөрш болон бус доторх улсад хилээр хууль бус аргаар зорчиход хялбар байдаг байхад өөр холын улсад зорчиход бичиг баримт бүрдүүлэх болон хохирогчдыг ил авч явах шаадлага гардаг нь тэднийг онгоц, галт тэрэг болон усан онгоцоор ил байдлаар тээвэрлэж, мөн хил гаалийн шалганаар нэвтрэх шаардлагаас урган гарч ирдэг.

Түүнээс гадна, хуурч мэхлэх арга хэрэглэн хохирогчийг элсүүлсэн тохиолдолд гэмт этгээдүүд хохирогчдод сэжиг төрүүлэлгүйгээр тэдний бичиг баримтыг гэмт үйлдэлдээ ашиглан өөрсдийн үйлдлээ хууль ёсны мэт харагдуулах сонирхолтой байдаг. Бэлгийн мөлжлөгийн тохиолдлуудад, ялангуяа Европ болон хойд Америкад хохирогчид өөрсдийн эсвэл сайн чанарын хуурамч бичиг баримтаар ил байдлаар хөдөлгөөнд оролцуулдаг. Энэ нь ХХГХ-ийн гэмт хэрэгтнүүд хохирогчдыг хаалттай байранд хууль бусаар хорьж байлгасанаас тухайн улс дотроо чөлөөтэй хөдөлгөөнд

байлгах нь тэндий ашиг олох үйлдэлд ашигтай байдаг.

### 7. Бичиг баримт хэнд байгаа вэ?

Ихэнх тохиолдолд ХХГХ-ийн хохирогчид бичиг баримт нь байдаггүй. Яагаад гэвэл бичиг баримттай нь үлдээвэл тэд оргочих боломжтой болох учраас гэмт этгээдүүд хохирогчдын бичиг баримтыг хураанавдаг мөн энэ нь тэдний хохирогчдыг албадах болон айлган сурдүүлэхэд хэрэглэдэг түгээмэл аргын нэг юм. Гэхдээ дээр дурдаж байсанчлан тухайн хүн бичиг баримтгүй байх нь Хууль бусаар хил нэвтрэх болон орогнол эрсэн хүмүүсийн дунд бас тохиолддог.

Гэхдээ эдгээр нөхцлүүдээс харахад нөхцөл байдал тухай бүрт өөр өөр байх магадлалтайг харуулж байна. ХХГХ-ийн зарим хохирогчдод бичиг баримтыг нь үлдээсэн байх боловч өөр байдлаар тэднийг албадан эсвэл айлган сурдүүлж явах аргагүй болгосон байдаг. Тийм учраас бичиг баримт нь өөрт нь байвч эрх чөлөөгүй байх нь тохиолддог.

### 8. Хохирогч дамжуулагч болон гуравдагч оронд очсоны дараа тэнд удаан хугацааны туршид байсан эсэх болон байх хугацаандаа аливаа хууль бус үйлдэлд оролцсон эсэх? Тийм бол тэр нь ямар үйлдэл байсан бэ?

ХХГХ-ийн хохирогчдыг хүлээн авагч улсад тэр болгон шууд тээвэрлэдэггүй. Тухайн зорьсон газраа хүрэхээс өмнө хохирогчийг хэдэн 7 хоног, сарын туршид нэг газраас нөгөөд шилжүүлэн, олон газраар зорчуулж, мөн энэ хугацаандаа мөлжөгт ашигласаар байдаг. Хэрвээ хохирогчид ийм үйлдэл үйлдэгдэж байсан бол энэ нь ХХГХ-т өртсөний тод илэрхийлэл юм.

### *Мөлжлөгийн үе шат*

### 9. Хүлээн авагч улсад очсоны дараа хохирогчийг ямар төрлийн үйлдэл татан оролцуулсан бэ?

ХХГХ-ийн зорилго нь бэлгийн болон хөдөлмөрийн эсвэл өөр ямар ч төрлийн мөлжлөг байсан албадлагын шинж чанарыг агуулсан

мөлжлөг байдаг. Тиймээс хохирогчийг албадан хөдөлмөр, биеэ үнэлэлт, гудамжны гүйланчлал, юм худалдах, гэрийн үйлчлэгч хийлгэх мөлжлөгт өртүүлэхэд түүнийг заавал байдлаар албадсаныг батлах нотолгоо байвал (эсвэл хохирогчийн эрхтэн эсвэл эрхтнүүдийг нь авсан байвал хүний эд эрхтэнийг авах зорилготой ХХГХ) тэр нь тухайн гэмт үйлдэл улс дотроо эсвэл гадаадад үйлдэгдсэнээс үл хамаараад ХХГХ үйлдэгдсэнийг баталгаажуулах гол нотолгоо юм.

ХХГХ-ийн хамгийн гол бөгөөд анхдагч зорилго нь хүнийг мөлжих замаар ашиг олох асуудал байдаг учраас хохирогчийг хүлээн авагч газар аваачсаны дараа түүний хөдөлмөрлөж олсон цалин, мөнгийг бүхлээр нь эсвэл бараг бүгдийг нь хүраан авсан байдал ХХГХ-ийн гол нотолгоо юм

#### 10. Хүлээн авагч газар очсоноос хойш хэдий хэр хугацааны дараа энэ үйлдэл эхэлсэн бэ?

Энэ хэсэгт цаг хугацаа маш чухал үзүүлэлт болдог. Хохирогч нь хүлээн авагч газар очсон даруйдаа эсвэл очоод удалгүй мөлжлөгт ашиглагдаж эхэлдэг нь гэмт этгээд хохирогчоос аль болох хурдан ашиг олох эсвэл үйлчилгээ авах сонирхолтой байдагт оршино. Хэрвээ хүлээн авагч газраа очсоноос хойш мөлжлөгт эхлэх хүртэл нилээн хугацааны завсартай байсан бол энэ нь байнгын бус цагаач бичиг баримтын зөрчлийн улмаас мөлжлөгийн чанартай бөгөөд тогтмол бус ажил эрхэлсэн гэсэн үг. Нөгөө талаар зорьсон газраа хууль бусаар хил нэвтрэн хүргэгдсэн хүн тухайн улсадаа ХХГХ-т өртөн ХХГХ-ийн хохирогч болсон тохиолдол байж болно. Жишээ нь: нэг эмэгтэй гадаадын улсад өөрийн сайн дураар, хууль бусаар эсвэл хуулийн дагуу бичиг баримт бүрдүүлэн бие даан эсвэл хууль бусаар хил нэвтрүүлэгчдийн тусламжтайгаар аль нэгэн байдлаар очиж, тэндээ өөрөө биеэ үнэлж байсан байж болно. Энэ бол ХХГХ-ийн тохиолдол биш юм. Гэхдээ зуучлагч түүнийг биеэ үнэлж байхад нь тааралдан, эмэгтэйг эслүүлж, өөр газар тээвэрлэн, албадан, боолчлолтой ижил нөхцөлд байлган ажиллуулж, өөртөө ашиг олж байсан бол энэ нь ХХГХ-ийн тохиолдол мөн.

#### 11. Тухайн хүнийг ямар нэгэн үйлдэлд татан оролцуулахаар албадсан эсэх, хэрвээ тийм бол ямар үйлдэлд оролцуулж байсан бэ?

Хүнийг албадсан үйлдэл нь өөрөө ХХГХ үйлдэгдсэн байх үзүүлэлт юм. Хохирогчийг ямар нэгэн үйлдэлд оролцуулахаар албадсан албадлагын түвшин тухайн хүнийг эхлээд хулгайлсан эсвэл хууран мэхлэх замаар элсүүлсэн байдлаас хамаарна. Хохирогч хулгайлагдсан байсан тохиолдолд тухайн гэмт үйлдлийн хамгийн эхэн үеэс албадлагад өртөнө. Харин хохирогчийг хууран мэхлэх замаар элсүүлэн, ямар ажил эрхлэх талаар мэдэгдэлгүй мэхэлсэн байсан тохиолдолд албадлага даруй үйлдэгдэж эхэлнэ, яагаад гэвэл хохирогчийг өөр ажил буюу айлын хүүхэд асрах, бүжигчин хийх эсвэл зөөгчөөр ажиллана гэж итгүүлж байсан ч зорьсон газраа очсоод гэмт этгээд түүнийг биеэ үнэлэлтэнд албадан оруулах болно. Өөр байдлаар гэвэл хохирогч ямар төрлийн ажил хийхээр, жишээлбэл хууль бус ажил эсвэл секс-ийн үйлдвэрлэлд ажиллана гэж мэдэж байсан ч ямар нөхцөлд ажиллах болон/эсвэл цалин огт өгөхгүй гэдэг нь тодорхой болж эхэлмэгц албадлагын үйлдэл эхэлдэг. Гэмт этгээдүүд хохирогчдыг албадах замаар өөрсдийн хүслийг биелүүлэх, тэдний биеийг нь үнэлэх, өөрийн нь үнэлэмжийг нь алдагдуулахын тулд мөн оргож зугатаахаас урьдчилан сэргийлж төрөл бүрийн аргуудыг хэрэглэдэг. Эдгээр аргуудад: хохирогч эсвэл түүний гэр бүл, эсвэл ойр дотны хэн нэгэнд биеийн, бэлгийн эсвэл сэтгэл зүйн хүчирхийлэл үйлдэх болон үйлдэхээр сүрдүүлэх, нийгмийн болоод хэлний бэрхшээл, тухайн газрын эрх баригчдад болон албаны агентлагуудад итгэх итгэлгүй болгох, өөрт нь чи бол хэнд ч хэрэггүй, ийм тийм гэж гутаан доромжлох, цагдаад гүнээ үл итгэх, аюултай гэж итгүүлэх зэрэг үйлдлүүд ордог. Гэмт этгээдүүд хохирогчдыг архи, хар тамхины хамааралтай болгон тэднийг хоол, ундаар дамжуулан хянах тогтолцоо бий болгодог. Тэд мөн хохирогчдыг зэр зэвсэг, хяналтын камер эсвэл нохойгоор хянаж, удирддаг. Хэрвээ дээр дурдсан болон түүнтэй ижил төстэй үйлдлүүд үйлдэгдсэн бол энэ нь ХХГХ үйлдэгдсэний тод үзүүлэлт мөн.

## 12. Тэр үйл ажиллагаанд оролцсоноор тухайн хүн ямар хэмжээний цалин авсан бэ?

Ямар төрлийн үйл ажиллагаанд оролцсоноос нь хамаараад тухайн хүний авсан цалингийн хэмжээ ялгаатай байдаг. Биеэ үнэлэлтэд худалдагдсан эмэгтэй албадан хөдөлмөрт худалдагдсан хүний 7 хоногийн цалинг нэг өдөрт авч болно. Гэхдээ, хохирогч

цалингийнхаа тун бага хувийг эсвэл огт авахгүй, түүний олсон бүх мөнгөийг хүн худалдагч гэмт этгээдүүд болон тэдний хамсаатнууд хураан авдаг. Зарим тохиолдолд мөнгийг нь хадгалж байгаад хожим нь өгнө гэж хууран мэхлэж байсан байдаг. Түүнээс гадна зарим тохиолдолд цалингийн талаар огт яригддаггүй бөгөөд ялангуяа гэрийн үйлчлэгчээр худалдагдсан бол хоол байрны тооцоонд, эсвэл цэрэг дайны зориулалтаар худалдагдсан бол хоол, хар тамхины төлөө үнэ хөлсгүй ажиллах болдог.

### 13. Тухайн хүнд олсон мөнгөө өөртөө хадгалахыг зөвшөөрдөг байсан эсэх.

Ихэнх тохиолдолд ХХГХ-ийн хохирогчид нь хөдөлмөрлөж олсон мөнгөнийхөө ихэнх хэсгийг гар дээрээ авалгүй өрөндөө эсвэл өөр ямар нэгэн сүүтгэлд төлөх боловч, ямар ч мөнгө олоогүй гэж үгүйсгэдэг тохиолдууд бас байдаг. Үүний эсрэгээр хууль бусаар цагаачлагчид нь зорьсон газраа ирсэнээсээ хойш даруй ажил хийж мөнгө олж эхэлдэг. Тэд олсон мөнгөнийхөө зарцуулалтыг өөрсдөө мэдэж, тухайн байгаа газраа зарцуулж эсвэл эх орондоо байх гэр бүлийнхэндээ илгээдэг. Гэтэл ХХГХ-ийн хохирогч гэр орондоо мөнгө илгээж байсан баримт байлаа ч энэ нь түүний ХХГХ-ийн хохирогч болсон асуудлыг үгүйсгэж чадахгүй, яагаад гэвэл хүний наймаачид нь хохирогчдод бага хэмжээний мөнгө төлж эсвэл хохирогчийн гэр бүлийн нэр дээр хурамяа данс нээлгэн тэднийг оргох, эсвэл сэтгэл дундуур байлгахаас урьдчилан сэргийлдэг.

### 14. Хохирогч гэмт этгээдүүдэд өр төлөх ёстой байсан эсэх, тийм бол хэдий хэмжээний өр ямар учраас төлөх ёстой байсан бэ?

Дээр дурдсанчлан өрийн барьцаа нь ХХГХ-ийн хэлбруүдэд хамгийн өргөн хэрэглэгддэг онцлог шинж бөгөөд хохирогч нь бичиг баримтны бүрдүүлэлт, аялалын зардал, визний мэдүүлэг, байр болон бусад зүйлд зарцуулсан гэх хамаагүй өсгөсөн өрний боолчлолд орсон байдаг. Хохирогчийг хүлээн авагч газар ирэх үеэс эхлэн түүнд өр тооцож эхэлнэ. Үүнд нь: хоол хүнс, байр, хувцас өмсгөл, ажил хийхэд шаардлагатай материалын үнийг хөөргөн нэмэхээс гадна эд юмс эвдэж гэмтээсэн эсвэл хулгайлсан хэмээн хурамчаар өрийг нэмэгдүүлэн хохирогчдод төлж барагдуулах боломжгүй болгодог.

Энэ байдлын жишээ дэлхийн өнцөг булан бүрт олон олноор байдаг. Жишээлбэл: Баруун Африк болон Тай эмэгтэйчүүд гэмт этгээдүүдэд 30,000-50,000 ам долларыг биеэ үнэлж буцаан төлөх өрөнд амьдрах нь түгээмэл байдаг. Латин Америкад хохирогчдын цагаачилсаны, гэр бүлийнхэнийхээ эрүүл мэндийн зардалд эсвэл байшин худалдан авсан зээлийн улмаас өр үүсгэдэг. Өр нь эмэгтэйүүдийг мөлжлөгт байлгахад ашигладаг гол хэрэгслүүр мөн. Этиоп-д эмэгтэйчүүдийг гадаадад гэрийн үйлчлэгчийн ажил хийлгэхээр худалдаалан цалинг нь гэмт этгээдүүд аялал, бичиг баримт, ажилд зуучилсаны зардлын өр гэж тооцон авдаг байна. Этиоп-д худалдагдсан эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх эсвэл гэрийн үйлчлэгчийн мөлжлөгт ажил хийлгэх болсон тэр үеэс эхлэн тэдний эvdэлсэн / гэмтээсэн / хулгайлагдсан зүйлс эрс нэмэгдэж түүнийг даган тэдний өр нэмэгдэж, төлж барагдуулах аргагүй хэмжээнд хүрдэг.

### 15. Хөдөлмөрийн нөхцөл байдал ямар байсан бэ?

Ажиллах нөхцөл байдал нь хүмүүнлэг бус, хязгаарлагдмал байсны хэрээр тухайн тохиолдол ХХГХ-ийн тохиолдол байх магадлал ихэснэ. Хохирогчийг тасралтгүй хяналтад байлгаж, туйлын мөлжлөгт ажиллуулах зэрэг нь ХХГХ-ийн гол нотолгоо юм.

### 16. Тухайн хүн өөрийн дураар өөр тийш явах хөдөлгөөний болон сонголтын эрх, эрх чөлөөтэй байсан эсэх?

ХХГХ-ийн хохирогчдод ажлын нөхцөл байдал, ажлын цаг эсвэл үзүүлэх ёстой үйлчилгээнээс нь хамаарад тун бага эсвэл ямар ч эрх чөлөө олгогддоггүй. Түүнээс гадна ихэнх тохиолдолд тэдэнд өөр тийшээ явахыг зөвшөөрдөггүй эд хөрөнгийг нь хураан авч, нэг эсвэл хэд хэдэн хүн худалдаалагчид дагалдахаас өөр байдлаар гадагш гарах эрхгүй байдаг.

#### *Нотлох нэмэлт баримт*

Нэмэлт баталгаажуулах баримтыг хохирогчийн талаар гүнзгийрүүлэн тодруулах, холбогдох шийдвэр гаргах процесст ашиглаж болно. Бичиг баримт эсвэл бусад хэрэгцээтэй материалууд цагдаа болон бусад ТББ-аас олж болохоос гадна хохирогч өөрөө гаргаж ирж болно. Дараах жишээнүүдийг харна уу:

- Цагдаа болон цагаачлалын албаны тайлан
- Аялалын бичиг баримт болон тийз
- Хилээр орсон болон гарсан хуудас
- Үйлчилгээ авахаар хандуулж ирэхээс өмнөх болон туслалцаа үзүүлэх явцад эмнүүлж байсан гэмтэл бэртлийн талаарх эмнэлгийн эмчилгээний ямарваа нэгэн тайлан, бүртгэл
- Ажил эрхлэлтийн гэрээний хуулбар эсвэл зарын жинхэнэ хувь
- Өдрийн тэмдэглэл дэх тэмдэглэгээ, хохирогчийн өөрийнх нь бичсэн захиа
- Гэрчийн мэдүүлэг
- Мөлжлөгт байх үеийнх нь фото зураг
- Эрүүл мэндийн болоод сэтгэл зүйн шинжилгээнүүд

### Шийдвэр

Ярилцлагын эцэст ярилцагч этгээд дээр дурдсан гурван асуудлын дагуу олж болох бүхий л материалуудыг нэгтгэн бөөнд нь үнэлэх хэрэгтэй.

- Ярилцлагын өмнөх тодорхойлох үзүүлэлтүүд (2.2-ийг харна уу)
- Тодорхойлох ярилцлагад хохирогчийн хариулсан хариултууд
- Нэмэлт материалууд (өмнө дурдсан байдлаар)

Эдгээр зүйлийг хийж дуусгасаныхаа дараагаар бүхий л цуглувансан материал дээрээ үндэслэн туйхан хүн ХХГХ-ийн хохирогч мөн үү, Хууль бусаар хил нэвтрэгч цагаач эсвэл санаандгүй байдалд орсон бие даасан эдийн засгийн боломж хайгч цагаач эсвэл мөлжлөгийн өөр хэлбэрт өртөгч эсвэл туслалцаа шаардлагатай эмзэг байдалд орсон хүний аль нь вэ гэдгийг ярилцлагэ авагч тодруулах шаардлагатай. Шийдвэр гаргасаны дараагаар үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тухайн хүнд өөрийн хөтөлбөрийн дагуу туслалцаа үзүүлэх боломжтой эсэх эсвэл өөр байгууллагад туслалцаа үзүүлүүлэхээр хандуулах эсэхээ тодорхойлно. Тухайн хүн ХХГХ-ийн хохирогч биш гэж тодорхойлогдсон тохиолдолд ярилцлага хийгч түүнтэй хийсэн ярилцаганы тэмдэглээнд байх “Тэмдэглэгээ” гэсэн хэсэгт тэр талаар товч тэмдэглэнэ. Үүнийг хожим үүсч болох аливаа гомдлоос сэргийлж өөртөө хамгаалах хэрэгсэл болгож хэрэглэхээс гадна тухайн процедурыг цаашид улам сайжруулахад ашиглаж болно. Бусад тохиолдлуудад ярилцага

өгч буй хүн түүнд үзүүлж болох үйлчилгээ, туслалцаануудын төрөл, туслалцаа үзүүлэх бусад байгууллагуудын талаарх мэдээлэл, мөн хэврээ өөрсдөө хүсвэл тэдэнд үйлдэгдсэн гэмт үйлдлийн талаар хаашаа, хэрхэн мэдээлж болох талаар, хуулийн ямар төрлийн үйчилгээ эсвэл хамгаалалд хамрагдаж болох талаар дэлгэрэнгүй мэдээлэгдсэн байх ёстай.

### *Нэмэлтүүд*

Маягтад оруулсан сүүлийн хайрцаг нь “Тэмдэглэл” хийхэд зориулсан бөгөөд маягтад өөр газар тэмдэглэгдээгүй ч тэмдэглэх шаардлагатай бусад мэдээллийг тэмдэглэгдэхэд зориулагдсан болно.

**Тайлбар:** “NA” гэсэн ангилал нь асуултуудад хариулсан хариултын сонголтыг харуулна. “NA” нь “Авах боломжгүй” гэсэн утгатай. Тиймээс аливаа асуултад харилсан хариултын ард “NA” байвал хариултыг үзэх боломжгүй гэсэн үг. Түүнээс гадна: тавьсан асуулт тухайн хариулагчид “мэдэхгүй”, эсвэл асуулт нь тухайн хүн болон нөхцөл байдалд “тохиромжгүй”, эсвэл хариулагч түүнд “хариулаагүй” зэрэг тохиолдлуудад “NA” гэсэн тэмдэглэгээ тавигдана.

## Тайлбарууд

- 1
- 2 ОУШСБ, 2006, ХХГХ: *Афганистанд хийсэн анализ*. Олон улсын шилжилт Суурьшлийн Байгууллага, Афганистан, Кабул хот
- 3 Розенберг.Р., (Ред) (2003), *Индонези Эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг ХХГХ-т өртуулсан байдал*, Олон Улсын Католик Шилжин Суурьшлын Хороо болон Ойлголцлын Төв, Индонези, Жакарта
- 4 АНУ-ын Төрийн Департамент, (2005), ХХГХ-ийн тайлан: 2005 оны 6 сар, АНЦ-ын Төрийн Департамент, Вашингтон хот
- 5 ЮНИСЕФ, Баримтын товчоон: ХХГХ. ЮНИСЕФ <http://www.unicef.org/protection/files/trafficking.pdf>
- 6 ОУХБ, (2005), Албадан Хөдөлсөрийн Эсрэг Дэлхийн Холбоо: Хөдөлмөрлөх суурь зарчмууд болон Эрхийг Хамгаалах ОУХБ-ын Декларац-ын хэрэгжилтийн тайлан, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Щвейцарь, Женев хот, (2005)
- 7 Насанд хүрээгүй хүүхэдтэй ярилцлага хийх нэмэлт удирдамжыг: ХХГХ-ийн хохирогч хүүхдэд хамгаалал үзүүлэх Удирдамж, 2006 оны шинэчилсэн хувилбар, ЮНИСЕФ, Хүүхэд хамгааллын хэлтэс, НЙ.; ЮНИСЕФ Европад ХХГХ-ийн хохирогч болмон хүүхдийн эрхийг хамгаалах тайлбар зөвлөмж, 2006, ЮНИСЕФ, Бүсийн оффис, CEE/CIS [http://www.unicef.org/ceecis/protection\\_4440.html](http://www.unicef.org/ceecis/protection_4440.html); НҮБ-ийн Хүүхдийн эрхийн Конвенц: Өөрийн эх орноос өөр улсад, харгалзах хүнгүй болон ганцаар зорчих хүүхдэд үзүүлэх харилцаа, туслалцаа: [http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(symbol\)/CRC.GC.2005.6.En?Open](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(symbol)/CRC.GC.2005.6.En?Open) Баримт бичиг: Ярилцацаа: ХХГХ болон Хүүхдий эсрэг хүчирхийллийн хохирогч болмон хүүхэдтэй харьцах харилцааг боловсруулах нь 2004 оны 9 сар, ЮНИСЕФ, Косово
- 8 Хааны Шүүх, Төв Оффис, (2001). Эрүүгийн гэмт хэрэгт хэрэгцээт нотолгоог олэ авах: Эмзэг болон Айлган сурдүүлэгдсэн, мөн түүнчлэн насанд хүрээгүй гэрчид зориулсан Удирдамж, лондон, Хааны Хэвлэл
- 9 Тухайн хүнийг ХХГХ-ийн хохирогч байх магадлалтай гэж үзэж байгаа тохиолдолд нөхөн сэргээгдэх болон жаахан амсхийх цаг олгогдож байгаа бөгөөд энэ хугацаанд тухайн хүнд шаардлагатай үйлчилгээ үзүүлэгдэж байна.

## Хавсралт 1 Хохирогчоор тодорхойлон тогтоох Ярилцлагын Маягт



International Organization for Migration

IOM-OIM

ХХГХ-ийг хохирогчоор тодорхойлон тогтоох ярилцлагын маягт

ОУШСБ .....

Нууц

Бүртгэлийн мэдээлэл

ОУЦБ-ын хувь хүний ID:

Нэр:  
Хүйс: (M/ F)  
Төрсөн он/сан/өдөр:

Овог:

Яс үндэс:  
Төрсөн орон:  
Төрсөн газар:

Кейсийн мэдээлэл

Хандуулсан байгууллагын төрөл: (NGO/ IO/ Law Enforcement/ Embassy/ Other/ NA)

Тэмдэглэх - Нэр:

Байршил:

Тодорхойлох ярилцлага хийсэн он/сар/өдөр:

Тодорхойлох ярилцлага хийсэн газар:

ОУШСБ-ын ахилтан, ярилцлага хийсэн хүний нэр

Ярилцлага ёгч буй хүний хэл:

Орчуулагч: (Тийм/Үгүй)

Орчуулагчийн нэр:

### ЭЛСҮҮЛЭЛТ

Тухайн хүн болон элсүүлэгчийн эхний харилцаа ямар байдлаар үйлдэгдсэн бэ?

(Хувийн харьцаа/Сонингийн зар сурталчилгаа/Радио зар сурталчилгаа/Интернэт зар сурталчилгаа/ТВ зар сурталчилгаа/Гэр бүлийн гишүүн нь худалдсан/Хулгайлагдсан/Бусад)

Хэрвээ БУСАД бол тодорхойлнуу:

Хохирогч хүлээн авагч улсад очоод ямар ажил хийнэ гэж итгэж байсан бэ?

(Аирай-Хүүхэд асрагч/ Газар тарилангийн ажил/ Гэрийн үйлчилгэч/ Үйлдвэрийн газарт ажиллах/ Худалдаа/ Гүйланчлал/ Бусад доогуур төрлийн түвшиний гэмт хэргийн үйлдлүүд/ Албадан цэргийн үйл ажиллагаанд/ Бүжигчин-зугаа цэнгээ/ Sex-worker/ Зөөгч/ Бусад/ NA)

Хүлээн авагч улсад очоод ямар хэмжээнэй цалин авах болно гэж амласан байсан бэ?

(нэг сард хэдэн ам. доллар болох)

Хохирогч элсүүлэгчид менгэе урьдчилан төлсөн эсэх? (Тийм/ Үгүй)

Хэрвээ ТИЙМ бол хэдийн хэр мөнгө төлсөн бэ? (хэдэн ам. доллар болох)

Хэрвээ ЭЛСҮҮЛЭГДЭЭГҮЙ бол хохирогч хулгайлагдсан байсан уу? (Тийм/ Үгүй)

Хэрвээ ТИЙМ бол хохирогч хулгайлагдан эх орныхоо аль нэг хэсэгт албадан тээвэрлэгдсэн үү? (Тийм/ Үгүй)

Хохирогч хулгайлагдан эх орноосоо гадагш албадан тээвэрлэгдсэн үү? (Тийм/ Үгүй)

ОУШСБ.....

Нууц

### ТЭЭВЭРЛЭЛТ

Явахаас өмнө аялалын зардал төлөх шаардлага гарсан эсэх, хэрвээ тийм бол түүнийг хэн төлсөн бэ?  
Ямар төрлийн унаагаар зорчсон бэ? (Автобус/ Машин/ Агаараар/ Гэлт тэрэг/ Завь онгоц/ Явганаар)

Хилээр зорчихдоо тухайн хүн албан ёсны хилийн зурвасаар хил нэвтэрсэн үү? (Тийм/ Үгүй)

Хэрвээ ҮГҮЙ бол хаагуур, хэрхэн хил нэвтэрсэн бэ?

Хэрвээ ТИЙМ бол тодруулна уу-

Хохирогч өөрийн бичиг баримтаар аялсан эсвэл хуурамч бичиг баримтаар хил нэвтэрсэн

(Өөрнийн/Хуурамч/NA)

Тухайн улсад орох эсвэл гарах виз авсан эсэх? Орох виз: (Тийм/ Үгүй/)

Гарах виз: (Тийм/ Үгүй/)

Биеийн байцаалт, бичиг баримт одоо хэнд байгаа вэ? (Тухайн хүнд өөрт нь/ажил олгогчид/

Цагдаагийн газар/Гэмт этгээдэд/NA)

Тухайн хүн дамжуулагч улсад байсан эсэх?

(Тийм/ Үгүй/)

Хэрвээ ТИЙМ бол тодруулна уу-

Тухайн улсад ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байсан эсэх? (Тийм/ Үгүй/)

Хэрвээ тийм бол ямар үйлдэлд оролцож байсан бэ, тодруулна уу-

(Аи pair-Xүүхэд асрагч/ Газар тариалангийн ажил/ Гэрийн үйлчлэгч/ Үйлдвэрийн газарт ажиллах/

Худалдаа / Гүйланчлал/ Бусад доогуур төрлийн түвшиний гэмт хэргийн үйлдлүүд/ Албадан цэргийн

үйл ажиллагаанд/ Бүжигчин-зугаа цэнгээ/ Sex-worker/ Зөөгч/ Бусад/ NA)

### МӨЛЖЛӨГ

Тухайн хүн хүлээн авагч оронд очсонохкоо дараа ямар төрлийн үйл ажиллагаанд оролцсон бэ?

Аи pair-Xүүхэд асрагч/ Газар тариалангийн ажил/ Гэрийн үйлчлэгч/ Үйлдвэрийн газарт ажиллах/ Худалдаа /

Гүйланчлал/ Бусад доогуур төрлийн түвшиний гэмт хэргийн үйлдлүүд/ Албадан цэргийн үйл ажиллагаанд/

Бүжигчин-зугаа цэнгээ/ Sex-worker/ Зөөгч/ Бусад/ NA)

Хэрвээ БУСАД бол тодорхойлоно уу:

Хүлээн авагч оронд очсонохкоо дараа хэдийн хэр хугацааны дараа тэрхүү үйл ажиллагаанд ороцож эхэлсэн бэ?

(Очсонохкоо 7 хоногтоо багтааж/Очсоноосоо 7 хоногийн дараагаар)

Хохирогчийг тухайн үйлдэлд албадан оролцуулсан эсэх? (Тийм/ Үгүй/)

Хэрвээ тийм бол хэрхэн? (Айлан сүрдүүлэх/биеийн хүчирхийлэл хэрэглэн)

Тэрхүү үйл ажиллагаанаас тухайн хүн мөнгө ажиллаж олдог байсан эсэх?

(Нэг сараар, ам.доллар-т харьцуулж гаргах)

Тэр мөнгөнөөс хохирогчид үлдэхийг зөвшөөрдөг байсан эсэх: (USD-p)

Тухайн хүн элсүүлэгч/тээвэрлэгч/мөлжигч-д өр төлөх ёстай эсэх (Тийм/ Үгүй/)

Хэрвээ тийм бол тодруулна уу- Хэдий хэр? (Нэг сараар, ам.доллар-т харьцуулж гаргах)

Ямар зүйлд өр төлж байсан бэ?

Тухайн хүн өөрийн хүслээр дуртай зүйтээ явах эрх чөлөө ямар хэмжээнд байсан бэ?

Ойт зөвшөөрдөгүй/ Зөвхөн хүн дагаж л гардаг/ Хязгаарлалт

тавьдагтуу/ NA)

Мөлжлэгийн нөхцөл байдал ямар байсан бэ?

Ажлын цаг хэтэр урт

Сонголт хязгаарлагдмал/сонголт хийх эрхгүй

ОУШСБ.....

Нүүц

### НЭМЭЛТ БАРИМТЖУУЛАХ МАТЕРИАЛ

#### Нэмэлт баримтжуулах материалууд

Цагдаа болон цагаачлалын албаны тайлангууд  
Аливаа бичиг баримт эсвэл а аялалын тийз  
Хилзэр гарсан болон газардсан хуудас  
ХХГХ-ийн улмаас хүчирхийлэлд өртсөний улмаас эмнэгтийн үйлчилгээ үзүүлэгдсэн талаарх бүртгэл,  
тэмдэглэл  
Хуурамч алжлын гэрээ эсвэл зарын жинхэнэ хуулбар  
Тухайн хүний өөрийн гараар бичигдсэн захианууд

### ШИЙДВЭР

#### Тухайн ХХГХ-ийн хохирогч мөн үү?

(Тийм/ Үгүй/)

Хэрээ үгүй бол (Хууль бусаар хил нэвтрэх/ өөр төрлийн гэмт хэргийн хохирогч/байнгын бус шилжигч/  
гаднаас нэвтрэх оролдлого)

Тухайн эрэгтэй эсвэл эмэгтэй гартуу харих хүснэлтэй эсэх?

(Тийм/ Үгүй/)

Тухайн эрэгтэй эсвэл эмэгтэй ОУШСБ-аас үзүүлэх туслалцаа авахаар шалгарсан эсэх? (Тийм/ Үгүй/)

Хэрвээ үгүй бол Яагаад? (ОУШСБ-аас үзүүлэх туслалцаанаас татгалзсан/албадан гаргагдах тушаал нь гарсан/  
гаднаас нэвтрэх оролдлого/бусад)

Хэрвээ бусад бол тодруулна уу?

Хэрвээ ОУШСБ-аас үзүүлэх туслалцаанаас татгалзсан бол яагаад?

(Айсан/Тухайн улсад үлдэх хүснэлтэй байгаа/ОУШСБ эсвэл ТББ-д итгэхгүй байгаа/бусад)

Хэрвээ бусад бол тодруулна уу

Тэмдэглэгээнүүд



Өөр байгууллагаас  
үйлчилгээ авахаар  
хандуулах болон эргэн  
нийгэмших туслалцаа  
үзүүлэх

# Бүлгийн агуулга

## Танилцуулга

- 3.1 Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах болон туслалцаа үзүүлэх зорилгоор шилжүүлэн байрлуулах
- 3.1.1 Олон улсын байгууллагуудаас туслалцаа үзүүлэхээр хандуулах
- 3.1.1.1 Олон улсад аялах бэлтгэл процедуру
- 3.1.1.2 Олон Улсын Харилцаа холбооны процедуру
- 3.1.1.3 Олон улсад аялах процедуру
- 3.1.2 Улс доторх байгууллагуудаас туслалцаа үзүүлэхээр хандуулах
- 3.1.2.1 Улс доторх Бэлтгэл Процедур
- 3.1.2.2 Улс доторх Харилцаа холбооны процедуру
- 3.1.2.3 Улс дотор аялах процедуру
- 3.1.3 Эргэж ирэхэд үзүүлэх туслалцаа
- 3.1.4 Кейсийн эргэх холбоо
- 3.2 Эргэн нийгэмшүүлэх
- 3.2.1 Нэхэн сэргээх тодорхойлолт болон төлөвлөгөө
- 3.2.1.1 Хувь хүний Эргэн нийгэмшүүлэх тодорхойлолт
- 3.2.1.2 Нэхцэл байдалд эргэн нийгэмшүүлэх тодорхойлолт
- 3.2.1.3 Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө
- 3.2.2 Эргэн нийгэмшүүлэх үйл явц
- 3.2.2.1 Эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэх механизмууд
- 3.2.2.2 Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хамгийн эхний дэмжлэг
- 3.2.2.3 Урт хугацааны Эргэн нийгэмшүүлэх Дэмжлэг
- 3.2.2.4 Хохирогчдод үзүүлэх төр засгийн дэмжлэг
- 3.2.3 Эргэн нийгэмшүүлэх туслалцааны төрөл зүйлс
- 3.2.3.1 Эрүүл мэнд/ эмнэлэг
- 3.2.3.2 Зөвлөгөө егөх
- 3.2.3.3 Санхүүгийн
- 3.2.3.4 Хууль зүйн туслалцаа
- 3.2.3.5 Боловсрол эзэмшигч үйл явцыг үргэлжүүлэх
- 3.2.3.6 Мэргэжил олгох сургалт
- 3.2.3.7 Жижиг үйлдвэрлэл болон орлого бий болгох үйл ажиллагаанууд
- 3.2.3.8 Ажилд зуучлах, цалингийн тэтгэлэг, дагалдан сургах
- 3.2.3.9 Гэр, байраар хангах
- 3.2.4 Насанд хүрээгүйчүүдэд зориулсан эргэн нийгэмшүүлэх туслалцаа
- 3.2.5 Эргэн нийгэмшүүлэх үйл явцтай холбоотой үйл ажиллагааны аюулгүй байдал,
- 3.2.6 Эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааны мониторинг
- 3.2.7 Үнэлгээ
- 3.2.7.1 Хохирогчийн үнэлгээ
- 3.2.7.2 Дотоод үнэлгээ
- 3.2.7.3 Гадаад үнэлгээ

**Хавсралт I: Мониторингийн тайлан**

## Танилцуулга

Энэ бүлэг нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ХХГХ-ийн хохирогчоор тодорхойлогдсон, тогтоогдсон хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн туслалцааг хэрхэн ХХГХ-ийн хохирогч мөн гэж эхэлж тодорхойлох үе шатаас эхлээд статусыг нь тогтоох, үйлчилгээнд хамруулахаар хандуулах, эргэн нийгэмшүүлэх бүхий л үе шатуудад тухайн хохирогч өөрийн эх оронд эсвэл хүлээн авагч оронд эсвэл гуравдагч оронд байгаагаас үл хамааран явуулах талаар өгсөн шат шатны удирдамжийг агуулна.

---

### Хамгаалал үзүүлэх үйл явцад хохирогчийн хэрэгцээ, хүсэлтийг харгалзан үзэж, хүндэтгэх талаар

Хохирогчийг эх оронд нь эсвэл орон нутагт нь буцаах нь түүний хувьд тэр болгон хүсмээр эсвэл түүнд тохирох хамгийн зөв шийдэл биш байдаг. Тийм учраас хохирогчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ХХГХ-ийн хохирогчид зарим нь эх орондоо эргэж очоод мөрдөн мөшгилт, амь нас, эрх чөлөөнд нь аюул заналхийлэл хийхээс айж буцаж очихыг хүсэхгүй эсвэл очих боломжгүй байж болно. Эх орондоо буцах хүсэлгүй эсвэл боломжгүй хохирогчид тухайн хүлээн авагч болон дамжуулагч улсын ХХГХ-ийн хохирогчдод зориулсан орогнол эрэх үйл явц эсвэл тусгай хамгаалалтын механизмд үйлчилгээ үзүүлэхээр хандуулах ёстой. Хохирогчид хэрвээ өөрсдөө зөвшөөрөч эсвэл хүсэж байвал байгууллагууд тэдний сайн сайхны төлөө, хүлээн авагч улсад нь урт хугацааны туршид оршин суух эсвэл гуравдагч улсад шилжүүлэн нүүлгэх зөвшөөрөл эрэхэд нөлөөлж болно. Үйлчилгээ үзүүлэгч хохирогчийг эх оронд нь буцаахдаа заавал түүний урьд өмнө нь амьдарч байсан тухайн орон нутгатай эргэн очих ёстой биш гэдгийг сайтар санаж байх хэрэгтэй. Хэрвээ боломжтой бол хохирогчийн өөрийнх нь хүссэн газар аваачиж суурьшуулах үйлчилгээ үзүүлэгдэх ёстой.

---

Энэ бүлэг хоорондоо холбоотой хоёр хэсгээс бүрдэнэ:

- Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах болон туслалцаа үзүүлэх зорилгоор шилжүүлэн байрлуулах
- Эргэн нийгэмшүүлэх

Энэ хоёр дэд бүлэгт туслалцаа үзүүлэх хувилбаруудын өргөн

сонголт, тэдний удирдамж, дэд бүлэг болгоныг хэрхэн үйл ажиллагаанд ашиглах талаарх дэлгэрэнгүй тайлбарыг санал болгож байна. ХХГХ-ийн мөн чанараас шалтгаалаад кейс болгоныг тусад нь судлан тус бүрт нь асуудлыг шийдэх тул энэ бүлэг аль нэгэн улсад үйлдэгдсэн тодорхой нэгэн кейсийг шийдвэрлэхэд тохиорох өргөн хүрээний бүхий л сонголт бүхий, хамгийн тэгс тохиромжтой тэрхүү ганц зүйл гэж хэлж болохгүй.

Түүнчлэн санхүүжилтийн хязгаарлалт, үндэсний онцлогоос улбаалан зарим тохиолдолд зарим төрлийн эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг хохирогчид хүргэх боломжгүй байдаг. Түүнээс гадна аль нэг байгууллага хохирогчдод хэрэгцээтэй бүх туслалцааг тухайн хүнийг бүрэн эргэн нийгэмшүүлэх эсвэл хохирогчийг эхлэн олж тогтоох, хандуулах, эх оронд нь буцаах болон эргэн нийгэмшүүлэх зэрэг бүхий л үе шатуудад дангаараа үзүүлэх нь бодит бус юм. Гэхдээ энэхүү Гарын авлага нь хохирогчийн эх оронд, дамжуулагч улсад эсвэл хүлээн авагч улсад байх бүх байгууллагуудад зориулан хохирогч хамгаалал, туслалцаа үзүүлэх үйл явцын бүхий л түвшнийг хамруулан бичигдсэн.<sup>1</sup> Тиймээс бүх хэсгүүд нь байгууллага болгонд ижил хэмжээнд тохиороо биш байгаа. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад бүх үйл явцыг сайтар ойлгохын тулд мөн байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хөгжүүлэхэд энэхүү гарын авлагын бүх л бүлгүүд, дэд бүлгүүдийг сайтар үншихыг зөвлөж байна. Гэхдээ зөвхөн зарим нэгэн хэсгүүд нь л тэдний үзүүлдэг үйлчилгээтэй холбоотой байж болохыг ойлгоно уу.

Хохирогчдод шууд туслалцаа үзүүлдэг хамгаалах байр болон бусад байгууллагууд нь цогц бөгөөд туйлын нарийн асуудал мөн тул хохирогчийг өөр байгууллагаас ямар нэгэн эсвэл хэд хэдэн үйлчилгээнд хамруулахаар хандуулах, эргэн нийгэмшүүлэх нийт процесс, хамгаалах байрны онцлог асуудлууд бүгд хамгаалах байрны менежментийн асуудлын талаар тусгасан Бүлэг 4-т тусгагдсан байгаа.

Сэтгэхүйн эрүүл мэнд болон түүнтэй холбоотой асуудлаар үйлчилгээ авахаар хандуулах, эргэн нийгэмшүүлэх асуудлууд нь үе шат болгондоо туйлын нарийн эмзэг байх тул тэдгээрийн талаарх дэлгэрэнгүйг энэ бүлэг болон бүлэг 5-аас сайтар үншин судална уу.

## ХАМГААЛАЛТ БОЛОН ШУУД ТУСЛАЛЦААНЫ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажиллуулдаг хамгаалах байрны үйл ажиллагаанд Холбогдох хүний эрхийн зарчмууд болон НҮБ-ын Палермо Протокол-д үндсэлэн туслалцаа болон хамгаалалтын арга хэмжээнд дараах зарчмуудыг заавал дагж мөрдөх ёстай:

*Хүний эрхийг хамгаалах болон хүндэтгэх нь*

ХХГХ нь хүий эрхийг ноцтой зөрчдөг, ХХГХ-ийн хохирогчийн эрхийг цаашид ч үргэлжүүлэн хохироодог онцгой хор нөлөөтэй үйлдэл тул бүхий л туслалцаа, үйлчилгээг хохирогчийн эрхийг сэргээх, дараа хойшид эрх нь дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд зориулсан хүчин чармайлт байлгах ёстай. Хүний эрх нь хүмүүнлэгийн ажлын бүхий л талуудыг хөхиүлэн дэмждэг. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага туслалцаа үзүүлж буй бүх хохирогчдын хүний жам ёсны эрхийг дэлхийн болон бүсийн хүний эрхийг хамгаалах арга хэрэгсэлд, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай Протокол, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л төрлийн ялгаварлан гадуурахлтыг утсгах тухай Конвенц, Болон бусад Олон Улсын холбогдох арга хэрэгслүүр болон стандартууд үүнд Хүний эрхийн нийтлэг тунхаг мониторинг хүмүүс болон НҮБ-ын хүний эрхийн Дээд Комиссириатаас зөвлөмж болгон Хүний эрх болон Хүний наймааны талаар гаргасан Зарчмууд болон Удирдах зарчмууд хэрхэн дурдсан тэр байдлаар хүндэтгэнэ. ХХГХ-ийн хохирогчид нь эдгээр арга хэрэгслүүдэд дурдсан өөрсдийн эрх болон үүргийг сайтар ухамсарлах ёстай.

*Мэдээлэл бүрэн авсаны үндсэн дээр өгөх зөвшөөрөл*

Хохирогчдод үзүүлэх бүхий л туслалцаа нь хохирогдод тэдгээрийн талаар бүрэн мэдээлэл өгөгдсөний үндсэн дээр явагдана. Хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад анх ирэхээс эхлэн нийгэмд бие даасан, өөртөө итгэлтэй гишүүн болж эргэн ирэх хүртэл, үйлчилгээ үзүүлэгч болон хамтрагч түнш

байгууллагууд хохирогчид үзүүлж буй туслалцаа, үйлчилгээ тэдгээртэй холбогдох үйлдэл, бодлого, үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарлаж, тэдгээр үйл ажиллагаанд хохирогчийн зөвшөөрлийг авах ёстой.

Хохирогчийн бичиг үсэг тайлагдсан бол туслалцааны зарим үе шатуудад хохирогчийн зөвшөөрлийг бичгээр үйлдэх нь нэн чухал. Хэрвээ ажилтнууд хохирогчийн мэддэг хэлээр түүнтэй ойлголцож чадахгүй бол аман болон бичгийн харилцаанд орчуулагчийн туслалцааг авах нь зүйтэй.

Хохирогч нь насанд хүрээгүй хүүхэд байх тохиолдолд тухайн нэгэн арга хэмжээ авах талаар хүүхдийн асран хамгаалагчтай заавал зөвлөлдөж, зөвшөөрөл авсаны дагуу үйл ажиллагаа явуулж байх. Хүүхдийн эрхийн Конвенцийн 12-р зүйлд заасан дагуу хүүхдийн хүсэл, үзэл бодлыг нэн тэргүүнд тавьж анхааралдаа авч үзэх ёстой. Сайтар мэдээлэгдсэний үндсэн дээр үзэл бодол, хүсэлтээ илэрхийлэх боломжыг олгохын тулд хүүхдүүдэд холбогдох бүхий л мэдээллийг заавал байдлаар, жишээлбэл: тэдний эрх, хүртэх боломжтой үйлчилгээнүүд, үүн дотроо харилцаа холбоо, хорогдох байрны процесс, гэр бүлийг хайж олох болон эх орон дахь нөхцөл байдлыг мэдээлэх нь тэргүүн чухал. Асран халамжлах, байр сууцаар хангах, хуулийн төлөөлөл зэрэг бүгдэд хүүхдийн үзэл санааг асуун, тусгах тал дээр анхаарвал зохино. Мэдээллийг хүүхдийн нас, хөгжилд тохирсон байдлаар хийх нь зүйтэй. Хүүхдийн оролцоо нь хоорондын итгэлцлээс эхлэх тул шаардлагатай нөхцөл бүрт, туслалцаа үзүүлэх үе шат болгонд орчуулагчаар хангах шаардлагатай.<sup>2</sup>

### Ялгаварлан гадуурхахгүй байх

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх ажлыг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр явуулах асуудлыг баталгаажуулах үүднээс үйлчилгээ үзүүлэж буй ажилтнууд хохирогчдыг хүйс, бэлгийн чиг хандлага, нас, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, шашин шүтлэг, хэл, улс төрийн итгэл үнэмшил, болон өөр аливаа байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх талаар бичгээр үйлдсэн тусгай бодлоготой байхыг ОУШСБ зөвлөж

байна. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь мөн түншлэгч байгууллагууд болон хохирогчдыг үйлчилгээ үзүүлүүлэхээр хандуулах байгууллагуудад дээр дурьдсан баримтлалтай байх талаар санаа тавин ажиллах.

### *Нууцлал болон хувийн нууцтай байх эрх*

Хохирогчтой хамааралтай бүхий л мэдээлэл болон харилцаанд хохирогчийн нууцлал, хувийн нууцыг хамгаалах үүднээс хандах ёстой. Хохирогчтой уулзах эхний уулзалтаас эхлэн туслалцаа үзүүлэх бүхий л үйл явцыг дуустал тухайн хувь хүн, тухайн тохиолдолтой холбоотой бүхий л мэдээллүүдийг чандлан нууцлах нь тухайн байгууллагын ажилтнуудын хариуцлагын асуудал. Дараах мэдээллийг нууцлал бүхий мэдээллийн жагсаалтад оруулах боловч жагсаалт нь зөвхөн эдгээрээр хязгаардлагдахгүй, үүнд: хохирогчдын өгсөн мэдээлэл, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ үзүүлсэн талаарх бүртгэлүүд, хохирогчийн хуулийн статусын талаарх тодорхойлолт зэрэг орно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ажилтнууддаа хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг зөвхөн “мэдэх шаардлага”-ын дагуу, хохирогчийн бүрэн зөвшөөрлийн үндсэн дээр цуглуулж эсвэл хуваалцах ёстой гэдэг зарчмыг заавал даган мөрдүүлэх ёстой. ОУШСБ нь байгууллагууд тухайн хохирогч урьдчилан мэдээлэгдсэн болон зөвшөөрсөн байдалд үндэслэн, мөн түүнд ямар нэгэн аюул заналхийлэхгүй гэдээт итгэлтэй байх зөвхөн тэр тохиолдолд түүний талаарх мэдээллийг гадагш задалж болно гэсэн нарийн тогтсон бодлоготой байхыг зөвлөж байна. Хувийн нууцыг хадгалах процедурын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөөг 1-р бүлгийн 1.2 болон 5-р бүлгийн 5.17-с харна уу.

ХХГХ-ийн насанд хүрээгүй хүүхэд хохирогчийн талаар Хүүхдийн эрхийн хорооны 6-р Ерөнхий Зөвлөмжийн 29-30-хэсэгт Улсууд болон талууд ганцаараа болон дагалдах хүнгүй хүүхдээс авсан мэдээллийн нууцлалыг хүүхдийн эрхийг хамгаалах ялангуяа түүний хувийн нууцтай байх эрхийг хамгаалах үүднээс хамгаалах ёстой. Энэхүү үүрэг нь эрүүл мэнд болон нийгмийн хамгаалын бүхий л хүрээнд даган мөрдөгдөх болно. Нууцлалтай байх нь бусдын эрхийг хүндэтгэхэд бас хамаатай. Жишээ нь ганцаараа болон дагалдах хүнгүй хүүхдээс мэдээлэл авах, хуваалцах болон хадгалах талаар анхаарах, хүүхдийн эх оронд байгаа

хүмүүст ялангуяа хүүхдийн гэр бүлийн гишүүдэд ямар нэгэн сөрөг үр дагавар дагуулахааргүй байх тал дээр онцгой анхаарах шаардлагатай. Түүнээс гадна хүүхдийн байрлалын талаарх мэдээллийг зөвхөн хүүхдийн аюулгүй байдлын хамгаалалд шаардлагатай үед эсвэл “хүүхдийн сайн сайхны төлөө” зөвхөн эцэг эхэд нь биечлэн өгнө.

#### *Өөрөө өөрийгөө тодорхойлох болон оролцох*

Хохирогчийн эрх болон хэрэгцээг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хохирогчийн сонголт болон шийдвэрийг өөрт нь мэдээлэгдсэнүүдийн үндсэн дээр гаргуулах үүднээс, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд хохирогчтой холбоотой гарч буй шийдвэр болгонд тэдний оролцоог дэмжих ёстой. Ажилтнууд хохирогчидтой хамтран тэдний өөрийгөө хүндэтгэх үзэл, бие даасан байдал, өөрсдөдөө хариуцлагатай байх болон ирээдүйд өөрийнхөө амьдаралд өөрөө хяналт тавьдаг байх чадварыг эргэн сэргээхийн тулд чармайн ажиллах ёстой. Хүүхдийн онцгой хэрэгцээ болон эрхтэй холбоотой мэдээллийг “Мэдээлэгдсэн зөвшөөрөл” хэмээх дээр дурдагдсан хэсгээс харна уу.

#### *Хувь хүнд зориулсан эмчилгээ, хамгаалал*

ХХГХ-ийн хохирогчдод тохиолддог зүйл зарим байдлаараа хоорондоо нийтлэг байдгийг хүлээн зөвшөөрөхийн хажуугаар, ажилтнууд хохирогчдод хувь хүний үүднээс хандан: бие хүн, соёлын, жендерийн болон насны ялгаатай, ХХГХ-т өртөхөөс өмнөх, өртөх үеийн болон өртсөний дараах туршлагууд өөр өөр байдгийг харгалзан үзэж, боломжтой бол зөвхөн тухайн хүнд зориулсан халамж болон туслалцаа үзүүлэх ёстой. Туслалцаа үзүүлэх процесийн бүхий үе шадуудад хохирогчийн хамгаалалт, туслалцаа болон дэмжих арга хэмжээг түүний хувь хүний онцлог хэрэгцээнд тулгуурлан явуулах.

#### *Халамжийг цогц байдлаар тогтвортой хүргэх*

Үйлчилгээнүүд нь ХХГХ-ийн хохирогчийг нөхөн сэргээх нэгэн цогц зүйлийг бүрдүүлэгч хэсгүүд гэдэг утгаараа бүх талын бөгөөд үргэлжлэх хугацаа нь үйлчлүүлэгчийн биеийн, сэтгэл зүйн, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой байна. ХХГХ-

ийн хохирогчдод шаардлагатай бөгөөд чанартай туслалцааг тэдний бүхий л хэрэгцээнд нийцсэн байлгах үүднээс үйлчилгээ үзүүлэгч байгууллага туршлага бүхий өөр үйлчилгээ үзүүлэгч настай хамтран хохирогчдод хэрэгцээтэй бөгөөд бүрэн төгс үйлчилгээ үзүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулна. Хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэхээр хандуулах механизмыг бий болгоно.

### *Нөөцийг тэгши байдлаар хуваарилах*

Үйлчилгээ үзүүлэгч байгуулагууд нь бүхий л үйлчилгээ, материалууд болон нөөцийг хохирогчдын хэрэгцээнд тулгуурлан тэгш байдлаар хуваарилахыг зорих хэрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд хохирогчдод хүртээж болохуйц болон ТББ, Улс хоорондын байгууллага болон төрийн байгууллагаас үзүүлдэг бололцоотой бусад нөөц болон үйлчилгээнээс хүртээх өөр бусад үйлчилгээний талаар санаж байх.

### *Хүүхдийн ашиг сонирхлыг хамгаас илүүд тавих*

Хүүхдэд үзүүлэгдэж буй бүхий л туслалцаа, хамгаалалт нь хүүхдийн сайн сайхан байдлыг дээдлэх зарчид тулгуурлагдана. Насанд хүрээгүйчүүдэд үйлчилгээ үзүүлэх талаар энэ бүлэгт тусгасан байгаа. Хамгааллын болон хүүхэдтэй ярилцлага хийх талаарх нэмэлт удирдамжийг 5-р бүлгийн 5.6 гэсэн хэсгээс үзнэ үү.

## **3.1 Өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулах болон туслалцаа үзүүлэх зорилгоор шилжүүлэн байрлуулах**

Гадаадаас эргэн ирсэн болон эх орондоо байгаа хохирогчдод үйлчилгээ авахаар хандуулах үйл ажиллагааг аль алинд нь аюулгүй, хүндэтгэсэн байдлаар явуулах процедур, үзүүлэх анхны туслалцааг энэ хэсэгт тусгасан.

### **3.1.1 ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХЭЭР ХАНДУУЛАХ**

Дамжуулагч болон хүлээн авагч улсад байгаа хохирогчдод хамаатай 4 зүйл:

- Хохирогч нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад өөрийн хүсэлтээр эсвэл цагдаа болон ТББ байгууллагын тусlamжтайгаар эх орондоо буцах асуудлаар хандуулсан.
- Хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад эх орондоо буцах асуудлаар шууд хандан эсвэл тэр асуудлаар гэр бүлээс нь эсвэл хохирогчийн ойр дотны хүнээс эсвэл үйлчлүүлэгчээс нь хүсэлт гаргасан.
- Хохирогч нь өөр байгууллагын тусlamжтайгаар эх орондоо ж.н.: ТББ, төрийн байгууллагаар буцаагдсан бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллага зөвхөн дамжин өнгөрөгч болон эх оронд нь туслалцаа үзүүлсэн.
- Хохирогч нь хүлээн авагч эсвэл дамжин өнгөрөгч улсад түр хугацаагаар оршин суууч.

Эхний гурван тохиолдолд дамжин өнгөрөгч эсвэл хүлээн авагч улс дахь байгууллага хохирогчийг өөрийн нь хүсэлтээр буцаах асуудлыг зохион байгуулах, явахын өмнөх туслалцаа буюу эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүй зөвлөгөө зэрэг эргэн нийгэмшүүлэх туслалцааг хүсэлт<sup>3</sup> гаргаж, нэн тэргүүнд эх оронд нь хүлээн авагч байгууллагад илгээхээр төлөвлөх шаардлагатай.

Гадаадын иргэн ХХГХ-ийн хохирогч дамжин өнгөрөх болон хүлээн авагч оронд оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийг тухайн улс дахь холбогдох буюу орогнол шийдвэрлэдэг албан тушаалтанд мөн түүнчлэн НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал хариуцсан дээд коммисариатад хандан хохирогч эх орондоо буцахаас айх аюултай талаар хүсэлт гаргах.

### 3.1.1.1 Олон улсад аялах бэлтгэл процедурууд

Хохирогчдын эрхийн хүндэтгэх улмаас байгууллагууд хохирогчдыг эх оронд нь буцаах асуудлыг зөвхөн сайн дурын үндсэн дээр гэдгийг баталгаажуулах үүднээс хохирогчийн мэдээлэл авсаны үндсэн дээр өөрийнх нь бичгээр өгсөн зөвшөөрөлийн дагуу үйлдэнэ. Энэ зорилгоор эх оронд нь буцаах үйлчилгээг үзүүлэгч байгууллага хохирогчийн сайн дураар буцах декларацид гарын үсэг зуруулна.

Сайн дурын үндсэн дээр эх орондоо буцахад туслалцаа үзүүлэх дундаж хугацаа нь тухайн улс дахь нөхцөл байдал тухайн

хувь хүн болгоноос хамаарна. Шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлэхэд цаг хугацаа шаардах бөгөөд мэдээж нөгөө талаас хохирогчид өөрт нь маш чухал болох шийдвэрийт зөв гаргахад нэн чухал биеийн болоод сэтгэл зүйн эрүүл мэндийн байдал тогтворжиход бас хугацаа шаардлагатай.

Хохирогчийг эх оронд нь буцаахаас өмнө үйлчилгээ үзүүлэх өсөхэд Цаг хугацаа хангалттай байдал чухал үүрэг гүйцэтгэнэ. Ихэнх тохиолдолд хохирогчийг эх оронд нь буцаах процесс хэдэн өдөр эсвэл хэдэн 7 хоногийг шаарддаг бөгөөд энэ нь түүнд үзүүлэх үйлчилгээг тодорхойлдог. Хохирогчийг аль болох эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээх нь аялалын өмнөх үеийн гол асуудал, тиймээс гол анхаарлыг аюулгүй байдлын хамгаалал, эрүүл мэндний асуудалд хандуулдаг ч цаг хугацаа болон боломж байвал өөр төрлийн үйлчилгээ үзүүлж болно.

Хохирогчтой эхлэж уулзахад нэгэн даруй хангах ямар нэгэн хэрэгцээ байхгүй тохиолдолд эхний өдөр хохирогчийн нөхөн сэргээхэд зориулж мөн ажилтан төлөвлөгөөг эргэн хянаж туслалцааны үзүүлэх талаар дараагийн өдрөөс нь эхэлж ярилцана гэдгийг мэдэгдэх хэрэгтэй.

#### Аялалын өмнөх эмнэлгийн туслалцаа

Буцахын өмнөх эрүүл мэндийн туслалцаа нь үндсэн эсвэл яаралтай үзүүлэх тусламж болон эрүүл мэндийн үндсэн толрхойлолтоор хязгаарлагддаг. Эрүүл мэндийн үндсэн тодорхойлолтыг хийх үзлэгийн үеэр бусад хохирогчид, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудад, байрлуулах болон аялах хугацаанд бусад олон нийтэд халдвартаж болохуйц хурц халдвартай өвчинд (жишээлбэл сүрьеэ) голчлон анхаарлаа хандуулна. Хохирогчийн эрүүл мэндэд үнэлгээ хийх гол зорилго нь хохирогч эрэгтэй, эмэгтэйн аялалын үед садаа болохуйц эрүүл мэндийн хүндрэлтэй асуудлыг тогтооход оршино. Энэ асуудалд анхааралтай хандан эмийг биеийн болоод сэтгэл зүйн яаралтай хэрэгцээнд зориулахаар бэлдэнэ. Хохирогч эрэгтэй/эмэгтэйн буцаж очих улсад тэр эмний олдоц хангалтгүй эсвэл эмний хэрэглээний нарийн горим зөрчигдэх магадлалтай тул удаан хугацааны туршид хэрэглэх эмээр эмчлэхээс зайлсхийх хэрэгтэй. Хэрвээ хохирогчийн биеийн байдал эрс муу, эмчилгээг

эх оронд нь эргэж очихоос өмнө эхлэх зайлшгүй шаардлагатай бол эмчилгээг үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эсвэл төрийн зохих зөвшөөрөл лиценз бүхий эмч хийх ёстой. Эх оронд нь анагаахын онцлогын улмаас тухайн эмийг олж хэрэглэхэд боломжгүй тохиолдол байдаг тул хүлээн авагч эсвэл гуравдагч улсаар дамжуулан энэ асуудлыг шийдвэрлэнэ.

Эх орондоо эргэж ирэх туслалцааны төрөл, тухайн туслалцааг үзүүлэхэд үүсэх эмчилгээний холбогдолтой аливаа онцлог бүх мэдээллийг хүлээн авагч байгууллагад заавал мэдэгдсэн байна.

### *Түр зуурын байр*

Сайн дураар эргэн ирэх аялалыг аюулгүй зохион байгуулалтын зохицуулах хугацаанаас шалтгаалаад (эрүүл мэнд эсвэл аюулгүйн байдлын асуудал зэрэг) хохирогчийг түр хугацаагаар байр сууцаар хангах шаардлага үүсэн гардаг. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрийн хамгаалах байргүй тохиолдолд байрны асуудлыг нь тухайн улс дахь ТББ, ОУ Байгууллага эсвэл төрийн тогтолцоогоор зохицуулж болно.

### *Түр зуурын бичиг баримт (виза),*

Хохирогч гэмт этгээдүүдэд аялалын болон бусад бичиг баримтаа хураалгасан байж болно. Түр хугацаагаар зорчих болон, эсвэл биеийн байцаалт, бичиг баримтын асуудлыг зохицуулахад холбогдох улсын элчин сайдын яам эсвэл консулын газартай зайлшгүй холбогдож орлуулах бичиг баримт авах шаардлага нь ихэнхдээ цаг авсан, хүнд суртлыг давах шаардлага бас дагуулдаг. Гэхдээ хохирогч орогнол эрсэн хүсэлт гаргасан тохиолдолд тэрхүү хүсэлтийг шалгах хугацаанд дээр дурдсан ЭСЯ болон консулын газруудтай холбоо тогтоо шаардлагагүй. Хүлээн авагч улс дахь дипломат газрын төлөөлөгчдөд үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн талаар урьдчилан мэдэгдэх нь зөв байдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд хохирогчийг буцаах асуудлаар хамтран ажиллах урьдчилан тохиролцолтой байх хэрэгтэй. Тэрхүү уулзалтыг гаргагч орны хүлээн авагч байгууллага зохион байгуулж, шаардлагатай нэмэлт мэдээллээр хангаж байвал тохиромжтой.

## Аюулгүй байдлын дохио

Аюулгүйн байдлыг хангахад нууцлалыг чандлан сахих асуудал чухал бөгөөд мэдээлэл авах эрх аль болох цөөн хүнд байвал зүгээр. Тэр ч байтугай сайн санаатай, итгэлтэй хүн ч хохирогчдод болон туслалцаа үзүүлж буй хүнд хор учруулахуйц мэдээллийг өөр этгээдэд санаандгүй байдлаар өгч болно. Тиймээс хэн нэгэнтэй харьцахдаа үүнд ЭСЯ болон бусад дипломат албаныхан ч орох бөгөөд шаардлагатай бичиг баримт болон туслалцаа авахад хэрэгцээтэй мэдээллийг хамгийн ерөнхий байдлаар өгөх хязгаарлалт хийх хэрэгтэй. Эх орондоо буцахаас эмээж, оргонол болон цагаачлал эрж байгаа хохирогчийн асуудлаар ЭСЯ болон бусад дипломат албаныханд заавал мэдэгдэх шаардлагагүй.

### Насанд хүрээгүй хүүхдийг буцаах нь

ХХГХ-т өртсөн насанд хүрээгүй хүүхдийг түүний сайн дурын хүсэлтийн үндсэн дээр эх оронд нь буцаах нь цогц байдлаар үйлдэгдэх туйлын нарийн асуудал юм. Хүүхдийн эрхийн хорооны 6-р Ерөнхий Зөвлөмжийн 84-р хэсэгт заасанчлан “Хүүхдийг эх оронд нь буцаах нь ‘шалтгаан бүхий эрсдэл’-д хүргэхээр мөн хүүхдийн хүний эрхийг зөрчих нөхцөл болж байвал энэ нь хохирогчийн буцаахгүй байх шалтгаан болж чадна” гэжээ. Хүүхдийг эх оронд нь буцаахдаа энэ нь түүний сайн сайханд төлөө, хүүхдийн ашиг сонирхолд хамгаас тохирсон байх зарчмаар үйлдэгдэх ёстай. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хүүхэд өөрөө эх орондоо буцах хүсэлт гаргасаны дагуу эсвэл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч түүнд эх орондоо буцах туслалцаа авахыг зөвлөх үед түүнийг ямар нэгэн татгалзах зүйлгүй хүлээн авсан тохиолдолд гэхдээ түүний эх оронд буцах эрсдлийн тодорхойлолт эргээр хийгдсэн тохиолдолд энэ үйл ажиллагааг явуулна. Насанд хүрээгүй хүүхдийг эх оронд нь эсвэл гуравдагч улсад дагалдагчгүйгээр явуулах тохиолдолд дараах зааварчилгааг мөрдөх ёстай:

- **Процессийн бүхий л явцад талууд хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх зорилгоор бүхий л зүйлийг түүнд зориулна /Хүүхдийн эрхийн Конвенцийн дагуу мөн тухайн хандуулж буй улсын үндэсний хуулинд эсвэл хэрэжүүлж буй бодлого (практикт тусгагдсанаар)**

- Хүүхэд өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ба илэрхийлэхэд оролцоно;
- Эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрөл;
- Гэр бүлийг хайж олох (энэ нь хүүхдийн ашиг, сонирхолтой зөрчилдөхгүй бол мөн тухайн гэр бүлийн гишүүдэд сөрөг үр дагавар авчрахгүй бол);
- Хүүхэд болон түүний асран хамгаалагчид хангалттай мэдээлэл, зөвлөгөө өгөгдсөн тохиолдолд
- Гэр бүлд нь үнэлгээ хийж тухайн гэр бүл хүүхдийг дэмжиж чадах эсэхийг (гэр бүл хүүхдийг халамжлах хүсэлтэй, болоцоотой эсэх) эсвэл хүлээн авагч орон дахь эргэн нийгэмшүүлэх механизм зэрэг халамж үзүүлэгчийг тодорхойлох
- Хандуулж буй орны хуулиас хамаараад хүүхэд нийгмийн үйлчилгээний байгууллагын эцэг эхийн үүрэг гүйцэтгэгчийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах ёстой. Энэ үйлчилгээ тухайн газар байдаг бол хүүхдийг явахаас өмнө энэ үйлчилгээг үзүүлэх газрыг олсон байна;
- Гэр бүл нь ХХГХ-тэй холбоотой байж магадгүй тохиолдолд бүхий л зохицуулалтыг тэр өнцгөөс харж хийх хэрэгтэй, мөн гэр бүл нь үнэхээр ХХГХ-т холбоотой эсэхийг тодруулах хэрэгтэй.

### Аюулгүй байдлын тодорхойлолт

Аюулгүй байдлын тодорхойлолт нь хувь хүн болгонд сайн дураар эх орондоо буцах процесийн өмнө хийгдэх ёстой. Бүлэг 1-ээс аюулгүй байдлын тодорхойлолт хийх, эрсдлийг буруулах талаар үзнэ үү.

**Зарим олон нийтийн хувьд гэр бүлээ шившиг болгосон эмэгтэйг** гэрийнхэн нь хөөх, тэр ч байтугай амь насыг нь өгүүтгэх хүртэл арга хэмжээ авахыг соёл, заншил хуулиараа хүлээн зөвшөөрсөн байдаг. Хэрвээ хохирогчыг эргэж очиход тэр төрлийн шийтгэл, хүчирхийлэл хүлээж байгаа гэх таамаг бий бол (эсвэл таамаглах өөр бусад шалтгаан байгаа бол) тэр талаар болон өөр бусад сонголтуудын талаар сайтар хэлэлцэн түүнд хохирогчийн хүслийг харгалзан, түүний хүсэлтийн дагуу шийднэ.

### Аялалын өмнөх эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө

Эх орондоо буцахаас өмнөх эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө доор дурьдах хувь хүний тодорхойлолтоор хязгаарлагдана, энэ нь “хэрэгцээ болон хүсэлт”-д чиглэсэн, эрүүл мэндийн анхан шатны тодорхойлолтыг агуулсан байх ч хохирогчийн сэдэлжүүлэлт болон

боловжид харгалзан үзнэ (3.2.1 хэсгээс үзнэ үү).

Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг хохирогчид эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан, буцаж очиж буй улс дахь хүлээн авагч байгууллага боловсруулана. Хохирогчид боломжтой хувилбарууд, боломжуудын талаар зөв ойлголт, хүлээлтийг бий болгох шаардлагатай, ягаад гэвэл эдгээр ойлголтыг буруу эсвэл давуу байдлаар өгөх нь хохирогчийн цаашдын эргэн нийгэмшиг үйл явцад сөрөгөөр нөлөөлж болзошгүй.

### Аялалын тэтгэлэг

Зарим тохиолдолод хохирогчийг эх орондоо буцах үйл ажиллагаанд зориулан аялалын томилолт, хоол хүнс, ус зэрэг хэрэгцээт зүйлсийг хохирогчид бэлтгэн өгөх нь түүний эх орондоо буцах аялал үр дүнтэй явагдахад нэн шаардлагатай байдаг. Аялалын тэтгэлэг эсвэл хэрэгцээт зүйлс нь хохирогчийн эх орондоо буцах аялалыг зохиог байгуулах ажил бөгөөд ялангуяа уг аялал нь аль нэг орноор дамжин өнгөрөхөөр бол аялалын тэтгэлэг болон хангамж аялалд тохиолдож болох зардал, хэрэгцээ, хүнсэнд хангалттай байх ёстой. Боломжтой бол хохирогчид бэлэн мөнгөнөөс илүүтэйгээр түүнд хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлэх нь зүйтэй. Жишээлбэл: урьдчилан бэлдсэн байраар хангах, хайрцаглаж бэлдсэн хоол хүнс эсвэл эм тариа бэлдэж өгөх нь бэлэн мөнгөнөөс илүү хэрэгцээтэй байж болно. Эдгээр зүйлс нь аялалын явцад хохирогч мөнгөө хаяж гээх, онц шаардлагагүй зүйлд зарцуулахаас урьдчилан сэргийлж байгаа арга хэмжээ юм.

Хохирогчийг эх орондоо буцаж очиход нь түүнийг тосох үйлчилгээ үзүүлэхээр урьдчилан зохицуулах ёстой. Тухайн очиж буй газар нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын түвш байгууллага байхгүй бол өөр тохиромжтой байгууллага олж хэрэгцээтэй туслалцаагаар хангах шаардлагатай. Гэхдээ хохирогчийн очсон газар эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагаа байдаггүй бол өөр төрлийн үйлчилгээ, эм, тариа эсвэл тэтгэлэг зэргийг урьдчилан шууд олгох нь тохиромжтой.

### Хохирогчийг эх орондоо буцахаас өмнөх бэлтгэл ажил

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хохирогчид эх орондоо эргэн

очсоны дараа түүнд үзүүлэх туслалцааг ерөнхийд нь урьдчилан хангаж өгөх ёстой. Эх орондоо буцаж буй хохирогчид ихэнхи тохиолдолд хэдий хугацааны дараа эх орондоо буцах вэ хэмээн асуудаг. Ярилцлага авагч тодорхой нөхцөл байдал болон / биеийн байцаалт бичиг баримт нь өөрт нь байгаа эсэх зэрэг/ шаардлагатай үе шатуудыг эхлээд үнэлэн тодорхойлж дараа нь тэдгээрийг давахад хэдий хэр хугацаа шаардагдахыг сайтар тодорхойлох ёстой. Хохирогчид шаардлагатай үе шатууд болон, тэдгээрийг давах хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэгдсэн байна. Тэд мөн уг процессиийн удаашруулах болон түргэтгэх аливаа нөхцлийн талаар сайтар мэдээлэгдэж хэрвээ явах хугацаа тооцож байснаас нь илүү хурдан эсвэл удаан байвал гайхахгүй байх ёстой.

Хохирогчийг эх оронд нь эргүүлэн буцаах үйл ажиллагааг зөв зохион байгуулалттай, аюулгүй байдлаар явуулахын тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хохирогчийг аялалд бэлтгэх хэрэгтэй. Үүнд дараах зүйлсийн талаарх мэдээллүүд хийгдсэн байх ёстой:

- Өөрийнх нь эдлэх эрх болон түүнд үйлчилгээ үзүүлэх хувилбарууд мөн эргэж очсоныхоо дараах даган мөрдөх дүрмүүд болон тэдгээрийг баримтлах зарчмууд,
- Хүлээн авагч байгууллагын утсаны дугаар, очоод холбогдох хүний нэр
- Хэрвээ төлөвлөгдсөн бол аялалын тэтгэлэгийн төлбөр
- Аялалын явцад ялангуяа эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд ямар ч согтууруулах ундааны зүйлс хэрэглэхгүй байх талаар,
- Хүлээн авагч улсад хүртэж болох үйлчилгээний талаар

Хохирогчид түүний эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг хүлээн авч буй улсад хүлээн авагч байгууллага эргэн нийгэмшүүлэх эцсийн тодорхойлолт хийсний дараа боловсруулна гэдгийг тайлбарлах.

---

**Хохирогчид түүнийг хүлээн авч буй улсад хүлээж буй сонголтуудын талаар бодит мэдээллийг өгөх нь нэн чухал, яагаад гэвэл буруу эсвэл худал мэдээлэл өгсөний хор уршиг хохирогчдийн нөхөн сэргээлтийн үр дүнд сэргэээр нөлөөлж болно.**

---

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийн эх орондоо буцах эсвэл үйлчилгээ авахаар өөр байгууллагад хандуулахаас өмнө дараах зүйлсийг баталгаажуулсан байх шаардлагатай:

- Түр хугацаагаар байрлах эсвэл одоогийн түр байрлаж байгаа байрнаас явахад тухайн эрэгтэй, эмэгтэйн биеийн болон сэтгэл зүйн байдал аялалын аюулгүй байдалд нөлөөлхөөргүй хангалттай сайн
- Явахтай холбоотой бүхий л процедурыг ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа
- Зорьсон газраа очсоныхоо дараа тохиромжтой бөгөөд аюулгүй газар түр хугацаагаар байрлана гэдгийг хохирогчтой хамтран сайтар тодорхойлсон байх
- Шаардлагатай хуулийн болон зохион байгуулалтын ажлууд мэн аялалын бичиг баримтууд хохирогчийг явахаас өмнө бэлэн болсон байх
- Эх орондоо очсоны дараа үзүүлэгдэх туслалцаа, үйлчилгээний талаарх бүхий л хандалтууд, хүсэлтүүд сайтар тайлбарлагдсан бөгөөд илгээгдсэн байх
- Хүлээн авагч улс дахь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хохирогчийг хандуулахдаа шаардлагатай бүхий л бичиг баримтууд, аюулгүй байдлын талаарх өгөх бололцоотой мэдээллийг илгээх
- Хохирогчийг транзит (дамжин өнгөрөх) эсвэл хүлээн авагч улс дах түнш ТББ эсвэл бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандуулахдаа аялалын эсвэл үйлчилгээний бүхий л мэдээлэл, төлөвлөгөөнүүд түншлэгч ТББ-д эсвэл үйлчилгээ үзүүлэгч өөр байгууллагад илгээгдсэн, тэр байгууллага нь хүлээн авсан байх
- Хохирогчид өөрт нь холбогдолтой хувийн бичиг баримтыг нь үүн дотроо эрүүл мэндийн эмчилгээ, кейсийн прогресс, болон бусад зайлшгүй шаардлагатай мэдээллийн хувийг хүлээлгэн өгсөн байх,
- Хохирогч өөрийнх нь явах үйл явцын талаар, тээвэр, дараагаар нь хүртэх ёстой үйлчилгээний талаар бүрэн мэдээлэгдсэн байх

*Хохирогч дамжин өнгөрөх, хүлээн авах улсад түр оршин суух эрх хүсэх талаар*

ХХГХ-ийн Протоколын 7-р зүйлд зөвлөсөнөөр талууд улсууд ХХГХ-ийн хохирогчид зохих тохиолдолд түүний нутаг дэвсгэрт нь түр буюу байнга оршин суух бололцоо олгох талаар хууль тогтоох буюу арга хэмжээ авах асуудлыг харж үзнэ. Дээр дурдсан түр болон байнга оршин суух эрхийг зөвшөөрөл олгох хууль, журам бухий улс орнууд (түр хугацааны, эсвэл хүмүүнлэгийн виз) ХХГХ-ийн хохирогчид олгох процедур болон дараагийн үе шатуудын талаар мэдээлэгдэх ёстой. Хохиргчийн хувийн байдалд тулгуурлан (ж.нь: ХХГХ-ийн гэмт этгээдүүдийн эсрэг хуулийн процессд оролцохоор, эсвэл өөр холбогдох асуудлаар виз хүсэх) үйлчилгээ үзүүлэгч байгууллагын захиргааны үйл ажиллагаа явуулах туршлагаас хамааран (бичиг цааш боловсруулан, түүгий дагуу зохих шийдвэрийг хүлээн авах) ярилцлага хийгч тухайн процессийн үргэлжлэх болон дуусах хугацаа, авагдах шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох ёстой. Хохирогч нь процесс болон процессд зайлшгүй шаардлагатай цаг хугацааны талаар тодорхой мэдээлэгдсэн байх ёстой. Түүнээс гадна хохирогчийг сэтгэл санаагаар унах байдалд оруулахгүйн процессийг удаашруулах болон хурдасгах магадлал бүхий хүчин зүйлсийн талаар мэдээлсэн байх ёстой. Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн процесст хэдий хэр хугацаа шаардахыг урьдчилан мэдэж хохирогчид үзүүлэх, санал болгох үйлчилгээг эдгээр байдалд уялдуулан төлөвлөх.

#### **Хохирогч дамжин өнгөрөгч болон хүлээн авагч оронд орогнол эрэх**

ХХГХ-ийн хохирогчидтой ажилладаг үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь зарим хохирогч эх орондоо буцахаас айх айдастай байж болох талаар сайн мэдлэгтэй байх шаардлагатай. Тийм ч учраас хохирогчид нь гэмт этгээдүүдээс зугатан хамгаалал эрэн дамжин өнгөрүүлэгч болон хүлээн авагч улсад орогнол хүсэх эсвэл өөр төрлийн хамгаалалтын механизмын үйлчилгээнд хамрагдах хүслээ илэрхийлэх тохиолдолд тухайн үйлчилгээг үзүүлэх баталгаа байх ёстой. ХХГХ-ийн зарим хохирогчид эх орондоо эргэн очих тохиолдолд амь нас нь аюулд өртөх магадлалыг ХХГХ-ийн Протоколын 14-р зүйл ангид хүлээн зөвшөөрсэн.

ХХГХ-ийн Протоколын 14-р зүйлд “Олон улсын эрх зүй, Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй тухайлбал, Дүрвэгсэдийн эрхийн

байдлын тухай 1951 оны Конвенц болон 1967 оны Протокол, тэдгээрт тусгагсаны дагуу Улсууд болон хувь хүмүүст хамаарах эрх, үүрэг ба хариуцлагыг хөндсөн ямар ч зүйл энэхүү Протоколд байхгүй болно” хэмээн заажээ.

Эргүүлэн-буцаахгүй хэмээх зарчим нь Олон улсын хамгааллын тулгын чулуу болдог. Эргүүлэн-буцаахгүй хэмээх зарчим нь 1951 оны Дүрвэгсэдийн статустай холбоотой Конвенцийн (энд 1951 оны Конвенц гэж заана) бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн Олон улсын эрхийг олж авсан.

Энэ нь удаан хугацааны туршид энэхүү нь зарчим дэлхийн олон орны түүн тусамаа 1951 оны Конвенцэд нэгдэн ороогүй бүх улсуудыг хооронд нь холбодог зарчим юм. Эргүүлэн-буцаахгүй хэмээх зарчмыг бүх улсууд даган мөрдөх ёстой:

- (i) Эргүүлэн буцаахгүй орогнол хүсэгчид эсвэл дүрвэгсэд нь тэдний амьдарч оршин суудаг газар тэдний амь нас, эрх чөлөөг аюул заналхийлэлд оруулах
- (ii) Орогнол хүсэгчид эсвэл дүрвэгсэдийг Хууль бусаар хил нэвтэрсэн эсвэл ХХГХ-т өртөн тухайн оронд ирсэн тул эх орондоо буцвал амь нас эсвэл эрх чөлөө нь эрсдэлд орох улмаас тухайн орноос хамгаалал эрсэн бол татгалзах ёсгүй
- (iii) Өөрийн орон нутагтаа мөрдөн мөшгилтөд өртөн, түүгээс зугатан тухайн улсын хилийн зурваст хүрч ирсэн хүмүүст газар нутагтаа ороход татгалзахгүй.

Эргүүлэн буцаахгүй хэмээх зарчим нь олон улсын болон бүсийн хүний эрхийн хэрэгслийг үүн дотроо Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн З-р зүйлд заасан байдаг. Эргүүлэн буцаахгүй хэмээн хүлээсэн хариуцлага нь бүсийн болон ОУ-ын хүний эрхийн хэрэслүүрт байдаг, түүн дотроо Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн З-р зүйлд тодорхой зааж өгсөн байдаг. Мөн Хүн эрхийн хорооны 31-р Ерөнхий Зөвлөмжиндөө онцгойлон ХХГХ-ийн хохирогчид төрийн төлөөлөгч бус талуудаас үйлдэгдэж болох хүмүүнлэг бус, эсвэл нэр төрийг нь гутаасан арга хэмжээ эсвэл ял шийтгэлээс айж болгоомжлохтой хамаатай (12 параграф)

боловсруулсан хүний эрхийн өмнө хүлээх үүрэгт тусгасан заалт бий. Хүүхдийн асуудлаар Хүүхдийн Эрхийн Хорооны 6-р Ерөнхий Тайлбарт "...(Хүүхдийн Эрхийн) Конвенцийн дагуу хүлээсэн үүргийнхээ улмаас Улс Орнууд нь хүүхдэд нөхөж болшгүй хор хохирол учруулж болзошгүй гэх бодит, буюу үүнд гэхдээ дараах заасан байдлалаар хязгаардлагдахгүйгээр, тус конвенцийн<sup>6</sup> болон 36-р зүйлд заасан эрсдэл учирч болно итгэж болохуйц эрсдэл байвал хүүхдийн амь насанд халдах магадлалтай улсад эсвэл хожим нь хүүхдийн амь насанд нь халдах нь тодорхой улсад эргүүлэн буцаах ёсгүй гэж үүрэг хүлээлгэсэн.<sup>7</sup>

Эргүүлэн буцаахгүй хэмээх зарчим нь ХХГХ-ийн хохирогч дагах мөшгөлт, эсвэл өөр ноцтой аюулын улмаас, жишээблэл ХХГГ-т дахин өртөх, гэмт этгээдүүдийн зүгээс үйлдэгдэж болзошгүй хэлмэгдүүлэлт, эсвэл гэмт хэрэгтнүүдийг сүлжээ болон, эсвэл мөрдлөг хавчлага, нийгмийн гадуурхалт, эсвэл ялгаварлан гадуурхалт зэрэг асуудал мөрдөн мөшгилт болох хэмжээнд үйлдэгдэх магадлалтайн улмаас өөрийн эх орондоо очиходо аиж болгоомжловч буцаагдах тохиолдолд энэ зарчим нь зөрчигдэж байгаа болно. Жишээлбэл зарим хохирогчид өөрийн эх орондоо дахин ХХГХ-т өртөхөөс, ХХГХ-ийн үйлдэгч нараас эсвэл тэдний сүлжээний бусад хүмүүсээс хилсдүүлэлт, сүрдүүлэг өртөхөөс аиж байж болно. Мөн түүнчлэн тун элбэг тохиолддог зүйл бол ХХГХ-ийн хохирогч нар өөрийн эх орны албаны болон эрх баригч хүмүүсээс эсвэл нийгмийн гадуурхалтаас эсвэл өөрийн гэр эсвэл тухайн олонлогоосоо аиж болно. ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хуухдууд гэр бүл нь худалдсан байсан тохиолдолд буцаад өөрийн эх оронд эсвэл олон нийтдээ эргээд очиходор төрөл бүрийн туйлын харгис эрсдэлд орох магадлалтайн улмаас айдастай байж болно. 1951 оны Дүрвэгсэдийн статусад дүрвэгч гэдэг нь - арьсны өнгө, шашин шүтлэг, яс үндэс, тодорхой нэгэн нийгмийн бүлэгт харьялагддагийн улмаас, эсвэл улс төрийн үзэл бодолын улмаас хавчигдан гадуурхагдсан, тухайн улсаар өөрийгөө хамгаалуулах боломжгүй, эсвэл хамгаалуулахыг хүсэхгүй байх ноцтой үндэслэл бүхий шалтгаантай хүнийг хэлнэ гэжээ. ХХГХ-ийн хохирогч нь өөрийх нь эх оронд түүнийг мөрдөн мөшгинө гэж маш сайн үндэслэл бүхий нэг эсвэл таваас дээш шалтгаан айdas бүхий дүрвэгчийн шалтгаан бүхий хүний дүрвэгч болно ХХГХ нь өөрийн гэмт үйлдлийн мөн чанаараараа хүний эрхийг хилсдүүлэлт, сүрдүүлэг, эсвэл өөр байдлаар

айлган сүрдүүлэх зэрэг үйлдээр ноцтой зөрчдөг тул нийгмийн гадуурхалт, хавчлага нь хохирогчийн мэдрэмж, сэтгэл зүйд дайралт болдог мөрдөлт мөшгилтийг заавал араасаа дагуулдаг. ХХГХ-ийн үйлдэлд хүний эрхийг ноцтой зөрчих хэд хэдэн үйлдүүд тухайн гэмт хэргийн мөн чанарын улмаас оршиж байдаг үүнд: ХХГХ-ийн хохирогч нь харгис хэрцгий, мөрдөн мөшгилт түүнд тохиолдсон бол тэр үйлдүүд нь хохирогч эмэгтэй, эрэгтэй эх орондоо буцах тал дээр субъективтэй айдас бий болгож, энэ нь түүнийг дүврэгчийн статуст хүсэлт гаргахад нөлөөнө. ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хүүхэд байх тохиолдолд дүрвэгчийн статусыг нас болон хүйсийн үзүүлэлтээр авч үзэж, хүүхдийн тусгай хэрэгцээг харгалзан, хүүхдэд тохиолдож болох мөрдөн мөшгилтийг бас тогтооно.

ХХГХ-ийн хохирогч хүүхэд жишээлбэл, хүүхдийн онцлог бүхий мөлжлөгт өртсөн байж болно, үүнд, хүүхдийн оролцоотой пронограф, хүүхдийн бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр, тэмээн уралдаан, болон албадан үрчлүүлэлт зэрэг орно. НҮБ-ийн дүрвэгсэдийн асуудал эрхэлсэн зөвлөлийн дээд удирдлагын комиссариатаас 1951 онд гаргасан Зөвшилцэл эсвэл/болон Протоколын 1А зүйлд дүрвэгсэдийн статусыг ХХГХ-ийн хохирогчдод эсвэл ХХГХ-т өртөх магадлалтай хүнд хамаарна хэмээн батламжлагдсан удирдамжийг гаргасан.<sup>8</sup>

Эх орондоо буцах хүсэлгүй боловч 1951 оны Конвенцийн дагуу дүрвэгчийн статус авч чадахгүй байгаа ХХГХ-ийн хохирогч нь байнгын болон түр оршин суух өөр төрлийн зөвшөөрлийн үндэсний хууль тогтоомжинд заасан дагуу авч болно (ХХГХ-ийн хохирогч Дамжуулагч Болон Хүлээн Авагч Улсад Түр Хугацаагаар оршин Суух Эрх Хүсэх Тухай уншина уу). Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ажиллагч ажилтан, сэтгэл зүйчид энэ талаар сайн мэдэж, хохирогч өөрийн эх орондоо ямар нэгэн хуулийн заалтын дагуу шийтгэл авах магадлалыг тогтоох ёстой. Хохирогч аюул занал, эрсдэлд орж болохуйц магадлалын талаар эхний тодорхойлон таних ярилцлага болон зөвлөгөөний үед асуулт тавих хэрэгтэй. Бүх хохирогчдод хорогдох эрх хүсэх боломжийн талаар мэдээлэн тэрхүү эрхийг авах боломжтой тохиолдолд аль нэгэн төрлийн оршин суух эрх авахад шаардлагатай процедурыг ХХГХ-ийн хохирогчид үзүүлнэ. Дүрвэгчийн статус эрэгч ХХГХ-ийн хохирогч нь хорогдох улсдаа хэлмэгдүүлэлт, ял шийтгэл

эсвэл давтан ХХГХ-ийн хохирогч болохоос айдастай байж болно. Хэрвээ дүрвэгч нь орогнол эрсэн улсдаа болон өөрийн эх орондоо адил аюулд өртөхүйц эсвэл түүний ямар нэгэн онцгой хэрэгцээ хангагдахгүй гэж үзвэл тухайн эрэгтэй эсвэл эмэгтэйг гуравдагч оронд шилжүүлэн суулгах асуудал хөндөгдөж болно.<sup>9</sup>

### 3.1.1.2 ОУ-ын харилцаа холбооны процедуру

Хүлээн авагч болон хандуулан дамжуулагч байгууллагуудын хооронд мэдээллийн шуурхай, байнгын солилцоо явагдаж байх нь хохирогчийг эх оронд нь буцаах процессыг зохицуулах болон аюулгүй байдалд аливаа занахийлэл учруулахгүй байх талтай. Дараах тэмдэглэгээнүүд нь мөрдөгдөх ёстой наад захын стандарт болно:

- Үйлчилгээ үзүүлэх хүсэлт бүхий хандуулалт гаргасан байгууллагын туслалцаа хүссэн тэмдэглэгээ
- Хүлээн авагч байгууллага хүсэлтийг хүлээн авсан батламж
- Шилжүүлэлт хийгч байгууллагын эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ хүссэн хүсэлт
- Хүлээн авагч байгууллага эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн батламж
- Шилжүүлэлт хийгч байгууллага хохирогч явсан талаарх батламж
- Хүлээн авагч байгууллага хохирогч ирснийг батламжлах

---

### Аюулгүй байдлын хамгааллын дохио

**Харилцаа холбоо алдагдаж болно.** Тийм учраас тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс тээвэрлэлтийн талаарх нарийвчлал мэдээлэлийг дамжуулах явцад аюулгүй байдлыг сахих шаардлагатай. Тэрхүү харилцаа холбоонд кодлосон имайл, нууцлагдсан утас зэрэг аль болох аюулгүй байдлын өндөр хамгааллыг сахисан аргуудыг ашиглах шаардлагатай.

---

**Шилжүүлэг хийгч байгууллагын туслалцаа хүссэн тэмдэглэгээ**

Хүсэлт гарган, шилжүүлэг хийсэн байгууллагын илгээсэн мэдээлэл дараах агуулгатай байна:

- Хохирогчийн нэр

- Төрсөн он сар өдөр, эх орондоо оршин суудаг газар (хэрвээ эх орондоо буцаж байгаа бол)
- Тодорхойлон таних Ярилцлагын маягт (2-р бүлэн, хавсралт 1)
- Тухайн хүний эрүүл мэндийн талаарх гарч болохуйц эсвэл одоо явагдаж нөхцөл байдал эсвэл эмзэг байдал
- Аюулгүй байдлын хамгаалал болон эрсдлийн үнэлгээ
- Явах өдөр болон цаг
- Холбогдох бусад асуудлууд

ХХГХ-ийн хохирогчийг тогтоох, тодорхойлох тогтоох ярилцлагын маягтыг бүлэг 2, хавсралт 1-д хавсаргасан. ТББ болон бусад хамтрагч байгууллага ХХГХ-ийн хохирогч байх магадлалтай хүнийг илрүүлсэний дараа тухайн хүн үнэхээр Палермо Протоколыг баримтлан тухайн хүн ХХГХ-ийн хохирогч мөн эсэхийг тодорхойлон тогтоох маягтыг ашиглан тодорхойлох процедур явуулж тогтооно. Энэ маягт нь тэрхүү үйл явцын хэрэслүүр юм. Энэ мэдээллийг хүлээн авагч байгууллагад мөн дамжуулах хэрэгтэй. Үйлчилгээ үзүүлэхээр хандуулсан байгууллага энэхүү мэдээлэлд үндэслэн зөвлөлдсөний улмаас үйлчилгээ үзүүлэхээр хандуулсан хүн тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлэх зорилго, удирдамжийн дагуу туслалцаа тохиromжтой хүн эсэхийг өөрсдөө тогтооно.

*Хүлээн авагч байгууллага туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авсан талаарх батламж*

Хүлээн авагч байгууллага тэдэнд үйлчилгээ авахаар илгээсэн хүнийг үнэхээр ХХГХ-ийн хохирогч мөн гэж эсвэл өөрсдийн эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрөөр үйлчилгээ үзүүлэхээр шийдсэн бол шилжүүлэг хийсэн байгууллагад тухайн хохирогчид өөрийн байгууллагын эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэхийг зөвшөөрсөн шийдвэрийг мэдэгдэнэ.

Хэрвээ хүлээн авагч байгууллага үйлчилгээ авахаар хандуулсан хүн ХХГХ-ийн хохирогч биш бол эсвэл өөр шалтгаанаар туслалцаа үзүүлэх боломжгүй хүн гэж тодорхойлсон бол хандуулалт хийсэн байгууллагад тэр талаар тухайн тохиолдол нь тэдний байгууллагын үйлчилгээ үзүүлэх шаардлагад нийцэхээс нааш үйлчилгээ үзүүлэх боломжгүй талаар мэдэгдэнэ. Хүлээн авагч байгууллага өөрсдөө туслалцаа үзүүлэх боломжгүй

байвал уг тохиолдлыг шаардлагатай туслалцаа үзүүлэхүйц өөр байгууллагад хандуулах ёстой.

Батламжлах мэдээлэл нь дараах агуулгатай байна:

- Хохирогчийн нэр
- Төрсөн он, сар өдөр болон эх орондоо оршин сууж байсан байршил (хэрвээ эх орондоо эргэн буцсан бол)
- Хохирогч илрүүлэх болон тодорхойлох удирдамжийн дагуу эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэгдэхээр тодорхойлогдсон (эс тодорхойлогдсон) талаарх батламж
- Хохирогч, боломжтой бол, очих газар нь хэн нэгэн хүлээн авна гэсэн баталгаа
- Шаардлагатай тохиолдолд бусад нэмэлт мэдээллийн талаарх хүсэлт
- Тухайн хүний тохиолдол тэдний туслалцааг авахаар биш бол өөр байгууллагад хандуулсан байдал

#### *Эргэн нийгэмшүүлэх туслалцаа хүсэх нь*

Тухайн хүний статус тодорхойлогдож, үйлчилгээ хүссэн шилжүүлэг илгээгдсэн байгууллага хүлээн авсаны дараа шилжүүлэг хийгч байгууллагаас эргэн нийгэмшүүлэх туслалцааны албан ёсны хүсэлтийг хүлээн авагч байгууллагад илгээх ёстой. Энэхүү хүсэлт нь хохирогчид шаардлагатай туслалцааг дүрсэлсэн байна. Энэ нь эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө биш байна. Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг хүлээн авагч оронд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага боловсруулна. Гэхдээ хохирогч ямар нэгэн онцлог хүсэлт, хэрэгцээтэй байгаад түүнийг нь хандуулагч байгууллага мэдэж байвал тэр талаарх мэдээллийг хүлээн авагч байгууллагад илгээнэ.

#### *Эргэн нийгэмшүүлэх туслалцааг үзүүлэхээр батламжлах*

Эргэн нийгэмшүүлэх хүсэлтийг хянан шийдэх явцдаа хүлээн авагч байгууллага нь санал гаргагч нөгөө байгууллагаас хүсэж буй үйлчилгээг үзүүлж чадах эсэхээ тооцоолж үзнэ. Хэрвээ нөгөө байгууллагын хүссэн үйлчилгээг үзүүлэх боломжтой бол тэр

талаар шилжүүлэг хийсэн байгууллагад эргэж мэдээлнэ. Эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэхэд санхүүжилтийн хэрэгцээ шаардлагатай бол тэр асуудлыг тодорхой байдлаар бичиж илгээнэ.

*Үйлчилгээ шаардлагтай хүн илгээгдсэн талаарх мэдээллийг хүлээн авагч байгууллагаад илгээх нь*

Хохирогчид туслалцаа үзүүлэхээр зөвшилцсөний дараа тухайн үйлчилгээг үзүүлэхэд ОУ-ын тээвэрлэлт шаардлагатай болсон тохиолдолд хохирогчийн явсан талаарх мэдээллийг хохирогчийг биечлэн явсан даруйд хандуулагч байгууллагаас хүлээн авагч байгууллагад илгээгдэнэ. Хэрвээ шилжүүлэг хийгдэх хамгийн сүүлийн мөчид төлөвлөгөөнд ямар нэгэн өөрчлөлт орвол тэр асуудлыг сайтар тодорхойлох шаардлагатай.

Явсны дараа илгээх мэдээлэлд дараах зүйлс орно:

- Хохирогчийн нэр
- Төрсөн он сар өдөр болон байршил
- Аялалын мэдээлэл (аялал, авч явсан хүний нэр г.м.), хөдөлмөрлөх газраа ирсэн он сар өдөр, цаг
- Дагалдан явагчдын нэр;
- Холбогдох бусад мэдээллүүд.

*Хохирогчийн ирсэнийг хүлээн авагч байгууллагаас батламжлах нь*

Хүлээн авагч байгууллага хохирогчийн ирсэн талаар мэдээлийг и-мэйл эсвэл утсаар хандуулсан байгууллагад заавал мэдэгдэх шаардлагатай. Ирсэн талаарх мэдээлэлд:

- Хохирогчийн нэр
- Төрсөн он сар өдөр
- Хохирогч хүрэлцэн ирсэн болон уулзах газар тосож уулзсан талаарх баталгаа
- Холбогдох бусад мэдээллүүд орно.

### 3.1.1.3 Олон улсад аялах процедур

#### Аялалыг төлөвлөх нь

Эх оронд нь буцаах зөвшөөрөл болон санхүүжилт өгөгдсөний дараа бичиг баримт, биеийн байцаалтын асуудал шийдэгдэх хүртэл аялалын түр хугацааны маршрут боловсруулагдах ёстай. Хэрвээ боломжтой бол хохирогчийн аялалын хөтөлбөрийг хохирогч хүлээн авагч улсад ажлын цагаар эсвэл өдрийн цагаар очигоор зохиохыг хичээх хэрэгтэй. Түр хугацааны аялалын төлөвлөгөө зохиогдсоны дараа түүнтэй холбогдох нарийвчлалыг хүлээн авагч байгууллагад бас илгээгдэх ёстай.

#### Тээврийн хэрэгсэл

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хохирогчийг аюулгүй байдлын хамгаалал, нэр төртэй болон хүмүүнлэг байдлаар эх оронд нь буцаах улмаар хандуулагч болон хүлээн авагч улсуудын хооронд явагдах хохирогч буцаах үйл явцыг аль болох стандартчлах хэрэгтэй. Аюулгүй байдлыг хангах үүднээс хамгийн найдвартайд тооцогддог тээврийн хэрэгсэл бол агаарийн тээвэр байдаг, яагаад гэвэл энэ нь бусад төрлийн буюу автобус эсвэл галт тэргийг бодвол зохион байгуулалттай, тодорхой байдаг. Мөн тийм ч учраас хохирогчийн аюулгүй байдлыг хангахад илүү тохиромжтой унаа юм. Хэрвээ тухайн тохиолдолд агаарын тээврийг ашиглах боломжгүй бол өөр төрлийн тээврийн хэрэгслийг гэхдээ тээврийн хэрэгслийг аль болох цөөн удаа солихоор төлөвлөнө.


### 3.1.2 УЛС ДОТОР ТУСЛАЛЦАА ХҮССЭН ХАНДУУЛАЛТ ХИЙХ

Дараах процедур нь хохирогчийн аюулгүй байдал, хувь хүний хүндэтгэсэн хандуулалт болон эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг сайн дураараа эх орондоо эргэж ирсэн эсвэл өөр байгууллагаас үйлчилгээ авахаар хандуулсан хохирогчдод хэрхэн үзүүлэх талаар өгүүлнэ.

Энд дараах гурван нөхцлийг дурьдах нь зүйтэй:

- Хохирогч нь хүлээн авагч орноос албадан эсвэл захиргааны

Зураг 1 Олон улсад хандуулах схемийн блок



шийдвэрээр гаргагдаж эх орондоо ирсэн бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагад өөрөө холбоо барьж ирсэн эсвэл туслалцаа хүсэн хандуулагдсан бол

- Хохирогч өөрөө бие даан эх орондоо хүрч ирсэн бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагад өөрөө холбоо барьж эсвэл өөр байгууллагаар туслалцаа хүсэн хандуулагдсан бол
- Хохирогч улс дотроо үйлдэгдэх ХХГХ-т өртсөн бол.

Нөхцөл байдал ямар ч байсан хүлээн авагчийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага хүлээн авах болон эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ хүссэн бүхий л асуудалд анхаарал хандуулах ёстой.

### 3.1.2.1 Улс доторх бэлтгэх процедур

Хохирогчдод туслалцаа үзүүлэх бүхий л тохиолдлуудад бүхий л туслалцаа нь хохирогчид сайн дурын үндсэн дээр мэдээлэгдсэний улмаас бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хэрвээ бичиг үсэг тайлгадаагүй бол амаар өгсөн зөвшөөрөлд үндэслэн үйлдэгдэх ёстой.

#### Эрүүл мэндийн туслалцаа

Хохирогчид эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэх хүсэлтийг гаргагч байгууллага, институт, албан тушаалтууд тухайн аялал хохирогчид хэр тохиромжтой талаар, хэрвээ боломжтой бол улс доторх хандуулалтад тодорхойлж өгнө. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад аливаа аялал эхлэхийн өмнө тухайн хүний эрүүл мэндийн эмзэг байдлын талаар явахын өмнөх мэдээллийг илгээсэн байх ёстой.

Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх талаарх дэлгэрэнгүйг энэхүү гарын авлагын 5-р бүлгээс үзнэ үү.

#### Аюулгүй байдал болон эрсдлийн үнэлгээ

Аюулгүй байдал болон эрсдлийн үнэлгээ тухайн хүн бүрт нь тусад нь эргэн нийгэмшүүлэх туслалцааны хөтөлбөрт орохоор хийгдэх ёстой. Энэ нь 1-р бүлэгт өгүүлсэн байдлаар тодорхойлох болон туслалцаа үзүүлэх процессиийн аль болох хамгийн эхэнд хийгдэх ёстой.

### Насанд хүрээгүй хүүхдийг хандуулах

Дээр 3.1.1-д дурдсан дагуу улс доторх болон олон улсын хэмжээнд үндсэн нэг ойлголтын дагуу хандуулалтыг хийх болно.

#### 3.1.2.2 Улс доторх харилцаа холбооны процедуру

Улс хоорондын хандуулалт хийх үйл явцтай адил мэдээллийг байнга, өндөр хурдаар, бүрэн байдлаар хүлээн авагч болон хандуулагч байгууллагуудын хооронд дамжуулах нь хохирогчийн аюулгүй бөгөөд үр дүнтэй хандуулалт, эргэн нийгэмшүүлэлтэд туйлын өндөр ач холбогдолтой.

Байгууллагууд аль аль нь эргэн нийгэмшүүлэх үйл явцад тохиолдож болох хязгаарлалт, боломжууд, үүсч болох бэрхшээлүүдийн талаар мэддэг тул үр дүнтэй, аюулгүй эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг тухайн улс орон дотроо хийх нь Олон улс хооронд зохион байгууллах, зохицуулахаас илүүтэй хялбар байдаг. Гэхдээ хохирогчийг улс дотор хандуулахад адил тэмдэглэгээнүүд дагалдах нь зүйтэй, ялангуяа хохирогчийг тээвэрлэх эсвэл шилжүүлэн байрлуулах процедурын явцад анхаарна. Энэ талаар 3.1.1.2-ээс тодруулна уу.

#### 3.1.2.3 Улс дотор аялах процедуру

Хохирогч ямар нэгэн шилжих хөдөлгөөн хийх тохиолдолд шилжүүлэг хийсэн байгууллагын ажилтан дагалдан явж, онгоц эсвэл галт тэргэнд суутал нь хамт байлцана. Аялал хийх шаардлагагүй тохиолдолд шилжүүлэг хийсэн байгууллагын ажилтан хохирогчийг хүлээн авагч байгууллагатай уулзах хамгийн эхний уулзалтанд хамт дагалдан очно.

#### 3.1.3 ЭРГЭЖ ИРЭХЭД ҮЕСТ ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА

Хохирогчийг аюулгүй байдлаар эргэн ирэх болон эсвэл хандуулах үүднээс хохирогчид хүрэлцэн ирэх үед үзүүлэх туслалцааг зохицуулах нь зүйтэй. Хохирогч эргэн ирэх үест хүлээн авагч байгууллага туслалцаа үзүүлэхээс өмнө хүн худалдагч гэмт этгээдүүдтэй тааралдан буцаад худалдагдсан байсан тохиолдууд байдаг.

Хохирогчийг илүү сайн хамгаалахын тулд ОУШСБ-аас хохирогчийг эх орондоо буцах туслалцаа авахад тэднийг тосох туслалцааг бас зайлшгүй байдлаар авахыг санал болгох хэрэгтэй хэмэн зөвлөж байна. Гэртээ харихад туслалцаа авч буй хохирогчид тэндийг тосож авах туслалцааг хүлээн авахыг дэмжих шаардлагатай. Тэмдэглэгээ: энэ нь хохирогч буцаж харьсаны дараа урд нь үзүүлэгдэж байсан тумлалцааг үргэлжүүлэн авах талаар бус зөвхөн эх орондоо харих үест тосуулах үйлчилгээг зөвшөөрөх тухай юм.

Хэрвээ хандуулсан байгууллага хүлээн авагч улсад өөрийн төлөөлөгчтэй бол тосох үйлчилгээ тэр байгууллагаар дамжуулан хийгдэж болно, хэрвээ байхгүй бол өөр төрөл бүрийн хувилбарууд байж болох бөгөөд үүнд: бусад байгууллагуудтай хамтран ажиллах механизмыг хэрэглэж болно. Эх орондоо буцах талаар байгууллагууд холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байдаг.

Улс дотроо хандуулан шилжүүлэг хийх тохиолдолд энэ дүрмийг баримталж, ирэх үед тосож авах үйлчилгээ шаардлагатай байдлаар хийгдэх ёстой.

### 3.1.4 КЕЙСИЙН ЭРГЭХ ХОЛБОО

ХХГХ-ийн хохирогч өөр байгууллагад үйлчилгээ үзүүлэгдэхээр шилжигдсэн тохиолдолд тухайн хүлээн авагч байгууллага хохирогчийн статус болон тухайн хүн сайн байгаа талаарх мэдээллийг хандуулсан байгууллагад нь байнга мэдээлж байх. (3.2.6-д тусгасан эргэн нийгэмшүүлэлтэд мониторинг хийх хэсгийг үзнэ үү). Хохирогчийг өөр байгууллагад үйлчилгээ үзүүлэхээр шилжүүлсэн байгууллага тухайн хүнтэй өртэй нь холбоо тогтоохыг зөвлөдөггүй. Холбоо тогтоох шаардлагатай бол хүлээн авч үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хариуцлага дор, хохирогчийн өөрийнх нь өгөх зөвшөөрлийн дагуу үйлэгдэнэ.

## 3.2 Эргэн нийгэмшүүлэх

Бүлгийн энэ хэсэгт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад ХХГХ-ийн хохирогчдод хамгийн эхэлж холбоо тогтоохоос эхлээд эргэн нийгэмшүүлэх бүхий л процесст хэрхэн туслалцаа үзүүлэх талаар тусгасан байгаа. Тиймээс ч энд ОУ-ын болоод улс доторх хохирогч

хандуулах процесстэй холбоотой. Энэ нь сайн дураар нутаг буцаж буй болон дамжуулагч, хүлээн авач эсвэл өөр гуравдагч оронд орогнол эрсэн хохирогчдын аль алинд нь хамааралтай.

Эргэн нийгэмшүүлэх туслалцааны гол зорилго нь хохирогчийг аюулгүй, хувь хүний хувь хүндэтгэсэн болон биеэ цаашид өрөө аваад явж чадахуйц болгон нийгмийн амьдралд, хүний хэвийн амьдралд эрүүлэн оруулах явдал юм. ХГХ-ийн хохирогч туслалцаа үзүүлэх процесс нь түүнийг хамгаалах байранд эсвэл өөр байранд байрлуулахаас эхлээд эрүүл мэнд сэтгэл зүйн халамж, эргэн нийгэмшүүлэх тэтгэлэгийн нийгмийн болоод хуулийн зөвлөгөө, нийгэмд эргэн оруулах болон мэргэжил олгох сургалтууд зэрэг үйлчилгээний бүхэл бүтэн өргөн хүрээг хамардаг. Гэхдээ ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх туслалцаа нь улс болгонд, хөтөлбөр болгонд өөр өөр байж, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ нь тухайн хэрэгжиж буй хөтөлбөр болон түүнд олгогдож буй санхүүжилтээс шууд хамааралтай байдаг. Зарим туслалцаа нь хүлээн авагч байгууллагагаа өөрөө шууд үзүүлнэ эсвэл хохирогчийн эргэн нийгэмшүүлэлтийг зохион байгуулаж буй тухайн байгууллага үзүүлнэ. Гэхдээ ихэнх үйлчилгээнүүдийг хохирогчийн эх оронд байх төрийн болоод ТББ-ууд үзүүлдэг.

Хохирогчид үзүүлэж буй бүхий л үйлчилгээ болон эргэн нийгэмшүүлэх туслалцаанууд түүний бүрийн зөвшөөрсөн сайн дурын үндсэн дээр явагдана. ОУШСБ-аас үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ажилнууддаа хохирогчдод үзүүлж буй алаваа туслалцаа, үйлчилгээ нь тэдэнд ямар нэгэн нөлөө, үр дүн үзүүлнэ гэдгийг хохирогчдод сайтар тайлбарлах хэрэгтэй гэсэн зааварчилгааг өгөх хэрэгтэй үйлчилгээнүүд нь хохирогч тухайн үйлчилгээг сайтар мэдсэний үндсэн дээр өгсөн зөвшөөрлийн дагуу түүний хувь хүний нууцыг чандлан хадгалагдана гэсэн үндсэн дээр үзүүлэгдэнэ.

### 3.2.1 НӨХӨН СЭРГЭЭХ ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ТӨЛӨВЛӨГӨӨ

Эргэн нийэмшүүлэлтийг үнэлэх нь хохирогч болгонд тус бүрт нь эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг боловсруулахад чухал ач холбогдолтой. Хояр төрлийн үнэлгээг хохирогч болгонд хийх ёстой:

- Хувь хүний үнэлэх, хохирогчтой шууд холбоглотой үзүүлэлтүүдийг үнэлэх;
- Нэхцэл байдлын үнэлгээ нь хохирогчийн орчны бие даасан нэхцэл байдлуудад чиглэсэн үнэлгээ хийх, жишээлбэл: нийгэм-эдийн засгийн онцлог нэхцэл байдал, хохирогчийн буцаж очсон орон/бусэд эргэн нийгэмшүүлэх туслалцааг хүргэх дэд бүтцийн байдал

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үзүүлэх иusлалцааны боломж тэр болгон хохирогчийн хэрэгцээг бүрэн хангахааргүй байдаг нь бодит амьдралд ихээр тохиолддог. Тиймээс хохирогчид нэхцэл байдлын үнэн дүр зураг, боломжийг тайлбарлан, эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөхүйц хүлээлт төрүүлэх зүйл хэлж болохгүй. Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг зөвхөн хүлээн авагч улсад боловсруулах бөгөөд шилжүүлэг хийж буй орон дахь байгуулага нэхцэл байдлын тохиромжтой үнэлгээ гаргах боломжтой бус бол эсвэл хохирогч шилжүүлэг хийсэн байгууллагын хэлсэн зүйлийг буруугаар ухаж ойлгосон, эсвэл байгууллага нэхөн сэргээх өөр онцлог хувилбарын санал болгоогүй бол хэзээ ч шилжүүлэг хийсэн байгууллага тухайн төлөвлөгөөг боловсруулах ёсгүй. Харин ч хандуулалт хийж буй байгууллага хохирогчид эцсийн эргэн нийгэмшүүлэх төлөвлөвлөөг хүлээн авагч улсад хийнэ гэдгийг хэлж өгөх ёстой. Гэхдээ хохирогчийн хувь хүний хувьд хэрэгцээт зүйлс, хүслийг доор дурьдсан байдлаар асуун хүлээн авагч байгууллагад явахын өмнөх тэмдэглэгээнд хавсарган илгээнэ.

---

Хохирогчийн сайн сайхан сэтгэл санаа, урам нь эргэн нийгэмшүүлэх процесст хамгийн чухал зүйл бөгөөд тиймээс ч ялангуяа хүний нөөцийн, санхүүгийн нөөцийн болон цаг хугацааны хувьд хязгаарлалттай тохиолдолд гол анхаарлыг аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлуудад хандуулна.

---

### 3.2.1.1 Хувь хүний Эргэн нийгэмшүүлэх тодорхойлолт

Үнэлгээг хохирогчийн кейсийг хамгийн сайн мэдэх тэр хүн хийх ёстой. Тэр хүн нь тухайн байгууллагын ажилтан, нийгмийн ажилтан, хүүхдийн асран хамгаалагч, ТБ-ыг ажилтан, эсвэл сэтгэл зүйч байж болно. Тухайн хүн эргэн нийгэмшүүлэх хувилбаруудыг амжилттай эргэн нийгэмшүүлэх болон нийгэмд

буцаан оруулах зорилгоор хохирогч болгонд дараах зүйлийг баримтлан үнэлгээ хийх ёстой:

- Хамгийн гол бөгөөд чухал зүйл бол хохирогчийн хэрэгцээ, үүнд: биеийн, сэтгэл зүйн, хуулийн, нийгмийн болон эдийн засгийн хэрэгцээгүүд орж болно.
- Хохирогч зарим нэгэн онцлог хүсэлтүүд, тухайн эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэг нь түүнд үзүүлэх боломжтой эсвэл боломжгүй эргэн нийгэмшүүлэхийн эмзэг нэгэн онцлог хувилбарыг эсвэл үйлчилгээг хүсвэл.
- Зарим нэгэн боломжууд тухайн хүний онцлогоос хамаараад боломжтой байж болно: нас, хүйс, боловсролын түвшин, эсвэл ажлын туршлага.
- Хохирогчийн сэдлийн түвшин, жишээлбэл: эргэн нийгэмшүүлэх процесст оролцсоны улмаас болон эсвэл хувийн нөхцөл байдлын улмаас

ОУ-д хандуулах тохиолдолд хувийн үнэлгээг шилжүүлэг гаргаж буй байгууллага санаачлан хийж, эцэст нь эх оронд нь байх хүлээн авагч байгууллага дуусгана.

### 3.2.1.2 Нөхцөл байдалд эргэн нийгэмшүүлэх тодорхойлолт

Хувийн үнэлгээг нөхцөл байдлын үнэлгээ дагалдах ёстой. Энэ үнэлгээ нь хохирогчийн кейсийг хамгийн сайн мэдэх, түнчлэн хохирогчийн эх орон дахь гэрийнх нь хавийг сайн мэдэх тэр хүн хийх хэрэгтэй. Үүнд ажилтан, нийгмийн ажилтан, ТБ-ын ажилтан, эсвэл сэтгэл зүйч байга. Тэр хүн хохирогч болгоны эргэн нийгэмшүүлэлтийн үнэлгээг дараах хоёр төрлийн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хийнэ:

- Тухайн хүнд үзүүлэх боломжтой хувилбаруудад: тухайн газар орон нутагт нь тодорхой төрлийн мэрэгжлийн сургалт авах боломжгүй эсвэл шаардлагатай санхүүжилт дутмаг тул байсан ч авах боломжгүй. Үүнтэй төстэй байдлаар хамгаалах байр, эрүүл мэндийн үйлчилгээ, улсын халамж эсвэл боловсролын хөтөлбөрүүд хохирогчийн оршин суух газарт хамрагдах боломжтой ба боломжгүй байдаг.
- Санал болгож буй эргэн нийгэмшүүлэх хувилбар хохирогчийн онцлог нөхцөл байдалд хэр тохирч байгаа эсэх. Жишээлбэл:

мэрэгжлийн сургалт хохирогчийн орондоо оршин суух газарт нь тохирожтой байх (жишээ нь: хэрвээ ня-бо мэрэгжлийн хүмүүс ажилтгүйдэлд их өртөж байвал хохирогчид энэ мэргэжил олгох шаардлагагүй эсвэл ня-бо нь хохирогчийн оршин суух газарт хэрэгцээгүй мэргэжил байж болно).

### 3.2.1.3 Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө

Тухайн хүний хувийн болон нөхцөл байдалд хийсэн үнэлгээн дээр суурилан эргэн нийгэмшүүлэх цогц төлөвлөгөө боловсруулж болно. Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсвэл холбогдох түвш ТББ хохирогчдын зөвхөн хувийн хэрэгцээ, чадвар, чанарт тохируулалгүйгээр, эргэн нийгэмшүүлэлт явагдах тухайн улс орон, бус нутаг болон оршин суух газарт илүү тохиромжтой байдлаар, хохирогчийн эргэн нийгэмшүүлэх үнэлгээтэй тохирох, хүрч болохуйц зорилго тавихад нь туслалцаа үзүүлэх нь чухал байдаг. Түүнээс гадна эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсвэл түүний түвш байгууллага үзүүлж чадахуйц туслалцаан дээр тулгуурлах нь зүйтэй. Энэ байдлыг эргэн нийгэмшүүлэх үнэлгээ хийх явцад тооцож орулах нь зүйтэй.

Цаашид төлөвлөгөөнд өөрчлөлт орсон ч гэсэн эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө нь бичгээр туслалцаа үзүүлэх байгууллагуудад (Төрийн, ТББ, Төрийн алтан тушаалтнууд зэрэг) болон хохирогчид илгээгдсэн байх. Төлөвлөгөөний маят улс орон, байгууллага бүрт өөр өөр байх авч дараах зүйлсийг оруулсан байна:

- Гэр бүлийг эргэн нэгтгэх/зуучлах
- Анагаах/эрүүл мэндийн;
- Санхүүгийн /нөхөн олгох тэтгэлэг, гэр бүлийн эсвэл асуултагчийн тэтгэлэг/;
- Хуулийн;
- Боловсролын/мэргэжил олгох сургалт/сургалтын
- Орлогын эх үүсвэр бий болгох үйл ажиллагаанууд;
- Аюулгүй байдлын хамгаалал.

Дээр дурьдсаны дагуу үйлчилгээг хохирогчид бүрэн мэдээлсэн болон хохирогчийн зөвшөөрсөн зөвшөөрлийн дагуу үзүүлэх шаардлагатай. Тиймээс байгууллага хохирогчийн зөвшөөрөл

бүхий гарын үсэтгтэй маягтыг дээр дурьдсан асуудалд болгоноор бүрдүүлэн авах шаардлагатай. Насанд хүрээгүй хүүхдийн тохиолдолд хүүхдийн эцэг эх эсвэл албан ёсны асран хамгаалагч тэрхүү зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурах ёстай.

Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө нь давхар мониторинг, үнэлгээний зорилгоор доор дурдсан байдлаар хэрэгждэг.

### 3.2.2 ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө тодорхой болсоны дараа эргэн нийгэмшүүлэх жинхэнэ үйл явц эхэлж болно.

#### 3.2.2.1 Эргэн нийгэмшүүлэх туслалцаа үзүүлэх механизмууд

ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх туслалцаанууд нь хамгаалах байр, эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээнээс нийгмийн болон хуулийн зөвлөгөө, мэргэжил олгох сургалт хүртэл өргөн хүрээнд явагддаг. Зарим туслалцаанууд хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар үзүүлэгдэж болно. Гэхдээ зарим туршлагын улмаас олон туслалцаанууд өөр байгууллагуудаар эсвэл улсын байгууллагаар үзүүлэгдэж болдог. Зарим тохиолдолд нэг байгууллага бүх үйлчилгээг өрөө дангаараа үзүүлэх боломжгүй эсвэл байгууллага хохирогчийн байх газарт үйл ажиллагаа явуулдаггүй бол туслалцааг өөр байгууллагаар дамжуулан үзүүлэх нь зүйтэй. Мөн эргэх холбоо, мониторинг хохирогчийн оршин суух газрын ойролцоо байгууллага хийх нь зүйтэй. ХХГХ-ийн хохирогчид эргэн нийгэмшүүлэх туслалцааг үзүүлэх 3 гол механизмууд:

- 
- **Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хамгийн эхний дэмжлэг**
  - **Удаан хугацаагаар эргэн нийгэмшүүлэх дэмжлэгийг хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсвэл өөр байгууллагад шилжүүлэх журмаар эсвэл улсын байгууллагаар үзүүлэх**
  - **Хохирогч үзүүлэх төрийн дэмжлэг.**
-

### 3.2.2.2 Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хамгийн эхний дэмжлэг

Энэхүү дэмжлэг нь хүрч ирэхэд үзүүлэх туслалцаа, нэн даруй, эрүүл мэнд, сэтгэл зүйн шинжилгээ, болон богино хугацаагаар байрлуулах, хохирогчийн нийгмийн, хуулийн эдийн засгийн хэрэгцээнд туслах. Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь өөрийн хэрэгжүүлж буй эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр хохирогчид ямар нэгэн түвшний хамаарлын нөхцөл бий болгож байгаа эсэхээс урьдчилэн сэргийлэх асуудалд хүчин чармайлт гаргаж хохирогч өөрийнхөө амьдралд өөрийн шийдвэрээр амьдарч чаддаг болоход тусална. Удаан хугацааны дэмжлэг нь төрийн бус болон төрийн дэмжлэг үзүүлэх бүтцээр үзүүлэгдэнэ.

### 3.2.2.3 Урт хугацааны Эргэн нийгэмшүүлэх Дэмжлэг

Удаан хугацаагаар хохирогч зориулсан эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр нь тэднийг үр дүнтэй эргэн нийгэмшүүлэхэд их ач тустай. Хэрвээ хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага тохирох үйлчилгээг үзүүлдэг бол тэндээс шаардлагатай цогц үйлчилгээг шууд явуулж эхэлнэ. Хэрвээ тийм боломжгүй бол үйлчилгээнүүдийг орон нутгийн нэг эсвэл хэдэн ТББ-уудаар үзүүлнэ. ТББ нь ХХГХ-ийн хохирогчид шууд үйлчилгээ үзүүлэхэд туйлын тохиромжтой байр суурьтай байхаас гадна эргэн нийгэмшүүлэх үнэлгээг хийх, хийхэд туслалцаа үзүүлэх, мөн эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг бэлтгэх болон хэрэгжүүлэх боломжтой юм. Нийгэлд аюулгүй, хүмүүнлэг байдлаар эргэн нийгэмшүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаануудад:

- **Эрүүл мэнд (сэтгэл зүйн үзлэг, шинжилгээ, эмчилгээ) зөвлөгөөг ХХГХ-ийн хохирогчдод оршин суух газарт нь явуулах;**
- **Гэр бүлийг нэгтгэх/зөвлөгөө өгөх;**
- **Эргэн нийгэмшүүлэх процессийн мониторинг хохирогчийн оршин сух газарт нь хийх;**
- **ХХГХ-ийн хохирогч хүүхдийн байр сууц, халамж үзүүлж буй асуудалд мониторинг хийх;**
- **Сургуульд үргэлжүүлэн суралцахад нь туслалцаа үзүүлэх;**
- **Мэргэжил олгох хөтөлбөрүүдийг боловсруулахад туслалцаа үзүүлэх;**
- **Хохирогчдод зориулсан мэргэлжил олгох зөвлөгөө, сургалт;**
- **Ажилд оруулах болон хөдөлмөр эрхлэх талаарх зөвлөгөө;**

- Хохирогчдод зориулсан шилжин суурьших болон мэргэжил олгох сургалтанд суух тэтгэлэг;
- Паспорт зэрэг алдаж гээсэн бичиг баримтаяа эргүүлж авахад туслалцаа үзүүлэх;
- Иргэний асуудалдтай холоотой хуулийн туслалцаа (гэр бүл салалт, эд хөрөнгөө эргүүлэн авах, иргэний хариуцлага);
- Эрүүгийн хэрэгт гэрчээр оролцох хохирогчид хуулийн зөвлөгөө болон төлөөлөгчөөр туслалцаа үзүүлэх (3.2.3.4 болон бүлэг 6, 6.5 үзнэ үү);
- Яаралтай болон мэдээллийн итгэлийн утасны үйл ажиллагаа;
- Хохирогчтой байнгын холбоотой байж түүний аюулгүй байдлыг хамгааллыг батагаажуулах;
- Хохирогчид сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх шаардлагатай үйлчилгээ болох тэднийг өөрсдийгөө хүндлүүлэх эрхийг эдлүүлэх;
- Аюулгүй тээврийн хэрэгслээр хангах зэрэг болно.

Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь орон нутгийн болоод ОУ-ын ТББ-тай сүлжээгээр хамтран ажиллах, хамтын ажиллагааг дэмжих. Энэ дэмжлэг, хамтын ажиллагаа нь хохирогчийн эргэн нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой байхаас гадна эргэн нийгэмшүүлэх механизмын цаашдын оршин тогтоно байдалд ач тустай.

Байгууллагууд өөрсдийн хамтын ажиллагааг ойлголцлын меморандумд эсвэл өөр баримт бичигт байгууллагууд өөрсдийг болоод бусдынхаа үүрэг, ролийг ойлгож байгаа хэмээн гарын үсэг зурж баталгаажуулах нь зүйтэй. Хүлээн авач байгуулага үйлчилгээ үзүүлэхээр хандуулсан байгууллагуудынхаа үйл ажиллагаанд мониторинг хийж үзүүлж буй үйлчилгээний чанар, үрд дүнг баталгаажуулна.

### 3.2.2.4 Хохирогчдод үзүүлэх төр засгийн дэмжлэг

Зарим тохиолдод ХХГийн хохирогчдод үзүүлэх тусламжийг шууд төрийн байгууллагаас үзүүлдэг. Дээр өгүүлсэн туслалцаатай ижил байдлаар төртэй ойлголцолцлын меморандумд гарын үсэг зурах нь тохиролцсон үүргүүдийг биелүүлэх, үйлчилгээг найдвартай үзүүлэхэд хэрэгтэй байдаг. ХХГХ-ийн хохирогчдод төрөөс үзүүлэж буй эргэн нийгэмшүүлэх дэмжлэг нь нийгмийн болоод ажлын зөвлөгөө, мэргэжил олгох сургалт, эрүүл хэндтэй холбоотой туслалцаанууд, хамгаалал болон боловсролын төрөл бүрийн хөтөлбөрүүд байдаг.

### 3.2.3 ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ ТУСЛАЛЦААНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛС

Туслалцаа нь хохирогч болгоны хувийн хэрэгцээнд тулгуурлан үзүүлэгдэх боловч доор дурдагдах туслалцаа ХХГХ-ийн хохирогчдод ихэнх тохиолдод шаардлагатай байдаг туслалцаанууд болно:

- Эрүүл мэнд/эмнэлгийн халамж, үйлчилгээ
- Зөвлөгөө
- Санхүүгийн туслалцаа
- Хуулийн туслалцаа
- Боловсролын системд эргэн ороход ньүзүүлэх туслалцаа
- Мэргэжил олгох сургалт
- Жижиг үйлдвэрлэл явуулах, орлого бий болгох үйл ажиллагаанууд
- Ажилд оруулах, тэтгэмж, халамжийн хөтөлбөрт хамруулах
- Орон гэр, байртай болгох

#### 3.2.3.1 Эрүүл мэнд

ХХГХ-ийн хохирогч нь ХХГХ-т өртөх явцдаа өртөж байсан төрөл бүрийн хандлага, мөлжлөгөөс үүдсэн эрүүл мэндийн асуудалтай байдаг. Тэрхүү эрүүл мэндийн асуудалд ДОХ/ХдХВ, БЗХӨ болон цочрооны дараах синдром орно. Эргэн нийгэмшүүлэх процессийг амжилттай гүйцэтгэхэд хохирогчийн биеийн болоод сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал голчлон тавигдах ёстай.

Тухайн оронд эргэн нийгэмшүүлэх төв байдаг бол эрүүл мэднийн цогц үзлэг шинжилгээг тэнд хийх нь зүйтэй. Хэрвээ удаан хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлага гарвал үйлчилгээ үзүүлэгч байгууллага тэрхүү эмчилгээг хохирогчийн оршин суудаг газрын ойролцоо зохих институттээр нь хийлгэх талаар орон нутгийн байгууллага институтуудэд зохион байгуулна.

Үзүүлж буй бүхий л бусад туслалцааны нэгэн адил хохирогч мэдээлсэний улмаас түүний зөвшөрсөний дагуу хийгдэнэ. Ямарваа шинжилгээ авах эсвэл эмчилгээ эхлэхээс өмнө бүх үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчид мэдээлэгдсэн болон сайн дураар оролцохыг хүсэн зөвшөөрлийг бичгээр авна. Эмийн эмчилгээ нь хохирогчийн биеийн болоод сэтгэл зүйн өвчнийг

анагаахад шаардлагатай. Боломжтой бол хохирогчид өөрт нь бий болсон өвчний талаар тайлбарлан түүнээс үүдэн гарах үр дагавар, бусад холбогдолтой нөхөн үргижүйн болон сэтгийн эрүүл мэндийн байдлын талаар мэдээлэл өгнө.

Түүнээсгадна хохирогч эрүүл мэндийн үзлэг шинжилшээ болон эмчилгээний бүх баримтын хувийг авах эрхтэй. Эрүүл мэндийн ажилтнууд нь хохирогчийг зохих эмчилгээнд бэлдэж, хохирогчийн зөвшөөрөлтэйгээр хохирогчийн оршин суудал газрын ТББ-ад мэдээлж хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туслалцаа хүснэ.

Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх талаарх онцлон удирдамжуудыг энэ гарын авлагын 5-р бүлгээс үзнэ үү?

### 3.2.3.2 Зөвлөгөө өгөх

ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үндсэн зөвлөгөөний талаар доор өгүүлэв. ХХГХ-т өртсөн хүмүүст үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусалцааны талаар 5-р бүлгийн, 5.12.2 хэсгээс тодруулан үзнэ үү. Зөвлөгөөг зохих сургагдсан хүн өгнө. Зөвлөгч нар хүүхэдтэй ажиллах талаар тусгайлан сургагдсан хүмүүс ХХГХ-ийн хохирогч хүүхэдтэй ажиллана.

#### Бэлтгэл

Зөвлөгч нар ХХГХ-ийн хохирогчид зөвлөгөө өгөх үед тухайн нөхцөлд тохируулан биеэ бэлдлэнэ. Үүнд хохирогчтой уулзах бүрт кейсийг нь үзэж танилцах. Шаардлагатай бол зөвлөгч нь хохирогчийн байрлаж буй хамгаалах байрны ажилтнууд болон бусад мэргэжлийн хүмүүстэй уулзан хохирогчид ямар нэгэн ахиц дэвшил гарч байгаа болон өөр ямар нэгэн тусгай хэрэгцээ байгаа эсэхийг лавлана. (жишээ нь: орчуулна, тусгай халамж гэх зэрэг)

Зөвлөгч хохирогчийн ярих асуудалд анхаарал хандуулан шийдвэрлэх, гарсан ахиж дэвшилийг тодорхойлох, практик зөвлөмж гаргах, дараагийн үе шатыг тодорхойлоход хангалттай цаг зарцуулахаар төлөвлөнө. Эхний удаагийн уулзалтын дараа нэгээс хоёр цагийг нэмж төлөвлөнө.

## *Богино хэмжээний зорилго тодорхойлох*

Хохирогчийн гол асуудал, хэрэгцээ, шийдвэрлэх стратегүүд тодорхойлогдоны дараагаар зөвлөгч нь хохирогчтой хамтран нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэхэд процесст шаардлагатай богино хугацааны зорилго тодорхойлох болно. Тохиромжтой богино хугацааны зорилго нь хохирогчийн ирээдүйн тогтвортой хөгжил, нөхөн сэргээлтэнд чиглэсэн хэсэг хугацаанд биелүүлж, хүрч болохуйц байна. (хохирогч хамгаалах байранд байрлах хугацаанд гэх мэт). Зөвлөгч болон хохирогч тусгай зорилтуудыг тодорхойлж гарган зорилгодоо хүрэх цаг хугацааг товлоно.

## *Нөөцөө зарцуулах*

Гол анхаарал хандуулах асуудал, түүнийг зохицуулах үр дүнтэй механизм болон богино хугацааны зорилтууд тодорхойлогдоны дараа зөвлөгч хохирогчид тэрхүү зорилгодоо хүрэх, нөхөн сэргээх шаардлагатай туслалцааг томъёолно. Тэрхүү туслалцанд дараа зүйлс орж олох боловч зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй: эрүүл мэндийн үйлчилгээ, хуулийн үйлчилгээ, гэр бүлд нь нэгдүүлэх, мэргэжил олгох сургалт, ажил олоход нь туслалцаа үзүүлэх болон бусад нөхөн сэргээх эсвэл эргэн нийгэмшүүлэх үйлчилгээнүүд байна. Зөвлөгч нь туслалцаа үзүүлэх хувилбаруудыг хохирогчтой ярилцаж, түүнд санал болгож буй үйлчилгээг хүлээн авах хүсэлтэй байгаа эсэхийг лавлана.

## *Бэлтгэх болон төлөвлөх*

Хэрэгцээтэй үйлчилгээнүүд болон дараагийн үе шад тодорхойлогдоны дараа тэдгээр үйлчилгээг хүртэх, зорилгодоо хүрэх боломжийн талаар батагаажуулах төлөвлөгөө боловсруулна. Энэ шатанд зөвлөгч нь хохирогч болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудад хэрэгжүүлэх шаардлагатай үүргүүдийг өгөх болно. Жишээ нь: ажилтнууд хохирогчдод эрүүл мэндийн үзлэг зохицуулах, тэр үед хохирогч мэдээллийн хаваст байх эрүүл мэндийн халамжийн үйлчилгээний талаар уншиж судалж, эмчээс асуух асуулт байвал бэлдэж, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаж эмчийн өгсөн зааврын дагуу эмчилгээ хийж эхэлнэ.

Зөвлөгч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хамтрагчид болон хохирогчийн тодорхойлсон үүрэг даалгаварын мөн чанар, тоо хэмжээ нь хохирогчийн байдал, нөхцөл байдал, зорилгоос шалтгаална. Туслалцаа үзүүлэх эхний хэдэн өдөрт зөвлөгч нь хохирогчид бага үүрэг даалгавар өгч болно, үүнд: байнгын хооллолт, цагийн хуваарьт дасах, биеийн дасгал сургуулилт хийх зэрэг.

### Ганцаарчилан зөвлөгөө

Хохирогчтой хийх ганцаарчилсан зөвлөгөөнд асуудлыг шийдвэрлэх практик шийдлүүд болон зан үйлийн асуудалд чиглүүлэгдэх болно. Ганцаарчлсан зөвлөгөөний гол зорилго нь ХХГХ-ийн хохирогчид нэн даруй бүрэн нөхөн сэргээгдэхийн тулд асуудлыг шийдэх, нийцүүлэх, суралцах болон хөгжүүлэх зэрэгт туслахад оршино.

Богино хугацааны зөвлөгөөг сэтгэл заслаас тусад нь ялган ойлгох хэрэгтэй. Зөвлөгөө нь ХХГХ-ийн хохирогчид амьдралын онцлог нөхцөл байдлыг шийдвэрлэхэд, нөхөн сэргээгдэх процесст хамааралтай уялдуудан дараагийн шатыг тогтоох туслалцаа үзүүлэх, богино хугацааны зөвлөгөө болохоос хувь хүнийг өөрчлөх ямар ч зорилго агуулахгүй болно.

**Зөвлөгөө өгөх уулзалтуудын үеэр анхаарал хандуулах асуудлууд**

Зөвлөгөө өгөх уулзалтын үед яригдах зүйлс болон, хэмжээ нь хохирогчийн байдал, туршлага, нөхцөл байдал, соёл зан заншил, нас, хүйс, болон хэрэгцээгээс хамаарна. Ерөнхийдөө тухайн хүний нэн даруй, бодит хэрэгцээнд чиглэсэн богино хэмжээний зөвлөгөө болно.

Ихэнх хохирогчдод уулзалтыг цаг нь асуудлын шийдвэрлэх уулзалт болж хохирогчид тулгарч буй дараах асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгддэг:

- Сэтгэл санаа, биеийн хувьд хуучин хэвэндээ эргэн орох;
- Хувийн аюулгүй байдал, гэр бүлээ ХХГХ-дээс холуур аюулгүй байлгах;
- Эрүүлгийн шийтгэл болон бусад ял шийтгэлээс зайлсхийх;

- ХХГХ-нүүдийн эсрэг хууль хэрэгжүүлэгч байгууллагын явуулж, буй хуулийн поцедурт оролцох;
- Гэр бүлийн гишүүнтэй холбоо тогтоо болон өөрийн олон нийт, гэр бүлдээ буцах эсэх;
- ХХГХ-ийн хохирогчийн алга болсон хийгээд эргэж ирэх асуудалд гэр бүл, олон нийт хэрхэн хандах;
- Цаасны ажил, захиргааны бичиг баримт, холбогдох хуулийн асуудлыг дуусгахад шаардлагатай цаг хугацаа;
- Хаана, хэнтэй амьдрах;
- Эдийн засгийн дэмжлэг, тогтвортой байдал.

Дээр дурдсан асуудлуудыг тухайн кейс, хохирогчийн нөхцөл байдал болон бололцоотой нөөцөөс хамааран шийдвэрлэнэ. Дээр дурьдсан асуудлуудыг шийдэх талаарх онцлог зүйлсүүд энэ гарын авлагын холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тусгасан байгаа. Гэхдээ эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд доох дурдагдах зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй.

### Зөвлөгөө өгөх зарчмууд

Хохирогчид дараах зорилгоор туслалцаа, дэмжлэг үзүүлнэ:

- Асуудлыг шийдвэрлэх механизм, шийдвэр гаргах чадвар бий болгох, нөхөн сэргээх;
- Хувь хүний хөгжлийн нөөц бололцоо бусдаас дутуу зүйл байхгүй гэдгийг ойлгох хүлээн зөвшөөрөх хувь хүний өөрийнх нь нөөцийг хөгжүүлэх;
- Тэдний хувийн хэрэгцээ болон нөхцөл байдалд тохирсон практик ач холбогдол бүхий асуудлыг шийдвэрлэх арга замуудыг бий болгох.

Хүүхдэд зөвлөгөө өгөхдөө хүүхдийн ярих хэл, соёл, зан заншил, хөгжлийг анхаарах.

### Туслагч, зөвлөхийн үүрэг

Нийгмийн ажлын мэргэжилтнууд зөвлөхдөө “хүнийг нөөц бололцоо бүхий хүн гэж харах нь түүнийг сэтгэцийн эмгэг тээгч эсвэл эх үүсвэр гэж хандахаас илүү” үйлчлүүлэгчид чадваржуулдаг гэжээ.<sup>10</sup> Энэ нь үйлчлүүлэгч өөрт тулгарсан

асуудлыг хэнээс ч илүү ойлгох чадвартай, бололцоотой учир түүнд тохиолдсон асуудлыг шийдвэрлэхдээ өөрийнх нь туслалцааг авах нь илүү үр дүнтэй гэдэгт үндэслэлдэг байна. Хэтийн энэ төлвөөс үүдэн туслагчийн гол үүрэг бол туслалцаа үзүүлж буй үйлчлүүлэгч эрэгтэй эсвэл эмэгтэйд өөрийгээ хүндэтгэх, өөрийгээ хамгаалах сэтгэлийг өөрийнх нь дотоод нөөц дээр тулгуурлан сэргээх, мөн тухайн хүнд өөрийнх нь амьдрал өөрийнх нь гарг байгаа бөгөөд өөрөө л хянана гэдэг шийдвэрийг өөрөөр гаргуулж, харуулахад оршино.<sup>11</sup>

Тиймээс туслагчийн үүрэг нь үйлчлүүлэгчид асуудлаа зохицуулах, шийдвэрлэх чадварыг өөрийнх нь дотоод эх нөөц, хүсэл зоригороо бий болгоход нь өөрөө өөртөө туслах процессийг явагдахад туслах<sup>12</sup>. Туслагчийн үйлчлүүлэгдэд үзүүлэж буй туслалцаа нь бололцоо олгогч, брокер, өмгөөлөгч, багшийн үүргээр илэрхийлэгддэг:

- Бололцоо олгогчийн хувьд туслагч нь үйлчлүүлэгчид хэрэгцээгээ тодорхойлох, зорилгоо тогтоох, өөрийн эсэргүүцэн даван гарч ирэх чадварыг танъж мэдэх болон асуудлаа шийдвэрлэх арга олоход нь туслах, тавьсан зорилгодоо хүрэх арга замыг зааж өгөхөд туслагч юм.
- Брокер өмгөөлөгчийн хувьд туслагч нь үйлчлүүлэгчид бололцоотой эх үүсвэрээ олоход туслан дэмжих, боломжтой эх нөөцөө үнэлэхэд нь туслах, холбож өгөх ажлын зохицуулах эсвэл өөр байгууллага, хүмүүст хандуулах.
- Багшийн хувьд туслагч нь үйлчлүүлэгчийн чадвар, мэдээллийг өөрөөр нь хөгжүүлэн тухайн үйлчлүүлэгч шийдвэрээ сайтар мэдээлэлтэй байж гаргах, өөрт тулгарсан асуудлыг шийдвэрлэх, урдаа тавьсан зорилгодоо хүрэхэд шаардлагатай чадварыг хөгжүүлэхэд оршино.<sup>13</sup>

Туслагч нь тусалж буй харилцаа нь хэвийн харилцаанаас ялгаатай гэдгийг байнга санаж байх шаардлагатай. Энэ нь мэргэжлийн хүн тод тодорхой зорилго болон чиглэлтэй байх. Ийм байдлаар үйлчлүүлэгчийн зорилгууд тогтоогдож, хүндрэл бэрхшээлүүд ойлгомжтой болж, үйлчлүүлэгч болон нийгмийн ажилтанд аль алинд нь одоо хэрхэх талаарх хариулт илт болсон байна.<sup>14</sup> Энэхүү туслах харилцаа нь хүйтэн хөндий эсвэл халуун хайрласан аль нь ч биш юм. Туслагч нь өөрийн үйлчлүүлэгчид

гаргах хандлагыг сэтгэл зовнисон, халуун дотно, үнэн сэтгэл гаргаж байгаагаа илт ойлгогдохоор илэрхийлэх ёстай.<sup>15</sup>

### 3.2.3.3 Санхүүгийн туслалцаа

Хохирогчийг эргэн нийгэмшүүлэх үйл явцад түүнд зориулсан хэдэн төрлийн санхүүгийн туслалцаа үзүүлж болно. Санхүүгийн туслалцаа үзүүлэх хэлбэр нь хохирогчийг эргэн ирэх, эргэн нийгэмшүүлэхэд оролцсон байгууллагын хөтөлбөрөөс шалтгаална. Хэрвээ санхүүгийн туслалцаа үзүүлэх бололцоотой бол хохирогчид түүний үйлчилгээг нь хүртэж болох тэтгэлэгүүдийн ялгаа, зорилгыг тайлбарлана.

Бэлэн мөнгөөр туслалцаа үзүүлэх олон төрлийн эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ байдаг. Тэдгээрийн зарим нь:

- Тэтгэлэгийг нөхөн шилжүүлэх;
- Гэр бүл эсвэл тэтгэгчийг дэмжих тэтгэлэг

#### *Нөхөн шилжүүлэх тэтгэлэг*

Хохирогч эргэн нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдаж буй оронд энэ тэтгэлийг өгдөг бөгөөд хохирогчийн нийгэмд эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг амжилттэй болгох зорилготой. Θөр орон эсвэл эргэн нийгэмшүүлэх өөр өөр хөтөлбөрөөс ирсэн хохирогч тэдний эргэн нийгэмшүүлэхэд зарцуулагдах тэтгэлэгийн хэмжээнээс болж хоорондоо зөрчил үүсгэн улмаар тэдний эргэн нийгэмших явцад саад болдог туршлага байгаа билээ. Нийт тэтгэлэгийн хэмжээ үлс оронд болгоны амьдарлын өртөгөөс хамааран хоорондоо ялгагдах тул үүнээс үүсэх аливаа асуудлаас зайлсхийхийн тулд тухайн нэг улсад үйл ажиллагаа явуулж буй нэг байгууллагын нэг хөтөлбөрөөс үзүүлж буй тэтгэлэгийг хохирогчдод ижил хэмжээтэйгээр олгохыг зөвлөж байна.

Нөхөн олгох тэтгэлэг нь хохирогчийн хандаж ирсэн 30-90 хоногт нийгэмд эргэн орох ажлыг үр дүнтэй гүйцэтгэх, байр, хоол, хувцас болон бусад нэн шаардлагатай хэрэгцээт зүйлсийг худалдан авахад зориулна. Энэ тэтгэлэгийг хэд хэд хуваан олгож болно. Үүнд хохирогч эх орондоо эргэж ирсэн эсвэл өөр

улсад байрласаны дараа эхний 3 сард эхний шилжүүлгийг хийж болно. Тэтгэлэгийн хэрэгцээт хэмжээг хохирогчийн эргэн нийгэмшүүлэхэд хариуцлагатай хулээн авагч улсад байрлах хүлээн авагч байгууллага тогтоох бөгөөд тухайн орны эдийн засгийн үзүүлэлтүүдэд тулгуурлана.

### Гэр бүл эсвэл тэтгэгчийг дэмжих тэтгэлэг

Гэр бүл эсвэл тэтгэгчийг дэмжих тэтгэлэгийн хүлээн авагч улс дахь үйлчилгээ үзүүлэгч байгууллага хүлээж аваад дамжуулан өгч болно. Энэ тэтгэлэгийг хохирогчийн эцэг эх хүндээр өвчилсөн, дөнгөж хүүхэд төрүүлсэн, өөрөө жирэмсэний улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эсвэл эдгээртэй ижил нөхцөл байдалд байгаа улмаас олгоно. Тэтгэлэгийн хэмжээг хүлээн авагч байгууллага кейсийн нөхцөл байдалд шинжилгээ хийсний улмаас шийдвэрлэн тогтооно. Гэхдээ байгууллага удаан хугацааны хамааралтай байлгах нөхцлийг бий болгож болохгүй. Гэр бүл болон тэтгэгчийг тэтгэх тэтгэлэг нь хохирогчийн эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнтэй нь шууд холбоотой.

#### 3.2.3.4 Хууль зүйн туслалцаа

Хуулийн тулалцаа хоёр том хэсэгт хуваагдаж болно:

- Эрүүгийн процедуртэй холбоотой хуулийн туслалцаа;
- Иргэний процедуртэй холбоотой хуулийн туслалцаа.

Дараах үйл ажиллагааг хохирогчийн нэн даруй хангах шаардлагатай хэрэгцээнд тухайн хүнд эрүүгийн болон иргэний хүүлийг тайлбарлан өөрт хамаатай хуулийн асуудлыг мэдээлэх ёстой. ХХГХ-ийн хохирогчид хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтарч ажиллах, эрүүгийн хэрэгт гэрчээр оролцох боломж буйг мэдэгдэх, хэрвээ гэрчээр оролцох тохиолдолд хуулийн хамгаалалд орох боломжтой, мөн ХХГХ-т өртүүлсэний улмаас өөрт нь учруулсан хор, хохиролд нөхөн төлбөр гаргуулах үүднээс ХХГХ үйлдсэн гэмт этгээдүүдийн эсрэг иргэний хувиар шахалт үзүүлэх магадлалын талаар мэдээлнэ. Хохирогч хуулийн дагуу хандах сонголтын талаар 6-р бүлгийн 6.5 хэсгээс үзнэ үү.

Хохирогч нь ихэвчлэн өөрийн эрхийн талаар мэддэггүй бөгөөд

тэдэнд хуулийн дагуу хандах эрх байгаа талаар болон тэр тохиолдолд ямар амжилт эсвэл үүсч болон эрсдлийн талаар тайлбарлах. Цагаа олсон, холбогдох хуулийн туслалцаа хохирогчийн айдсыг бууруулдаг бөгөөд тухайн эрэгтэй/эмэгтэй хулийн байгууллагатай хамтран ажиллах эсвэл шүүх хуралд оролцохыг хүсч байгаа талаар мэдээлэл авсаны үндсэн дээр шийдвэр гаргахад ач холбгдолтой байдаг. Өөрсдийг нь худалдсан гэмт этгээдүүдийн эсрэг мэдүүлэг өгч буй хохирогчдод хуулийн нэмэлт туслалцаа зайлшгүй шаардлагатай бөгөөд гэрчийн мэдүүлэг өгөх үед дэмжэг үзүүлэх шаардлагатай.

### *Иргэний процедурын туслалцаа*

ХХГХ-ийн хохирогчид гэмт этгээдүүдийн эсрэг тэдэнд үйлдсэн хор хохирол, гэмтэл бэртэл болон эд хөрөнгөө нэхэмжлэх иргэний гомдол гаргаж болно. Ихэнх тохиолдолд иргэний гомдлыг эрүүгийн гомдолтой нэгэн зэрэг гаргаж болдог. Түүнээс гадна хохирогч гэр бүл салалт, хүүхдээ авах, эд хөрөнг хуваарилах, зэрэг ХХГХ, гэмт этгээдүүдтэй хамааралгүй, боловч хуулийн туслалцаа шаардлагатай асуудалтай учирч болно.

Иргэний хэрэгт хуулийн туслалцаанд дараах зүйлсийг багтаана:

- Гэр бүл салалтанд туслалцаа үзүүлэх **Assistance with divorce**
- Паспорт олон бусад бичиг баримт буцаан авах
- Эд хөрөнгөө эргүүлэн олж авах
- Эд хөрөнгөө нэхэмжлэх
- Өв залгамжлах
- Эцэг эх байх эрх
- Гэтэл бэртэл болон алдсан зүйлээ нэхэмжлэх

### **3.2.3.5 Боловсрол эзэмших үйл явцыг үргэлжүүлэх**

ХХГХ-ийн хохирогч боловсролоо дүүргээгүй байх тохиолдолд гардаг. Энэ байдал нь цаашдын ажил хөдөлмөр эрхлэхэд нь саад болдог байна. ХХГХ-ийн хохирогчид тасалдсан боловсролоо гүйцээн эзэмшихэд нь туслалцаа үзүүлэх явдал нэн тэргүүний зорилтуудын нэг мөн. Тухайн орны төрийн байгууллагын албан тушаалтантай хамтраад хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийг боловсролоо үргэлжүүлэх ажлыг

зохион байгуулах эсвэл хохирогч боловсролоо үргэлжүүлэхэд нь санхүүгийн туслалцаа үзүүлэх шаардлагатай. Хохирогчийн оршин суух газар ойрхон байрлах боловсролын байгууллагад хохирогчийг эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөн дахь боловсролыг үргэлжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой.

### *Их дээд сургууль*

Дагалдан гарах зардал өндөр байдаг тул үйлчилгээ үзүүлэгч байгууллага их дээд сургуулийн санхүүжилтийг хийдэггүй. Гэхдээ санхүүжилт хангалттай байх үед их дээд боловсролд тэтгэлэг олгосон тохиолдлууд байдаг. Энэ нь хохирогч сургуулиа дүүргэхэд хэдхэн симестер үлдсэн эсвэл хэрвээ сургуулиа төсвэл ажилд авна гэсэн нөхцөл үүссэн тохиолдлууд юм. Боловсролоо үргэлжүүлэхийг хүссэн хохирогчийн хүсэлтийг түүний эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөнд хэр нийцэх эсэхийг шалгана. Зэрэг бүхий сургалтыг төгсөх хүмүүс бие даан сургалтаа амжилттай дүүргэх, аюулгүй ажил эрхлэх чадвартай гэж үнэлэгдэх ёстой.

### *Сургууль (техник мэргэжлийн сургууль)*

103

Хохирогчийн үнэлгээнд элбэг тохиолддог зүйл бол тухайн хүнд тохирсон мэргэжил олгох болон бусад сургалтанд хамруулах нь тохиромжтой гэж үздэг байна. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрөө энэ үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй бол санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх өөр арга зам хайж болно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн газар, Боловсролын Яам зэрэг холбогдох төрийн байгууллагад хандаж болно.

### *Академик сургалт*

Академик сургалт нь зарим байдлаараа ашигтай. ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хүүхэд ХХГХ-т өртсөний улмаас тасалдсан сургалтаа үргэлжүүлэх тул хүүхдийн эргэн нийгэмшүүлэхэд нэн ач холбогдолтой байдаг. Сургуульд суугаагүй жилүүдээ нөхөн суралцах боломжтой бөгөөд хүүхдийн эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөнд үзүүлэх гол үйлчилгээ байдаг. Тиймээс сургуулийн системд амжилттай эргүүлэн оруулах асуудлыг зохицуулах шаардлага гарна.

### 3.2.3.6 Мэргэжил олгох сургалт

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хохирогчдод тэдний чадавхи, чадвар, боловсролын түвшинд тохирсон болон тухайн газар оронд байх ажил олгогч зэргийг тооцож боловсруулсан ажил эрхлэх зорилго тавина. Түүний дараагаар зорилгодоо хүрэхэд шаардлагатай мэргэжил олгох сургалт явуулна. Мэргэжил олгох сургалт нь хохирогчийг эргэн нийгэмшүүлэхэд хамгийн чухал шаардлагатай үйл ажиллагаа бөгөөд үүгээр дамжуулан тухайн хохирогч нийгэмд бүрэн эрхтэй гишүүн болж эргэн орох, мөн ажил эрхэлж өөрийн амьдралд итгэлтэй байж амьдрах ерөнхий чадавхia дээшлүүлэх боломжтой болдог.

Мэргэжил олгох сургалт нь сайн дурын үндсэн дээр явагдаж, ажил эрхлэхэд шаардлагатай чадавхи зааж сурган, эргэн нийгэмшүүлэх цогц үнэлгээ болон кейсэнд тулгуурлан тухайн хүнд санал болгоно.

Мэргэжил олгох сургалт нь ихэнхдээ бусад ТББ-ууд, боловсролын институтууд, хандивын байгууллагууд, шашны бүлэглэлүүд эсвэл төрийн түншлэгч байгууллагуудтай хамтран явуулдаг. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь өөр газраас авах боломжтой уг нөөцийг хайж, сургалт нь хохирогчийн эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөтэй уялдаа холбоо бүхий бөгөөд тухайн орон нутгийн шаардлагад нийцсэн байх.

### 3.2.3.7 Жижиг үйлдвэрлэл болон орлого бий болгох үйл ажиллагаанууд

ХХГХ-ийн насанд хүрсэн хохирогчид нь эх орондоо эргэн ирсэн даруйдаа эдийн засгийн хүндрэлтэй тулгардаг. Энэ нь тухайн улс дахь эдийн засгийн дорой байдал болон эсвэл сэргэжлийн болон мэргэжшсэн чадавхи дутагдах, зарим тохиолдолд тэдэнд тохиолдсон гэмт хэргийн улмаас нийгэмд гадуурхагдах, депресст орсон болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай болсон байдгаас хамааралтай. Эдгээр хүндрэлүүд хохирогчийг дахин ХХГХ-т өртүүлэх хүчин зүйл болох магадлалтай байдаг нь тэд анх энэ гэмт хэрэгт эдгээр л хүчин зүйлсүүдээс шалтгаалан өртсөн байдаг.

Орлого бий болгох үйл ажиллагаанууд, бичил-үйл ажиллагаа эхлүүлэх тэтгэлэг нь тухайн хүний бие даасан хараат бус байдал, өөртөө итгэх итгэл нэмэгдэхэд үр дүнтэй байдаг. Бага хэмжээний орлого бий болгох үйл ажиллагаа явуулсаны үр дүнд хохирогчийн өөртөө итгэх итгэл нь нэмэгдэж, өрхийнхөө орлогыг мөн нэмэгдүүлдэгээрээ туйлын ач холбогдолтой. Энэ үйл ажиллагааг үр дүнтэй болгох үүднээс орлого бий болгох төслийг бусад хамгаалах болон дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн туслалцаа, мэргэжил олгох сургалт зэрэг үйлчилгээтэй хослуулж болно.

Үйлчилгээ үзүүлэгч эргэн нийгэмшүүлэх үйлчигээний ажилтан болон бусад ижил төстөй үйлчилгээ үзүүлэгч нараас бүрдсэн шинжээчийн бүлэг магадлал бүхий хүмүүст тэдний түрүүчин ажлын туршлага, боловсролын түвшин, чадавхи, бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай чадавхитэй эсэх, ер нь тухайн хүн бизнес чиглэлийн хүн мөн үү гэдэгт хариулт өгнө. Энэ тохиолдолд хохирогчийн хувийн болон нөхцөл байдлын үнэлгээ нь тухайн хүний орон нутаг дахь зах зээл дээрх боломжийг ашиглаж чадах чадавхитай хамт үнэлэгдэнэ.

Анхааруулга: ХХГХ-ийн хохирогч болгон сайн бизнес хийгч байдаггүй. Ихэнх тохиолдолд ХХГХ-ийн хохирогч нар нь нас залуу, туршлагагүй бөгөөд өөрийнхөө бизнесийг эхлэхэд шаардлагатай хариуцлага болон өөрийгөө хийж байгаа үйлдэлдээ зориулах тал дээр дутмаг байдаг. Үзүүлж буй халамж залуу хүмүүсийг өөрийнхөө бизнесийг эхлэхад хүргэж болохгүй, яагаад гэвэл туршлага дутмагийн улмаас бүтэлгүйтэх аваас тэдний нөхөн сэргээх үйл явцад туйлын хор хөнөөлтэй үр дагаварыг дагуулж магадгүй.

Бичил-үйл ажиллагаа явуулах, зохицуулахад мэргэшсэн чадвар, туршлага шаардлагтай болно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хүлээн авагч байгууллагын шаардлагад нийцэхүйц хөтөлбөрийг хийж, олон тэдний үйлчилгээг ХХГХ-ийн хохирогчдод хүргүүлэхээр ажиллана.

ХХГХ-ийн ихэнх хохирогч бизнес эхлүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаагаас хамаагүй ихийг хүсдэг. Бичил-үйл ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлэхэд стандартын 4 шатны загварыг шаарддаг. Түнш байгууллагууд эдгээрийн нэгийг

эсвэл бүгдийг хангаж өгөх бололцоотой байж болно:

- Бизнесс төлөвлөгөө хийх сургалт;
- Бичил-үйл ажиллагааны менежментийн сургалт/орлого бий болгох сургалт;
- Бэлэн тэтгэлэгт хамрагдах;
- Үнэлгээ.

Бичил-үйл ажиллагааны хөтөлбөрүүд дээр нь суралцах болон мэргэжил олгох хөтөлбөрөөр нэмэгдэн бүрэн бүрдэл болж болно. Сургалын болоод орлого бий болгох хөтөлбөрийг нэгтгэсэнээр түрүүчийн үйл ажиллагаанд гарч байсан цоорхойг нөхөн боломжтой боллоо.

### 3.2.3.8 Ажилд зуучлах, цалингийн тэтгэлэг, дагалдан сургах

Хохирогчийг буцаах нь түүнд ажил олж өгөх маш чухал туслацаа шаардлагатай болгодог. Ихэнх тохиолдолд хохирогчдын буцаж буй улс бол ажлын байрны хомсдолд орсон, цалингийн хэмжээ маш доогуур магадгүй тэр үзүүлэлтээс болоод ХХГХ-ийн өртөмтхий болсон байсан байх. Дээр өгүүлсэнчлэн ихэнх хохирогчид ажил хайж олох, ажил олгогчид өөрийгөө нааштай талаас нь танилцуулж мэддэггүй, туршлага бага эсвэл тухайн байгуулага ажлын хуваарийг нууж байдаг. Туслапцаа, үйлчилгээ нь ХХГХ-ийн хохирогчид зөвхөн цалин сайн төлдөг ажил олохоос гадна тэдний байр суурийг бататгах үүднээс ажил олгогч, хамт ажиллагчид агаа харьцах харьцааг зохицуулж өгдөг. Ажилд авах магадлалтай ажил олгогчийн жагсаалтыг дараа нь ирээдүйн эх үүсвэр болгож ашиглаж болох юм. Холбогдох төрийн байгууллагаас ирээдүйн ажил олгогч болох магадлалтай ажил олгогчийн жагсаалтыг гаргуулан авч болно.

Олон нийтийн байгууллагууд болон компаниуд сургалтанд хамрагдаагүй эсвэл өөрөө биеэ дааж суралцсан хүмүүсийг ажилд авах дургүй байдаг. Энэ тохиолдолд цалингийн тэтгэлэг олгох хөтөлбөр нь эдгээр хүмүүст эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд тус нэмэр болдог. Хэрэгжүүлж болох тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь зарим сонгогдсон хүмүүст ажил хийж туршлага хуримтлуулах эхний хэдэн сарын явцад цалингийн тэтгэлэг олгодог. Мөн зарим компанийд ажил

хийхэд шаардлагатай байдаг ажлын хэрэгслээр хангаж өгдөг. Энэ тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллага ажил олгогчид санхүүгийн болон ажлын багаж хэрэгсэл санал болгож оронд нь ХХГХ-ийн хохирогчийг ажилд авахуулахаар тохиролцдог нь нөгөө талаасаа эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад дөхөм болдог.

ХХГХ-ийн хохирогчид мөнгө төлөх өсвэл цалингийн тэтгэлэг хэсэг хугацааны туршид олгохоор тохирсон байхад ажил олгогч тэр ажилд өөр хүн авах бодолтой байж болно. Гэхдээ ийм зүйл тохиолдоггүй байхад сургалтанд суууч сургагдсан, туршлагатай болж өөр газар ажил хайх, ажилд орох садвартай болно. Энэ нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага аль тохиолдолд анхааралтай байж цалингийн тэтгэлэг олгох үйл ажиллагаагаар тухайн хүнийг тэр үйлчилгээнээс хамааралтай болгохгүй байх харин ч тэднийг бие даасан, өөртөө итгэлтэй, ирээдүйд биеэ даагаад авч явж чадахуйц, дахин энэ төрлийн үйлэлд өртөхгүй байх чадвар эзэмшүүлэх шаардлагатай.

Цалингийн тэтгэлэгийн хэмжээ тухайн ажилд зэх зээл дээр оногдож байгаагаас хэтрэх гэрэх ёсгүй. Цалингийн тэтгэлэг нь хохирогчийн орлого нэмэгдүүлэх зорилготой бус. Энэ тэтгэлийн зорилго нь ажил олгогч хохирогчийг өөр хүнд төлдөгөөс доогуур үнээр цалинжуулан ажиллуулах, өсвэл огт цалин өгөхгүйгээр тодорхой хугацааны туршид ажиллуулахыг дэмжихэд оршино. Хохирогч хэсэг хугацны дараагаар жинхэнэ ажилтан шиг чанартай сайн ажиллаж сурсаны дараа ажил олгогч түүнд бүрэн хэмжээний цалин олгон ажиллуулна. Тэтгэлэгийг зах зээлийн жишигээс дээгүүр тооцон олгох нь хүний тэрхүү тэтгэлэгээс хамааралтай болгохоос гадна дараа нь ажил олгогч цалинг бууруулах үед хохирогч сэтгэл дундуур үлдэх болно. Хэрвээ тухайн ажлын хөлс хүний амьдарлын өртөгөөс доогуур буюу амьдралд хүрэлцэхгүй бол өөр нэмэлт ажил олж хийх талаар асуудлыг шийдвэрлэх болно.

### Аюулгүй байдлын хамгаалал болон хувийн нууцлалын дохио

Хохирогчийн хувийн нууцтай байх эрх хэзээд хүндэтгэгдэх ёстой. Ажил олгогч өсвэл ажил олгох магадлалтай хүн хохирогчийн ХХГХ-т өртсөн талаар өөр хүмүүст хэлэх ёсгүй өсвэл одоогийн ажил

**эрхлэлтэй нь огт холбоогүй хохирогчийн өнгөрсөн амьдралын талаар ярих ёсгүй. Энэ нь хохирогчдын эрхийг зөрчихөөс гадна тэдний аюулгүй байдлын хамгаалалд заналхийлэл болно.**

---

### **3.2.3.9 Гэр, байраар хангах**

Хохирогчийн эх оронд нь ХХГХ-ийн насанд хүрсэн хохирогчдод зориулсан хамгаалах байр, эргэн нийгэмшүүлэх төв байдаг ч хохирогчид тэнд эргэж ирсэн дараахан хугацаанд л байрладаг. Хэрвээ хохирогч өөрийгөө авч явах чадваргүй бол гэр бүлдээ эргэж очихыг хүсэхгүй эсвэл очиж чадахгүй байвал амьдран суух ямарваа байнгын орон байр байхгүй бол үйлчилгээ үзүүлэгч байгууллага тэднийг хамгаалах байр эсвэл түр байрлах байранд амьдрахад нь туслалцаа үзүүлэх ёстай. Байрлуулах боломжтой хамгаалах байр эсвэл түр байлгах байрыг тогтоохдоо бусад түнш ТББ-уд, халамжийн албаны хүмүүсээс туслалцаа хүсч болно. Хохирогч тэрхүү мөнгө төлөх шаардлагагүй байранд хэдэн сарын туршид энгийн амьдарч байрлаж сургалтаа дүүргэн, ажил хайж, бололцооны байдлаар ажилд орж, биеэ даасан байдалтай болно. Түүнээс гадна кейсээс хамаараад байрлуулах хөтөлбөр нь эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дөхөм болж болох.

Аюулгүй байрыг нөхөн сэргээх төвөөс гаргаж өгч болох ч энэ нь тэдгээр байгууллагуудыг үйл ажиллагааны гол чиглэл биш бөгөөд тэд зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээг бүрнээр нь хүргэх ёстай болохоос удаан хугацаагаар хүн байрлуулах эсвэл ХХГХ-ийн хохирогчдыг дэмжих зорилготой биш юм. Хохирогчдын яаралтай хэрэгцээг хангасаны дараа хохирогчдыг эх орондоо, төрөлх нутагтаа хариулах талаар хүсэлт гаргана. Гэхдээ тэд эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай хэрэгцээтэй байх тул хохирогчдыг удаан хугацаагаар тэднийг байрлуулах хамгаалах байр эсвэл орогнуулах байртай холбоо тогтоож болно.

Байрлуулах нь хамгаалах байрыг бодвол тогтвортой эргэн нийгэмшүүлэх болон энгийн амьдралд ортол байрлаж байх түр байр юм. Аливаа үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөтөлбөрийн хамгийн гол зорилго нь ХХГХ-ийн хохирогчийг аль болох хурдан хугацаанд, хамгийн бүрэн цогц байдлаар эргэн нийгэмшүүлэх

явдал юм. Хүн байрлуулах хүчин чадал бага, жишээлбэл түрээсийн байранд тодорхой хязгаарлагдмал хугацаанд байрлах нь хамгаалах байрнаас илүү үр дүнтэй байж чадна. Яагаад гэвэл зарим тохиолдолд хамгаалах байр нь хүнийг бусдаас хамааралтай болгож эргэн нийгэмшүүлэх процест сөрөгөөр нөлөөлөх тохиолдол байдаг.

Эцэст нь дурдахад кейсээс хамаарч хохирогчдод аюулгүйн ямар нэгэн заналхийлэл тулгарсан бол өөр байранд байрлуулах сонголт байнга бэлэн байх ёстой. (Тэмдэглэгээ: хамгаалах байрны менежментийн талаар 4-р бүлэгт тодорхой дурдсан байгаа).

### 3.2.4 НАСАНД ХҮРЭЭГҮЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА

Тэднийг эх оронд нь буцаахад ХХГХ-ийн хохирогч /ялангуяа насанд хүрээгүйчүүд/ эдийн засгийн доройтлоос болоод эрүүл мэндийн, эдийн засгийн, мэргэжлийн болоод туршлага дутмагаас, депресс болон бусад сэтгэл зүйн асуудал нийгмийн гадуурхалтанд өртөж болно. Туслалцаа үзүүлэхээр хандаж ирсэн насанд хүрээгүй хүүхдийн ихэнх нь энэ гэмт хэргийн улмаас биесийн болон сэтгэл зүйн асар их дарамтаас гарч ирсэн байх тул тэдгээрийг тодруулан, эмчлэх шаардлагатай. Насанд хүрээгүйчүүдэд тулгарсан эрүүл мэндийн асуудал нь онцгойлон хүнд байдаг. ХХГХ-ийн хохирогч хүүхэд эргэн нийгэмшүүлэх туслалцааг статусаас үл хамаараад, хууль ёсны асран хамгаалагчийнхаа саналд болгосоны дагуу шууд болон шууд бус байдлаар төрөл бүрийн эргэн нийгэмшүүлэх туслалцааг хүлээн авах хүслээ ирэхийлэх эсвэл зөвшөөрөх тохиолдолд энэ туслалцааг хүүхдэд үзүүлнэ. Хүүхдийн гэр бүлийн эдийн засгийн нөхцөл байдал хүүхдийн хэр амжилттай эргэн нийгэмшүүлэх асуудалд нөлөөгч хүчин зүйлс болдог. Эдийн засгийн дэмжлэг болон зөвлөмж зэргийг агуулсан туслалцаа нь зөвхөн хохирогчид ч биш мөн түүний гэр бүлд үзүүлэх шаардлагатай байж болно. Эргэн нийгэмшүүлэх туслалцааг эх оронд нь үзүүлэхээс өмнө дараах зүйлс баталгаажсан байх ёстой.<sup>16</sup>

- Хүүхдийн хамгийн нэн тэргүүн сонирхлыг Хүүхдийн эрхийн Конвенцэд заасан бөгөөд тухайн орны хууль эсвэл бодлогод

тусгагдсан байдаг бөгөөд бүхий л процессийн явцад, оролцогч бүх хүмүүс энэд хамаатай;

- Хуулийн асран хамгаалагчийн зөвшөөрөл;
- Хүүхэд болон/эсвэл хүүхдийн асран хамгаалагчид сайтар мэдээлсэн, зөвлөгөө өгөгдсөн байх шаардлагатай.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь мэргэшсэн ЮНИСЕФ, эсвэл мэргэшсэн ТББ болон холбогдох төрийн албан тушаалтууд, байгууллагуудтай хамтран насанд хүрээгүй хүүхдийн эргэн нийгэмшүүлэх асуудлаар зөвлөгөө тусlamж авч ажиллах ёстай. Хандуулалт хийж буй улсын хууль эрх зүйгээс хамаараад шаардлагатай нөхцөлд хүүхэд төрийн нийгмийн халамжийн хамгаалалд орох ёстай. (Дэлгэрэнгүйг 5-р бүлгийн, 5.6 хэсгээс үзнэ үү)

### **3.2.5 ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ ПРОЦЕССТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

ХХГХ-ийэй тэмцэх хөтөлбөрийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад эрүүгийн гэмт этгээдүүдтэй шууд болон шууд бус байдлаар харилцаанд орж болох магадлалтай тул энэ процессийн явцад эрсдлийг зөв тооцон зохих байдлаар хандах хэрэгтэй. Хохирогчийн эргэн нийгэмшүүлэхтэй холбоотойгоор аюулгүй байдлыг хамгаалах асуудалтай холбоотой байгууллагууд ажилтныхаа, хохирогчийн эсвэл түнш байгууллагын мэдээлж буй аливаа өөрчлөлтийн талаарх мэдээнд анхаарал хандуулж, зохих аюулгүй байдлын хамгаалалын үнэлгээнд засвар оруулах шаардлагатай. Хүлээн авагч үйлчилгээ үзүүлэгч байгууллага эргэн нийгэмшүүлэх процессээс ашиг хүртэгсэд болон ажилтнуудыг хамгаалж чадна хэмээн итгэж байгаа орон нутгийн цагдаа/гүйцэтгэгч түншүүдтэй нягт, хамтран ажилах ёстай.

Энэхүү гарын авлагад санал болгож буй ажилтнуудыг болон ашиг хүртэгсэдийн аюулгүй байдлын хамгааллын арга хэмжээ, түүний хэрэглээг аюулгүй байдалд заналхийлэл болон асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд ашиглана. Аюулгүй байдлын хамгаалалын үйл ажиллагааг сайжруулах, эргэн нийгэмшүүлэх процессийг найдвартай сайн явуулахын тулд эрсдлийн үнэлгээ ойрхон давтамжтай хийж, түр хугацааны аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэх хэрэгтэй. (Дэлгэрэнүй мэдээллийг 1-р бүлгээс үзнэ үү)

### 3.2.6 ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МОНИТОРИНГ ХИЙХ

Эргэж ирсэнээс нь хойш ХХГХ-ийн хохирогчтой байнга уулзан, холбоотой байж тэдний аюулгүй байдал, эргэн нийгэмшүүлэх порцессийн үр дүнг ажиглана. Хохирогчийн оршин суудаг газрын ойролцоо байрлах түншлэгч байгууллага шууд туслалцааг үзүүлэлгүй эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөөг бэлтгэх, хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хянах болно. Эргэн нийгэмшүүлэх процессын мониторинг нь түүний хэрэгжилтийн үр дүнд гарч буй амжилтуудын үзүүлэлтүүдийг тэмдэглэх зорилгоор зайлшгүй шаардлагтай зүйл юм.

Мониторинг нь туслалцаа авч буй хохирогч болгоноор сар болгоноор гүйцэтгэгдэн энхий гурван сард тасралтгүй хийгдэх ёстай. Мөн дараагийн хагас жилийн туршид эргэн нийгэмшүүлэх -мониторинг хийгдэх байх ёстай. Хохирогчийн эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг эргэн хянах явц үргэлжлэхээс гадна мониторингийн хяналтаар тухайн хохирогч өөрийн гэр булийн хүрээнд заналхийлэл, сүрдүүлэг болон дарамт шахалтанд орж байгаа эсэхийг хянана. (мониторинг тайлангийн загварыг үзнэ үү, энэ бүлгийн Хавсралт 1).

Хохирогчийг нэг жилээс илүү хугацаагаар мониторингийн хяналтанд байлгахаас зайлсхийх хэрэгтэй /насанд хүрээгүй хүүхэд биш бол/. Яагаад гэвэл энэ нь нөхцөл байдлын хэвийн урсгалаар явах үйл явцад садаа болохоос гадна эргэн нийгэмшүүлэх процессэд сөрөгөөр нөлөөлөх магадлалтай. Насанд хүрээгүй хүүхдийн талаар ЮНИСЕФ-ийн зөвлөмжийг үзнэ үү.<sup>17</sup>

#### Дэмжих бүлэг

Хохирогчийг дэмжих бүлэг нь түүнд үзүүлж буй эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чухал нөлөөтэй байдаг. Дэмжих бүлгийн хүмүүс бие биедээ тусалж дэмжихээс гадна асуудал үүссэн тохиолдолд шаардлагатай нэмэлт туслалцааг хүсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандана.

### 3.2.7 ҮНЭЛГЭЭ

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хянах, үнэлэх шаардлагатай тохиолдолд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ болон холбогдох процедурыг байнга, давтамж болон үргэлжлэлтэйгээ тохируулж байх шаардлагатай. Үүнд дараах аргачлалуудыш ашиглаж болно:

- Хохирогчийн үнэлгээ
- Дотоод үнэлэх
- Гадаад үнэлгээ
- Донорын үнэлгээ
- Үнэлгээ нь Үндсэний Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах мониторинг процессийн нэг хэсэг юм.

#### 3.2.7.1 Хохирогчийн үнэлгээ

Ашиг хүртэгсэд хүлээн авч буй үйлчилгээний талаарх илэрхийлж буй илэрхийлэл нь тухайн үйл явцын сүл талуудыг эмнэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн, хуулийн хэрэгцээг нь хангаж чадаж байгаа эсэх эсвэл дараагийн төсөлд зарим өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлж өгдөгөөрөө нэн давуу талтай.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үзүүлж буй үйлчилгээнд санал асуулга авдаг маягтыг боловсруулж үйлчилгээ авсан хүн болгоны нэрийг нь нууцлан бөглүүлж болно. Үүнийг эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааны үе шат болгонд, хандуулсан оронд хүлээн авсан үйлчилгээнд, явах болон ирэх туслалцаанд, эрүүл мэндийн сэтгэл зүйн туслалцаа, эргэн нийгэмшүүлэх тэтгэлэг, мэргэжил олгох сургалт, хуулийн туслалцаа, болон бусад бүхий л хэлбэрийн тусалцаанд энэ асуулгыг явуулж болно.

#### 3.2.7.2 Дотоод үнэлгээ

Дотоод үнэлгээг байнга, үргэлжлэл бүхий явуулсанаар өөрийн улсад одоогийн эргэн нийгэмшүүлэлтийн нөхцөл байдалын сүл болон давуу тал, байгууллагад хэрхэн хамгийн зөв төлөвлөгөөг зохиох болон ирээдүйн эргэн нийгэмшүүлэх санаачлагад ямар зүйлсийг хамгуулах шаардлагатайг мэдэж болно.

### 3.2.7.3 Гадаад үнэлгээ

Өөрийн явуулж буй эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагаанд үнэн зөв үнэлгээ авахын тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллага гадны байгууллагыг урин хэрэгжүүлж буй үйл ажиллагаанудын давуу болон сул талуудыг хөндлөнгийн үнэлгээ хийлгэн тайлан гаргуулах нь зохистой байдаг.

#### Тэмдэглэгээ:

- 1 Удаан хугацаанд явуулах эргэн нийгэмшүүлэх процесс нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Удаан хугацааны туршид эргэн нийгэмшүүлэх туслалцааны талаар хийсэн үнэлгээний тайлан маш цөөн байдаг. Энэ нь хохирогч хэдийгээр эргэн нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдах боловч хувь хүний хувьд өөрийн амьдралыг хөөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбоо тасрах нь элбэг тул энэ талын туслалцааны талаар мэдээлэл хомс байдаг. Тиймээс энэ талаар тус гарын авлагад оруулаагүй болно.
- 2 Хүүхдийн эрхийн Хороо, 6-р Ерөнхий Тайлбар, CRC/GC/2005/6, 1 September 2005, para. 25.
- 3 Хохирогч эх орондоо эсвэл гуравдагч улсад очих талаар гаргасан хүсэлтийн хүрээнд “хандуулагч байгууллага” гэдэг нэр томъёо нь хохирогчийг анх ирсэн гэж тогтоогдсон улсад нь хохирогчийг буцах асуудлыг зохицуулах, очсон хойноо хандан туслалцаа авах холбогдох байгууллагуудтай холбож үүрэг гүйцэтгэнэ. “Хүлээн авагч” байгууллагад ирсэн хохирогчийг хүлээж авах, эргэн нийгэмшүүлэх туслалцааг үзүүлэх эсвэл шаадлагатай туслалцаа авахад нь өөр байгууллагад хандуулах үүрэг гүйцэтгэх байгууллагыг хэлнэ.
- 4 Насанд хүрээгүй хүүхэд дагалдах хүнгүй зорчих талаарх бусад холбогдох мэдээллүүд: ЮНИСЕФ (2006). ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хүүхдэд хамгаалал үзүүлэх удирдамж, ЮНИСЕФ НЙ: Сайн туршилагаас, Гуравдугаар хэвлэл, 2004, Европын тусгаарлагдсан хүүхэд Хөтөлбөрөөс хэвлүүлсэн; Европын холбоо, гуравдагч улсын иргэн болох, дагалдах хүнгүй хүүхэд, Зүүн өмнөд европд ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдийн эрхийг хамгаалах удирдамж, ЮНИСЕФ 2003 оны 5 сар.
- 5 ЮНИСЕФ (2006). ХХГХ-ийн хүүхдэд хамгаалал үзүүлэх асуудларх удирдамж, ЮНИСЕФ НЙ 25-р худ.
- 6 Ерөнхий тайлбар №31, (80), 2004 оны 3 сарын 29-нд нэгдсэн Гэрээний өмнө Улсуудыг хүлээх үүргийн ерөнхий хууль зүйн мөн (2187-р уулзалт), CCPR/C/21/Rev.1/Add.13.
- 7 Хүүхдийн эрхийн Хорооны 6-р ерөнхий тайлбар CRC/GC/2005/6, 2005 оны 9 дүгээр сарын 1, 27-р хэсэг.

- 8 НҮБ Хүний эрхийн дээд комиссариат 1951 оны Конвенцийн 1A (2) зүйлийн дагуу олон улсын хамгааллын удирдамж болон/эсвэл 1967 оны протокол: ХХГХ-т өртөж хохирогч болсон хүмүүсийн болон өртөх эрсдэлтэй хүмүүсийн дүрвэгч болох статус, HCR/GIP/06/07, 2006 оны 4 дүгээр сарын 26.
- 9 НҮБ Хүний эрхийн дээд комиссариат 1951 оны Конвенцийн 1A (2) зүйлийн дагуу олон улсын хамгааллын удирдамж болон/эсвэл 1967 оны протокол: ХХГХ-т өртөж хохирогч болсон хүмүүсийн болон өртөх эрсдэлтэй хүмүүсийн дүрвэгч болох статус, 28-р хэсэг, болон НҮБ Хүний эрхийн дээд комиссариат, *Дахин суурьшуулах гарын авлагага*, 2004 оны 11-р сар, 4.1 бүлэг.
- 10 Либасси болон Маллусио (1986) DuBois B. болон Miley, K.K. (1996). *Нийгмийн ажил: Мэргэжлийг чадавхижуулах нь*. Аллин ба Бэйкон: Нийдхарм Хейтс, Массачусетс, 215-р хууд.
- 11 Волписэлли (2004). *ХХГХ-ийг таньж ойлгох ба түүнтэй тэмцэх үйл ажиллага явуулах нь: Эмэгтэй шашны семинарын Актууд*. Олон Улсын Шилжин Суурьшигчдын Байгууллага: Итали улс, Ром хот.
- 12 Дээрхээс үзнэ үү.
- 13 Дүй Бойс Б. ба Милей, К.К. (1996). *Нийгмийн ажил Мэргэжлийг чадавхижуулах нь*. ба Бэйкон: Нийдхарм Хейтс, Массачусетс.
- 14 Дээрхээс үзнэ үү.
- 15 Дээрхээс үзнэ үү.
- 16 Дагадлах хүнгүй насанд хүрээгүй хүүхдийн талаар холбогдох материалууд: *Сайн туршилагаас*, 2000, *Сайн туршилагаас*, Гуравдугаар хэвлэл, 2004, Европын тусгаарлагдсан хүүхэд Хөтөлбөрөөс хэвлүүлсэн; Европын холбоо, гуравдагч улсын иргэн болох, дагалдах хүнгүй хүүхэд, Зүүн өмнөд европд ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдийн эрхийг хамгаалах удирдамж, ЮНИСЕФ 2003 оны 5 сар.
- 17 ЮНИСЕФ (2006). *ХХГХ-ийн хохирогч насанд хүрээгүй хүүхдээд хамгаалал үзүүлэх удирдамж*, ЮНИСЕФ: НЙ, 30-31-р хууд.

## Хавсралт | Мониторингийн тайлан

Байгууллагын нэр:

### Хэсэг 1: Хохирогчийн хувийн мэдээлэл

Нэр:

Овог:

Төрсөн он сар өдөр:

Гэрлэлтийн байдал:

Хүүхэд:

Шуудангийн хаяг:

Утас:

### Хэсэг 2: Нөхөн сэргээх

- Хохирогч хэр удаан хугацааны туршид холбоо тогтоож байсан бэ?
- Хамгийн сүүлийн уулзалт хэзээ хийгдсэн бэ?:
- Энэ хугацаанд үзүүлэсэн туслалцааны агуулга:
  - Зөвлөгөнүүд
  - Курсүүд
  - Сэтгэл зүйн дэмжклэгүүд
  - Эрүүл мэндийн халамжийн үйлчилгээнүүд
  - Гэр бүлтэй нь эргэн нэгтгэсэн
  - Хуулийн туслалцаа
  - Боловсрол
  - Байрлуулах
  - Тээвэр
  - Бусад:
- Ажил эрхлэлт:
  - Ажилт орсон (аль хэлтэс, албан тушаал)
  - Ажилгүй
  - Оюутан
  - Бусад:
- Тухай эрэгтэй/эмэгтэй цалинтай ажилд орсон уу?
  - Байнгын ажилтан
  - Хагас цагийн ажилтан
- Гэртээ эргэж ирсэнээс хойш ямар төрлийн асуудал тухайн эрэгтэйд/эмэгтэйд тулгарсан бэ?

7. Тухайн эрэгтэй/эмэгтэйг хүн худалдагч нар дарамт, шахалт үзүүлсэн эсэх?
  - Тийм
  - Үгүй
8. Хэрвээ тийм бол хэрхэн? Хамгаалалт хүсэн хэнд хандсан бэ?
9. Тухайн эрэгтэй/эмэгтэй тэр асуудлын удмаас хууль хэрэгжүүлэгч байгууллагад хандсан уу?
  - Тийм
  - Үгүй
10. Тухайн эрэгтэй/эмэгтэй хууль хэрэгжүүлэгчидтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаа эсэх?
  - Тийм
  - Үгүй
11. Ирээдүйдээ яах төлөвлөгөөтэй байна?

# Хамгаалах байр

# **Бүлгийн агуулга**

- 4.1 Хамгаалах байр бий болгох нь**
- 4.2 Байшин болон хамгаалах байрны байршил**
  - 4.2.1 Хамгаалах байрны барилгын онцлог
  - 4.2.2 Хамгаалах байранд хүн байрлуулах дээд хэмжээ
  - 4.2.3 Үйл ажиллагаа явуулах
  - 4.2.4 Ариун цэврийн нөхцөл байдал, үйлчилгээнүүд
  - 4.2.5 Хамгаалах байрны үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь, хүн хүлээн авах бодлого
  - 4.2.6 Аюулгүй байдлын хамгаалал
- 4.3 Хамгаалах байрыг удирдан ажиллуулах болон ажилтан ажиллуулах**
  - 4.3.1 Хамгаалах байранд ажиллахажилтнуудын бүрэлдэхүүн
  - 4.3.2 Хамгаалах байрны менежмент
  - 4.3.3 Шууд зөвлөгөө өгөх болон/эсвэл сэтгэл зүйн туслалцаа
  - 4.3.4 Байрлагчийг хянах болон тэдэнд үзүүлэх ерөнхий халамж
  - 4.3.5 Санхүүгийн хяналт болон хэрэгцээт зүйлсийг худалдан авах
  - 4.3.6 Бусад ажилтнууд
  - 4.3.7 Сайн дурынхныг ажиллуулах
- 4.4 Хамгаалах байрны ажилтнуудын зохион байгуулалт, тэдэнд явуулах сургалтууд**
  - 4.4.1 Сургалт болон ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөрүүд
  - 4.4.2 Хамгаалах байрны ёс зүйн дэглэм/үйл ажиллагаа явуулах процедурууд
  - 4.4.3 Ажилтнуудын цагийн хуваарь
  - 4.4.4 Хяналт
  - 4.4.5 Шатах
- 4.5 Хамгаалах байранд байрлагч хохирогчдод үйлчилгээ үзүүлэх процедур**
  - 4.5.1 Хамгаалах байранд байрлагч хохирогчтой ажиллах үндсэн ойлголт
  - 4.5.2 Хамгаалах байранд хүрэлцэн ирэх
  - 4.5.3 Эхний уулзатыг хэн зохион явуулах асуудлыг тодорхойлох
  - 4.5.4 Уулзалтын цагийг товлох, тохирох
  - 4.5.5 Эхний уулзалтыг хийх
  - 4.5.6 Эхний уулзалтын зорилт
  - 4.5.7 Хамгаалах байранд байрлагчид - эрх болон үүргүүд
  - 4.5.8 Хамгаалах байрны туслалцаа болон үйлчилгээнүүд
  - 4.5.9 Хохирогчтой гүнзшийрүүлсэн ярилцлага хийх
  - 4.5.10 Эхний уулзалтын төгсгөх
  - 4.5.11 Анхан шатны хэрэглээний хэрэгсэл бүхий боодол, нөхөн сэргээх эхний үе шат
- 4.6 Хүүхдэд зориулсан тусгай санамжууд**
- 4.7 Хамгаалах байр үйлчилгээ, туслалцаа**
  - 4.7.1 Зөвлөгөө өгөх
  - 4.7.2 Эрүүл мэндийн үйлчилгээ
  - 4.7.3 Сэтгэл зүйн үйлчилгээ

- 4.7.4 Сэтгэл заслын үйлчилгээ
- 4.7.5 Хуулийн туслалцаа
- 4.7.6 Амралтын үйл ажиллагаанууд
- 4.7.7 Нэмэлт нөхөн сэргээх үйлчилгээнүүд
- 4.7.8 Биеийн байцаалт, аялалын бичиг баримтууд болон дамжуулагч болон хүлээн авагч улсад байгаа хохирогчийг сайн дураар буцахад туслалцаа үзүүлэх
- 4.8 Кейсэд үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг боловсруулах**
- 4.9 Хамгаалах байрнаас явах**
- 4.10 Бүртгэлийн менежмент**

Хавсралт I : Ажилтнуудын биеэ авч явах стандартыг тогтоох удирдамж  
 Хавсралт II : Нууцлалыг чанадлан хадлагах талаар ажилтнуудыг хийх гэрээ  
 Хавсралт III : Хамгаалах байранд байрлагчдын эрх  
 Хавсралт IV : Хамгаалах байрны ерөнхий дүрмүүд  
 Хавсралт V : Хамгаалах байрнаас хүн явах үед ажилтнуудын хариуцлага  
 Хавсралт VI : Хамгаалах байрнаас явах хүнээс авах асуумж

Энэхүү бүлгийн гол агуулга нь ХХГХ-ийн хохирогчдод зориулсан хамгаалах байр байгуулах болон үйл ажиллагаа явуулах талаарх дэлгэрэнгүй удирдамжийг танилцуулахад оршино. “Хамгаалах” гэсэн үгэнд ХХГХ-ийн хохирогчдод зориулсан эрүүл мэндийн нөхөн сэргээх төвүүд, түр байрлуулан дамжуулах байр зэрэг зориулалтын байрууд ордог.

#### Хамгаалах байр юунаас бүрддэг вэ?

Хамгаалах байрууд нь төрөл бүрийн байдаг нь олон хүчин зүйлсээс хамаардаг: Санхүүжилт, аюулгүй байдлын асуудал, үйлчилгээ үзүүлэх боломж, хүчин чадал, хамгаалах байр байгуулсан шаардлага г.м. эдгээрийн үр дүнд хамгаалах байр нь цөөн эсвэл олон хүнд зориулладаж болно. Мөн тэдгээр хүмүүсийн түр хугацаагаар доор дурдсан газруудад байрлуулж болно:

- Байшиングууд;
- Байр;
- Зочид буудал;
- Зориулалтын байран дахь тусгай өрөө (эмнэлэг зэрэг);
- Сүмүүд.

Хамгаалах байрыг зөвхөн ХХГХ-ийн хохирогчдод хэмээн тусад нь зориулж байгуулаж болох ч өөр төрлийн хүчирхийллийн /гэр бүлийн хүчирхийлэл/ хохирогчтой цуг байрлахаар бас байгуулж болно.

---

Энэхүү удирдамжинд хамгаалах байрыг ажилуулах үндсэн зарчим бүхий тодорхой зөвлөмжүүдийг ХХГХ-ийн хохирогчид зориулсан хамгаалах байрыг хүлээн авагч, дамжуулагч болон эх орон дахь ажиллуулдаг байгууллагуудад зориулан оруулсан болно.

## 4.1 Хамгаалах байр байгуулах

Хамгаалах байрууд дараах зүйлсийг зорилгоо болгох ёстой

---

- ХХГХ-ийн хохирогчид зориулсан тохиромжтой, аюулгүй, хамгаалагдсан түр хугацаанд амьдрэн суух байр орчин
  - Хамгаалах байрны ажилтнуудад зориулсан тохиромжтой, аюулгүй, хамгаалагдсан ажлын орчин
  - Хохирогчдод ирээдүйд хор хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, эргэн нийгэмшүүлэлтийг хамгийн сайн үр дүнд хүргэх тогтвортой байдлыг бий болгох
  - Сайтар сургагдсан ажилтнууд хамтран ажиллаж хохирогчдод байнгын бөгөөд бүх талын цогц хамгааллыг үзүүлэх
  - Хохирогчдын хувь хүний нь онцлог, кейсэд тулгуурласан үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөнд үндэслэн чанартай хамгаалалт болон туслалцаа үзүүлэх
  - ХХГХ-ийн эсрэг хохирогчид туслахаар үр дүнтэй, үр нөлөөтэй ажиллах мөн бус болон улс орнуудад хамгааллын тогтолцоогоор ажиллах
- 

Хамгаалах байр ажиллуулж буй байгууллага нь хамгаалах байрыг тухайн улс орны хууль тогтоомжинд нийцүүлэн ажиллуулна.

Ихэнхдээ энэ нь Төрийн Нийгмийн Үйлчилгээний Газраас зөвшөөрөл авах асуудал байдаг.. Нөгөө талаас засгийн газартай Хамгаалах байр байгуулах талаар Ойлголцлын Гэрээ байгуулж болно. Аль ч тохиолдолд ХХГХ-ийн хохирогчдод зориулах хамгаалах байрыг бий болгох болон эсвэл хамгаалахын байрны менежментийн асуудал бичгээр тодорхой хийгдэж болно. Үүнийг Ойлголцлын гэрээгээр холбогдох Яамтай эсвэл засгийн газрын холбогдох албан тушаалтантай мөн хамтрагч байгууллагуудаа оролцуулан эсвэл бүртгэл эсвэл бичиг баримтын лицензийн асуудлаар эсвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллага хамгаалах байрны үйл ажиллагааг зохицуулан явуулах талаар үйлдэнэ. Дараах нь хамгаалах байрыг бий болгох бичиг баримтанд шаардлагатай асуудлуудыг тусгасан болно.

### Үндсэн зарчмууд

Холбогдох түншүүд хамтын ажиллагааны үндсэн зарчмууд, үйл ажиллагааны нарийвчлалуудыг дараах байдлаар торхойлно. Дараах нь санал болгож буй зарим нэгэн үндсэн зарчмууд болно.

- ХХГХ-ийн хохирогчийн хамгаалал болон туслалцааны асуудлалд холбогдох түнш байгууллагуудын хамтын ажиллагаагаар хандивлах нь.
- Бүх талууд ХХГХ-ийн хохирогч болон хохирогч байх магадлалтай хүний аюулгүй байдал, хамгаалал нь хамгийн тэргүүлэх зорилго болгон ажиллах ёстой.
- Бүхий л туслалцаа нь НҮБ-ын Палермо Протокол, НҮБ-ын хүний Эрхийн Дээд хорооны ХХГХ болон Хүний Эрхийн Зарчим болон Удирдамж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенц зэрэг олон улсын стандарт, удирдамжуудыг удирдлага болгон ажиллана.
- Туслалцаа үзүүлэх хөтөлбөр хамрагдах нь зөвхөн сайн дурын үндсэн дээр хохирогчийн мэдээлэл авсаны үндсэн дээр өгсөн зөвшөөрлийн дагуу үзүүлэгдэх болно.
- ХХГХ-т өртсөн хүний цагаачлагчдыг тодорхойлох байранд эсвэл хаяг тогтоох газарт хэзээ ч байрлуулж болохгүй
- Өөр хүний аюулгүй байдлын асуудал үүссэн тохиолдлоос өөр нөхцөлд байгууллага хохирогчийн зөвшөөрөлгүй эсвэл хохирогчийг ашиг сонирхолд нэн шаардлагатай нөхцөл байдлал үүссэнээс өөр тохиолдолд түүний мэдээллийг задлах шаардлагагүй.

Эдгээр 6 үндсэн зарчмуудыг яамд, төрийн албаныхан, ТББ-үүд эсвэл олон улсын байгууллагаутай хамтран ажиллах аливаа үйл ажиллагааны хүрээнд хийгдэх гэрээнд заалт болгон оруулах ёстай.

### **Хамгаалах байр байгуулах зорилго**

Хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон хүмүүст зориулсан хамгаалах байр байгуулах эсвэл хамгаалах байрны менежментийг явуулах талаар өгүүлнэ.

Хамгаалах байр нь анхаасаа ямар хугацаанд хохирогчийг байрлуулах урт эсвэл богино хугацааны зориулалтаа тодорхой болгоно.

### **Ашиг хүртэгчэд**

ХХГХ-ийн хохирогчдод зориулан хамгаалах байр байгуулах боловч ХХГХ-ийн хохирогч бүх хүмүүст зориулагдсан эсвэл зарим төрлийн хохирогчдод онцгойлон зориулагдсан аль нь болохыг тодорхойлох шаардлага гардаг. Ямар төрлийн хүмүүст үйлчилгээ үзүүлэхээр зорьж байгаагаас шалтгаалаад албан болон албан бус бүтцээс хамгаалах байранд хандуулж буй ашиг хүртэгчид тодорхойлогдоно. Энэ нь хохирогч байрлуулах асуудлалтай холбоотой үүсдэг зарим нэг үл ойлголцлоос урьдчидлан сэргийлэх нэхцлийг бүрдүүлдэг. Дараах жагсаалт нь тухайн хамгаалах байранд ямар хүнд үйлчилгээ үзүүлдэг байж болох төрлүүд юм:

- ХХГХ-ийн тодорхой хэлбэрт өртөн хохирогч болсон хүмүүс (бэлэгийн мөлжлөг, хүнд хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр, хүүхэд цэрэг, газар тариалангийн хөдөлмөр болон бусад);
- Эмэгтэй
- Эрэгтэй хохирогч
- Насанд хүрсэн хохирогч
- Хүүхэдтэй насанд хүрэгч насанд хүрэгч
- Хүүхэд хохирогч;
- Дотоодын хохирогч
- Гадаадын хохирогч
- Буцаж харих хүсэлтэй гадаадын хохирогч
- Түр хугацааны оршин суух эрх хүсэгч гадаадын хохирогч.

## Насанд хүрээгүйчүүдэд зориулсан байр

- Хүүхэд тогтоогдоны дараа аль болох тэр даруй аюулгүй байранд байрлуулагдах ёстай.
- Хүүхдэд түүний нас, хөгжилд тохирсон байранд байрлуулах ёстай.
- Хүүхдийг өөртэй нь нас болон хүйс ижил хүүхдүүдтэй хамт байрлуулах
- Гэр бүлийн хүмүүсийг хамт байрлуулах тал дээр анхаарал хандуулах (энэ нь хүүхдийн эрх ашигт нийцсэн байдлаар мөн түүнд аюулгүй бөгөөд тухайн нөхцөл байдалд хамгийн тохиromжтой бол)
- Хохирогч хүүхдийг ямар ч нөхцөл байдалд хаяг тогтоох газар байрлуулж болохгүй
- Насанд хүрээгүй хүүхдэд зориулсан хамгаалах байр ажиллуулдаг байгууллагууд тухайн газрын хуулийн дагуу насанд хүрээгүйчүүдэд зориулсан хамгаалах байр ажиллуулах хүсэлт гарган, зохих зөвшөөрлийг авсан гэдгийг баталгаажуулах.

Насанд хүрээгүй хүүхдэд хамгаалах байраар үйлчлэх талаар 5-р бүлгийн 5.6 хэсгээс үзнэ үү.

## Үйлчилгээний төрлүүд

Энд хамгаалах байранд үзүүлдэг үйлчилгээний жагсаалтыг агуулсан байгаа. Доор дурьдсан хамгаалал болон нөхөн сэргээх туслалцаанууд ихэнх тохиолдод үзүүлэгддэг:

- Аюулгүй болон хамгаалал бүхий байранд түр хугацаагаар байрлуулах
- Хоол хүнс
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Сэтгэл зүйн туслалцаа, зөвлөгөө
- Хуулийн зөвлөгөө
- Үндсэн хэрэглээний материалууд.

Хамгаалах байр тухайн хүний эх оронд, дамжуулагч улсад болон хүлээн авагч улсад байрлаж байгаагаас хамаараад энэ хэсэг дахь зөвлөмж дараах асуудлуутай уялдаатай байж болно:

- Сайн дураар эх орондоо эгрэн харихад үзүүлэх туслалцаа
- Эргэн нийгэмшүүлэх туслалцаанууд:
  - Боловсрол/Сургуульд эргэн суралцах
  - Мэргэжил олгох сургалт
  - Ажилд оруулах
  - Гэр бүлтэй нь нийлүүлэх, эвлэрүүлэх

## Зардлууд

Хэрвээ гэрээнд ямар байгууллага санхүүжилт үзүүлэх талаар заасан бол энэ хэсэгт төсвийг тодорхойлох, хамгаалах байрны зардалтай холбоотой талуудад хуваарийн дагуу төлбөр хийх зэрэг асуудлыг шийдвэрхэд ашиглаж болно. Үүнд:

- хамгаалах байр барих санхүүжилт
- хамгаалах байрыг сэргээн засварлах болон дахин шинээр засварлах санхүүжилт
- хамгаалах байрыг ажиллуулах санхүүжилт
- тавилга болон тоноглох санхүүжилт
- ажилтан болон хохирогчийг тээвэрлэх зардал
- хохирогчийг байрлуулах, хооллох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх санхүүжилт
- шаардлагатай болон гэнэтийн хэрэгцээнд зорилусан санхүүжилт
- түрээс болон бусад үйлчилгээнд зориулсан төрийн тэтгэмж.

## Хамгаалах байрны байрыг хүлээн авах болон хүлээлгэн өгөх

Хэрвээ тохиоромжтой бол энэ хэсгийг хамгаалах байр байгуулах байр авах эрх бүхий хүн ашиглаж болно. Хэрвээ орон нутгийн хуулиар хамгаалах байр байгуулахад зөвшөөрөл авах шаардлагатай бол энэ хэсэгт эль тал нь аль асуудалд хариуцлага үүрэх болохыг тодорхойлж өгнө.

## Хамгаалах байранд ажилтан авах болон ажиллуулах нь

Энэ хэсэг нь хамгаалах байранд ажилтан авах, ажиллуулах, зохих цалин олгох, зардал гаргах эрх бүхий хүнд зориулсан болно. Зарим тохиолдолд гэрээ хийгч талууд тухайн хамгаалах байрны ажилтныг ажилд авах болон цалинжуулах талаар

хариуцлагыг хуваан хариуцдаг. Үүнд ихэнх тохиолдолд ямар ажилтан байх болон ажилтны тоог заавал заадаггүй. Ажилтныг сургах, ажилтныг ажиглах, сахилга батын арга хэмжэнүүд, техникийн туслалцааны талаар энэ хэсэгт зааж өгч болно.

### **Хамгаалах байрны аюулгүй байдлын хамгаалал**

Энэ хэсэгт хамгаалах байрны хамгааллын талаарх хувь хүний болон хамтын хариуцлагын талаар онцлон өгүүлнэ. Хамгаалах байрны хамгааллын асуудалд орж ирж буй, амьдарч буй, болон хамгаалах байрнаас явж буй хохирогчийнхамгааллын талаар өгүүлэхээс гадна хамгаалах байрны ажилтны хамгааллын талаар өгүүлнэ. (1-р бүлэг, 1.3 болон 1.4-р хэсгүүд).

### **Бусад байгууллага, институтуудтай үйлчилгээний гэрээ хийх**

Энэ хэсэгт хамгаалах байранд байрлах хохирогчид үйлчилгээ, туслалцаа үзүүлэгч төрийн болон ТББ-тай хамтын ажиллагаа эсвэл үйлчилгээ үзүүлэх талаар гэрээтэй байх (эсвэл гэрээг төлөвлөх)-ийн чухлыг онцлон тэмдэглэнэ. Энэ хэсэгт дээр дурдсан үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн шалгуурыг тодотгох, үүнд дотроо халамж болон уйлдаа холбоог хамгаалах байрны үйл ажиллаганы стандартууд болон зарчмуудтай нийцүүлэх зэргийг агуулсан байна.

### **Хамгаалах байрны даатгал**

Энэ хэсэгт ямар байгууллага хамгаалах байранд даатгалыг хариуцах болон ямар төрлийн даатгал шаардлагатай талаар өгүүлнэ.

## **4.2 Хамгаалах байрны байршил болон байр**

Хамгаалах байранд байрлагчид болон тэнд ажиллагсадын аюулгүй байдал, эрүүл мэнд хамгийн чухал зүйлс мөн. Бүхий л хамгаалах байрууд цэвэр, аюулгүй, тохилог орчинг дотор тадлаа бий болгон гадна талдаа хамгаалалттай, сайтар төлөвлөсөн байна. Бүхий л хамгаалах байрны байр, тавилга сэлт сайн байдалтай байж аливаа эрүүл мэнд, гал, цахилгаан болон барилгын бүхий стандартыг хангасан байх.

#### **4.2.1 ХАМГААЛАХ БАЙРНЫ БАРИЛГЫН БАЙДАЛ**

Хамгаалах байрны үйл ажиллагаа явуулах байр нь тухайн үйл ажиллагаанд ашиглагдах байрны барилгын байдал, санхүүжилт, дэмжлэг хэр хангалттай эсэхээс хамаарна. Хэдийгээр ихэнх хамгаалах байрууд 24 цагийн үйлчилгээг, тэр тусмаа дараах үйлчилгээг явуулах ёстай:

##### **Гал тогоо болон хооллох өрөө**

Хоол бэлтгэх, хооллох өрөө нь аюулгүй хоол хүнс бэлдэх болон хадгалах зориулалттай байх. Гал тогоо нь хоол бэлтгэж хийх болон хооллоход шаардлагатай бүхий л хэрэгслүүдтэй байх.

##### **Бүлгээр (бөөнөөр амьдрах өрөө)**

Хэсэг бүлгээр байрлагчдад үйл ажиллагаанд оролцох болон цугларахад хангалттай орон зай байх

##### **Угаалгын өрөө**

Бие засах өрөө, угаалгын өрөө нь засвар үйлчилгээ хийгдсэн, цэвэр, хангалттай хүрэлцээтэй байх. Хамгаалах байранд байрлагчид тэдгээр өрөөг ариун цэвэр байлгах, хэрэглэх ёстай.

##### **Унтлагын өрөө**

Хамгаалах байранд байрлагчдад унтаж амрахад эвтэйхэн ор, цэвэр даавуу, хувийн эд хэрэглэлээ хадгалах шүүгээ, зайтай байх. ХХГХ-ийн хохирогчид ямар ч тохь тухгүй орчинд, бүр шалан дээр унтах, эсвэл өөр хохирогчтой хамт унтах зэргээр амьдарч байсан тул хамгаалах байранд тэрхүү нөхцөл байдлыг түр хугацаагаар боловч давтаж огт болохгүй. Онцгой шаардлага гарсан тохиолдолд ажилтнууд байрлагчийг орон дээр эсвэл өөр тохиромжтой байдлаар байрлуулна. Өөр тохиросжтой байдалд гэдэгт нэн бүгино хугацаанд байрлуулагчийг өөр зохих байранд байрлуулах боломж гартал хамгаалах байранд эсвэл өөр газар байрлах тохиромжтой байранд байрлуулна.

## Ганцаарчилан зөвлөгөө өгөх өрөө

Хамгаалах байранд хамгийн наад захын шаардлага болгон нэг өрөө тэнд байрлагчидтай аль цагт ганцаарчилсан, нууцлаг ярилцлага хийх, зөвлөгөө өгөх зориулалттай өрөөг тохижуулан ажиллуулна. Хохирогчтой хийх ярилцлага болон хохирогчид өгөх зөвлөгөө зэрэг нь хувь хүний нууцыг агуулсан дотоод асуудлыг хөндсөн байх тул өр ажилтнууд эсвэл бусад байрлагчлад сонсогдох ёсгүй. Тийм учраас эдгээр өрөөнүүд бусад хүмүүс чагнах боломжгүй, хүний хөлөөс зайдуу газрыг сонгон бэлтгэх хэрэгтэй.

## Хамгаалах байрны ажилтнуудад зориулсан оффис

Хамгаалах байранд нэг өрөөг тэнд ажиллагсадад оффис болгон бэлтгэх хэрэгтэй. Энэхүү өрөөг хамгаалах байранд шөнийн цагаар хонох ажиллагсадад амрах эсвэл унтах өрөө болгон тохижуулж болно.

## Эрүүл мэндийн үзлэгийн өрөө

Байрнаасаа хамаараад мөн эмнэлгийн үйлчилгээ хамгаалах байранд явагдаж болох эсвэл болохгүй байдлаас үл хамаараад хамгаалах байр эрүүл мэндийн үзлэг хийх өрөөтэй байж болно. Эмнэлгийн ажилтан эсвэл эмч тэр өрөөнд байх эсэхээс үл хамаараад тухайн өрөөг байнга цоожтой байлгана. Ялангуяа эмийг тэрхүү өрөөнд мөн цоожтой шүүгээнд хадгалах нь нэн шаардлагатай. Хамгаалах байр болгон ахнан шатны тусламж үзүүлэх цогц хэрэгсэл болон бусад шаардлагатай зүйлсүүдийг эмнэлгийн өрөө болгонд заавал байлгах.

## Хувцас угаалгын өрөө

Байранд хувцас угаах өрөө, машин үнэгүй, мөн хүний хэрэгцээтэй үед ашиглахаар байлгах.

## Амрах өрөө

Байранд дотор болон байрны гадаа амран суух өрөө, жижиг ч гэсэн заавал байх шаардлагатай.

## Агуулах

Хамгаалах байр болгон зориулан бэлдсэн агуулахын өрөөтэй байх нь зүйтэй. Хамгаалах байрны хэрэгслүүд, хувийн ариун цэврийн хэрэгслүүд, байрлагчдад зориулсан илүү хувцас, болон бусад зүйлс нилээдгүй зайд эзэлдэг тул тэдгээрийг нэг өрөөнд хадгалах нь зүйтэй. Дараах эд зүйлс нь нь байнга хэрэглэгддэг тул тэдгээрийг худалдан аваад, жагсаалт үйлдэн, цоожтой газар хадгалан, хэрэгцээтэй үед гаргаж хэрэглэж байх.

- Хамгаалах байрны цэвэрлэгээний бодис
- Байрлагчдад зориулсан хувь хүний ариун цэврийн хэрэгсэл
- Байрлагчдад зориулсан хувцас, гутал (улирлын)
- Аялалын цүнх
- Бусад материаллаг эд зүйлс.

### 4.2.2 ХАМГААЛАХ БАЙРНЫ ХҮЧИН ЧАДАЛ

Хамгаалах байрны хүчин чадлын дээд хэмжээ нь (аюулгүй нөхцөлд байрлаж болох хамгийн олон байрлагчдын тоо) нэмэлтээр хэдэн байрлаж болох тоогоор хэмжигдэнэ. Тухайн орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартын дагуу, хамгаалах байрны нөөц, хүчин чадал болон унтахад тохиromжтой унтилагын өрөө зэргийг харгалзагч хамгаалах байрны ажилтан хамгаалах байрны хүчин чадлыг тооцно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хамгаалах байрны ажилтнууд хамгаалах байрны хүчин чадлыг давсан ачаалал гарах үед тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар боловсруулсан төлөвлөгөөтэй байх ёстой. Хамгаалах байранд зайд байхгүйн улмаас тэнд байрлах боломжгүй хохирогчдод аюулгүй байр болон зохих үйлчилгээг үзүүлэх өөр зохицуулаттай байх гаардлагатай.

### 4.2.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хамгаалах байр болгон яаралтай болон энгийн цагт засвар үйлчилгээ үзүүлэх талаарх гэрээ байгуулсан байх шаардлагатай. Яагаад гэвэл хамгаалах байрны нууцлаг, нарийн мөн чанарын улмаас засвар үйлчилгээ, зэрэг бусад шаардлагатай тохиолдолд хэнтэй холбоо барихаа хамгаалах байрны ажилтнууд мэддэг байх ёстой. Хамгаалах байр нь засвар үйлчилгээ үзүүлэх

талаарх тусгайлсан гэрээг тухайн үйлчилгээг үзүүлэгчтэй хамгаалах байрны дүрэмд нийцүүлэн хийнэ. Засвар, үйлчилгээ авах талаарх гэрээнд дараах зүйлсийг оруулах хэрэгтэй:

- Барилгын материаллаг тогтолцоо
- Хэрэглээ (сантехник болон цахилгааныг оруулж тооцох)
- Тавилга
- Тоног төхөөрөмж
- Машин, унаа (боловжтой бол)

#### **4.2.4 АРИУН ЦЭВРИЙН НӨХЦӨЛ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ**

Хамгаалах байр болгон тухайн орон нутгийн ариун цэвэр болон цэвэрлэгээний стандартыг мөрдөн байгууллагаа дээр даган мөрдөнө. Хамгаалах байранд байрлагчид хамгаалах байрны цэвэрлэгээний ажилд оролцон, хамжилцах болон тус бүр өөрийн унтдаг газрыг цэвэр байлгахыг хариуцна. Хамгаалах байр болгон байрлагчид болон ажилтнуудад байрыг цэвэр байлгах, өдөр тутмын үүргийг хуваарилана. Хамгаалах байрны ажилтнууд цэвэрлэгээ хийх болон ариун цэврийн стандарт хамгаалах байранд байнга даган мөрдөх тал дээр анхаарал тавин ажиллана. Хамгаалах байрны хэмжээ, хамгаалах байрны ажилтан болон байрлагчдын тооноос шалтгаалан үйлчлэгч ажилд авах шаардлагатай байж болзошгүй.

Дараах нь хамгаалах байрны өдөр тутмын хувиарт ажлын жагсаалт болно:

Гал тогоо, хоол бэлдэх, хооллох өрөө:

- Наад зах нь өдөрт 2 удаа цэвэрлэгдэж байх
- Байрлагчдад өдөрт гурван удаа, тэжээллэг, чанартай хоол эсвэл хоолны дэглэм барих хүнсээр хангах, хүүхдэд өдөрт 3 удаагийн хоолноос гадна 2 удаагийн зууш олгох бичгээр үйлдсэн удирдамж
- Гал тогооны дүрмүүд болон гар тогоо ажиллах цаг
- Хоолны дэглэм шаардлагатай байрлагчдад зориулсан хоолны дэглэмийн зохицуулалт.

Угаалгын өрөө болон бие засах өрөө

- Өдөрт наад зах нь нэг удаа сайтар угааж цэвэрлэж байна.

- Шаардлагатай бол угаалгын өрөөг ашиглах хуваарь.

#### Үнтлэгийн өрөөнүүд

- Өдөрт нэг удаа цэвэрлэнэ
- Байрлагч өөрөө цэвэр, цэмцгэр байлгана.
- Ор хөнжлийн даавуу, дэр, хөнжил тогтмол угааж байх.
- Байрлагчдын хувийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байх бодлого, процедурыг бичгээр үйлдэх.

#### Оффис болон уулзалтын өрөөнүүд

- Өдөрт нэг удаа цэвэрлэнэ.

#### Байрыг бүхэлд нь

- Тогтмол цэвэрлэж, шүүрдэх
- Тамхигүй орчин байх

### 4.2.5 ХАМГААЛАХ БАЙРНЫ ЦАГУУД БОЛОН ХҮН ХҮЛЭЭН АВАХ БОДЛОГО

Хамгаалах байр болгон ажиллах цаг болон шинээр иргэсэдийг байрлуулах талаарх тодорхой, ойлгомжтой бодлого боловсруулж, холбогдох хүмүүст мэдээлэх хэрэгтэй. Эдгээр бодлогууд түнш байгууллагууд болон хохирогчид үйлчилгээ авах хандуулдаг байгууллагуудтай зөвшилцэн бэлтгэж, хэвлэгдэн тараагдах ёстой. Шинээр ирж байрлагчийг ажлын цагаар байрлуулах нь шинээр байрлагчид шаардлагатай үйлчилгээнүүдийг хангальттай үзүүлэхээс гадна хамгаалах байрны хэвийн үйл ажиллагаа болон тэнд байрлагчдад төвөг удахгүй. Хамгаалах байр болгон шинээр байрлагчийг шуурхай хүлээн авах төлөвлөгөө боловсруулсан байна. Зохих байдлаар хүлээн авах бэлтгэлд хохирогчид кейсийн хавтас нээх, эхний үнэлгээ хийх, аюулгүй байдлын анхан шатны арга хэмжээнүүдийг авах, хохирогчтой эхний уулзалт хийх хүнийг тодорхойлох, нэмэлт туслалцаа шаардлагатай болсон тохиолдолд тэр туслалцааг үзүүлэх хүнийг томилох зэрэг орно. Гэхдээ ажлын бус цагаар ирж буй хохирогчийг хүлээн авах тохолдолд бага зэрэг хүндрэл гарч болзошгүй. Хамгаалах байранд шөнө орой болсон хойно хүн ирэх нь тэнд байрлагчдад ямар сэтгэгдэл, нөлөө үзүүлэхийг тооцох хэрэгтэй. Шинээр байрлагчийг хамгийн халуун, дулаан байдлаар тохилог орчинд

хүлээн авахаас гадна бусад байрлагчдыг ямар нэгэн байдлаар хүндруулэхүйг хичээн ажиллах шаардлагатай.

#### **4.2.6 АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ**

Эрсдлийн ерөнхий үнэлгээний үйл явцад эрсдэлтэй хэмээн тодорхойлогдсон газруудад эрсдлийг үр дүнтэй баталгаажуулан, хохирогч, ажилчдад дээд заргийн зэргийн аюулгүйн хамгааллыг баталгаажуулахын тулд (1-р бүлгийн 1.1 хэсэгт заасан дагуу), тохирох стандарт, процедуруудыг боловсруулан, эрсдлийг доод түвшин хүртэл дараах байршлуудад бууруулах шаардлагатай.

- Хамгаалах байр
- Хамгаалах байрны нөөц байр
- Ажиллагчид
- Хамгаалах байранд ирэгсэд
- Байрлагчид
- Нууцлал, зохион байгууллалтын болон бичиг баримтын эрсдэл.

#### **Аюулгүй байдлын стандарт болон процедурууд - хамгаалах байр**

Доор дурдах удирдамж нь одоогийн байдлаар ОУШСБ-ын туршлагад сууриссан “Хамгийн сайн загвар”. Тохиромжтой байр байшин, хэрэгцээтэй санхүүжилт болон төслийг дэмжих Төрийн дэмжлэгийн түвшин зэрэг нь аль ч тохиолдолд асуудлыг нааштайгаар, үр дүнтэйгээр шийдэн, зохицуулах эсэхийг тодорхойлогч үзүүлэлт болно.

- Туршлага болон санхүүгийн болоцоотой үед хамгаалалтын ажилтан тухайн байранд байрлан аюулгүйн хамгаалал, үнэлгээг хариуцах шаардлагатай. Хэрвээ боломжтой бол цагдаагийн ажилтан гэрээнд заасан нөхцлийн дагуу энэ ажлыг гүйцэтгэж болно. Эсвэл санхүүгийн байдалд зөвшөөрвөл өөрөөр буюу гадаах хамгаалалтын ажилтан байрлан хамгаалалтыг хариуцлах бололцоотой.
- Хамгаалах байр болгон галын аюулгүйн/шаардлагатай тохиолдолд хүмүүсийг нүүлгэн гаргах дэлгэрэнгүй

төлөвлөгөөтэй байх ёстай. Гаднаас халдагчаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээнд - дохиоллын болон автоматаар түгжигдэх системийн бүх хаалга, цонхонд байрлуулж, тэдгээр нь дотроосоо хялбар онгойдог байх.

- Зарим оронд байх хуучин хамгаалах байрууд дахь цахилгааны холболт, байр байшин нь нь хуучирч муудсаны улмаас галын аюулд өртөмхий болсон байдаг тул энэ байдлыг эрсдлийн үнэлгээнд оруулж байх.

### **Хамгаалах байранд хамгаалалтын ажилтан байлгах**

Хэдийгээр хамгаалах байранд дотор болон гадуур хамгаалалтын ажилтан байх нь зүгээр хэмээн зөвлөмөөр, хүсүүштэй боловч дараах эрсдлийг дагуулж байдаг:

- Хамгаалалтын ажилтан илт харагдаж байх нь хүмүүст энд хамгаалах байр ажиллаж байгааг ойлгомжтой болгож өгдөг.
- Байрлагчдад хамгаалагчийн дүрэмд хувцастай хүмүүс сэтгэл зүйн сэрөг нөлөөлөл үзүүлдэг.

Хэрвээ хамгаалалтын ажилтан байх шаардлагатай бол төрийн байгууллагатай хамтран ажиллах гэрээтэй тохиолдолд 24 цагийн туршид цагдаагийн ажилтан хамгаалалт үзүүлвэл зүгээр. Хэрвээ дээр дурдсан гэрээ байхгүй бол гэнэтийн тохиолдолд туслуулах гэрээг тухайн газрыг хамаарах цагдаагийн хэлтэстэй байгуулан дохиолол болон өөр сэргэжлүүлгийн дохиогоор яаралтай байдлаар хамгаалалтын туслалцаа үзүүлүүлж болно. Үр дүн нь тухайн орон нутгийн нөхцөл байдлаас шууд хамарна. Хэдийгээр бэлтгэгдсэн, мэргэжлийн хамгаалалтын хүн байх туйлын найдвартай боловч энэ зайлшгүй шаардлагатай зүйл биш юм. Хувийн хамгаалалтын албанаас хүн хөлслөх журмаар энэ асуудлыг зохицуулж болно. Энэ тохиолдолд санхүүжилтийн асуудал үүсэхээс гадна гэрээний тухай ярилцахаас үүсэхээс өмнө тухайн байгууллагын тодорхойлох болон шалгах процедурууд гүйцсэн байх ёстай. Хамгаалалтын албыг ажиллуулах шийдвэр болон хүсэлт нь эрсдлийн түвшин, орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаална.. Хамгаалалтын хамгийн сайн туршлагаас харвал хамгаалалтын албаны хүн хамгаалах байранд байх нь туйлын оновчтой байдаг. Мөн хамгаалах байрны аюулгүй байдлын бүрэн үнэлгээг тухайн харьяалах цагдаагийн газар

эсвэл хамгааллын албаны компаниар хийлгэх байдлаар асуудлыг шийдвэрлэж болно.

### **Аюулгүйн стандартууд болон процедурууд - хамгаалах байр**

Зарим газар туслалцаа авч буй ХХГХ-ийн хохирогчийг тухайн олон нийт дангаараа дэмжин хамгаалах зориулалттай бус өөр байранд нууцлан байрлуулах тохиолдолд байдаг. Ийм тохиолдол бүхий газар ажилтнууд нь эрсдлийн үнэлгээнийг хийлгэн, аюулгүйн хамгааллыг дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээс уртаж баталгаажуулах шаардлагатай. Хохирогчийг хувийн эзэмшилийн байранд байлгах талаар санал гарсан тохиолдолд дараах зүйлсүүдэд анхаарал хандулах шаардлагатай:

- Санал болгож буй байрны аюулгүйн үнэлгээ болон тухайн байр туслалцаа үзүүлэх хохирогчид тохиромжтой эсэхийг үнэлэхдээ: тухайн газар гэмт хэрэг гаралтын өндөр хувьтай эсэх, туслалцаа үзүүлж буй хохирогч өөрийг нь эрсдэлд оруулах хувь хүн болон бүлэг хүмүүстэй тулгарч болзошгүй эсэхийг тооцох шаардлагатай.
- Тухайн байшин, орон сууцны аюулгүйн үнэлгээ, тухайн байранд орон болон очиход хүндрэлтэй эсэх, тухайн газар хувь хүн болон бүлэг хүмүүст аюулгүй эсэх мөн хохирогч эрүүл мэнд, сэтгэл зүйн эсвэл өөр төрлийн уулзалт эмчилгээнд явах, ирэхэд хэр тохиромжтой эсэх.
- Тухайн газар харилцаа холбоо хэр хангалттай талаар: хохирогч яаралтай туслалцаа шаардлагатай болсон үедээ утсаар дуудлага өгөх шугаман болон мобил утас хэрэглэх бололцотой эсэх.
- Тухайн харьяалах газрын цагдаад мэдэгдэх: тухайн харьяаллын цагдаагийн газар тэдний харьяаллын газарт туслалцаа авч буй хохирогч байгааг мэдэгдэхэд зохих чадвартай, итгэлтэй гэж үнэлэгдвэл мөн хохирогч өөрийнх нь талаар цагдаагийн газар мэдэгдэхийг зөвшөөрвэл.
- Хохирогчийн байрлах газар өөр хүн тухайн газар хамт байхаар бол, хэрвээ тийм бол тэр хүн, хүмүүс хохирогчийг ямар нэгэн байдлаар эрсдэлд оруулах магадлалтай эсэх?

Дээр дурдсан нөхцлүүдэд доор дурдсан хохирогчид туслалцаа үзүүлж буй хувь хүний хариуцлагын талаарх аюулгүйн

хамгааллын удирдамжууд түүнд хамаатай бөгөөд тухайн хүн зөвлөмжүүдийг даган мөрдөж, ажилтнуудад зориулагдан бичиг баримтын нууцлалын зохицуулалтын талаарх удирдамжийт мөн сайтар даран мөрдөх шаардлагатай.

## **Ажилтнуудад зориулсан Аюулгүйн хамгааллын стандарт, процедурууд**

### **Ажилтныг шалгах болон гэрээнд орох заалтууд**

ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах байранд байрлуулах, туслалцаа үзүүлэх ажил нь байрлагчид болон ажилтнуудыг зохих эрсдэлд оруулдаг. Энэ эрсдлийг хэзээ ч дутуу үнэлж болохгүй ялангуяа илүү олон хохирогч тусламж эрж хандаж мөн тухайн газрын хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ ажлын нарийн нууцлал бүхий мөн чанараас хамааран энэ ажилд ажилтныг авахдаа олон удаагийн шат дараалсан зөвшөөрөл, сонголтын процедурыг явуулсаны үр дүнд ажилд авна. Ажилд орох өргөдөл гаргасан хүн тухай үйлчилгээ үзүүлэгч байгууллагаад эсвэл хамгаалах байранд сайн танил хүн бус бол ажилд орох маягт, өөрийн түүх, чадвар, урд нь ажилаж байсан ажлын газрын тодорхойлолт, тухайн байгууллагад эсвэл хамгаалах байранд ажиллах хувийн сэдлийн талаар баримтууд бүрдүүлнэ. Ажилд орох маягтийг бусад дагалдах бичиг баримтуудыг нарийн дарааллын дагуу бүрдүүлэн өгнө. Ажилд орох хүсэнлт гаргасан хүмүүст тэдний сонирхож буй ажлын онцлог нөхцөл байдал, үүрээт ажил болон аюулгүйн байдалтай холбоотой эрсдлийн талаар сайтар тайлбарлах. Ажилд орох хүсэлт гаргасан хүмүүс тухайн ажлын байранд тохирх өсэх асуудлыг нарийвчлан шалгасаны эцэст шийдвэрийг гаргана. Хамгаалах байрны ажилтнууд бүгд тэдний ажил үүргийн дагуу олж авах нууцлал бүхий мэдээллүүд ялангуяа хувь хүний болон ХХГХ-ийн холбогдолтой мэдээллэл, материалыг чанадлан нууцлах талаар тодорхой оруулж өгсөн гэрээнд гарын үсэг зурах ёстой. Нууцлалын ижил хариуцлагыг хамтрагч байгууллагын ажилтнуудад эсвэл хамгаалах байранд ажиллах сайн дурынханд танилцуулах.

## Ажилтнуудын аюулгүйн байдлын процедур

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хамгаалах байранд ажиллагчдын аюулгүйн хамгааллыг хариуцдаг тул ажилтнууд мөн хүн болгон өөрийн аюулгүй байдалдаа санаа тавин аюулгүй байдлаа баталгаажуулах болон аюулгүйн дүрмийг чанадлан мөрдөх ёстой. Аюулгүйн хамгааллыг баталгаажуулах үүднээс дараах арга хэмжээг авна:

- Бүх ажилтнуудад ХХГХ болон ауюлгүй байдлын хамгааллын нөхцлийн мэдээлж, эрсдлийн хамгийн сүүлийн үнэлгээг мэдэж байх
- Ажилтнууд хоорондоо солилцож байгаа мэдээллийг “мэдэх шаардлагын улмаас” буюу тухайн ажилтан өөрийн албан үүргээ биелүүлэхэд зөвхөн шаардлагатай мэдээллийг авах, өгөхөөр хязгаарлан зохицуулна.
- Ямар ч нөхцөл байдалд хувь хүний болон ХХГХ-ийн талаарх нууц мэдээ материалын утсаар болон хэн гэдэг нь тодорхойлогдоогүй хүнд биечлэн өгөх ёсгүй.
- Ямар ч нөхцөл байдалд албаны ажилтны хувийн тодорхой мэдээллүүд, хаяг эсвэл утасны дугаар зэргийг байнгын ажилтан хүнээс өөр хүнд өгөгдөх ёсгүй.
- Ажилтны оноосон нэрээс бусад тодорхой мэдээлэл хамгаалах байранд байрлаж хүмүүст мэдэгдэх ёсгүй.
- Ажилтнууд хүрээн буй орчны талаар байнга мэдээлэлтэй байна
- Ажилтнууд аюулгүй байдлыг хамгаалах, хамгаалах байранд байрласан ХХГХ-ийн хохирогчдын сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулна.

## Аюулгүйн анхан шатны сургалт

Аюулгүйн анхан шатны сургалт нэн шаардлагатай эсвэл явуулбал зүгээр гэдгийн ялгааг тухайн орон нутаг дахь нөхцөл байдлаас шалтгаална. Аюулгүйн анхан шатны сургалт нь хүний аюулгүйн хамгааллын бүтэн мэдлэг олгох курс биш учир нь бүтэн хэмжээний хамгаалалтын курс нь шаардлагагүй бөгөөд тэр ч байтугай ажилтны үүргээ биелүүлэхэд саад болно. Тухайн газрын хууль хэрэгжүүлэгч байгууллагаас аюулгүйн хамгааллын сургалт явуулах боломжтой эсвэл чадамжтай бол өөрийгөө

хамгаалах техник, аюулгүйн хамгааллын мэдлэг олгох, аюулгүйн үнэлгээ хийх, эргэн тойрон дахь орчноо таньж мэдэх, ажиглалт болон ажиглалтын эсрэг анхан шатны техник болон бие хамгаалах анхан шатны техник, аюулгүйн хамгааллын мэдлэг, түүн дотроо аюулын дохио өгөх болон газ (хий) ашиглах талаарх мэдлэг олгох, богино хэмжээний сургалтыг ажилтнууд болон байрлагчдад явуулах нь зүйтэй. Анхан шатны мэдлэг олгох өөр бусад сургалтууд хамгаалах байрны менежер, эрүүл мэндийнхээс бусад ажилтнуудад шаардлагатай байж болно. Түүнээс гадна харилцаа холбооны тактик, хувь хүний биеэ авч явах байдал, аюулын үзүүлэлтүүдийг таньж мэдэх болон зугатаан холдох техник зэрэг ажилтнууд дүрэм зөрчигч байрлагч болон хүсээгүй гийчинтэй харьцаах харьцаанд зайлшгүй шаардлагтай чухал мэдлэгт суралцуулах нь зүйтэй байж болно.

### **Аюулгүйн хамгааллын стандартууд болон процедурууд - хамгаалах байранд хүн ирэх**

Хамгаалах байр нь мэргэжлийн бусад хүмүүс, донорууд, эрдэмтэд, сэтгүүлчид зэрэг хамгаалах байранд ирэх сонирхолтой хүмүүс байдаг. Гэвч хамгаалах байрны асуудалд нь өөрөө туйлын нарийн бөгөөд тэнд байрлагчид болон ажилтнуудын аюулгүй байдал, сайн сайхан, нууцлалын асуудалтай холбоотой. Гэхдээ хүн болгоны ирэх саналд татгалзсан хариуг өгөх боломжгүй бөгөөд тэр ч байтугай байгууллага үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй нөхцөл үүсгэх магадлалтай. Тийм учраас ОУШСБ-аас хамгаалах байранд ирэгсдэд зориулсан хатуу дүрэм боловсруулсан чандлан мөрдүүлэхийг зөвлөж байна. Дагаж мөрдөх тодорхой дүрэм нь байрлагчдын сайн сайхан болон хувийн нууцыг баталгаажуулах болон хүсэлтүүдэд хариулт өгөхөд тулгуурлах үндсэн асуудал тул ажилтнуудад зарим онцгой хүсэлтүүдийг ззохицуулах, доноруудад болон бусад сонирхогч хүмүүст тухайн байгууллагад даган мөрддөг үндсэн бодлогыг ойлгоход тустай. Даган мөрдөх үндсэн бодлогод дараах зүйлс орно:

- Хамгаалах байрны байрлалтыг хамгаалан нуух
- Хамгаалах байрын ХХГХ-нүүдийн халдлагаас хамгаалах
- Хамгаалах байранд байрлагчдын хувийн нууцыг хүндэтгэх, хамгаалах байр нь тэдний хувьд түр боловч оршин суух газар

- болж байгааг хүлээн зөвшөөрөх
- Байрлагчид болон ажилтнуудыг бусдад таниулахгүй байх
  - Байрлагчдийн хамгийн сайн сайхны төлөө тэдний сонирхлыг хамгаалах, баталгаажуулах
  - ОУШСБ-аас дараах зөвлөмжийг хамгаалах байранд зочин хүлээж авах талаарх удирдамжийг боловсруулахад анхаарч үзүүштэй хэмээн гаргаж байна:
  - Хамгаалах байранд ирэгч зочид болон айлчлалыг аль болох хамгийн цөөн байлгах. ОУШСБ-аас нэг удаа айлчлах айлчлагчдын тоог хязгаарлан жишээлбэл: нэг дор 2 айлчин хамгаалах байранд айлчлалж болохгүй.
  - Айлчид урьдчилан төлөвлөсөн дагуу хамгаалах байранд байрлагчдад түгшүүр төрүүлэхгүйгээр тохирсон цагийг чанд баримтлан айлчлахыг зөвшөөрнө.
  - Хамгаалах байранд айлчлал хийх хүсэлт болгоныг үйлчилгээ үзүүлэгч байгууллага тус бүрийг судлан, тодорхойлох ёстай.
  - Хамгаалах байранд хүн ирэх зөвшөөрөл олгохын өмнө үйлчилгээ үзүүлэгч байгууллага хамгаалах байранд байрлагчдад тухайн айлчлал ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдгийг баталгаажуулан хамгаалах байрны сэтгэл зүйчдээр үнэлгээ хийх ёстай.
  - Байрлагчдын эргэн нийгэмшихүйд ямар нэгэн байдлаар сэтгэл зүйн үр даравар дагуулахгүй гэж тогтоогдоноы дараа л айлчлал хийлгэж болно.
  - Айлчлагчид өөрсдөө дураараа шууд ирэхээс урьдчилан сэргийлж, хамгаалах байрны хаягийг өгч болохгүй, гэхдээ хамгаалах байрны нэг ажилтан дагуулан ирнэ.
  - Айлчлалын үер ирсэн хүмүүсийг хамгаалах байрны ажилтан нэг хүн заавал дагалдаж явах ёстай.
  - Байрлагч өөрөө зөвшөөрөл илэрхийлээгүй, хэрвээ зөвшөөрсөн бол уг зөвшөөрлийг сэтгэл зүйч сайшаагүй бол айлчлагчид байрлагчтай уулзахыг зөвшөөрч болохгүй. Хэрвээ сэтгэл зүйч зөвшөөрсөн бол хамгаалах байрны сэтгэл зүйч эсвэл ажилтан тэрхүү уулзалтын үед байнга хамт байх ёстай.
  - Хамгаалах байранд ирэгсэд зургийн аппарат эсвэл өөр ямар нэгэн бичлэг хийх техник авч ирэх ёсгүй. Хэрвээ авч орж ирсэн бол хамгаалах байранд оронгут зургийн аппарат эсвэл өөр ямар нэгэн бичлэг хийх техник айлчлал дуусах хүртэл хадгалуулан үлдээнэ.
  - Гаднаас айлчилж ирсэн хүмүүсийн айлчлал болгоны

бүртгэлийг хөтлөн, бүрэн тайланг хамгаалах байрны менежер хадгална.

- Хэвлэл мэдээллийнхэнтэй харьцах тодорхой бодлого хамгаалах байранд боловсруулж даган мөрдөх:

### *Хэвлэл мэдээллийнхэнтэй харьцах*

Байгууллагууд хэвлэл мэдээллийнхэнтэй туйлын болгоомжтой харьцах ёстой. Зарим хамгаалах байрууд хэвлэл мэдээллийнхэн ямар ч байдлаар мэдээлэл өгөхгүй бодлого баримталдаг, зарим нь тодорхой нөхцөлд хэрвээ тухайн сэтгүүлчийг сайтар мэдэн итгэлтэй хэмээн үнэлсэний үндсэн дээр харилцдаг. Хэрвээ зөвшөөрөгдхөөр бол дээр дурьдсан зургийн аппарат, бичлэгийн аппарат, ярилцлага хийхийг зохицуулах болон байрлагчидтай ярилцах бүхий л дүрмийг баримталх нь тустай.

### **Аюулгүй стандарт болон процедурууд – хамгаалах байранд байрлагчид**

#### *Хамгаалах байрны хариуцлага*

Дараах процедур нь байрлагчдын аюулгүйн хамгаалал, аюулгүй байдлыг дээд зэргээр баталгаажуулахад зөвлөгдөх зүйлс

- Байрлагчдад эргэн тойрны орчноо сайтар сэдэж байх хэрэгтэй талаар зөвлөж байх
- Ажилтан байрлагч хамгаалах байр эсвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллагын байрнаас гадуур эмзэг байдлалд оруулж болохуйц газраар явахад нь заавал дагалдан авах (зам үзүүлэх, хууль, эсвэл цагдаад очих)
- хэрвээ уг уулзалт нь цагдаа эсвэл хууль хэрэгжүүлэгч байгууллагын албаны хүнтэй хийхээр бол хохирогчийг хуулийг зөвлөгч дагалдан явна.

#### *Байрлагчдын хүлээх үүрэг*

Хамгаалах байранд ХХГХ-ийн хохирогч байрлах нь эрсдлийг ямар нэгэн байдлаар заавал нэмэгдүүлж байдаг. Хохирогч эх орондоо эргэж очсоныхоо дараагаар гэр бүлийнхэн болон найз

нөхөдтэйгээ уулзах нь тодорхой бөгөөд тэдгээр нь хамгаалах байрны аюулгүй байдал, хамгаалалд ямар нэгэн байдлаар эрсдэл оруулдаг. Мөн ижил байдлаар байрлагчид хамгаалах байранд байрлах хугацаандаа байнга тэндээс гарахгүйгээр байрлах боломжгүй тул тэд гадуур гарахдаа хамгаалах байрны ажилтнуудын өгсөн зөвлөмжийг дагалгүй хуучин байнга очдог байсан газраараа очин өөрсдийнхөө байгаа гэдгийг мэдэгдэх эрсдэл байдаг. Зарим тохиолдолд хохирогч гэмт этгээдүүд эсвэл элсүүлэгчтэйгээ сэтгэл зүйн хувьд хамааралтай байх тул тэдэнтэй буцаж холбоо тогтоох, хуучин харьцаагаа сэргээх хүсэлтэй байдаг. Эдгээр эрсдлийт тооцоод хамгаалах байранд байрлагчид нь өөрсдөөс нь хамаах асуудалд өндөр хариуцлагатай байж өөрсдийгээ хэрхэн хамгаалахаас хамгаалах байрны бусад байрлагчид болон тэнд ажиллагчдын аюулгүй байдал, хамгаалал шалтгаална гэдгийг сайтар тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй. Энэ ч зорилгоор хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангахын тулд байрлагчид нь аюулгүйн хамгааллын тодорхой хэмжээний процедур, тухайн байрны дүрмийг даган мөрдөх шаардлагатай. Байгууллагууд ойлгомжтой процедур, дүрэм боловсруулан бүхий байрлагчид болон ажилтнуудад түүнийг даган мөрдүүлэх шаардлагатай. Тэрхүү дүрэмд хувь хүн байранд байрлахдаа байрны ажилд оролцох болон бусад байрлагчид мөн тэнд ажиллагчидтай сайн харьцаатай байх тал дээр хувь хүн болгон хариуцлагатай байх талаар хүлээх үүрэгтэй байна. Тэрхүү дүрэмт хар тамхи, согтууруулах ундаа, зэвсэг, гар утас хадгалах, хэрэглэх түүнээс гадна гаднаас зөвшөөрөлгүй хүн оруулах бүгд хориотой байхаар дүрэмдээ оруулж өгөх нь зүйтэй юм.

Хохирогчыг бүртгэн хамгаалах байранд байрлуулахаас өмнө тэдэнд аюулгүйн процедур, байрны дүрмийг уншуулан гарын үсэг зуруулж авна.

### **Аюулгүйн стандарт болон процедурууд – нууцлал, захиргааны болон бичиг баримтын эрсдэл**

---

Хувь хүний болон ХХГХ-ийн нууцлал бүхий, цахим болон цаасан дээр буулгасан мэдээллийг зохицуулах болон устгах ажиллагааг болгоомжтой үйлдэх шаардлагатай. Энэ талаарх тодорхой зөвлөмжүүдийг 1-р бүлгийн, 1.2 хэсгээс нэмэлт мэдээлэл болгон уншина уу.

---

Одоо бидний хөндөх гэж буй асуудал нь хамгаалах байрууд нь байрлагчид болон ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагааны улмаас туйлын завгүй байдаг газар тул дараагийн сэдэв энэ талаарх зохицуулалтын зөвлөмжийг хийх болно. Энэхүү хоорондыг харьцаа болон энэ харьцаанаас үсэх нөхөрсөг харилцаа нь нууцлал бүхий бүртгэлийн хадгалалт, хамгааллын процедурыг зөрчихөөс гадна хамгаалалтын бусад дүрмүүдийг зөрчих магадлал бий болгодог.

---

- **Хамгаалах байрны байрлагчид болон ажилтнуудын хувь хүний нууцлалтай холбоотой аливаа бүртгэл, тэмдэглэл болон бусад бүхий л бичиг баримт аюулгүйн хамгааллын үндсэн нөхцөл болохынхоо хувьд аюулгүй, хамгаалалттай орчинд хадгалагдах ёстай.**
  - **Хамгаалах байран дахь бүхий нууц бичиг баримт, бүртгэлийн найдвартай хамгаалал нь хамгаалах байрны менежерийн хариуцлагад хамаарна.**
  - **Аюулгүйн хамгааллын процедур болон бүх хүмүүст барамтлах асуудал нь хамгаалах байрны менежерийн шууд үүрэгт хариуцлага мён.**
- 

Баталгаажуулах ёстай аюулгүйн хамгааллын гол арга хэмжээнүүдэд:

- Хохирогчид болон ажилтнуудад хамааралтай ямарваа нууц бичиг баримт эсвэл ХХГХ-ийн нууц мэдээлэл зөвшөөрөлгүй хүний санаатай болон санаандгүй үйлдлийн улмаас хүрээмжтэй байж болохгүй.
- Хамгаалах байранд байрлагчидтай холбоотой бүхий л бичиг баримт, бүртгэл хамгаалах байрны хөтөлбөрийг зохицуулах болон хянахад л шаардлагатай төдий хэмжээнд байлгана. (бага)
- Мэдээллийг гуравдагч талд дамжуулахдаа “мэдэх шаардлага” гэдэг зарчмын дагуу хязгаарлалттай байх

## 4.3 Хамгаалах байрны менежмент болон ажилтан ажиллуулах

### 4.3.1 ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТНУУДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хамгаалах байранд ямар мэргэжил боловсрол, чадавхитай, хэдэн ажилтан ажиллах нь тухайн хамгаалах байрны хэрэгцээ, нөөц мөн тухайн хамгаалах байр болон зорилгоос нь хамаарна. Хамгаалах байранд зайлшгүй байх шаардлагатай, хэрэгцээт ажилтны бүрэлдэхүүн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон холбогдох бусад түншүүд дараах зүйлсийг харгалзана:

- Хамгаалах байрнаас үзүүлэхээр санал болгож буй үйлчилгээний хүрээ
- Үйлчилгээнүүд байран дээрээ явагдаж байгаа эсвэл өөр байгууллагуудад хандуулах журмаар явагдаж байгаа эсэх
- Байрлан, туслалцаа авах байрлагчдыг хүлээн авах дундаж тоо
- Хамгаалах байранд байрлах өдрийн тоо, дунджаар.

Хамгийн багадаа хамгаалах байр болгон дараах ажил үүргийг гүйцэтгэх 1 болон түүнээс дээш байнгын ажилтантай байх ёстой:

- Хамгаалах байрны менежмент
- Шууд зөвлөгөө болон (эсвэл сэтгэл зүйн туслалцаа)
- Байрлагчдыг ерөнхийд нь харгалзах болон халамжлах
- Санхүүгийн хяналт, шаардлагатай бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах

### 4.3.2 ХАМГААЛАХ БАЙРНЫ МЕНЕЖМЕНТ

Хамгаалах байр болгон хамгаалах байрны менежерийг үүргийг гүйцэтгэх нэг ажилтантай байх ёстой. Хамгаалах байрны менежерийн албан үүрэгт хамгаалах байрны ажилтнууд болон байрлагчдад үзүүлэгдэж буй үйлчилгээнд хяналт тавин өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулалгүй, найдвартай явуулах ажлыг гүйцэтгэнэ. Хамгаалах байрны менежер нь хамгаалах байрны зорилго, зарчмуудын хүндэтгэн, хамгаалах байранд байрлагчдын болон ажилтнуудын аюулгүйн хамгаалал, эрүүл

мэнд, сайн сайхныг баталгаажуулна. Хамгаалах байрны хариуцлах ажлын жишээг доор гаргав:

- Хамгаалах байрны өдөр тутмын үйл ажиллагааг хянах. Хамгаалах байранд байрлагчдын хэрэгцээнд нийцүүлэхийн тулд боловсруулагдсан төлөвлөгөөг сайжруулж, хэрэгжүүлж, зохицуулж, үнэлэх ёстой.
- Захиргааны гүйцэтгэх дэд бүтцийг бий болгон, хяналт тавьж, хамгаалах байрны ажилтнууд, байрлагчид болон үйлчилгээг удирдан, чиглүүлнэ.
- Ажилтнууд хамгаалах байрны зарчим, зорилго, бодлогыг чанадлан баримтлаж байгаа, байрлагчийн үнэлгээ, оролцоо, үйлчилгээ авахаар өөр байгууллагад хандуулж байгаа эсэх болон хамгаалах байранд байрлагчдад хувийн асуудлаа шийдвэрлэх зэрэгт нь ерөнхий туслалцаа үзүүлэж байгаа гэдгийг баталгаажуулах. Хувийн асуудал гэдэгт эрүүл мэндий, зөвлөгөөний ба хуултйн туслалцаа, шаардлагатай тохиолдолд бусад хоол хүнс, материаллаг хэрэгцээ болон үйл ажиллагаанууд орно:
- Байрлах хэрэгцээ болон явах асуудлийг шийдэх
- Аюулгүйн болон хамгааллыг систем, тест болон процедурыг даган мөрдөх
- Хөтөлбөр төлөвлөгдсөний дагуу гүйцэтгэгдэж, үйлчлүүлэгчийн бүртгэл нямбай хөтлөгдсөн бөгөөд нууцлал бүхий хадгалагдаж байгааг баталгаажуулах.
- Хамгаалах байрны ажилтнууд болон үйлчилгээ үзүүлэгчдийг тодорхойлох, ажилд авах, чиглүүлэх, сургалтанд хамруулах болон дэмжихэд оролцох.
- Хамгаалах байрны ажилтны ажлыг хянаж, үнэлнэ. 7 хоног тутмын ажилтнуудын хурлыг тэргүүлэх болон оролцох, кейсийн үйлчилгээ үзүүлэх төолөвлөгөөг эргэн харах, ажилтнуудын хоорондын зэрчил, маргааны шийдвэрлэх, зохицуулах, дэг журмын арга хэмжээг шаардлагатай болон зохих ёсоор нь захиран явуулах.
- Ажилтнуудыг байнгын ажиллагааг зохицуулах - ажилтны амралт, өвдсөн үе болон бусад байхгүй тохиолдлыг тооцох
- Ажилтнууд үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэж байгааг мониторинг хийх
- Айлчлан ирэгчдийн бүргэлийг үзэх, хянах, янзлах
- Шаардлагатай бол сар болгоны тайланг бэлтгэх

- Төсвийн зарцуулалтыг хянан, шаардлагатай тохиолдолд нэлэт өөрчлөлт оруулах
- Хамгаалах байрны байшингийн болон тоног хэрэгслийн цэвэрлэлт, найдвартай үйл ажиллагааг хянан, баталгаажуулж байх
- ХХГХ-ийн эсрэг тэмцэгч байгууллага, албаны хүмүүстэй ХХГХ-ийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа явуулах зорилгоор холбоо тогтоон хамтын ажиллагааг үүсгэн бий болгож, хөгжүүлж, зорицуулж, зохион байгуулна.
- Шаардлагатай бусад үүргийг гүйцэтгэнэ.

#### **4.3.3 ШУУД ЗӨВЛӨГӨӨ БОЛОН/ЭСВЭЛ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАЦЛАА**

Хамгаалах байр болгон шууд зөвлөгөө өгөх эсвэл сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүрий нэг болон түүнээс дээш тооны ажилтантай байна. Энэ төрлийн туслалцааг хамгаалах байранд байрлагчдад ихэнх тохиолдолд нийгмийн ажилтан, зөвлөгч, эсвэл сэтгэл зүйч хамгаалах байрны менежерийн удирдлага дор болон түүний дэмжлэгтэйгээр үзүүлдэг.

##### **Нийгмийн ажилтан/зөвлөгч**

Нийгмийн ажилтан/зөвлөгч нь хамгаалах байранд дахь байрлагчдад зөвлөгөө өгөхөөс гадна бусад халамж үзүүлэгчдийн хамт боловсруулсан хувь хүний кейсийн төлөвлөгөөний дагуу үзүүлэгдэх үйлчилгээг зохион байгуулж, үзүүлэгдэж байгаа эсэхийг хянана. Нийгмийн ажилтан/зөвлөгчийн ажил үүргийн жагсаалтыг ддор үзүүлсэн болно:

- Хохирогчтой эхний уулзалтыг хийх, хамгаалах байранд хаана юу байдгийг тайлбарлаж өгөх
- Байрлагчдад хамгаалах байрнаас санал болнож буй үйлчилгээнүүдийг ойлгож, зөвшөөрөх асуудлыг хариуцна
- Байрлагчдын яаралтай хамгийн чухал болон түүний дараа орон хэрэгцээг тодорхойлно.
- Байрлагчтай хамтран хувь хүнд зориулсан кейсэд тулгуурласан туслалцаа үзүүлэх төлөвлөгөөг байрлагч, хамгаалах байрны ажилтан болон бусад халамжлагчидтай

- хамтран боловсруулах
- Байран доторх болон байрнаас гадуур үйлчилгээ үзүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэхээр хандуулалт хийх
- Шаардлагатай болон байрлагч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд байрлагчдыг үйлчилгээ үзүүлэгчидтэй уулзахад дагалдах,
- Байрлагчдын кейсэнд болон байрлах хугацаанд гарсан ахиц дэвшилтэд мониторинг хийх..
- Байрлагчийн хамгаалах байрнаавы явах өдөр хоногийг тогтооход оролцох болон хохирогчид дараагаар үзүүлэгдэх үйлчилгээ, хандуулалтын хэрэгжилтийг хянах
- Байрлагчтай хамтран явах процедурыг тохиролцон төлөвлөж, байрлагч процедур болон хандуулалтыг сайтар ойлгосон эсэхийг баталгаажуулна.
- Хэрвээ дамжин өнгөрүүлэгч болон хүлээн авагч улсад байрлалтай бол байрлагчийн эх оронд дахь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо тогтоож болох эсэхийг шалгаад, байрлагч явсанаас хойших гурван сарын дэвшлийн үр дүнгийн тайланг олж авах.
- Хэрвээ эх оронд нь байрлаж байгаа бол байрлагчийг хамгаалах байрнаас явсанаас хойш тухайн хүний кейсэнд мониторинг хийж, мөн 6 сарын туршид холбоотой байна.
- Хамгаалах байр өөрийн байрлаж буй газар болон хохирогчийн эх орон дахь үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоо тогтоон, шинэ тутам мэдээллийг солилцож байх.
- 7 хоног тутам ажилтнуудын уулзалт, мөн хувь хүний кейсийн хурал хийж.

### Сэтгэл зүйч

Хамгаалах байр нысэтгэл зүйч нь байрлагчидтай ярилцан тэдний сэтгэцийн байдал, тухайн орчин, нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулах чадавхийг тодорхойлно. Сэтгэл зүйч нь ганцаарчилсан эсвэл булгийн сэтгэл заслын эмчилгээ, хүний зан үйлдлийг өөрчлөх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх болон шаардлагатай бол бусад халамжлагчидтай хамтран байрлагчдад зориулсан эсчилгээ, заслын хөтөлбөрийг боловсронгуй болгон хэрэгжүүлнэ. Сэтгэл зүйчийн албан үүргийн загвар жагсаалт:

- Байрлагчдад үнэлгээ хийх, оношлох тест явуулах

- Байрлагчдад яаралтай тохиолдолд, асуудал үүссэн үед ямар байдлаар шийдвэрлэхийг зөвлөх.
- Байрлагчдад халамж, дэмжлэг үзүүлтэх.
- Сэтгэцийн өвчлөлтэй байх шиг тэмдэг илэрсэн байрлагчдыг олж тодорхойлж, сэтгэц заслын эмчилгээнд явуулах.
- Байрлагчийн сэтгэцийн чадавхи эргэлзээ төрүүлж байвал тухайн хүнд үнэлэлт хийж, хамгаалах байрны менежер бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчдэд мэдэгдэх.
- Байрлагчдыг хувь хүний кейсд тулгуурласан төлөвлөгөө боловсруулахад оролцно.
- Байрлагч явж байгаатай холбогдуулсан кейсийн өөрчлөлтөд оролцох үүнд: цаг хугацаа, нөхцөл байдал, үйлчилгээнд хандуулах зэрэг.
- Хамгаалах байрны бүхий л үйл ажиллагаа, хөтөлбөрийн сайжруулан боловсруулахад тусалж дэмжих
- Кейсийн хуралд суух
- 7 хоног болгоны уулзалтанд шаардлагатай бол оролцох.

#### **4.3.4 БАЙРЛАГЧДАД ХАРГАЛЗАН ХЯНАХ БОЛОН ЕРӨНХИЙ ХАЛАМЖ ҮЗҮҮЛЭХ**

Хамгаалах байрны ажилтнууд жижүүр ажилтантай хамтран байрлагчдыг ерөнхийд нь 24 цагийн туршид ажиглах. Хамгаалах байрны жижүүрүүд өөрсдийн ажил үүргээ Хамгаалах байрны менежерийн удирдлага дор, түүний дэмжлэгтэйгээр гүйцэтгэнэ.

#### **Хамгаалах байрны жижүүр**

Хамгаалах байр болгон тэнд байрлагчдад анхаарал тавих, харгалзан хянах 2 болон түүнээс дээш тооны жижүүртэй байна. Жижүүрүүд байрлагчдад ерөнхий халамж үзүүлэхийн сацуугаар тэдэнд зохих хяналт тавина. Хамгаалах байрны жижүүр нь өдөртөө тэнд явагдаж буй үйл ажиллагаануудыг ажиглан, хамгаалах байранд даган мөрдөгдөх ёстой дүрэм болон аюулгүй байдлын хамгааллын хэрэгжилтийн ажиглана. Хамгаалах байрны жижүүрийн ажил үүргийн хувиарт:

- Ерөнхий хяналт, байрлагчид хамгаалах байрны дүрэм, журмыг баримталж байгаа эсэх.

- Өдөр тутмийн үйл ажиллагааг өдрийн цагийн хувиар болон хамгаалах байрны менежерийн удирдамжийн дагуу зохион байгуулагдаж, хэрэгжүүлэгдэж, хийгдэж байгаа эсэх.
- Байрлагчдын гарах, орох бүртгэл.
- Хамгаалах байрны менежерийн урьдчилан зөвшөөрөл өгсөн хүмүүсийн гарах, орох бүртгэл.
- Байрлагчдад үзүүлэж буй эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээний бүртгэл.
- Байрлагчид эрүүл мэндийн болон бусад үйлчилгээгий зорилгыг ойлгон, үйлчлүүлэхээр зөвшөөрч гарын үсэг зурж байгаа эсэх.
- Байрлагчид аюлгүй байдлын дүрэм, удирдамжийг биелүүлж байгаа эсэх.
- Байрлагчид, ажилтнууд хамгаалах байрны ариун цэвэр, тохижилт орчныг бүрдүүлэх, хэвээр байлгахад шаардлагатай цэвэрлэгээ, үйлчилгээг хийх байгаа эсэх.
- Байрлагчид бие биедээ хүндэтгэл, ойлголцлын үүднээс хандаж байгаа эсэх.
- Байрлагчид хоорондоо гаргасан болон байрлагчаас хамгаалах байрны менежментийн талаар гаргсан гомдлыг цаг тухайд нь, зохих ёсоор нь шийдвэрлэх.
- Шаардлагатай бол ерөнхий цэвэрлэгээ, угаалга хийж бусдыг цэвэр байлгах.
- Санхүүгийн туслах/няравт энгийн хэрэглээ болон хамгаалах байранд ямар нэгэн зүйл дутагдаж, хэрэгцээ гарахад мэдэгдэх.
- Хамгаалах байрны менежерт ямар нэгэн засах, янзлэх зүйлийг мэдэгдэх.
- Хамгаалах байрны менежерт яливаа асуудал, аюулгүй байдлын эрсдэл эсвэл содон үйлчилгээ, тохиолдлын талаар мэдээлэл.
- Хамгаалах байрны үйл ажиллагаа болон болсон явдлуудыг бичгээр тэмдэглэн хадгалах.
- Өдөр тутамын үйл явдал, жижүүр солилцооны мэдээллийг 7 хоногоор бичгээр, нэгтгэх.
- 7 хоног тутамд ажилтнуудын уулзалтанд оролцох.

#### 4.3.5 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ БА ХАНГАМЖ

Хамгаалах байрны ажилтнууд нэг ажилтныг дундаасаа

(санхүүгийн ажилтан эсвэл санхүү, хангамжийн ажилтан эсвэл туслах) хамгаалах байрны санхүү, хангамж хариуцуулан тавина.

### **Санхүүгийн хяналт ба хангамжийн ажилтан**

Энэ албан тушаалын гол үүрэг нь хамгаалах байрны бүхий л зардлагыг хянахад оршино. Үүнд: хамгаалах байранд шаардлагатай бүхий л зүйлсийг хамгаалах байрны менежерийн удирдлагаар болон дэмжлэгтэйгээр төсөвт тааруулан худалдан авах. Санхүүгийн ажилтны ажил үүргийн хувиарын загвар:

- Гарсан бүхий л зарлагын дэлгэрэнгүй, нямбай тэмдэглэгээ хөтлөх.
- Хамгаалах байрны нөөцийг арга гамтай, үр дүнтэй ашиглаж байгаа эсэх.
- Хамгаалах байрны үйл бүхий л төлбөр тооцоог цаг тухайд нь хийх.
- Хамгаалах байрны агуулахад шинэ, лаазласан, хатаасан хүнсээр дүүргэн, яаралтай хэрэглээнд бэлэн байлгаж, бусад тохиромжтой хувцас, гутал, ариун цэврийн хэрэгсэл, аяны цүнх, хэрэгцээт зүйлсийг нөөцлөө.
- Хамгаалах байрны менежертэй зөвлөлдөн шаардлагатай зүйлсийг худалдан авах (эсвэл худалдан авсан зүйлийг өгөх болон хянах)
- Хамгаалах байрны менежерт 7 хоног тутмын санхүүгийн тайлан гаргаж өгөх.
- Шаардлагатай тохиолдолд ажилтнуудын уулзалтанд оролцох, эсвэл шаардлагатай тохиолдолд уулзалтын үеэр хамгаалах байрны хяналтыг явуулах.

#### **4.3.6 БУСАД АЖИЛТНУУД**

Хамгаалах байрны нөөц, хэрэгцээ, тухайн хамгаалах байр ихэнх үйлчилгээг өөрийн байранд дээрээ эсвэл өөр газар явуулж байгаагаас хамаараад, хамгаалах байранд эмч, багш, үйл ажиллагааны зохицуулагч, орчуулагч бусад шаардлагатай хүмүүс ажиллана.

#### **4.3.7 САЙН ДУРЫНХНЫГ АЖИЛЛУУЛАХ НЬ**

Зарим хамгаалах байр үзүүлж буй үйлчилгээний төрөл, тоо,

байрлагчдад санал болгож буй үйл ажиллагаанаас шалтгаалаад сайн дурынхныг ажиллуулдаг. Энэ тохиолдод сайн дурынхны туслалцаа хангамжийн үйлчилгээ болон хамгаалах байранд явуулж буй үйл ажиллагаанд туслуулахаар хязгаарлагдаж, хамгаалах байрны гол үйл ажиллагаанд ажилтнуудтай адил оролцдогүй. Зарим хамгаалах байруудад сайн дурынхны туслалцаа эдгээр зүйлүүдэд голчлон авдаг:

- Хэлний мэдлэг;
- Компьютерийн мэдлэг
- Бүжиг болон дууны терапи
- Урлаг болон гар урлал

Сайн дурынхны хэрэгцээг аюулгүй байдлыын асуудлууд, нөөц, хяналтын хүчин чадал, байрлагчдын хэрэгцээ болон сайн дурынхны нэмэр хандивын түвшингээр тодорхойлно. Сайн дурын хүн үйл ажиллагаа явуулах үед хамгаалах байрны ажилтан нэг хүн хажууд заавал хамт байх шаардлагатай. Аюулгүй байдлын дүрэм, чанарын хяналтыг баталгаажуулах үүднээс бүх сайн дурынхан:

- Эхний шалгалт, хувь хүний шалгуурыг;
- Хамгаалах байрны дүрмийг мөрдөх талаар гарын үсэг зурах;
- Нууцлалын гэрээнд гарын үсэг зурах;
- ХХГХ-тэй тэмцэх анхан шатны сургалтанд суух.

Хүүхэдтэй ажиллах сайн дурынхан ХХГХ-ийн хохирогч хүүхдийн онцгой хэрэгцээ, эрхийн талаар сургалт, мэдлэг дээшлүүлэх сургалтанд суух ёстой.

#### **4.4 ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТНУУДЫН МЕНЕЖМЕНТ БА СУРГАЛТ**

Хамгаалах байрны менежментийн хамгийн гол нь дараах хамгаалах байрны ажилтнуудыг менежментийг хөгжүүлэх болон хянахад оршино:

- Ажилтнуудын сургалт;
- Ажилтнуудын ёс зүйн дүрэм;
- Ажилтнуудын ажлын цагийн хувиар;
- Ажилтнуудын хяналт, шалгалт.

#### **4.4.1 СУРГАЛТ БОЛОН АЖИЛТНУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД**

Ажилтан болгон ажилд орсон эхний 7 хоногт хамгаалах байрны ба ХХГХ-ийн эсрэг тэмцэх ерөнхий бичиглэл олгох сургалт, хичээлд суралцан хамгаалах байрны менежерийн удирдлага дор ажиллана. Ажилтны өөрийн туршлагаас хамаараад ажлын онцлогтой холбоотой чиглүүлэх, шаардлагатай сургалтанд хамрагдана. Сургалтанд заагдах сэдвүүд:

- ХХГХ-ийн үзэгдэл;
- ХХГХ-ийн хохирогчийн эрх болон, хамаарах хуулийн үндсэн зарчим, Палермо Протокол болон бусад үндэсний ХХГХ-тийг тэмцэх хууль, тогтоомж, хөтөлбөрүүдийг ерөнхийлөн үзэх;
- Цочролд орсон хохирогчдод эдгэрэх, нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа, чиглэлийн үндсэн удирдамж;
- ХХГХ-ийн хохирогчдод нөхөн сэргээх үйл явцыг дэмжих зорилгоор нөхөн сэргээх, дэмжих үйлдлүүд болон оролцоонууд;
- Цочролд орсон хохирогчтой харилцах талаарх тусгайлан мэргэшүүлсэн чадавхи;
- Үйлчилгээ үзүүлэхэд багаар ажиллах, өргөн хүрээнд сэтгэх хандлага;
- Хямралын нөхцөлд зохицуулалт хийх зарчмууд;
- Зөвлөгөө өгөх үндсэн зарчмууд;
- ХХГХ-ийн хохирогчдод зөвлөгөө өгөх тусгай удирдамж;
- Боломжтой дэмжих үйлчилгээ болон тухайн хүрээний тусгай үйлчилгээ;
- Аюулгүй байлын хамгаалал болон аюулгүйн сургалт;
- Түргэн тусламжийн туслалцаа үзүүлэх сургалт.

Дараа дараагийн шатны сургалт ба тусгай сургалтын хичээлүүдийг хамгаалах байрны менежер хамгаалах байрны ажилтнуудын хэрэгцээ, ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааны ахиц дэвшилтэй уялдуулан зохион явуулах ёстой.

#### **4.4.2 ХАМГААЛАХ БАЙРНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ/ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ СТАНДАРТУУД**

Хамгаалах байр болгон хамгаалах байрны ёс зүйн дүрэм/үйл

ажиллагаа явулах стандартууд боловсруулан ажилтнууддаа даган мөрдүүлнэ. Ёс зүйн дүрэм нь хамгаалах байрны өөрийн нь ХХГХ-ийн эсрэг явуулдаг бодлоготой уялдан боловсруулагдана. Гол зарчмууд энэ гарын авлагын урд өгүүлсэн бүлгүүдэд тусгагдсан билээ. Хамгаалах байрны ажилтнууд Ёс Зүйн дүрмийг бусад Хамгаалах байрны аюулгүй байдлын болон нууцлалын процедуур, дүрмүүдтэй нэгэн адил хатуу даган мөрдөнө (Ажилтнуудын Ёс Зүйн Дүрмийн Удирдамж болон Ажилтнуудын Даган Мөрдөх Нууцлалын Гэрээг, энэ бүлгийн төгсгөлд байх Хавсралт I ба II-оос үзнэ үү).

#### 4.4.3 АЖИЛТNUУДЫН ЦАГИЙН ХУВИАР

Хамгаалах байрны менежер ажилтнуудыг цагийн хувиарыг 24 цагийн үйл ажиллагаагаар 7 хоногийн 7 өдөр үйл ажиллагаа тасралгүй явагдахаар зохиож, хэрэгжүүлнэ. Хамгаалах байрны үйл ажиллагааг байнгын үргэлжлэх байдлыг хадгалах үүднээс ямар нэгэн яаралтай эсвэл гэнэтийн асуудлаар ажилдаа ирж чадахгүй болсон ажилтнуудын оронд гарч ажиллах нөөц ажилтныг тодорхойлсон байна. Үйл ажиллагааг үр дүнтэй болгох үүднээс хамгаалах байрны ажилтны тоо болон тэнд байрлагчдын тооны хоорондын харьцааг алдагдуулахгүй байх нь чухал. Энэ нь хамгаалах байрны ажилтны хүрэлцээ, хамгаалах байрны хүчин чадал болон тэнд байрлагчдын дундаж тоо, үзүүлж буй үйлчилгээ, байрлагчдын хэрэгцээ болон хамгаалах байрны үзүүлэх халамжийг хамгийн дээд түвшинд байлгахад шаардлагатай ажилтнуудын чадавхиас шалгаална. Ажилтнууд болон байрлагчдын тооны харьцааг байнга хянаж зохих үр бүтээлтэй үйл ажиллагаа явагдах нөхцлөөр хангах.

#### 4.4.4 ХЯНАЛТ

##### 7 хоног тутмын ажилтнуудын уулзалт

Ажилтнуудын уулзалтыг 7 хоног тутамд хийх нь ажилтнуудын үйл ажиллагаанд болон байрлагчдын кейс түүхэнд мониторинг, хяналт хийхэд шаардлагатай. 7 хоног тутмын ажилтнуудын уулзэлтыг байнга хийх нь дараах асуудлуудыг хэлэлцэх нөхцлийг бүрдүүлдэг:

- Кейсийг зохицуулах;
- Кейсэд гарч буй ерөнхий ахиц дэвшил;
- Гаднаас ирж буй болон явж буй кейсүүд;
- Кейсд гарсан аливаа асуудлыг шийдвэрлэх;
- Ёс зүйн асуудлууд;
- Үйлчилгээ үзүүлэгч өөр байгууллагууд болон ХХГХ-ийн эсрэг тэмцэгчидтэй харьцааны байдал;
- Байрлагчид болон/эсвэл ажилтнуудын хоорондын зөрчилдөөн эсвэл гомдлууд;
- Хамгаалах байрны бодлого, процедурын үнэлгээ;
- Байрлагчдын асуултуудыг эргэн хянах;
- Хамгаалах байртай холбогдолтой аливаа асуудал, санаа бодлууд.
- Ганцаарчилсан ярилцлага, хяналт

Хамгаалах байрны менежер нь шаардлагаас хамаарч ажилтнуудтайгаа үе үе уулзалдан дараах асуудлаар санал солилцон, хэлэлцэнэ:

- **Чиглэл.** Хамгаалах байрны ажилтнуудын өмнөө тавьсан зорилго гүйцэлдүүлж болохуйц, тухайн газар орны нөхцөл байдалтай уялдсан бодит, байх ёстой.
- **Дасгалжуулалт.** Хамгаалах байрны менежер хамгаалах байрны ажилтнуудад зориулсан мэдээллийн сургалт, хичээлийг тэдний гүйцэлдүүлж буй зорилгод нийцүүлэн, дэмжих байдлаар зохион байгуулна.
- **Эргэх холбоо.** Эргэх холбоо нь ажилтнуудыг үнэлэх, батламжлах, дэмжих болон шүүмжлэхэд болон хамгаалах байртай холбоотой бүхий л төрлийн харилцааны асуудлыг шийдэхэд хэрэглэгдэж, хамгаалах байрны ажилтнууд болон тэнд байрлагчдын аливаа асуудал, давамгайлах нөхцөл байдлыг зохицуулахад хэрэглэгдэнэ.
- **Зөвлөгөө өгөх.** Ажилтнуудын аль нэгний зан үйл, ажлын гүйцэтгэл, эсвэл байрлагчийн биеэ авч байдалтай холбоотой, аливаа асуудалд хамгаалах байрны менежер тухайн холбогдох хүнд нь мэдэгдэн, асуудлыг зөвөөр шийдвэрлэхэд нөлөө болохуйц дэмжлэг, зөвлөгөөг өгнө.
- **Сахилга бат.** Хамгаалах байрны дүрэм, журмыг үл ойшоон, зөрчигдсөн бол хамгаалах байрны менежер шаардлагатай арга хэмжээг авна. Тухайн менежер ажилтанд даган мөрдөж

буй дүрэм, журмын болон тэдний үүсэн бий болсон гол шалтгаанд анхаарлыг нь хандуулан энэ бүгдийг заавал даган мөрдөх яс шаардлага байдгийг тайлбарлаж өгнө. Аюулгүй байдлын хамгааллыг дүрмүүд, эсвэл нууцлалын талаарх зохицуулалтуудыг зөрчсөн талаарх аливаа үйлдэл, гүйцэтгэлд онцгой анхаарал хандуулах ёстой.

#### 4.4.5 ХЭТ ЯДРАЛД ОРОХ

Хэт ядралд орох нь удаан хугацааны туршид бие, сэтгэл зүй, сэтгэлгээ сэтгэл хөдлөлийн нэхцэл байдалд байж ядарсанаас үүсдэг. ХХГХ-ийн хохирогчтой ажилладаг ажилтнууд өөрсдөдөө анхаарал халамж тавьж, ажилдаа зарцуулж болох сэтгэл хөдлөлийн энергий зөв хязгаарлалттай зарцуулах зохицуулалт хийнэ. ХХГХ-ийн хохирогч зэрэг цочролд орсон хүмүүст халамж, үйлчилгээ үзүүлэгч нар өөрсдөө төрөл бүрийн сэтгэл зүйн хөдлөлөлөөс үүсэх стресст өртөмхий бөгөөд үүнээс улбаалан хоёр дахь цорчоод оруулж болзошгүй гэдгийг менежерүүд мэдэх ёстой. Хэрвээ тухайн хүн байнга стрессийн байдалд удаан байвал “хэт ядралд” ордог. Нэг ажилтнуудад дэмжлэг үзүүлэх, хэт ядралд орсон тохиолдолд тэрийг олж таних, тэнээс урьдчилан сэргийлэх талаарх гүнзгийрүүлсэн мэдээллийг 5-р бүлгийн, 5.15 хэсгээс олж үзнэ үү.

### 4.5 Хохирогчдод хамгаалах байранд туслалцаа үзүүлэх процедурууд

Энэ бүлгийн үлдсэн хэсгийг хамгаалах байрны ажилтнуудад ХХГХ-ийн хохирогч хамгаалах байранд ирэх үеэс явах үе хүртэлх хооронд явуулах үйл ажиллагааны удирамжийг өгөхөд зориулна. Тус удирдамж нь хохирогчийн эх орон дахь, болон түүнийг дамжуулан өнгөрүүлсэн болон хүлээн авсан улс дахь хамгаалах байрны процедурыг дүрслэх болно. Хамгаалах байр хохирогчийн эх оронд, дамжуулагч улсад эсвэл хүлээн авагч улсад байгаагаас үл хамаараад явуулах процедур нь өөр хоорондоо ижил байна. Ихэнх тохиолдолд үйлдэгддэг тэрхүү процедурын талаар доор өгүүлэх болно. Процедурын зарим нь нэмэлт хандуулалт, эх оронд нь эргүүлэн буцаах, эргэн нийгэмшүүлэх процедур болгонд

хоорондоо зайлшгүй давхцах тул уншигч тухайн хандуулалт, эх оронд нь буцаах, эргэн нийгэмшүүлэх талаар энэ бүлгийн эхэнд өгүүлсэн хэсгээс илүү дэлгэрэнгүй уншина уу. Хамгаалах байрны процедуур нь тухайн онцлог нөхцөл байдал, хэрэгцээ, тухайн хохирогчид шаардлагатай туслалцааны хүрээнээс хамаарна. Процедурын ялгаатай байдлууд гарын авлагад тусгагдсан болно.

#### **Хавсралт I: ХХГХ-ийн хохирогчидтой ярилцлага хийх болон халамж үзүүлэн баримтлах ёсзүйн зарчмууд-ыг харна уу.**

**ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх эсвэл ярилцлага хийхээс өмнө үйлчилгээ үзүүлэгч байгууллагын бүх ажилтнууд энэ гарын авлагын хавсралт 1 - ХХГХ-ийн хохирогчидтой ярилцлага хийх болон халамж үзүүлэхэн баримтлах ёс зүйн зарчмууд, Хавсралт 2 – ярилцлага хийх асуултыг анхааралтай уншина уу.**

#### **4.5.1 ХАМГААЛАХ БАЙРАНД БАЙРЛАХ ХОХИРОГЧТОЙ АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ ҮНДСЭН УХАГДАХУУНУУД**

Хамгаалах байранд байрлагчдад тохиромжтой байдлаар үзүүлэх халамж, интевенийн зохистой эсэхийг баталгаажуулахад хамгаалах байрны ажилтнууд ХХГХ-ийн үзэгдлийг ойлгох, ХХГХ-ийн орт нөлөө, үйлчилгээг хамтран үзүүлэх үйлчилгээний талаар зохих ойлголттой байх ёстой. Хамгаалах байрны ажилтнууд нь ХХГХ болон ХХГХ-ийн процессийн талаар сайн мэдэх шаардлагатай. Энэ гарын авлагад дурьдсан гол зарчмуудад ХХГХ-ийн элементүүд болон ХХГХ-ийн процесс, мөн сэтгэлзүйн, сэтгэл хөдлөлийн, болоод биеийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн талаар өгүүлсэн тул энд дахин давтахгүй. Хамгаалах байрны бүх ажилтнууд энэ гарын авлагыг сайтар уншиж танилцан удирдламжуутдай танилцах нь зүйтэй.

#### **Үндсэн ухагдахуунууд - ажилтнуудын хандлага, зан үйл**

Хамгаалах байрны ажилтнууд ХХГХ-ийн хохирогчдод хэрхэн хандах болон ямар зан шил гаргах нь тэдний эргэн нийгэмшүүлэх, нийгэмд эргэн орох процесс, нөхөн сэргээлтэд маг чухал. Хамгаалах байрны ажилтнууд ХХГХ-ийн хохирогчдтой харьцахдаа дараах зүйлсийг санаж байх нь зүйтэй:

- **Хүлээн зөвшөөрөх.** Энэ нь байрлагчдад дотно таатай хандана гэсэн үг. Үүнийг жинэхээсээ сэтгэл зовинох, өрөвдөн сонсох, хатуу ширүүнээр хариулахгүй, бие биенээ хүндэтгэсэн уур амьсгал бий болгох. Хохирогч өөрийгөө буруутгагдаж айна гэж ойлгохгүй байх нь хамгийн чухал.
- **Хувь хүнийг нь батламжлах.** Ажилтнууд байрлагч болгоныг хувь хүний хувьд бусдаас онцгой гэдгийг хүлээн зөвгөөрөхийг хичээх хэрэгтэй. Байрлагчдад тэднийг ойлгож байгаа мөг анхаарал тавьж байгаа гэдгийг мэдрүүлэхийн тулд түүнд өөрийн хувтйгн мэдрэмж, бодол санаагаа илэрхийлэх боломж олгож болно.
- **Юманд бодитоор хандах.** Ажилтнууд нөхцөл байдлыг бодитоор үнэлэн, өөрийн хувийн бодлоо хамгаалах байрны байрлагчидтай ажил үүргийн журмаар бий болгосон харилцаандаа оролцуулахгүй.
- **Хохирогчийн идэвхийн түвшин.** Тухайн хохирогчийн биений болоод сэтгэл зүйн байдалд хөндлөнгөөс оролцоо байх хэрэгтэй. Энэ нь удаан хугацаагаар асуулт тавихаас зайлсхийх, хэлсэн зүйлд нь анхаарал их тавих, эсвэл хамгаалах байранд байрлагч өөр нэг хохирогчийн хэлсэн болон хэлээгүй зүйлд огт анхаарахгүй байх.
- **Сэтгэл санаа хөдлөхийг хянах.** Ажилтнууд илэрхийлэгдсэн болон илэрхийлэгдээгүй мэдрэмжүүдэд анхааралтай хандах, хүний зан байдалд үндэслэн ойлгож байгаа эсэхээ үзүүлж, түүнийхээ нэгэн адилаар мөн хүндэтгэж байгаагаа үзүүлэх хэрэгтэй. Хамгаалах байрны ажилтнууд хуутэн хөндий эсвэл огт анхаарал хандуулалгүй хандаж болохгүй. Гэхдээ тэд хохирогчтой хэтэрхий дотно харилцаанд орж эсвэл сэтгэл санааны хувь маш ихээр татагдан орж болохгүй.

Хамгаалах байрны ажилтнууд маш мэдрэмтгий, хэнийг ч буруутгасан байдалгүй байх хэрэгтэй. Хохирогчтой хамгаалах байранд уулзах үед үгэн болон үгэн бус байдлаар хамгаалах байранд байрлах хохирогчид түүнийг өрөвдөж байгаагаа илүү тодорхой ойлгуулж болно. Хамгаалах байранд байрласан хохирогчтой ажиллах арга техникээс:

- Тухайн хүний хувь хүний кейсэнд анхаарах;
- Анхааралтай сонсох;
- Хүнлэг, хүндэтгэсэн байдлаар хариулах;

- Тайван, анхааралтай, сэтгэл зовисон, хүнлэг байх;
- Хянах, даргалах хандлагаас зайлсхийх;
- Боломжтой бол шийдвэр гаргах эрх санал болгох;
- ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг системийг тайлбарлах;
- ХХГХ-ийн хохирогчдод хүрэлцэхүйц нөөцийг мэдэх;
- Тухайн хүний хэрэгцээн хангахад уян хатан байх;
- Хохирогчид шаардлагатай нөхцөлд нэмэлт тусламж, дэмжлэг авах.

ХХГХ-ийн хохирогчтой үр дүнтэй ажиллах арга барил бий болгох үүднээс хамгаалах байрны ажилтан хохирогчтой сэтгэл зүйн болон биеийн байдал, нөхцөл байдал, сонирхолд нийцсэн хөндлөнгөөс оролцох аргачлалыг хөгжүүлэх.

#### **4.5.2 ХАМГААЛАХ БАЙРАНД ХҮРЭЛЦЭН ИРЭХ**

Хамгаалах байранд хохирогч ирэхэд урьдчилан бэлтгэгдсэн байх нь тохиromжтой. Ихэнх тохиолдолд хамгаалах байрны иенежер шинээр байрлагч хохирогч ирэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулдаг ч зарим тохиолдолд энэ үүргийг өөр хүнд даатгаж болно (хохирогчтой Ярилцлага хийх талаарх сайн туршлагыг энэ номын Хавсралт 1-ээс үзнэ үү: ХХГХ-ийн хохирогчтой ярилцлага хийх, халамж үзүүлэхэд баирмлах Ёс зүйн зарчмууд. Мөн 5-р бүлэг, 5.12.2 хэсгээс ХХГХ-т өртсөн хүмүүст сэтгээцийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх талаар дэлгэрэнгүй үзнэ үү).

#### **4.5.3 ЭХНИЙ УУЛЗАЛТ ЯВУУЛАХ ХҮНИЙ ТОДОРХОЙЛОХ**

Хохирогч хамгаалах байранд ирэхэд эхний уулзалт хийх хүнийг хамгаалах байрны менежер тосно. Зарим хамгаалах байруудад менежер нь өөрөө эхний уулзалтыг хийдэг бөгөөд заримд нь хамгаалах байрны сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтан нь энэ уулзалтыг хийдэг.

Эхний уулзалтыг хийж байгаа хэн боловч дараах мэргэжил чадвартай байх ёстой:

- Харьцаа тогтоох чадвар, чадавхи;
- Хэрвээ шаардлагатай бол хэлний мэдлэг;
- Сэтгэл зүйн чадавхи, хохирогч сэтгэл зүйн хүнд асуудлалтай байдаг;
- Хүүхэдтэй харьцах мэргэжлийн чадвар, хэрвээ хүүхэд хохирогчтой харьцах хэрэгцээ гарвал.

Хамгийн тохиромжтой нь ХХГХ-ийн хүүхэд хохирогчтой ярилцлага хийх хүн нь хохирогч хүүхдийн зан үйл, сэтгэлзүй, сэтгэлийн хөдлөлийн болоод биеийн хөгжлийн талаар тусгайлан сургагдсан мэргэжлийн хүн ёстай. Хэрвээ боломжтой бол тэрхүү мэргэжлийн хүн нь хүүхдийн ижил яс үндэстэн, эсвэл соёл зан заншилтай нь ижил эсвэл төсөөтэй байж ижил хэлээр ярьдаг байвал бүр сайн. Хохирогчтой хамгийн эхлээд уулзаж ярилцах хүн хүүхдийн байрлах хамгаалах байранд ажилладаг хүн биш байвал тохиромжтой. Яагаад гэвэл эхний уулзалт нь тухайн уулзалтыг хийж буй хүнээс анхаарал төвлөрлийг дээд зэргээр шаардах тул хамгаалах байрны бусад байрлагчдад анхаарал тавих ёстай өөр нэг хүн байх тохиромжтой.

#### 4.5.4 УУЛЗАЛТЫН ЦАГ, ОРЧИН

Ихэнх тохиолдолд хамгаалах байрны менежер хэдний өдөр хэдэн цагт хохирогч тухайн хамгаалах байранд ирэхийг мэдэж зохицуулан товлодог. Уулзалтанд оролцох ажилтан наад зах нь нэг бутэн цагийг тухайн уулзалтанд зарцуулна гэж төлөвлөх хэрэгтэй. Тийм учраас хохирогчийн ирэх хугацааг ажилтны ээлж дуусах үетэй дахвцуулахгүй байна уу хэмээн зөвлөмөөр байна. Ерөнхийдөө хамгаалах байрны ажилтан нь нэг зэрэг нэгээс дээш хохирогчтой уулзалт явуулахгүй байхыг хичээх хэрэгтэй. Хэрвээ хамгаалах байр нь нэг дор хэдэн хохирогчийг хүлээн авах чадвартай бол шинээр ирэгч хохирогчтой уулзалт хийх нэмэлт ажилтан байх шаардлагатай. Хэрвээ эхний уулзалтанд хохирогчтой хэл нэвтрэлцэхгүй бол тухайн уулзалтыг орчуулагч байх үест хийх шаардлагатай. Хамгаалах байр болгон хандуулдах талаар тогтсон бодлоготой мөн хандуулах түншүүд хамгаалах байранд ирдэг тогтсон цагтай байх ёстай. Хэрвээ боломжтой бол хамгаалах байр нь ажлын цагийг шинэчлэхгүй байсан дээр /хэвийн хувиараар явагдах боломжгүй яаралтай

тохиолдлоос бусад тохиолдолд/ Хамгаалах байр болгон шинээр ирж буй хүнийг тохиромжтой цагт хүлээн авах, түүнийтлаар энхий мэдээллийг оруулах, хохирогчтой эхлээд уулзах болон шаардлагтай тохиолдолд нэмэлт үйлчилгээ үзүүлэх хүнийг тодорхойлох талаар зохицуулах өөрийн бодлоготой байх ёстай.

#### **4.5.5 ЭХНИЙ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ**

Эхний уулзалт нь хамгаалах байранд нууцлал бүхий бөгөөд хувь хүний нууцын талаар хэлэлцэж болох газар явагдах ёстай. Ярилцлага явагдах өрөө нь цэлгэр, гэрэлтүүлэг сайтай, тохилог тавилга бүхий хүн орохооргуй хаалттай өрөө байх. Хамгийн тохиромжтой нь хамгаалах байрны наанадаж нэг өрөөг хувийн, нууцлал бүхий ярилцлага хийхэд тохиромжтой, хэдийд ч бэлэн байхаар байлгах ёстай. Хохирогчтой хийх эхний ярилцлага хувь хүний нууцыг агуулсан бөгөөд маш нарийн зүйлсийг агуулсан нууцлаг байх учраас хамгаалах байрны бусад ажилтнууд эсвэл бусад байрлагч нар сонсохооргуй байх ёстай. Тийм учраас энэ өрөөг хамгаалах байранд хүний хөлөөс зайдуу байрлалтай байхаар тохижуулах хэрэгтэй. Хэрвээ боломжтой бол эхний ярилцлага хамгаалах байр ажилтны оффист явагдахгүй байвал зүгээр. Ярилцлага явуулж буй ажилтан тухайн ярилцлагагад хэн нэгэн санаандгүй байдлаар садаа болох бүхий эрсдлийг тооцон бусад ажилтнууд, утас зэргээс хол байхад анхаарал тавих хэрэгтэй. Мөн өөр байрлагч тухайн өрөөнд байхыг зөвшөөрөх ёсгүй.

#### **4.5.6 ЭХНИЙ УУЛЗАЛТЫН ЗОРИЛГО**

Хамгаалах байранд буй хохирогчтой хийх эхний уулзалтад баримтлах 4 зүйлс байдаг.

- Холбоо тогтоох
- Аюулгүй байдлыг баталгаажуулах
- Хохирогчид хамгаалах байрны талаарх мэдээлэл болон хаана юу байдаг баримжааг тайлбарлах
- Хохирогчоос үзүүлэх үндсэн үйлчилгээ болон хувь хүнд зориулсан үйлчилгээний үйлчилгээний төлөвлөгөөг гаргахад шаардлагатай мэдээллийг авах

## Холбоо тогтоох

Хамгаалах байранд ирсэн хохирогчтой хийх эхний ярилцлага нь хохирогч эхний холбоог хохирогчтой тогтооход оршино. Бүхий л тохиолдлуудад хохирогчтой эхлээд холбоо тогтоохын зорилго нь түүнд аюулгүй байдал болон туслалцаа үзүүлж түүний нөхөөн сэргээлтийг хийх хүмүүс байна гэдийг сайтар ойлгуулах явдал юм. Хамгаалах байрны ажилтан эхний ярилцлагыг хэрхэн явуулах нь тухайн ярилцагчийн ярилцлага хийх байдал, нөхцөл байдлын үнэлгээ, хохирогчийн байдал болон хариулах байдал зэргээс болон хохирогчийн талаарх урьдчилан авсан мэдээллийн хэмжээнээс хамаарна. Ихэнх тохиолдолд ярилцлага хийгч хүн хамгаалах байры үзүүлдэг үйлчилгээнүүдийг тайлбарлахаас өмнө эхлээд өөрийгөө дуудах нэрээрээ танилцуулна, албан тушаалаа тайлбарлаад, хамгаалах байранд ямар үүрэгтэй ажилладагаа хэлээд, хохирогчид ямар нэгэн зүйл хэрэгтэй эсэхийг лавлана (цай, ус г.м.). Ярилцлага явагдах явцад ярилцлага хийгч хүн хохирогчийн биеийн болон стэгэл санааны байдал, асуултанд хариулах байдал зэргийг анзаарч явна. ХХГХ хохирогчид ямар нөлөө үзүүлдэг талаар бичсэн энэ номны хэсгийг сайтар уншиж танилцан, түүний байдлыг мэдсэний үндсэн дээр жишээлбэл өрөвдөх байдал гарган хохирогчийн итгэлийг олж авахыг хичээхийн зэрэгцээгээр түүний өөрөө өөрийнхөө амьдралд хяналт тавьдаг, өөрийгөө мэддэг болохын төлөө гаргасан зоригийг мөн сайшаан, хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

## Хохирогчийн итгэлийг олох

Хамгийн эхний энэ үе шатанд хохирогчид биеийн болоод сэтгэл зүйн аюулгүй байдлыг итгүүлэх нь маг чухал. Нөхөн сэргээх процессийг амжилттай эхлүүлэх үүднээс хохирогчийн биеийн болоод сэтгэл зүйн аюулгүй байдлыг баталгаажуулах ёстай. Тийм учраас эхний ярилцлагыг хийж буй хүн хохирогчид хамгаалах байр нь түүнд байрлагчид болон ажиллагдчын хэрэгцээг хангахуйц бөгөөд аюулгүй газар гэдгийг батламжлах ёстай. Тэрхүү хэрэгцээнд гэмт этгээдүүд болон тэдний гар хөл бологдоос найдвартай хамгаалагдсан, биеийн болоонд сэтгэл зүйн аюулгүй, хамааралгүй, мөн хоол хүнс, үндсэн хэрэгцээ, эрүүл мэднийн үйлчилгээ болон бусад шаардлагтай хамгаалал үйлчилгээг оруулна. Эхний холбоо танилцах болон харилцаж

эхлэх үе болон дээр дурьдчан зүйлсийг батламжилсаны дараагаар хохирогчид хамгаалах байрны дүрэм болон хаана юу байдгийг тайлбарлах хэрэгтэй.

### **Хохирогчид хамгаалах байрны дүрэм болон хаана юу оршдог талаар тайлбарлах**

Хохирогчтой эхэлж холбоо тогтоох танилцах болон аюулгүйн болон бусад зүйлсийн талаар тайлбарлан батламжилсаны дараагаар эхний уулзатлын хоёр дахь хэсэг нь хохирогчид хамгаалах байр болон тэнд үзүүлэх үйлчилгээний тайлбарлах болно. Хамгаалах байрны хамгийн гол үүрэг нь хохирогчийн өөрөө өөрийгөө мэдэх, сонголт хийх, орчин тойрныхны талаар тодорхой ойлголтууд зэргийг агуулсан нөхөн сэргээх үйл явц байдаг тул дараах асуудлуудаар шинээр ирсэн хохирогч болгонтой ярилцах шаардлагатай.

- Хохирогчийн хамгаалах байранд байрлах эрх болон үүрэг
- Хохирогчийн зөвшөөрлийг харгалzan үзэх
- Боломжтой үйлчилгээ болон идэвхтэй оролцоо мөн шийдвэр гаргах зэрэг нь түүнд зориулан үйлчилгээний төлөвлөгөөг гаргахад шаардлагатай
- Хохирогчийн талаар мэдээлэл авч үйлчилгээ болон тухайн хүнд зориулсан үйлчилгээний талаар төлөвлөгөө гаргах үндсийг бий болгох.

#### **4.5.7 ХАМГААЛАХ БАЙРАНД БАЙРЛАГЧИДЫН ЭРХ, ҮҮРГҮҮД**

##### **Хамгаалах байранд байрлагчдын эрх**

Хохирогчид хамгаалах байранд байрлагчид бусад байрлагчид болон ажилтнууд хүндэтгэх ёстой тодорхой эрхтэй байдгийг тайлбарлах тэрхүү эрхийн талаар тайлбарласан танилцуулгыг ярилцлагын дараагаар өгөх боломж бий гэдгийг хэлэх. Зарим хохирогчид тэрхүү танилцуулга бүхий хавтсыг ярилцлагын эхэн үед авахыг хүсэж болох боловч энэ нь хохирогчийн анхаарлыг ярилцлагын дараагийн хэсгээс бүр мөсөн хөндийрүүлэх болно. Энэ шалтгааны улмаас бүхий бичиг танилцуулгыг ярилцлагын сүүлд өгөх нь тохиромжтой. Ярилцлагын үеэр шинээр ирсэн

хохирогчид түүний эрхийн талаарх зөвшөөрөл, нууцлагийн талаар болон өөрөө өөрийгөө тодорхойлох зэрэг ерөнхий ойлголтыг өгөх. Хамгаалах байранд хунд байрлуулах зөвшөөрлийн дагуу хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад амаар болон бичгээр зөвшөөрөл өгсөн байх бөгөөд түүний хувиуд хохирогчийн хамгаалах байрны хавтас болон кейсийн хавтаст хавсаргасан байна. Хэдий тийм боловч зөвшөөрөл өгөх эрхийн талаар бүрэн ойлгосон, мэдсэн гэдгийг баталгаажуулах үүднээс хохирогчоос өөрийнхөө үгээр аль боломжтой байдлаараа хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээг хүлээн авах асуудлыг зөвшөөрөх эрхийн талаар батламжлахыг хүсэх шаардлагатай. Хохирогчид мөн хамгаалах байрнаас үзүүлж буй үйлчилгээний талаарх эсвэл тодорхой байдлаар гомдоох үйлдэл гаргасан талаар ямарваа нэгэн гомдол гаргах, асуудлыг шийдэх үүднээс хамгаалах байрны ажилтнуудад түүн дотроо хамгаалах байрны менежертэй ганцаарчлан уулзаж болно гэдгийг мэдээлэх хэрэгтэй. Хамгаалах байранд байдрагчдын эрхийг хэвлэсэн байдлаар бэлтгэн хувийг байрлагчдын хэл дээр бэлтгэн тэдэнд танилцах боломжтой байлгах. Дараах нь байрдах хүмүүсийн эдлэх эрхийн жишээнүүд бөгөөд энэ бүлгийн Хавсралт 3-т мөн давтагдсан байгаа.

### Хамгаалах байранд байрлагчдын эрх

#### Хамгаалах байрны бүхий л байрлагчдад

- Хүндэтгэл болон ёс заншлын хэм хэмжээнд хандах
- Нууцлалтай байх эрхтэй
- Хувийн нууцтай байх эрхтэй
- Тэдэнд үзүүлэх үйлчилгээний зорилго, төлөвлөгөөг тодорхойлоход оролцох эрхтэй.
- Өөрсдөд нь бүрэн мэдээлэл хийсэн үндэс дээр үзүүлэх үйлчилгээг хүлээн авах эрхтэй
- Өөрийн ойлгох хэл дээр тэдэнд үзүүлэх үйлчилгээ болон үйлчилгээний зорилгыг мэдэх эрхтэй
- Өөрсдийнхөө тэмдэглэлд хүндэтгэх шалтгаан бүхий улмаас үзэж танилцах эрхтэй

Хэрвээ дээр дурдсан эрхүүдээс аль нэг нь зөрчигдсөн гэж үзэж болох аливаа үндэслэл бүхий шалтгааны улмаас эсвэл байрлагч түүнд гарч буй хандлага эсвэл үзүүлж буй үйлчилгээний талаар

гомдолтой бол хамгаалах байрны менежертэй ганцаарчлан уулзаж дээр дурхьдсан асуудлуудаар хэлэлцэх эрхтэй. Энэ шатанд тухайн нөхцөл байдал болон хохирогчийн кейс, нөхцөл байдлын талаар сэтгэл зүйлийн гаргасан санаанаас хамаараад ярилцагч хохирогчийн хууль ёсны эрхийг товч эргэн харж болно. Гэхдээ ихэнх тохиолдолд хуулийн эрхийн талаарх хэлэлцүүлэг нь хохирогч нэг хоног амарч, нөхөн сэргээгдэсэний дараа мөн хамгаалах байрны үйлчилгээний талаарх мэдээллийг хянан үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг ажилтнуудтай хэлэлцэсний дараагаар тэрхүү хуулийн эрхийн талаарх ярилцлагыг хохирогчтой хийж болно.

### **Хамгаалах байранд байрлагчдын х үлээх үүрэг**

Хамгаалах байранд байрлагчдад өөртөө болон хамгаалах байрны ажилтнууд мөн бусад байрлагчдын өмнө хүлээх үүрэгтэй гэдийг сайтар тайлбарлан ойлгуулах хэрэгтэй. Байрлагчдын хүлээх үүргийн хувийг шинээр ирсэн хүнд тэр даруйд нь өгөх бөгөөд уулзалт хийж буй хүнтэй хамтран түүнийг уншиж мэдэж авах ёстой. Энэ байдлаар хүн болгонд тэрхүү дүрмийн талаар тус тусад нь тайилбарлах шаардлагагүй болох бөгөөд уулзалт хийж буй хүн тэрхүү дүрмийн ерөнхий ойлголтыг шинээр ирсэн хүнд ойлгуулсан байна. Хамгаалах байрны дүрэмд оруулж болох заалтуудыг доор дурсдан байгаа.

### **Хамгаалах байрны ерөнхий дүрэм**

- Бусад байрлагчид болон албан үүргээ гүйцэтгэж буй ажилтнуудтай хүндэтгэлтэй, эелдэг харьцах
- хамгаалах байрны ажилтнуудын үүрэг болгосон дотоод болон бусад даалгаваруудыг хүссэн даруйд хийж гүйцэтгэх
- байрлагчид нь өөрсдийн унтдаг газрынхаа ариун цэвэр, эмх цэгцийг хариуцна
- хамгаалах байрны өмч, нөөцийг ариг гамтай хэрэглэх
- байрлагч нь хамгаалах байрны ажилтнанд хадгалуулахаар өгөөгүй өөрийн эд зүйлсээ өөрөө хариуцна
- хамгаалах байрны салхинд гарах, гэрэл унтраах зэрэг болон бусад хуваарийг зөрчихгүй байх
- хамгаалах байрнаас гарах тохиолдолд тухайн байрны ажилтнаас зөвшөөрөл заавал авсан байх

- эмч, сэтгэл зүйч болон хамгаалах байрны ажилтны өгсөн зөвлөгөөг зохих журмын дагуу хийх, эмийг жорын дагуу заасан цагт уух.
- бүх байрлагчид хувийн ариун цэврийг дээд зэргээр сахих
- хамгаалах байранд байрлагч чангаар хашгирах, чанга чимээ гаргах ёсгүй.
- хамгаалах байран дотор тамхи тахыг зөвшөөрөхгүй
- хамгаалах байрнаас бусад хэсгүүдэд (ажилтны өрөө, эрүүл мэндийн өрөө зэрэг) ажилтны зөвшөөрөлгүйгээр орохгүй байх.

Ерөнхий дүрмийг ХХГХ-ийн хохирогч хүүхдэд тэдний нас, хөгжилд тохируулан тайлбарлаж өгнө. Дараа зүйлс нь насанд хүрээгүйчүүдэд зориулсан дүрмийн жишээнүүд болно.

- Өөрөө өөртөө санаа тавих ба ариун цэврээ сахих
- Аж ахуйн ажилд туслалцаа үзүүлэх үүнд, ороо хураах, хувцас юмсаа цэгцтэй байлгах
- Бусдын эрх, тэдний өмч эдийг хүндэтгэх
- Бусад байрлагчид, ажилтнууд болон бусад хүмүүстэй хамтран ажиллах
- Хуваарийн дагуу заасан бүхий л үйл ажиллагаануудад оролцох.

Ерөнхий дүрмийг тайлбарласаны дараа шинээр байрлагч тэдгээр дүрмийн хуувийг тухайн хүний эх хэл дээр бэлтгэсэн байгаа бөгөөд түүний кейсийн хавтаст хавсаргасан мөн хамгаалах байранд хэвлэж тавьсан гэдгийг хэлэх. Ямар нэгэн шалтгааны улмаас хохирогч тухайн дурэмд гарын үсэг зураагүй бол эсвэл хамгаалах байранд гарын үсэг бүхий дүрмийн хувь байхгүй бол хохирогчоос турхүү дурэмд дахин гарын үсэг зурахыг эхний уулзалтын төгсгөлд хүсэх болно. (Хамгаалах байрны дүрмийн загваа Хавсралт 4-т энэ бүлгийн төгсгөлт байгаа)

### Хамгаалах байрны аюулгүйн дүрэм

Ерөнхий дүрмийн талаар ярилцаж дууссаны дараа ярилцлага хийгч хүн аюулгүй байдлын дүрмийн талаар ярилцана. Ярилцлага хийж буй хүн аюулгүй байдлын дүрмийн заалтыг тус бүрээр нь хохирогчтой ярилцах нь нэн чухал бөгөөд хохирогч

дүрмийг ойлгрсн мөн даган мөрдөхийг хүсч байгаа талаар баталгаажуулах. Дараах нь хохирогчид аюулгүй байдлын талаар тайлбарлаж өгөх хэрэгтэй дүрмийн жишээ болно.

- Хар тамхи, согтууруулах ундаа, зэвсэг, эсвэл өөр төрлийн ямар хууль бус худалдааны зүйлс хамгаалах байранд ямар ч тохиолдолд байлгахыг зөвшөөрөхгүй
- Гар утас эсвэл пейджерийг ямар ч тохиолдолд хамгаалах байранд байлгахыг зөвшөөрөхгүй. Эдгээр зүйлсийг хамгаалах байранд ирэхдээ ажилтнуудад өгөн хадгалуулаад тэндээс явахдаа буцаан авна.
- Үрьдчилан хэлээгүй эсвэл бүртгэгдээгүй тохиолдолд ямар хүнийг гаднаас уулзуулах журмаар оруулахгүй.
- Яаралтай эсвэл хамгаалах байрны менежерийн зөвлөлдсөний дагуу хамгаалах байрны ажилтан зөвшөөрсөн зөвшөөрлөөс бусад ямар ч тохиолдолд тухайн газар, орон болон олон улсын утасны яриаг зөвшөөрөхгүй.
- Хамгаалах байрны байршил тэнд байрлагч хүмүүс эсвэл тэнд ажиллагч хүмүүсийн талаар хэнд ч хэрж мэдэгдэхгүй байх.
- Хохиргчийн бүтэн нэр болон бусад хувийн мэдээллийг бусад байрлагчид болон ажилтнуудад мэдээлхэгүй байх.
- Хамгаалах байрны ажилтны мэдээлсэн аюулгүй байдлын дүрмийг гэр бүлийн гишүүн, бусад ойр дотны хүн, хамгаалах байрнаас гадна байдаг бусад хүмүүстэй цанадлан даган мөрдөх
- Хамгаалах байрнаас гадна байхдаа хамгаалах байрнаас гадна байх аливаа хөдөлгөөн болон харилцаа холбооны талаар хамгаалах байрны ажилтанд өгсөн зааварчилгааг чанадлан даган мөрдөх
- Аливаа сэжиг бүхий контакт эсвэл үйлдлийн талаар цаг тухайд нь хамгаалах байрны ажилтанд мэдээлж байх. Аюулгүй байдлын дүрмийг тайлбарлаж өгсөний дараа тухайн дүрмийг хохиргчийн эх хэл дээр бэлтгэн түүний кейсэнд хавсаргах мөн хувийг хамгаалах байранд тавих. Хэрвээ ямар нэгэн шалтгааны улмаас хохирогч аюулгүйн дүрэмд гарыг үсэг зураагүй эсвэл хамгаалах байранд түүний гарын үсэг бүхий дүрмийн хувь байхгүй бол ярилцлагын төгсөглд хохирогчоос аюулгүйн дүрэмд гарын үсэг дахин зурахыг хүсэх.

Хохирогч түүнд тайлбарласан дүрмийг сайтар ойлголоо гэж мөн түүнийг даган биелүүлнэ ярилцагч тооцвол хамгаалах байрнаас авч болох үйлчилгээ болон туслалцааны талаар тайлбарлаж өгнө.

#### **4.5.8 ХАМГААЛАХ БАЙРНААС ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

Эхний ярилцлагын үеэр хохирогчид өгөгдөх мэдээллийн агууламж, хэмжээг хохирогчийн түүнийг ойлгосон, хүлээн зөшөөрсөн болон даган мөрдөх асуудлыг батламжлахын тулд ОУШСБ-ын зүгээс тэрхүү үйлчилгээний талаарх ерөнхий ойлголтыг эхний уулзалтын үеэр өгч дараагийн өдрүүдэд гүнзгийрүүлсэн мэдээллийг өгөх нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Хохирогчид авч болох үйлчилгээний жагсаалт, зориулалтыг түүнд өгөх мэдээллийн хатсат байгаа бөгөөд дараагийн өдрүүдэд тэдгээрийн талаар хамгаалах байрны ажилтан илүү тайлбарлаж өгнө гэж хэлэх нь зүйтэй. Хохирогчийн ойлгох хэлээр бэлтгэгдсэгн үйлчилгээний жагсаалтыг мөн хамгаалах байранд тавих нь зүйтэй. Түүнд дараах зүйлсүүд орж болно.

- Гэрт нь тээвэрлэн хүргэж өгөх
- Хоол хүнс
- Үндсэн материал бүхий хавтас
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Зөвлөгөө
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Хууль зүйн мэдээлэл
- Мэргэжилтний үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд
- Дахин сэргээх үйл ажиллагаанууд.

Дамжин өнгөрүүлэгч болон хүлээн авагч улс дахь хамгаалах байр нь түр хугацаагаар оршин суух эрх хүсэмжлэхэд болон/эсвэл Өөрийн хүсэлтээр Туслалцаа буцах хөтөлбөрөөр дамжуулан туслалцаа үзүүлдэг. Буцаах хөтөлбөрүүд дараах байдлаар туслалцаа үзүүлдэг:

- Биеийн байцаалт болон аялалын бичиг баримт
- Гэрт нь хүргэж өгөх
- Очсон даруйдаа байрлах аюулгүй байр

- Дараагийн үйлчилгээ, эргэн нийгэмшүүлэх боломжийн талаарх хандуулалт. Эх оронд нь байх хамгаалах байранд явагддаг эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ нь туслалцаа болон мэдээллийг дараах байдлаар үзүүлэх болоцоотой.
- Гэр бүлийг нэгтгэх болон зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Биеийн байцаалт болон нийгмийн халамжийн бичиг баримт
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Сэтгэл зүйн үйлчилгээ болон сэтгэл заслын туслалцаа
- Хуулийн туслалцаа
- Боловсрол олгох, ажилд зуучлах туслалцаа
- Ажил олоход нь туслалцаа үзүүлэх
- Жижиг бизнес болон бичил зээлийн хөтөлбөрүүд
- ТББ түншүүд
- Эргэн нийгэмшүүлэлтийн мониторинг хийх

Бүлэг 3-ын 3.2-р хэсгээс Эргэн нийгэмшүүлэх туслалцааг боловсруулах болон хэрэгжүүлэх талаарх дэлгэрэнгүйг олж үзнэ үү.

#### 4.5.9 ХОХИРОГЧТОЙ ХИЙХ ДЭЛГЭРЭНГҮЙ ЯРИЛЦЛАГА

165

---

**ХХГХ-ийн хохирогчтой ярилцлага хийх эсвэл туслалцаа үзүүлэхээс өмнө үйлчилгээ үзүүлэгч бүх байгууллагууд энэ гарын авлагын Хавсралт 1 буюу ХХГХ-ийн хохирогчтой ярилцлага хийхдээ баримтлах ёс зүйн зарчмууд болон Хавсралт 2 буюу Ярилцлага хийх асуултын жагсаалтыг анхааралтай унших хэрэгтэй:**

---

Хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээний талаарх ерөнхий асуудлуудыг тайлбарлаж өгсөний дараагаар хохирогчтой илүү мэдээлэл авах үүднээс гүнзгийрүүлсэн ярилцлага хийгдэх болно.

Тус ярилцлагын эхний хэсэг нь:

- Хохирогчийн талаар бүх талын гүнзгийрүүлсэн мэдээлэл авах
- Хохирогчидод өөрт нь тохиолдсон зүйлсийн талаар сайтар ярих боломж олгох
- Хохирогчид нэн тэргүүнд шаардлагатай байгаа хэрэгцээт зүйлс болон тулгарч буй асуудлуудыг мэдэх.

## Хохирогчоос мэдээлэл авах

Хамгаалах байрны ажилтнуудад өгөгдсөн мэдээллийг илүү сайн гүйцээх болон тодруулах боломж олгох үүднээс ярилцлага хөтлөгч хохирогчоос шаардлагатай мэдээллийг авах. Үйл ажллагааны эхний энэхүү шатанд өгөгдөж мэдээлэл дэх аливаа утгын болон дэс дарааллын холимог, эсрэг тэсрэг байдлыг уг мэдээллийн хүнд мөн чанар, хязгаарлалыг ойлгон хүлээж авах хэрэгтэй. Хамгаалах байранд дөнгөж ирсэн хүний биеийн болон сэтгэл зүйн байдал тодорхой зарим нэгэн асуултанд хариулах чадвар болон хүслийг харгалзан авч үзэх шаардлагатай. Хохирогч ядарч туйлдсан, эргэлzsэн, учрыг сайтар ухаж амжаагүй, болон аиж эмээсэн, тодорхой зүйлсийг сайн санахгүй эсвэл дүрслэн хэлэхэд хүндрэлтэй байж болох.. Хэрвээ эдгээр шинжүүдээс илэрвэл ярилцлага хөтлөгч хүн өөрөө шийдэн ярилцлагыг үргэлжлүүлэх эсвэл хохирогч амарч, тайвширсаны дараагаар үргэлжлүүлэхээр хойшлуулах эсэхээ шийднэ.. Ярилцлага хөтлөгч хохирогч асуултанд яагаад хариулахгүй, хувийн мэдээллээ өгөхгүй байгаа шалтгааныг таамаглан мэдэх хэрэгтэй. Эдгээрт:

- Ичсэн болон сандарч мэгдсэн
- Цагдаагийн оролцооноос айсан
- Урд нь хууль хэрэгжүүлэгчидтэй таарч байсан гашуун туршлагатай.

Ярилцлага хөтлөгч хохирогчийг дараах байдлаар итгүүлэх тайвшруулж болно:

- Хохирогчид туслалцаа үзүүлж байгаагийн зорилгыг ойлгомжтой, ээлдэг байдлаар тайлбарлах
- Хохирогч аюулгүй, хамгаалалттай газарт байна гэж итгүүлэх
- Хохирогчид бүхий л мэдээллүүдийг чанадлан нууцлагдана гэж итгүүлэх

Хэрвээ эдгээр оролдлогууд амжилтгүй болбол ярилцлага хөтлөгч уян хатан байж ярилцлагыг тухайн өдрөө арай хожим хийхээр, магадгүй ямар нгэн туслалцаа үзүүлэгдсэний дараагаар эсвэл хамгаалах байрны сэтгэл зүйч эсвэл хамгаалах байрны менежер уулзсаны дараагаар хийхээр хойшлуулах.

## Хохирогчид болсон явдлын талаар өөрийн ойлголтоор ярих боломж олгох

Ярилцлага хөтлөгч хохирогчийг саяхан болсон үйл явдлын талаар илүү болон тодорхой мэдээлэл авах зорилгоор өөрөөр нь дүгнэн яриулах.. Түүнээс гадна хохирогчийн талаар илүү сайтар мэдэх боломжийг санал болгох, хохирогчид онцгой чухал эсвэл айdas төрүүлсэн явдал болон деталуудыг өөрөөр нь хувийн дүгнэлт хийлгэн яриулах. Түүхийг ярьж өгөх нь ярилцлага хийгчтэй ойр, сайн харилцаа тогтооход тус болох бөгөөд энэ нь хохирогч болон түүнтэй ярилцаж буй хүний хооронд холбоос үүсч цаашдын итгэлцэл, харилцаа холбооны үндэс болох учиртай.

Хохирогч өөрт нь тохиолдсон юмсын талаарх детал болгоныг ярих шаардлагатай гэх нь зөвлөмж гэхээсээ илүү зайлшгүй шаардлагатай зүйл юм. Деталийн хэмжээ нь хохирогч хамгаалах байранд ирэхээс өмнө асуулганд хариулсан too, хариулсан байдлаас бас хамаарна. Хохирогч өөрт тохиолдсон явдлаа өөрийнхөө үгээр ярих нь нэн чухал бөгөөд, үүнд туслах зорилгоор ярилцлага хөтлөгч дараах зүйлсийг хийж болно:

- Өөрт тохиолдсон, мэдэrsэн зүйлсээ ямар хүрээнд хэрхэн илэрхийлж байгааг ажиглах
- Хохирогчид өөрийг нь дэмжиж байгаа гэдгийг мэдрүүлэх
- Ямар нэгэн байдлаар түүнийг шүүсэн, сонжсон байдал үгүйгээр харьцах.

## Хохирогчийн хэрэгцээг тодорхойлох

### Нэн тэргүүнд шаардлагатай зүйлс

Хохирогчийн өөрийнх нь сонгосон түүнд тохиолдсон зүйлсүүдийн талаар чөлөөтэй ярилцсаны дараа ярилцлага хөтлөгч хохирогчид яаралтай шаардлагатай зүйлсийг тодруулж мөн яаралтай асуудлыг тодорхойлох ёстай. Ярилцлага хөтлөгч нь хохирогчийн асуудал чухал болохыг онцолж, үйлчилгээ болон санал болгож буй туслалцаа нь хохирогчийн хүсэлт, сонирхол, оролцооны дагуу боловсруулагдан, хэрэгжигдэх болно гэдгийг дахин тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Хохирогч өөрт хамгийн хэрэгтэй байгаа зүйлс, тулгарч буй ауудлуудаа илэрхийлсэн

бол ярилцлага хөтлөгч нь тэдгээр нь түүнд үнэхээр хэрэгцээтэй зүйлс болох талаар хохирогчоос дахин асууж, дахин хэлүүлэх байдлаар баталгаажуулна. Бусад тохиолдлуудад ярилцагч хохирогчийн байдлыг судлан түүнд хэрэгтэй зүйлсийг тодруулна. Ярилцагчийн туршлагын түвшин энэ үед хохирогчид туслалцаа болдог. Жишээлбэл дамжуулагч болон хүлээн авагч улсад байгаа хохирогчид гэмт этгээдүүдээс хол, аюулгүй байх, гэмт бүлэглэлүүдээс хамгаалах, гэрлүүгээ буцах асуудалд гол нь оршдог. Эх орондоо байгаа хохирогчид гэр булийнхэнтэй нь холбоо тогтоох, тэд хохирогчийг хүлээн авах дуртай байгаа эсэх, ХХГХ-т өртсөн талаар бусад хүмүүс мэдчих вий хэмээн айх мөн түүнчлэн эрүүл мэндийн асуудал байдаг. Хохирогчид хамгийн хэрэгтэй зүйлсийг тодруулсаны дараагаар ярилцагч хохирогчийн илэрхийлсэн асуудлуудыг лавлан баталгаажуулах нь чухал. Зарим тохиолдолд хохирогчийн хэлсэн хэрэгцээтэй гэх зүйлс нь логик холбоосгүй, эмх замбараагүй байдаг. Тийм тохиолдолд ярилцагч хохирогчийн хэлсэн зүйлсийг дахин баталгаажуулах явцдаа практик ач холбогдолтой зүйлсийг тодорхойлох шаардлагатай болдог.

### **Хямралын болон онцгой байдал бүхий үеүүдийг ялган ойлгох нь**

Хохирогчид нэн тэргүүн шаардлагатай зүйлсийг тодорхойлох явцад хямралын болон яаралтай үеүүдийг ялган ойлгох нь нэн чухал. Эдгээр нь хоёулаа нэн даруй бөгөөд анхаарал шаардсан зүйлс боловч нэн даруй нь яаралтай үед илүү тохиолддог гэнэтийн аюул эсвэл даруй эмчлүүлэх, үзүүлэх шаардлагатай эрүүл мэндийн байдал зэрэг нь хойшилтуулшгүй зүйлс юм.

### **Онцгой байдлыг биеийн ерөнхий цочролын илэрлүүдээс ялгах нь**

Ихэнх тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан, хамгаалах байрны менежер аливаа хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх хэрэгцээтэй эсэхийг шалган хэрэгцээтэй хүнд хамгаалах байранд байрлах үед нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх болно. Гэхдээ хамгаалах байрны ажилтнууд ХХГХ-ийн хохирогчид элбэг тохиолддог биеийн ерөнхий цочрооны талаар мөн тухайн хүнд эмнэлгийн яаралтай тусламж хэрэгцээтэй байгааг сайтар ялган мэддэг

байх шаардлагатай. ХХГХ-т өртсөн хохирогчийн биед гардаг ерөнхий цочрооны талаар энэ номны 5-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан байгаа. Ярилцлага хийгч хүн энэ талын шинж тэмдгүүдийг сайтар мэддэг байж шаардлагатай тэмдэглэгээг энхий уулзалтын хаваст тэмдэглэн үлдээх шаардлагатай. Хэрвээ тухайн хүнд эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай байгаа шинж тэмдэг илрэх аваас хамгаалах байрны эмчид эсвэл эмнэлгийн ажилтанд мэдэгдэн зөвлөгөө авна.

*Сэтгэл зүйн хямрал болон сэтгэл зүйн онцгой байдлыг хооронд нь яланг ойлгох*

Шинээр ирсэн хохирогч эмнэлгийн энгийн үйлчилгээ аваахаас урьдаж сэтгэл зүйн зөвлөгөө туслалцаа авах хэрэгтэй эсэх эсвэл сэтгэл зүйн болон биеийн яаралтай тусламж авах шаардлагатай байгаа эсэхийг тодорхойлохын тулд ярилцагч сэтгэл зүйн хямралыг сэтгэл зүйн онцгой байдлаас яланг ойлгодог байх шаардлагатай. Сэтгэл зүйн онцгой байдалтай байвал яаралтай тусламжийг үзүүлэх шаардлагатай.

**Хямрал:** хамгаалах байранд ирж буй ХХГХ-ийн хохирогч ихэнх нь сэтгэл зүйн хямралын байдалтай ирдэг үүнд: сэтгэл зүйн тэнцвэргүй байдлаас үүссэн стресс, энэ үед тэдэнд тохиолдсон хүндрэл, бэрхшээлийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх чадваргүй, эсвэл тэдэнд саяхан тохиолдсон зүйлсээс болоод хөдөлж чадахгүй болсон байдаг. Энэ байдал нь хэдэн өдрөөс хэдэн сар үргэлжилж болох бөгөөд энэ бүхий хугацаанд байнгын зөвлөгөө, халамж, дэмжлэг шаардлагатай байдаг. Энэ байдал маш ихээр аиж цочирдсон, эсвэл депресст орсон бөгөөд бүтэлгүйтэн муу юманд өртсөн сэтгэгдэл зэрэг нь хохирогчийг өдөр тутмын энгийн үйлдлүүдэд оролцох чадвар муутай эсвэл бүр ямар ч чадваргүй болгодог. Хямралыг интервалчлах нь дараагийн үнэлгээ, зөвлөгөө хохирогчийг нөхөн сэргээх бусад оролцоонуудыг түүнийг аль болох хурдан нөхөн сэргээн урд байсан хэвэнд нь оруулахад оршино.

**Онцгой байдал:** сэтгэл зүйн онцгой байдал нэн даруй арга хэмжээ авч оролцохгүй бол сөрөг үр дагавартай хурц нөхцөл байдал юм.

### Онцгой байдалд ямар зүйлс тооцогдох вэ?

- Амия хорлох эрсдэл - хохирогч өөртөө хор хохирол учруулах хүсэл илэрхийлэх эсвэл амия хорлохоор завдах
- Бусдад биений гэмтэл учруулах эрсдэл - хохирогч бусдад гэмтэл хохирол учруулах хүсэл илэрхийлэх эсвэл учруулахаар завдах
- Хохирогч бусдыг шүүх, бусдад хор хохирол учруулахаар байдал гаргах (хий дээмийрэх, оюун ухааны хомсдол, сэтгэцийн хямралын хурц илрэлүүд).

Хэрвээ дээр дурдсан зүйлсээс аль нэг илэрсэн, эсвэл тэдгээрийг байна гэх шалтгаан бүхий бол ярилцлага хөтлөгч хамгаалах байрны сэтгэл зүйчтэй, сэтгэл засалч, эмч болон/эсвэл хамгаалах байрны менежертэй нэн даруй зөвлөлдөнө. Дээр дурдсан сэтгэл зүйн онцгой тохиолдолд хэрхэн арга хэмжээ авах талаар энэ гарын авлагын 5-р бүлгийн, 5.12.2-т дэлгэрэнгүй заасан байгаа.

**Насанд хүрээгүй хүүхдийн тохиолдолд хууль эрхийн асран хамгаалагч эсвэл хүүхдийг хамгаалах бусад эрх бүхий хүмүүстэй яаралтай тусlamжийн талаар холбоо барих хэрэгтэй.**

Эхний ярилцлагын үеэр яаралтай туслалцаа үзүүлэх ямар нэгэн хэрэгцээ гараагүй бол эсвэл яаралтай тусlamжийг урд үзүүлчихсэн бол хохирогчтой ярилцлага хийж буй хүн хохирогчтой хийх ярилцлагын хөдөлмөрийн шатанд шилжих ёстой.

### 4.5.10 ЭХНИЙ УУЛЗАЛТЫГ ТӨГСГӨХ НЬ

Хохирогчтой хийх ярилцлагын хөдөлмөрийн шатанд ярилцлага хөтлөгч дараа зүйлсийг хийх ёстой.

- Хохирогчид мэдээллийн хавтсыг өгөх
- Хохирогчоос дүрэм болон бусад холбогдох бичгүүдэд гарын үсэг зуруулах
- Хохирогчид шаардлагатай дараагийн үе шатыг тодорхойлох

### Хамгаалах байрны мэдээлэл бүхий хавтас

Хамгаалах байранд байрлагчид бүгд хамгаалах байрны талаарх

мэдээлэл бүхий өөрийн ойлгож чадах хэл дээр бэлтгэсэн материалыг хүлээн авах ёстой. Тэрхүү хавтаст дараах зүйлс хавсрагдана:

- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаарх мэдээлэл
- Үзүүлэгдэх үйлчигээнүүдийн талаарх мэдээлэл
- Зөвшөөрлийн маягтын загвар
- Хамгаалах байрны дүрэм
- Аюулгүй байдлын дүрэм.

### **Хохирогчоор дүрэм болон зөвшөөрлийн маягтад гарын үсэг зуруулах**

Хохирогчид мэдээллийн хавтсыг олгосоны дараагаар ярилцагч дараах зүйлсэд хохирогчийн гарын үсгийг зуруулан авсан байна:

- Зөвшөөрлийн маягт
- Хамгаалах байрны ерөнхий дүрэм
- Хамгаалах байрны аюулгүй байдлын дүрэм

Хэрвээ хохирогч эдгээрт бичиг баримтанд гарын үсэг зурахаас татгалзвал ярилцлага хөтлөгч эдгээр бичиг баримт бүрт гарын үсэг зураагүй тохиолдолд тухайн хамгаалах байранд хэн ч байрлахыг зөвшөөрдөггүй тайлбарлах хэрэгтэй. Хохирогч тайлбар өгсөний дараагар мөн гарын үсэг зурахаас татгалзсан хэвээр байвал ярилцлага хөтлөгч тэрхүү татгалзсаны шалтгааныг олохыг хичээх хэрэгтэй. Хохирогчийн шалтгаан болон зорилгыг тогтоохын тулд хамгаалах байрны менежер болон сэтгэл зүйчийн туслалцааг авахыг зөвлөж байна. Хэрвээ тухайн хүн хамгаалах байранд байрлагуун улмаас тэдгээр бичигт гарын үсэг зурахаас татгалзсан бол хамгаалах байрны ажилтан тухайн эрэгтэйн/эмэгтэйн хүслийн эсрэг хамгаалах байранд байлгахын тулд хүчээр гарын үсэг зуруулах боломжгүй юм. Хамгаалах байр болгон хамгаалах байранд байрлахгүйгээр тэндээс туслалцаа, үйлчилгээ авахыг хүссэн хүмүүст өдрийн цагаар үйлчилгээ явуулах талаар зохих тогтсон бодлоготой байх ёстой. Тийм ч учраас хохирогчид туслалцаа үзүүлэх тэрхүү бодлого болон холбогдох нөхцөл байдлын талаарх мэдээллийг өгсөн байх шаардлагатай. Хэрвээ хохирогч хамгаалах байранд байрлахыг хүсэхгүй мөн байрлагч бус ч гэсэн тэндээс явуулах

үйлчилгээнээс хүртэхийг хүсэхгүй бол ярилцлага хөтлөгч хохирогчид өөр бусад тусlamжийн талаарх жагсаалтыг үзүүлэнэ, үүнд: түнш ТББ, Олон улсын төрийн байгууллагууд эсвэл төрийн албан тушаалтууд. Хэрвээ хохирогч дээр дурдсан үйлчилгээнээс нэг эсвэл хэдийг авахаар болбол хамгаалах байр эсвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллага холбогдох хандуулалтыг болон ххолбоо тогтоох ажлыг хийж өөрсдийн боломжийн хүрээнд тухайн хүнд туслалцаа үзүүлэх өөр боломжийг бодитой болгоно. Хохирогчийн кейс дэх хөдөлмөрийн байдал болон хандуулах ажлыг гүйцэтгэсэн талаарх оролдлогуудыг хохирогчийн кейсийн хаваст тэмдэглэнэ.

### **Хохирогчийн дараагийн үе шатыг тоймлох нь**

Мэдээллийн хавтсыг өгсөны дараа, шаардлагатай маягтууд дээр гарын үсэг зурсаны дараа хохирогчид дараагийн үе шат эхэлж байгааг хэлнэ. Тэдгээр нь хохирогчийн хүссэн тусlamжаас шалгаалах болно мөн хохирогч эх орондоо, дамжуулагч улсад эсвэл хүлээн авагч улсад байгаа зэргээс хамаарна.

### **Хохирогчийн асуултанд хариулах**

Мэдээллийн хавтсыг хохирогчид өгөөд мөн хохирогчийн асуусан асуултуудад тодорхой хариулт өгсөний дараагаар хамгаалах байрны талаарх аливаа асуултууд, хамгаалах байрны бодлогууд болон холбогдох үйлчилгээний талаар асуусан хохирогчийн асуултуудад аль болох тодорхой, дэлгэрэнгүй хариулна. Хэрвээ ярилцлага хөтлөгч тухайн асуултанд хэрхэн хариулах талаар эргэлзээтэй байгаа бол тэр асуултыг тэмдэглэж аваад хамгаалах байрны ажилнуудтай хэлэлцэн дараагаар нь хохирогчид хариултыг өгөх шаардлагатай.

### **4.5.11 ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ БОЛОН НӨХӨН СЭРГЭЭХ ЭХНИЙ ҮЕ**

Анхны уулзалтын дараа хохирогчид хамгаалах байрыг танилцуулан, үндсэн хэрэглээний зүйлсийг өгч (ариун цэврийн хэрэглэл, шаардлагатай тохиолдолд улирлын хувцас) унтах газрыг зааж өгнө. Хэрвээ боломжтой бол тухайн эрэгтэй/эмэгтэй өөрийнхөө зүйлсийг хийгээд хадгалчихаар түгжээтэй сав байвал

тун хэрэгтэй. Хохирогч өөрийн унтаж амрах газраа амрахаар эрт явж болно. Хамгаалах байрны ажилтан хэдийгээр хамгаалах байрыг ажиллуулах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах боловч шинээр ирсэн тэнд дасан, тэнд мөрдөгддөг хуваарийг дагах хүртэл хэдэн өдөр шаардлагатай байдаг. Урд өмнө нь хамгаалах байранд байрлаж, тодорхой цагийн хуваарийг дагаж үзээгүйн улмаас хохирогч шөнөдөө сэргүүн байж өдрийн цагаар унтаж болзошгүй. Цагийн хуваарийг огцом бусаар өөрчлөн, өдөртөө хамтран дасгал хийх нь байрлагчийг удалгүй цагийн хувиарыг дасгадаг. Ихэнх тохиолдуудад шинээр ирэгч өөр хүмүүстэй хамт нэг өрөөнд байрлана. Хэрвээ нэгээс дээш ор чөлөөтэй байвал шинээр ирэгч тэднээс сонгож болно. Хамгаалах байрны ажилтан бусад байрлагчидад шинээр өөр хүн нэмж ирж байгаа талаар хамгийн наад зах нь хэдэн цагийн өмнө хэлэх ёстой. Зарим хамгаалах байрны ажилтнууд бусад байрлагчийг шинээр ирж байгаа хүнд зориулан хийх бэлтгэлд оролцуулдаг нь тэд шинээр байрлагчид туслах сэтгэлийг бий болгох мөн хамтран байх нөхцлийг бий болгодог байна. Хэд хэдэн яс үндэстэн байгаа тохиолдолд нэг үндэстэнүүд нэг өрөөнд хамт байхыг илүүд үздэг. Гэхдээ ажилтнууд байрлагчид хамтдаа байж чадах эсэхийг бодолцон тэдгээр хүмүүс хамтдаа үнэхээр байж чадах, хоорондоо таармжтай байхаар бол хамтад нь байрлуулна. Хамгаалах байр хангалттай зйтай бол хүмүүсийг нэг нэгээр нь байрлуулж болох ч ХХГХ-ийн хохирогч ганцаар байхаас хэдүүлээ байвал илүү аюулгүй, тухтай санагддаг. Боломжтой бол ажилтнууд энэ талаар хохирогч өөрөө ямар бодолтой байгаа талар асуух шаардлагатай.

## 4.6 ХҮҮХДИЙН ТАЛААРХ ОНЦЛОГ АСУУДЛУУД

(насанд хүрээгүй хүүхдийг халамжлах болон ярилцлага хийх талаар энэ гарын авлагын 5-р бүлгийн, 5.6-аас үзнэ үү.

Боломжтой бол ХХГХ-ийн хохирогч хүүхдийг өөртэй нь ижил нас, хүйсийн хүмүүстэй байрлуулж насанд хүрэгчилтэй аль болох хамт байрлуулахгүй байх хэрэгтэй. Хамгаалах байрны ажилтнууд эмзэг байдалд байгаа хүүхэдтэй ажиллах, ялангуяа бэлгийн мөлжлэгт өртсөн хүүхэдтэй ажиллах талаар тусгайлан сургагдсан байх шаардлагатай. Хамгаалах байрны ажилтнууд дагалдах

хүнгүй, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, байрлуулах талаарх ОУ-ын стандартыг даган мөрдөнө. Бүхий л түвшинд хамгаалах байрны ажилтан хүүхэд бүрийн хамгийн сайн ссайхны төлөө нөхцөл байдлыг бүрдүүлэн ажиллана.

## 4.7 ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ТУСЛАМЖ

Хамгаалах байранд байрлаж буй хохирогчид 3-р бүлэг, 3.2.3-т заасан эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг хүсэж болно. Тэдгээр үйлчилгээг үзүүлэх боломжгүй хамгаалах байр хохирогчийг өөрийн байранд байрлуулахын зэрэгцээ үйлчилгээг өөр байгууллагаас авч болно. Дараах хэсэгт тэдгээр үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар дурдаагүй бөгөөд хамгаалах байрнаас үзүүлэдэг онцлог үйлчилгээ, тусlamжийг үзүүлсэн болно. Хамгаалах байранд байрлаж буй хүн болгонд тус тусад нь ямар үйлчилгээ үзүүлэх талаар үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна.

Хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээнүүдэд дараах орж болно:

- Зөвлөгөө
- Эрүүл мэндийн үйчилгээ
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Сэтгэл заслын үйлчилгээ
- Хуулийн туслалцаа;
- Нехэн сэргээх үйл ажиллагаанууд
- Нехэн сэргээх нэмэлт үйлчилгээнүүд (боловсрол, мэргэжил оргох сургалт, орлого бий болгох, ажилд оруулах, санхүүгийн туслалцаа)
- Биеийн байцаалт, аялалын бичиг баримт болон AVR туслалцаа
- Явахаас өмнөх туслалцаа

Эдгээр хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээнүүд болон тусlamжууд доор дэлгэрэнгүй тайлбарласан байгаа.

### 4.7.1 ЗӨВЛӨГӨӨ

Ганцаарчилсан болон булгээр зөвлөгөө өгөх үйлчилгээ хамгаалах байрны үзүүлж буй чухал үйлчилгээнүүдэд тооцогддог. Ганцаарчилсан зөвлөгөөний талаар 3-р бүлгийн 3.2.3.2 хэсгээс

олж уншина уу. 5-р бүлгийн 5.12.2-оос ХХГХ-ийн хохирогчид сэтгэлзүйн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан зөвлөгөөний талаар дэлгэрэнгүйт үзнэ үү. Үүнд нэмэлт болгоход олонх хамгаалах байрууд хохирогчдод байнгын бүлгийн зөвлөгөө болон боловсрол олгохсургалтуудыг зохион явуулдаг. Бүлгээр зөвлөгөө өгөхийн гол зорилго нь аюулгүй бөгөөд тэднийг дэмжсэн орчинд хувийн болоод бие хүний чадваруудаа хөгжүүлэх боломж олгож байгаа юм. Үүнд: тэд өөрсдийн мэдрэмжээ илүү үо дүнтэйгээр илэрхийлнэ. Бүлгийн хичээлд хохирогчдыг асуудлын талаар ярилцах болон хэрхэн шийдэх талаар ярилцахад суралцуулах, дэмжих юм. Эдгээр хичээлүүд нь хохирогчдод бусад хүмүүс адил хэцүү нөхцөлд байдалд ороод хэрхэн тэмцсэн талаар суралцсан, өөрсдөө мөн тэмцэх чадварыг бий болгоход оршино. Бүлгээр зөвлөгөө авах хичээлд зөвхөн сайн дурын үндсэн дээр оролцох бөгөөд хохирогчийн тодорхой зарим хэрэгцээ, нас, соёлд тулгуурласан байна.

### **Бүлгийн зөвлөгч (удирдагчийн үүрэг)**

Бүлгийн зөвлөх эсвэл удирдагчийн үүрэгт бүлэг дотор үр дүнтэй, бие биенээ хүндэтгэсэн харилцаа үүсгэхэд оршинр. Бүлгийн зөвлөх бүлэг дотор зарим тогтолцоог бий болгоно, жишээлбэл: хичээлийн нэр, зорилтыг танилцуулах, түүнчлэн оролцогчдод чиглүүлэх г.м. Тухайн эрэгтэй/эмэгтэй тухайн өдөр үзэх сэдвийг тэмдэглэн, урд нь үзсэн зүйлсийн талаар эргэн асууж, мөн шаардлагатай үед дэмжлэг үзүүлнэ. Гэхдээ хэн нэгэн хохирогчийн хувийн мэдээлэл агуулсан аливаа агуулга байж болохгүй бөгөөд хэрвээ тэдгээрийн талаар ярилцах шаардлагатай блд өөртэй нь ганцаарчлан уузлана.

### **Бүлгийн хичээлд үздэг сэдвүүд**

Бүлгийн хичээлийн сэдвүүд нь ХХГХ-ийн хохирогчид хамааралтай өргөн хүрээний асуудлуудыг багтааж болно. Зөвлөгчид аливаа сэдвийн талаар заахдаа хүнд мэдлэг олгох талаас нь хандана. Ихэнх хохирогч өөрсдийн биеийн болоод нийгмийн сайн айхны талаар эмүзэглэдэг тул дараах сэдвүүдээр хичээл орж болно:

- Гэр бүлийн харилцаа
- Өөрийгөө хүндэтгэх нь

- Депресс
- Айдас
- Стрессийг бууруулах
- Хоол хүнс
- Ариун цэвэр;
- БЗХВ болон ДОХ/ХДХВ.

#### 4.7.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛАМЖ/ҮЙЛЧИЛГЭЭ

Хохирогчийн биеийн болон сэтгэл зүйн эрүүл байдал нь тухайн эрэгтэйн/эмэгтэйн нөхөн сэргэхэд нэн чухал. Хамгаалах байр болгон ХХГХ-ийн хохирогчдод зориулсан тэндээ байнгын эсвэл хандуулдаг эсвэл хамгаалах байрны бус гадуур байх үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн үйчилгээний газартай байх Эмнэлгийн газрууд болон/эсвэл эмнэлгийн ажилтнууд хамгаалах байр болгонд ажиллах эсэх нь тухайн хамгаалах байрны нөөцөөс хамаарна. ОУШСБ-аас хохирогчдод хамгаалах байрны ажилтан биш, өөрийн эсвэл гадна байрлах эмнэлгийн үйлчилгээний ажилтантай хохирогчдод үйлчилгээ үзүүлэх талаар бичгээр байгуулсан гэрээний дагуу ажиллах ёстой гэж зөвлөж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ төрийн эсвэл хувийн аль байгууллагаар эсвэл ТББ-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг үйлчилгээ, халамжийн стандарт, нууцлал болон эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн талаар зөвшилцсөн асуудлуудыг оруулна. Хамгаалах байр болгоны байрлагч болгонд эхний уулзалтын үед болоод дараа дараагийн уулзатын үеэр эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх саналыг тавина. Хамгаалах байрны ажилтан даар зүйлсийг хохирогчийн ойлгомжтой хэлээр хэлж өгнө:

- Хамгаалах байрны мэдээллийн хавтаст байх эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээлэл
- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ эмчилгээ хийх байдал
- Шинжилгээнээс өмнөх болон дараах зөвлөгөө өгөх хичээлүүд БЗХӨ болон ДОХ/ХДХВ зэрэг
- Эмчилгээний хуваарь, эмчилгээний бүртгэл
- Хувь хүн бүрийн шинжилгээ болон хийлгэх эмчилгээний эрүүл мэндийн тэмдэглэгээ

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх талаарх онцгой удирдамжийг энэ гарын авлагын 5-р бүлгээс тодоруулна уу.

### 4.7.3 СЭТЛЭГ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ/ХАЛАМЖ

Хамгаалах байр болгон ХХГХ-ийн хохирогч шаардлагатай үед туслалцаа үзүүлэх сэтгэл зүйчийг өөрийн байран дээрээ, гаднаас дуудах эсвэл хамгаалах байрнаас сгадуур байрлах мэргэжилтнээс туслалцаа авах байдлаар зохицуулна. Хамгаалах байр өөрийн сэтгэл зүйчтэй байх эсэх асуудал нь тухайн хамгаалах байрны нөөц, хэрэгцээнээс хамаарна. ОУШСБ-аас хохирогчдод хамгаалах байрны ажилтан биш, өөрийн эсвэл гадна байрлах сэтгэл зүйчтэй хохирогчдод үйлчилгээ үзүүлэх талаар бичгээр байгуулсан гэрээнтй дагуу ажиллах ёстой гэж зөвлөж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ төрийн эсвэл хувийн аль байгууллагаар эсвэл ТББ-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг үйлчилгээ, халамжийн стандарт, нууцлал болон эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн талаар зөвшилцсөн асуудлуудыг оруулна. Хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх талаар шаардлагатай туршлага бүхий, цочролд орсон болон эмзэг байдалтай хүүхдэд туслалцаа үзүүлэх талаар мэргэшсэн хүн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. 5-р бүлгийн 5.12.2-оос ХХГХ-ийн хохирогчид сэтгэлзүйн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан зөвлөгөөний талаар дэлгэрэнгүйг үзнэ үү.

### 4.7.4 СЭТГЭЛ ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ (ХАЛАМЖ)

Шаардлагатай тохиолдолд ХХГХ-ийн хохирогчдод сэтгэл заслын туслалцаа үзүүлэхээр хандуулах эсвэл үзүүлэх болоцоотой байх талаар өөрийн бодлоготой байх ёстой. Хамгаалах байр өөрийн сэтгэл засалчтай байх эсэх асуудал нь тухайн хамгаалах байрны нөөц, хэрэгцээнээс хамаарна. Эмч эсвэл сэтгэл зүйч хохирогчийг сэтгэл засалчид хандуулах асуудалын тухайн орон нутгийн туршлагаас хамаарна. ОУШСБ-аас хамгаалах байрууд өөрийн байран дээрээ эсвэл гадуур байрлах, стационарийн эсвэл амбулаторийн сэтгэл заслын үйлчилгээг хамгаалах байрны ажилтан бус хүнээр, түүнтэй үйлчилгээ үзүүлэх талаар бичгээр үйлдсэн гэрэний дагуу хохирогчид сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэхийг зөвлөж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ төрийн эсвэл хувийн аль байгууллагаар эсвэл ТББ-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг үйлчилгээ, үйлчилгээний стандарт, нууцлал болон сэтгэл заслын үйлчилгээний төлбөрийн талаар зөвшилцсөн

асуудлуудыг оруулна. Хүүхдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх талаар хамгаалах байрны ажилтнууд хүүхдийн асран хамгаалагч болон хүүхдийг хамгаалах эрхтэй бусад хүмүүстэй сэтлэг заслын зөвлөгөө болон эмчилгээний талаар зөвшилцнө. 5-р бүлгийн 5.12.2-оос ХХГХ-ийн хохирогчид сэтгэл зүйн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан зөвлөгөөний талаар дэлгэрэнгүйг үзнэ үү.

#### 4.7.5 ХУУЛИЙН ТУСЛАЛЦАА

Ихэнх тохиолдолд хуулийн зөвлөгөөг хамгаалах байранд явуулж болно. Хэрвээ хамгаалах байр өөрийн ажилтан хуульч байхгүй бол хуулийн үйлчилгээ үзүүлдэг хувийн, төрийн, ашгийн бус байгууллагатай энэ үйлчилгээг авах тохиролцож болно. Хамгаалах байрны ажилтнууд наад зах дараа мэдээллийг хохирогчийн ойлгох хэл дээр бэлтгэн байрлагчдад мэдээлэх хэрэгтэй:

- Хамгаалах байр байрлаж орон дахь ХХГХ-ийн хохирогчийн статус (хамгаалах байрны мэдээллийн хавтас)
- ХХГХ-ийн хохирогчдийн талаарх олон улсын стандарт (хамгаалах байрны мэдээллийн хавтас)

Насанд хүрээгүй хүүхдэд хуулийн туслалцаа үзүүлэхдээ хамгаалах байрны ажилтан насанд хүрээгүй хүүхдэд хуулийн тусгай заалтууд үйлчилдэг бөгөөд олон улсын стандартад заасан дагуу хуулийн туслалцаа авдаг болохыг санаж байх. Илүү нарийвчилан мэдээллийг 3-р бүлгийн, 3.2.3.4-р хэсгээс болон 6-р бүлгийн, 6.5-р хэсгээс үзнэ үү.

#### 4.7.6 НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Хамгаалах байрууд өдөр тутмын нөхөн сэргээх төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаанд оролцохыг хүссэн байрлагч болгонд бэлтгэнэ. Тэдгээр үйл ажиллагаанууд байрлагчдад дараах боломжуудыг өгдөг:

- Хамт байрлагчидтай хамтран ажиллах

- Уйдах байдалтай тэмцэж анхаарлаа бүтээн бий болгох, өөх сонголт бүхий ажилд төвлөрүүлэх
- Унтах цагаа зохицуулан идэвхтэй байдал, дасгал сургуулилт хийх
- үйл ажиллагаанд оролцох замаар чадавхи, өөрийн үнэлэмжээ дэшлүүлэх.

Нөхөн сэргээх үйл ажиллагаанууд дараах практик зорилгуудтай байж болно:

- Хоолны цэс бэлдэх (хоол хүнс)
- Дэлгүүрээс юм авах (төсөвлөх)
- Ширээ засах (nymбай байдал болон гаднах үзэмжээс бахархах сэтгэгдэл төрөх)
- Хоол хийх (хоол хүнс, гаднах үзэмжээс бахархах сэтгэгдэл төрөх, өөртөө болон бусдад анхаарал халамж тавих)
- Цэвэрлэгээ (гэр цэвэр байлгах).

Үүнд мөн биеийн хяналт, итгэлд нөлөөхөйц биеийн дасгалуудыг оруулж болно:

- Гимнастик
- Аэробик
- Ёог
- Бүлгээр спортоор хичээлэх.

Урлаг болон гар урлалын үйл ажиллагаанууд нь заслын (therapeutic) үйл ажиллагаанууд бөгөөд хүний чадавхийг нэмэгдүүлэх, байрлагчдад хүүхэд болон гэр бүлийнхэндээ бэлэг өгөх боломж олодог. Онцгой нөхөн сэргээх болон боловсролын хөтөлбөрийг хүүхэд, өсвөр насыханд өөрсдийнхөө нас, хөгжилд тохирсон зүйлд оролцох бололцоогоор хангахын тулд тэдэнд тусад зориулан боловсруулна.

#### **4.7.7 ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД**

Хамгаалах байранд байрлагчид тухайн хамгаалах байрнаас үзүүлдэг болон үзүүлдэггүй нэмэлт үйлчилгээнүүд шаардлагатай байж болно. Хамгаалах байрууд хохирогчийн хэрэгцээг

хангахын тулд ажиллах ёстой бөгөөд өөрийнхөө хамгаалах байрнаас үзүүлэх боломжгүй үйлчилгээг өөр байгууллагаас авах ёстой. Ийм үйлчилгээтэй адил үйлчилгээнд: боловсролын системд эргүүлэн оруулах, мэргэжил олгох сургалт, жижиг бизнес эрхлэхэд туслалцаа үзүүлэх, оролго бий болгох үйл ажиллагаанууд, ажилд оруулах, эсвэл санхүүгийн туслалцаа зэрэг багтана. Эдгээр дурдсан туслалцааг үзүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 3-р бүлгийн, 3.2.3-р хэсгээс үзнэ үү.

#### **4.7.8 ДАМЖУУЛАГЧ БОЛОН ХҮЛЭЭН АВАГЧ УЛСАД БАЙГААХ ХОХИРОГЧИЙН САЙН ДУРААР ЭХ ОРОНДОО БУЦАХАД ТУСЛАЛЦАА, БИЕИЙН БАЙЦААЛТ, АЯЛАЛЫ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛЭХ НЬ**

Ихэнх тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан хохирогчид шаардлагатай биеийн байцаалт, аялалын бичиг баримтыг бүрдүүлж өгөх, эргэн очсоны дараа үзүүлэгдэх туслалцаа асуудалд хариуцан ажилладаг. Энэ тохиолдолд хамгаалах байрны ажилтан үүрэг дараах байдлаар тодорхойлогдоно:

- Шаардлагатай процедурыг шаардлагатай хүнтэй холбох
- Холбогдох мэдээллийг хамгаалах байранд байрлагчаас асуун мэдэж авах
- Бичиг цаасны ажил ямар түвшинд явж байгааг блон хэзээ бэлэн болох хугацааг байрлагчид мэдээлэх,
- Хувь хүний кейсийн үйлчилгээний хөтөлбөр хамгаалах байранд байрлагчийн сайн байдал болон үйлчилгээ үзүүлэх хугацаатай таарч байгаа эсэхийг шалгах
- Явахаас өмнөх төлөвлөлт болон туслалцааг үзүүлэх, түүн тусмаа дараагийн байгууллагад зориулсан хандуулалтийг хийх.

#### **4.8 Кейсэд үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг боловсруулах**

Хамгаалах байрны ажилтан нь хохирогч болгонд тусад нь зориулсан кейсэд үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

Хохирогч эхлэж уулзсаны дараа ярилцлага хөтлөгч хамгаалах байрны менежер болон бусад холбогдох ажилтнуудтай уулzan туслалцаа үзүүлэх хамгийн тохиромжтой курсийн талаар хэлэлцэнэ. Хохирогчид зориулан бэлтгэх төлөвлөгөө нь хохирогч болгоны байдлаас, яаралтай хангах хэрэгцээ, хамгаалах байрны нөөц бололцоо, хамгаалах байранд байрлах хугацаа болон хохирогчийн өөрийнх зөвшөөрлөөс хамаарна. Үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөний урьдчилсан зөвлөгөөг хохирогчтой хамтран хэлэлцэх нь зүйтэй.

Хохирогчид туслалцаа үзүүлэх төлөвлөгөө болгонд дараах зүйлсүүд орох ёстай.

- Хохирогчид үзүүлсэн болон үзүүлэхээр зөвлөсөн туслалцааны баримтууд
- Хүнийг хүлээн авсан болон зөвшөөрсөн туслалцааны баримтууд
- Гарын үсэг зурж зөвшөөрсөн маягтууд
- Хохирогч хамгаалах байранд байх хугацаандаа хүрэхээр бэлдсэн зорилго, түүний хэрэгжилт
- Хохирогчийн зорилго болон кейсийн бүхий л амжилтын тэмдэглэгээ.
- Хохирогч өдөр тутам хүрсэн амжилтын тэмдэглэгээ
- Хохирогчийг явах үест хамгаалах байрнаас бүрдүүлэх бичиг баримт
- Хохирогч гэр булийн гишүүд болон найз нөхөдтэйгээ холбоо тогтоосон эсэх талаарх баримт
- Үргэлжлүүлэн явагдах халамж/үйлчилгээний талаарх хандуулалт, зөвлөгөөнүүд

Хүүхэд болон өсвөр насыханы кейсийн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг хүүхдийн асран хамгаалагч өсвэл хуулийн хамгаалагчтай зөвшилдсөний үндсэн дээр боловсруулагдана. Бүхий л тохиолдлуудад хүүхэд хохирогчийн хүсэл, үзэл бодлыг хүүхдийн нас, туршлагатай харьцуулан тусгах. Шийдвэр гаргах, олон туслалцаа тодорхойлох асуудалд хүүхдийн оролцоо тухайн хүүхдийн биеийн болон сэтгэл зүйн хөгжлөөс хамаарах болно. Хохирогчид тохиромжтой туслалцааны курс болон хүрсэн амжилтуудын талаар зөвхөн тухайн хохирогчтой ганцаарчлан уулзах үеэр яригдана.

## 4.9 Хамгаалах байрнаас явах

Ихэнх тохиолдолд хамгаалах байрны менежер байрлагчдыг хамгаалах байрнаас явах асуудлыг тохиромжтой бөгөөд аятай байдлаар явагдахыг хариуцах бөгөөд шаардлагатай процедурууд даган мөрдөгдсөн эсэхэд хяналт тавина. Үүнээс гадна хамгаалах байрны менежер эсвэл өөр ажилтан явах маягтыг бөглөнө. Маягтын загварыг Явах Процедурын Маягт, Хавсралт 4-т энэ бүлгийн эцэст байгаа.. Хамгаалах байранд байрласан байрлагчид тухайн хамгаалах байрны тохиромжтой эсэх болон үзүүлсэн үйлчилгээний талаар санаал ирэлхийлж болно. Түүнээс гадна байрлагчидтай ганцаарчилсан зөвлөгөө болон үйлчилгээ төлөвлөх хичээлийн үеэр үзүүлсэн үйлчилгээний талаарх санал бодлыг тэднийг явахын өмнө бичгээр авч болно. Энэ зорилгоор байрлагчдыг явахаас нэг, хоёр хоногийн өмнө асуулга бүхий асуумжийг өгч явах өдөр нь буцаан авч ажилтнуудын хурлын үеэр сар болгоны сүүлээр хэлэлцэж болно. Байрлагчийн Явах үед авах Асуумжийн асуулгыг Хавсралт 4-т энэ бүлгийн төгсгөлөөс авч болно.

## 4.10 Тайлангийн менежмент

Хамгаалах байр болгон бичгээр үйлдсэн хамгаалах байрны болон бүхий л ажилтнууд болон байрлагчдын мэдээлэл бүхий тайланг цуглуулах, хадгалах, ашиглах талаар бодлого, тусгай процедурууд болон удирдамжуудтай байх ёстой.

Хамгаалах байрны бүхий л тайлан үйлчилгээ үзүүлэгч байгууллагын аюулгүй процедур болон хувийн нууцыг цуглуулах, хадгалах, ашиглах болон задруулах үндэсний болон олон улсын урдирдамжийн дагуу үйлдэгдэх ёстой. Хохирогч болон ажилтны талаарх мэдээлэл хэрэгцээгүй болсон тохиолдолд бүхий л цаасан баримтууд хувь хүний тухай мэдээлэл агуулсан эсэхээс үл хамааран хайчлан эсвэл цаас устгагч машинаар устгагдах ёстой. (мэдээллийн аюулгүй байдлын мэдээллийг 1-р бүлгийн, 1.2 хэсэг болон 5-р бүлгийн 5.17-р хэсгүүдээс үзнэ үү)

### Тэмдэглэгээ

<sup>1</sup> С.Кахил-ээс нэгтгэсэн, “Туслах мэргэжилд тохиолдох шаталтын үеийн интервенц” А Туршлагын батлах баримт эргэн хянах,” Канадыг зөвлөн хянах сэтгүүл, 22:3. (1988).

## Хавсралт | Ажиллагсдын чанадлан биелүүлэх удирдамж

### ӨМНӨХ ҮГ

Энэ хэсэгт удирдамжийн зарчмууд эсвэл байгууллагын эрхэм зорилгыг агуулж болно. Үүнд мөн мэдэгдлийг ёс суртахууны зарчмын кодексийг тодорхой багцлан агуулж болох: үүндээ байгууллага өөрийн өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд, байгууллагынхаа нэр хүндийг унагаахгүй байхад ажилтнуудын биеэ авч явах байдал нэмэр хандив, ажилтнуудаас байгууллагын хүлээж буй гүйцэтгэлийн болон мэргэжлийн чадваруудыг тодорхой заан батламжилж болно.

### Гол үнэт зүйлс болон даган мөрдөх зарчмууд

Энэ хэсэгт байгууллага үнэнчээр даган мөрдөх үнэт зүйлсээ тодорхойлон зүйлчилж болно, жишээ нь: хүний жам ёсны эрхийг дээдлэх, нийгмийн шударга байдал, бүх хүний нэр хүнд болон үнэт зүйлс, заавал цогц байдлаар нь мөн энэ хэсэгт байгууллага өөрийн үнэт зүйлсээ, өөрийн итгэн дагадаг зүйлсээ тодорхойлж болно, жишээ нь: хүний жам ёсны эрхийг хүндэтгэх үүрэг, бүхий л хүмүүсийн үнэт зүйлс, нэр хүнд болон нийгмийн шударга байдал; бүхэллэг чанарыг заасан заалтууд; бүхий л үйл ажиллагаандаа үнэнч, шударга байдлыг эрхэмлэх, тэвчээртэй байж бүхий л тал дээр ойлгож хүндэтгэж харьцах, яс үндэс, хүйс, шашин шүтлэг, арьсны өнгө, үндэсний гарал үүсэл, гэр бүлийн байдал, бэлгийн чиг хандлага, нас, биеийн хөгжлийн бэрхшээл эсвэл улс төрийн үзэл бодлоор ялгаварлахгүй байх болон/эсвэл байгууллагын эх үүсвэр юмсыг хэрэгцээний хэрээр гэхдээ хямгатай зарцуулах гэсэн.

### Стандартуудыг биелүүлэх нь

Энэ хэсэгт ажилтны биелүүлэх ёстой стандартуудыг оруулах.

### Ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх чөлөө

Энэ хэсэгт байгууллага ажилтнаа бүхий л хүмүүсийн тэгш байдал, үнэт зүйлс, болон нэр хүндийг хүндэтгэх, яс үндэс, хүйс, шашин шүтлэг, арьсны өнгө, үндэсний гарал үүсэл, гэр бүлийн байдал, бэлгийн чиг хандлага, нас, биеийн хөгжлийн бэрхшээл

Эсвэл улс төрийн үзэл бодлоор ялгаварлахгүй байх зэргийг даган мөрдөх гэж оруулж болно.

### **Дарамтаас ангид байх эрх чөлөө**

Энэ хэсэгт ажилтан ямар нэгэн байдлаарх дарамт гаргахгүй байх болон байгууллага өөрөө дарамтаас ангид орчин бий болгоно гэдгийг батламжилж болно. Бэлгийн болон жендер зэргийг оруулан аливаа ялгаварлан гадуурхалт болон дарамтыг ажлын байр, эсвэл ажилтай холбоотой газар биеэр болон амаар үйлдсэн тохиолдлыг хориглох. Ажилтнууд тэдэнд албан байдлаар олгогдож буй албан тушаалын эрх мэдлийг хувийн шалгааны улмаас өөрийн сайшаадаггүй ажилтанд хохирол учруулахаар ашиглаж болохгүй.

### **Жендерийн тэгш байдал**

Энэ хэсэгт байгууллага өөрөө эрэгтэй эмэгтэй хүмүүсийн жендерийн тэгш байдлыг хангаж, жендерийн тэгш бус байдлын саадыг давахад хандив оруулна гэж тэмдэглэх.

### **Сонирхлын зөрчилдөөн**

Ажиллагсад сонирхлын зөрчилдөөнд юуг ойлгож болохыг мэдээлж, сонирхлын зөрчилдөөн байх магадлалтай гэж үзвэл ямар арга хэмжээ авагдах ёстой талаар ойлгуулах. Тухайн эрэгтэй/эмэгтэй шууд болон шууд бус байдлаар эдийн засгийн сонирхолын улмаас аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд оролцсон бол дараагийн шат нь ямар байх талаар тодорхой зааж өгөх.

Энд мөн түүнчлэн нэг ажилтан ямар нэгэн үйл ажиллагааг явуулахаар, явуулахад саад болгохоор, эсвэл явуулахыг хойшуулахаар ямар нэгэн хувийн ашиг сонирхлын үүднээс өөр нэг ажилтанд эсвэл гуравдагч талд бэлэг өгөх, ашигтай байх санал тавих эсвэл эдгээрийг үйлдэхээр амлах байдал гаргах ёсгүй гэдгийг тодорхой зааж өгч болно. Эдгээртэй ижил байдлаар ажилтан нь ямар нэгэн үйл ажиллагааг явуулахаар, явуулахад саад болгохоор, эсвэл явуулахыг хойшуулахаар ямар нэгэн хувийн ашиг сонирхлын саналыг өөр нэг ажилтнаас эсвэл гуравдагч талаас хүлээн авах эсвэл дээрх үйлдэлд бэлэг,

ашигтай байх санал хүлээн авахаар үйлдэл хийх эсвэл хүлээн авах ёсгүй гэдгийг тодорхой зааж өгөх. Ажилтнууд нь өөрийн албан үүрэг болон мэдрэгийг хувийн ашиг, санхүүгийн болон бусад ашиг, эсвэл гуравдагч талд үүнд, гэр бүл, найз нөхөд болон дотно ханддаг нэг нэгэнд ашиг олуулах үүднээс ашиглаж блолхгүй гэдгийг урьдчилан сануулах.

### **Эд хөрөнгийг ашиглах**

Байгууллага энэ хэсгийг тухайн байгууллагын эд хөрөнгийг ашиглахтай холбогдуулсан аливаа дүрэмийг боловсруулахад ашиглаж болно.

### **Ажилтны-менежментийн харилцаа холбоо**

Энэ хэсгийг байгууллага аливаа менежментийн талаар тодруулга хийхэд ашиглаж болно. Ажилтны харилцааны асуудлууд, жишээлбэл бие биенээ хүндэтгэсэн орчин бий болгох, нийгэмлэг эсвэл холбоо байгуулах болон нийгэмлэг эсвэл холбоонд нэгдэх эрх болон тулгарч буй асуудлын талаар бүхий л ажилтнуудыг оролцуулсан, зөвлөлдсөн байхын ач холбогдолыг гаргана.

### **Хэвлэл мэдээллийнхэнтэй харьцах**

Энэ хэсэгт байгууллага хэвлэл мэдээллийнхэнтэй харьцах асуудлаар ямар ч дүрэм бий болгож болно. Үүнд: хэн байгууллагаа төлөөлж хэвлэл мэдээллийнхэнтэй харьцах, ямар төрлийн мэдээллийг өгч болох эсвэл болохгүй гэх зэрэг. Энэ хэсэгт мөн ХХГХ-ийн эсрэг хэвлэл мэдээллийнхэнтэй хэрхэн мэдээлэл өгөх харьцах талаар орж болно.

### **Мэдээллийг ашиглах болон хамгаалах**

Энэ хэсэгт байгууллага мэдээллийг хэрхэн түгээх талаар, нууцлал бүхий мэдээллийн талаарх удирдамжуудыг оруулж болох. Энэ хэсэгт ажилтнууд ХХГХ-ийн эсрэг үйл ажиллагаанс ашиг хуртэгсэдийн талаарх мэдээллийг нууцлах хариуцлага болон чухлын талаар оруулж болно.

## Аюулгүй байдал

Энэ хэсэгт заавал, ялангуяа, туслалцаа авч буй ХХГХ-ийн хохирогчид даган мөрдөх ёстай аюулгүй байдлын дүрэм, зохицуулалтыг оруулсан болно. Аюулгүй байдлын хамгааллын дүрмийн загваруудыг энэ гарын авлагын 4-р бүлэг, Хавсралт 2, 3, 4-т хавсаргасан болно.

## Ажилтны хувийн зан үйл

Байгууллага энэ хэсэгт өөрийн ажилтнуудын зан үйлийн талаарх аливаа хүлээлтээ оруулж болно. Энд үндэсний болон олон улсын жишээлбэл: хүнийг худалдаалахыг эсрэг аливаа хууль эсвэл хүний эрхийн стандартыг зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон талаарх сэжиг төрүүлэхээр хэний тухайд боловч нэтгэж оруулж болно.

## Гадуур ажил эрхлэлт болон үйл ажиллагаа

Энэ хэсэгт байгууллага өөрийн үйл ажиллагаанаас гадуур хийгдэж боло үйл ажиллагаа жишээлбэл багшлах, ярилцлагад оролцох, ном хэвлүүлэх эсвэл хэвлэлд өгүүлэг юм бичих зэрэг бусад үйл ажиллагаануудыг дурьдсаж болно.

## Гадна эх үүсвэрээс бэлэг, шагнал, хүндэтгэл хүлээн авах

Энэ хэсэгт байгууллага бэлэг, шагнал, хүндэтгэл хүлээн авсан бол тэдгээрийн талаар хэрхэн тайлангнах талаар өгүүлнэ.

## Хавсралт II Ажилтны нууцын хийх тухай гэрээ

Би хамгаалах байр, түүнд байрлагчдын болон ажиллагсадын аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хамгаалах байрны нууцыг хадгалахын чухалыг ойлгож байна. Байрлагчдын нууцыг чандлан хадгалахын чухалыг ойлгож байгаа бөгөөд хэрвээ яаралтай шаардлага гарсан үед байрлагч болон миний даргын зөвгөөрөлгүйгээр нууцыг задлахгүй байх ёстой.

Би хамгаалах байранд байрлагч, эсвэл хамгаалах байрны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийнхэнтэй энэ талаар ярилцахгүй, хэрвээ ярилцахаар болбол надаас дээгүүр албан тушаалтны ярилцлагын гол санаа, зорилго болон хязгаарлалтуудын талаар өгсөн зөвшөөрлийн дагуу ярилцлага хийнэ.

Би байрлагчийн талаар олон нийтийн газар ярихгүй. Хамгаалах байрны байрлалыг нууцлан хадгалана.

Хамгаалах байрны үйл ажиллагаа болон ажилтнуудын талаар олон нийтийн газар ярихгүй.

Нууцын талаарх аливаа асуулт болон хандлагуудыг өөрийн шууд ахлах албан тушаалтанд дамжуулна.

Би нууцыг санаатай алдагдуулсан тохиолдолд надад сахилгын дотроо ажил үүргээс түр түдгэлзүүлэхээс эхлээд ажлаас халагдах хүртэл арга хэмжээ авагдана гэдгийг ойлгож байна.

### Хавсралт III Хамгаалах байранд байрлагчдын эрх

Хамгаалах байранд байрлаж буй хэн боловч дараах эрхтэй байна.

- өөрийг нь хүндэтгэсэн, нэр хүндийг нь хамгаалсан байдлаар хандах
- чандлан нууцлах
- хувийн нууцыг хүндэтгэх
- үйлчилгээний зорилго, төлөвлөгөөг тодорхойлох боловсруулахад өөрөө өөрийгөө тодорхойлох
- тухайн хүний соёл занглыг хүндэтгэн харьцах
- үйлчилгээг бүрэн гүйцэд болон мэдээлэл бүхий хүлээн авах
- байрлагчид хэрэгцээтэй болон цаанаас заавал үзүүлэх үйлчилгээний зорилтыг өөрийн мэдэх хэл дээр тодорхой тайлбарлуулах
- хувийн мэдээлэлдээ тодорхой үндэслэл бүхий байдлаар хүрэлцэх (авах) боломж

Хэрвээ дээр дурьдсан зүйлсийн аль нэг зөрчигдсөн гэж итгэх шалтгаан байгаа бол асуудлыг шийдвэрлүүлэхээр хамгаалах байрны менежертэй уулзахаар шаардаж болно.

## Хавсралт IV Хамгаалах байны өрөнхий журам

- Бусад байрлачид болон ажилтнуудтай хүндэтгэж харьцах
- Хамгаалах байрны ажилтны ноогдуулсан байрандаа хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх
- Хамгаалах байранд өөрийн унтдаг газрыг цэвэр нямбай байлгах
- Хамгаалах байрны хөрөнгө нөөцийг хүндэтгэн зориулалтын дагуу ариг гамтай хэрэглэх
- Хамгаалах байр нь хамгаалах байрны ажилтанд хадгалуулахаар хүлээлгэн өгөөгүй аливаа хувийн зүйлсэд хариуцлага хүлээхгүй
- Хамгаалах байрны цагийн хуваарийг, түүн дотроо унтах болон салхинд гарах хуваарийг даган мөрдөх
- Хамгаалах байрнаас гарах болон орж ирэх тохиолдол бүрт холбогдох ажилтнаас зөвшөөрөл авсан байх
- Эмч, сэтгэл зүйч болон хамгаалах байрны ажилтны өгсөн зөвлөгөө, эмчилгээг даган хийх
- Эмийг заасан хугацаанд бичсэн тунгаах хэрэглэх
- Хамгаалах байранд байрлагч бүх хүмүүс хувийн ариун цэврийг чандлан сахих
- Хамгаалах байранд чангаар хашгирах болон чанга дуу чимээ гаргахгүй байх
- Хамгаалах байран дотор тамхи татахыг зөвшөөрөхгүй байх
- Ажилтны зөвшөөрөлгүйгээр орохыг хориглосон өрөөнүүдэд (ж. нь ажилтны оффис, эрүүл мэндийн үзлэгний өрөө г.м.)

Ерөнхий журам нь ХХГХ-ийн хохирогч хүүхдүүдэд тэдний нас болон бие гүйцсэн байдлаас хамааран мөрдөгдөх болно. Дараах насанд хүрээгүйчүүдэд журам мөрдөх чадавхийг тодорхойлоход зориулсан жишээнүүд юм:

- өөрийгөө аваад явж чадах болон ариун цэврээ сахиж чадах
- өөрийнхөө юмыг янзалж чадах (ороо засах болонх хураах г.м.)
- бусдыг эрхийг, өөрийнхөө эрхийг болон өөрийнхөө эд зүйлсд хүндэтгэж байгаагаа үзүүлэх болон
- бусад байрлагчид, хамгаалах байрны ажиллагсад болон бусадтай хамтарч чадах болон идэвхтэй байх чадвар
- хуваарилсан бүхий л үйл ажиллагаануудад оролцох болон анхаарал хандуулах

## Хавсралт V Хамгаалах байранд байрлаж байсан хүн гарах тохиолдолд хүлээх ажиллагсадын үүрэг хариуцлага

Ажилтны нэр:

Байрлагч:

Гарч буй он сар өдөр.

Энэ нь дараах ажилтан дараах процедурыг явуулсан гэсэн баталгаа болно

Аялалын процедур, түүний дараагийн шатны үйл ажиллагаануудыг явж буй байрлагчид сайтар тайлбарлан тухайн хүнээр явах асуудалтай холбоотой бүхий л шаардлагатай үе шатууд, процедурууд ойлгосон эсэхийг батламжлуулна.

Гарч буй хүн Хамгаалах байрнаас гарах маягтад гарын үсэг зурсан болон хувийг авсан

Гарч буй байрлагч хамгаалах байрны үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд асуулж бөглүүлж авдаг асуудлыг бөглөх санал тавигдсан.

Гарч буй байрлагч дараах бичиг баримтуудаг хүлээн авсан болно:

- “Аялал хийж чадна” гэсэн баримт
- Хувийн эрүүл мэнд болон эмчилгээний баримт
- Холбогдох кейсийн бичиг баримт (гарын үсэг зурсан маягт)
- Дараагийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох хаяг, мэдээлэл

Хамгаалах байранд байрдаж байх хугацаанд хамгаалалх байрны ажилтаны хадгаламжинд байсан хувийн бүхий л эд зүйлс болон мөнгөө буцаан авсан байдал

Гарч буй байрлагч бусад хувцас болон хувийн зүйлсээ авсан байдал

Гарч буй байрлагч хувцас болон гутал зэргийг гадаах цаг агаарт тохируулсан хүлээн авсан байдал

Гарч буй байрлагч хувийн хэрэгцээг нь хангахуйц аяны хэрэгсэлийг хүлээн авсан байдал

Гарч буй байрлагч хоол хүнсний зүйлс хүлээн авсан байдал

Гарч буй байрлагч хамгаалах байрны өмч болох зүйлийг буцаан өгсөн болох нь

## Хавсралт VI Хамгаалах байрнаас гарах үед авах асуулга

### БАЙРЛАГЧИЙН ЯВАХ ҮЕД АВАХ НЭРГҮЙ АСУУЛГА

Энэхүү асуулгын гол зорилго нь хамгаалах байр байлагч явах үед түүнээс хамгаалах байр нь бүх байрлагчдад хэрхэн хамгийн хэрэгцээтэй, сайн үйлчилгээ явуулж болох талаарх санаа бодол, төрсөн сэтгэгдэл, шинэ санаа болон санал зөвлөгөөг цуглуулахад оршино.

Энэхүү нэргүй санал асуулга нь тухайн сард цуглуулагдсан бусад асуулгуудтай хамт хадгалагдана. Сар болгоны сүүлээр ажилтнууд тухайн асуулгуудыг үзэж хамгаалах байрнаас үзүүлэж буй үйлчилгээнд оруулах шаардлагатай өөрчлөлтүүд, үнэлэлт болон ажиглалтын талаар хэлэлцэнэ. Дараах асуулганд хариулна уу.

Хамгаалах байранд тантай шударга, хүндэтгэх шалтгаан бүхий байдлаар харьцах байсан гэж санагдаж уу?

Байнга,  ихэхдээ,  ховорхон тохиолдолд,  хэзээ ч үгүй

Танд авч болох үйлчилгээний талаар ажилтан хэрэгцээтэй мэдээллийг өгсөн гэж танд бодогдж байна үү?

Байнга,  ихэхдээ,  ховорхон тохиолдолд,  хэзээ ч үгүй

Ажилтан таны кейсийн нөхцөл байдлын талаар шаардлагатай мэдээллийн өгсөн гэж танд санагдаж байна үү?

Байнга,  ихэхдээ,  ховорхон тохиолдолд,  хэзээ ч үгүй

Ажилтан таны хүсэл санаа, үзэл бодлыг тусган авч байсан гэж танд санагдаж байна уу?

Байнга,  ихэхдээ,  ховорхон тохиолдолд,  хэзээ ч үгүй

Хамгаалах байрнаас үзүүлж буй доор дурьдсан үйлчилгээний талаар танд ямар нэгэн санал байна уу?

- Хамгаалах байр/ байр
- Хоол хүнс
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Зөвлөгөө
- Хууль зүйн туслалцаа
- Дахин сэргээх/мэргэжил олгох/боловсрол олгох үйл ажиллагаанууд

Хамгаалах байрнаас үзүүлж буй үйлчилгээ таны сэтгэлд хүрч байна уу?

Хэрвээ та хамгаалах байранд ямар нэгэн өөрчлөлт хийгдээсэй гэж хүсэж байгаа бол тэр юу байх байсан бэ?

Хамгаалах байрны талаар танд өөр ямар санал хүсэлт байна вэ?





Хүн худалдах гэмт  
хэрэг ба эрүүл мэнд

# Бүлгийн агуулга

- 5.1 Оршил
- 5.2 Хүн худалдах гэмт хэрэг ба эрүүл мэндийн асуудлын хүрээ
- 5.3 Халамжийн үйлчилгээний ёс зүйн болон аюулгүйн зарчим
- 5.4 Хүн худалдах гэмт хэргийн (ХХГХ-ийн) хохирогчийг ойлгох нь:  
Халамжид нөлөөлөх асуудлууд
- 5.5 Ахнаараг хандуулах тусгай асуудлууд
  - 5.5.1 Уламжлалт ёс заншил
  - 5.5.2 Гэмтэл хохирол ба санамж
  - 5.5.3 Хүйс ба жендер
  - 5.5.4 Ялгаварлал ба эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэг
  - 5.5.5 Бэлгийн болон нөхөн үргжихүйн эрүүл мэнд
  - 5.5.6 Бэлгийн цөөнх
  - 5.5.7 ХХГХ-ийн хохирогч эмэгтэйчүүдийн хүүхэд
- 5.6 Хүүхэд ба өсвөр насынхан
  - 5.6.1 Худалдаалагдсан хүүхэд, өсвөр насынханд үзүүлэх туслалцаа
  - 5.6.2 Хүүхдийн өсөлт, хөгжил ба хүчирхийллийн үр дагавар
  - 5.6.3 Хүүхдэд ээлтэй орчин
- 5.7 ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх тусламжийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал
  - 5.7.1 Сэтгэцийн өвчлөл
  - 5.7.2 Хүн худалдах гэмт хэргийн хүрээн дэх сэтгэл зүйн хүчирхийлэл ба дарамт
  - 5.7.3 Сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодисын хэрэглээ болон хамаарал
  - 5.7.4 Үйлчилгээний байгууллагын халамжид байх үеийн стресс түүний шалтгаан
- 5.8 ДОХ ба ХДХВ
- 5.9 Хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж ба эрүүл мэнд - хууль эрх зүйн хүчин зүйл
- 5.10 Эмчлэгч - өвчтний харилцаа
- 5.11 ХХГХ-ийн төслүүдэд эрүүл мэндийн асуудлыг тусгах
- 5.12 ХХГХ-ийн үед үүсч болох нөхцөл байдалыг зохицуулахад мөрдөх ерөнхий зааварчилгаа
  - 5.12.1 Бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ)
  - 5.12.2 Сэтгэцийн эрүүл мэнд
  - 5.12.3 Эрүүл ахуй, ариун цэвэр
  - 5.12.4 Сүрьеэ
  - 5.12.5 Ажлын байрны эрүүл ахуй
  - 5.12.6 Вакцинжилтаар урьдчилан сэргийлэж болох өвчинүүд
  - 5.12.7 Хоол хүнс, осол гэмтэл, амны хөндийн эрүүл ахуй, архаг өвчин
- 5.13 ХХГХ-ийн хохирогчдын эрүүл мэндийг нөхөн сэргээх төлөвлөгөө
- 5.14 Хохирогчид туслалцаа үзүүлэх хөтөлбөр ба эрүүл мэндийн төлөвлөлт
- 5.15 Үйлчилгээний ажилтнууд ба эрүүл мэнд
  - 5.15.1 Стресс
  - 5.15.2 Халамжийн ажилтнуудад үзүүлэх туслалцаа, стрессийг сааруулах нь
  - 5.15.3 Бие махбодийн хямралыг сааруулах тусламж дэмжлэг
  - 5.15.4 Цусаар дамжих эмгэг ба хөдөлмөрийн нөхцөл
  - 5.15.5 Ажилтны сургалт

**5.16 Эрүүл мэндийн үйлчилгээ ба түншлэгч байгууллага**

**5.17 Эрүүл мэндийн мэдээлэл ба мэдээллийн системийн менежмент**

5.17.1 Эрүүл мэндийн мэдээлэл, мэдээллийн менежмент

5.17.2 Өвчтний хувийн хэргийн нууцлал, аюулгүй байдлыг хангах  
ерөнхий зарчмууд

5.17.3 Үйлчилгээ үзүүлэгчид ба мэдээллийн нууцлал

5.17.4 Хохирогч өөрийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл авах эрх

**Хавсралт I. Будапештийн тунхаглал**

**Хавсралт II. Сэтгэцийн эмчилгээ, тусламжийн барууны зарим арга барил**

## 5.1 Оршил

Саяхныг хүртэл хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг ихэвчлэн мэдээлэл солилцох, эрүүгийн болоод хууль эрх зүйн хамтын ажиллагаа, хохирогчдыг эх оронд нь буцаах, тэднийг эргэн нийгэмшихэд нь туслах үйлчилгээгээр хязгаарлан төсөөлж байсан билээ. Харин сүүлийн жилүүдэд хүн худалдаах гэмт хэрэг, хохирогчдын эрүүл мэндтэй холбоотой олон улсын эрх зүйн акт<sup>1</sup>, тунхаглал<sup>2</sup>, хийгдсэн судалгаанууд хүн худалдаах гэмт хэргийн эрүүл мэнд талд илүү анхаарал хандуулах болжээ. Эдгээр баримт бичгүүд хүн худалдах гэмт хэргийн хохирогч болон энэ хэрэгтэй холбоотой нэрвэгдсэн орон нутгийн иргэдийн хэрэгцээ, онцлогт тохирсон тусгай үйлчилгээ үзүүлэх жишиг стандартыг бий болгоход онцгой анхаарал хандуулсан байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч албадан хөдөлмөр эрхэлсэн, бэлгийн, болоод бусад хэлбэрээр ашиглагдсанаас үл хамааран эрүүл мэндтэй холбоотой асуудалтай байнга тулгарсан байдаг. Бусдын эрхшээлд орсон хүмүүс бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамтад өртдөгөөс гадна нөхцөл муутай орчинд амьдарч олон төрлийн өвчинд давхар нэрвэгддэг нь тухайн хүний бие махбодь, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцэд удаан хугацаанд муу нөлөө үзүүлдэг.<sup>3</sup>

Ийм учраас Будапештийн Тунхаглал (хавсралт 1)-д “хүн худалдаалах гэмт хэргийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулах ёстой” гэсэн байна. Нэн ялангуяа, энэ гэмт хэргийн хохирогчдод “цогц, тогтвортой бөгөөд тэдний нас, хүйс соёл, ёс заншлын онцлогт тохирсон эрүүл

мэндийн халамж хүртэх ёстай (...) хамгаалагдсан, халамж бүхий орчинд тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтнүүд энэхүү үйлчилгээг үзүүлнэ” гэжээ. Олон улсын шилжин суурьшлын байгууллагаас сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх жишиг стандартыг боловсруулан гаргасан юм.<sup>4</sup>

## ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас “эрүүл мэнд гэдэг нь бие махбодь, сэтгэл санааны болоод нийгмийн сайн сайхан байдлын цогц илэрхийлэл бөгөөд зөвхөн өвчлөл, эрүүл байх мэндийн асуудал биш юм гэсэн байна”. “Арьс өнгө, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, эдийн засгийн болоод нийгмийн нөхцөл байдалаас үл хамааран эрүүл мэндийн боломжит хамгийн дээд стандартыг эдлэх нь хүн бүрийн эдлэх суурь эрх” гэжээ.<sup>5</sup>

Хүний эрхийн тухай олон улсын хэд хэдэн бичиг баримтад эрүүл мэнд болон хүний эрхийн харилцан уялдааг тодотгосны гадна ХХГХ-ийн хохирогч эрүүл мэндийн наад захын үйлчилгээг боломжтой үедээ авах эрхийн талаар дурдсан.<sup>6,7,8,9</sup> НҮБ-аас 2000 онд баталсан Хүн худалдаалах гэмт хэргээс, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг өртөхөөс сэргийлэх, хязгаарлах, шийтгэх тухай Нэмэлт Протоколд хохирогчийн эрүүл мэндийн хохирол олон талтай (бие махбодь, сэтгэл зүй, нийгмийн) байдаг тул нөхөн сэргээх олон талт үйлчилгээ үзүүлэхийг санал болгосон байдаг.

Хохирогчид эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Холбогдох журам, дүрэм нь хувь хүний эрхийг бүрэн хамгаалж байгаа эсэхийг хянах ёстай төдийгүй ялгаварлан гадуурхахгүй байх тухай, олон улсын холбогдох хууль журмад заасан зарчмуудыг тусгасан байна.<sup>10</sup>

## ЭНЭХҮҮ БҮЛГИЙН ТОЙМ

Энэхүү бүлэг ХХГХ-ийн хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар өгүүлнэ. Эдгээр мэдээлэл нь эрүүл мэндийн салбарын дүрэм журам, урьд өмнө хийгдсэн судалгаа, хүн худалдах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгуулагуудын туршлага, үүнтэй төсөөтэй бүлгийн (цагаачид,

дүрвэгсэд, эмэгтэйчүүд, хүүхдийн эсэрэг хүчирхийлэл) эрүүл мэндийг хамгаалах стратеги зэрэгт тулгуурлагдсан болно.

Эрүүл мэнд хэмээх энэ бүлгийг энэхүү гарын авлагын бусад хэсгүүдтэй уялдуулан уншихыг зөвлөж байна.

## ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИШИГ СТАНДАРТ

Ихэнх улс орны хүн хүчний, зохион байгуулалт зохицуулалт болоод эд материалын наад захын боломж, бололцоо нь тухайн улс орны эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадлаас хавьгүй бага байдаг. Хамгийн үр дүнтэй шилдэг туршлага бол хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх шишиг стандартыг боловсруулах асуудал байдаг. Хүн худалдахын эсрэг асуудлаар ажилладаг байгууллагууд тухайн гэмт хэрэг гардаг улс орнуудын засгийн газартай хамтран хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх жишиг стандартыг боловсруулах чиглэлээр хамтран ажиллах боломжтой билээ.

### 5.2 Хүн худалдах гэмт хэрэг ба эрүүл мэндийн асуудлын хүрээ

Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний талаарх судалгаанаас харахад үйлчилгээг гурван үндсэн бүлэгт хувааж болохоор байна.<sup>11</sup> Үүнд:

- Хүн худалдах гэмт хэрэг үргэлжилж байх үеийн
- Эмзэг, гадуурхагдсан давхрагын
- Эрсдэл, хүчирхийлэл болон эрүүл мэндэд нөлөөлөх үр дагавар

## ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТУУД

Хохирогсодын эрүүл мэндтэй холбогдон гарах эрсдэл болоод эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах хэрэгцээг хүн худалдаалах гэмт хэргийн таван үе шатын дагуу тодорхойлж болох юм.<sup>12,13</sup> Үүнд:

- Явахын өмнөх үеийн
- Аялал тээвэрлэлт ба дамжин өнгөрөх үеийн
- Хүлээн авагч улсад байх үеийн
- Илрүүлэх, албадан гаргах болонгэмт хэргийн нотолгооны үеийн
- Буцаж ирэх, эргэж нийгэмших үеийн.

**Явахын өмнөх үе** гэдэг нь тухайн хүн хүн худалдаалах гэмт хэргийн золиос болох эхлэл үе юм. Энэ нь тухайн хүний ийм төрлийн гэмт хэрэгт өртөх эмзэг байдлал болдгийн гадна мөн явахын өмнөх биеийн болон сэтгэхүйн эрүүл мэндийн байдал нь хүн худалдах гэмт хэргийн туршид үргэлжилдэг. Худалдагдсан хүмүүс ихэнхдээ эрүүл мэндийн үйлчилгээ муутай орон нутгаас гаралтай, тухайн орон нутагт нь тэдний өвчнийг оношлох, эмчлэх боломж муутай, өвчин нь оношлогдож, эмчдэгдэж байгаагүй байх тохиолдол цөөнгүй гардаг. Тийм учраас хохирогсдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах халамжийн үйлчилгээг төлөвлөхдөө эрсдэлд өртөхөөс өмнө эрүүл мэндийн байдал нь ямар байдалтай байсныг тогтоож судлах нь чухал байдаг.

**Аялал, тээвэрлэлт ба дамжин өнгөрөх үе** гэдэг нь тухайн хүнийг элсүүлэх үеэс эхлээд тээвэрлэх, хүлээн авагч улсад хүргэх хүртэлх хугацааг хамардаг. Үүнийг мөн “анхны хохирол амсч эхлэх үе” ч гэдэг. Учир нь энэ үед хохирогч анх удаа түүнийг хуурч мэхэлснийг ойлгож мэддэг ба амь насанд нь аюул учирч, нөхцөл байдлыг хянах боломж маш бага буюу боломжгүй болсныг мэдэрч эхэлдэг. Мөн тээвэрлэлтийн аюултай горим, нууцаар хил нэвтрэх эрсдэл, баривчилгаа, аюул, занал зэрэгтэй нүүр тулахын зэрэгцээ хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн аюултай тулгардаг.

**Хүлээн авах газарт ирсэн үе** гэж тухайн хүнийг хүчирхийллэл, мөлжлөг, өрийн дарамтанд болон хүчирхийллийн бусад хэлбэрүүдийг хослуулан албадан ажил хийлгэх эн үеийг хэлнэ. Худалдаалагдсан хүн мөлжлөгөөс чөлөөлөгдхөөс өмнө эрүүл мэндийн болон бусад төрлийн тусlamж авах нь ховор байдаг. Зарим тохиолдолд тэд эрүүл мэндийн үйлчилгээний хомсдлоос шалтгаалан халдвэр, гэмтэл авч, өвчинд нэрвэгдэн хүндэрдэг.

Хэргийг илрүүлэх, албадан гаргах, нотолгоо бүрдүүлэлтийн

шатанд хохирогч эрүүгийн болоод цагаачлалын хуулийг зөрчсөн хэргээр цагдаа, цагаачлалын албанад мэдүүлэг өгч, өөрийг нь худалдсан гэмт хэрэгтэн, хүчээр хөдөлмөр эрхлүүлж буй ажил олгогч болон хүчирхилэгчийн эсрэг мэдүүлэг өгч мөрдөн байцаалт явулахад хамтран ажилладаг. Зарим саатуулах газрын дэглэм хэт хатуу байдаг нь хохирогчийн эрүүл мэндэд мөн муугаар нөлөөлдөг талтай. Үүнээс гадна энэ үед зөвхөн хүчиний байгууллагын албаны хүмүүстэй (баривчлагаа, мэдүүлэг, хэргийн нотолгоо) харьцдаг нь хохирогчийн сэтгэхүйд муугаар нөлөөлж сэтгэл зүйчийн тусламжтайгаар нөхөн сэргээхээс аргагүй байдалд ч хүргэдэг.

**Буцаж ирэх эргэн нийгэмших үе** гэдэг нь урт хугацааны, олон талт үйл явц бөгөөд хохирогч өөрийн улс орны эдийн засаг, соёл иргэншил, нийгэм, улс төрийн амьдралын идэвхтэй гишүүн болон нөхөн сэргээгдэх хүртэл үргэлжилнэ.<sup>14</sup> Хохирогч нөхцөл байдлаас оргон зайлж чадсан нь аяндаа нөхөн сэргээгдэх боломж той болчихлоо гэсэн үг биш юм. Хохирогчид ихэвчлэн айдас, түгшүүрийн улмаас тусгаарлагдмал, зан ааш нь түрэмгий, дээрэнгүй, өөрийгөө жигших, бусад хүмүүс түүнээс жигшиж байна гэсэн ойлголттой болж өөрт хэрэгтэй нөөцөөс хүртэх, тусламж үзүүлж буй хүмүүстэй харьцаж чадахгүй болдог төдийгүй хэт их тамхи татах, согтууруулах ундаа, хар тамхи хэрэглэх зэрэг сөрөг зан үйл автагдах нь бий.

Энэхүү сөрөг зан байдал нь хүн худалдах гэмт хэргээс хохирч доройтсон эрүүл мэндээ нөхөн сэргээх, гэр бүл, найз нөхөдтэйгээ эргэн нийгэмшиж дасан зохицоход муугаар нөлөөлдөг.

## ТУСГААРЛАГДМАЛ БОЛОН ЭМЗЭГ БАЙДЛЫН НӨЛӨӨ

Хүн худалдах гэмт хэрэгийн хохирогчийн эрүүл мэндийн асуудлыг бусад эмзэг бүлгийн эрүүл мэндийн үйлчилгээтэй уялдуулан тодорхойлж болох юм. Үүнд:

- Шилжин суурьшигчид, дүрвэгсэд
- Хүчирхийлэл, тамалал, бэлгийн хүчирхийлэл, хүүхэд насандаа биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд
- Биеэ үнэлэгчид, насанд хүрээгүй биеэ үнэлэгчид
- Хөдөлмөрийн мөлжлөгт өртөгсөд

Төрөл бүрийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж эмзэг байдалд орж бие махбодь, сэтгэхүй, нийгэмд эзлэх байр суурийн хувьд хүн худалдах гамт хэргийн хохирогчид дээр дурдагдсан эмзэг бүлгийнхэнтэй эрүүл мэндтэй холбоотой асуудал, эмзэг байдлын хувьд адил эмзэг байдалд ордог. Хүн худалдах гэмт хэрэг болон өртөгсөдийн эрүүл мэндийн талаар мэдээлэл нэн хомс байдаг учир дээр дурдсан бүлэгт халамж, үйлчилгээ үзүүлэх талаар нэгэнт хийгдсэн судалгаа, материалыг эргэн харж ашиглах шаардлагатай.<sup>15,16</sup> Худалдаалагдсан хүмүүст шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд дээрх мэдээллийг мөн ашиглаж болох юм.

## ЭРСДЭЛ, ХҮЧИРХИЙЛЭЛ БА ЭРҮҮЛ МЭНДЭД УЧИРАХ ХОХИРОЛ

Хүн худалдаалах гэмт хэргийг дагалдаж олон төрлийн эрсдэл, хүчирхийлэл, эрүүл мэндээр хохирох асуудал дараалан болон давхардан үүсдэг. Тухайлбал:

- Бие махбодийн хүчирхийлэл/бие махбодийн эрүүл мэнд
- Бэлгийн хүчирхийлэл/нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Сэтгэл санааны дарамт/сэтгэхүйн эрүүл мэнд
- Хар тамхи, согтууруулах ундааг хүчээр хэрэглүүлэх/хамааралтай болох
- Нийгмийн хязгаарлалт түүгээр далимдуулан залах/нийгийн сайн сайхан байдал
- Эдийн засгийн мөлжлөг болон өрийн дарамт/эдийн засгийн боломж
- Эрх зүйн хамгаалалгүй байдал/хууль эрхэзүйн аюулгүй байдал
- Хөдөлмөрийн болон амьдралын боломжгүй нөхцөл/хөдөлмөрийн болон хүрээлэн буй орчны эрүүл ахуй
- Хязгаарлагдмал байдалтай уялдсан эрсдэлүүд/эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хүргэх

### 5.3 Халамж үзүүлэхэд мөрдөх ёс зүйн болоод аюулгүйн зарчмууд<sup>17</sup>

(Хавсралт 1-ийг үзнэ үү. Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод халамж үзүүлэх, ярилцлага хийхэд мөрдөх ёс зүйн зарчмууд)

Цаашид “Худалдагдсан хүн” гэх, худалдагдсан хүнийг дагалдан яваа хүүхэд, насанд хүрэгч хууль эрх зүйн тусламж шаардлагатай байгаа хэн боловч “худалдагдсан хүн буюу түүний асран хамгаалагч” гэсэн утгаар уншиж ойлгоно.

Худалдагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө шаардлагатай дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээх мэргэжлийн бүх хүмүүс ёс зүйн болоод аюулгүй байдлын энгийн зарчмуудыг байнга мөрдөх ёстай. Мэргэжлийн хүмүүс худалдагдсан хүний эргэн төлөвшиг үйл явцын нэг хэсэг учир мэргэшлийн тусгай ур чадвартай байх шаардлагатай юм. Эерэг ур чадвар нь худалдагдсан хүний итгэлтэй болох, бусдад итгэх итгэлийг төрүүлэх, өөртөө болон, ирээдүйдээ итгэх итгэлийг төрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Сөрөг ур чадвар нь хувь хүмүүст бусдаас ичих, олны шившиг болсон мэт сэтгэгдэл төрүүлэхийн зэрэгцээ итгэлгүй, сул мэдрэмжийг төрүүлдэг.

- 
- **Хүүхдүүд (18-аас доошхи насын) болон онцгой анхаарал шаарддаг оюуны соготой хүмүүсийн хувьд дорхи зарчмуудыг бусад аргуудтай уялдуулан ашиглана (тухайлбал, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд, асран хамгаалагч буюу хуулийн төлөөгч шаардлагатай хүмүүс)**
  - **Энэхүү бүлэгт дурьдсан бүх зарчмууд болон зааварчилгаа нь худалдаадагдсан хүмүүст адил тэгш үйлчлэх (оюун санааны хувьд болоод бие махбодийн хувьд чадамжтай, бусдыг ойлгох, харилцах болон өөрсдийнхөө амьдралын талаар шийдвэр гаргах чадвартай насанд хүрэгсэд) бөгөөд мөн дээр дурьдсан тусгай анхаарал, туслалцаа шаардлагатай хүүхдүүд болон насанд хүрэгсэд хамарагдана.**
  - **Эрүүл мэндийн ажилтнууд болоод бусад мэргэжилтнүүд тухайн хүүхэд эсвэл, хязгаарлагдмал чадамжтай насанд хүрэгчийн эрх ашгийг байнга хамгаалах ёстай төдийгүй зөвхөн сайн санааны үүднээс үйл ажиллагаа явуулна.**
- 

## БАЙДЛЫГ ДОРДУУЛАХГҮЙ БАЙХ НЬ

“Байдлыг дордуулахгүй байх” гэдэг нь эрүүл мэндийн ёс зүйн хамгийн анхны зарчим юм. Хүн худалдахтай холбогдсон маш

хүнд эрсдэлийн золиос болсон хүмүүс маш эмзэг болсон байdag ба тэдний амссан зовлонг улам хүндрүүлэхгүй байхын тулд энэхүү суурь зарчмыг мөрдлөг болгоход илүүдэхгүй. Эрүүл мэндийн ажилтан бүр учирч болох эрсдлийг урьдчилан тооцох ёс зүйн үүргийг хүлээх ба тухайн хүнтэй ярилцах, эсвэл эмнэлгийн үзлэг хийх зэрэг нь хохирогчийн байдлыг улам хүндрүүлэхээр байна гэж үзвэл хойшлуулах ёстой. Хүн бүрийн нөхцөл байдалд тохируулан эмчлэх, гэхдээ байдлыг доройтуулахгүй байх нь зүйтэй юм.

## НАЙДВАРТАЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХАМГААЛАГДСАН ТОХЬ ТУХ

Худалдаалаагдсан хүнтэй ярилцлага хийхийн өмнө тухайн хүн аюулгүй байдалд байгаа эсэхдээ итгэлтэй байгааг тодруулах нь чухал юм. Тухайн хүний аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийг бусад зорилгоор шалгасан хэдий ч туслалцаа үзүүлж байгаа хүмүүс үйлчлүүлэгч аюулгүй байгаагаа мэдэрч буй эсэхийг дахин лавлаж, аюулгүй байдлыг нь хангахад юу шаардлагатай байгааг асуух хэрэгтэй.

Худалдаалаагдсан бүх хүмүүсээс эрүүл мэндийн тусlamж яаралтай авах шаардлагатай байгаа эсэхийг нь онцгойлон асуух нь чухал юм. Хувь хүн ярилцлага хийх эсвэл үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулж байх хооронд бие махбодийн болоод сэтгэл санааны тайван бус шинж тэмдгүүд үгдэрэн архагшдаг. Тийм учраас туслалцаа үзүүлж буй хүмүүс дараах зүйлсийг онцгойлон асуух ёстой: Үүнд

- Яг одоо таны сэтгэл санаа ямар байна?
- Танд яг одоо ямар нэг зовиур, шаналал байна уу? Эмч, сувилагчид үзүүлэх шаардлагатай зовиур байна уу? гэх мэт (эрүүл мэндийн ажилтны хувьд: “ярилцахаас өмнө танд надад хэлэх зовиур, өвчин байна уу?”)

## 5.4 Худалдагдсан хүний хүрээлэн байгаа орчны талаарх үзэл бодол ба халамж үйлчилгээнд нөлөөлөх асуудлыг ойлгох нь

Худалдаалагдсан хүмүүсийн туулж өнгөрүүлсэн хүчирхийллийн үр нөлөө, тэдний өнөөдрийн болоод ирээдүйн амьдралд хэрхэн нөлөөлэхийг эрүүл мэндийн халамж үйлчилгээ үзүүлж буй хүмүүс ойлгох зайлшгүй ойлгох хэрэгтэй. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд худалдагдсан хүмүүст санаа тавьж, туслалцаа үзүүлэх чин сэтгэлээр ханддаг хэдий ч худалдаалагдсан хүмүүсийн байдал нь ажилтнуудын үйл ажиллагааг хязгаарлаж, зарим тохиолдолд эргэн төлөвшиг үйл явцад нь саад болдог байна.

---

**Анхааруулга:** **Худалдаалагдсан хүний гаргаж буй зан авир, үйл хөдлөл нь өнгөрсөн хугацаанд тэдний амссан бүхнээс үүдэлтэй гэж үзэж болохоос гадна тухайн хүний гаргаж буй ааш авир нь өөрийгөө хамгаалах гэсэн эсвэл бодит аюулаас зайлсхийх гэсэн оролдлого гэж үзэж болох юм.** Тухайн хүн айж түгшиж эсвэл ярилцах хүсэлгүй байх, эсвэл дарамттай байгаа гэдгээ илэрхийлж байгаа нь тухайн үеийн бодит аюултай холбоотой гэдгийг ойлгох хэрэгтэй. Тухайлбал, түүнийг худалдсан хүмүүс түүнээс өшөөгөө авах болно гэсэн айдас, эсвэл бусад хүмүүс түүнийг дахин зовооно гэсэн түгшүүр юм. (жишээ нь: гэр бүлийн гишүүд, хөршүүд, хамт ажиллагсад нь гэх мэт)

---

### АЙЛГАН СҮРДҮҮЛГИЙН ДУНДАХ АМЬДРАЛ

Хүн худалдах гэмт хэрэгтнүүд, ажил олгогчид, зуучлагчдын ашигладаг хяналтын аргууд нь тамлан зовоох, гэр бүлийн хүчирхийлэл эсвэл хүүхдийг хүчирхилэгчдийнхтэй адил байдаг.<sup>18</sup> Тухайлбал:

- **Айлган сүрдүүлэх:** байнгын айдаст байлгах
- **Хуурах, мэхлэх:** хүмүүсийн өөртөө итгэх итгэл, эргэн тойрноо ойлгох ойлголтыг үгүй хийх
- **Урьдчилан тааж хянах боломжгүй нөхцөл байдал бий болгох:** хувь хүмүүсийг тогтвортгүй болгох, ямарваа зүйлийг

төлөвлөх боломжийг хаах, эсвэл тэдний ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маягийг өөрчилж зөвхөн хариу өгөх, өөрийгөө хамгаалж амь гарах арга барилтай болгох

- **Шийдвэр гаргах эрх мэдэлгүй болгох:** хүний сайн сайхан байдал, амь гарах эсэх нь “энээс” шалтгаалана, эзний үгэнд орж түүнийг сэтгэл хангалаун байхаас шалтгаална гэсэн ойлголтыг төрүүлэх
- **Сэтгэл хөдлөлийг нь хянах:** хайр дурлал, хамаарал (гэмт хэрэгтэнтэй дотно харьцаатай тохиолдолд) зэрэг хувь хүний мэдрэмжийг удирдаж хүнийг хянах. Хүн наймаалагч нь хүн худалдах гэмт хэргийн эерэг талуудыг харуулахыг оролддог ба энэ нь хохирогчийн сэтгэл санаанд шингэж тэдний энэ аялал, хийж буй ажил нь гэр орныхондоо илүү их мөнгө илгээх боломж олгож байгаа гэсэн ойлголт төрүүлж эхэлдэг. Мөн нийгмийн болоод шашны зан заншлыг гүйцэтгэх, хувь хүнийхээ мөрөөдлийг биелүүлэхэд тусалж, ирээдүйд илүү сайхан амьдарна гэсэн тэдний хүлээлтийг бий болгодог.

Хүчирхийллийн эдгээр аргууд болон дарамт, сэтгэл санаагаар нь тоглохын гол зорилго нь хохирогчийг бусдаас хамааралтай болгож, бие хүн гэсэн сэтгэлгээг устгаж, бусадтай харилцах холбоог үгүй болгодог.

Нэгдүгээрт, Хохирогчийг эн түрүүнд “амь дүйх хүнд нөхцөлд” оруулж үхэлтэй нүүр тулаад<sup>19</sup> байна гэдгийг хүчээр ойлгуулдаг.. Хохирогчид өөрийн аюулгүй байдлыг хянах эрхгүй, зөвхөн хүн наймаалагч бүхнийг хянаж байна гэдэг ойлголтыг төрүүлнэ.

Хоёрдугаарт, “бие махбодийн гэсгээл”-ийг мэдрүүлнэ. Хохирогчийг уртасгасан цагаар, чөлөөт цаггүй, амралтгүй дарамтан дор ажиллуулж хүн наймаалагчийн бүрэн хяналт байна гэдгийг олгуулдаг. Ямар ч амралтгүй ажилласан хохирогч ядарч туйлдан, өөрийгөө хамгаалах төлөвлөгөө зохиох чадваргүй болох ба зөвхөн хүний өгсөн тушаалтыг биелүүлж, дарамт зодуурыг хүлээн зөвшөөрдөг.

Бүрэн хамааралтай байлгах эцсийн шат бол хяналт ба ганцаардуулан тусгаарлах явдал юм.<sup>20</sup> Олзны байдалд байлгахад хохирогчид зөвхөн хүн наймаалагчтай харьцдаг ба гадаад ертөнцийг болоод өөрийгөө зөвхөн хүн наймаалагчийн ярьж

хэлснээр төсөөлж өхөлдэг байна. Ийм замаар хохирогч хувь хүн байхаа болж хүн наймаалагчийн удирдлаганд бүрэн ордог. Ихэнх хохирогчдын хүн наймаалах гэмт хэрэгт хандах хандлага нь сэтгэл зүйн, сэтгэл санааных болдог буюу хохирогч эсвэл өөрийн мэдрэлгүй эсвэл байнгын хяналтанд байгаа мэт болж хувирдаг байна.

(Энэхүү бүлгийн Анхаарах асуудлууд ба Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хэсгийн Эмнэлгийн зааварчилгаа гэсэн дэд хэсгийн 5.5 ба 5.8 хэсгүүдээс хохирогчийн сэтгэцэд үүсэх үр нөлөөний талаарх дэлгэрэнгүй ярилцлагыг үзнэ үү)

## АЙДАС

Хүн худалдаалах гэмт хэргээс үүдэн гарсан амь гарах аргуудтай холбоотойгоор олон янзын нөлөөлөл гарч болох хэдий хохирогч өнөөдөр болон ирээдүйнхээ талаар айдас, түгшүүрт автаж ингэдэг гэдгийг дурьдах хэрэгтэй.

Эх ороосоо хол байгаа хүн худалдах гэмт хэргийн хохирогчид цагаачид, дүрвэгчийн туулж гардаг саад бэрхшээл болох бусдаас тусгаарлагдах, хэл, иргэншил соёлын зөрөөний бэрхшээл, оршин суух, буцах бэрхшээл, хүн наймаалагчаас бүрэн хамааралтайгаар амьдрах бэрхшээлүүдийг нэг адил туулдаг.

Хохирогчид мөн тэдний туулж өнгөрсөн амдралтай холблитойгоор нийгэмийн зүгээс зэмлэл, доромжлолыг амсна гэсэн дарамт бодлыг тээж явдаг. Хүчээр биеэ үнэлж байсан, бэлгийн хүчирхийлэлд автсан, амласан мөнгөө авчраагүй, эсвэл өрөө өрийн төлөөсөнд орсон шалтгаанаар гэр бүлийнхэн нь эсвэл хүрээлэн буй хүмүүс нь хохирогчоос татгалзах, гадуурхах явдал олонтаа байдаг.

## ДЭМЖЛЭГИЙН ҮЙЛДЭЛ БА ТУСЛАХ ХҮСЭЛ<sup>21</sup>

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчидтой ажилладаг ажилтнууд хохирогч ямар шалтгаанаар тийм зан ааш гаргаж байгааг ойлгохыг хичээх хэрэгтэй. Ингэснээр хохирогчдод

тусламж, туслалцааг хэрхэн үзүүлэх, хохирогчид яагаад тусламж авах хүсэлгүй байгаа, товлосон уулзалт ярилцлагадаа ирэхгүй байх эсвэл эмчилгээ хийлгэхгүй байгаа шалтгааныг олж мэдэх боломжтой болно. Хүн бүр хүн худалдаалах гэмт хэрэгт өөрийнхөөр хандаж ойлгодог. Ихэнх хүмүүс үүндээ гутарч, сэтгэлийн дарамтад ордог бол зарим нь эрх чөлөөгөө мэдэрч, өөртөө итгэлтэй болдог байна. Гэвч энэ хоёр тохиолдлынд аль алинд хохирогчид хувь хүн гэсэн утгаар хүндэтгэлтэйгээр хандаж нэгэн ижил боломжийн тусламж үзүүлэх зарчмыг баримталдаг.

ХХГХ-ийн хохирогч нарт туслалцаа үзүүлэх үед хамгийн их тохиолддогг бэрхшээл бол тэд бусдад болоод өөртөө итгэх итгэлгүй болсон, өөрсдийн амьдралаа хянах чадваргүй болсон гэсэн бодол байдаг. Өөрийгөө хянах боломжгүй болсон байдаг ба үүнээс үүдэн гарах үр дагавар, бэрхшээлийг (тухайлбал, бэлгийн хүчирхийлэл, аюулгүй байдлыг хангаагүй орчинд хүчээр ажил хийлгэх гэх мэт) хохирогч давж гарах ёстой бөгөөд үүнийг эрүүл мэндийн ажилтнуудын тусламжтайгаар даван туулдаг байна.

Ийм төрлийн халамж үйлчилгээ үзүүлэхэд хэн нэгэнд итгэх нь маш чухал хэдий ч хохирогчийн хувьд өөр хүнд итгэх, түүнээс тусламж авах нь өөрийгөө бусдын хяналтанд өгч байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Хамгийн гол нь бусдын тусламж, туслалцаанаас (ихэнхдээ өөрийгөө хамгаалах гэсэн сэтгэлгээгээр) татгалзаж байгаа хохирогч өөрсдийгөө бусдын эрхшээлд байна гэж үздэг учир нь тэд хэн нэгнээс зөвшөөрөл авч бус өөрсдөө шийдвэр гаргах ёстой гэж үздэгт байдаг.

Дараах хүснэгтэнд ХХГХ-ийн хохирогчдын гаргадаг ижил төстэй зан үйл, тэдний үйл хөдлөл үзүүлж буй тусламж үйлчилгээнд хэрхэн нөлөөлж буй, туслалмж үзүүлж буй мэргэжилтэн ямар хариу үйлдэл хийж аргуудыг харуулжээ.

Мөн энэ бүлгийн Анхаарах асуудлууд ба Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, ХДХВ/ДОХ-ийн тухай дэд бүлгийн Эмнэлгийн заavarчилгааны 5.5, 5.7.1 ба 5.8 хэсгээс дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

Гүсламж үйлчилээ Узшлэх Уед ХХГХ-ийн хохи рогчдын гаргах зан байдалтай харьцах нь<sup>21</sup>

ХХХГ-Хийн талаарх өрнөжиний сийлжлийн бий болгоход	Туснамж үүчинчлэгээ үзүүлэх үед илрүү болох зан ашиг	Серег зан үйлдэлд яхь эрэг харуу үйлдэл
Айлас, түшүүр, сэргээн зөвийнгүй	Хүмүүстийн улахаас дургүйцэх, гадашига гарах буюу ганцаар байхгүй илүүдэй үзэх, алж дагжих, чичээх буюу зүрх нь юхилж, унтаж чадахийг байх, хэр дарж үзүүлэх, цэдүүг чадахийг байх, анхааралсаа төвлөрүүг чадахийг байх	Аюулгүй байдлыг хангах агаа хамжээ, аюулгүй байдлын агаа хамжээ авсан тэдийг тайлбарлах, бийнгүй байдлыг нүүцлэх, алгуулж орчинд байна гэдэггүй олон ултуудах, бусдадай улцаад хэн нээн дагдацаа
Бусдад итгэхгүй байх	Туснамж үүчинчлэгээ үзүүлж буй хүн, үзүүлж буй үүчинчлэгэнд эрэлзэх, мэдээлэлтэй яхесэс гаталгаах, худал мэдээлэлтэй яхес, туслаамж үзүүлж бусдайтай, гар бүринжийнээс холын жетгэлтэй хамралдаж байгаа идэвхгүй, шийдвэр гарах буюу хэн наянхийн гарасан шийдвэрт эрэлзэж байх, ирээдүйнээс төвлөрүүдээс эрэлзэх, хэт мэдрэмжтэй буюу бусдад болон гадны непенч эзэлж хандаж	Харилцаа тогтоодо тэвчээртэй, хүлээлтийг байх, туслаиж туслацаа, сэтгэл санавын дээжигжэй, үзүүлэлтээс накшэл болзоул тэвийгүй байх, хөхрөгчийн хэрэгээц, сайн сайхны төлөө байнаа санаа тавих төвлөрүүг чадахийг байх
Өөрөө итгэлгүй байх.	Нийл рүү харж чадахийг дэлдэгч, өөрийгөө илэрхийлж чадахгүй байх, ийн явдлын талбар болгодой сотгэлдээг тайлгарж чадахгүй байх, ийнээс ношнуулж, эмчилгэнэнд бүлтээр болон бусад хэлбэрээр оролцохкоо татталазах	Болж өнгөрсөн бүхэн хөхрөгчийн бүрүү биш гэдгүйг ойлтуулж итилгүү, хүн худалданаад гаралт олон хүний хөхрөгчийг болгоход тэмт хэрэг бүхийдээ гэдэггүй сануултуух, хүнд хануу нэхцэлд түүчөөр агаа зам байгаагүй гэдэггүй сануултуух
Өөрийн шүүмжлэх, иных буюу дууту үзэлж	Туснамжуудаа үзүүлж буй ажилтнуудаа болоод бусдад тухайн бол, хамтран аильдагчид, гар бүйнжинчдэд дайсанч, дээрээгийн харьцаа, еврөөгээ биеийн гамтж, гар бүйнжинчдэд дайсанч, дээрээгийн харьцаа, еврөөгээ уруулах, аливаа хэтгэхийн эзэлжтэй хүчинтэй авах, ортолцож хүслэхий байх, бусдад буруутах, биеэ дайлхахгүй буюу тааламжийн ханах	Тэвчээртэй байх, дайсанахаа зан байдал гаргаван тайван байх, хөхрөгчид үүрэлж, дайсанахийг байх, эсвэл урмын нь хугац байхгаяа хэрүүлжийг байх, хөхрөгчийн аюулгүй байдлыг ханах шардлагатай агаа хамжээ авах, бусдын аюулгүй байдлыг ханах УДНЭС шандлагатай агаа хамжээ авах
Ой тогтолцот穆удах, санахан ойлгүй болох	Өнгөрсөн бүхийг хасчлан буюу бүтнээр нь эртэн санахаа чадварийг боловх, өнгөрсөн үйльдэг хольж хугтах, асуултанд харуулах сонирхийн нийт байх	Хөхрөгчийн шүүх, шүүмжлэхгүй байх, хөхрөгчийг дарамжлахгүй аильтнүүдийн сурдуулжийг байх, зарим хүмүүсийн санахийг байхын ач холбогдуулж оглох
Уйтгар гурин, хямран,	Шийдвэр гарахаа чадварийг буюу хүслэгийг, бусдад таанлагдахыг хүсэх, хийж байхгүй болгоход, агаа хамжээнд оролцохгүй болгоход	Жижиг - давталтад яхь, хуялаа зассан зорилтуулж болгох хөхрөгчийн чадварий, чадварийн үзүэлж, хүн сайн сайнажиж төлөө бусдад илөнгийн, алхардаж аваха, өөрийн буюу бариний сонголтоо хүчтэй харилцуулж үзүүлж, хамтадаа томдоод гарах, туслацаа, зөвлөхөө хамтадаа чадварийг байх, байнаа томдоод гарах, туслацаа, зөвлөхөө авахас татгалзах, хисэлжийг байх
Тусгасарладман байдал, ганднаардал	Уйтгар гурин, хямран, бусдадаас холдох, агаа хамжээнд оролцохгүй байх, үлбэрээр суп болгох зөвхөн сөрөөг төвлөрөх, өөр хэн ч верийг нь омногийн гээдэг итгэлтийг байх	Бусдаас хамаарах, саахрагдах буюу өөрийнхөө хамгаалах

## 5.5 Анхаарах тусгай асуудлууд

Энэхүү хэсэгт ХХГХ-ийн хохирогчдод тусlamж үзүүлэхэд тавих онцгой аргуудын талаарх асуудлуудыг авч үзэх юм. Соёл уламжлалын хэв маягийг тайлбарлах (өөрөөр хэлбэл соёл уламжлалд тохирсон туслалцаа үзүүлэх), зарим нэг эмзэг асуудал болон жендерийн асуудалтай холбоотой оцнгой шаардлага хэрэгцээг тодотгох, ХДХВ/ДОХ байдал, мансууруулах бодисын хэрэглээнд анхаарал хандуулхаас гадна, эмчлэгч-өвчтөний хоорондын харилцаанд гарч болох хүндрэлүүдийг тайлбарлах нь гол зорилго болно.

### 5.5.1 УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ ХҮНДЭТГЭХ НЬ

Уламжлал, ёс заншлыг хүндэтгэх гэдэг нэр томъёог эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус хүрээнд үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн хооронд яс үндэс, арьс өнгө, үндэстэн, нийгмийн болоод хэл зүйн хүчин зүйлсүүдийг харгалзан үзэх үед хэрэглэдэг. Уламжлал ёс заншлыг хүндэтгэх мэдлэгтэй байх нь уламжлалын ялгаатай байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, хариу үйлдэл хийхэд тустай. Хүмүүсийн ёс заншил, уламжлалын ялгааг хүндэтгэн хүлээн зөвшөөрч түүнд тохируулан хандах нь үр дүнтэй эмчилгээ үзүүлэхэд ач холбогдолтой төдийгүй мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хамгаалах хэм хэмжээнд тухайлбал, Олон улсын Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Пактад заасан шаардлагыг биелүүлж байгаа юм.<sup>22</sup>

---

Уламжлалт ёс заншил гэдэг ойлголтыг мэдлэг, зан байдал болоод ур чадварын нэгдэл бөгөөд энэ нь үндэстэн хоорондын харилцааг бэхжүүлж, үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгодог хэмээн тодорхойлжээ. Үүнд:

- Бусдын зан заншил, итгэл үнэмшил, зан байдлын үр нөлөөний талаарх мэдлэг
  - Хувь хүний соёл уламжлал, үзэл бодол болоод бусдад нөлөөлөх нөлөөллийн талаар мэдлэг
  - Тухайн нөхцл байдлын нийгэм, улс төр, байгаль орчин болоод эдийн засгийн үр нөлөөллийн талаарх ойлголттой.<sup>23</sup>
-

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд, үйлчлүүлэгч хүн ам, эмнэлгийн байгууллагын ялгаатай нөхцөл байдлаас шалтгаалан уламжлалт ёс заншилд суралцаж, мэдрэгтэй болох асуудал цаг хугацаа, нөөцийг ихээр шаарддаг. Үүнд хүмүүсийн зан байдал, зан авир, мэдлэг болоод ур чадварийг байнга суралцаж (ядахаа суралцах дэмжлэгтэй байх) хүсэл эрмэлзлэл удирдлага болон ажилтнуудад байх ёстой.

---

**Тогтсон журам ёсыг олон аргаар илэрхийлэхийн зэрэгцээ энэ нь эргээд ойлгоход хүнд зан байдал болон хувирдаг. Үл ойлголцол оношийг буруу тогтооход хүргэх магадлалтай.**

---

Сэтгэлийн үйл хөдлөл нь соёл уламжлалын хувьд нийгмээр тодорхойлогдсон гэдгээс үүдэн сэтгэцийн эрүүл мэндийн оношлогоо, үйлчилгээг авч үздэг. Хувь хүмүүсийн туулж өнгөрүүлсэн хүнд хэцүү, сэтгэл санааны гэмтэл учрулсан үйл явдал нь тэдний хувийн амьдрал, тэдний соёл заншилтай нягт холбоотой байдаг. Тэдний гэр бүл, нийгэм, хамт олон хүнд хэцүү үеийг хүлээн ойлгох тэдний хариу үйлдэл нь худалдаалагдсан хүмүүсд гол нөлөө үзүүлдэг.

Нэг нийгмийн төсөөллийн загварууд нь өөр соёл уламжлалтай, өөр гарал үүсэлтэй нийгмийн төлөөлөгчдөд тохирдоггүй. Барууны хэм хэмжээнд ихэвчлэн туслах стратегийг ашиглан найдз нөхөд эсвэл бусад хүмүүс өөрт нь учирсан сэтгэлийн зовлонг хэрхэн туулсантай харьцуулдаг. Тухайлбал, хохирогчдод өнгөрсөн хугацаанд болж өнгөрсөн бүхнийг эргэн санаж, түүнийг ярихыг дэмжсэн уулзалт хийдэг. Энэ нь туулж өнгөрүүлсэн зовлонгоо мартах ёстой гэсэн үзэлтэй бусад үндэстний тохиромжгүй байж болох юм. Эсвэл гэр бүлийн хүрээнээс бусдад хэтэрхий дотно, эсвэл аймшигтай бүхнийг эргэн дурсахыг хүлээн зөвшөөрдөггүй тийм үндэстэн ч байна.<sup>24</sup>

Зарим үндэстний хувьд сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх үйлчилгээ байж болшгүй төдийгүй зарим тохиолдолд аюултай ч байж болдог. Тухайлбал, сэтгэцийн өвчин гэдгийг сэтгэл мэдрэлийн байгууллага, эмнэлэгтэй холбож ойлгодог, эсвэл хүний сэтгэл санааг удирдах нь ерийн бус гэж үздэг үндэстний хувьд үүнийг эрс эсэргүүцдэг төдийгүй сэтгэл зүйн эмчилгээнд орохдоо айж, зовдог байна. Ийм учраас эрүүл мэндийн ажилтнууд

шаардлагатай тусламж өгөх үүднээс өвчтнийхөө соёл заншил, шашин шүтлэгийн талаарх мэдээллийг олж авах ёстой.

Эрүүл мэндийн ажилтнууд “Та гэртээ байсан бол одоо танд учраад байгаа асуудалд хэрхэн хандах вэ?” гэх зэргийн асуултуудыг үйлчлүүлэгчээс асуух хэрэгтэй. Энэ тохиолдолд тусламж туслалцаа үзүүлж буй ажилтнууд хохирогчдод шашны байгууллага, шашны ажилтнууд эсвэл уламжлалт домч эмч, эсвэл өөрийн зан заншлыг үйлдэх зэрэг боломжуудыг ашиглахад нь туслалцаа үзүүлж чадна.

Уламжлалт заншлын талаар шаардлагатай мэдлэгтэй болоход тулд янз бүрийн газрын ХХГХ-ийн хохирогчидтой харьцах чухал бөгөөд ажилтнууд хэвшсэн үзэл бодлоос татгалзаж, зан байдлын хувьд ойролцоо хүмүүстэй харьцуулалт хийж, ажлын явцад харилцах хүмүүсийн тухайд мэдлэгтэй болох хэрэгтэй. Зарим эрүүл мэндийн ажилтнууд нийгэм, эдийн засгийн хувьд арай боломжтой давхаргын эсвэл боловсролоор арай дээгүүр хүмүүст илүү хандах тохиолдол байдаг нь бусад боломж багатай үйлчлүүлэгчдийн сэтгэл санаанд муугаар нөлөөлдөг. Хохирогчдыг хүндэтгэн тэднийг дорд үзэлгүй харилцан ойлгож харьцах хэрэгтэй.

Соёл уламжлалын талаар мэдлэгтэй болохын бас нэгэн чухал ач холбогдол бол тухайн соёл заншлын талаар ойлголттой болох, эмчилгээний уламжлалт арга тэдний итгэл үнэмшлийг хүндэтгэж байгаагаа харуулах явдал бөгөөд нэн ялангуяа хамтран ажиллаж буй тухайн бүлэгт хүндэтгэлтэй хандах нь зүйтэй. Тусламж туслалцаа үзүүлж буй ажилтнууд дээрх хандлагыг эмчилгээний төлөвлөгөөтэй уялдуулан хэрэглэх хэрэгтэй.

Мөн боломжтой бол тухайн үндэстэн зуучлагчидтай хамтран ажиллах нь давуу талтай. Зуучлагчид шилжин суурьшигч болоод байгаа улс орны зан заншлын онцлог, уламжлалыг ойлгодог хоёр талыг холбох боломжтой байдаг.<sup>25</sup> Энэ нь үйлчлүүлэг эмчилгээ хийж буй ажилтнд итгэх чухал зүйл болдог.

Соёл уламжлалыг нэг хэрэгслээ болгон ашиглаж буй үйлчилгээ нь бүх хүмүүсийн хувьд маш чухал байдаг. Энэ тохиолдолд ажилтнуудад сургалт явуулах нь тохиромжтой бөгөөд ажилтнууд

ХХГХ-ийн хохирогчидтой ажиллахдаа шаардлагатай үзэл бодол, зан байдал, мэдлэг, ур чадвартай болдог.

### 5.5.2 ХОХИРОЛ БА САНАМЖ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйл явдал, үүний дотор хүний нэр, он цаг, байршил зэргийг нарийвчлан санах чадваргүй байх нь олонтаа тохиолддог. Хохирогчид болж өнгөрсөн үйл явдлыг цаг хугацаа өнгөрхийн хирээр өөрөөр эргэн санах нь мөн бий. Анхны хохирол<sup>26</sup> амссан тэр үед санамжаа алдах тохиолдол ихэвчлэн тохиолддог ба хохирогч анх удаа аюулыг мэдэрсэн эсвэл тэр үеийн талаархи мэдээллийг албаны болон бусад хүмүүс асуух үед, (тухайлбал, явах зохицуулалт, төлөвлөлтийн үе, хүн худалдагч зуучлагчдын нэр, орж ирсэн хилийн боомт гэх мэт) тохиолддог.

Хохирол амсах үеийн санамж, сэтгэлийн шаналлалын бие маш бодь болон сэтгэл зүйн хариу үйлдэл нь хожим хохирогчдод болж өнгөрсөн бүхнийг санах, үйл явдлыг бүрэн төгс санаход саад болдог. Аюултай тулгарсан үед хүн сэтгэл санааны хувьд “дайралт буюу хариу дайралт” хийж, үүний үр дүнд тархинаас ялгарах бодисууд мэдээллийг шүүж, тодорхой зарим зүйлийг нь санамжид үлдээдэг.<sup>27</sup> Энэ үед хохирогч анхаарлаа төвлөрүүлж, ажиглах чадвараа алдаж зөвхөн дараагийн аюулд хэрхэн хурдан хариу өгөхөө л бodoх чадвартай болдог байна. Мэдрэлийн системийн зөвхөн нэг хэсэгт л хариу үйлдэл боловсوردог учир мэдээлэл алдагдаж, хохирогч дараа нь өөрийгөө өөрийгөө буруутгах бодолд автдагаас өнгөрсөн үйл явдлыг санах чадамжаа алддаг байна.

---

**Хохирогч үйл явдлыг санахгүй, эсвэл үйл явдлын дарааллыг алдагдуулж байгаа нь хохирогч худал ярих эсвэл туслалцаа авахыг хүсэхгүй байна гэсэн үг биш юм. Санамж алдагдсан бол тэвчээртэй байж, хохирогчийн санамж сэргэхийн хирээр болж өнгөрсөн үйл явдлын талаархи мэдээллийг бага багаар авч болно.**

---

### 5.5.3 ХҮЙС БА ЖЕНДЕР

Хүйс ба жөндер нь эрүүл мэнд болоод эрүүл мэндийн үйлчилгээнд чухал үүрэгтэй. Эрэгтэй юу, эмэгтэй юу гэсэн биологийн баримт болох хүйсийн нөлөөг хүлээн зөвшөөрөх нь эр, эмийг тодорхойлох уламжлалт тодорхойлолт бөгөөд эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд онцгой үүрэг гүйцэтгэдэг.<sup>28</sup> Жендерийн мэдрэмжтэй хандлага хүний эрхийн мэдрэмжтэй хандлага төдийгүй ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрхийг тэгш хандах зарчим юм. Худалдагдсан хүмүүсийн дунд эмэгтэйчүүд зонхилдог ч эрэгтэйчүүд, залуучууд, хөвгүүд энэ хэргийн хохирогч болж бэлгийн хүчирхийлэл, дараангуйлал, мөлжлөгийг амсч эрүүл мэндээрээ хохирсон байдаг.

Эмэгтэйчүүд болоод эмэгтэй хүүхэд, өсвөр насынханд эмэгтэй ажилтан тусlamж үзүүлэх боломж олгох нь нэн чухал. Эмэгтэй ажилтан байхгүй бол биеийн үзлэг хийхэд эмэгтэй хүн байлгах хэрэгтэй. Үүнтэй адил эрчүүд болон өсвөр насын эрэгтэй хүүхдэд эрэгтэй ажилтан тусlamж үзүүлнэ.

Нийгмийн болоод улс төрийн байдлаас хамааран эмэгтэйчүүдийн эрхийг боогдуулж, дорд үзэх нь олонтаа байдаг.

#### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Эмэгтэйчүүдийг худалдах явдал эмэгтэйчүүдийн хүчирхийллийн хамгийн өргөн тархсан хэлбэр гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” гэсэн ойлголт нь эмэгтэйчүүдэд бие махбодийн, бэлгийн болоод сэтгэл санааны хохирол учруулж буй жендерээр ялгаварлан гадуурхсан хүчирхийллийн гэмт хэрэг бөгөөд үүнд мөн заналхийлэл, доромжлол эсвэл нийгмийн буюу хувийн амьдралын эрх чөлөөг хаан боогдуулах зэрэг хэлбэрүүдийг хамааруулан авч үздэг. Үүнд дараахь үйлдлүүд багтдагба үүгээр ч хязгаарлагдахгүй:

- Гэр бүл дэх бие махбодийн, бэлгийн болоод сэтгэл зүйн хүчирхийлэл, зодуур, эмэгтэй хүүхдийг хүчирхийлэх, багтлон гэрлүүлэхтэй холбоотой хүчирхийлэл, гэр булийн хүнийг хүчиндэх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг гэмтээх,

зэрэмдэглэх болон эмэгтэйчүүдэд хортой бусад уламжлалт заншил, гэр бүлийн гадуурх хүчирхийлэл, хүний хөдөлмөрийг мөлжихтэй холбоотой хүчирхийлэл.

- Хамт олны дундах эмэгтэйчүүдийн бие махбод, бэлгийн болоод сэтгэл зүйн хүчирхийлэл. Үүний дотор хүчиндэх, бэлгийн хүчирхийлэл, ажлын байр, боловсролын байгууллага болоод бусад газар дахь эрх мэдлээр дарамтлах бэлгийн өнгөлзлөг, бэлгийн дарамт, эмэгтэйчүүдийг худалдах, хүчээр биеийг нь үнэлүүлэх.
- Улс оронд хэвшил болон хайхардаггүй бие махбодийн, бэлгийн болоод сэтгэл зүйн хүчирхийлэл.<sup>29</sup>

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд мөн хүчээр хүүхэд гаргах боломжгүй болгох, хүчээр үр хөндүүлэх, жирэмсэн болохоос хамгаалах хэрэгслийг албан хүчээр хэрэглүүлэх, эмэгтэй нярай хүүхдийг хороох зэрэг багтана.

Эмэгтэйчүүдийг ихэвчлэн тэдэнд ойр байдаг хүмүүс нь хүчирхийлдэг. Судалгааны үр дүнгээс үзэхэд эмэгтэйчүүдийн 10-50% нь бэлгийн харилцаатай байдаг хүмүүс нь хүчирхийлсэн гэсэн хариулт өгчээ.<sup>30</sup> Судалгааны явцад мөн эмэгтэйчүүд гэр бүлийнхээ хүрээнд хүчирхийлэлд өртдөг гэсэн дүгнэлт гарсан бөгөөд эмэгтэйчүүдийн бие махбодийн болоод сэтгээцийн эрүүл мэндийг нарийвчлан судлах, цаашдын төлөвлөлт хийхэд аюулгүй байдал, эрүүл мэндэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж харуулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх эмэгтэйчүүдийн хувьд маш эмзэг асуудал байдаг. Өнгөрсөн хүчирхийллийг ихэвчлэн бэлтгэгдсэн сэтгээцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд эсвэл туршлагатай эмч, эрүүл мэндийн ажилтнууд тухайн эмэгтэйн эрүүл мэндийн түүхийг судлах явцдаа олж мэддэг байна. Эмч, ажилтнууд болж өнгөрсөн хүчирхийллийг зөвөөр ойлгож туслах бэлтгэлтэй байх ёстой.

## Бэлгийн хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэл гэдгийг “хүчирхийлэгч этгээд хохирогчид ямар хамаарлтай болох, үйлдэгдсэн газар түүний дотор гэр, ажлын байр хаана үйлдэгдсэнээс үл хамааран, бэлгийн үйл ажиллагаа, бэлгийн харьцаанд орох зорилгот үйлдэл, хүсээгүй

байхад бэлгийн харьцаа санал болгох, давшлах, хүч хэрэглэн бэлгийн зорилгоор худалдах, айлгах, сүрдүүлэх, гэмтэл учруулалах эсвэл бие махбодын хүчирхийлэл үзүүлэх” зэргийг хэлнэ гэж тодорхойлжээ.<sup>31</sup> ХХГХ-ийн хувьд эмэгтэйчүүдийг худалдсан зорилгоос үл хамааран бэлгийн мөлжлөг маш түгээмэл байдаг. Бэлгийн хүчирхийлэл, зөвшөөрөлгүй бэлгийн харьцаанд “хүчээр биеийг нь үнэлүүлэх, хүчээр садар самуунд уруу татах, хүчээр жирэмслүүлэх, хүчээр цэвэршүүлэх, хүчээр үр хөндүүлэх, хүчээр боолчлох, хүчээр гэр бүл болох” зэрэг үйлдлүүд багтдаг.<sup>32</sup>

Бэлгийн дайралт нь нийгэм хувь хүнд сэтгэхүйн сөрөг нөлөө үзүүлдэг. Сэтгэл зүйн хувьд бэлгийн бус хохирол учруулсан гэмт хэргийн хохирогчоос, бэлгийн хүчирхийллийн хохиргчид анхааралтай хандахыг шаарддаг. Бэлгийн хүчирхийлэлд хандах хандлага нь хохирогчид учруулсан хохирол, бодит доромжлогоор илэрдэг ба хохирогч өөрийгөө буруушах, өөртөө итгэлээ алдах, ихэнх тохиолдолд энэ нь хохирогчийн сэтгэлээс хэзээ ч арилахгүй толбо болон үлддэг.

Бэлгийн хүчирхийлэл, биеэ үнэлэхтэй холбоотой сэтгэлийн шаналал хохирогчийн сэтгэцэд муугаар нөлөөлж нөхөн сэргээхэд хүндрэл учруулдаг төдийгүй бусадтай харилцах, илэн далангуй байх, өөрийгөө үнэлэх, өөрийгөө учлах нөхцлийг бурдуулэхэд ихээхэн саад болдог. Ихэнх тохиолдолд гэр бүлийнхэн, нэг нутгийн иргэдийн зүгээс сөрөг хандлага, хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага үүсгэдэг. Худалдагдсан эмэгтэйчүүд тэдний эсрэг үйлдэгдсэн бэлгийн мөлжлөг, ялангуяа хүчээр биеийг ньүнэлүүлж байсныхаа төлөө тэд өөрсдөө буруутгадаг. Бэлгийн мөлжлөгт өртөж, биеэ үнэлсэн эмэгтэйчүүд байнга санаа зовж явдаг нь сайн дураар тусламж хүсэхээс татгалзахад нөлөөлдөг тул үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хувь хүнийг хүндэтгэх, өөрийгөө хамгаалах гэсэн эрмэлзэл, зөн совин, бэлгийн мөлжлөг болоод хүчирхийллийг туулж амь гарсан гэдгийг нь санаж, ХХГХ-ийн золиос болсон эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэхдээ гадны байгууллага, эх сурвалжтай холбоо тогтоох, эмэгтэйчүүдийг байрлуулахдаа гарч болох нийгмийн сөрөг үр дагаврыг анхаарч үзэх ёстай.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчтой тэднийг хүндэтгэн ойлгож, болгоомжтой харьцах хэрэгтэй. Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч өөрийн амьдралаа хянах боломжийг албадлага,

хүчирхийллийн дор алдсан байдаг. Цагдаагийн ажилтан буюу эмчтэй уулзахдаа эмэгтэйчүүд ихэнхдээ өөрийгөө хянах чадваргүй болсон тэр мэдрэмжээр ханддаг. Мэдүүлэг авах, үзлэг хийх үеийн сэтгэлийн шаналал тэднийг бүрмөсөн хүний эхэнд орсон мэт сэтгэгдэл, ичих, өөрийгөө буруутгах, итгэл алдрах, өнгөрсөн хохирол шархыг улам сэдрээн гүнзгийрүүлдэг. Тиймээс тэдэнд эелдэг, найрсаг хандаж өөртөө итгэх итгэлийг нь бататгах хэрэгтэй. Өөрийгөө ямарваа нэгэн байдлаар үнэлж, өөртөө итгэж, тусламж санал болгосон хүмүүст итгэж эхэлснээр зөв оношлогоо, эмчилгээ хийх боломжтой болох ба нөхөн сэргээх үйл явц хурдасдаг.<sup>33</sup>

### **Хувийн амдрал, бүрэг байдлыг хүндэтгэх**

Зарим тохиолдолд эмнэлгийн үзлэг болоод сексийн талаарх сэдвээс хөндөхөөс эмэгтэйчүүд ичиж, нэрэлхэж байгааг эмч ойлгож байгаагаа харуулах хэрэгтэй. ХХГХ-ийх хохирогч эмэгтэйчүүдийн үзлэг хийх нь тогтсон хэвшил бөгөөд янз бүрийн асуулт асуух нь үзлэгийн нэг хэсэг гэдгийг ойлгуулахдаа тэвчээртэй хандаж ХХГХ-ийн хохирогчид туслахын тулд энэхүү үзлэгийг бусад бүх хохирогчдод хийдэг гэдгийг сайтар ойлгуулна. Үзлэг хийж буй эмч олон удаа ийм төрлийн үзлэг хийж байсан гэдгээ хэлж, хохирогчийг тайвшируулан, асуултанд хариулах нь хохирогчид хэрэгтэй гэдгийг ойлгуулах шаардлагатай. Бие болоод эд эрхтний талаар ярихдаа тухайн ёс заншил, соёлд хэрэглэгддэг томьёолол, нэршлийг ашиглах нь давуу талтай.

#### **5.5.4 ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛАМЖЛАЛТ ҮҮРЭГ**

Эрүүл мэндийн ажилтнууд худалдагдсан хүний нийгэм болон соёлд тулгуурласан хэвшмэл ойлголтыг хүлээн зөвшөөрөх бэлтгэлтэй байх хэрэгтэй. Эмэгтэйчүүд, ялангуяа хохирогч эмэгтэйчүүд, тэдэнд итгэхгүй байх хэмээн айснаас үйл явдал, эрүүл мэндийн талаар зүйлийг нуух эсвэл багасгаж ярих тохиолдол байдаг. Эмэгтэйчүүд ихэвчлэн өөрсдийн эрүүл мэндийн тухай мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэдэхгүй, эсвэл холбогдох эрх бүхий байгууллагын нэр хүнд эсвэл эмч, ялангуяа

эрэгтэй эмч нарын мэдлэгэд үл итгэх байх эрүүл мэндийн тухай мэдээллийг ойлгох өөрсдийн чадвар, мэдээлэл авах өөрсдийн хэрэгцээгээ дутуу үнэлэх нь их байдал.

Эрүүл мэндийн талаах мэдээлэл, эрүүл мэндийн боловсролын гарын авлага дараах сэдвээр бэлтгэгдэх нь зүйтэй. Үүнд: зөв хооллолт ба эрүүл ахуй, нөхөн үргижүйн эрхтний өрөнхий ажиллагаа болон эмэгтэйчүүдийн эрүүл ахуй арчилгаа, бэлгийн эрүүл ахуй, аюулгүй бэлгийн харьцаа, жирэмслэлтээс хамгаалах арга, бэлгийн замын халдварт (шинж тэмдэг болон урт хугацааны туршид үргэлжилж болзошгүй эрсдэл). Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд эрүүл мэндийг дэмжихтэй холбоотой арга хэмжээг хөгжүүлэхэд тал бүрийн туслалцаа үзүүлэх шаардлагатай юм. Эдгээр арга хэмжээ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, бэлгийн цөөнх болон хүүхдүүдэд зориулсан байх нь зүйтэй.

Эмч нь эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээг ямар нэг хэлбэрээр ялгаварлан гадуурхах буюу хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүний эрүүл мэнд, түүнийг илааршуулахаас өөр аливаа зүйлийг үл хайхран үзүүлэх, мэдээлэл авах эрх, мэдээлэл авсны дараа сонголтоо хийх эрхийг нь зөвлөлгөө өгөх болон эмчилгээ хийх явцад хангах арга замыг байнга эрэлхийлнэ.

Зарим улс орон дахь эмэгтэйчүүдийн нийгэм болон эдийн засгийн буурай байдал цаашид тэднийг мэргэжлийн болон иргэний амьдралд хэвийн байдлаар оролцох, бие даан амьдрахад шаардлагатай нөөцөөс хүртэх боломжийг нь бууруулдаг. Олон улс оронд айлын охин эцэг эхээ асарч, халамжлах ёстой гэсэн ойлголт байдаг. Гэрээсээ ажил хийж мөнгө олно хэмээн явсан эмэгтэйчүүд мөнгөгүй буцаж ирэх нь тэднийг гэмших, гутрах, өөрийгөө буруутгах байдалд оруулж зарим тохиолдолд гэр бүлийн гишүүд нь тэднийг гэр бүлийнхээ нэр хүндийг гутаасых нь төлөө буруутгах, шийтгэх, хариугаа авах гол бай болгодог. Энэ байдал ялангуяа ажил эрхлэх боломж бий болгож явахад нь зориулж хөрөнгө мөнгө зарцуулсан гэр бүлийн хувьд зонхилон тохиолддог. Зарим газар гэр бүлийнхээ нэр хүндийг гутаасан эмэгтэйчүүдээс гэр бүлийн гишүүд нь нүүр буруулах, бүр тэдний амь насыг хөнөөхийт хүртэл нийгэм соёл, хууль эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хохирогч ийм нөхцтэй учирсан эргэж ирсэн эрэгтэй/эмэгтэй хүний эсрэг хүчирхийлэл

үйлдэгдэж болзошгүй хэмээн сэжиглэвэл (эсвэл сэжиглэх өөр шалтгаан байгаа бол) хохирогчийг хамгаалах өөр хувилбарт арга хэмжээний талаар ярилцаж тухайн эмэгтэй/эрэгтэйн хүслийн дагуу идэвхтэй хэрэгжүүлнэ.

### **5.5.5 БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД**

Эмэгтэйчүүд ХХГХ-ийн хохирогч болсноор тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд ноцтой үр дагавар бий болгодог. Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд нь ихэвчлэн бэлгийн хүчирхийллээс үүдэлтэйгээр хорирсон байдаг. Зарим тохиолдолд эмэгтэйчүүд хүн худалдаах гэмт хэргийн золиос болоогүй ч бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс болж хохирох нь түгээмэл байдаг. Бэлгийн болон нөхөн үржихүйн өвчлөл нь нийгэм, сэтгэл зүй болон бие махбодод сөрөг үр дагаварыг бий болгодог ба эдгээрийг тус бүрд нь мэргэжлийн түвшинд тусламж үйлчилгээ үзүүлснээр эмчлэх нь зүйтэй. Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд бэлгийн замын халдварт ХДХВ авах магадлал өндөр байдаг. Эдгээр халдвартыг илрүүлэх шинжилгээг сайн дурын үндсэн дээр хийлгэхийг санал болгож шаардлагатай гэж үзвэл шинжилгээ өгөхөөс өмнө болон дараа зөвлөлгөө өгнө (ХДХВ/ДОХ-ын тухай хэсгийг харна уу). Шинжилгээ хийх хариуг гаргах үйл явц шуурхай, нууцлалыг хадгалсан байх ёстой.

---

**Эмч нар эмэгтэйчүүдэд шаардлагатай мэдээлэл өгөхдөө тэдний мэддэг хэлээр зан заншлын зохистой хэлбэрийг баримтална. Үүнд:**

- **Бэлгийн эрүүл мэнд, бэлгийн аюулгүй зан үйл ба жирэмслэлтээс хамгаалах арга;**
- **Бэлгийн замаар дамжих халдвартууд, шинж тэмдэг ба ирээдүйд тохиолдож болзошгүй эрсдлүүд;**
- **Нөхөн үржихүйн эрүүл мэнд, төрөхийн өмнөх үеийн тусламж үйлчилгээ;**
- **ХДХВ/ДОХ ба шинжилгээний өмнө болон дараах зөвлөлгөөний талаах мэдээлэл Ерөнхий нөхөн үржихүйн эрхтнүүдийн үйл ажиллагаа ба эмэгтэйчүүдийн эрүүл ахуй Зарим газар эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэдэг талаар**

- (шаардлагатай бол);
- Эрүүл мэндийн болон бэлгийн чиг хандлагаа чөлөөтэй илэрхийлэх эрх.

Гол хамтрагч байгууллагууд шаардлагатай үед хамтран ажиллаж нөхөн үржихүйн болоод бэлгийн эрүүл мэндийн талаарх эмэгтэйчүүдийн мэдлэг, өөрийгөө илэрхийлэхэд чиглэсэн мэдээллийг боловсронгуй болгон сайжруулахад анхаарах. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хувьд тусгайлан анхаарах ёстой хэд хэдэн асуудал байдаг. Тэдгээрийг дор дурьдсан болно.

---

## Жирэмслэлт

Эмч, эмнэлгийн ажилтнууд хувь хүмүүсийн гаргасан төрөхийн өмнөх, болон эх барих үе, төрсний дараа ямар үйлчилгээ авах талаар гаргасан шийдвэрийг нь хүндэтгэн үзэх хэрэгтэй. Энэхүү тусламж үйлчилгээ хүн худалдах үйл явцын бүхий л хугацаанд хийгдэх ёстой байдаг бөгөөд туслалцааг хүн худалдаалах гэмт хэргээс сэргийлэх, хамгаалах аливаа хөтөлбөрийн санхүүжилт болон орон нутгийн хууль эрх зүйн хүрээнд багтаан бололцоотой бүхий л байдлаар үзүүлнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон жирэмсэн эмэгтэйд дараах байдлаар хандана:

- Шүүмжилэн буруутгах зорилгогүй, мэдрэмжтэй хандсан үйлчилгээ үзүүлэх;
- Жирэмслэлтэй холбоотой үзлэг, үйлчилгээг шалтгаангүйгээр хойшлуулахгүй байх;
- Холбогдох зөвлөлтөө, тусламж үйлчилгээ болон нэмэлт туслалцааг хангалттай хэмжээгээр өгөх;
- Аян зам, эх орондоо буцах үйл явц төрхийн өмнөх хүндрэл ялангуяа жирэмслэлт буюу төрөлттэй холбоотой хүндрэл байгааг нь оношилсон, эргэж ирэх улс нь хүндрэлийг шаардлага хангахуйц хэмжээнд эмчлэх боломжгүй гэж үзвэл тухайн улс орноос нь түр явуулахгүй байх.

Хэрэв эмэгтэй жирэмслэлтийг таслах хүсэлт гаргавал хүлээн авагч орны энэ талаарх мэдээлэл, зөвлөгөөг ямар нэг саадгүйгээр

өгч холбогдох тусламж үйлчилгээг авах боломжоор хангасан байна. ДЭМБ-ын тооцоогоор эмнэлгийн бус нөхцөлд хийлгэсэн үр хөндөлтийн улмаас жилд ойролцоогоор 200 000 эмэгтэй нас бардаг ба энэ хувь нь хөгжилтэй оронтой харьцуулахад хөгжиж буй улс оронд илүү өндөр байна. (100 000 үр хөндөлт тутам 330 нас баралт).<sup>34</sup>

## Жирэмслэлтээс сэргийлэх арга

Эмч, эмнэлгийн ажилтнууд хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүмүүст жирэмслэлтээс хамгаалах боломжит аргын талаар зөвлөж жирэмслэлтээс сэргийлэх аргын сонголт, арга техник зэргийг тайлбарласан тухайн зан заншилд нийцсэн ДЭМБ болон НҮБ-ын Хүн амын сангаас баталсан олон улсын стандартын дагуу боловсруулсан эрүүл мэндийн сургалтын холбогдох материалыг тараана.

Олон улс оронд эмэгтэйчүүд тэдний жирэмслэлтэй холбоотой ямар нэг сонголт хийх эрхгүй буюу маш бага эрх эдэлдэг. Жирэмслэлтээс сэргийлэх аргатай холбоотой асуудлыг хүчирхийлэл, заналхийлэл, хууран мэхлэлээс ангид, эмэгтэйчүүд мэдээлэл олж авах эрхийн ерөнхий хүрээнд хөндөн ярина.<sup>35</sup>

## Үргүйдэл

Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудлуудын дунд нэлээд түгээмэл тохиолддог нь хүн худалдаалах гэмт хэргээс үүдэлтэйгээр бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн үргүй болох вий гэсэн айдас юм. Ийм учраас үргүйдэлтэй холбоотой худал болон бодит байдлыг тодруулж түүнчлэн халдвар авсан буюу гэмтэл учирсан бол шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх нь чухал юм.

Хүн худалдах гэмт хэргийг дагалдаж бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал ихэвчлэн яригддаг боловч энэ гэмт хэргийн золиос болсон эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж авах зайлшгүй салбар нь зөвхөн энэ биш юм. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар ажилладаг бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид хохирогчийн

бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд (тухайлбал, бэлгийн замаар дамжих халдвартууд, бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зэрэг)-голчлон анхаарал хандуулж эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлөх зарим асуудлыг орхигдуулдаг юм.

### 5.5.6 БЭЛГИЙН ЦӨӨНХ

Энэхүү ангилалд эрэгтэй хүнтэй бэлгийн харьцаатай эрэгтэй хүмүүс болон эмэгтэй хүмүүстэй бэлгийн харьцаатай эмэгтэй хүмүүс хамаарна. Бэлгийн цөөнх ихэвчлэн нийгмээс тусгаарлагдсан шахагдсан хүмүүс байдаг бөгөөд тэдний энэхүү эмзэг байдал нь эрүүл мэндийн тусгай хэрэгцээнд тохирсон зан үйл, онцгой анхаарлыг шаарддаг. Эдгээр хүмүүсийн ялгаварлан гадуурхагсан тусгаарлагдмал байдал нь тэдний сэтгэцийн эрүүл мэндэд муу нөлөө үзүүлдэг. Хүмүүс тэднийг хүлээн зөвшөөрч, хүндэлж, тухайн хувь хүмүүсийг сонсож буруушаахгүй байна хэмээн тайтгаруулсан байдлаар анхаарал хандуулах хэрэгтэй. Бэлгийн цөөнхийн эрх нь олон улсын хүний эрхийн тухай хуульд заасан үндсэн эрхэд заагдсан байdag.<sup>36</sup>

Бэлгийн цөнхөд багтах хүмүүс ялгаварлан гадуурхагдаж, хүчирхийлэлд өртөх болон бэлгийн чиг хандлагаасаа болон бэлгийн хүчирхийлэлд өртөх нь түгээмэл байдаг. Зарим улсад эмэгтэйчүүдийг лесби чиг хандлагаас нь салгаж “эмчлэхийн тулд” гэр бүлийнх нь зөвшөөрлөөр хүчинддэг. Гомосексууд хүчиндүүлж, доромжлуулж, зодуулах эсвэл амь насаа хөнөөлгөх зэргээр хүчирхийлэлд өртөх нь түгээмэл байдаг.

Хувь хүний чиг хандлагыг өөрчлөх гэсэн ямар нэг оролдлого байж болохгүй. Тийм учраас биологийн хувьд эрэгтэй ч, чиг хандлагын хувьд эмэгтэй хүнтэй эмч эмэгтэй хүн шиг харьцаж эмчилнэ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд биологийн болон хүйс солигдсонтой холбоотой аль аль асуудлыг тооцож үйлчилгээ үзүүлэх нь чухал юм. Хүйс нь солигдсон бэлгийн цөөнх нь гормоны эм бэлдмэл хэрэглэдэг байж болно. Тэд өөрсдийн хэрэглэж буй эм бэлдмэлийн тун эсвэл нэрийг нь мэдэхгүй байж болно. Хувь хүмүүсийн тусгай хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай гормоны жорыг олгох нь эмчийн хүлээх үүрэг хариуцлага юм.

## 5.5.7 ХУДАЛДАГДСАН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮҮХДҮҮД

Худалдагдсан эмэгтэйчүүдийн олонх нь ганц бие эхчүүд байдаг бөгөөд ихэнх тохиолдолд хүүхдүүд нь төрөлх нутагтаа амьдарч байдаг. Гэхдээ эмэгтэйчүүд худалдагдсаныхаа дараа хүүхэд төрүүлж, хүүхдүүд нь эх нь худалдагдсан оронд амьдрах тохиолдол гардаг. Хэрэв хүүхэдтэй эмэгтэй цагдаа буюу цагаачлалын албаны баривчилгаанд өртөж хүүхэд ганцаар хоцорвол эх хүүхэд хоёрын хувьд аль алинд ноцтой асуудал болж хувирдаг. Ялангуяа, зарим тохиолдолд хүний наймаачид хүүхдээс нь өшөө авахаас айх бодит шалтгаанаас болж эхчүүд өөрсдийн хүүхдийнхээ төлөө санаа зовдгыгхүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэрэв хүүхдүүд нь төрөлх орондоо амьдардаг бол эмэгтэйд гэр бүлтэйгээ холбоо барих боломж олгоно. Хүүхдүүд эхтэйгээ хамт нэг оронд амьдардаг бол тусламж үйлчилгээ үзүүлэгч нь худалдагсан эхтэй цагдаа буюу хүүхдийг нь сайн сайхан байгааг нь баталгаажуулахад туслалцаа үзүүлж чадах нийгмийн үйлчилгээ үзүүлдэг бусад холбогдох байгууллагатай холбоо барих талаар зөвшилцнө.

## 5.6 Хүүхэд ба өсвөр насынхан

Хүүхэд болон өсвөр насынхныг янз бүрийн хөдөлмөр эрхлүүлэх болон насанд хүрэгсэд (тухайлбал, үйлдвэрийн ажил, гэрийн үйлчилгээ, биеийг нь үнэлүүлэх болон гэрлүүлэх)-тэй ижил зорилгоор худалддаг. Тэднийг мөн хүүхдэд илүү түгээмэл тохиолддог аргаар мөлждөг. (тухайлбал, садар самуунд уруу татах, уралдааны тэмээ унуулах, гүйлгээ гүйлгах, уурхайд ажиллуулах, эрхтнийг нь авах. Ийм үед хүүхэд хэвийн эрүүл орчинд хөгжих боломжоо алдаж биеийн махбодийн болон сэтгэл зүйн хохирол амсдаг.)<sup>37</sup>

### Хүүхэд бол насанд хүрсэн бяцхан хүн биш

Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүүхдэд туслалцаа үзүүлж буй эмч, эрүүл мэндийн ажилтнууд тэдэнтэй насанд хүрсэн бяцхан хүнтэй харьцаж байгаа юм шиг харьцаж болохгүй бөгөөд ийм хүнд нөхцөлд орсон хүүхдийн тусгай хэрэгцээнд

мэдрэмжтэй хандах хэрэгтэй.<sup>38</sup>

Хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой хүчирхийлэл бие маш бодь, сэтгэхүйн хувьд хөгжих насандaa явaa залуу хүмүүсийн хөгжилд муугаар нөлөөлдөг. Өсвөр насныхан ертөнцийг ойлгох, түүнд өөрсдийн гүйцэтгэх үүргийн талаар ойлголтыг төлөвшүүлж байдаг. Энэ хугацааны туршид олж авсан зан үйлийн хэв маяг насан туршийн амьдралын нь туршид үргэлжлэх хандлагатай байдаг ба өсвөр насныхан өөрсдийн эрсдэлтэй нөхцөл байдлаа бүрэн ухаараагүй байдаг. Ялангуяа, насанд хүрээгүй хүүхэд болон өсвөр насны хүүхэд худалдагдах нь (бэлгийн болон бусад) өөрийгөө тодорхойлох болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрдүүлж эхлэх үеийг нь улам хүндрүүлдэг.

### **5.6.1 ХУДАЛДААЛАГДСАН ХҮҮХЭД БОЛОН ӨСВӨР НАСНЫХНЫГ ХАЛАМЖЛАХ НЬ**

Хүүхэд, өсвөр насныханд нас, хэрэгцээнд нь тохирсосон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нь тэднийг эсэн мэнд амьдрах нөхцлийг бүрдүүлэх эрхийн асуудал төдийгүй Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хүүхдийн дээд эрх ашгийг эн тэргүүнд тавих заалт хүний үндсэн эрхийг хангах асуудал юм.<sup>39</sup> Эмч, эрүүл мэндийн ажилтнууд энэ конвенц болон хүүхдийн эрх, ялангуяа худалдаалагдсан хүүхдийн эрхийг шийдвэрлэхэд чиглэсэн бусад олон улсын холбогдох хууль, зааврын дагуу гаргасан стандартыг мөрднө.<sup>40</sup>

**Хүүхэд, өсвөр насныхан болон залуу хүмүүсийн насны талаарх тодорхойлолт<sup>41</sup>**

**Хүүхдийн эрхийн тухай конвенц - НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан**

<b>Хүүхэд</b>	<b>0-18 нас</b>
<b>Өсвөр насныхан</b>	<b>10-19 нас</b>
<b>Залуучууд</b>	<b>15-24 нас</b>
<b>Залуу хүмүүс</b>	<b>10-24 нас</b>

Улс орон бүрийн хувьд хүүхэд, өсвөр насынхан болон насанд хүрэгсдийн насын талаарх тодорхойлолт өөрчлөгджэй болно. Өсвөр насын хүүхэд насанд хүрсэн хүний үүрэг роль, хариуцлагыг хир зэрэг хүлээж байгаагаар хүүхдийн насын талаарх тухайн улс орны ёс заншлыг харж болдог. Гэхдээ хүүхэд болон өсвөр насын хүүхдийн эмчилгээ, эрүүл мэндийн менежментэд тухайн улс орны буюу бус нутгийн соёл, хууль эрх зүйн тодорхойлолтыг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээтэй зөрчилдөхгүй бол хүндэтгэн авч үзнэ. Эм бэлдмэлийг хүүхдийн эсвэл насанд хүрсэн хүний тунгаар өгөх эсэхийг шийдвэрлэхэд соёлыг харьцуулж үзэх шаардлага байхгүй.

Худалдаалагдсан хүүхэд, өсвөр насын хүүхдийг асрахын тулд:

- Хүндэтгэн үзэж байгаагаа илэрхийлэх хандлагыг хөгжүүлэх, оролцоог сайжруулах;
- Тэдний туулсан амьдрал тэдэнд ямар хор учруулсан тухай төвөгтэй нөхцөл байдлыг ойлгох;
- Насны бүлэг бүрийн хэрэгцээнд таарсан үйлчилгээг тухайн хүүхдийн нас болон хэрэгцээнд тааруулан үзүүлэх бөгөөд насанд хүрэгсдэд зориулсан хөтөлбөрийг хэзээ ч мөрдөхгүй байх;
- Гэмтлийн улмаас бий болсон үр дагаварыг бууруулах болон амьдралын эрүүл хэв маягийг бүрдүүлэхэд чиглэсэн стратегийг хэрэгжүүлэх

## Оролцоо

Олон улсын стандартад хүүхэд өөртөө хамааралтай бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангагдсан байх бөгөөд “хүүхдийн нас болон нас биеээ даах чадвараас нь хамаарч үзэл бодол нь төдий хэмжээгээр үнэлэгдэнэ” (ХЭТК, 12-р зүйл).<sup>42</sup> Энэхүү эрхийг хүндэтгэн үзэж шаардлагатай. Ямар ч тохиолдолд эрүүл мэндийн үзлэг явуулах буюу эмчилгээ хийхдээ эмч, эрүүл мэндийн ажилтнууд хүүхдийн сайн сайхан байдалд нөлөөлөх шийдвэр гаргахад тэднийг оролцох боломжийг нь бүрдүүлэхийн тулд тухайн хүүхдийн түвшинд тохируулан мэдээллээр бүрэн хангах шаардлагтай. Эмч, эрүүл мэндийн ажилтнууд хүүхдийн үзэл бодлыг анхааралтай сонсож, гэр

бүл эсвэл эх нутагтаа буцаж очихтой холбоотой шийдвэрт нухацтайгаар хандана.

**Хүүхэд өсвөр насны хүүхдийг төлөөлөх хууль ёсны асран хамгаалагчийг томилж болно.**

**Анхааруулга:** Зарим тохиолдолд хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч нь түүнийг хүчирхийлдэг, эцэг эх, хамаатан садан нь түүнийг хүний наймаачдад зарсан этгээд байж болно. Ийм учраас хүүхдийн асуудлыг гэр бүлийн гишүүдэд нь дэлгэрэнгүй танилцуулахаас өмнө уг хүүхэд өнгөрсөн хугацаанд хэрхэн хүчирхийлэлд өртөж байсан, хүний наймаачидтай ямар байдлаар холбогдсон талаар болгоомжтойгоор асууж лавлах нь тусlamж үзүүлж буй хүний хувьд чухал юм. Хүүхэд гэр бүлийнхээ (эсхүл хуучин оршин сууж байсан газар) асрамжид буцаж очсоноор хүчирхийлэлд өртөх буюу өртөж байсан гэж үзэх шалтгаан байвал тусlamж үзүүлж буй ажилтан хуулийн зөвлөлгөө авах эсвэл нэр хүнд бүхий нийгмийн ажилтан, хүүхдийн сэтгэл зүйгээр мэргэшсэн хүмүүсийн туслалцааг авна.

(3-р бүлгийн 3.1-ийн Насанд хүрээгүй хүнэх орондоо буцах гэсэн хэсгийг үзнэ үү).

### **Хүүхэд, өсвөр насны эрүүл мэндийн мэргэжилтнүүд**

Худалдаалагдсан хүүхэд болон өсвөр насныханд тусlamж үзүүлэх ажлыг тэдний насанд хурсэн хүмүүсээс тодорхой ялгарах онцгой хэрэгцээний тухай мэдлэг бүхий сургагдсан мэргэжилтнүүд үзүүлнэ.<sup>43</sup> Энэ нь хүүхдийн хөгжил болон өсвөр насныхны эрүүл мэнд анагаах ухааны чиглэлээр бэлтгэгдсэн, эмчийн ур чадварыг шаарддаг. Хэрэв хүүхдийн хүчирхийллийн талаар ажиллах хүн хүчиний нөөц байхгүй бол дайчлан ажиллуулж болох юм.

### **Хүүхдийг мэдээллээр хангаж ярилцлага авах нь**

**Хүүхдийн амь насанд аюул учрахаас бусад тохиолдолд зохих**

## ЗӨВШӨӨРЛИЙГ АВАХ ХҮРТЭЛ ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГ БУЮУ ЭМЧИЛГЭЭ ХИЙХГҮЙ.

Аливаа ярилцлагыг явуулахад мөрддөг өрөнхий заавраас гадна хүүхдэд мэдээлэл олгох болон ярилцлага авахад нэмэлт болон тусгай зарчим, арга техникт дор дурдсан зүйлс орно:

- Ярилцлага эхлэхээс өмнө хүүхдэд тохиолдсон явдлын талаар аль болох ихийг мэдэж ойлгомжтой бөгөөд найрсаг танилцуулгыг хийх (хүүхдийн мэддэг зүйлийн талаар ярих нь харилцан ойлголцлыг бий болгоход тусалдаг).
- Ярилцлага хийхэд аюулгүй бөгөөд тавлаг орчинг бүрдүүл (харилцан ойлголцлыг бий болгоход дөхөм болгох тоглоом, ном зэргийг хэрэглэ).
- Хүн худалдах гэмт хэрэгтэй холбоогүй зүйлийн талаар ярих буюу хийх замаар харилцан ойлголцлыг бий болгох (хүүхдийн мэддэг зүйлийн талаар ярих, тоглоом тоглох гэх мэт).
- Ярилцлага явуулахад хангалттай хугацаа зарцуул, бүү яар.
- Тохиромжтой бөгөөд хүүхдэд ойлгомжтой хэлээр харьцах (хүүхдийн хэрэглэж заншсан нэр томъёог хэрэглэх).
- Аливаа юмыг хүүхэд хялбар ойлгох байдлаар тайлбарла (шаардлагатай бол үзүүлэн ашиглa).
- Уур амьсгалыг энгийн бөгөөд албаны бус байдалд байлгаа (тухайлбал, байцаасан буюу хариулт авахын тулд шахалт үзүүлэх).
- Хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож нээлттэй асуудлаар эхэл. “Тэр хүн чамайг хүчирхийлсэн үү?” зэрэг шууд асуулт тавихаас зайлсхийж “Тэр хүн юу хийсэн?” зэрэг илүү нээлттэй асуултыг асуу.
- Хүүхэд мэддэг бүх зүйлээ ярьсан нь илэрхий байвал илүү дэлгэрэнгүй зүйл яриулах гэж бүү шах. Гэхдээ хэрэв зөв асуулт тавихгүй бол хүүхэд ярихгүй өнгөрч ярилцлага авагчийн сонсохыг хүсэж байгаа гэж тооцсон хариултыг өгнө.
- Хүүхэд ярилцлагыг сайн өгсөн гэж итгүүлэн хэрэв дахин ярих хүсэлтэй бол хэзээд бэлэн гэдгийг ойлгуулснаар ярилцлагыг дуусгана.<sup>44</sup>

### 5.6.2 ХҮҮХДИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ БА ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮР ДАГАВАР

Хүүхдийн хөгжил нь биеийн, танин мэдэхүйн, хэлний, нийгэм-сэтгэл зүйн, темпераментын буюу хөдөлгөөний өрөнхий эвслийн

хөгжлийн түвшнээр тодорхойлогддог. Хүчирхийлэл болон архаг стресс нь хүүхдийн бие махбодод нөлөөлж, сурх үйл явц, өсөлт болон сэтгэл зүйн хөгжилд саад болдог.<sup>45</sup> Худалдагдсан хүүхэд байнгын заналхийллийн дор аюултай орчинд байдаг. Архаг хүчирхийлэл болон стрессийн ийм хэлбэртэй тулгарсан хүүхэд болон өсвөр насны хүүхдийн хувийн зан чанар нь амиа хамгаалах хандлагатай болдог бөгөөд энэ нь хэвийн, аюулгүй нөхцөлд тохиромжгүй эрүүл бус байдлаар хөгждөг.

ДЭМБ-ын судалгаагаар, хүчирхийлэлд өртдөг хүүхэд өөрт нь аюултай заналхийлэлтэй хандаж буй асран хамгаалагчтайгаа сайн харьцаатай байж итгэл төрүүлэх ёстой гэж боддог гэжээ. Байнгын дарамтад байж итгэл алдарсан хүүхэд өөрийн төлөө тэмцэх, эсхүл дотно харьцаа бий болгох чадвар муутай болсон байдаг. Хүүхдүүд асран хамгаалж буй хүн нь дандаа зөв, тэд бүх юмыг сайн мэднэ гэж итгэснээр хүүхдүүд өөсдийгөө байнга буруутах, ямар нэг зүйлийн буруутан хэмээн тоооцдог учраас муу зуршил буюу хийсэн буруу үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой гэж боддог. Хүчирхийллийн улмаас хүүхдийн хөгжилд бэрхшээл учирч энэ нь хүүхэд хүнд итгэл өгч дасахаа болих, итгэлгүй болох, өөрийгөө дутуу үнэлэх болон нийгмээс тусгаарлагдах Зэргээр илэрдэг. Түүнчлэн, хэт сексийн, эсхүл хэт түрэмгий зан авир гаргах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, өөрийгөө гэмтээх буюу стресс, түгшүүрээ зүй бус аргаар шийдвэрлэх гэсэн бэрхшээлүүд гарч ирж болно.<sup>46</sup>

Эмч, эрүүл мэндийн ажилтнууд хүүхэд өсвөр насханы хөгжлийн түвшинд тохирсон эрүүл мэндийг дэмжих, ирээдүйд идэвхтэй, утга учиртай амьдрах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Үүнд, хоол тэхжээл, биеийн болон сэтгэцийн хөгжил, боловсролын зэрэг янз бүрийн хэрэгцээг шийдвэрлэх асуудал багтана.

Гэр бүл дэх хүчирхийлэл, үл тоомсорлох болон хүн худалдах гэмт хэргийн тохиолдлууд

Худалдагдаж байсан хүүхдүүд ихэвчлэн үчирхийлэлтэй буюу хүүхдийн биеийн болон сэтгэцэд уршигтай эсхүл тогтвортгуй орчноос гаралтай байдаг. Хүн худалдах гэмт хэргийн золиос болж буруу замд орсон, хүчирхийлэлд байсан хүүхэд ертөнц болон

бусад хүмүүсийн талаар сөрөг бөгөөд үгүйсгэсэн ойлголттой болсон байдаг.

Худалдагдсан хүмүүсийг орон байраар хангаж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн эмпирик нотолгооноос, худалдагдсан хүүхдийн нэлээд хэсэг нь хүчирхийлэлтэй, салалт, хагацал, эсхүл эцэг эх нь нас барсны улмаас өрх толгойлсон эх/эцэгтэй өрх зэрэг хэвийн бус гэр бүлийн орчин, асрамжийн газар, цагаачлалын төв буюу гэрээсээ оргож гудамжинд амьдарч байсан хүүхдүүд байжээ. Зарим тохиолдолд гэр бүлийн гишүүн нь хүүхдийг худалдсан тохиолдол гардаг.

Хүүхдийн гэрт тулгарч болохээрсдлийг тооцон хүлээн зөвшөөрснөөр аливаа эрүүл мэндийн хэрэгцээнд үнэлэлт өгөхийн тулд эрх бүхий байгууллагын албан тушаалтны талаарх хүүхдийн бодлыг ойлгох, уялдуулах, дахин нэгтгэх төлөвлөлтийн хувилбарт үнэлгээ өгөх нь чухал юм. Дайн, гэмт хэрэг, улс төрийн хэлмэгдүүлэлт, байгалийн гамшиг эсхүл халдварт өвчний үр дүнд хүүхдүүдийн эцэг эх амь насаа алдсан, эсвэл байхгүй бөгөөд худалдагдсан хүүхэд өнчин байж болно. Насанд хүрэгсдийн дунд хүн амын 40 орчим хувь ХДХВ-ийн халдвар авч, олон хүн ДОХ-ын улмаас нас барж байгаа бүс нутагт эцэг эхгүй хүүхдүүдийн бүхэл бүтэн нэг үе хүн худалдах гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй байна.

## Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл

Хүн худалдах гэмт хэргийн золиос болсон насанд хүрэгсдийн нэг адилаар зарим хүүхдүүд худалдаалагдах явцдаа буюу өмнө эсвэл энэ үеүүдэд бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй байдаг. 20 оронд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тархалтын талаар явуулсан судалгаанаас охидын 7-36% нь, хөвгүүдийн 3-29% нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэжээ.<sup>47</sup> Хүн худалдаалах явцад хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөг нь биеэ үнэлэх ажил шууд гүйцэтгэдэггүй хүүхдийн дунд хүртэл түгээмэл байдаг аж.

Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөнөөр эрүүл мэндэд нь шууд болон урт хугацааны туршид ноцтой сөрөг үр дагаварыг бий болгодог ба үүнд бэлгийн замаар дамжих халдвар, бэлэг эрхтний

гэмтэл, ирээдүйд бэлгийн харьцаанд учрах эрсдэл, мансууруулах бодис хэрэглэх, эрүүл бэлгийн харьцааг хөгжүүлэхэд бэрхшээлтэй байх, сэтгэл гутралд орох, амиа егүүтгэх зэрэг ордог байна.<sup>48</sup> Бэлгийн хүчирхийлэл нь хүүхэд, ялангуяа өсвөр наснаас өмнө болон өсвөр насандаа өөрсдийн бие махбодь, өөрсдийн үнэлэмж болон бусадтай харьцах харилцаагаа хүлээж авах ойлголтод нөлөө үзүүлдэг (Сэтгэцийн эрүүл мэндэд хандуулах онцгой анхаарал, 5.5 болон 5.6-р хэсгүүд). Хүйс, бэлгийн асуудлын талаар өөрсдийн ойлголт, зан үйлийг судалж, хөгжүүлж байдаг өсвөр насны хүүхдүүдийн хувьд секс болон бэлгийн харьцааны талаар зэрлэг, хүчирхийлэл хэрэглэн танилцуулснаар ирээдүйн харилцаа болон амьдралын хэв маягт нь уршигтай байдлыг бий болгодог.<sup>49</sup>

Хүүхэд бэлгийн хүчирхийллийн талаар бусдад мэдэгдэх гэхээр гэмшил төрөх, өөрсдөө төвөгтэй хүүхэд гэдэгтээ итгэсэн, хүчирхийлэгчийг хамгаалах хэрэгцээ, бусдад хэлүүлэхгүй байхын тулд хүчирхийлэгчийн зүгээс өгсөн анхааруулга, тоохгүй эсвэл өшөө авна гэсэн айдастай байдаг зэрэг нь саад болдог. Хүүхдуудтэй бэлгийн хүчирхийллийн тухай ярилцлагыг хүүхдүүдтэй бэлгийн хүчирхийллийн талаар ярих тусгай техник эзэмшиж бэлтгэгдсэн мэргэжилтнүүд илүү сайн явуулдаг. Дотоод нөөц бололцоо муу, туршлагатай эмч байхгүй тохиолдолд ярилцлагыг хүүхэдтэй харилцан ойлголцол бүхий харилцаа тогтоосон хүн болгоомжтой хийнэ.

### 5.6.3 ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН

Сэтгэцийн эрүүл мэндийн зохих тусlamж үйлчилгээг тодорхойлоход нас хамгийн чухал хүчин зүйл болдог. Хүчирхийлэлд автсан хүүхдүүд өөрсдийн амьдралын тогтолцоо болон зан үйлээ тулгарч буй нөхцөлд тохируулж дасан зохицдог. Гэмтэл болон хүчирхийллийн асуудлаар мэргэшсэн нэг шинжээчийн тайлбарласнаар хүчирхийлэл үүссэн нөхцөлд хүүхэд “итгэж үл болох хүмүүст итгэх итгэлээ хадгалах арга замыг эрэлхийлэх, аюултай орчинд аюулгүй байх, урьдчилан таамаглахын аргагүй нөхцөлд хяналт тавих, ямар ч туслалцаа авах боломжгүй үед хүчтэй байх ёстой”. Өөрөө өөртөө анхаарал тавьж чадахгүй тул хүүхэд насанд хүрэгсдийн зүгээс авч чадаагүй

анхаарал, хамгаалалтыг зөвхөн өөрөө өөрийгөө авч явах, сэтгэл зүйн хамгаалалтын боловсроогүй системээр орлуулах ёстой.”<sup>50</sup>

Сурч боловсрох нь хүүхдийн хөгжлийн нэг чухал асуудал байдаг. Аль болох хурдан хүүхдийг сургалтанд хамруулах, хувиар нь багш авах эсхүл орон нутгийн сургуулийн хөтөлбөрт хүүхдийг хамруулах зэрээр (тохиромжтой бөгөөд аюулгүй үед) сургалтанд хамруулах хэрэгтэй. Боломжтой, тохиромжтой гэж үзвэл үе тэнгийн хүүхдүүдээр зөвлөлгөө өгүүлэх болон үе тэнгийн сургалтын арга техникийг анхаарч үзэх хэрэгтэй.

## **5.7 ХХГХ-ийн хохирогчдод тусlamж үзүүлэхдээ анхаарах сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд**

### **5.7.1 Сэтгэцийн өвчлөл**

Сэтгэцийн эрүүл мэнд болон сэтгэцийн өвчлөл нь тасралтгүй гинжин холбоонд тооцогддог учраас тодорхойлоход төвөгтэй асуудлууд юм. ДЭМБ-ын санал болгосноор сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголтод дор дурдсан зүйлс багтана:

(...) хүний сайн сайхан байдал, ажлын бүтээмж, өөрийгөө жлоодох, ур чадвар, өмнөх үеэс хамааралтай байх, хүний оюуны болон сэтгэл санааны боломжийн хувьд өөрийгөө бататгах. Зан заншилтай холбоотой сэтгэцийн эрүүл мэндийг олон талаас нь тодорхойлох бараг боломжгүй юм.<sup>51</sup>

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас тодорхойлсны дагуу сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг илүү өргөн утгаар нь, тухайлбал, сэтгэцийн эмгэгийн дутагдлаас илүү өргөн бөгөөд сэтгэл мэдрэлийн тусlamж үйлчилгээтэй утга ижил бус гэж ойлгож болно. “Сэтгэц-нийгмийн аргачлал”-ыг сэтгэцийн сайхан байдлыг ойлгож, түүнтэй холбоотой асуулдлыг шийдэх онцгой арга хэмээн тодорхойлжээ. Сэтгэц-нийгмийн аргачлалыг хэрэглэснээр нийгэм болон зан заншлын хүчин зүйлийг холбогч холбоос, “сэтгэл мэдрэл” буюу илүү өргөн хүрээнд сэтгэцийн сайхан байдалд нөлөөлнө. Энэ нь, хувь хүний үйлдлийг ойлгохын тулд хувь хүнийг гэр бүл, хамт олон буюу зан заншлыг багтаасан

хам утгаар нь авч үзэх хэрэгтэй гэсэн үг юм. Сэтгэц-нийгийн аргачлал нь хувь хүний сэтгэцийн сайн сайхан байдал буюу хүрээлэн буй нийгмийн хүчин зүйл рүү чиглэсэн ямар нэг үйлдэл хийснээр эргээд нөлөөнд автах бүлэгт нөлөөлнө.<sup>52</sup>

Одоогийн байдлаар сэтгэцийн эрүүл мэнд болон хүн худалдах гэмт хэргийн талаар хангалттай судалгаа хийгдээгүй байна. Худалдагдсан хүний сэтгэцийн хариу үйлдлийн талаар мэдэгдэж байгаа зүйл гэвэл худалдагдсан хүмүүстэй ажилладаг байгууллагын тайлан, худалдагдсан хүмүүс болон маш цөөхөн хэдий ч чанартай судалгаа юм.

## 5.7.2 ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХҮРЭЭН ДЭХ СЭТГЭЦИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ДАРАМТ

Сэтгэцийн хүчирхийлэл болон дарамт нь худалдагдсан хүмүүсийн хувьд ялгарах зүйл нь болдог ба хувь хүмүүсийг эрхшээлдээ оруулан идэвхтэйгээр барьцаалахын тулд хүний наймаачдын хэрэглэдэг үндсэн тактик арга нь юм. Сэтгэцийг хяналтанд байлгах тактик аргад айлган сүрдүүлж, заналхийлэх, хуурах мэхлэх, сэтгэл санаагаар эрхшээлдээ оруулах, аюултай, урьдчилан таамаглах, хяналт тавих боломжгүй нөхцөлд оруулах явдал ордог. Ийм сэтгэцийн хүчирхийлэл нь ихэвчлэн арилахгүй, туйлын ноцтой, хувь хүний сэтгэцийн болон бие махбодийн хамгалалтыг сүйтгэхэд хэрэглэгддэг. Эхлээд хувь хүнийг “амьд үлдэхэд туйлын хүнд нөхцөл”-д оруулж амь насаа алдах аюулыг бодитой болгосноор хувь хүн хувийн аюулгүй байдалдаа тавих хяналтаа алдаж хүн худалдаалагчдын олз болсноо ухаардаг. Хоёр дахь шатанд хүн “бие махбоды”-ийн хувьд доройтдог, Хувь хүмүүсийг олон цаг, өдрөөр ажиллуулснаар эзний хяналтыг чангараулдаг (мөн орлого өсөн нэмэгдэнэ). Ямар ч амрах цаггүй ажилласан хүн сульдаж ямар нэг хувилбар бодож үзэх буюу хамгаалалтын стратеги боловсруулах чадваргүй болдог. Хамааралтай байдлыг үүсгэх хамгийн эцсийн элементүүд нь хяналт ба тусгаарлалт юм. Олзлогч-олзлогдсон хүний нөхцөлд зөвхөн худалдаачинтай бодит харьцааг үүсгэх бөгөөд хувь хүн хорвоо ертөнц болон өөрийнхөө талаар өөрийн бий болгосон гаж ертөнцийн нөлөөгөөр хүлээн авдаг.<sup>53</sup>

### 5.7.3 СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ БОЛОН ХАМААРАЛ

Олон дахин худалдагдаг хүн ямар нэг байдлаар сэтгэцэд нөлөөлөх бодист донтох буюу зүй бусаар хэрэглэх явдал тохиолддог ба улмаар химиин бодисын хамааралтай болж болно. Хүн хулгайлах буюу хулгайлсан хүнийг хянахын тулд хүний наймаачид ихэвчлэн хар тамхи болон архийг хэрэглэдэг. Донтуулагч бодисыг зөвхөн хувь хүнийг илүү дуулгавартай байлгахаар хэрэглээд зогсохгүй байнгын хэрэглээ нь хамаарлыг бий болгож донтсон хүн худалдаачдыг нийлүүлэгчээ хэмээн тооцоход хүргэнэ. Эмэгтэйчүүдийг хүчээр биесийг нь үнэлүүлэхдээ анхны үйлчлүүлэгчтэй нь илүү хүлцэнгүй байлгах зорилгоор хэрэглэж болно. Хар тамхийг хууль бус эсвэл хуулийн дагуу, хүчээр эсвэл сайн дурын үндсэн дээр хэрэглэхдээ хувь хүнийг илүү олон цаг ажиллах чадварыг нь нэмэгдүүлэх, хүнд ажил хийлгэх (буюу биес үнэлэх ажил дээр илүү олон үйлчлүүлэгчид үйлчлэх), хүчирхийлэл бүхий нөхцөл, харьцааг үргэлжлүүлэх, доромжилсон буюу дур гутам байдлыг тэвчих, эсвэл тухайн хүнийг гэмтэл болон стрессстэй нөхцлийг мэдрэхгүй болоход нь туслах зорилгоор хэрэглэдэг. Худалдагдсан хүнтэй ажиллаж буй эмч нар хувь хүн химиин бодисын хамаарал бий болох шалтгааны талаар мэдлэгтэй бөгөөд холбогдох шинж тэмдгийг нь ойлгодог байх ёстой. Худалдагдсан хүн химиин бодисын хамааралтай холбоотой асуудлаа бусдад мэдэгдэх буюу ажилтан асуудал байгаа хэмээн сэжиглэвэл хувь хүнийг тусгай бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтан руу шилжүүлнэ.

### 5.7.4 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХАЛАМЖИНД БАЙХАД ҮҮСЭХ ДАРАМТЫН ШАЛТГААН

Хүн худалдаалах гэмт хэргээс хол, тусламж үйлчилгээ үзүүлэгчийн халамжинд байснаар олон арга замаар сэтгэцийн хувьд тайвшрах хэдий ч, энэхүү нөхцөл нь өөр хурцадмал байдлыг шинээр үүсгэж болно. Хамгийн түгээмэл тохиолддог дарамт үүсэх шалтгааныг дор дурдав.

**Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай ярилцлага хийх.** Цагдаа буюу цагаачлалын албатай уулзах нь худалдагдсан

хүний хувьд олон талаараа дарамт үүсгэдэг. Олон хүн тэднийг сэжиглэж байна эсвэл баривчлагдах вий, тэдэнд итгэхгүй байх вий хэмээн үндэслэлтэйгээр айх, байцаалт буюу мөрдөн байцаалтын төвөтгэй бөгөөд хүнд нөхцлөөс аиж түгших, эрх нь байгаа учраас буруу хариулсны улмаас тэдний ирээдүй үндсээрээ өөрчлөгднө хэмээн түгших (тухайлбал цагаачлах эрх, хүн наймаалагчдын зүгээс өшөө авах), ой санамжкаа алдах буюу гол зүйлүүдийг эргэн санах чадваргүй болох, хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудаас өмнө нь аиж байсан болон үл итгэдэг (хээль хахуульд автсан буюу аюултай албан хаагчтай таарч байсан эсвэл төсөөлж байсантай холбоотой).

Эмч нар хувь хүмүүсийг хууль хэрэгжүүлэгч албаны хүмүүстэй уулзах бэлтгэл болгож уулзалтын мөн чанар, асууж болзошгүй асуулт, энэ нь тэдний ирээдүйд хэрхэн нөлөөлөх буюу нөлөөлөхгүй вэ гэдэг талаар тайлбарлах үүрэгтэй.

**Мэдүүлэг өгөх ба эрүүгийн гэрч болох.** Мэдүүлэг өгөхөөр хүлээх болон хүний наймаачдын эсрэг мэдүүлэг өгөх нь худалдагдсан хүнийг сэтгэл зүйн хувьд их дарамтанд оруулдаг. Эдгэрээр үйл явдал нь тухайн худалдагдсан хүн эдгэрээд ямар шатанд хүрсэн байснаас үл хамааран дахин цочролд оруулж болно. Туршлагатай хүмүүсийг хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон хүмүүсийг болох шүүх хуралд бэлдүүлэхээр томилдог. Боломжтой тохиолдолд орон нутгийн хуулийн дагуу мэргэжлийн эмч, хүмүүсийг шүүх хурал дээр гэрчээр орох, асууж болох асуултыг нь ойлгоход нь туслалцаа үзүүлнэ (ялангуяа их түрэмгий болон буруутгасан өмгөөллийн арга хэрэглэж болзошгүй тохиолдолд).

**Цагаачлалын албанд өргөдөл гаргах процесс.** Тухайн улсад оршин суух хууль ёсны зөвшөөрөл байхгүй бол худалдагдсан хүн түгшиж ирээдүйд нь бие махбодийн болон сэтгэцийн хувьд хөрөнгө оруулалт хийхээс өөрсдийгээ хамгаалдаг. Энэ нь хувь хүний тогтвортой байх мэдрэмжийг бууруулж, тэд өөрсдийн амьдралдаа тавих хяналтаа алджээ гэсэн сэтгэгдлийг нэмэгдүүлдэг.

**Гэр бүл болон хүүхдүүдтэйгээ ярилцах нь.** Гэртээ байгаа хайртай хүмүүстэйгээ утсаар ярих нь сэтгэлийг нь тайвшуулж таатай байдлыг үүсгэж болох хэдий ч энэ нь зарим хүмүүсийг

гунигтай, ганцаардмал эсвэл хол газар яваадаа гэмших сэтгэлийг төрүүлдэг. Заримдаа гэр бүлийн гишүүд нь хатуу ширүүн хандаж буруутгах тохиолдол гардаг. Эдгээр ярилцлага нь маш их сэтгэл хөдөлгөм байдаг гэдгийг ойлгож, ойр дотны хүмүүстэйгээ холбоо барьсны дараа дэмжлэг үзүүлэхэд бэлэн гэдгээ харуулах хэрэгтэй.

**Эмчилгээ, шинжилгээний хариу.** Эмчилгээ хийлгэх явцад шинжилгээний хариу авах нь хүмүүсийг, ялангуяа барууны хэв маяг бүхий эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо буюу клиник эмнэлгийн орчинд эмчлүүлж үзээгүй хүмүүст айdas төрүүлж болно. Тухайн байгууллага, эмчилгээний ёс журмын дагуу хүмүүст юу хэлсэн, эсвэл юу болоод байгааг ойлгоогүй, шинжилгээний хариу муу гарна гэсэн сэжиг зэрэг нь айdas төрүүлдэг учраас юу болоод байгаа тухай тайлбарлах, айдсыг нь бууруулахад туслах хүнийг байлцуулах шаардлагыг үүсгэдэг.

**Цагаачлалын/орон байраар хангах байгууллага дахь зөрчил буюу гуниг.** Орон байраар хангадаг байгууллага нь олон шалтгааны улмаас сэтгэл зүйн дарамтыг үүсгэдэг (янз бүрийн нөхцөлд цочролд орсон хүмүүс нэг дордоо амьдардаг, угсаа болон зан заншлын хувьд өөр өөр хүмүүс зэрэгцэн амьдрах, хөдөлгөөн буюу зан үйлд хязгаар тавигдах, цаг удаан өнгөрч уйтгартай байх гэх мэт). Хүмүүс чөлөөт цагаа өнгөрүүлэх болон хурдан өнгөрөх түгшүүртэй байдлыг тайвшируулахын тулд эрүүл бус байдлаар амьдардаг (тамхи татах, зөрчил үүсгэх, хөтөлбөрийг орхин явах). Оршин суугчдыг биеийн тамирын арга хэмжээ нд оролцуулах боломжийг нь бүрдүүлэх замаар эмч нар эдгээр асуудлуудаас бололцоотой хэмжээ (тухайлбал, гадуур алхах, дасгал хийх зэрэг)-нд сэргийлэх арга хэмжээ авах ба үүний хажуугаар хамгаалалтын асуудал, оюун ухааныг тогтмол өдөөх болон үзвэр үйлчилгээ (оловсролын болон үзвэр үйлчилгээний тухай ном, радио, тоглоом) зэргийг анхаарч үзнэ. Оргнуулах газар өөр ямар үйл ажиллагаа явуулж болох боломжтойг 4-р бүлгээс харна уу.

**Буцах.** Гэртээ харих нь худалдаалагдсан хүнд айdas, түгшүүр, стресс, гуниг буюу уур төрүүлж болох ба тэд өшөө авалт, гэр бүлийнхээ нэр хүндийг унагасан гэж бодох, өөрийгөө болон гэр бүлээ тэжээхийн тулд ажил буюу мөнгө хэрхэн олох вэ хэмээн санаагаа зовоодог. Эх орон руугаа буцах хувь хүнд сэтгэл

санааны дэмжлэг үзүүлэх хүмүүс тэдэнд гэртээ харихад нь туслах зорилгоор аль болох их хугацааг зориулах хэрэгтэй. Энэ нь гэртээ харихдаа ямархуу сэтгэгдэлтэй байгааг нь судлах, хэнтэйгээ амьдрах вэ гэдэг асуудлаа анхаарах, ямар ажил хийх вэ гэдгээ шийдвэр гаргахад нь туслалцаа үзүүлнэ гэсэн үг юм. Худалдагдсан хүмүүсийн олонх нь тэдний сэтгэцийн болон бие махбодийн эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон тусламж үйлчилгээг тодорхойлоход нь туслана гэсэн үг юм (Энэ бүлгийн 5.13 болон 5.14-р хэсгүүдийг үзнэ үү).

Хохирогч эх орондоо буцахдаа дамжин өнгөрөх үед буюу онгоц, галт тэргээр эсвэл дамжин өнгөрөхөөр хүлээлгэйт байхад илүү их дарамтанд ордог. Хохирогч сэтгэлээ тайвшруулах, дарамтнаас гарахыг хичээдэг ба согтууруулах ундаа хэрэглэж, согтох нь бий. Онгоц болоод тээврийн бусад хэрэгсэлд согтууруулах ундаа хэрэглэхийг зөвшөөрдөг ч согтотлоо ууна гэдэг нисэх онгоцны компаниудад хүндрэл учруулж байгаа хэрэг (зарим тохиолдолд биеэ аюултай байдлаар авч явсан хэрэгээр хуулийн дагуу шийтгэл ногдуулдаг) төдийгүй онгоц газардахад тухайн хүнд туслалцаа үзүүлэхэд хэцүү байдаг.

## 5.8 ХДХВ ба ДОХ

ХДХВ, ДОХ-ын талаарх буруу ойлголтоос болж эрүүл мэндийн үйлчилгэнд хүндрэл гарч улмаар өвчтөн болон ажилтнууд аль аль хямралд ордог. Хохирогчид ХДХВ-н халдварт авсан байх магадлал өндөр тул ажилтнуудад уг вирус болон ДОХ-ыг биологи, сэтгэхүй, нийгмийн байдлын талаас нь тайлбарлаж өгөх хэрэгтэй. (Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас гаргасан ХДХВ болон ДОХ-ын талаарх материалууд, мөн энэ гарын авлагын Эрүүл Мэнд гэсэн бүлэгт жагсаасан бүтээлүүдийг харна уу).<sup>54</sup>

### ЯАГААД ХДХВ БОЛОН ДОХ-ЫН ТАЛААР МЭДЛЭГТЭЙ БАЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

ДОХ-ыг үүсгэдэг ХДХВ вирусын халдварт авч буй хүний тоо жил ирэх тусам өссөөр байна. Нийгмийн анги давхрага, үндэс угсаа,

гарал үүсэл, шашин шүтлэг, нас хүйс, бэлгийн хандлагаас үл хамааран хэн ч энэ вирусын халдварт авч болзошгүй. Тиймээс хүн бүрт ХДХВ болон ДОХ-н талаар мэдээлэл өгч, өөрсдийгтэй болон бусдыг хэрхэн хамгаалах тухай ойлголттой болгох хэрэгтэй. Өрөвдөн хайлаж, ойлгон тусладаг орчин бүрдүүлэн, айdas хүйдэс, ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх хамгийн оновчтой арга бол ХДХВ болон ДОХ-н талаар зөв ойлголт өгөх явдал юм.

## ХДХВ ГЭЖ ЮУ ВЭ?

- ХДХВ гэдэг нь Human Immunodeficiency Virus буюу Хүний Дархлал Хомсдолын Вирус гэсэн утгатай товчлол
- ХДХВ нь бэлгийн болон цус солилцооны замаар халдвартладаг.
- ХДХВ вирусээр халдварт авсан хүн нь амьдралынхаа туршуулж вирусыг тээнэ. Хичнээн эрүүл саруул харагдаж байсан ч бусдад халдвартараасаар байдаг.
- ХДХВ-ийн халдварт эдгэршгүй бөгөөд үүнийг эмчлэх эмчилгээ эсвэл вакцин одоогоор гаргаагүй байна
- ХДХВ нь хараахан ДОХ биш боловч, энэ өвчнийг идэвхжүүлж чаддаг.

## ДОХ ГЭЖ ЮУ ВЭ?

- Хүний биед орсон ХДХВ биднийг янз бүрийн халдвараас хамгаалж байдаг дархлалын системийг гэмтээдэг
- ДОХ гэдэг нь Дархлал Олдмолын Хам Шинж гэдэг үгийн товчлол. Энэ нь ХДХВ-н халдварт авснаас үүсч болзошгүй бүлэг өвчин (шинж тэмдэг) юм.<sup>55</sup>
- ХДХВ-н халдварт авсан хүмүүсийн ихэнх нь яваандаа ДОХ-оор өвчилдөг. Гэхдээ энэ вирусын халдварт авсан хүний дархлалын систем удаан хугацаанд, олон жилээр супрахгүй эсвэл хомсдохгүй байх тохиолдол бий. Халдварт авсан бол хүний бие яваандаа халдвартай урьдынх шигээ тэмцэж чадахаа больж улмаар ДОХ-оор өвчилнө.<sup>56</sup>

## ХҮН ЯМАР ЗАМААР ХДХВ ХАЛДВАР АВДАГ ВЭ?

- ХДХВ-гаар халдвартлах хамгийн түгээмэл зам бол халдвартай хүнтэй бэлгийн хавьталд орох явдал юм.
- Вирус мөн тариураар дамжин хүнээс хүнд халдвартлах боломжтой. Тухайлбал: тариурыг дахин ашиглахад. Халдвартай цус болон цусан бүтээгдэхүүнээр дамжин халдвартлана. Гэхдээ донорын цусыг системтэйгээр шинжилдэг орнуудад энэ төрлийн халдварталт тун ховор болсон.
- Халдвартай жирэмсэн эхчүүд жирэмсний үедээ болон хөхөөр хооллох үедээ хүүхэддээ ХДХВ-г халдаах боломжтой.
- Хүн мөн ариутгаагүй зүү, хутга, татуурга гэх мэт хэрэгслийг ашиглах үедээ биеэ эсгэн цус гаргах үед ХДХВ вирусын халдвар авах магадлалтай.

Халдвартлах авсан хүнтэй ердийн байдлаар хүрч, харилцсанаар ХДХВ-н халдвартлах боломжгүй.<sup>57</sup> Ариун цэврийн цааснаас нь хэрэглэх, шүршүүрт нь орох, аяга таваг, гол тогооных нь хэрэгсэл, гар утсыг нь ашиглалаа гээд халдвартлахгүй. Хөлс, нулимс, ханиалгах, найтаалгах эсвэл шээсээр халдвартлах боломжгүй. Хорхой шавьж, шумууланд хазуулснаар халдвартлах боломжихгүй. ХДХВ тээгч хүнийг тэвэрсэн учраас халдвартлах авсан хүн ганц ч байхгүй.

## ХҮН ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ХДХВ-ГЭЭС ХАМГААЛЖ ЧАДАХ ВЭ?

Бэлгийн замаар вирусын халдвартлах явдлаас сэргийлэх аргуудад:

- Бэлгийн харьцаанд орохдоо хавьтахгүй байх
- Халдвартлах тээгээгүй, бусадтай хавьталд ордоггүй бэлгийн нэг л хамтрагчтай байх
- Бэлгэвчийг зохих байдлаар нь хэрэглэх
- Хүний цусанд хүрсэн зүү тариур бусад багажийг ашиглахгүй байх эсвэл ариутгасан эсэхийг нь нягталж байх.

## ХДХВ-ГИЙН ШИНЖИЛГЭЭ ӨГӨХ ТУХАЙД

Цусны шинжилгээгээр нь тухайн хүн ХДХВ-н халдвартлах авсан

Эсэхийг тогтоох боломжтой. Халдварт авсан эсэхээ мэдэж авсан хүн өөрийгөө болон бусдыг хамгаалж, эрүүл мэндийн байдал болон ирээдүйнхээ талаар илүү тодорхой шийдвэр гаргах боломжтой болно.

Хүн ХДХВ халдварт авснаа мэдснээр зарим сөрөг үр дагаврууд гардаг. Стрессд илүү гүн орж, бусадтай харилцах харилцааных нь хувь заяа тодорхойгүй, хүнд байдалтай учирна. Хэрэв хэн нэгэнтэй шинжилгээний үр дүнгийн талаар ярилцаагүй бол цаашид энэ нууцыг хадгалах зүдэрдэг. Энэ тухай ярьснаасаа болж ичгүүртэй байдалд орон, бусдад адлагдан гадуурхагдаж ч магад. ХДХВ тээгч гэдэг нь батлагдвал олон хоригт тушигдаж болзошгүй. Тухайлбал: цагаачлах, гадуур чөлөөтэй явах эрх нь хязгаарлагдаж, ажил эрхлэх эсвэл эрүүл мэндийн даатгал хамрагдах боломжгүй болно.

Тиймээс ХДХВ-н шинжилгээ өгөх эсэх тухайгаа нухацтай ярилцсаны үндсэн дээр сайн дураар шийдвэр гаргана. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас туслалцаа авч байгаа хохирогч охид эмэгтэйчүүдэд зохих зөвлөлгөө өгсний дараа тэд шинжилгээ өгөх шийдвэр гаргавал Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага вирусын болон эрүүл мэнд, нөхөн үржихүйн шинжилгээ хийлгэх мөн сэтгэл судлалын зөвлөлгөө авах хүсэлт гаргана.

---

**Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь ХХГХ-ийн хохирогчид ХДХВ шинжилгээ хийлгэх сайн дурын шийдвэрийг дэмждэг.**

**Зарим орнууд нутагтаа эргэн ирж байгаа хохирогчдоос ХДХВ-н шинжилгээ шаарддаг. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь вирусын шинжилгээ хийх талаарх зөвлөлгөөг өгдөг бөгөөд ХДХВ шинжилгээг хохирогчдыг нутагт нь буцаах үйл ажиллагаанд оролцдоггүй байгууллагауд хийнэ. Ингэхдээ ажилтан тухайн хүний эрүүл мэндийн талаарх мэдээллийг хадгалах үүргээ зөрчихгүй бөгөөд хүлээн авч байгаа тухайн улсын эрх баригчдад энэ тухай мэдээлэх үүргийг хүлээхгүй.**

**Түүнчлэн хүлээн авч байгаа орноос гадна байгаа агентлагууд тухайн хүний ХДХВ статусын талаар мэдээллэх үүрэг хүлээж**

байгаа учраас, энэ вирусын гэнэтийн шинжилгээг дамжин өнгөрөх мөн хүлээн авч байгаа оронд хийлгэхгүй байх нь дээр гэж Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага зөвлөж байна. Үүний оронд хүлээн авч байгаа орон тэднийг найрсагаар угтан авах учиртай. Нутаг руу хүргэж өгөхийн өмнө ХДХВ шинжилгээ хийлгэх тухай зөвлөгөөг шинжилгээний өмнө мөн дараа нь өгдөг.

---

## ХДХВ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨМНӨХ БА ДАРААХ ЗӨВЛӨГӨӨ

ХДХВ шинжилгээ хийхээс өмнө мэргэжлийн зөвлөгөөг заавал өгөх хэрэгтэй. Тухайн хүнийг зөвшөөрсний дараа шинжилгээг хийнэ. Шинжилгээ хийсний дараа хүн болгонд тэдний дотор хохирогчид мөн халдвартай нь тогтоогдсон хүмүүст мэргэжлийн зөвлөгөө өгөх ёстой. Харин шинжилгээгээр тээгч болох нь батлагдсан хүмүүст шаардлагатай хугацаагаар, найдвартай, мэргэжлийн зөвлөгөөг давтан өгнө.

ХДХВ болон ДОХ-ын шинжилгээний өмнөх болон дараах зөвлөгөө өгөхийн гол зорилго нь:

- Цагаач иргэд болон хохирогчдод шинжилгээний үр дүнгийн талаар бүрэн дүүрэн ойлголт өгөх
- Бусдад ХДХВ халдаахаас зайлсхийх ёстой гэдгийг халдвартээгч хүмүүст ухамсарлуулах
- Бусдад ХДХВ халдаахаас хэрхэн зайлсхийх тухай ойлгуулах<sup>58</sup>

## ХДХВ-Г ЭМЧЛЭХ

ХДХВ тээгчид өөрсдийнхөө төлөө санаа тавьж чадвал эмчийн тусгай хяналтуулжээр олон жил эрүүл саруул явж чадна. Тухайлбал: тэжээллэг хоол хүнс хэрэглэн, хангалттай амарч, хувийн эрүүл ахуйг сахихдаа идэвхтэй байх ёстой. ХДХВ тээгч гэдгээ мэддэг хүмүүс янз бүрийн өвчний халдварт болон ХДХВ-тай холбогдсон бусад нөхцөл байдалд зохистой эмчилгээ авч чаддаг.

Хөгжингүй орнуудад 1996 оноос хойш вирусын эсрэг эмчилгээ хийгдэж эхэлсэн. Энэ үр дүнтэй эмчилгээ удахгүй хөгжиж байгаа

орнуудад хэрэгжиж эхлэх найдвар байгаа юм. Уг эмчилгээний талаарх мэдлэг, туршлага газар сайгүй хурдацтай хэрэгжиж байна. Гэхдээ вирусын эмчилгээ нь хөндлөнгийн бусад үр дагавар өгч болзошгүй учраас байнгын хяналтанд урт хугацаанд хийгдэх ёстой. Түүнчлэн эмчилгээ буруу хийгдвэл ХДХВ вирус улам боловсронгуй болж, эмийн үйлчилгээг эсэргүүцэх чадвартай болох аюултай.

## **ХҮҮХДҮҮД ХДХВ/ ДОХ-Д АМАРХАН ӨРТӨЖ БОЛЗОШГҮЙ**

Нийгмийн давхаргаасаа болоод хүүхдүүд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлал маш өндөр байдаг. Энэ утгаараа хүүхэд ХДХВ-н халдвар авах магадлал өндөр юм. Дэлхий дахинд ХДХВ болон ДОХ-ын аюул өсөн нэмэгдэж байгаа ч үүний улмаас тээгч байх эрсдэл багатай залуухан охидтой бэлгийн харьцаанд орох хүсэл сонирхол нэмэгдэж байгаа юм. Мөн зарим орнуудад онгон охинтой хавьтвал ХДХВ, ДОХ болон бусад БЗХӨ-нөөс салдаг гэсэн ойлголт нилээд тархжээ. Энэ шалтгааны золиос болсон хүүхдүүд олон удаа БЗХӨ-н тусах, мөн гүйцэд эмчлүүлээгүйгээс болж ХДХВ-ээр халдварлах эрсдэл их байна.

Хүүхэдтэй ажиллах дадлага туршлагатай, тэдний насанд тохирсон эмчилгээ хийх эмч ХДХВ-н шинжилгээ хийлгэх зөвлөгөөг хүүхдэд өгөх ёстой. Харин насанд хүрэгчдийн хувьд сайн дураар зөвшөөрсөн тохиолдолд ХДХВ-ийн шинжилгээ хийгдэнэ. (Энэ бүлгийн 5.6 хэсгийг үзнэ үү)

## **ЭХЭЭС ХҮҮХДЭД ХАЛДВАРЛАХ**

Хүүхдээ төрүүлэхээс нь өмнө эмчилгээ хийснээр ХДХВ эхээс үрд халдварлах магадлалыг эрс буруулах боломжтой юм. Жирэмсэн эх ХДХВ тээгч гэдэг нь батлагдсан тохиолдолд эмч нар түүнд заавал эмчилгээ хийнэ гэдгийг хэлж ойлгуулах хэрэгтэй. Хэрэв тухайн эмэгтэйг өөр хэсэг рүү шилжүүлэх гэж байгаа бол мөн тэнд нь эрүүл амаржих нөхцөл бага бол ажилтан эх үрийг эрүүл саруул байлгах, шаардлагатай эмчилгээ хийх өөр бусад хувилбаруудыг (хууль ёсны эмчилгээнүүд) судална.

## 5.9 Хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусlamжийн эрүүл мэнд-хууль эрх зүйн хүчин зүйл

ХХГХ-ийн хохирогч болсон хүмүүстэй ажиллаж байгаа ажилтнууд хохирогчид үзүүлэх эмнэлгийн болон хууль эрх зүйн тусlamжийн талаар санаа тавих ёстой. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээлэл хохирогчдод олгогдсон хууль ёсны эрх болон хууль хэрэгжүүлэх тухай Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэсэн 6-р бүлгээс үзнэ үү. Энэ бүлгийн зорилго нь хохирогчид хууль хэрэгжүүлэгчидтэй хамтран ажиллах шаардлагатай буюу хүн наймаалагчдын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхэд тухай биш, харин ажилтан хохирогчдыг хууль хэрэгжүүлэгчидтэй сайн дурын үндсэн дээр хамтран ажиллахыг урамшуулахын ач холбогдлыг харуулахад зорьсон болно. Тийм учраас ХХГХ-ийн эрүүл мэнд, хуулийн нотолгоо гаргах тухай дараах зарчмуудыг эрүүл мэндийн ажилтнууд мэдэж байх ёстой. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай бүх мэдээлэл (үүнд өвчтний түүх, шинжилгээ, лаборатори, рентген болон бусад дүгнэлтүүд, эмчилгээ) нууц байх ёстой бөгөөд зөвхөн хохирогчийн зөвшөөрөлтэйгөөр хууль хэрэгжүүлэгч байгууллагад үүнийг өгч болно.
- Хүн наймаалах гэмт хэрэгт буруутгагдсан этгээдийг яллах эсвэл өмгөөлөхийн тулд шүүхээс мөрдөн байцаагчид эрүүл мэндийн тухай мэдээллийг өгөх тушаалыг ажилтандаа ирүүлж болох юм. Энэ тохиолдолд ажилтан эрүүл мэндийнх нь тухай мэдээлэл бусдад ашиглагдаж болзошгүй тухай хохирогчид мэдэгдэх чухал. Хэрэв хохирогч энэ үйл ажиллагаанд оролцохоос татгалзвал ажилтан сэжигтний эсрэг үүсгэсэн мөрдөн байцаалтанд хохирогчийн эрүүл мэндийн тухай мэдээллийг өгөх, ашиглахаас татгалзана.
- Зарим тохиолдолд ажилтан шинжээч буюу гэрчийн хувиар шүүхэд мэдүүлэг өгөхөөр дуудагдаж болзошгүй. Ажилтан эрсдэлтэй мэдүүлэг өгөхөөс зайлсхийх үүднээс гаднаас шүүхийн шинжээчийг урьж эмнэлгийн нотолгоо (хохирогчийн зөвшөөрөлтэйгөөр) гаргуулж, шүүхэд шинжээч, гэрчээр оролцуулж болно. Гаднаас урьсан шинжээч хохирогчтой ярилцах эсвэл шинжилгээ хийх бүрт эрүүл мэндийн ажилтан заавал байлцах ёстой бөгөөд хохирогч хүссэн тохиолдолд түүнд болон шинжээчид дэмжлэг үзүүлнэ.

- Хохирогчийн зөвшөөрөлтэйгээр ажилтнууд өөрсдөө шүүх болон хууль хэрэгжүүлэгч нарт мэдүүлэг өгөхгүй ч, шүүн хэлэлцэх явцад болон мөрдөн байцаагчидтай хохирогч уулзах бүрт ажилтан (хохирогчтой харилцаатай эрүүл мэндийн болон нийгмийн ажилтан байх ёстой) байлцаж, хууль хэрэгжүүлэгчидтай хамтран ажиллах ажиллагааг илүү үр дүнтэй болгох үүднээс сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг байх ёстой.

Ажилтан мэдүүлэг, мэдээлэл өгөхөөр шүүхэд дуудагдаж болзошгүй учраас эрүүл мэндийн ажилтан шүүх эмнэлгийн талаар мэдлэг, дадлагатай байх ёстой. Ийм ажилтнууд тухайн хохирогчийн түүхийн ямар хэсэг нь (хүчирхийлэл гэх мэт) хамааралтай болох, биеийн үзлэгийн аль хамаатай болохыг (шарх, мах болон ясанд үүссэн гэмтэл, тэжээлийн дутагдал гэх мэт) мэддэг байх ёстой. Мөн гарсан дун шинжилгээг батлахын тулд ердийн лаборатори болон рентген шинжилгээг хийлгэх хүсэлт гаргаж, холбогдох тэмдэглэл (эмнэлгийн шинжилгээний хаваст хэрэг), баримт материал, шарх, гэмтлийн гэрэл зураг зэргийг хадгална. Хэрэв мөрдөн байцаалтын үед хүсэлт гаргавал цаашид хийгдэх шинжилгээнд шаардлагатай бодит дээжийг олж чаддаг байх дадалтай байх ёстой. Шаардлагатай бол хохирогчийн өмнөөс шүүх эмнэлгийн шинжээчээс тусламж авна.

## 5.10 Эмч, өвчтөний харилцаа

Эрүүл мэндийн ажилтнууд (сувилагч, эмч, сэтгэл судлаач эсвэл нийгмийн ажилтан) болон үйлчлүүлэгч/өвчтөний харилцааны эрх мэдэл тэнцвэргүй байдаг. Дээрх тэнцвэргүй байдлаас болж өвчтөн асуулт асуух, санал бодлоо илэрхийлэх, эмчээс санаа бодлыг нь асуух эсвэл эрүүл мэндийнхээ талаар шийдвэр гаргахдаа шийдэмгий бус байдаг. Хохирогч эмчтэй уулзаж байх үедээ эмч тэднийг анхааралтай сонсож ойлгож байна гэдгийг мэдэрсэн үедээ эмчдээ илүү хүндэтгэлтэй ханддаг. Түүнчлэн бусдаас тусламж авдаг хүмүүс ялангуяа тэдний сайн сайхан байдал, мөн амьдрал нь бусдын зөв зөвлөгөөг ямарваа нэг болзолгүйгээр хүлээн авахаас хамаарч болно гэдэгт итгэдэг, бусадтай асуудалд орохгүй харин ч эвтэй байхыг хичээж, зөв зан ааштай байх нь цаашид тусламж авах гол хүчин зүйл гэдгийг

оилгуулах нь хохирогчийн хувьд чухал юм.

Эрүүл мэндийн ажилтнуудын хувьд эрх мэдэл эсвэл халамж тавих үүргээ биелүүлж, тэр байдлаараа бусдад хариу өгдөг. Гэхдээ ажилтан дээрэнгүй, захирангуй өнгөөр бус харин мэдэлэл өгч, түүнийг баталгаажулах өнгөөр ярих ёстой гэдгийг анхаарах ёстой. Өвчтөнд ойлгомжтой хэл, нэр томъёогоор түүний өөрийн үнэлэмж, санал бодлыг урамшуулж, итгүүлэх өнгөөр ярина. Мөн түүнчлэн ажилтан шинжилгээ, сорилын үйл явцын туршид өвчтөнг дэмжиж урамшуулан, юуг яах гэж хийж байгааг мөн хэр зэрэг хугацаа шаардлагатай зэргийг тайлбарлаж өгөх ёстой. Эрүүл мэндийн нөхцөл байдал, шаардлагатай эмчилгээг сайн оилгуулж чадсан ажилтан үр дүнтэй ажилласан гэсэн үг.

Өвчтөн болон ажилтны хооронд үүсдэг нэг асуудал бол маш олон хүн эмнэлгийн шинжилгээнээс айж сүрдэн, үүнийг хортой хөнөөлтэй, зарим нь бүр доромжлол гэж хүлээн авдаг байдал юм. Биеийн үзлэгт орж үзээгүй хүн дэлхий дээр маш олон байдаг. Зарим газар эмч, ажилтнууд өвчтөний биенд хүрэлгүйгээр, шинж тэмдэгт нь үндэслэн ямар эмчилгээ хийлгэхийг зөвлөдөг. Зарим эмэгтэйчүүд дотуур үзлэгт хэзээ ч орж байгаагүй учраас ийм үзлэг нь эмэгтэйчүүдийн шинжилгээний нэг хэсэг гэдгийг огт мэддэггүй. Үүнд гайхах зүйл байхгүй юм. Ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр насыхан, эмэгтэйчүүдийн хувьд ийм үзлэг нь хүчирхийллийн бас нэг хэлбэр мэт санагдаж ч болзошгүй. Ийм учир шалтгааны үүднээс эмэгтэйчүүд болон охидыг эмэгтэй ажилтнаар үзэх нь илүү оновчтой юм. Энэ сонголтыг бий болгохын тулд бүхий л хүч чармайлтаа гаргах хэрэгтэй.

---

**Эрүүл мэндийн ажилтан (эсвэл туслалцаа үзүүлж буй хүн) хүний наймаанд өртөж хохирогч болсон хүмүүст шинжилгээ, үзлэг хийх бүх үе шат болон ямар үзлэг, шинжилгээ хийгдэх вэ гэдгийг цаг гарган тайлбарлаж өгөх нь маш чухал. Үзлэг хийхийн өмнө болон хийгдэж байх үед хохирогчид тайлбарлаж өгөх нь маш үр дүнтэй байdag.**

---

## 5.11 ХХГХ-ийн төсөлд Эрүүл мэндийн асуудлыг тусгах нь

Хүн наймаалах гэмт хэрэгтэй тэмцэх, дэмжлэг үзүүлэх асуудалд эрүүл мэндийн тухай асуудал зайлшгүй хөндөгдөнө гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс төслийн загвар, эхлэл, хэрэгжүүлэлтийн үе шатыг анхнаас нь төлөвлөхдөө энэ тухай урьдчилан тусгах ёстой. Гэхдээ нэг төсөлд тусгасан эрүүл мэндийн хэсэг нөгөө төслөөс өөр шаардлага гарч болзошгүй. Ялангуяа өөр өөр улс оронд хэрэгжиж байгаа төслүүд хооронд бүр ч өөр.

Дээрх шалтгааны үүднээс эрүүл мэндийн төслийг боловсруулагч нь эрх мэдэл, мэдлэг бүхий эрүүл мэндийн мэргэжилтэн байх ёстой бөгөөд дараах өрөнхий алхмуудыг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Гэхдээ доорх жагсаалт нь өрөнхий зүйл бөгөөд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас дэлхий даяар хэрэгжүүлдэг төслийг төлөвлөх зарчмаас тусган авсан болно.

ХХГХ-тэй тэмцэх, энэ үйл ажиллагааг дэмжих төсөлд тусгах эрүүл мэндийн төлөвлөлтөд тусгах зүйлс:

- Тухайн хохирогчийн гарал үүсэл болон түүний харилцаанд орсон байж болзошгүй хүн амын судалгаа (нас хүйс, тархалт), өвчний тархалтын (сүрьеэ, гепатит шар, халуун хумхаа, БЗХӨ, ХДХВ, ДОХ гэх мэт нийгмийн халдварт өвчний тухай) судалгаа гаргаж, дүгнэлт хийх
- Зохих зөвшөөрөлүүдийг авах эсвэл Эрүүл Мэндийн Яам (үйл ажиллагаа эрхлэх лиценз), орон нутгийн эрүүл мэндийн байгууллага (хуаран, эмнэлэг, клиник, лаборатори ашиглах), үндэсний эрүүл мэндийн газрууд (олон нийтийн эрүүл мэндийн байдлын талаарх тайлан мэдээлэл), шилжилт хөдөлгөөн, хүчний болон төрийн бусад байгууллагуудаас зөвшөөрөл авах арга замуудыг судлах.
- Хэдий тооны хохирогчид байна гэж үзэж байгаа тэр тооны хүмүүсийг хүлээн авч, эрүүл мэндийн зохистой хalamж үзүүлэхэд тохирсон байр, байгууламжуудыг судлан сонгож, гадаад дотоод тохижилт, шаардагдах орон зай, эрүүл мэндийн урьдчилсан нөхцөл зэргийг хангах арга замаа тодорхойлох.

Клиникийн шинжилгээ, сорил хийх хэсэгт шаардлагатай тоног төхөөрөмж тавьж, өвчтөний эрүүл мэндийн түүх, ярилцлага, биесийн үзлэг хийх үйл явцыг (өндөр, жин гэх мэт) хангалттай нууцлах нөхцөл байдал, мөн температурт эмзэг зүйлсийг (эм, вакцин, реактив зүйлс гэх мэт) хадгалах хөлдөөгч болон хөргөгчнүүдийг төсөлдөө тусгах. (мөн энэ хэсэгт тусгасан орон зайн зохион байгуулалтын талаар үзэх).

- Орон нутгийнхны зүгээс шаардагдах тусламж, үйлчилгээг хангалттай хэмжээгээр авах нөхцөл байдлыг судлаж дүгнэлт гаргах. Эмнэлэг, клиник болон анагаахын үйлчилгээ (мэдээлэл авах удирдамж, үнэ, санхүүгийн урамшуулал, хэрэгжих стандарт, хэргийн зохицуулалтын чанар гэх мэт) үзүүлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах.
- Эм болон эмнэлийн хангалтыг нийлүүлэх төлөвлөгөө боловсруулах (вакцин, хувийн эрүүл ахуй болон ариун цэврийн газрын хангарт гэх мэт).
- Эрүүл мэндийн бичиг баримт, өвчний түүх, харилцаа холбоо, и-мэйл мөн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, шинжилгээний хариу гэх мэт материалуудыг хадгалах шаардлагыг судлаж мэдэх.
- Хохирогчийг буцаах газрын (ихэнхдээ дамжин өнгөрөх болон төрөлх нутаг орон) эрүүл мэндийн асуудал эрхэлсэн эрх баригчидтай зохистой харилцаа тогтоож, хохирогчдыг хүлээн авангутлаа нэн даруй шаардлагатай эмнэлгийн туслалцаа үзүүлэх талаар нь урьдчилан тохиролцох.

## 5.12 ХХГХ-ийн үед үүсч болох нөхцөл байдалд мөрдөх ерөнхий зааварчилгаа

Дэлхийн улс орнуудад дараах бүлэг энгийн зүйл байдаг бөгөөд тухайн хүний ХХГХ-т орохоос өмнөх эрүүл мэндийн байдлын талаарх мэдээллийг авахад учирч болох саад бэрхшээлийг дурьдах нь зүйтэй. Хохирогчийн нөхөн сэргээлтийн явцад тухайн хүний эрүүл мэндийн талаар авах арга хэмжээ, биесийн байдлыг баримтжуулах зорилгоор хохирогчийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл хангалтгүй байдаг нь мөн хүндэрэл учруулдаг.

Эрүүл мэндийн үзлэгт өвчтний эрүүл мэндийн түүх (гэр бүл дэх хүчирхийллийн түүх, ХХГХ-ээс өмнөх нөхцөл байдал, үйл

явлыг оруулсан), биеийн бүрэн үзлэг, холбогдох эмчийн хийсэн сэтгэцийн үзлэг багтдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгийг зөвхөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ.

Хохирогчид бэлгийн мөлжлөгт өртсөн, хүчирхийлүүлсэн, БЗХӨ-ний халдвэр авсан, хүсээгүй жирэмсэлсэн, үр зулбуулснаас болсон хүндрэл зэрэг хохирогчид илрэх өвчний шинж тэмдгийн талаар мэдлэгтэй байх ёстой.

(MHS Эмнэлгийн гарын авлага, 2001 он, хуудас 30-33 үзнэ үү)

Гарын авлагыг ашиглаж буй Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагаас гаргасан кейсийн менежментийн зааврыг ([www.who.int](http://www.who.int)) цахим хуудаснаас үзэж болно. Мөн кейс менежментийг нарийвчлан тайлбарласан анагаах ухааны бусад сурах бичгийг үзэж болно. Халдварт өвчний талаарх өвчний судалгаа, кейс менежментийн туршлагын зааварчилгаа бүхий доорх хоёр номноос үзэж болно.

- Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянахад санал болгох стратеги, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага / UNAIDS, 2001 он, Женев
- Халдварт өвчний хяналтын тухай гарын авлага, Америкийн олон нийтийн эрүүл мэндийн нийгэмлэг (17-р хэвлэл, 2000 он)

### **5.12.1 БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН (БЗХӨ)**

Заг хүйтэн, мөөгөнцөр зэрэг бэлгийн замаар дамжих халдварууд нь худалдагдсан хүмүүсийн дунд их тохиолддог нь тэднийг худалдаж бэлгийн мөлжлөгт өртэж байсантай холбоотой юм. Худалдагдсан хүмүүсийн дунд тохиолддог хэмээн анхаарал татаж буй БЗХӨ-ний дунд ХДХВ мөн багтаж байна.

БЗХӨ-ний тохиолдлын менежмент нь урьдчилан сэргийлэх болон эмчилгээний зарчимд тулгуурласан байх ёстой ба хэрэв лабораторийн үйлчилгээ авах боломжтой бөгөөд найдвартай бол БЗХӨ-нийг илрүүлэх серологийн шинжилгээ өгөхийг санал болгоно. Гэхдээ, нөөц бололцоо муутай нөхцөлд оношийг баталгаажуулах лабораторийн үйлчилгээ авах боломжгүй бол

зарим БЗХӨ-ний эмчилгээ нь синдромын аргаар хийгдэнэ. Лавлагаат үйлчилгээний стандартууд нь хоёр гол баримт болгон нэгтгэгдсэн бөгөөд хүн худалдаалах гэмт хэргээс сэргийлэх, туслалцаа үзүүлэх хөтөлбөрүүд байршиж байгаа газруудад тараах хэрэгтэй. Энэ нь “Бэлгийн замын халдварт өвчнийг эмчлэх заавар – 2002, MMWR-ын Зөвлөмж тайлан, 2002 оны 5 сарын 3, мөн “Халдварт өвчнөө сэргийлэх, хяналт тавихад ДЭМБ-аас зөвлөмж болгосон стратеги” (2001, ДЭМБ, Женев).

## 5.12.2 СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Худалдагсан хүн сэтгэл санааны хувьд ямар реакц үзүүлэх нь янз бүрийн хүчин зүйлээс, нэн ялангуяа, тухайн хүний өнгөрсөн түүх, туулж өнгөрүүлсэн үйл явдал болон ихэнх тохиолдолд одоогийн айdas, тодорхойгүй байдалтай холбоотой стрессээс хамаардаг. Өнгөрсөн явдлын хувьд, худалдагсан олон хүн энэ явдал болохоос өмнө цочролд орж байсан буюу хүчирхийлэлд өртөж байсан гэдгийг нь анхааралдаа авах хэрэгтэй. Хулгайлагдахаас өмнө болсон явдлуудын улмаас сэтгэцийн эрүүл мэндэд учирсэн стресс, хулгайлагдах явцад үүссэн хүчин зүйл нь нийлээд цаашид дахин нэгдэх шатанд ноцтой нөлөө үзүүлдэг. Өөрсдийн төрөлх нутгаасаа хол байгаа хүмүүсийн хувьд үүн дээр шилжилт хөдөлгөөн, одоогийн тодорхойгүй байдлаас (оршин суух эрх, засаг захиргааны журам) үүдэлтэй сэтгэл санааны өөрчлөлт болон түгшүүртэй байдлыг мөн багтааж болно (тухайлбал, хэл, зан заншил, хөндий байх, ганцаардах, хуучин туслалцаа авдаг байсан сүлжээгээ алдах зэрэг). Өөр улс оронд байгаа эсвэл эх нутагтаа байгаа хүмүүсийн хувьд худалдагсаны улмаас үүссэн цочрол нь гэр бүл нь хэрхэн хүлээж авах бол, яаж ажил олох бол, зугтсан эсвэл төлөөгүй өрийнх нь төлөө хүний наймаачид түүнээс өшөөгөө авах болов уу хэмээн одоогийн санаа зовнилтой хосолдог.

Хэдийгээр худалдагсан явдалтай холбоотой хүн бүр өөр өөрийнхөөрөө хариу үзүүлэх хэдий ч зарим нэг түгээмэл тохиолдох хариу үйлдэлд дараах зүйлс орно:

## Сэтгэцийн хариу үйлдлүүд

- өвдөлт, өвчин, толгой, хүзүү, нуруу, гэдэс өвдөх, хоол боловсруулах эрхтэн хямрах;
  - чичрэх, хөлрөх, зүрх дэлсэх;
  - нойр болон хоолны дэглэм өөрчлөгдөх;
  - дархлаа сулрах болон үүнтэй холбоотой хүндрэлүүд (тухайлбал, хамрын ханиад, ханиаданд мэдрэг байх);
  - эрсдэлтэй зан үйл нэмэгдэх (тухайлбал, тамхи татах, архи уух, хар тамхи, бэлгийн эрсдэлтэй харьцаа).
- 

**Анхааруулга:** Нойртой холбоотой элдэв гомдол ань дандаа стрессээс үүдэлтэй байдгийг тооцохгүй байх нь чухал юм. Ялангуяа, худалдагдсан хүн бие махбодийн хувьд их хүнд нөхцөлд байсан эсвэл санаатайгаар гэмтэл авсан бол бие махбодод байгаа шинж тэмдгийг анхааралтай үзэж хангалттай үнэлгээ хийх хэрэгтэй.

---

## Сэтгэл зүйн хариу үйлдэл

- Итгэлгүй, цөхөрсөн байдалд орох, амиа хорлохын өмнөх байдал
  - Ямар нэгэн шалтгаангүйгээр огцом уурлах
  - Сэтгэл санаа нь тогтвортгуй болох, ой тогтоолт муудах, зарим үйл явдлыг санахгүй байх
  - Ганцаараа байхыг илүү үзэх, бусдад итгэхгүй байх, харилцаагаа өөрчлөх
- 

**Анхааруулга:** худалдагдсан хүмүүс хэн нэгэнд дайсагнах, бусдыг үзэн ядах байдал гаргадаг нь олонтаа байдаг. Уур уцаартай болох, сэтгэл санаагаар унах эсвэл бусдаас зайлсхийх гэх зэрэг зан аашийг өөрчлөх нь чухал юм. Эдгээр зан ааш, үйл хөдлөл нь танд хандаагүй гэдгийг санаж бай.

---

Хэдийгээр дээр дурьдсан сэтгэл хөдлөл, зан аашийг байж болшгүй үйл явдлын үр дагавар (хохирол учруулсан үйл явдлын) гэдгийг санаж байх хэрэгтэй ч эдгээр зан байдал нь нэн яаралтай тусгай эмчилгээ шаардагдах сэтгэцийн өвчний анхны шинж тэмдгүүд байж болох талтай.

Зарим хохирогчдоос сэтгэцийн өвчний ноцтой шинж тэмдэг илэрдэг бөгөөд тухайлбал, зан ааш нь өөрчлөгдөх, айдаст автах, дасан зохицооос татгалзах, хохирлын дараахь дарамт, болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хамаарал зэрэг илрэх нь бий.

### Сэтгэл мэдрэлийн өвчний оношлогоо ба тэмдэглэгээ

Сэтгэл мэдрэлийн өвчнийг оношлохтой холбогдон, нэн ялангуяа хохирлоос үүдсэн шинж тэмдгийг оношлоход эрс тэс хоёр хандлага гардаг. Үүний нэг нь хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд оношийг тогтоох юм. Ингэснээр сэтгэл зүйн хувьд тухайн хүнд бусдаас тусгаарлагдаагүй буюу ганцаардаагүй гэдгээ мэдрүүлэх боломжийг олгодог. Зарим хохирогчдын хувьд онош нь тогтоогдсон тохиолдолд тухайн хүн өөрийгөө илүү ихээр яллаж, сэтгэл санаагаар унаж, зан ааш нь эвдэрдэг байна. Энгийнээр тайлбарлавал хүмүүс өөрт нь учирсан онцгой хохирлоос болж зөвхөн бие махбодийн хувьд бус мөн сэтгэцийн хувьд өвчтэй болдог ба аль алиныг нь онцгой анхаарч үзэх ёстой. Мөн эмнэлгийн туршлагаас үзэхэд зарим улс орнууд оношлогоог хүлээн зөвшөөрч хохирогчид шаардлагатай байгаа бүх нөөц бололцоог ашиглах боломжийг олгодог байна.

Нөгөө талаас жирийн бус нөхцөлд үүссэн жирийн зан байдлыг өвчний шинж тэмдэг гэж үзсэнээр хохирогч богино буюу урт хугацааны дотор өөрийгөө буруутгаж, эсвэл буруутай гэж бодож эхэлдэг. Ингэснээр хохирогч өөрийгөө бусдын адил бус, чадваргүй, найдваргүй гэж ойлгож эхэлбэл өөрийгөө дутуу үнэлж, буруу ойлгож, өөрийгөө хязгаарлаж эхэлдэг.

### Сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж гэж юу вэ?

Сэтгэцийн эрүүл мэндийн тусlamжийг олон хэлбэрээр үзүүлдэг ба энэ нь цаг хугацаанаас хамааран өөрчлөгдэж, ихэнхдээ нөөц бололцоо, тодорхой зан заншил болон соёлоос бүрэн хамаарч байдал. Тусlamжийг үр дүнтэй болгохын тулд дэмжсэн стратегийг тухайн хохирогчийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдал (нас, хүйс, соёл гэх мэт) болон хувь хүнд нь тохируулах ёстой. Тусlamж нь цогц байх ёстой ба сэтгэцийн эрүүл мэндийн олон

талыг тусгасан (биеийн эрүүл мэнд, нийгмийн болон санхүүгийн байдал), тусlamжийн олон хэлбэрийг (сэтгэл санааны, боловсролын, ажлын байрна) тусгасан байна. Өнгөрсөн үе нь хохирогчдод хохирол учруулж болох хэдий ч үзүүлж буй тусlamж үйлчилгээ нь өнгөрсөн үед нь бус, өнөөдөрт хандаж, зөвхөн санах ойд чиглэсэн байхаас гадна хохирогчид эрүүл ирээдүйд итгэх итгэлийг өгөхөд тусалдаг.

Барууны буюу орчин үеийн сэтгэл зүйн загварчлал нь зөвхөн сэтгэлийг нь түгшээсэн үед хийх дээд түвшний хариу үйлдэл гэж ойлгохгүй байх нь чухал юм. Сэтгэцийн эрүүл мэндийн тусlamжийг сэтгэл зүйч эмч эсвэл нийгмийн ажилтантай ярилцах хэлбэрээр хийж болох бөгөөд мөн олон нийтийн ажилд оролцуулах, сургалт, боловсролын болон соёлын мэдээллийн хөтөлбөрт оролцуулах, ажилд авах эсвэл бусадтай шинэ харилцаа тогтоох буюу харилцаагаа сэргээх зэрэг аргаар явуулж болно.

Хийгдсэн ёстай үйл ажиллагаанаас гадна хоргодах байранд буюу хохирогчдын бүлэгт тусlamж үзүүлж буй ажилтнууд хохирогчдыг гэнэтийн байдлаар уулзуулах, тэднийг албан бусаар танилцуулах, үзэл бодлыг нь солилцуулах зэрэг нь эмчилгээнд онцгой зэрэг нөлөө үзүүлдэг.

Хохирогчид туслалцаа үзүүлж буй мэргэжилтнүүд тэдэнд хамгийн ойр хүмүүс (гэр бүл, найз нөхөд, нутгийнхан)-ийн халамж, ойлголцол эргээд нийгэмд орох үйл явцад нэн чухал нөлөөтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. ХХГХ-ээс үүдэн үүсэх сэтгэцийн эрүүл мэндийн хүндрэлүүд урт удаан хугацаанд эдгэдэггүй бөгөөд үүнд туслах хамгийн гол зүйл бол хохирогчдод хүнд хэцүү үед нь байнгын туслалцаа үзүүлэх явдал юм. Хохирогчид туслалцааны хөтөлбөрөөс маш бага туслалцаа авч (төрөлх эх орон руугаа явж байгаа эсвэл түр байрлах байр байхгүй бол) байгаа ч гэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үзүүлэх боломжтой юм.

**Сэтгэцийн эрүүл мэндийн тусlamжийг хэн үзүүлэх чадвартай вэ?**

Үйлчилгээ үзүүлэгч аль болох эрт хохирогчид эрүүл мэндийн мэргэшсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой бол эн түрүүнд сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг хийх ёстай. Сэтгэцийн

эрүүл мэндээр хохирсон (ХХГХ-ийн улмаас буюу өмнөх сэтгэцийн өвчний улмаас) хохирогчдыг тодорхойлох, нэн яаралтай тусгай эмчилгээ шаардлагатай хүмүүсийг тогтоох шаардлагатай. Өөрсдийгээ буюу бусдад хохирол учруулах эрсдэлд орсон хохирогчид буюу сэтгэцийн байдлаас болж өөртөө анхаарал хяналт тавьж чадахгүй хохирогчид (тухайлбал, хувцас өмсөхгүй байх, хоол идэхгүй байх, галзуурлын шинж тэмдэг илэрсэн гэх мэт) эрүүл мэндийн байдлыг нь тогтвортжуулах эмчилгээ хийж, зарим тохиолдолд эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ. Тиймээс оношийг зөв тогтоохын тулд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэргэшсэн эмч үйлчилгээ үзүүлж буй ажилтнаас тусlamж авч буй бүх хохирогчдыг үзэх шаардлагатай. Нөхцөл байдлаас шалтгаалан, үзлэгийг сэтгэцийн эрүүл мэндээр мэргэшсэн ерөнхий эмч, мэдрэлийн эмч, эмнэлгийн сэтгэл зүйч, мэдрэлийн сувилагч, эсвэл мэдрэлийн өвчний мэдлэгтэй нийгмийн ажилтан хийж болно. Хохирогчид ноцтой өвчилсөн бол мэргэжилтнүүд нарийн мэргэжлийн эмчид хандах буюу эмчилгээг нэн даруй эхлэх ёстой. Санамж: Дээр дурьдсан бүх эмч нар эмчилгээний заavarчилгаа өгч чадахгүй. Тухайн өвчтнийг өвчнийг тогтоож чадахгүй бол ур чадвар эзэмшсэн өөр мэргэжилтэнд хандана.

---

**Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх богино хугацааны буюу албан бус сургалт (тухайлбал, З долоо хоногийн сургалт) буюу зөвлөгөө өгөх нь ажилтнуудад анхан оношлогоо хийх буюу сэтгэл зүйн эмчилгээний эсвэл эмчилгээ үзүүлэх чадварыг олгож чадахгүй.**

---

Үйлчилгээ үзүүлэгч ажилтны халамжинд байгаа, нэн яаралтай мэдрэлийн эмчилгээ шаардаагүй (эмчилгээ, эмнэлэгт хэвтүүлэх) хохирогчид сэтгэл зүйч, мэдрэлийн эмч, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх туршлагатай сувилагч, нийгмийн ажилтнуудаас авч буй сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ үр дүнгээ өгөх магадлалтай. Сэтгэцийн эрүүл мэндийн албан бус буюу богино хугацааны сургалтанд суусан хүмүүс буюу сэтгэл зүйн туслалцаа нь эмчилгээний орчинг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг (бусад ажилтнуудад ойлголт өгөх) ба бүх хохирогчдод сэтгэл санааны туслалцаа үзүүлдэг.

Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн туслалцаа санал болгоходоо хохирогч бүр нэг ажилтантай ажиллаж байхаар зохицуулах ёстой. Томилж өгсөн ажилтан нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эсвэл

сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтанд хамрагдсан сувилагч, эсвэл ажилтан байна. Тухайн ажилтан нь эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх багийн гишүүн байх ба голлох үүрэг гүйцэтгэх хүний удирдлаган дор ажиллана. Энэ тухай энэ бүлэгт дурьдсан болно. Томилогдсон ажилтны үүрэг нь:

- Хохирогч мэдээлэл авах, хүсэлт гаргахдаа хэнд хандахаа мэддэг байх
- Хохирогч үзүүлж буй үйлчилгээ, хийгдэж буй эмчилгээ гэх зэрэг бүх үйлчилгээг хольж хутгахгүй байх
- Мэдээлэл тасраагүй эсвэл замдаа алга болоогүй
- Ажилтнууд давхар ажил авахгүй байх
- Хохирогчид ижил мэдээллийг давтаж хуваалцахгүй байх
- Итгэл төрүүлэх, харилцаа тогтоох үйл явцыг хурдасгах

### Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн үе шатууд

Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх шилдэг загвар байдаггүй. Сэтгэцийн эрүүл мэндийн салбарын ажилтнууд болон хохирол амсч амьд гарсан хохирогчидтай ажиллаж байсан мэргэжилтнүүд нөхөн сэргэх арга зам, туслалцаа үзүүлэх стратегийг санал болгодог. Гэхдээ ХХГХ-ийг золиос болсон хохирогчдод сэтгэл зүйн бүх талын туслалцаа үзүүлэх зорилго бол ХХГХ-ийг үл хамааран хохирогчид өөрийн амьдралаа дахин босгох тэдний итгэлийг төрүүлэх явдал юм.

Нөхөн сэргээлт гэдэг нь хувь хүн бүрийн хувьд онцгой үйл явц юм. Гэхдээ дээр хэлсэнчлэн хувь хүний өөртөө итгэлийг сэргээх, орчин тойрондоо эрүүл аргаар дахин зохицох чадварыг бэхжүүлэхэд олон хүчин чадал нөлөөлдөг. (тухайлбал, хохирлын түвшин, хугацаа, тухайн хүний туулсан зам, туслалцааны чанар гэх мэт). Нэлээд олон өргөн цар хүрээтэй үе шатуудыг хохирол, гэмтлийн явцад туршлагажсан хүмүүсийн тусламжтайгаар тодорхойлсон болно.

**Үе шат I. Аюулгүй байдлыг бий болгох.** Нөхөн сэргээлтийн анхны даалгавар бол хохирогчийн аюулгүй байдлыг бий болгож, хангах. Мөн хохирогчийн бие махбодь, сэтгэл хөдлөл, орчны талаар хяналт тавих ёсгүй. Хохирогч аюулгүй байдалд байгаа

гэдгээ мэдрэх хүртэл ямар нэгэн үйл ажиллагаа зохиох ёсгүй.

**Үе шат II. Эргэн санах, гашуудах.** Онол ёсоор энэ шатанд хохирогч өөрт нь тохиолдсон зүйлийг санаж, сэтгэл зүйн хувьд болоод сэтгэл санааны хувьд гашууддаг. Гэхдээ зарим хохирогчдын хувьд энэ шатанд орохдоо үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудтай илүү их цагийг хамт зарцуулах хүсэлтэй болсон байдаг. Хэзээ хаана тэр муу муухай өнгөрсөн бүхэнтэй тулгарснаа санах нь хувь хүний хэрэг.

**Үе шат III. Жирийн амьдралтай дахин харилцаа тогтоох.** Нөхөн сэргээлтийн сүүлийн зорилго нь нийгэмд нэгдэх, бусадтай харилцаа тогтоох буюу харилцаагаа сэргээх юм. Энэ шат удаан хугацаа шаардаж болох юм. Зарим хүмүүс амьдралынхаа туршид энэ шатыг даван туулдаг. Сэтгэл зүй, нийгмийн тусlamжид боловсролын, ажлын байрны, эдийн засгийн хүчин зүйлс багтах ба эдгээр нь хохиргчийн шат ахиж нийгэмд нэгдэхийн тулд туулах хэсэг юм.

### Сэтгэцийн эрүүл мэндийн тусlamжийн ерөнхий онцлог ба шийдвэр

Амссан хохирлыг даван туулахад ашиглаж болох хариу үйлдлийн онцлогууд:

- Хохиргчийг буруутгахаас зайлсхийх
- Дэмжсэн орчныг бүрдүүлэх
- Хүчирхийллийг эрүүгийн гэмт хэргийн чанартай хохирол гэж үзэх
- Хохирол амсаадаа хийсэн хариу үйлдлийн талаарх мэдээлэл өгөх
- Өвчин илаарших шинж тэмдэг илэрч байгаа талаар

Эмчилгээний стратегийн талаар шийдвэр гаргахдаа хохиргчийн оролцох хүсэлтэй байгаа эсэх, ямар хугацаагаар байх сонирхолтой байгааг анхаарч үзнэ. Мөн анхаарч үзэх бусад хүчин зүйлүүдэд:

- Эмчилгээний зорилго (тухайлбал, идэвх сайтай болох, хэт эмзэг болсон, эсвэл сэтгэх чадвараа алдсан)

- Хавсарсан өвчин (урьд байсан өвчин, хүнд өвчин)
- Сэтгээд нөлөөлөх эм/согтууруулах ундааны хамаарал, хүчээр хэрэглэх
- Сэтгэцийн эрүүл мэндийн хүнд өвчин, тухайлбал, амиа хорлох, бусдад хохирол учруулах, өөрийгөө авч явах болон
- Эрүүл мэндийн бусад асуудал.

Сэтгэцийн эрүүл мэндийн ямар туслалцаа үзүүлэх ёстой вэ гэдгийг сэтгэцийн эрүүл мэндээр мэргэшсэн эмч хохирогчтой ярилцаж байж шийднэ. Нэмэлт II-оос сэтгэл зүйн эмчилгээний баруунд хэрэглэгддэг зарим аргуудын тухай үзнэ үү. Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний чухал хүчин зүйлүүдийн нэг нь хохирогчийн орчин тойрны хүмүүст хохирогчийг эмчлэг арга бөгөөд тэдний сонголтыг хүндэтгэх ёстой.<sup>59</sup>

### 5.12.3 ЭРҮҮЛ АХҮЙ БА АРИУН ЦЭВЭР

Хохирогчид ядуу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орон сууц эсвэл хувийн ариун цэвэрт анхаарал тавих боломжгүй байдгаас эрүүл мэндийн байдал нь эрүүл ахуйн бохир нөхцөл ба хувийн ариун цэвэртэй холбоотой байдаг. Арьс, чих, үс, нүдний халдварт (бактерийн, вирусны буюу мөөгөнцөрийн)-ыг үзэж шаардлагатай бол тохирох эмчилгээ хийх нь чухал юм. Хамуу, цагаан хорхой, мөөгөнцөр болон бусад өвчин үүнд багтана. Хэт олон хүнээс гадна мөн бохирдсон ус, эсвэл хоол хүнснээс шалтгаалан ходоодны өвчин, тухайлбал, хижиг, паразит хорхой болон хими, физикийн цэвэршүүлэгч бодисууд хүний хэрэглээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс их байснаас үүдэн гарах бусад өвчлөл байна. Мөн хижиг халуун зэрэг халуун орны өвчин хангалтгүй эрүүл ахуйн нөхцөл, хэт олон хүнээс болж халдвартладаг.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага. Халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, хянах санал болгож буй стратеги. 2001 он. Энэ номонд эрүүл ахуйн бохир нөхцөл, хувийн ариун цэвэр, усны чанар, бохир хүнснээс шалтгаалан үүсэх өвчинтэй холбоотой тусгай зааварчилгааг өгсөн. Стандартын тухай мөн Америкийн Олон нийтийн эрүүл мэндийн нийгэмлэгээс гаргасан Хүнд халдвартлах өвчнийг хянах (17-р хэвлэл, 2000 он) гэсэн гарын авлагад дурьдсан.

#### 5.12.4 СҮРЬЕЭ

Хэдийгээр хийгдсэн судалгаагаар нотлогдоогүй ч сүрьеэг ХХГХ-ийн үндсэн үр дагавруудын нэг гэж ойлгож болно. Хохирогч худалдагдахаасаа өмнө нийгэм эдийн засгийн муу нөхцөлд амьдарч байсан төдийгүй мөн худалдаалагдсаны дараа хэт олон хүнтэй, тэжээл муутай хоолтой, сэтгэцэд нөлөөлөх эмийн нөлөөнд байсан гэдгийг санаж байх ёстой. Мөн сүрьеэ нь ХДХВ-тэй хавсарсан байдлаар илэрдэг учир хохирогчидтой харьцахдаа үүнийг онцгой анхаарах шаардлагатай.

#### 5.12.5 АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ МЭНД

Ажлын байрны эрүүл мэндийн асуудал албадан хөдөлмөр эрхлүүлэхээр буюу зугаа цэнгээний зорилгоор худалдагдсан хүмүүст тулгардаг хэдий ч хохирогчийн амьдарч буй нөхцөл, ажлын байрны болон ажлын байрны бус эрүүл мэндийн аюулаас шалтгаалдаг. Анагаах ухааны сурах бичиг, тухайлбал Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зааварчилгаанд эдгээр байдлаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх стратегийг дурьдсан байдаг төдийгүй мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжин суурьшиж буй хүмүүсийн ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх бүтээлүүдээс үзэж болно.

Ажлын байрны эрүүл мэндийн асуудалд дараахь хохирол багтдаг. Үүнд:

- Зөвлөн эдийн гэмтэл, тухайлбал, зүссэн шарх, бууны шарх, тариа, хугарлын гэмтэл, бага хэмжээний гэмтэл, урагдсан шарх, хөхрөлт болон гаж үйлдлээс үүдэн гарах бэлэг эрхтний урагдал гэх мэт
- Ясны болон булчингийн гэмтэл, үе мөч мултрах, хугаралт, булчин сунах, эд эрхтнээ тайруулах, алдах, болон яс, булчингийн бусад гэмтэл
- Арьсны байдал, үүнд дээр өгүүлсэн эрүүл ахуйн бохир нөхцөл, хувийн ариун цэврээс шалтгаалсан халдварт өвчин, мөн халдварт бус химиин тулэгдэл, арьсны улайлт, мөн сорвитой эсэхийг харах ёстой (эрхтэн авсан эсэх, нэн

- ялангуяа бөөр)
- Гэмтэл согог/ сонсох болон харах чадваргүй болсон
- Цусны өвчлөл: цус багадалт, цусны цагаан бөөм багассан
- Зарим үйлдвэрлэлийн онцлогт хамааралтай амьсгалын замын өвчлөл (тухайлбал, уушиг тоосжих, уушкины хавдар)
- Зарим халдварт өвчин тусах өндөр эрсдэл, тухайлбал, бруцеллез, сальмонеллез болон худалдагдсан байхдаа гэрийн тэжээвэр/зэрлэг амьтадтай харьцсан хүмүүс (тухайлбал, мал нядалгааны газар, шувууны аж ахуй, яс болон мах боловсруулах үйлдвэр, арьс ширний үйлдвэр зэрэг).

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Ажлын байран дахь хүүхдүүд: эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл гэсэн номыг үзнэ үү.<sup>60</sup>

#### **5.12.6 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ БОЛОХ ӨВЧИН**

Хохирогчид буурай хөгжилтэй орон нутгаас гаралтай байвал эмч тухайн хүнд хийсэн вакцин, вакцинжуулалт, дархлаа тогтоосон эсэх талаарх ямар ч мэдээлэл олж авч чадахгүй. Тиймээс хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ мөн дархлаа тогтоох үйлчилгээг үзүүлнэ.

#### **5.12.7 ТЭЖЭЭЛЛЭГ ХООЛ ХҮНС, ГЭМТЭЛ, ШҮДНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, СУУРЬ ӨВЧИН**

Эрүүл мэндийн эдгээр байдал нь ихэвчлэн ХХГХ-тэй холбоотой байдаг ба Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон дэлхийн бусад байгууллагын ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааны тайландаа энэ талаар дурьдажээ. Ажлын нөхцөл, хүн худалдаалах үйл явцын ялгаатай байдаг ч хохирогчид цагаач ажилчдын дунд тохиолддог ижил төрлийн өвчтэй байдаг. Тухайлбал, хоол тэжээлийн дутагдал нь ХХГХ-ийн хохирогчид болоод цагаач ажилчдын дунд өргөн дэлгэрсэн байдаг. Шаардлагатай тэжээллэг хүнсийг хязгаарласан, ядарч туйлдуулсан ажил, бэлгийн мөлжлөг, хавсарсан өвчин болоод халдварт эсвэл сэтгэцэд нөлөөлөх эмийн нөлөө зэрэг нь хохирогчийг тэжээлийн дутагдалд оруулах гол хүчин зүйл болдог байна. Тэжээлийн дутагдалд орсон хүүхдийн

хөгжил зогсох төдийгүй мөн цус багадах, арьсны, шүдний өвчтэй болох зэрэг өвчний шалтгаан болдог.

Хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэгдсэн байдал, мөлжлөг нь ихэнх тохиолдолд яс, булчингийн, мөн тулгуур эрхтний гажиг үүсгэдэг ба (нэн ялангуяа албадан хөдөлмөр эрхлүүлэхээр худалдагдсан хүмүүс), зөөлөн эдийн гэмтэл (бэлэг эрхтний гэмтэл зэрэг) болон бусад гэмтэл (сум, хутганы шарх, зүсэлт, эдийн гэмтэл зэрэг) зэргийн шалтгаан болдог төдийгүй сэтгэцийн болон бусад сөрөг үр дагавартай.

Хохирогчдын дунд мөн хүндэрсэн өвчтэй хүмүүс их байдаг ба тухайлбал, амьсгалын замын болон ходоод-гэдэсний өвчин, булчирхайн өвчин (сахарын өвчлөл, уушгини тоосжилт гэх мэт), бөөрний, элэгний болон бодисын солилцооны бусад өвчин, мөн арьсны өвчтэй байдаг. Эдгээр өвчлөлүүд нь ХХГХ-ээс өмнө туссан буюу худалдагдсан байхдаа олж авсан өвчин байна. Худалдагдсан байхдаа халамж үйлчилгээ авах эрхийг нь хязгаарласан учир хохирогчдод өвчнөө хүндрүүлэхээс урьдчилан сэргийлэх, эмчлэх боломжгүй байдаг. Ингэснээр хохирогч үйлчилгээ үзүүлж буй байгууллага дээр ирэхдээ өвчин нь хүндэрсэн, цаашид хүндрэх магадлалтай байдалтай ирдэг.

Хохирогчдын дунд элбэг тохиолддог архаг өвчинд мөрдөх зарчмуудыг энэ гарын авлагад дурьдан боломжгүй юм. Мөрдлөг болгох гол зарчим нь хохирогч эрүүл мэндийн тусlamж авах боломжгүй байсан, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын халамжинд орсон учир нэн шаардлагатай, тохирох эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх ёстой гэсэн зарчим болно.

### 5.13 ХХГХ-ийн хохирогчдын эрүүл мэндийн төлөвлөлт

Энэхүү хэсэг нь Бүлэг 5-ын нэмэлт хэсэг бөгөөд тусlamжийн хөтөлбөрт хамрагдах болон хөтөлбөрөөс хасагдаж байгаа хохирогчдод эрүүл мэндийн төлөвлөлтийн зөвлөгөө өгөх тухай өгүүлнэ. Энэхүү хэсгийн эхнээс эмнэлгийн заавар болоод эмчилгээний талаарх мэдээлэл авч болох ба мөн Эрүүл мэнд гэсэн хэсэгт эмнэлгийн үйлчилгээ болоод дэд бүтцийг

(тоног төхөөрөмж, хангамж, туслах болон нэмэлт үйлчилгээ, эмнэлгийн туслах хангамжийн материал зэрэг) бий болгох төсөл боловсруулахад шаардлагатай эрүүл мэнд, эмнэлгийн төлөвлөлтийн шаардлагын талаар бичсэн болно.

Тусlamжийн хөтөлбөрт хамрагдаж байгаа хохирогч бүрийн хувьд эрүүл мэндийн стратегийн төлөвлөлтийг боловсруулах нь эрүүл мэндийн халамж үйлчилгээг сайтар тооцоолсон байх ёстой бөгөөд хохирогчид эмнэлгийн талаарх мэдээлэл нээлттэй, мэдээллийг зөв зохистой дамжуулдаг, очих, дамжин өнгөрөх болон төрөлх орны үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон түнш байгууллагуудтай харилцан уялдаатай ажилладаг гэдгийг мэдрүүлэх ёстой.

Хохирогчид зориулан эрүүл мэндийн төлөвлөлтийг боловсруулахдаа дараах үндсэн алхмуудыг хийнэ. Үүнд:

Эрүүл мэндийн тусlamж үзүүлэхэд голлох хүнийг томилох. Энэ хүн нь хохирогч үйлчилгээ үзүүлж буй байгууллагын халамжинд байхад үзүүлэх эрүүл мэндийн тусlamжийг (өвчтний түүх мөн багтана) хариуцна. Томилсон хүн нь анагаах ухаан, эрүүл мэндийн халамж үйлчилгээ, сэтгэл зүй буюу эрүүл мэндтэй холбоотой нийгмийн ажлын сургалтанд хамрагдсан байна. Байгууллагын салбар бүр бичгээр тухайн хүний үүргийг (хүлээх үүрэг, хязгаарлалт) нарийвчлан тодорхойлно. Эрүүл мэндийн халамж үзүүлэх гол хүн тусlamж авч буй хохирогчийн эх хэлээр ярьж чадахгүй бол сургалтанд хамрагдсан орчуулагч авах зохицуулалтыг хийнэ. (Хавсралт I: ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх болон ярилцлага хийхэд баримтлах ёс зүйн зарчмууд, 18, Орчуулагч авах) Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гол хүн нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд болоод хууль хэрэгжүүлэгч байгууллага зэрэг бусад байгууллагуудтай харилцах харилцааг идэвхтэй зохицуулах үндсэн үүрэгтэй бөгөөд нэн ялангуяа тэдэнтэй хамтран хохирогчид эмнэлгийн, нийгмийн болоод хуулийн үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

**Анхны ярилцлага хийж, эрүүл мэндийн төлөвлөлтийн эхний уулзалтыг зохион байгуулах.** Анхны ярилцлага болон эрүүл мэнд төлөвлөлтийн уулзалтыг хохирогчийн хамт аль болох эрт зохион байгуулна. Анхны ярилцлага болоод төлөвлөлтийн уулзалтын гол зорилго нь:

- Нэн шаардлагатай, яаралтай эрүүл мэндтэй холбоотой асуудлыг тодруулах (үүнийг мөн анхны ярилцлагын үеэр хийнэ).
- Үзүүлж болох ба болохгүй эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний талаар тайлбарлах, хамтран ажиллагч байгууллагын үзүүлэх тусlamжийн талаар ярих. Үйлчилгээний хязгаарлалтын талаар тодруулга хийх. (Хохирогчийн халамжлах, ярилцлага авахад мөрдөх ёс зүйн зарчим, 5, мэдээлэл өгөх). Биеийн эрүүл мэндийн халамж үйлчилгээ, эмнэлгийн шинжилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж, нийгмийн тусlamж зэргийн талаар мэдээлэл өгөх.
- Хохирогчид санал болгож байгаа бүх үйлчилгээ ямар нэгэн төлбөргүй, зөвхөн тэдэнд зориулсан үйлчилгээ гэдгийг ойлгуулах, бүх мэдээлэл дээд зэргийн нууцлалтай гэдгийг хэлэх.
- Нийгэмд нэгдэх явцын ярилцлагад дурьдагдах эрүүл мэндтэй холбоотой бүх асуулт, хэрэг бүрт хийдэж байгаа үнэлгээг хянах, эсвэл явцад байлцах. Тухайлбал, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг буюу бэлгэвч хэрэглэсэн эсэх талаар хохирогчоос асуух ярилцлагын үед заавал байна. Хохирогчид гарч болох бие махбодийн болоод сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой асуултууд, үзлэг хийх биеийн хэсэг, хохирогч эрүүл мэндийн халамжийн талаар ямар бодол, хүсэлтэй байгаа, хохирогч ямар хугацаатайгаар тухайн салбарт байх сонирхолтой байгааг мэдэж тодорхойлох.
- Хохирогчдод үзүүлж болох үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, хийгдэх үзлэгийн хуваарь, эмнэлгийн шинжилгээ, зөвлөгөө өгөх хуваарийг боломжтой бол өгөх.

**Бусад эмч нартай хамтран зөвлөгөө хийж, цагийн хуваарь гаргах.** Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх томилогдсон хүн мөн туслалцаа үзүүлэх бусад хүмүүстэй холбоо тогтоох үргийг хүлээх ба хохирогчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, тусlamжийн урьдчилсан төлөвлөгөөг гаргана. Эрүүл мэндийн зөвлөлд багтсан эмч нар гэдэг нь дотрын эмч, сэтгэл зүйч болон нийгмийн ажилтан болно. Хохирогчдыг эх оронд нь хурдан хугацаанд буцаах гэж байгаа бол цаг хугацаа гэдэг үзүүлэх ёстой шаардлагатай тусlamжийг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Зарим тохиолдолд эрүүл мэндийн зөвлөл хохирогчийг эх оронд нь буцаах хугацааг хойшлуулах зөвлөмж өгдөг. (жирэмсний

хордлого, ХДХВ, гэр бүлийн хүчирхийлэл, гэх мэт, доороос үзнэ үү) Эмнэлгийн, эрүүл мэндийн болоод зөвлөгөө өгөх уулзалтуудыг томилогдсон хүн зохицуулах ба ингэснээр хуваарь давхцах, хохирогчийн эрүүл мэндэд илүү их анхаарал тавих боломжийг бүрдүүлж байгаа юм.

---

**Анхааруулга:** Хохирогчид эмнэлгийн яаралтай тусlamж шаардлагатай буюу эх оронд нь тухайн өвчнийг эмчлэх боломжгүй бол (мэргэшсэн эмч байхгүй, санхүүгийн хүндрэл гэх мэт) хохирогчийн эрүүл мэндийг хариуцаж байгаа ажилтан тухайн тохиолдолд үзүүлэх эрүүл мэндийн тусlamжийн талаар хатуу шийдвэр гаргаж хохирогчид шаардлагатай заавар өгөхөөс гадна эх оронд нь буцаах үүрэг хүлээсэн хүмүүст зохих зааварчилгаа өгнө. (хууль хэрэгжүүлэгч байгууллага болоод цагаачлалын албан). Холбогдох албан тушаалтнуудад тухайн хохирогчийг үүссэн нөхцөл байдалд эх оронд нь буцаана гэдэг эрхийг нь зөрчсөн хэрэг төдийгүй хохирогчийн эрүүл мэндэд сэргөөр нөлөөлнө гэдгийг хэлж, сайн дурын үндсэн дээр, эх орондоо аюулгүйгээр эргэн очно гэдэг үндсэн зарчим гэдгийг ойлгуулна.

---

**Хохирогчийг оролцуулсан эрүүл мэндийн төлөвлөлтийн хоёр дахь уулзалтыг зохион байгуулж, нэмэлт мэдээлэл өгч, эмнэлгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах.** Хохирогчтой хийж байгаа хоёр дахь уулзалтын гол зорилго нь санал болгож буй халамжийн төлөвлөгөөг тайлбарлах, зааврыг даган мөрдөх эсэх зөвшөөрөл авах юм. Эрүүл мэндийн тусlamж үзүүлж буй томилогдсон хүн зөвшөөрөл авах ажиллагааг бүрэн хариуцаж хийх ба санал болгож буй биеийн болоод сэтгэл зүйн тусlamжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. (Хохирогчийг халамжлах, ярилцлага авахад мөрдөх ёс зүйн зарчим, 5, мэдээлэл өгөх болон 6, зөвшөөрөл авах) Мөн хохирогчийн асуултанд хариулж, санааг зовоож буй зүйлийг тайлбарлана. Зарим тохиолдолд хамтран ажиллах байгууллага буюу халамжийн төвөөс бусад газарт очиж үйлчилгээ авах (эмнэлэг, олон нийтийн эрүүл мэндийн газар гэх мэт), тусгай шинжилгээ өгөх, эмчилгээ хийлгэх зэрэгт хохирогч хоёр дахь зөвшөөрөл өгч, үйл явцыг баримтжуулж магадгүй гэдгийг тайлбарлан ойлгуулна.

**Эмнэлгийн дүгнэлтийг аль болох цаг алдалгүй шууд**

**МЭДЭЭЛЭХ.** Эмнэлгийн шинжилгээ, эмчилгээний дүгнэлт гармагц эрүүл мэндийн тусlamж үзүүлж буй томилогдсон хүн хохирогчтой ганцаарчилсан уулзалт хийж дүгнэлтийг өгч, ярилцана.

## 5.14 Хохирогчийн тусlamжийн хөтөлбөрийг дуусгаж эрүүл мэндийн төлөвлөлт хийх

Хохирогчийн халамжийн үйлчилгээг зогсоохын өмнө тухайн хохирогч эрүүл мэндийнхээ байдлын талаар бүрэн мэдээлэлтэй эсэхийг шалгах ёстой бөгөөд халамж үзүүлэх явцад тодорхойлсон эрүүл мэндийн асуудлаа цаашид шийдэх бэлтгэлтэй эсэхийг мэдэж авна. Хохирогч гэр бүлдээ буюу нийгэмд нэгдэхээр эх орондоо эргэн очихын өмнө санал болгосон дараахь арга хэмжээг авах ёстой.

**Явахаас өмнөх эрүүл мэндийн байдлыг нягтлах.** Хохирогч тусlamжийн хөтөлбөрөөс гарахын өмнө тусlamж үзүүлж буй томилогдсон хүн хохирогчид эрүүл мэндийн байдал, хийгдсэн эмчилгээ, боломжтой бол онош болон бусад ердийн мэдээллийг хохирогчийн эх хэл рүү хөрвүүлэн бичсэн баримт бичгийн хувийг өгөх, хохирогчийн эрүүл мэндийн байдлыг үзэх, хийгдсэн эмчилгээ, эрүүл мэндийн тухайн үеийн байдлыг хянаж үзэх ёстой.

Энэ үеэр томилогдсон хүн:

- Хүн бүртэй биеийн эрүүл мэндийн байсан болон байгаа байдлын талаар ярилцах, дараах зүйлсийг тайлбарлах:
  - Үйлчилгээ үзүүлэгч, хамтран ажилладаг байгууллагын халамжинд байхад оношлосон өвчин, ач холбогдол
  - Үйлчилгээ үзүүлэгч байгууллага, хамтран ажилладаг байгууллагаас хийсэн эмчилгээ, хийгдсэн эмчилгээний үр дүн
  - Эмчлэгдээгүй бусад өвчин, цаашид хийгдэх эмчилгээ, эмчлэхгүй байвал гарч болох эрсдэл
- Цаашид хийгдэх эмчилгээнд шаардлагатай эрүүл мэндийн түүх болон бусад бичиг баримтыг хувийг өгөх.
- Хохирогч эм ууж эхэлсэн бол бичгээр болон амаар тухайн эмчилгээг хэрхэн хэзээ дуусгах (эмчилгээг бүрэн гүйцэд дуусгахгүй бол гарч болох эрсдлийг тайлбарлаж ойлгуулах)

заавар өгөх. Хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас бус өөр газраас нэмэлт эмчилгээ хийлгэх шаардлагатай бол шаардлагатай эм, эмчилгээ хийлгэх заавар өгөх, эмийн бичигт бичиж өгөх (тухайлбал, эмч, эмнэлгийн төвөөс өгсөн эм, эмчилгээний заавар, зөвлөгөө).

- Хохирогч өөрт нь өгсөн мэдээллийг ойлгосон эсэх, эрүүл мэнддээ анхаарах үүднээс ямар байдалтай байгаа (сэтгэл зүй, санхүүгийн хувьд гэх мэт) гэдгээ мэдэж байгаа эсэхийг дахин нягтлах.

Нэг үйлчилгээ үзүүлэгчээс нөгөөд шилжсэн хохирогчдод авах арга хэмжээг зохицуулах, эрүүл мэндийн тусlamж болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх. Хохирогчийг нэг үйлчилгээ үзүүлэгчээс нөгөөд шилжүүлэхэд эрүүл мэндийн талаарх мэдээллийг нууцлан кодлож, хохирогчийг явахаас **өмнө** и-мейлээр явуулна. (Ажилтнууд бүх хохирогчдод эрүүл мэндийн түүхийн хувийг өгнө гэсэн заавартай энэ зөрчилдөхгүй) Мөн тухайн хохирогчийн хэргийг хариуцаж буй томилогдсон хүн хохирогчийг хүлээн авч буй байгуулага, эмчтэй харилцах үүрэгтэй бөгөөд хохирогчийн эрүүл мэндийн байдал, шаардлагатай тусгай халамжийн талаар мэдээлэх үүргийг хүлээнэ. Үүнийг зөвхөн хохирогч нөгөө байгууллагад очихоос **өмнө** энэ гарын авлагын бусад бүлгүүдэд зааж өгсөн санал болгох зааврын дагуу хохирогчоос зөвшөөрөл авч гүйцэтгэнэ.

**Халамжийн хөтөлбөрөөс гарсан хохирогчдод эрүүл мэндийн тусlamж болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, цаашид авах арга хэмжээг зохицуулах.** Үйлчилгээ үзүүлэгч нь буцаж буй хохирогчийн эх орон болох улс орны болон түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсан хүмүүсээс эрүүл мэндтэй холбоотойгоор холбоо барих мэдээллийг авах үүрэг хүлээнэ. Холбоо барих мэдээлэл нь тухайн хохирогчийн эх хэл дээр бичигдсэн байна. Холбоо барих мэдээллээс гадна эмнэлгийн ажилтнууд хохирогчийг хариуцуулсан байгууллага буюу хүмүүстэй утсаар буюу захидаар шууд холбоо барих нь чухал юм. Үүнийг зөвхөн хохирогчийн зөвшөөрөлтэйгээр хийнэ.

Хохирогч эх орондоо бус өөр улс оронд үлдэж байгаа бол үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтан хохирогчийг тусlamж үзүүлэх байгууллага дээр очиход нь хамт явж, бичиг цаасны

ажилд нь тусалж, ганцаараа явж танихгүй байгууллага, хүнээс тусlamж гүйхдаа сэтгэлийн хямралд орохоос сэргийлбэл дээр байдаг. Гаднаас үйлчилгээ авахад төлбөр шаардлагатай ч үүнийг хохирогчид сайтар ойлгуулах ёстай.

**Хувийн боломж бололцоог үнэлэхэд туслах (тухайлбал, гэр бүлийнхэн эсвэл бусад хүмүүс).** Хохирогчид туслах сүлжээний үйл ажиллагааны чанар тухайн хүнийг нийгэмшүүлэх явцыг тодорхойлох чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Үйлчилгээ үзүүлэгч хохирогчийг хөтөлбөрөөс гарахад түүнд хамгийн үр ашигтай орчныг олж өгөх үүрэг хүлээдэг. Ихэнх тохиолдолд хохирогчид анхны сэтгэл зүйн тусlamж үзүүлсэн байгууллагын ажилтан (сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтан) нөхцөл байдлын үнэлгээг хийдэг. Учир нь тухайн ажилтан хохирогчийн гэр бүл, эсвэл дотны харьцаатай нایз нөхдийн харилцааг үнэлэхэд оролцсон байдаг. Зарим тохиолдолд ийм үнэлгээ хийхэд хүчирхийлэл (биийн болон сэтгэл санааны) гарсан харилцааг олж тогтоодог.

---

**Анхааруулга:** хүүхэд болон өсвөр насынхны гэр бүлийн харилцааны үнэлгээ хийх нь маш чухал юм. Хүүхдийг гэрт нь буцаах эсэхийг шийдэхэд эн түрүүнд хүүхдийн эрх ашгийг бодолцох ёстай. Ажилтнууд тухайн хүүхэд тухайн орчинд ямарваа нэгэн хохирол амссан эсэхийг олж мэдэх ёстай. (тухайлбал, дахин худалдагдсан, бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эсэх) Ажилтнууд мөн тухайн гэр бүл хүүхдээ тэжээх боломжтой эсэх, хүүхэд шаардлагатай халамж авдаг эсэхийг олж тогтоох ёстай ба энэ бүхнийг тодруулахын тулд хүүхдийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй холбоо барих шаардлагатай болдог. Хүүхэд буюу өсвөр насын хүүхэд урьд өмнө нь хүчирхийлэлд автаж байсан, үл тоомсорлосон зэргийг олж тогтоовол үйлчилгээ үзүүлэгч хүүхэдтэй ажиллаж, улсын нийгмийн халамжийн газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж хүүхдийн эрх ашгийн үүднээс ямар арга хэмжээ авахаа шийднэ.

---

Хохирогч эх орондоо буцахынхаа өмнө үйлчилгээ үзүүлэгч ажилтанд гэр бүлийнхэнтэйгээ холбоо тогтоохыг зөвшөөрсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хохирогчийн хүсэл, шаардлагыг эх орондоо очигоос нь өмнө туслалцаа үзүүлэх хүмүүст дамжуулдаг. Хохирогч хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээ

үзүүлэгч хохирогчийн дараахь зорилгоор гэр бүлийнхэн буюу өөр хүнтэй холбоо барина.

- Гэр бүлийн гишүүд буюу өөр хүмүүст хохирогчийн туулж өнгөрүүлсэн бүхнийг ойлгуулах
- Болж өнгөрсөн үйл явдал бол гэмт хэрэг гэдгийг ойлгуулах, энэ бүхэн хохирогчийн буруу биш, түүнийг буруутгах ёсгүй гэдгийг тайлбарлах
- Авах шаардлагатай аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар мэдээлэл өгөх
- Хохирогчийн сэтгэл санаа болоод хэсэг хугацаанд ямар байдалтай байж болохыг нь тайлбарлах
- Гэр бүлийн зүгээс ямар туслалцаа үзүүлж болохыг зөвлөх.

Хохирогчийн зөвшөөрөлгүйгээр буюу тэдний юу хийдгийг тодруулалгүйгээр хохирогчийн гэр бүл, дотно харьцаатай хүн буюу найз нөхөдтэй холбоо тогтоох ёсгүй.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ НЬ АЯЛАХАД ТОХИРОХ ЭСЭХ, ДАГАЛДАН ЯВАХ ЭМНЭЛГИЙН АЖИЛТАН**

263

Хохирогч эх орондоо дасан зохицож, нийгэмшихийн өмнөх шат болох дамжин өнгөрөх буюу очих газар руугаа явахаар бэлтгэх үед эрүүл мэндийн байдал аялахад тохирох эсэхт дүгнэлт хийдэг. Дүгнэлтийг хохирогч болон бусад зорчигчдын аюулгүй аяллыг хангах зарчмын дагуу гаргана. Асран хамгаалагчгүй насанд хүрээгүй хүүхэд буцахдаа Бүлэг 3-т заасан асран хамгаалал болон ёс зүйн зарчмын зааврыг мөрдөнө. Мөн энэ бүлгийн эхэнд дурьдсан зарчим болон анхааруулгыг мөрдөнө.

Эмнэлгийн ажилтан (нэн ялангуяа нислэгийн үед) дагалдан явах шаардлагатай эсэхийг энэ бүлгийн сүүлийн хэсэгт дурьдсан эмнэлгийн мөрдлөг гэсэн гарчиг дор мөрдөх зарчмуудыг дэлгэрэнгүй зааж өгсөн болно.

### **5.15 АЖИЛТНУУД БА ЭРҮҮЛ МЭНД**

Энэхүү хэсэгт үйлчилгээ үзүүлж буй болон хамтран ажилладаг

байгууллагуудын ажилтнуудын ажлын байрны эрүүл мэндтэй холбоотой асуудлыг хөндсөн болно. Мөн ажилтнуудын эрүүл мэнд, чиг хандлага, ур чадварын түвшин зэрэг тэдний халамжинд байгаа хохирогчдын сайн сайхан шууд нөлөөлөх хүчин зүйлүүдийн талаар ярилцах болно.<sup>61</sup>

Аюулгүй байдал, сэтгэлийн хямрал, болон ажлын байртай холбоотой бусад эрүүл мэндийн эрсдэлийн талаар (эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар) болон ажилтнуудыг сонгон шалгаруулах, дэмжлэг үзүүлэх тухай авч үзнэ.

### 5.15.1 СЭТГЭЛИЙН ДАРАМТ

Ажилтай холбоотой сэтгэлийн дарамт өндөр эрсдэлд, шахалтанд ажилладаг хохирогчдод тусlamж үзүүлж байгаа ажилтнуудад тохиолддог. Дарамт гэдэг нь хүмүүсийн хүлээн авсан аюул буюу сэтгэл зүйн логикийн хариу үйлдэл бөгөөд хүнийг тухайн үйл явдлыг хянах, эрсдэлийг бууруулах зорилгоор үйл хөдлөлөө өөрчлөхөд хүргэдэг. Байнгын буюу урт хугацаанд дарамт үүсгэгч буюу дарамт өсөн нэмэгдэж байгаа бол үйл хөдлөл, зан ашны өөрчлөлт тогтвортой болж энэ нь биеийн буюу сэтгэл зүйн шинж тэмдгээр илэрдэг. Эдгээр хариу үйлдэл нь тустай байдаг ч аюул тулгарсан үед амь гарах болоолцоог олгохоос гадна мөн аюул заналхийлэл тулж өнгөрсний дараа сул болж, заримдаа хэт ядаргаанд оруулах нь бий.

Дарамтын шалтгаана нь олон талтай байх ба өөрийн гэсэн онцлогтой. Тусlamж үзүүлэх хүмүүст тохиолддог дарамтын зарим үндсэн шалтгаанууд нь:

- Аюулгүй байдалдаа санаа зовох
- Шуурхай байх, хохирогчийн хүсэл хэрэгцээний цар хүрээ, түвшин
- Ачаалал ихтэй буюу нөөц бололцоо багатай байгууллагуудад ажиллаж буй ажилтны ачаалал
- Шийдвэр гаргах шаардлагатай асуудал “ачаа”. Нэн ялангуяа хохирогч тусlamжийн хөтөлбөрт оролцох шаардлага хангаж байна уу үгүй юу гэдгийг шийдвэрлэх. Учир нь зарим хохирогчийн хувьд энэ нь үхэл амьдралын зааг дээрх шийдвэр байдаг

- Θөрийгөө буруутгах, айх, уурлах, тухайлбал, хохирогч хөтөлбөрөөс гарахад, алдаа хийсэн мэт санагдах, тусlamж муу үзүүлсэн, эсвэл хохирогчийн хүлээлтийг даагаагүй
- Уур уцаартай, өөрийгөө хамгаалсан, хохирогч хүнд туслалцаа үзүүлж байгаадаа сэтгэл хангалуун биш байх
- Хүлээсэн үүргээ зөрчиж байгаад баригдах, тухайлбал, хохирогчид туслах болон хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллахдаа хууль, санхүүгийн зэрэг хязгаарлалттай ажиллах
- Бусдад өөрт тулгарсан бэрхшээл буюу дарамтыг ярихаас татгалзах (тухайлбал, чадваргүй гэдгээ харуулахаас айх, ажилдаа тохирохгүй байх буюу мэргэжлийн ур чадваргүй, хязгаарлалтад хэт мэдрэмтгий хандах, хэн нэгний ажилд аюул учруулах, даалгасан ажлыг гүйцэтгэж чадахгүй байх гэж айх, ажил дээрээ сэтгэл хөдлөлөө харуулах)<sup>62</sup>
- Θөрт тулгарсан бэрхшээлээ ярих хүн байхгүй байна гэж бодох, саад бэрхшээлээ хуваалцах газар байхгүй гэж сэтгэх
- Ажлынхнаас бусад нь түүнийг дэмжихгүй байна гэсэн бодолтой болох (тухайлбал, гэр бүлийн гишүүд, наиз нөхөд, ажлыг нь хүлээн зөвшөөрдөггүй олон нийтийн хэсэг бүлэг, эсвэл тусlamж үзүүлж байгаа хүмүүст дургүй (тухайлбал, бие үнэлэгчид, насанд хүрээгүй зарим хүүхэд) байдаг хүмүүс)<sup>63</sup>

Дарамтыг илэрхийлдэг хамгийн их тохиолддог шинж тэмдэг бол хэт ядрах, унтаж чадахгүй байх гэдгийг судалгаагаар тогтоосон байна. Гэхдээ эдгээр хариу үйлдэл нь ихэвчлэн “дарамт” гэсэн тодорхойлолтыг тодотгох хязгаарлагдмал, соёл уламжлалтай холбоотой шинж тэмдгийг илэрхийлдэг ба эелдэг бус зан ааш эсвэл асуудлаа илэрхийлэх гэсэн хүмүүсийн хүсэл нь зөвхөн тэдний ажилтай холбоотой байдаг.<sup>64</sup>

Эмзэг давхаргын хүмүүстэй ажиллаж байхдаа тусlamж үзүүлж буй хүмүүс өөрийн ур чадвараа (болон хохирогчийн хариу үйлдлийг хязгаарлах) болон өөрт тохиолдсон хүндрэл бэрхшээлээ буруу дүгнэх нь бий. Хэт ачаалалтай, хэт их найдвар тавьж ажилласан хүмүүс өөрсдөө сэтгэл зүйн тусlamж шаардлагатай байгаагаа хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Хамгийн туршлагатай мэргэжилтнүүд ч гэсэн хохирогчтой ажиллаж байхдаа итгэлээ алдах, урамгүй болох, алдах, эсвэл айх, уурлах зэрэг зан ааш гаргадаг байна. Эмнэлгийн мэдрэлийн эмч Стюарт Тёрнер

тамлалт гэсгээлтээс амь гарсан хүмүүст тусlamж үзүүлж байхдаа дараахь тэмдэглэлийг хийсэн байна.

(...) зайлшгүй анхаарал тавих ёстой хоёр хүн байна. Өвчтний хэрэгцээ хүслээс гадна (...) эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг (...) мөн анхаарч үзэх ёстой. (...) Эмчид тулгардаг бэрхшээлийн нэг нь тамлалт гэсгээлтийн түүх болоод амьд үлдсэн хүний хийсэн үйлдлийг тэмдэглэж авахдаа сэтгэл нь хэт их хөдлөх явдал юм. Сэтгэлийн хэт хөдлөл нь ирээдүйд нэлээдгүй үр уршигтай асуудал үүсгэж болох юм.<sup>65</sup>

Стюарт Тёрнер эмчлэгч эмч нарт тохиолддог зарим нэг сэтгэл хөдлөлийн талаар мөн бичжээ. Итгэл найдваргүй болох, бүхнийг чадна гэсэн бодол, өвчтөнд тулгарсан асуудлаас зайлсхийх зэрэг нь олонтаа тохиолддог. Эдгээр нь эмчилгээ авах ёстой гэсэн заалттай зөрчилддөг.<sup>66</sup>

Тусlamж үзүүлж буй хүн өөрөө биеийн хүчирхийлэлд автсан буюу бэлгийн мөлжлэгт автсан байж болохыг анхаарч үзэх ёстой бөгөөд эсвэл тухайн үед хүчирхийлэлтэй тулгараад байж болзошгүй юм. Мөргөлдөөний үед буюу мөргөлдөөний дараахь үед, иргэний буюу улс төрийн тогтвортгүй байдалтай бус нутагт хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн эзлэх хувь нэлээдгүй өндөр байдаг. Тусlamж үзүүлж буй хүний хүчирхийлэл буюу ялгаварлан гадуурхах үзэлтэй тулгарч байсан туршлага нь хохирогчийн түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэж болох ба хийж буй ажилд нь саад болох магадлалтай байдаг. Шаардлагатай бол тусlamж үзүүлж байгаа ажилтнуудын амссан хүчирхийллийн талаар ярилцах боломж бололцоог тодорхойлох нь зүйтэй юм. Зарим хүмүүсийн хувьд өөрсдийнх нь туулсан амьдралын тухай ярилцах нь тэдэнд удирдлага болоод хамтран ажиллагсадын зүгээс ойлгох, тэдний дэмжлэгийг авч өөрийн давуу талыг мэдрэх боломж байдаг бол зарим хүмүүс ийм сэдвээр ярилцах нь тэдний хувийн амьдралд хэт оролцох гэсэн оролдлого гэж үздэг байна.

Хохирогчидтай нүүр тулж ажилладаггүй ч хийж буй ажлаасаа үл хамааран ажилтнуудын сэтгэл хөдлөлийг анхаарч үзэх ёстой ба зохих ёсоор арга хэмжээ авах ёстой.

## 5.15.2 ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ АЖИЛТНУУДАД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛ-ЦАА, ДАРАМТЫГ БУУРУУЛАХ

Хохирогчтой ажиллах ажилтнуудыг сонгож шалгаруулах ба тэднийг дэмжиж, удирдах ёстай. Ёс зүй болоод аюулгүй байдлын зарчмын талаар өгүүлсэн өмнөх бүлэгт авч үзсэн шаардлагуудын үндсэн шаардлага нь дунд эрүүл мэндийн ажилтан хохиоогчид тусlamж үзүүлэх эрхийг авахаас өмнө эн түрүүнд хүндэтгэх, хувь хүний нууцыг хадгалах, шударга байх болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй байх ёстай. Ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, сайн сайхныг сайжруулах, тэднийг дэмжихийн тулд урьдчилан сэргийлэх бүхий л хүчин чармайлтыг нэгтгэсэн олон талт арга хэмжээ авах шаардлагатай. Ажилтнуудын эрүүл мэнд, учирсан дарамтын талаарх тайланда ажлын нөхцөл дарамтын эх сурвалж болдог тухай дурьдсан байна.<sup>67</sup> Удирдлагын зүгээс ажилтай холбоотой дарамтыг бууруулах арга хэмжээ авах ёстай. Шаардлагатай нөхцөл бүрдүүлэх, ажилтнуудын хэрэгцээг хангах, уламжлал соёлыг хүндэтгэх үүднээс ажилтнуудын оролцоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлнэ.

### Дарамтаас сэргийлэх (стрессээс)

Удирдлага болоод ажилтнууд ажилтай холбоотой дарамтыг бууруулах, ажилтнуудын биеийн болон сэтгэл санааны байдлыг сайжруулахтай холбогдуулан авах хэд хэдэн арга хэмжээ бий. Үүнд:

- Удирдлага болон ажилтнууд боломжийн хирээр хамтран ажиллаж, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах ёстай. Энэ нь дарамтаас сэргийлэх үндсэн арга хэмжээний эхний болоод заавал авах арга хэмжээ болно
- Удирдлагын зүгээс ажилтнуудын эрүүл мэнд, дарамттай холбоотой тэдний сэтгэлийг зовоосон бэрхшээлүүдийг шаардлагатай хүссэн үед нь хуваалцах, ажилтнуудын биеийн болон сэтгэл санааны байдлыг мэдэж байх
- Удирдлага ажилтнууд хүлээж буй үүрэг хариуцлагын ачааллыг багасгах арга хэмжээ авах. Тухайлбал, хэргүүдийн талаар шийдвэр гаргах үүрэг, үүнд хөтөлбөрт хамрагдах эсэхийг

тодорхойлох. Ингэснээр ажилтнууд ганцаараа тэрхүү хүнд ачааг үүрэг хүлээхгүй ба мөн тохиолдол бүрт хүлээх үүргээ ухамсарлана. Мөн үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлох – ажилтнуудын үүрэг хариуцлагыг хязгаарлан зааж өгөх

- Ажилтнууд өөрсдийн хийж болох зүйлийн боломж бололцоог мэддэг бөгөөд мөн тусlamж үзүүлж буй хүнийхээ чадвар, боломжийг мэддэг. Гэхдээ шийдвэрлэж болохгүй зарим нэг тохиолдол гардаг.
- Ажилтнууд болон удирдлага тухайн албан байгууллагын соёл уламжлалын ялгааг тодруулахдаа хамтран ажиллана
- Ажилтнууд болон удирдлага ажиллах болон дарамтыг бууруулахад тохиромжтой орон зайл өөрсдөө зохион байгуулж төлөвлөх ёстой
- Ажилтнууд болон удирдлага эдлэх ёстой амралт эдлэх боломж гарахаар ажлаа зохицуулах ёстой бөгөөд удирдлага амралт, чөлөөт цагийг зөвхөн тэр зорилгоор ашигласан эсэхийг мэдэж байх ёстой.

## Дарамтыг эмчлэх

Эмчилгээ гэдэг нь зарим талаараа арга хэмжээ авах буюу ажилтай холбоотой үүсэх дарамтыг бууруулах гэсэн үг юм. Дарамтыг бууруулахтай холбоотой авсан арга хэмжээг үнэлж дүгнэхдээ ажилтнууд ихэвчлэн өөрсөддөө тусlamж үзүүлсэн, мөн наиз нөхөд, хамт ажиллагсад, гэр бүлийнхнээс тусlamж дэмжлэг авсан гэж хариулдаг байна. Ажилтнууд зөвхөн өөрийн хувийн нөөц бололцоондоо тулгуурлан дарамтыг бууруулах ёсгүй бөгөөд эсвэл бусад ажилтнуудтай тулгарсан асуудал бэрхшээлийн талаар, ажилтай холбоотой дарамтын талаар ярилцаж сэтгэлээ нээх ёстой.

Ачаалал ихтэй ажилладаг хамт олны удирдагч “дарамтын менежмент” гэж нэрлэгдэх хөтөлбөр, аргуудыг тодорхойлж хэрэгжүүлэх ёстой. Дарамтыг арилгах зорилготой хөтөлбөрүүд нь дарамт бол ачаалалт ихтэй ажил болон ажлын хүнд нөхцөлд хандах энгийн хандлага гэсэн үндэслэл дээр суурилагдах ёстой бөгөөд ингэснээр хэн нэгэн ажлын ачаалаллынхаа талаар санаа зовохгүй байх, эсвэл ажлын байранд ярихаас

татгалзахгүй байх ёстай. Дарамтын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажилтнуудад дээрх мессежийг өгч, хүмүүсийг ажилтай холбоотой дарамтаа нухгүй байх нөхцлийг бүрдүүлдэг. Эдгээр хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд соёл уламжлал, туршлагыг анхаарч үзнэ. Дарамтын менежментийг хэрэгжүүлэхийг хичээж буй байгууллагууд ажлын байрны эрүүл мэндийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, санал болгоод буй дарамт бууруулах үйл ажиллагаа, байгууллагын дотоод журам болоод зохион байгуулалт ажилтнуудын хэрэгцээг хангасан, нөхцөл байдалд тохирсон эсэхийг шалгана.

### **5.15.3 БИЕЙИН ХЯМРАЛЫГ ОЙЛГОХ, ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ**

Ажиллагсадыг хүн худалдах гэмт хэргийн хохирогчтой үр дүнтэй ажиллахад нь шаардлагатай эх үүсвэр, харилцаа холбоогоор хангахад менежерийн гол үүрэг оршино. Ажиллагсадыг бие даан ажиллахыг нь хөхиулэн дэмжиж, ажлын байран дээр гаргаж болох сэтгэлийн хөдөлгөөний хэмжээ хязгаарыг тогтоох ёстай. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч зэрэг сэтгэл болон бие бялдрын хямралд орсон этгээдүүдтэй харьцах болон тэдгээрт үйлчилгээ үзүүлэх нь тэдгээртэй харьцаж буй ажиллагсадад сэтгэл зүйн тодорхой нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь сэтгэлийн нэмэлт хямралд хүргэж болзошгүйг менежерүүд анхаарах нь зүйтэй.<sup>68</sup>

Сэтгэлийн хямрал хэсэг хугацаанд тогтмол хуримтлагдсанаас болж эцэх тохиолдол гарч болзошгүй юм. Эцэлт гэдэг нь сэтгэлийн хөдөлгөөн шаардсан нөхцөл байдалд удаан ажилласнаас үүсэх бие, сэтгэл, оюун ухааны ядралын байдлыг хэлнэ.

Ажиллагсадын дотор эцэх тохиолдол байгаа эсэхийг илрүүлэхийн тулд менежерүүд болон бусад харгалзагч албан тушаалтнууд дараах таван шинж тэмдгийг анхаарах ёстай:

- Биед илрэх шинж: Ядрах, гэдэс хodoод хямрах, эцэх, нойргүйдэх болон толгой өвдөх, ханиад хүрэх, ханиалгах зэрэг бие махбодийн хямрал.
- Сэтгэлийн илрэл: Уцаарлах, сэтгэл санаа тогтвортгүй болох, өөрийгөө бууруутгах, ганцаардах, хүчин мөхөсдөх мэт санагдах

- Биеэ авч явах байдал: Уурлах, бүдүүлэг авир гаргах, гутранги үзэлтэй болох, өрөвч бус байх.
- Ажлын байртай холбоотой: Ажлын үзүүлэлт буурах, ажил таслах, ажлаас хоцрох
- Хүн хоорондын харьцаа: Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, амьдрагч этгээд болон хамт ажиллагсадаас зугтаах

Эдгээр шинж тэмдэг илэрвээс менежер болон бусад харгалзагч албан тушаалтан дараах арга хэмжээ авах ёстой:

- Түүний амьдрагч этгээдэд үзүүлж байгаа тус дэмжлэгийг өөрт нь үзүүлэх: сэтгэлийн дэм, тохь тух, хөхиүлэн дэмжих, зөвлөгөө өгөх г.м.
- Сэтгэлийн хөдөлгөөний хэмжээ хязгаарыг сануулах, зүйлсийг бодитоор харахыг анхааруулах
- Ажил үүргийн хуваарыг тохирох өөрчлөлт хийх
- Гаднаас сэтгэц мэдрэлийн эмчтэй ярьж зөвлөлдөхийг санал болгох
- Долоо хоног тутмын уулзалтан дээр ажиллагсадыг сэтгэлээ илэрхийлэх боломж олгох, эрэг бодлого болон шийдэл боловсруулахад анхааруулах.

#### **5.15.4 АЖЛЫН БАЙРАНД ЦУСНЫ ӨВЧИН ТЭЭГЧ ВИРУС ХАЛДВАРЛАХ ЭРСДЭЛ**

Цус бол ХДХВ болон В, С гепатит вирус халдвартлах цорын ганц эх үүсвэр юм. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын ажиллагсад цусан дахь өвчин тээгч вирусын байдал нь үл мэдэгдэх хүмүүсийн цус болон шингэнтэй харьцаж болзошгүй. Хэдийгээр В гепатит вирус ХДХВ-г бодвол дамжих бололцоо нь илүү боловч эдгээр хоёр вирусын халдвартлах арга зам нь ижил юм. Эдгээр өвчнүүд булчинд тария хийх, зүүгээр хатгах, ил шархтай харьцах, гэмтээгүй арьсанд (урагдсан, хөлөрсөн, арьс өнгөний өвчтэй) болон салстлаг хальсанд хүрэх зэрэг замаар ажлын байран дээр дамжих боломжтой. С гепатит вирусын халдвар тохиолдол бага илэрсэн хэдий ч ажлын байран дээрх халдвартлах нь дийлэнх тохиолдолд булчинд тария хийх аргаар дамждаг ажээ.

Цусан дахь өвчин тээгч вирусын халдвартыг хянах хүчин чармайлт

нь цусыг ил гаргахгүй байх болон В гепатит вирусын эсрэг дархлаажуулалтын ажил явуулахад чиглэх ёстай. Ажлын байран дээрх эрүүл мэндэд нь учирч болзошгүй аюулаас ажиллагсадыг урьдчилан хамгаалах эм, эмийн бэлдмэл бүхий хайрцаг байх ёстай.

### **5.15.5 АЖИЛЛАГСАДЫН СУРГАЛТ**

Сургалт нь үйлчилгээний чухал хэсэг юм. Ажилтныг зохих сургалтанд хамруулахгүйгээр түүнээс ажлын өндөр үзүүлэлт хүлээж болохгүй. Ажиллагсадыг сургалтанд хамруулахдаа дараах зүйлсийг анхааралдаа авч үзэх нь зүйтэй:

- Хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотойгоор: гэмт хэргийн мөн чанар, үзүүлэлт, тодорхойлолт, хэлбэрүүд, шалтгаан, мөлжлөг болон хүчирхийллийн хэлбэрүүд, хор уршиг (нэн ялангуяа эрүүл мэндийн хувьд), хохирогч, гэмт хэрэгтэн, сэтгэлийн шарх.
- Аюулгүй байдлын үндэс
- Ажиллагсадын үүрэг, роль ба тэдгээрийн хязгаарлалт
- Хүний эрх, эрүүл мэнд, ялгаварлан гадуурхалт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хөдөлмөр, цагаачлал г.м. асуудлууд
- ДОХ/ХДХВ, түүнтэй холбоотой худал яриа болон бодит байдал
- Сексийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
- Бие махбодь, сэтгэлийн шарх болон түүний хор уршиг (гол төлөв харьцах нийгмийн бүлгийн дунд тогтсон) соёл, зан заншил, хэм хэмжээ

Мэдээлэл ихтэй ажиллагсад ажилдаа илүү дуртай бөгөөд өөрсдөөдөө хэдийчинээ итгэлтэй байна, төдийчинээ өөрсдийн үзүүлж буй үйлчилгээндээ итгэлтэй байх бөгөөд наймаалагдсан хүмүүст мөн төдийчинээ сайн тусламж үзүүлэх чадвартай байна.

### **5.16 Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч түнш байгууллагууд**

Наймаалагдсан хүмүүст анхны үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь байр сууцны багтаамж хүрэлцээ муутай тохиолдолд эрүүл

мэндийн үйлчилгээ үзүүлэгч гадны байгууллагатай хамтран ажиллах нь маш чухал юм. Энэхүү хэсэгт үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь худалдагдсан хүмүүст эмнэлэгийн дараагийн тусlamж үзүүлэх гадны түвш байгууллагад дүн шинжилгээ хийх, сонгох, хамтран ажиллахад туслах зорилгоор эрүүл мэндтэй холбоотой зарим мэдээллийг агуулсан болно. Мэргэшсэн түвш байгууллагуудаас шаардлагтай үед эмнэлэгийн бүх талын тусlamж авах, тэдгээр байгууллагуудыг өвчтөн хүлээн авах тухай мэдээлэлтэй болон бэлтгэлтэй байлгахын тулд тэдгээр байгууллагуудыг аль бол эрт таньж мэдэх хэрэгтэй. Гадны эрүүл мэндийн болон эмнэлэгийн байгууллагууд дор хаяж дараахь үйлчилгээг үзүүлэх чадавхитай байх ёстой.

Анхан шатны эмнэлэгийн үзлэг үзүүлэхэд тавигдах доод шаардлагууд:

- **Эрүүл мэндийн болон өвчиний түүх.** Энэхүү бүлгийн өмнөх хэсгүүдэд заасан зааварчилгааны дагуу зайлшгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу хийгдэх ёстой.
- **Биеийн үзлэг.** Энэхүү хэсэгт багтсан мөн зааварчилгааны дагуу явагдах ёстой.
- **Сэтгэцийн эрүүл мэнд.** Онцгой анхааралд нэн даруй авах хүмүүсийг илрүүлэхийн тулд сэтгэцийн байдлыг шалгах.

Эмнэлэгийн нэмэлт үзлэгт дараахь зүйлс багтана:

1. **Лаборатори болон радиологийн шинжилгээ.** Түүний дотор цээжний рентген зураг, цус болон шээсний шинжилгээ, лабораторийн бусад шинжилгээ (наймаалагдсан хүнд тестээс өмнөх эсвэл дараах зөвлөгөө үзүүлэх тохиолдолд ХДХВ-н шинжилгээ үүнд багтана). Ихэнх тохиолдолд түвш байгууллагууд өөрсдийн санхүүжилт болон үйлчилгээний боломжоос хамааран лаборатори болон радиологийн шижнилгээг анхан шатны эмнэлэгийн үзлэгт багтаах эсэхээ шийддэг бөгөөд яаралтай тохиолдолд хийж болно.
2. **Дэлгэрэнгүй мэдээлэл.** Өвчиний түүх, биеийн үзлэг, лабораторийншиنجилгээ, түүний дотор сэтгэц мэдрэл, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хагалгаа болон бусад холбогдох мэдээллээс олж авсан аливаа чухал баримт мэдээллийг

судлах, батлах, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдээс дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

3. **Эрүүл мэндийн мэдээлэл.** Үүнд дээрх мэдээллүүдийг багтаан үйлчилгээ үзүүлэгчид тайлгаха, оношлох (туршилтын дифференциал шинжилгээ), цаашид явуулах судалгаа, санал болгох эмчилгээ болон түүний хяналт, өвчтөний талаарх таамаг зэрэг багтана.
4. **Дуудлага авсны үндсэн дээрхамгаалах байр, гэрт очих.** Үзлэг хийх, жор бичих, эмчилгээний явцыг хянах, холбогдох арга хэмжээ авах (тариа тарих, сэтгэл зүйн эмчилгээ, зөвлөгөө г.м.) дараа дараагийн эмнэлэгийн хяналттай холбоотойгоор мэдээлэл авах зорилгоор оромж, гэрт очино.

Үйлчилгээний гадны байгууллагыг сонгоходоо болон түүнтэй үр дүнтэй хамтран ажиллахын тулд дараах зүйлсийг анхааран үзэх ёстой.

1. **Үйлчилгээнд дүн шинжилгээ өгөх.** Үйлчилгээний үзүүлэгч гадны байгууллагын үйлчилгээг тохирох эсэхэд дүн шинжилгээ өгөхдөө дээр заасан үйлчилгээнүүдийг мэдээллийн ангилалд багтаана.

Эдгээр мэдээллийг хэлэлцүүлэг, үйлчилгээ хэрхэн үзүүлж байгааг харах, тухайн салбарын мэргэжилтнүүд эсвэл эмчлүүлэгсэдтэй ярилцах замаар цуглуулж болно.

- **Үйлчилгээний төрөл.** Наймаалагдсан хүмүүст ямар үйлчилгээ санал болгож байгаа болон тэдгээр үйлчилгээ нь хэрэгтэй үйлчилгээ мөн эсэхийг шалгах.
- **Багтаамж.** Үйлчилгээ тус бүрийг үзүүлж чадах хэдэн хүн байгаа, тэдгээрийн ажлын цаг, мөн өдөр болон долоо хоног тутам хэдэн өвчтөнүүдэд төрөл бүрийн эмчилгээ үзүүлж чадахыг судлах.
- **Чанар.** Тухайн байгууллага хэд дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгааг мэдэх: тоног төхөөрөмж орчин үеийнх эсэх, өвчтнийг асрах болон эмнэл зүйн менежмент нь олон улсын жишигт нийцэж байгаа эсэхийг (нууцыг чандлан хадгалах,

өвчтнүүдийн яс угсааг хардаг эсэх, тухайн улсын эрүүл мэндийн байгууллагаас зохих ёсны итгэмжлэл, зөвшөөрөл авсан эсэх г.м.) шалгах.

- **Ажиллагсад.** Ажиллагсадын боловсрол, мэргэшил. Одоогийн эрхэлж буй эсвэл эрхлэх гэж буй ажилдаа хэдэн жил ажиллаж байгаа болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын өвчтнүүдийг хэн голлож хариуцахыг судлах.
- **Сургалтын хэрэгцээ.** Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тухайн түнш байгууллагынхаа эрүүл мэндийн жишгийг энэхүү гарын авлагт заасан жишиг хүртэл дээшлүүлэх зорилгоор тус байгууллагын ажиллагсадыг сургалтанд хамруулах шаардлага, боломж байгаа эсэх (түүний дотор цаг хугацаа, хүчин чармайлт, санхүүгийн зарлага г.м.)
- **Хязгаарлалт.** Энэхүү гарын авлагад заасан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чадвартай эсэх; шийдвэрлэж чадахгүй байгаа бэрхшээл байгаа эсэх, баримтлах ёстой аливаа хориг хязгаарлалт байгаа эсэх (санхүү, нас, хүйс, яс угсаа).
- **Найдвартай ажиллагаа.** Ажлын болон хүлээн авалтын цаг баримтлаж байгаа эсэх. Гэрээнд зааснаас гадна “нэмэлт төлбөр” буюу хээл хахууль төлөх шаардлагатай эсэх (авилга, хээл хахууль дэлгэрсэн газар байвал). Өөрсдийн үзүүлнэ гэсэн бүх үйлчилгээгээ үзүүлж чадаж байгаа эсэх.
- **Цагийн баримжаа.** Наймаалагдсан хүн хэр хурдан төрөл бүрийн үйлчилгээ авч чадаж байгаа эсэхийг шалгах. Шинжилгээний хариу хэр хурдан гарч байна вэ.
- **Хэл болон соёл.** Хэл нэвтрэлцэхэд мэргэжлийн орчуулагчтай эсэх (хөгжилтэй орнууд дахь улсын эрүүл мэндийн байгууллагад илүүтэйгээр байдаг); соёлын зуучлагч байгаа эсэх.

2. **Байгууллагын болон ажиллагсадын соёлыг шалгах.** Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь наймаалагдсан хүмүүст үзүүлэх үйлчилгээнд нөлөөлөхүйц ялгаварлан гадуурхах бодлого болон үйл ажиллагаатай байгууллагатай түншлэлд орж болохгүй. Ихэнх тохиолдолд түнш байгууллагууд сургалтанд, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон бэлгийн дарамттай холбоотой асуудал хөндсөн сургалтанд хамрагдах хүсэлт гаргадаг.
3. **Нууцыг чандлан хадгалахыг шаардах.** Нууцыг хадгалах нь маш чухал бөгөөд сонгогдсон түнш байгууллагууд энэ үүднээс өөрсдийн албан ёсны бодлого болон үйл ажиллагааны

дагуу өвчтний түүх, мэдээллийн нууцыг чандлан хадгалах арга хэмжээтэй байх ёстай. Өмнө нь өвчний тухай олон нийтэд дэлгэдэг байсан улс, орнуудад БЗХӨ, түүний дотор ДОХ өвчний шинжилгээ нь зэрэг гарсан хэвтрийн өвчтний болон бусад наймаалагдсан хүмүүсийн эрх зөрчигдөөгүй эсэхэд тавих хяналт чанга байх ёстай. Нууцын жишгийг үйлчилгээний гэрээнд тусгасан байх ёстай бөгөөд тэрхүү заалт нь зөрчигдвөөс түншлэлийн гэрээг цуцлах нь зүйтэй.

4. **Сургалтанд хамруулах.** Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажиллагсадыг хамруулдаг сургалтанд бүх түнш байгууллагуудыг мөн адил урьж хамруулах ёстай.
5. **Мэдээлэл хуваалцах арга барилыг бий болгох.** Наймаалагдсан хүмүүс өвчний болон эрүүл мэндийн баримтаа үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсвэл түнш байгууллагын алиинд нь байгаа эсэхээс үл хамааран үзэх эрхтэй. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага тухайн хувь хүний эмнэлэгийн баримтан дахь мэдээллийг тодорхой шаардлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор болон тухайн хувь хүнд оношны талаар мэдээлэх үүрэгтэй тохиолдолд авна.

## 5.17 Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны менежмент

Хүн наймаалах гэмт хэргийн хохирогсодын хувийн хэрэгтэй хэрхэн харьцах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 1-р бүлгийн 1.2 хэсгээс харна уу.

Энэхүү хэсэгт эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн тогтолцоо болон наймаалагдсан хүмүүст үйлчилгээ үзүүлэх үед түүнийг хэрхэн ашиглах талаар заана. Эрүүл мэнд болон эмнэлэгийн мэдээлэлтэй хэрхэн харьцах нь зөв оношлох болон эмчлэх, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хооронд эрүүл мэндийн тухай мэдээлэл үр дүнтэй солилцоход маш чухал нөлөөтэйгээс гадна наймаалагдсан хүмүүс өөрсдийн эрүүл мэндийн байдал, шаардлагатай эмчилгээг мэдэх, өвчний түүхийн бүрэн хувийг авах, цуглуулсан мэдээллийн нууцыг хадгалахад мөн адил чухал юм.

Энэхүү хэсгийн зорилго нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас дэм, тус авч буй наймаалагдсан хүмүүсийн эрүүл мэндтэй холбоотой

МЭДЭЭЛЭЛТЭЙ ХЭРХЭН ХАРЬЦАХ ҮНДСЭН ОНЦЛОГУУДЫГ ЗААХАД ОРШИНО.

## 5.17.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТҮҮНИЙ МЕНЕЖМЕНТ (ЗОХИЦУУЛАЛТ)

### Эрүүл мэндийн тухай мэдээллийн тодорхойлолт

Эрүүл мэндийн мэдээлэл гэдэгт наймаалагдсан хүний бие, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндтэй холбоотой бүх мэдээлэл багтана. Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо гэдэг нь эрүүл мэндийн тухай мэдээллийг цуглуулах, зохион байгуулалтанд оруулах, хадгалах, солилцох, мэдээлэх арга замыг хэлнэ.

### Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх

Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог (ЭММТ) хөтөлбөрийн удирдлагын мэдээллийн тогтолцоог (УМТ) боловсруулахтай зэрэгцүүлэн хөтөлбөрийн бодит үйл ажиллагаа эхлэхээс өмнө аль болох эрт бий болгох хэрэгтэй. Мэдээллийг цуглуулах, оруулах, харьцах хүмүүсийг уг тогтолцоонд ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах ёстай.

### Хавтаст хэргийн аюулгүй байдал: Кодлох ба нууцлал

Аюулгүй байдал болон нууцлалын зорилгоор мөн чухал мэдээллийг алдагдахаас болон буруу газар байрлуулахаас урьдчилан сэргийлэхийн тулд баримт бичигтэй харьцахдаа цаг ямагт анхааралтай байх ёстай.

Хувь хүмүүсийн нэрсийг зөвхөн үндсэн код бүхий хүснэгтэнд бичсэн байх бөгөөд тэдгээр хүмүүсийг кодлож, тус хүснэгтийг тухайн байгууллагын цорын ганц этгээдэд аюулгүй байдлыг ханган хариуцуулна.

Бусад баримт бичигт хувь хүмүүсийг зөвхөн оноосон кодын дугаараар бичнэ. Баримт бичиг салгах тохиолдолд эргүүлэн нийлүүлэх үүднээс кодын дугаарыг тухайн хавтаст хэргийн хуудас тус бүрийн дээд өнцөгт бичнэ.

## 5.17.2 ХАВТАСТ ХЭРЭГ ДЭХ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН НУУЦЛАЛЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

- Хавтаст хэргийг зөвхөн таних кодын дугаараар таних ёстай. Хувь хүмүүсийн нэrsийг кодын дугаартай нь холбож буй үндсэн баримтыг хамгаалалттай газар хадгалах ба уг баримтыг эрүүл мэнд хариуцсан гол этгээд л авч үзэх эрхтэй байна.
- Кодлосон (нэр заагаагүй) хавтаст хэргийг хамгаалалттай газар хадгалах ба тухайн хэрэг дээр ажиллаж буй ажилтан л авч үзэх эрхтэй байна.
- Ажиллагсадын хооронд болон ажиллагсад ба түнш байгууллагуудын хоорондох баримт бичгийн солилцоог зөвхөн тодорхой шаардлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор болон тухайн хувь хүнд оношны талаар мэдээлэх үүрэгтэй тохиолдолд тухайн наймаалагдсан этгээдийн зөвшөөрөлтэйгээр хийнэ.
- Хавтаст хэргийг хэзээ ч хараа хяналтгүй орхиж болохгүй (ширээ, олон нийтийн газар г.м.)
- Хэргийн талаарх мэдээллийг наймаалагдсан хүнээс сгай зөвшөөрөл авалгүйгээр ажлаас гадуурх бусад этгээдэд хэрхэвч мэдээлж болохгүй.
- Ажиллагсадын хооронд болон ажиллагсад ба түнш байгууллагуудын хоорондох баримт бичгийн солилцоог хэрхэвч (танхим, хүлээлгийн өрөө, хаалга нь нээлттэй ажлын өрөө, бусад хүмүүсийн дэргэд, хоолны газар г.м.) олон нийтийн газар явуулж болохгүй.
- Наймаалагдсан хүний хэргийг өөр наймаалагдсан хүнтэй хэрхэвч ярьж болохгүй. Тодорхой тохиолдолд эсвэл эмчилгээний зорилгоор тухайн хүний хэрэгтэй төстэй хэргээс жишээ татах болбол тухайн жишээ татан ярьж буй хэргийг таних боломжгүй байх үүднээс нэр болон хувийн бусад мэдээллийг өөрчлөх хэрэгтэй.
- Ажиллагсад наймаалагдсан хүмүүстэй зөвлөлийн болон ажиллагсадын уулзалтын үеэр өөрсдийн ажлын талаар ярьж болно. (Сэтгэцийн) эрүүл мэндийн ажилтнууд өөрийн багийн эрүүл мэндийн ахмад ажилтнуудаас тогтмол зөвлөгөө авч ярилцах, нэн ялангуяа энэ зорилгоор томилогдсон гадны эрүүл мэндийн мэргэжилтнээс зөвлөгөө авах, ярилцах нь ердийн үзэгдэл (ялангуяа сэтгэц мэдрэлийн эмч гаднаас

урьж авчрах нь илүү үр дүнтэй байдаг). Эрүүл мэнд хариуцан ажиллаж буй хүмүүс ажиллагсадын тогтмол уулзалт, зөвлөгөөн, хурал зэргийг зохион явуулах нь тэдгээрийн ажлын явцад тулгарч буй асуудлыг ярилцах, шийдвэрлэх нэг арга зам нь байх ёстой. Эрүүл мэнд хариуцан ажиллаж буй багийн хүмүүсийн өөр хоорондох зөвлөгөөн, уулзалтууд нь ажлын чанарыг дээшлүүлж, илүү уялдаа холбоотой болгож, ажилтай холбоотой сэтгэл зүйн дарамтыг буурулдаг. Эдгээр зөвлөгөөн, уулзалтын үеэр хуваалцсан мэдээллүүд нууцлагдах ёстой.

- Наймаалагдсан хүн нь насанд хүрээгүй бөгөөд гэр бүлийн гишүүн нь түүний хууль ёсны харгалзагч байгаагаас бусад тохиолдолд, мөн түүний тухай мэдээллийг бусдад дэлгэснээр түүнд аливаа аюул тохиолдох эсэхийг асууснаас бусад тохиолдолд ажиллагсад тухайн наймаалагдсан хүний хэргийн талаар түүний гэр бүл, найз нөхөдтэй нь ярилцахыг хориглоно.
- Дээрх журмууд хэлмэрч хүмүүст мөн адил хамаарах бөгөөд эдгээр журмуудын талаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гэрээт болон гэрээт бус бүтэн цагийн ажилтнуудад үүний талаар онцгойлон сануулна. (үйлчилгээний гэрээнд тусгасан байх ёстой).

### 5.17.3 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ХООРОНД МЭДЭЭЛЭЛ ХУВААЛЦАХ

Хэдийгээр хавтаст хэргийг хуваалцах нь хэд хэдэн эрсдэл агуулдаг хэдий ч наймаалагдсан хүнд тусlamж үзүүлж буй цөөн хэдэн хариуцлагатай хүмүүсийн хооронд зохих аюулгүй байдал болон нууцлалын дүрэм журмыг мөрдөн хуваалцсан мэдээ эрсдлээс илүү ашиг тус өгдөг. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч болон холбогдох байгууллагуудын хооронд мэдээ солилцох нь наймаалагдсан хүний хувьд нэгэнт өгсөн мэдээллээ давтан өгөх шаардлагагүй болдог (зарим тохиолдолд мэдээллийг давтан өгөх нь сэтгэл санааны хувьд хүнд байдаг) бөгөөд наймаалагдсан хүмүүст эрүүл мэнд, нийгмийн халамж болон хууль зүйн зөвлөгөө өгөгч хүмүүсийн хүргэх тус дэм болон бусад хамтын ажиллагаа хөнгөвчилж өгдөг юм. Наймаалагдсан хүн үүний тухай мэдэж байх ёстой бөгөөд зөвшөөрөл олгох эрхтэй. Байгууллагууд наймаалагдсан хүнд туслаж буй байгууллага болон хувь

хүмүүсийн хоорондох мэдээллийн солилцоонд зориулан тохирох шалгуур болон журам боловсруулах ёстой.

**Анхаарах нь:** Хэдийгээр хүний нэрийг сольж код ашигладаг ч тухайн хувь хүнийг түүний ерөнхий мэдээллээр нь амархан тодорхойлж болно (нийгийн бүлэг, яс угсаа, үндэс, төрсөн он, сар, өдөр, гэр бүлийн тухай мэдээлэл, хэрхэн наймаалагдсан тухай мэдээлэл г.м.). Эдгээр ерөнхий мэдээлэл нь тухайн хувь хүний хавтаст хэрэгт байхаас гадна туслах ажилтан, эмч нар түүнийг нь үзэх боломжтой тул тухайн хүний эрүүл мэндийн мэдээлэл бүрт нь дээрх мэдээллийг давтах шаардлаггүй.

Мэдээллийг цахим хэлбэрээр (цахим шуудан болон Интернет) солилцох болон дамжуулахдаа мэдээллийг нууцлах технологи (криптографи) ашиглах ёстой. Харьцангуй төсөр бөгөөд найдвартай системүүдийг өргөн ашиглаж байгаа бөгөөд зах зээл дээр чөлөөтэй худалдан авах боломжтой.

#### 5.17.4 ХУДАЛДАГДСАН ХҮН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛЭЭ АВАХ ЭРХ

ХХГХ-ийн хохирогчид бүгд өөрсдийн эрүүл мэндийн мэдээллийн хуулбарыг авах эрхтэйгээ мэдэж байх ёстой. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаасаа гарахын өмнө тэрхүү мэдээллийн хуулбарыг авна. Эрүүл мэндийн мэдээлэл (улсын болон хувийн эмнэлэг г.м.) гадны эмнэлэгийн байгууллагын мэдэлд байгаа тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд наймаалагдсан хүнд түүний эрүүл мэндийн бүх мэдээллийг авахад нь туслана. Мөн наймаалагдсан хүмүүс тэдгээрийг наймаалсан этгээд болон тэдгээрийг дарамталсан, ашигласан этгээдийн эсрэг эрүүгийн болон иргэний гомдол гаргахдаа ашиглах зорилгоор шүүх эмнэлэгийн шинжилгээний дүнгийн хуулбарыг авах эрхтэй. Эх орондоо эргэн ирж буй хүн болон тэдгээрт дагалдах эмнэлэгийн тусламж үзүүлэхийн тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тухайн хүнийг хариуцсан эмчийн бичсэн эмнэлэгийн тайланг түүний төрөлх хэл дээр өөрт байгаа боломжийг ашиглан орчуулан түүнд өгөх талаар хүчин чармайлт гаргана.

## Тэмдэглэгээ

- 1 НҮБ (2000). Нэгдсэн үндэстний байгууллага, Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд хүхүдүүдийг хууль бусаар наймаалагдахаас сэргийлэх, тэдгээрийг барих болон шийтгэх протокол, мөн Нэгдсэн үндэстний олон улс хоорондын зохион байгуулалттай гамт хэргийн эсрэг хэлэлцээрийг хавсаргав. G.A. Res. 55/25, Хавсралт 2, 55U.N. GAOR, Supp. (No.49) 60, U.N. Doc. A/45/49 (Боть 1) United Nations (2000). United Nations Protocol to Prevent, Suppress, and Punish Trafficking in Persons, Especially Women and Children, Supplementing the United Nations Convention Against Transnational Organized Crime. G.A. Res. 55/25, Annex II, 55 U.N. GAOR, Supp. (No. 49) at 60, U.N. Doc. A/45/49 (Vol. I).
- 2 Хүн худалдахаас сэргийлэх болон тэмцэх Брюсселийн тунхаглал. URL: <http://www.belgium.iom.int/STOPConference/Conference%20Papers/brudeclaration.pdf>; Европийн зөвлөлийн зөвлөмж R(2000) 11, Хүнийг бэлгийн мөлжлэгийн зорилгоор ашиглан худалдахын эсрэг арга хэмжээ (19/5/2000); Төв, Зүүн ба Баруун Европийн нийт хүн амын эрүүл мэнд ба хүн худалдах тухай бусийн бага хурал. Будапешт хот, Унгар улс, 3-р сар 9-21, (2003). Будапештын мэдэгдэл (2002). <http://www.iomskopje.org.mk/CT/pdf/budapest-dec.pdf>. Будапештын тунхаглалын гол санаа нь ХХХХ-ийн хохирогчдын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулах ба эхний эргүүлэн авчрах шатны үед тэдний эрүүл мэндийг эн түрүүнд авч үзэх болон нөхөн сэргээх явцыг тус тусд нь хамарсан стандарт протоколыг бий болгох олон талт арга барилыг голчлон илэрхийлсэн байна. Brussels Declaration on Preventing and Combating Trafficking in Human Beings. URL: <http://www.belgium.iom.int/STOPConference/Conference%20Papers/brudeclaration.pdf> ; The Council of Europe's Recommendation R(2000) 11 on Action Against Trafficking in Human Beings for the Purpose of Sexual Exploitation (19/5/2000); Regional Conference on Public Health and Trafficking in Human Beings in Central, Eastern and South-east Europe, Budapest, Hungary, 19-21 March. (2003). The Budapest Declaration (2002). [http://www.iomskopje.org.mk/CT/pdf/budapest\\_dec.pdf](http://www.iomskopje.org.mk/CT/pdf/budapest_dec.pdf). The Budapest Declaration outlines a multi-dimensional approach to address the health needs of trafficking victims and calls for the establishment of a standardized protocol that notes that different health priorities exist during the initial rescue phase and the rehabilitation phase, respectively.
- 3 Циммерман, С., К. Юун, И. Шваб нарын (2003). Эмэгтэйчүүд болон өсвөр насынхны худалдаалагдсанас үүсэх эрүүл мэндийн эрдэлүүд ба үр дагаварууд. Европ дахь судалгаагаар. Лондон: Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль. [http://www.lshtm.ac.uk/hpu/new\\_papers.htm](http://www.lshtm.ac.uk/hpu/new_papers.htm) Zimmerman, C., K. Yun, I. Shvab, et al. (2003). Health risks and consequences of trafficking in women and adolescents. Findings from a European study. London: London School of Hygiene and Tropical Medicine. [http://www.lshtm.ac.uk/hpu/new\\_papers.htm](http://www.lshtm.ac.uk/hpu/new_papers.htm)
- 4 Энэ нь хоёр Олон улсын шилжин суурьшлын байгууллагаас гаргасан хэвлэмэлд буй: Хүнийг наймаалах сэтгэцийн эрүүл мэндийн үзэл бодол, Дадлагын заавар (Будапешт, 2004) ба Хүний худалдах сэтгэцийн эрүүл мэндийн үзэл бодол, Хамгийн бага жишгийн бүрдэл. (Будапешт, 2004) This can be found in two IOM publications: The Mental Health Aspects of Trafficking in Human Beings, Training Manual (Budapest, 2004) and The Mental Health Aspects of Trafficking of Human Beings, A Set of Minimal Standards (Budapest, 2004).

- 5 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үндсэн хууль. [http://policy.who.int/cgi-bin/om\\_isapi.dll?hitsperheading=on&infobase-basicdoc&record={9D5}&softpage=Document42](http://policy.who.int/cgi-bin/om_isapi.dll?hitsperheading=on&infobase-basicdoc&record={9D5}&softpage=Document42)  
Constitution of the World Health Organization. [http://policy.who.int/cgi-bin/om\\_isapi.dll?hitsperheading=on&infobase-basicdoc&record={9D5}&softpage=Document42](http://policy.who.int/cgi-bin/om_isapi.dll?hitsperheading=on&infobase-basicdoc&record={9D5}&softpage=Document42)
- 6 НҮБ (2000). Нэгдсэн үндэстний байгууллага, Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдүүдийг хууль бусаар худалдааас сэргийлэх, тэдгээрийг барих болон шийтгэх протокол.
- United Nations (2000). United Nations Protocol to Prevent, Suppress, Punish Trafficking in Persons, Especially Women and Children.
- 7 Европын холбоо. (1997). Гаагийн сайд нарын тунхаглал болох Эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлэгийн зорилгоор худалдадааас сэргийлэх болон тэмцэх үр дүнтэй арга хэмжээнүүдийн тухай Европийн зааварчилгаа. 3-р булэг.
- European Union. (1997). The Hague Ministerial Declaration on European Guidelines for Effective Measures to Prevent and Combat Trafficking in Women for the Purpose of Sexual Exploitation Section III.
- 8 2002 оны 9-р сар, Хүнийг худалдааас сэргийлэх ба түүнтэй тэмцэх Брюсселийн тунхаглал, 13-р булэг.  
September 2002 Brussels Declaration on Preventing and Combating Trafficking in Human Beings Section 13.
- 9 НҮБ-ын Хүний эрхийн олон улсын зарчмуудын дээд хороо болон хүний эрх ба ХХГХ-ийн удирдамж, Удирдамж 6.  
United Nations Office of the High Commissioner for Human Rights International Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking Guide line 6.
- 10 Жишиг нь: Хүний эрхийн бүх нийтийн тунхаглал; Иргэний ба улс төрийн эрхүүд Олон улсын гэрээ хэлэлцээр; Эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхүүд Олон улсын гэрээ хэлэлцээр; Хүүхдийн эрхүүд гэрээ хэлэлцээр; Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалыг арилгах хэлэлцээр; Хүнийг худалдаалахыг барих болон бусдын биеийг үнэлүүлэн ашиглах ба шилжин суурьшигч ажилчдыг хамарсан олон улсын хөдөлмөрийн байгууллагын зэмсэг хэлэлцээр.  
Examples include: Universal Declaration of Human Rights; International Covenant on Civil and Political Rights; International Covenant on Economic, Social and Cultural Rights; Convention on the Rights of the Child; Convention on the Elimination of all Forms of Discrimination Against Women; Convention for the Suppression of the Trafficking in Persons and of the Exploitation of the Prostitution of Others, and various International Labour Organization Instruments concerning migrant workers.
- 11 Циммерман, С., К. Юун, И. Шваб нарын (2003). Эмэгтэйчүүд болон ёсвэр насыхны худалдаалагдсанаас үүсэх эрүүл мэндийн эрсдэлүүд ба үр дагаварууд. Европ дахь судалгаагаар. Лондон: Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль. Энэ бүлгийн ихэнх нь LSHTM судалгаанаас засварлагсан болно.
- Zimmerman, C., K. Yun, I. Shvab, et al. (2003). "Health risks and consequences of trafficking in women and adolescents. Findings from a European study". London: London School of Hygiene and Tropical Medicine. Much of this section has been adapted from the LSHTM study. [http://www.lshtm.ac.uk/hpu/new\\_papers.htm](http://www.lshtm.ac.uk/hpu/new_papers.htm)
- 12 Циммерман, С. К. Юун, И. Шваб нарын (2003). Эмэгтэйчүүд болон ёсвэр насыхны худалдаалагдсанаас үүсэх эрүүл мэндийн эрсдэлүүд ба үр

- дагаварууд. Европ дахь судалгаагаар. Лондон: Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль.
- Zimmerman, C., K. Yun, I. Shvab, et al. (2003). "Health risks and consequences of trafficking in women and adolescents. Findings from a European study". London: London School of Hygiene and Tropical.
- 13 Гушулак, Б.ба Д.Макферсон ( 2000 ). Шилжиш суурьшагчдыг хууль бусаар хил нэвтрүүлэх ба худалдахтай холбоотой эрүүл мэндийн асуудлууд. Шилжин суурьшагчдын эрүүл мэндийн сэтгүүл, Дугаар 2. №2, 2000  
Gushulak, B. and D. MacPherson (2000). "Health issues associated with the smuggling and trafficking of migrants". Journal of Immigrant Health, Vol. 2, No. 2, 2000.
- 14 Цагаачид ба цэллөгдөгсдийн Европын зөвлөл ( ECRE ) ECRE, Гаунт, С (1999) Европын холбоонд цагаачлагчдын интегралалын сайн дадлагат хөтөч.  
Adapted from The European Council on Refugees and Exiles (ECRE) ECRE Task Force, Gaunt, S., et al. (eds.) (1999) Good Practice Guide on the Integration of Refugees in the European Union: [http://www.ecre.org/erfproject/good\\_practice/intro.pdf](http://www.ecre.org/erfproject/good_practice/intro.pdf)
- 15 Боллини, П ба Х. Сием (1995 ). Тэнцвэрт байдалд жинхэнэ үнэн ололт үгүй: 2000 оны босгон дээрх Цагаачдын ба цөөнх бүлгийн эрүүл мэнд. Нийгмийн шинжлэх ухаан ба анагаах ухаан 41 (6) 819-828.  
Bolini, P. and H. Siem (1995). "No real progress towards equity: Health of migrants and ethnic minorities on the eve of the year 2000". Social Science & Medicine 41(6), 819-828.
- 16 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2003) Олон улсын Цагаачлал, Эрүүл мэнд ба Хүний эрх. [http://www.who.int/hhr/activities/en/intl\\_migration\\_hhr.pdf](http://www.who.int/hhr/activities/en/intl_migration_hhr.pdf)  
Zimmerman, C. and C. Watts (2003). WHO Ethical and Safety Recommendations for Interviewing Trafficked Women. London School of Hygiene and Tropical Medicine and World Health Organization: London.
- 17 Циммерман, С ба С. Ваттс (2003). WHO Худалдагдсан эмэгтэйчүүдээс ярилцлага авах хууль ёсны болон аюулгүй зөвлөгөөнүүд. Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль ба Дэлхийн эрүүл мэндийн байгууллага: Лондон.  
Zimmerman, C. and C. Watts (2003). WHO Ethical and Safety Recommendations for Interviewing Trafficked Women. London School of Hygiene and Tropical Medicine and World Health Organization: London.
- 18 Циммерман, С. (2004). Эмэгтэйчүүдийг худалдаалах: Эрүүл мэндийн эрдэлүүд болон гарах үр дагаваруудыг хэмжих, Эрүүл мэндийн бодлогын хэлтэсийн Докторын цол хамгаалах дипломийн ажил. Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль. Лондон.  
Zimmerman, C. (2004). "Trafficking in women: Conceptualizing and measuring health risks and consequences." Dissertation for PhD, in Health Policy Unit. London School of Hygiene and Tropical Medicine: London.
- 19 Чомарова, М. (2001). Эмэгтэйчүүдийг худалдаалах - Нэгдсэн бус Европ дахь биеийн, сэтгэл зүйн ба нийгмийн асуудлууд, Анимус холбооны сан/ Ла Страна, Редактор. 2001: София, Болгар улс.  
Tchomarova, M. (2001). "Trafficking in women – personal, psychological and social problems in (non)-united Europe", in Trafficking in Women, Animus Association Foundation/La Strada, Editor. 2001: Sofia, Bulgaria.
- 20 Чомарова, М. (2000). Эмэгтэйчүүдийг худалдаалах: Асуултууд ба Хариултууд. София, Анимус сан/ Ла Страна.

- Tchmorova, M. (2000). Trafficking in Women: Questions and Answers. Sofia: Animus Foundation/La Strada.
- <sup>21</sup> Циммерман, С. (2004). Эмэгтэйчүүдийг худалдаалах: Эрүүл мэндийн эрсдэлүүд болон гарах үр дагаваруудыг хэмжих Эрүүл мэндийн бодлогын хэлтэсийн Докторын цол хамгаалах дипломийн ажил. Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль. Лондон.
- Zimmerman, C. (2004). "Trafficking in women: Conceptualizing and measuring health risks and consequences". Dissertation for PhD, in Health Policy Unit. London School of Hygiene and Tropical Medicine: London.
- <sup>22</sup> 22-р бүлэг, Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхүүдийн 1966 оны 12-р сарын 16ны Ерөнхий Чуулганы шийдвэрээр 2200A (XXI) дэмжигдэж гарын үсэг зуралцаж нээгдсэн олон улсын гэрээ хэлэлцээрүүд, 27-р бүлгийн дагуу. Article 2 International Covenant on Economic, Social and Cultural Rights Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966, entry into force 3 January 1976, in accordance with article 27.
- <sup>23</sup> Липсон, Ж. Г нарын (1995). Сувилах ба асрах боловсролд соёлын үр чадварыг сурталчлах: Үйл явдлын шүүмжлэлтэй тойм ба дэлгэрэнгүй төлөвлөгөө, (Ленбург, С. Б) Вашингтон, Д.С: Америкийн Сувилагчийн Академи.
- Lipson, J. G., et al. (1995). Promoting Cultural Competence in and through Nursing Education: A Critical Review and Comprehensive Plan for Action (Lenburg, C.B., Ed.) Washington, D.C.: American Academy of Nursing.
- <sup>24</sup> Саммерфиелд, Д. (1999). Дайнд өртсөн газруудын сэтгэл зүйн гэмтлийн хөтөлбөрийн цаадахь долоон таамаглалын шүүмж, Нийгмийн шинжлэх ухаан ба анагаах ухаан 42, 1465-1471.  
Summerfield, D. (1999). "A critique of seven assumptions behind psychological trauma programmes in war-affected areas". Social Science and Medicine 42, 1465-1471.
- <sup>25</sup> Брюсса, Л. (1999). Эрүүл мэнд Цагаачлал Биеэ Үнэлэх: TAMPER-ийн дадлага түршлага. Амстердам: TAMPER Олон улсын Сан.  
Brussa, L. (ed.) (1999). Health Migration Sex Work: The Experience of TAMPER. Amsterdam: Tamper International Foundation.
- <sup>26</sup> Циммерман, С., К. Юун, С. Ваттс, И. Шваб, Л. Тапполин, М. Трепетте, Ф. Бимби, С. Жирапорн, Л. Беси, М. Албрехт, Ж. Биндел ба Л. Реган, 2003. Эмэгтэйчүүдийг болон өсвөр насныхыг худалдаалахад гарах эрүүл мэндийн эрсдэлүүд болон гарах үр дагаварууд. Европ дахь судалгаагаар. Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анагаах ухааны Сургууль ба Европийн хорооны Дафнийн хөтөлбөр: Лондон  
Zimmerman, C., K. Yun, C. Watts, I. Shvab, L. Trappolin, M. Treppete, F. Bimbi, S. Jiraporn, L. Beci, M. Albrecht, J. Bindel, and L. Regan, 2003. "The health risks and consequences of trafficking in women and adolescents. Findings from a European study". London School of Hygiene and Tropical Medicine and the Daphne Programme of the European Commission: London.
- <sup>27</sup> Скосник. П. (2000) Сэтгэл зүйн стрессийн дараахь анхаарлын байдлын өөрчлөлт. Олон улсын Сэтгэл зүйн физиологи сэтгүүл, 36(1), 59-68.  
Skosnik, P. (2000). "Modulation of attentional inhibition by norepinephrine and cortisol after psychological stress". International Journal of Psychophysiology, 36 (1), 59-68.

- 28 WHO. (2002). Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага Хүйсийн Бодлого: Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагын ажилд хүйсийн байдлыг нэгтгэх. [Интернет дэхь баримт] URL: <http://www.who.int/gender/mainstreaming/ENGwhole.pdf>
- WHO. (2002). "WHO gender policy: Integrating gender perspectives in the work of WHO". [On-line document] URL <http://www.who.int/gender/mainstreaming/ENGwhole.pdf>
- 29 Бээжин дэх Дэлхийн Эмэгтэйчүүдийн 4-р бага хурлын үйл хэргийн тунхаглал болон байр суурь (1995). Declaration and Platform for Action of the Fourth World Conference on Women in Beijing (1995).
- 30 С. Ваттс ба С. Циммерман (2002), Эмэгтэйчүүдийн эсрэг хүчэрхийлэл: Дэлхий нийтийн цар хүрээ ба чухал ач холбогдол. Лансет, 359, 1232-37. Watts, C., and C. Zimmerman (2002). "Violence against women: Global scope and magnitude". Lancet, 359, 1232-37.
- 31 Жэнкинс болон бусад зохиогч нар Jenkins et al.
- 32 Коомараасвами Р. Тусгай сурвалжлагчийн бэлтгэн танилцуулсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчэрхийлэлийн тухай урьдчилсан сурвалжлага: түүний шалтгаанууд болон үр дагаварууд. Нью Иорк, NY, Нэгдсэн Үндэстэн, 1997 (сурвалжлага E/CN.4/1997/47). Coomaraswamy R. Preliminary report submitted by the Special Rapporteur on violence against women: its causes and consequences. New York, NY, United Nations, 1997 (report number E/CN.4/1997/47).
- 33 Келли. Л. (2000). VIP хөтөч: Эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн эсрэг хүчирхийлэлийг журамлах зөн, шинчлэл ба мэргэшил. Энэ нь Европийн Цагдаагийн ба Хүний эрхийн Зөвлөлийн 1997-2000 оны хөтөлбөр зориулагдан бүтээгдсэн. Штраусбург: Европийн Зөвлөл. <http://www.cwasu.org/resources.htm>
- Kelly, L. (2000). "VIP guide: Vision, innovation and professionalism in policing violence against women and children". Produced for the Council of Europe Police and Human Rights 1997-2000 Programme. Strasbourg: Council of Europe. <http://www.cwasu.org/resources.htm>
- 34 Жил бүр 46 сая эмэгтэйчүүд үр зулбуулдагаас, 78 хувь нь хөгжжих буй оронд амьдардаг ба 22 хувь нь хөгжилтэй оронд амьдардаг байна. Руминь, Куба, Вьетнам улсууд abortны тоо хэмжээгээрээ дэлхийд хамгийн өндөрт бичигдсэн ба энэ нь 1000 эмэгтэй дутмын 78-83 нь abortонд ордог байна. Тоон үзүүлэлт мөн Перу болон Чилид 1000д 50-с дээш байна. Материальыг Алан Гуттмахер Хүрээлэн (2003). Дэлхий даяар дэмжигдсэн үр хөндөлт. (Интернет дэх үнэн бодит мэдээлэл) URL: [http://www.agi-usa.org/pubs/fb\\_0599.html#13](http://www.agi-usa.org/pubs/fb_0599.html.13)
- Of the 46 million women undergoing abortions each year, 78 per cent live in developing countries and 22 per cent in developed countries. Romania, Cuba and Vietnam have the highest reported abortion rates in the world (78-83 abortions per 1,000 women). Rates are also above 50 per 1,000 in Chile and Peru. Source: The Alan Guttmacher Institute (2003). Induced abortion world wide. [On-line fact sheet] URL [http://www.agi-usa.org/pubs/fb\\_0599.html#13](http://www.agi-usa.org/pubs/fb_0599.html#13)
- 35 Нэгдсэн үндэстэн. Эдийн засгийн ба Нийгмийн мэдээлэл болон журмын шинжилгээний Хэлтэс. Хүн ам ба Хөгжил: Хүн ам ба Хөгжлийн Олон улсын бага хурлаар дэмжигдсэн үйл явдлын хөтөлбөр, Кайро, 1994 оны 9 сарын 5-

13. Нью Иорк: Нэгдсэн Үндэстэн, 1995, пар 96  
 United Nations. Department for Economic and Social Information and Policy Analysis. Population and Development: Programme of Action Adopted at the International Conference on Population and Development, Cairo, 5-13 September 1994. New York: United Nations, 1995. Par 96.
- <sup>36</sup> Хүний эрхийн Бүх нийтийн тунхаглал, G.A. res. 217A (III) U.N. Doc. A/810 71 (1948). Иргэний болон Улс төрийн эрхийн Олон улсын гэрээ хэлэлцээр, G.A. res. 2200A (XXI), 21 U.N. GOAR Supp. (No.16), 52, U.N. Doc. A/6316 (1966), 999 U.N.T.S. 171, 1976 оны 3 сарын –“нд хүчин төгөлдөр болсон. Хүүхдийн эрхийн гэрээ хэлэлцээр, G.A. res. 44/25, хавсралт, 44 U.N. GOAR. Supp. (No. 49), 167, U.N. Doc. A/44/49 (1989), 1990 оны 9 сарын 2нд хүчин төгөлдөр болсон. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн бүх хэлбэрийг устган зайлцуулах гэрээ хэлэлцээр. G.A. res. 34/180, 34 U.N. GOAR. Supp. (No. 46), 193, U.N. Doc. A/34/46, 1981 оны 9 сарын 3нд хүчин төгөлдөр болсон. Universal Declaration of Human Rights, G.A. res. 217A (III), U.N. Doc A/810 at 71 (1948).
- International Covenant on Civil and Political Rights, G.A. res. 2200A (XXI), 21 U.N. GAOR Supp. (No. 16) at 52, U.N. Doc. A/6316 (1966), 999 U.N.T.S. 171, entered into force 23 March 1976.
- Convention on the Rights of the Child, G.A. res. 44/25, annex, 44 U.N. GAOR Supp. (No. 49) at 167, U.N. Doc. A/44/49 (1989), entered into force 2 September 1990.
- Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, G.A. res. 34/180, 34 U.N. GAOR Supp. (No. 46) at 193, U.N. Doc. A/34/46, entered into force 3 September 1981.
- <sup>37</sup> Европын холбоонд дагалдах хүнгүй наасанд хүрээгүй хүнийг бэлгийн мөлжлэгийн зорилогоор худалдах, 2001 оны 5р сар, IOM- Зогс Хетөлбөр 2000.
- Trafficking in Unaccompanied Minors for Sexual Exploitation in the European Union, May 2001, IOM-Stop Programme 2000.
- <sup>38</sup> Си Грондин. Д. (2003). Худалдагдсан хүүхдүүд болон тэдний эрүүл мэндийн асуудлууд, Төв, Зүүн ба баруун Европийн бусийн нийт хүн амын эрүүл мэнд ба хүн наймаалах тухай бусийн бага хурал. Будапешт хот, Унгар улс, 3-р сарын 18-20, 2003.
- See Grondin, D. (2003). “The trafficked children and associated health issues”, Regional Conference on Public Health and Trafficking in Human Beings in Central, Eastern and South-eastern Europe, Budapest, Hungary, 18-20 March 2003.
- <sup>39</sup> Хүүхдийн эрхийн гэрээ хэлэлцээр, (Ерөнхий Чуулганы шийдвэрээ 1989 оны 11 сарын 20ны 44/25-д дэмжигдэж гарын үсэг зурагцаж нээгдсэн , 1990 оны 9 сард хүчин төгөлдөр болох). 3 ба 24р заалт. <http://www.unhchr.ch/html/menu2/6/crc/treaties/crc.htm>
- Convention on the Rights of the Child (Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 44/25 of 20 November 1989, entry into force September 1990), Article 3 and 24. <http://www.unhchr.ch/html/menu2/6/crc/treaties/crc.htm>
- <sup>40</sup> Нэгдсэн үндэстний Хүний эрхийн дээд хороо. Хүний эрхийн ба хүн наймаалахын зарим зөвлөгдсөн зарчимууд ба тусламжууд. UNICEF, (2003). Зүүн Европод худалдаалгадж буй хохирогч хүүхдүүдийн эрхийг хамгаалах тусламж.

- United Nations High Commissioner for Human Rights. Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking. UNICEF, (2003). Guidelines for the Protection of the Rights of Children Victims of Trafficking in South-eastern Europe.
- 41 Нэгдсэн үндэстний Цагаачдын дээд хороо (1999). Цагаачдын асуудлын нөхөн үржжүйн эрүүл мэнд. Дотоод агентлагын салбарын зааварчилгаас авав. Taken from: United Nations High commissioner for Refugees (1999). Reproductive Health in Refugee Situations. An Interagency Field Manual.
- 42 UNICEF, (2003). Дэлхийн хүүхдүүдийн гурэн 2003. Интернет дэхь мэдээлэл URL: <http://www.unicef.org/sowc03/>
- 43 UNICEF, (2003). Зүүн Европод худалдаалагдаж буй хохирогч хүүхдүүдийн эрхийг хамгаалахад туслах Хэвлэгдээгүй материал. Unicef (2003). "Guidelines for protection of the rights of children victims of trafficking in South-eastern Europe". Unpublished draft.
- 44 Дотоод хэргийн газар, Дээд шүүхэд татах үйлчилгээ, (2001), Гэмт хэргийн шүүх ажиллагааны шилдэг нотолгоог тодорхойлох: Эмзэг болон сүрдүүлэгдсэн гэрчүүдэд туслах, энэ нь хүүхдүүд юм. Лондон: Титэм зохиогчийн эрх.
- Home Office, Crown Prosecution Service, et al. (2001). Achieving Best Evidence in Criminal Proceedings: Guidance for Vulnerable or Intimidated Witnesses, Including Children. London: Crown copyright.
- 45 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2003) Шүүмжлэлт холбоо, Биений өсөлт ба сэтгэл зүйн хөжилд хөндлөнгөөс оролцох: Тойм URL: [http://www.who.int/child-adolescent-health/New\\_Publications/IMCI/WHO\\_CHC\\_CAH\\_99.3.pdf](http://www.who.int/child-adolescent-health/New_Publications/IMCI/WHO_CHC_CAH_99.3.pdf)
- World Health Organization (2003). "A critical link. Interventions for physical growth and psychological developments: A review". URL: [http://www.who.int/child-adolescent-health/New\\_Publications/IMCI/WHO\\_CHS\\_CAH\\_99.3.pdf](http://www.who.int/child-adolescent-health/New_Publications/IMCI/WHO_CHS_CAH_99.3.pdf)
- 46 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (1997), Хүүхдийг хүчирхийлэх ба зөнд нь хаях, Мэдээллийн хуудас №150 \Интернетийн бодит байдлын хуудас URL: <http://www.who.int/inf-fs/en/fact150.htm>
- WHO (1997). "Child abuse and neglect". Fact sheet N150 [On-line fact sheet] URL: <http://www.who.int/inf-fs/en/fact150.html>
- 47 С.Ваттс ба С.Циммерман (2002), Эмэгтэйчүүдийн эсрэг хүчэрхийлэл: Дэлхий нийтийн цар хүрээ ба чухал ач холбогдол. Лансет, 359, 1232-37
- Watts, C. and C. Zimmerman (2002). "Violence against women: Global scope and magnitude". Lancet, 359, 1232-37.
- 48 Циклер. П. (2002). Хүүхэд ахуй үеийн бэлгийн дарамт хүчирхийлэл нь насанд хүрсэн эмэгтэйчүүдийн мансууруулах бодист хамааралтай болох эрсдэлийг нэмэгдүүлдэг, Судалгааны үзүүлэлт, Мансууруулах бодисны Үндэсний хүрээлэн NIDA тэмдэглэл, дугаар 17, №1 [http://www.nida.nih.gov/NIDA\\_Notes/NNVol17N1/Childhood.html](http://www.nida.nih.gov/NIDA_Notes/NNVol17N1/Childhood.html)
- Zickler, P. (2002). "Childhood sex abuse increases risk for drug dependence in adult women". Research Findings, National Institute of Drug Abuse. NIDA Notes Vol. 17, No. 1 [http://www.nida.nih.gov/NIDA\\_Notes/NNVol17N1/Childhood.html](http://www.nida.nih.gov/NIDA_Notes/NNVol17N1/Childhood.html)
- 49 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2003 оны урьдчилсан тайлан), Өсвөр насныхын бэлгийн харилцаа ба хүчирхийлэл: Бэлгийн харилцаа хүчирхийллийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөө болон түүнээс хамгаалах

- боловжууд. 2003 оны 8 сар.
- World Health Organization (2003, draft document). "Sexual relationship violence in adolescents: A review on the impact of sexual relationship violence on health and opportunities for prevention". Draft, August 2003.
- 50 Херман, Ж.Л (1997). Гэмтэл ба эдгэлт. Нью Иорк: Үндсэн номнууд.
- Herman, J. L. (1997). Trauma and Recovery. New York: Basic Books.
- 51 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2001) Оюун ухааны Эрүүл мэнд: Шинэ ойлголт, Шинэ Итгэл. Женев хот: ДЭМБ
- World Health Organization (2001). Mental Health: New Understanding, New Hope. Geneva: WHO.
- 52 Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Цагаачдын сэтгэл зүйн болон оюун ухаан. Хурлын өрөөний тэмдэгэл, Гүйцэтгэх хорооны 99-р чуулган, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Женев хот, 2002 оны 7 сарын 4.
- IOM, "Psychosocial and mental well-being of migrants". Conference Room Paper, 99<sup>th</sup> Session of the Executive Committee, IOM, Geneva, 4 July 2002.
- 53 Циммерман, С., К. Юун, И. Шваб нар, (2003). Эмэгтэйчүүдийг болон ёсвэр насынхыг худалдаалахад гарах эрүүл мэндийн эрсдэлүүд болон гарах үр дагаврууд. Европ дахь судалгаагаар. Лондонгийн Эрүүл ахуй ба Халуун бүсийн Анаагаах ухааны Сургууль.
- Zimmerman, C., K. Yun, I. Shvab, et al. (2003). "Health risks and consequences of trafficking in women and adolescents. Findings from a European study". London: London School of Hygiene and Tropical Medicine.
- 54 ОШХБ (2002) ДОХИХДХВ ба шилжкин суурьших сэдэвт нийтлэл. <http://www.iom.int/DOCUMENTS/GOVERNING?EN?Mcinf252.pdf>
- IOM (2002) Position paper on HIV/AIDS and Migration. <http://www.iom.int/DOCUMENTS/GOVERNING/EN/Mcinf252.pdf>
- 55 ДОХИХДХВ-с сэргийлэх салбар, Асуултууд ба Хариултууд: ДОХ бол ХДХВ-ын үр дагавар. <http://www.cdc.gov/hiv/pubs/cause.htm>  
Division of HIV/AIDS prevention, Questions and Answers: HIV is the Cause of AIDS. <http://www.cdc.gov/hiv/pubs/cause.htm>
- 56 BBC Дэлхийн үйлчилгээ (2003). ДОХ ба ХДХВ гэж юу вэ? |Интернетийн баримтат хуудас| URL: [http://www.bbc.co.uk/worldservice/sci\\_tech/features/health/sexualhealth/aids/what.shtml](http://www.bbc.co.uk/worldservice/sci_tech/features/health/sexualhealth/aids/what.shtml)  
BBC World Service (2003). What is HIV and AIDS [On-line fact sheet]. URL: [http://www.bbc.co.uk/worldservice/sci\\_tech/features/health/sexualhealth/aids/what.shtml](http://www.bbc.co.uk/worldservice/sci_tech/features/health/sexualhealth/aids/what.shtml)
- 57 Пенсильванийн Хамгаалах Төсөл (2003). Stophiv.com. ДОХ-ын түүх ба баримт. |Интернетийн баримтат хуудас| URL: [http://www.stophiv.com/facts\\_myths/](http://www.stophiv.com/facts_myths/)  
Pennsylvania Prevention Project (2003). Stophiv.com. HIV myths and facts. [On-line fact sheet] URL: [http://www.stophiv.com/facts\\_myths/](http://www.stophiv.com/facts_myths/)
- 58 Цагаачлалын эрүүл мэндийн үнэлгээний нөхцөл байдалд ДОХI ХДХВ-ын талаар зөвлөх буюу шалгахдаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас лавлаж байх. Зөвлөгөө егөх заавар, Шинэчлэгдсан хэвлэл, 2004.  
Please refer to the IOM HIV/AIDS Counselling and Testing in the Context of Migration Health Assessment – Counsellor Guidelines, Revised version, 2004.
- 59 Косс, М.П., Л.А. Гудман, А. Броуни, Л. Фицжеральд, Г.П. Кейта, Н.Ф. Руссо (1994) Аюулгүй хорогдох байр үүгүй: Гэрт, ажлын байранд ба олон нийтийн газар дахь эрчүүдийн эмэгтэйчүүдэд үзүүлэх хүчирхийлэл. Вашингтон, Д.С.:

Америкийн Сэтгэл зүйн Холбоо.

Koss, M. P., L. A. Goodman, A. Browne, L. Fitzgerald, G. P. Keita, N. F. Russo (1994). No Safe Haven: Male Violence Against Women at Home, at Work, and in the Community. Washington, D.C.: American Psychological Association.

60 Форастери, В. (1997) Хүүхдүүд ажлын байранд: Эрүүл мэндийн ба аюулгүй байдлын эрсдэлүүд. Женева хот: Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Хүүхэд бол ажиллах хүчин түүвэр

Forastieri, V. (1997) Children at Work: Health and Safety Risks. Geneva: ILO Child Labor Collection.

61 Анни Халлегийн ажлаас газрын ажилчдын эрүүл мэнд болон стрессийн талаарх мэдээллүүд, IOM (2001) Стресс. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын ажилчдын дарамтын судалгаа. Женева: Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Цагаачлалын Эрүүл мэндийн үйлчилгээ, Мэргэжлийн Эрүүл ахуй.

Much of the information on staff health and stress is adapted from the work of Annie Halle, IOM (2001) "Stress. Analysis of stress amongst IOM employees", Geneva: IOM, Migration Health Services, Occupational Health.

62 Жишээ нь, зарим орны зан заншилд зөвхөн ойр дотныхон, тэр дундаа гэр бүлийнхэндээ узэл бодлоо илрэхийлж болдог бол зариманд нь асуудлыг сонссон хувд нь маш их төвөг болдог гэж үздэг юм байна. Халле. А-г хар (2001). For example, in some cultures it is only acceptable to reveal feelings to those one is close to, i.e., family members. In some cultural contexts, to express problems to another is to transfer the burden on the one who is told. See Halle, A. (2001).

63 Камбожид хүний эрхийн ТББ нь Вьетнамд хэвлэлийн шүүмжлэлд өртсөн болон сурдуулгдсан эмэгтэйчүүдэд тусламж үзүүлдэг байна. Зарим ажилнууд нь Вьетнам хохирогчидтой ажиллахаас татгалзсан байна.

In Cambodia, a human rights NGO providing assistance to women from Viet Nam was criticized in the local press and threatened. Some of the staff refused to continue to work with victims from Viet Nam.

64 Халле. А. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (2001). ОШХБ Хүн наймаалахын эсрэг төслүүд: Сэтгэл зүйн хэмжигдэхүүн дахь зарим нэг эргэцүүлэл, Эдгээр хариултууд хязгаарлагдсан байж болох ч ОШХБ-ын ажилчдад олон үндэстнүүд, соёлын заншлын цогц бий. Стресс бол соёлын бүтээн байгуулалт ба гэхдээ энэ нь ихэнхдээ өөр өөр үзэлт хүмүүст ижил замаар таарч, ойлгогдж, тулгардаггүй гэж үзэгдэг. Саммарфиелд. Д (2001) үз. Гэмтлийн дараахаа стрессийн өвчний оновчтой санаа ба сэтгэл мэдрэлийн зэрэглэлийн нийтгийн хэрэгцээ. Английн анагаах ухааны сэтгүүл, 322, 95-98.

Halle, A. IOM (2001). "IOM Counter-trafficking Projects: Some reflections on the psychological dimensions". These responses may have been rather limited, however, given the wide ethnic, national and cultural diversity of IOM staff. "Stress" is often considered a cultural construct that may not be applicable to, or understood or experienced in the same way by individuals in different contexts. See: Summerfield, D. (2001). The invention of posttraumatic stress disorder and the social usefulness of a psychiatric category. British Medical Journal, 322, 95-98.

65 Тёрнер. С (2000). Яргалалтнаас амьд үлдэгсдэд сэтгэл мэдрэлийн туслалцаа. Сэтгэл мэдрэлийн эмчилгээг үр дүнтэй болгох, 6, 295-303  
Turner, S. (2000). Psychiatric help for survivors of torture. Advances in Psychiatric Treatment, 6, 295-303.

66 Өмнөхтэй адил  
Ibid

- 67 Халле. А. (2001). Дарамт. ОШХБ-ын ажилчдын дарамтын судалгаа. Женева: ОШХБ, Цагаачлалын Эрүүл мэндийн үйлчилгээ, Мэргэжлийн Эрүүл ахуй. Halle A (2001) "Stress. Analysis of stress amongst IOM employees", Geneva: IOM, Migration Health Services, Occupational Health.
- 68 С.Кахиллын шинэчилсэн энэ гарын авлагын чухал хэсгүүдийг дэмжих ба таних, Туслалцаа үзүүлж буй ажилтнуудад ядрахгүй байх аргачлалыг заах: Туршилтан дээр үндэслэсэн нотолгооны тойм, Канадын сэтгүүл, 22:3 (1988). The Support and Recognizing Burnout section of this Manual is adapted from S. Kahill, "Interventions for burnout in the helping professions: A review of the empirical evidence", Canadian Journal of Counseling Review, 22:3 (1988).

## Хавсралт | Будапештын Тунхаглал

2003 оны 3 сарын 19-21-ний өдрүүдэд Будапешт хотноо болсон Төв, Зүүн болон Зүүн өмнөд Европын Хүн амын эрүүл мэнд, ХХГХ-ийн асуудлаарх бүсийн бага хуралд оролцогчид:

- **Хүний Худалдах нь** Хүний эрхийг ноцтой зөрчил болохыг батлан;
- Төв, зүүн ба зүүн өмнөд Европод худалдаалагдсан хохирогчид нь эрүүл мэндтэй холбогдолтой олон төрлийн асуудал тулгарч болзошгүй талаар авч хэлэлцсэн бөгөөд эдгээр асуудлууд нь сэтгэл зүйн болон биеийн хүчирхийлэл, гэмтэл, бэлгийн замын болон бусад халдвартай, халдвартгүй өвчинүүд ялангуяа ДОХХДХВ ба сүрьеэ өвчинүүр анхаарл татах байгаа талаар ярилцав;
- Бус нутгийн зарим улс орнуудад сүрьеэ болон ДОХ-ын халдвартахлын хэмжээнд хүрч, эмчлэгдэхгүй сүрьеэ өвчин байгаа гэдгийг хүлээн зөвшөөрчээ;
- ХХГХ-тэй холбоотой эрүүл мэнд болон олон нийтийн эрүүл мэндийн асуудлыг тал бүрээс нь авч үзэх хэрэгтэйг сануулах ёстой зэрэг асуудлуудыг авч хэлэлцээд;

Харилцан зөвшилцсөний үндсэн дээр дараах зүйлсийг амлаж байна. Үүнд:

- Бус нутгийн болон дэлхий хэмжээнд ХХГХ-тэй тэмцэх үйл явцад ихээхэн идэвх чармайлт гаргаж байгаа хэдий ч, энэ гэмт хэрэгтэй холбогдолтой эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай
- ХХГХ-ийн хохирогчийн нас, хүйс, зан заншид нийцсэн тэдний эрүүл мэнд сэтгэц, нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахад чиглэсэн өргөн хүрээтай, тогтвортой эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх.
- Эрүүл мэндийн үйлчилгээг тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн аюулгүй, хalamжийн таатай орчинд үзүүлэх бөгөөд мэргэжлийн ёс зүйг даган мөрдөж, хохирогчийн авч буй хalamж, үйлчилгээний талаар өөрт нь бүрэн мэдээлэл өгч, энхүү мэдээлийн үндсэн хохирогчоос зөвшөөрлийг нь авах бөгөөд, үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээлийн нууцлалыг чандлан хадгалах.
- Хохирогчдод үзүүлж буй эрүүл мэндийн хalamжийн жишиг тогтоох. Энхүү жишиг хэм хэмжээг хамтран ажиллагч улс орнуудын засгийн газар, засгийн газар хоорондын болон ТББ-

үуд судалгааны байгууллагууд өргөн хүрээтэй судалгаа, шилдэг туршлагад үндэслэн боловсруулж мөрднө.

- Хохирогчид үзүүлж буй эрүүл мэндийн хalamжийн үйлчилгээг тэдний хохролын үе шат, тэдний эрүүл мэндийн байдалтай уялдуулан эн тэргүүн хэрэгцээнд үндэслэн үзүүлнэ.

Хохирогчид аврах үйлчилгээ үзүүлэх эхний үе шат бол хохирогч, эрүүл мэндийн ажилтан хоёрын анхны уулзалт бөгөөд энэ уулзалт нь ихэвчлэн хүлээн авагч буюу дамжин өнгөрөх улс оронд болдог тул эн түрүүнд хохирогчийн гэмтэл, хохирлыг эмчлэх, хунд байдлыг даван туулах, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ болон зөвлөгөө өгөх зэрэг тусламжид сууринна.

Хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээ ихэвчлэн төрөлх эх оронд нь хийгддэг тул үйлчилгээг хохирогчийн ирээдүйн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлан хохирогчийг нийгэмшүүлэхэд төвлөрүүлнэ. Хохирогчидод зөвхөн түүний хэрэгцээ, онцлогт тохируулан тусгайлан төлөвлөсөн үйлчилгээг үзүүлнэ.

Урт хугацааны эрүүл мэндийн нөхцөл байдлыг сайжруулахад шаардлагатай үйлчилгээний урт жагсаалт зөвлөгөө, дараагийн шатны эмчилгээ, БЗХӨ, ХДХВ/ДОХ, сурьеэгийн болон биеийн, сэтгэл зүйн эмгэг хохирол, сэтгэцэд нөлөөлөх эмийн хамаарал болон бусад халдварын оношлогоо, эмчилгээг хийснээр дуусгах боломжгүй юм.

- Худалдагдсан хүүхэд, өсвөр насныхан эрүүл мэндийн тусгай эмчилгээ үйлчилгээ шаардсан онцгой эмзэг бүлэг билээ. Энэ бүлэгт эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ удаан хугацаанд хэрэгжүүлэх, тогтвортой бодлого баримтлах бөгөөд удаан хугацааны үр дүнгээ үзүүлэх сэтгэцийн болон сэтгэл зүйн эмчилгээнд илүү анхаарна.

Мөн худалдагдсан хүүхэд, өсвөр насныхны хувьд халамж үйлчилгээ нь асран хамгаалагч хамгаалзан дэмжигчтэй холбоотой хууль эрх зүйн цогц асуудлыг шийдвэрлэхийг шаардана. Эдгээр асуудлыг үйлчилгээний жишиг стандарт тогтоосноор шийдвэрлэнэ.

Гэхдээ ямар ч тохиолдолд хүүхдийн дээд эрх ашгийг эн тэргүүнд тавина.

- Хохирогчийг хамгаалах, туслах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх болон аюулгүй байдлыг нь хангахад халамжийн төв, хамгаалах

байр болон нөхөн сэргээх төвүүд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хамгаалах байр, нөхөн сэргээх төвүүдийн үйл ажиллагаа, удирдлага нь мэргэжлийн түвшинд стандартын дагуу явагдана.

- Олон талын үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн багуудад зориулагдсан мэргэжлийн сургалтын тусгай хөтөлбөрүүд нь хохирогчдын тусгай хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллийг эрүүл мэндийн ажилтнуудад өгөхөд чиглэгдэн боловсруулагдсан байна.
- Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө нь хохирогчдод итгэл найдвар төрүүлэх, хохирогчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тэдэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг авах, хохирогчийг нөхөн сэргээх үйл ажиллагаа, төлөвлөлтөнд оролцуулах, удаан хугацааны нөхөн сэргээлт, өөртөө итгэх итгэлтэй болоход нь гол үүрэг гүйцэтгэнэ.
- Хоргodoх байр, нөхөн сэргээх төв дээр зохион байгуулсан нийгмийн, амралтын, боловсролын болоод мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа нь хохирогчийг өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дахин бий болгоход онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хохирогчийн эрүүл мэндэд зөргээр нөлөөлнө.
- ХХГХ-тэй холбоотой нийгмийн эрүүл мэндийн асуудалыг сайжруулах шаардлагтай. Эрэлт нийлүүлэлттэй холбоотой аль аль талын эрсдэлт бүлэгт чиглэсэн хэн нэгнийг дорд үзээгүй, соёл уламжлалд нь тохирсон олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны аяанг бүс нутгийн хэмжээнд зохион байгуулна.
- Засгийн газрууд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хариуцлагатай хандаж, хохирогчийн аюулгүй байдал, хуулийн эрх, хамгаалалт, тусlamжид онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ нэн ялангуяа хүүхэд, өсвөр насыханд энэ төрлийн үйлчилгээ үзүүлэх, үндэсний эрүүл мэндийн байгууллагыг татан оролцуулах.
- Засгийн газар, засгийн газар хоорондын болоод ТББ-үүд хил дамнасан хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг тухайн хүлээн авагч улс орон, эх орон болон дамжин өнгөрөх улс орнуудад үзүүлэх зохицуулалт хийх. Хохирогчийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг зөвшөөрөл авсны үндсэн дээр нууцлалын журмыг хатуу баримтлан солилцох, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тусlamж үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлж байгаа эсэхийг хянах, удирдлага, нөхөн сэргээлт нийгэмшүүлэх үйл явцыг үр дүнтэй болгоход анхаарах ёстай.

Төлөөлөгчид дээрх амлалт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд онцгой анхааран дэмжихээ амлаж байна.

## Хавсралт II Сэтгэл зүйн эмчилгээний барууны зарим арга барилын тухай

Сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ гэдэгт эрүүл мэндийн боловсрол, сэтгэл зүй-боловсролын арга техник, бие даан амьдрах чадварт суралцах, нийгэмших ур чадварт суралцах, мэргэжлийн сургалтанд хамрагдах зэрэг арга хэмжээ багтдаг. Эдгээр арга хэмжээг ихэвчлэн эмчилгээний бусад аргуудтай хавсруулан ашиглана.

Уран бүтээлч эмчилгээ гэдэг нь мэргэшсэн эмч сэтгэл зүйн эмчилгээ, зөвлөгөө өгөх, тусгай боловсрол буюу нөхөн сэргээх зорилгоор дуу хөгжим, уран зураг, бүжиг, жүжиг зэргийг ашиглан эмчилгээ явуулахыг хэлдэг. Эдгээр эмчилгээний аргуд нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх, итгэл найдвар төрүүлэх болоод нийгмийн эрүүл сэтгэхүйтэй болоход тусладаг бөгөөд хохирогчийн өөрийгөө буруутгасан, жигшсэн бодлыг буруулах зорилго агуулдаг. Дээрх эмчилгээ нь санах ойг сайжруулах, мөн бусад эмчилгээний нөлөөллийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Бүлгийн эмчилгээний загвар нь ижил төстэй үйл явдлыг туулж өнгөрүүлсэн бүлэг хүмүүсийн хамтын эмчилгээ бөгөөд хүмүүс нэг нэгнийгээ дэмжих, зовлонг нь хуваалцах зэргээр нэг нэгнийгээ эмчилдэг. Бүлгийн уулзалтанд оролцож буй хүмүүс өөрийгөө үнэлэх үнэлэмж, харилцаа тогтоо чадвартай болохын зэрэгцээ шийдвэр гаргах ур чадвартай болдог. Хохирогчид мөн өөрийгөө хянах ур чадварт суралцахын зэрэгцээ ирээдүйн талаарх үзэл бодлоо хуваалцаж сурдаг.

Ганцаарчилсан эмчилгээ. Энэ төрлийн эмчилгээг хийлгэх хүсэлтэй хүмүүст энэ эмчилгээ үр нөлөөтэй. Нөхцөл байдал, нөөц боломжоос шалтгаалан тухайн эмчилгээг богино хугацаагаар явуулдаг.

Хүүхдийг дэмжих. Насанд хүрээгүй хүүхдийн (18 хүртэлх насны) тусгай хэрэгцээг ханглахад энэ эмчилгээг ашигладаг. Насанд хүрээгүй хүүхдийн хэрэгцээ шаардлага, сэтгэл зүйн асуудлыг насанд хүрэгсдийн адил тодорхойлно. Насанд хүрээгүй хүүхдэд бүлгийн буюу ганцаарчилсан эмчилгээ, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэхдээ насны онцлогийг харгалзан үзсэн сэдэв, боловсролыг ашиглах ба мөн хүүхдийн гэр бүлийн гишүүд буюу асран хамгаалагч нарыг оролцуулах нь хүүхдэд онцгой эерэг нөлөө үзүүлдэг. (уулзалт хийж чадахгүй бол утсаар) Хүүхдийн гэр бүлд хүчирхийлийн тохиолдол байсан бол холбоо тогтоохдоо мэргэжлийн түвшинд тогтоох ёстой буюу эсвэл огт тогтоохгүй байж болно гэдгийг анхаарна уу.



**Хууль хэрэгжүүлэгч  
байгууллагуудтай  
хамтран ажиллах нь**

# **Бүлгийн агуулга**

- 6.1 Оршил**
- 6.2 Ерөнхий зүйл**
- 6.3 Хууль хэрэгжүүлэгчтэй хамтран ажиллах нь**
- 6.4 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талтай хамтран ажиллах нь**
  - 6.4.1 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын стратегийн эрсдэл
  - 6.4.2 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны эрсдэл
  - 6.4.3 Хамтын ажиллагааны үр ашгийг тодорхойлох нь
- 6.5 Эрүүгийн эрх зүйн системийн боломжууд болоод хохирогчийн эрхийн судалгаа**
  - 6.5.1 Оршил
  - 6.5.2 Эрүүгийн эрх зүйн системийн боломжууд болон ХХГХ-ийн хохирогчийн эрх
  - 6.5.3 Боломжууд дээр толгуурлан зөвлөгөө өгөх оновчтой цаг үе
  - 6.5.4 Хууль эрх зүйн туслацаа
  - 6.5.5 Хохирогч-гэрчийг хуулийн дагуу хамгаалах
- 6.6 Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг**
  - 6.6.1 Хамтын ажиллагааны цар хүрээ
  - 6.6.2 Харилцан ойлголцлын санамж бичгийн үр ашиг
  - 6.6.3 Үндсэн зарчмууд
  - 6.6.4 Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийн агуулга
  - 6.6.5 Эрсдэл
- 6.7 ХХГХ-тэй тэмцэх нэгжүүдтэй ажиллах**
- 6.8 Техникийн хамтын ажиллагаа ба ур чадварыг хөгжүүлэх**
- 6.9 Удирдлага ба мэдээлэл хүргэх**
  - 6.9.1 ХХГХ-тэй тэмцэх тагнуулын байгууллага – тодорхойлолт болон нөөц боломж
  - 6.9.2 Тагнуулын байгууллагын төрлүүд болон тэднийг ашиглах нь
  - 6.9.3 Хоёр талт солилцооны үйл явц
  - 6.9.4 Бусад хохирогч буюу боломжит хохирогчдын талаарх мэдээлэл цуглуулах үүрэг
  - 6.9.5 Хохирогч цагдаагийн байгууллагад шууд мэдээлэл өгөх
  - 6.9.6 Мэдээллийг нээлттэй болгоход гарч болох эрсдэлийг тооцоолох нь
  - 6.9.7 Ил болгосон мэдээллийн нууцлал
  - 6.9.8 Хяналт ба үнэлгээ

## 6.1 Оршил

Энэхүү гарын авлагын энэ бүлгийн гол зорилго нь ХХГХ-ийн хохирогчдын эрүүгийн эрхзүйн системийн эрх болоод боломжуудыг тодруулах, үйлчилгээ үзүүлж буй байгууллага, үндэсний болон олон улсын хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын харилцаа холбоо, тэдгээрийн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг авч үзэх юм.

Энэхүү гарын авлага нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж буй талуудыг зөвтгөх, буруутгах ямарваа нэгэн зорилго агуулаагүй болно. Гэсэн хэдий ч хамтын ажиллагаа нь хохирогчдод туслалцаа үзүүлэхтэй холбогдон зайлшгүй гарах давуу талуудыг гаргаж ирэх нь чухал юм.

Үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд нь ихэвчлэн ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаанд хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах, тэдэнд туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэггүй. Улс үндэстнүүдийн хууль эрхзүйн систем ялгаатай байдаг хэдий ч үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа улс орныхоо хуулийн дагуу хүлээх үүргээ биелүүлж шалгаж байх ёстой. Мөн хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллахад стратегийн болоод үйл ажиллагаатай холбоотой онцгой эрсдэлүүд гардаг. Энэхүү бүлэгт дурьдсан зүйлс нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын цагдаагийн үргийг гүйцэтгэхийг зөвлөсөн санал буюу санаа агуулаагүй болно. Энэхүү бүлэг нь хамтран ажиллах боломж болоод талууд үүрэг хариуцлагын хүрээнд өөрийн хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд гол анхаарлаа хандуулсан болно.

## 6.2 Ерөнхий зүйл

ХХГХ-ийн хохирогчид өөрсдийг нь золиос болгосон гэмт хэргийг хуулийн хүрээнд шийдүүлэх эрхтэй. Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд хохирогчидтай энэ эрхийн талаар ярилцаж хохирогчдод хуулийн хүрээнд хэрхэн шийдүүлж болох боломжуудын талаар мэдээлэл өгч болно.

Өндөр ашигтай, эрсдэл багатай олон улсын хэмжээний зохион

байгуулалттай гэмт хэрэг өсч байгаагийн хирээр хохирогчдод бие махбодийн, бэлгийн болоод сэтгэл зүйн хохирол учруулж байгаа ХХГХ отцом нэмэгдэж байгааг харуулж байна. ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх туршлагатай үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд энэхүү гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой нөлөө үзүүлж буй хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай стратегийн болоод үйл ажиллагааны хувьд шууд харилцаатай болж байгаа юм.

### 6.3 Хууль хэрэгжүүлэх талаас хамтран ажиллах нь

Хууль хэрэгжүүлэгчийн талаас нь авч үзвэл хохирогчийн талын хамтын ажиллагаа болоод үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын туршлага, үйл ажиллагааны боломжийг ашиглах нь дараахь ач холбогдолтой.

- Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд эн түрүүнд хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
- Хохирогчдыг орон байраар хангах, туслалцаа үзүүлэх ба хохирогчид шүүх хурал дээр мэдүүлэг өгөх хүртэлх эрүүгийн үйл ажиллагааг мөрдөх явцад туслалцаа үзүүлэх.
- Цагдаагийн ажилтнуудын эрх үүргээс давж гарсан ХХГХ-тэй тэмцэх тагнуулын ажилтнуудад туслалцаа үзүүлэх, учир нь хохирогчид цагдаагийн ажилтнуудад итгэдэггүй, тэдэнтэй нээлттэй ярилцдаггүй (санамж: энэхүү бүлэгт мөн ХХГХ-ийн талаарх мэдээлэлтэй холбоотой гарах эрсдэлийг дурьдсан болно).
- ХХГХ-тэй тэмцэх хууль хэрэгжүүлэгч нэгжүүдэд техникийн туслалцаа үзүүлэх, тэдний ур чадварыг бэхжүүлэхэд туслах.

### 6.4 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаас хамтран ажиллах нь

ХХГХ-ийг хязгаарлах, хохирогчдыг хамгаалах зорилготой байгууллагуудын хувьд үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд хохирогчид, эсвэл хохирогчдын гэр бүл, хамаатан садан, найз нөхдөөс ХХГХ-ийн талаарх мэдээллийг авдаг. Энэхүү мэдээлэл нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад хохирогчдын байршлыг тогтоох, тэднийг аврахад онцгой ач холбогдолтой. Ийм төрлийн

мэдээлэл нь мөн хүн наймаалагчдыг тодруулах, тэднийг мөрдөх нөхцлийг бүрдүүлдэг. Хохирогчдыг аврах, хүн наймаалагчдыг олж илрүүлэх нь ХХГХ-тэй тэмцэх цогц стратегийн хоёр үндсэн хүчин зүйл юм. Үйлчилгээ үзүүлэгч болоод хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа нь зорилгоо биелүүлэх үндсэн алхам юм.

Гэмт хэргийн газар дээр хийсэн судалгаанаас үзэхэд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тусlamж авч байгаа хохирогчдын олонх нь ХХГХ-ийн эсрэг тагнуулын байгууллагыг хууль хэрэгжүүлэгч байгууллагатай нэгтгэх хүсэлтэй байсан. Зарим тохиолдолд хууль хэрэгжүүлэгч байгууллагын боломж чадвар мэргэжлийн, илүү аюулгүй байсан бөгөөд хохирогчид шууд цагдаад хандах боломжтой байв. Бусад тохиолдолд хохирогчид цагдаагийн ажилтнуудтай уулзах хүсэлгүй байсан бөгөөд үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад өөрсдийнх нь өмнөөс мэдээлэл өгөх хүсэлт тавьж байв. Цагдаагийн байгууллагад албан ёсоор мэдээлэл өгснөөр үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараахь боломжтой болно. Үүнд:

- Хохирогчийн хэргийн талаарх мэдүүлэг өгөхөд хохирогч талд туслах, өгсөн мэдээлэл нь хүн наймаалагчид шийтгэл ногдуулах, эсвэл бусад хохирогч нарт туслах.
- Хохирогчдыг аврахад өөрийн хувь нэмрээ оруулах, мөн хүн наймаалагчдыг олж тогтоох.

Хохирогчийн бичгээр өгсөн мэдээлэл бүхий зөвшөөрөл, байгууллага хохирогчийн эрх ашгийг бүрэн дүүрэн хамгаална гэсэн нотолгоо нь мэдээлэл солилцоход гол үүрэг гүйцэтгэдэг.

#### **6.4.1 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ**

Стратегийн түвшинд хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах нь үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын хувьд шинэ үүрэг хариуцлага хүлээлгэдэг төдийгүй хамтын ажиллагааны үр дүнд маш нарийн бодлогын асуудлууд болоод эрсдэл гардаг. Хамтын ажиллагааны цар хүрээ болоод байгууллагын үзүүлж буй үйлчилгээг нарийвчлан авч үзэх ёстой. Туслалцаа,

хамтын ажиллагааны цар хүрээ нь тухайн орны эрүүгийн эрхзүйн системийн дагуу хохирогчид үзүүлэх үйлчилгээ болоод хамгаалалтын байдал, чанар, мөн олон улсын ямар хэм хэмжээг баримталдаас шалтгаална. Дэлхийн хэмжээнд мөрддөг хүний түгээмэл эрхийг НҮБ-аас ХХГХ-тэй холбогдуулан гаргасан Палермогийн конвенци, НҮБ-ын Хүний эрхийн байгууллагын даргын гаргасан ХХГХ-ийн зарчим болон мөрдлөгт тусгасан байдаг. Мөн бус нутгийн гэрээнүүдийг даган мөрдөх ба тухайлбал, ХХГХ-ийн эсрэг явуулах тэмцлийн талаарх Европын холбооны конвенци (хүчин төгөлдөр болсон цагаас хойш) үүнд багтдаг.

Олон улсын хэм хэмжээг баримталдаггүй орны эрүүгийн эрхзүйн системийн дагуу хохирогчид туслалцаа, хамгаалалт өгдөггүй бол үйлчилгээ үзүүлж буй байгууллага тухайн орны цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах нь байгууллагын хохирогчдод туслалцаа, хамгаалалт үзүүлнэ гэсэн үүрэгтэй зөрчилддөг. Тийм учраас тодорхой хугацаанд хязгаарлагдмал хэмжээнд хамтран ажиллах нь давуу талтай бөгөөд ингэснээр хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажилтнууд хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах магадлалтай юм. Мөн шударга байх эсэх асуудал үүсэн гарах бөгөөд өөрөөр хэлбэл тухайн оронд үйлчилгээ үзүүлж буй байгууллага шударга хатуу шийдвэр гаргадаг, сайн удирдлагатай байх ёстой гэсэн шаардлага тавигддаг.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагааны үр дүнг зөвхөн байгууллага болон хууль хэрэгжүүлэгч байгууллагын харилцаагаар дүгнэж болохгүй. Тухайн байгууллага болон Засгийн газар, Засгийн газар хоорондын болоод төрийн бус байгууллагын харьцаа зэрэг өргөн хүрээнд үйлчлэх хүчин зүйлүүдийг мөн тооцож үзэх ёстой. Ихэнх тохиолдолд гарч болох эрсдэлүүдийг харилцан ашигтай хамтрагч нарын хэлэлцээр, зөвлөгөөгөөр зохицуулдаг.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах хамтын ажиллагааны цар хүрээг үүссэн нөхцөл байдал, шийдвэрлэх тодорхой асуудлуудаас шалтгаалан тогтоох ба хохирогчдод туслалцаа үзүүлэх зорилготой байгууллагын бие даасан байдлыг хүндэтгэх ёстой.

## 6.4.2 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хохирогчдод үзүүлэх үйлчилгээгээ сайжруулахын хирээр тухайн орны эрүүгийн эрхзүйн системтэй нягт хамтран ажиллахаас өөр аргагүй болдог. Хохирогчдод бүрэн цогц үйлчилгээ үзүүлэхийн хирээр тухайн байгууллагын гүйцэтгэх үүрэг улам үнэ цэнэтэй болж, орон нутгийн цагдаагийн байгууллага хүн наймаалагчдыг олж илрүүлж, шийтгэх үүднээс нягт хамтран ажиллах сонирхолтой болдог байна.

Нягт хамтын ажиллагаа нь хохирогчдод болоод ажилтнуудыг илүү их эрсдэлд оруулдаг. Энгийнээр авч үзвэх юм бол хохирогчдыг айлган сүрдүүлж, ажилтнууд нарийн зохион байгуулалттай, хэрцгий хүн наймаалагчидтай нүүр тулдаг. Шийтгэлээ авалгүйгээр аврагдсан хохирогч бүр буюу хүн наймаалагчдын эсрэг буй хохирогчийн гэр бүлийнхэн, эсвэл түүний ойр дотныхон хүн наймаалагчдын хувьд “муу бизнес” бөгөөд энэ нь оргох төлөвлөгөөтэй байж болох бусад хохирогчдыг эрхшээлдээ байлгах тэдний хүчийг сулруулдаг. Суллагдсан хохирогч гэрчийн суудалд суухад ХХГХ эрсдэлд ордог, учир нь энэ нь эргээд хүн наймаалагчдын эрх чөлөө, ашиг хөндөгдөж эхэлдэг.

Хүн наймаалагчид суллагдаж, тэдний эсрэг мэдүүлэг өгөх гэж буй хохирогчдоос өшөөгөө авдаг нь нэгэнтээ нотлогдсон бөгөөд олон улсын хэмжээнд тэдний эсрэг тэмцэл хийж байгаа учир тэд өөрсдийн бизнесээ алдахаас сэргийлэн өшөө авалтаа үргэлжлүүлдэг.

Хүн наймаалагчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хохирогчдод үзүүлэх туслалцааны талаарх ажил үргийг сайн мэддэг болохын хирээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд мөн эрсдэлд ордог. Цагдаагийн байгууллагатай нягт хамтран ажилласнаар хохирогч мэдээллтэй болохын зэрэгцээ гэрчээр дуудагдсан тохиолдолд шаардлагатай хамгаалалт авах боломжтой болох бөгөөд тэр хирээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнуудын эрсдэл нэмэгддэг. (энэхүү гарын авлагын Бүлэг 1-т эрсдэлийг үнэлэх, зохицуулах талаар дэлгэрэнгүй бичсэн болно)

### 6.4.3 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад үүсэх үйл ажиллагааны болоод стратегийн эрсдэлийг тооцож үзвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах үүрэг хүлээдэггүй. Гэхдээ хамтран ажиллах шаардлага байгаа эсэх талаарх асуудал гарч ирдэг.

Энэ асуултанд хариулт өгөх эсэхэд хохирогч шийдвэр гаргах нь чухал юм. Хохирогчид туслалцаа үзүүлэхэд онцгой нөлөөлдөг бас нэгэн хүчин зүйл бол хохирогч өөрийн эрх болоод эрхээ хамгаалах талаар мэдлэгтэй эсэх, мөн хохирогчид хүнд гэмт хэргийн золиос болсны хувьд эрүүгийн эрхэзүйн системийн боломжуудыг ашиглах хүсэлтэй байгаа эсэхийг магадлах юм. Ихэнх тохиолдолд хохирогчид зөвхөн хүн наймаалагчдад мөлжүүлээд зогсохгүй гэмт хэргийн хохирогч болсны хувьд тэдэнд туслах үүрэгтэй иргэний болоод эрүүгийн эрх зүйн системийн хохирогч болох нь бий.

Хуулийн зөвлөгөө, тусламж нь хохирогчдод үзүүлэх ёстой цогц үйлчилгээний нэг чухал хэсэг бөгөөд хохирогчдод мэдээлэл өгөх, тэдэнд шийдвэр гаргах эрх олгох, хуулийн дагуух эрх, боломжоо эдлэхэд дэмжлэг болдог. Бодит байдал дээр хохирогчид гэмт хэргийг шийдүүлэх, тэдэнд учруулсан хор хохирлыг төлүүлэх оролдлого болгонд, цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах хүсэлтэй байдаг байна. Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай харилцаа холбоо сайтай байснаар хохирогчдод энэ талын туслалцаа өгөх боломжтой юм.

### 6.5 Эрүүгийн эрх зүйн системийн боломжууд болоод хохирогчийн эрхийн талаар

#### 6.5.1 ОРШИЛ

Энэхүү бүлэгт:

- Хохирогчдын ашиглаж болох эрүүгийн эрхзүйн системийн 4 боломж
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хохирогчдод өгөх зөвлөгөө,

үзүүлэх үйлчилгээ

- Гэмт хэргийг мөрдөх явцад гэрчээр оролцох хүсэлтэй байгаа хохирогчдыг цагдаагийн байгууллагатай холбож өгөх

---

**Хохирогчид тусlamж үзүүлэх явцад үзүүлж буй тусlamж, туслалцааны үе шат бүрийг сайн дурын үндсэн дээр, зохих мэдлэгтэй байх гэсэн зарчим дээр тулгуурлан явуулна.**

---

Энэ хэсэгт үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод хохирогчдын хооронд яригдах сэдвүүд нь маш эмзэг байдаг төдийгүй хохирогчдоос маш хүнд шийдвэр гаргахыг шаарддаг. Дээрх шалтгаануудын улмаас ярилцлагыг хохирогчийн эх хэл дээр явуулах, эсвэл шаардлагатай тохиолдолд орчуулагч авах нь чухал юм.

#### **6.5.2 ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМИЙН БОЛОМЖУУД БОЛОН ХХГХ-ИЙН ХОХИРОГЧИЙН ЭРХ:**

ХХГХ-ийн хохирогчийн түгээмэл эрхийн нэг нь хууль зүйн болоод тэднийг цагаатгах эрхээ эдлэх юм. Тэдний эдлэх үндсэн дөрвөн эрх, боломжийт дурьдвал:

---

##### **Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад мэдүүлэг өгөхгүй байх**

---

Энэ нь хохирогчдын хувьд хамгийн сонгомол арга бөгөөд мөн хамгийн их ашиглагддаг. Учир нь тэд өөрийн болоод гэр бүл, эсвэл хайртай хүмүүсийнхээ аюулгүй байдалд санаа зовж байдгаас гадна цагдаагийн байгууллагад итгэхгүй байгаагаа үүгээр давхар илэрхийлдэг. Энэ нь хамгийн түгээмэл эрх бөгөөд эрүүгийн эрхзүйн байгууллага хохирогчийг гэрчээр дуудах, эсвэл мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй.

---

**Хохирогч гэрчээр дуудагдах, мэдүүлэг өгөх хүсэлгүй, хүчээр мэдүүлэг өгөхгүй гэсэн нөхцөлтэйгээр гэмт хэргийн болоод хэрэгтнүүдийн талаарх нууц мэдээллийг цагдаагийн байгууллагад өгөх.**

---

Мэдүүлэг өгөхтэй холбоотойгоор үүсэн гарч мэдэх ноцтой эрсдэлд оролгүйгээр хохирогчид тэднийг дарамтлаж байсан гэмт хэрэгтнүүдийн эсрэг тодорхой үйл ажиллагаа явуулах

боломжийг олгодог учир ихэнх хохирогчид энэ сонголтыг хийдэг. Энэ талаарх мэдээллийг 6.9 хэсгээс үзнэ үү.

---

**Хүн наймаалагчдын эсрэг ял сонсгох гэрчийн мэдүүлэг өгөх боломжийг судлах:**

---

Ихэнх хохирогчид эмчилгээ хийлгэж, сонголт хийх боломжт зөвлөгөө авсны дараа нөхцөл байдалд дүгнэлт хийж өөрсдийг нь наймаалсан гэмт хэрэгтнүүдийг цээрлүүлэх хүсэлтэй байдаг.

---

**Тэднийг хохирогч болгосон гэмт хэрэгтнүүдээс нөхөн төлбөр авах, нөхөн төлбөрөө авахад туслалцаа авах талаар хуулинд заагдсан эрхээ мэдэж авах:**

---

Хүн наймаалагчид хохирогчдыг хүчирхийлж, мөлжиж нэлээд их хэмжээний ашиг олж авдаг. Хохирогчдод нөхөн төлбөр авч болох эрхийнх нь талаар болоод нөхөн төлбөр авахад туслалцаа үзүүлэх ёстой.

**6.5.3 БОЛОМЖУУДЫН ТАЛААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ОНОВЧТОЙ ЦАГ ҮЕ**

---

**Насан хүрээгүй хүнийг эмчлэх, ярилцлага авах талаарх зааварчилгааг 5-р бүлгийн 5.6 хэсгээс үзнэ үү.**

---

**Дамжуулагч болоод хүлээн авагч орны байгууллагууд**

Байгууллагууд дамжуулагч болон хүлээн авагч улс оронд хийгдэх эмнэлгийн үзлэг, эсвэл явахаас өмнөх үед хохирогчдод тэдний хуулийн эрх болоод боломжуудын талаар мэдээлэл өгөх нь зөв үү, үгүй юу гэсэнтэй холбогдон асуудал үүсдэг. Ерөнхий журмын хувьд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хүлээн авагч улс орон буюу дамжуулагч улс оронд байх үед нь тусламж үзүүлэх үйл явцын үед хохирогчдод тэдний хуулийн эрхийн талаар болоод эрүүгийн эрхэзүйн системийн сонголтуудын талаар заавал мэдээлэл өгөх ёстой байдаг. Өөр байгууллага хохирогчид эх орондоо очсоны дараа үйлчилгээ үзүүлэгч байгууллагад

хандахыг зөвлөсөн бол хохирогч өөрийн эрх болоод эрүүгийн эрхзүйн сонголтуудын талаарх мэдлэгтэй гэсэн үг юм. Гэхдээ тухайн байгууллага санал болгосон байгууллагатай холбоо барьж мэдээлэл өгсөн эсэхийг дахин баталгаажуулах ёстой.

Хохирогч шууд туслалцаа авах хүсэлтэй боловч түүний хүссэн тусламжийг хууль хэрэгжүүлэгч эсвэл тухайн орны төрийн байгууллага, эсвэл ТББ үзүүлээгүй бол асуудал хүндэрдэг. Тухайн шатанд хохирогчид зөвлөгөө өгөх эсэх шийдвэр гаргахад хэцүү бөгөөд энэ нь зарим нэг хүчин зүйлээс шалтгаалдаг. Хохирогчид шаардлагатай байгаа цогц зөвлөгөө өгөхийн тулд ярилцагч тухайн орны эрүүгийн эрхзүйн талаар өргөн мэдлэгтэй байх ёстой. Мөн хохирогчид тулгараад байгаа хүндрэл бэрхшээлийн талаар тухайн орны баримталдаг бодлогыг анхаарч үзэх хэрэгтэй. ХХГХ-ийн хохирогч, ХХГХ-ийн хохирогч байхдаа гэмт хэрэг үйлдсэний улмаас гэмт хэрэгт холбогдон шийтгэл хүлээх гэж байгаа бол хохирогч гэрчийн мэдүүлэг өгөх эрхээ эдлэхгүй байх нь дээр юм. Гэхдээ гэрчийн мэдүүлэг өгөх боломжтой бол үйлчилгээ үзүүлэгч байгууллага эдлэж болох эрхийн талаар хохирогчид мэдээлж, тэдний гаргасан шийдвэрийг хүндэтгэж үзнэ.

Хохирогчид тодорхой хугацааны дараа боломжуудын талаар мэдээлэл өгөх ба сэтгэл зүйч хохирогчийн байдлыг оношилсны дараа эдгээр боломжуудын талаар ярилцах нь зөв юм. Хохирогч шаардлагатай байгаа эрүүл мэндийн болоод сэтгэл зүйн эмчилгээ авч, аюулгүй байдалд байгаа гэдгээ мэдэрч байх ёстой бөгөөд сэтгэл зүйч хохирогчид хор учруулахгүй гэсэн дүгнэлт гаргасны дараа эрх, боломжуудын талаарх мэдээллийг авах ёстой.

Энэ бүхнийг тэнцвэржүүлэн авч үзэхэд бэрхшээл үүсдэг ба үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрийн хэмжүүрээр хэрэг бүрт дүгнэлт гаргадаг. Хохирогчид хандсан эрүүгийн эрхзүйн боломжууд болоод эрхийг хохирогчийн аюулгүй байдал, эрх ашгийн үүднээс хохирогчийг олж тогтоосон тухайн улс оронд танилцуулах нь хамгийн зөв алхам байдаг. Хохирогч эх орондоо буюу гуравдагч улс орныг сонгосон тохиолдолд түүнийг хүргэж өгөх асуудал тулгардаг ба энэ нь хохирогчийн хуулийн дагуух эрхийг зөрчдөггүй. Өөрөөр хэлбэл тухайн хохирогчийг хүргэж өгөх асуудал сүүлд шийдэгдэг. Дамжин өнгөрсөн буюу очсон газартай холбоотой нууц мэдээлэл буюу баримт нотолгоог

хохирогч цагдаад өгөх хүсэлт гаргаж болох ба түүний өгсөн мэдээллийг тухайн улсын цагдаагийн байгууллагад дамжуулдаг.

### **Хохирогчийн эх орон дахь хүлээн авагч байгууллага**

Хохирогч нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эзэмшлийн хоргодох байранд байрлаж байгаа бол хуулийн зөвлөгөө өгөх эсэхийг хохирогчийн байр байдлаас шалтгаалан шийдвэрлэх ба эн түрүүнд эмнэлгийн, сэтгэл зүйн болоод бусад шаардлагатай туслалцааг үзүүлнэ. Хуулийн зөвлөх хоргодох байрны нийгмийн ажилтан, мэдрэлийн эмч буюу сэтгэл зүйчтэй ярилцсаны дараа хохирогчтой уулзаж зөвлөгөө өгдөг. Хохирогч сэтгэл санааны онцгой хүнд цохилтонд орсон бол илүү хүндрэл учруулахаас сэргийлж эрх зүйн зөвлөгөө өгөхөөс илүүтэйгээр сэтгэл зүйн эмчилгээ өгөх нь илүү зөв юм. Тийм учраас хууль зүйн зөвлөгөөг хойшлуулах ёстай.

Хохирогч эх орондоо буюу өөр газар руу эргэн очиж байгаа бол үйлчилгээ үзүүлэх ёстай байгууллагад боломжтой үед хохирогчид эрхийнх нь тухай мэдээлэл өгөх хүсэлт хүргүүлнэ.

#### **6.5.4 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА**

ХХГХ-ийн хохирогчид ямар төрлийн зөвлөгөө өгөхийг шийдвэрлэсний дараа нууц мэдээлэл өгөх эсэх, гэрч болж мэдүүлэг өгөх эсэх, нөхөн төлбөр авах боломжтой эсэх зэргийг дараах нөхцлөөс хамааруулан авч үзнэ.

- Хүлээн авагч оронд ХХГХ-тэй тэмцэх мэргэжлийн байгууллага байгаа эсэх
- Үгүй бол боломжтой бусад байгууллага байгаа эсэх
- Дээрх хоёр тохиолдолд хүлээн авагч байгууллага цагдаагийн байгууллагатай харьцдаг эсэх, харьцдаг бол хэрхэн ажилладаг?
- Тухайн байгууллагын мэргэжлийн ур чадварын түвшин
- Өмнөх туршлагаас үүдэн цагдаагийн байгууллагад итгэж болох эсэх
- Авиалгалаас үүдэн гарах эрсдлийн түвшин

- Хохирогч нууц мэдээлэл өгөхөөр шийдсэн бол цагдаагийн байгууллага мэргэжлийн талаас нууцлалыг хэрхэн хамгаалах вэ?
- Хүлээн авагч оронд хохирогч-гэрчтэй хамтран ажиллахад гэрчийг хамгаалах эрхзүйн хамгаалалтын тохирсон хөтөлбөр байгаа эсэх
- Хохирогч гэрчийн мэдүүлэг өгөхдөө түүнд учрах сэтгэлийн дарамтыг түүлж чадах боломжтой эсэх
- Тухайн орны эрүүгийн эрхзүйн системд нөхөн төлбөр авах журам байдаг эсэх, байдаг бол хохирогч хэрхэн авах, нөхөн төлбөр авахын тулд мөрдөн байцаалтын явцад гэрчийн мэдүүлэг өгөх шаардлагатай эсэх, эсвэл нөхөн төлбөр авахдаа иргэний хувьд гомдол гаргаж болох эсэх

Сэтгэл зүйч зөвшөөрсөн тохиолдолд хуулийн зөвлөх хохирогчид хуулийн дагуу эрхийг нь танилцуулна. Хохирогчид дараахь зөвлөгөөг өгнө. Үүнд:

- Шийдвэр гаргахын өмнө боломжит дөрвөн сонголтын талаарх тайлбарыг сайтар сонсч ойлгох
- Яаравчлан шийдвэр гаргах шаардлага байхгүй
- Хохирогч сонголт хийх хангалттай хугацаа бий
- Нэмэлт зөвлөгөө эсвэл тайлбарыг хэзээ ч авах боломжтой
- Шийдвэрээ хэзээ ч хамаагүй дахин өөрчилж болно

Хуулийн зөвлөх ямар ч тохиолдолд хохирогчид хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах санал тавих шаардлага тавих эрхгүй бөгөөд хуулийн зөвлөх хохирогчид хийсэн сонголтоос нь үүдэн гарч болох үр дагаврын талаар зөвлөгөө өгнө. Энд дараахь зүйлсийг дурьдах нь зүйтэй.

- Гэрчийн хувиар буюу мэдээллийн эх сурвалж гэсэн үүднээс хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах нь хохирогчийн санаанд хадгалагдах буюу бий болох янз бүрийн эрсдэл авчирна
- Хэдийгээр хохирогч хамтран ажиллах үүрэг хүлээхгүй боловч суллагдсан хохирогчид хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад нууц мэдээлэл өгөх эсвэл хүн наймаалагчдын эсрэг мэдүүлэг өгч хамтран ажиллахгүй бол ХХГХ-тэй тэмцэх мөн цаашид бусдын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүндрэл гарах юм.

- “Гэрч” болох боломжийн хувьд хохирогчид шийдвэр гаргах хүртэл нэлээдгүй хугацаа өнгөрч болох хэдий ч хугацаа өнгөрөх тусам хүн наймаалагчид хохирогч ортосноос болж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч эхэлдэг учир цагдаагийн байгууллага хүн наймаалагчдыг олж илрүүлэх, нотолгоог баримтжуулахад хүндрэлтэй тулгардаг.

Эцсийн дүнд хохирогч 6.5.2 хэсэгт заасны дагуу өөрийн сонголтыг бүрэн ухамсарлаж ойлгосон байх ёстой. Хохирогчид эдлэж болох эрх, хийх сонголтуудыг тайлбарлан өгч, тэднийг үг хэлэхийг хүчлэхгүй, шийдвэр гаргах эсэх нь тэдний сонголт гэдгийг ойлгуулсны дараа хуулийн зөвлөх мөн хохирогчид шийдвэрээ хэзээ ч өөрчилж болно гэдгийг сануулна.

#### 6.5.5 ХОХИРОГЧ-ГЭРЧИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ХАМГААЛАХ

Хохирогчид гэрч болох эсэхээ шийдэхийн өмнө гурван зүйл дээр анхаарлаа хандуулдагийг ажлын туршлага харуулсан билээ. Гэрчийн эрүүл мэнд болоод мөрдөн байцаалтын гэрчийг хамгаалах үүднээс дээрх зүйлсийг нэгтгэж, дурьдвал:

- Хохирогч, хохирогчийн гэр бүл болоод түүний ойр дотны хүмүүсийн аюулгүй байдал.
- Хохирогчийн гэр бүл болоод ойр дотны хүмүүсийг олон нийтэд ил гаргах эрсдэл, нууцлал, эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагаар зарлах. Бэлгийн хүчирхийлэлд автаж байсан хохирогчдын хувьд энэ айдас нь түүний шийдвэр гаргахад хүчтэй нөлөөлдөг.
- Хүн наймаалагчтай хамт байхаас айх. Хохирогчдын хувьд энэ нь зөвхөн тэдэнд тохиолддог нэг төрлийн айдас бөгөөд ялангуяа бэлгийн эсвэл бие махбодийн хүчирхийлэлд орж байсан хүмүүст тохиолддог.

Эдгээр шалтгааны улмаас хохирогчид тухайн орны нөхцөл байдлаас шалтгаалан тэдний санааг зовоож буй асуудлуудад тохирсон зөвлөгөө өгнө.

## Биеэр очиж мэдүүлэг өгөх гэрчийг хамгаалах

Хохирогч хүн наймаалагчдын эсрэг мэдүүлэг өгөх тэж байгаа бол нарийвчлан тодорхойлж болохгүй эрсдэл ямар нэгэн хэмжээгээр оршин байдаг. Ихэнх улс орнуудад гэрчийг хуулиар хамгаалдаг боловч хэрэгжүүлэх боломж бололцоо хязгаарлагдмал байдаг, мөн зарим нэг орнуудад хуулийн заалт, шаардлагатай нөөц бололцоо байдаг ч ХХГХ-ийн хохирогчид дээрх хөтөлбөрт хамрагдах нөхцлийг биелүүлэхээс татгалздаг байна. Тиймээс иргэдэд тэднийг болон гэр бүл, ойр дотныхныг нь тэдэнд учирч болох хохирлоос хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч болох талаар бодит мэдээллийг өгөх нь чухал юм.

Хохирогчид болон тэдний гэр бүлийнхныг хамгаалах арга хэмжээнүүдээс дурьдвал:

- Нүүлгэн суурьшуулах
- Шинэ орон сууц
- Овог нэрээ солих
- Хувийн хамгаалалт.

## Мөрдөн байцаалтанд мэдүүлэг өгөх гэрчийг хамгаалах:

Эрүүгийн эрхэзүйн ихэнх бүтцэд хохирогч-гэрч мөрдөн байцаалтын явцад хамтран ажиллаж, баримт нотолгоо өгөх явцад нууцлал болон хуулийн дагуу аюулгүй байдлыг нь хамгаалах зүйл заалтууд байдаг. Эдгээр зүйл заалтууд нь маш олон утга агуулж, улс орон бүрээс шалтгаалан ялгаатай байх боловч дараахь байдалаас хамаарч хохирогчид хамааралтай. Үүнд:

- Нууцлалыг батлан эрүүгийн хэрэг үүсгэх хуулийн заалт. Тухайлбал, нэрээ нууцлах буюу нууц нэрээр гэрчээр оролцох хуулийн заалт, эсвэл хүн наймаалагч болон түүний өмгөөлөгчөөс хохирогчийн хэн болохыг нууцлах
- Хохирогчийн мэдүүлгийг нууц нэрээр авах буюу хохирогчийн овог нэрийг хүн наймаалагч болон түүний өмгөөлөгчөөс нуух хуулийн заалт (нууц нэр ашиглах буюу мэдүүлэгт жинхэнэ нэрийг дурьдахгүй байсан ч мэдүүлэгт дурьдсан зарим нэг баримтаас үндэслэн хүн наймаалагч баримтын эх сурвалжийг

- олж мэдэх боломж байдаг. Үүнийг хохирогч мэдэж байх ёстой)
- Хохирогчийг мөрдөн байцаалтын явцад хүн наймаалагчтай нүүр тулж уулзахаас зайлсхийсэн хуулийн заалт
  - Хохирогч зөвхөн нэг талаас нь харж болох цонхоор хүн наймаалагчийг мөн эсэхийг батлах боломж олгох хуулийн заалт
  - Хэргийн анхны хэлэлцүүлэг дээр мэдүүлэг өгөх буюу видео, аудио холбоогоор цонхны цаанаас мэдүүлэг өгөх, эсвэл хүн наймаалагч буюу түүний өмгөөлөгчийг байхгүй байхад мэдүүлэг өгөх, эсвэл өмнөх өгсөн мэдүүлэг дээр үндэслэн шүүх хурал дээр мэдүүлэг өгөхгүй байх
  - Хохирогчид дэмжлэг үзүүлэх зорилгоор мөрдөн байцаалтын явцад гадны зөвлөхийг мөрдөн байцаалтын үе шат бүрд байлцуулахыг зөвшөөрөх хуулийн заалт, мөн мөрдөн байцаалтын явцад байнга хүн дагалдуулах заалт
  - Мөрдөн байцаах явцад хуулиар олгогдсон хамгаалалтын арга хэмжээг зөрчсөн тохиолдолд хохирогчийг хүчээр мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй гэсэн цагдаагийн болон прокурорын гэрээний заалт, өөрөөр хэлбэл анхны шүүх хурлын үеэр шүүгч хохирогч-гэрчийг олны өмнө гаргахыг тушаах, эсвэл хохирогч-гэрчийг цонх ашиглалгүйгээр хүн наймаалагчийг байхад мэдүүлэг өгөхийг шаардах.

## 6.6 Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг

Дээр дурьдсанчлан үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай сайн харилцаатай бол хуулийн байгууллагатай хамтран ажиллах хүсэлтэй байгаа хохирогчдод туслалцаа үзүүлэх боломжтой юм. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж ХХГХ-тэй тэмцэхэд өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой ба үүний үр дүнд хүн наймаалагчдад эрүүгийн шийтгэл хүлээлгэдэг.

### 6.6.1 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ

Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай ямар хүрээнд, хэрхэн яж хамтран ажиллаж, ямар үр дүнд хүрэх нь дараахь хүчин

зүйлүүдээс шалтгаална. Үүнд:

- Тухайн улс орон эх нутаг, дамжуулах, эсвэл хүлээн авагчийн аль нь болох
- ХХГХ-ийн хохирогчдын тоо
- Тухайн орны эрүүгийн эрхзүй олон улсын хэм хэмжээг мөрдөж байгаа эсэх
- ХХГХ-тэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын боломж бололцоо, мэргэжлийн ур чадвар
- Хохирогчийн аюулгүй байдал ба эрхийг хамгаалахтай холбоотой хууль эрхзүй
- Холбогдох төр засгийн байгууллагуудын шаардлага, зорилго
- Энэ үйл ажиллагааг дэмжих донор байгууллагын хүсэл эрмэлзэл, санхүүгийн чадвар.

## 6.6.2 ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙН ҮР АШИГ

Үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд хамтран ажиллана гэсэн шийдвэр гаргавал тал бүрийн хүлээх үүргийг харилцан ойлголцлын санамж бичигт бичгээр нарийвчлан зааж гарч болох үл ойлголцлоос зайлсхийнэ. Хууль хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа явуулж буй ажилтнууд мөрдөн байцаалтыг үр дүнд хүргэхэд нэлээдгүй дарамттай учирдаг бөгөөд ажилтнууд бичгээр нарийвчлан зааж өгөөгүй тохиолдолд ажлын явцад нөлөөлж болзошгүй гэсэн үүднээс хамтран ажиллахаас зайлсхийхийг оролдох магадлал өндөр байдаг.

Тухайлбал, үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нөлөө үзүүлэхүйц мэдээллийг гадагш гаргахгүй гэсэн шийдвэр гаргасан ихэнх тохиолдолд мөрдөн байцаагч нар хуулийн эрхийнхээ дагуу мөрдөн байцаалтаа явуулахын тулд нэмэлт мэдээлэл авах зорилгоор дарамт үзүүлэх нь бий.

Гэхдээ ийм тохиолдол цөөн байдаг. Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцлүүдийг дээд түвшинд батлан дэмжиж, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үүргийг хүлээн зөвшөөрдөг. Бичгээр үйлдсэн гэрээг яамны болоод цагдаагийн дээд удирдлагааас дэмжиж байгаа

нь харилцан уялдааг баталгаажуулахаас гадна мөн хамтын ажиллагааг дэмжиж байгаа гэсэн үг юм.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудын олонх нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажиллахыг дэмжихийн зэрэгцээ тухайн байгууллагаас авах дэмжлэг их гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хууль хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа энэ асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй, ХХГХ-ийн хохирогчдод шаардлагатай тусlamж үзүүлэх чадваргүй гэсэн үүднээс зарим тохиолдолд хардлага сэрглэг, дургүйцэл илэрдэг. Хамтын ажиллагааг бүтцийн зүгээс дэмжиж буй тохиолдолд хэсэг бүлгийн нөлөөлөл багасдаг байна.

### 6.6.3 ҮНДСЭН ЗАРЧМУУД

Хэлэлцээрийн дараа хамтын ажиллагааны үндсэн зарчмууд болоод амьдрал дээр хэрэглэх аргуудыг боловсруулж албан ёсны Харилцан ойлголцлын санамж бичигт тусгаж холбогдох яам, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гарын үсэг зурж баталгаажуулдаг. Цагдаагийн газартай хамтран ажиллахын хувьд тохиролцоог албан ёсоор баталгаажуулан эн түрүүнд үндсэн зармчууд болон хоёр талын хүлээх үүрэг, нөхцлийг албан ёсны баримтанд тусгах шаардлагатай. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод хууль хэрэгжүүлэгч байгууллагын хоород байгуулдаг жишиг харилцан ойлголцлын санамж бичигт дараахаа үндсэн зарчмуудыг тохирсон тухай тусгаж өгдөг. Үүнд:

- Зорилго нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хууль хэрэгжүүлэгч байгууллага үр дүнтэй хамтран ажиллаж ХХГХ-ийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулна
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрмэлзэлтэй, ХХГХ-ийн хохирогчдын эрхийн хамгаалах, нүүн суурьшигч, эмэгтэйчүүд, хүүхэд зэрэг зорилтолт бүлгийн сайн сайхныг сахин хамгаалахн төлөө ажиллах
- Талууд хохирогч болоод эрсдэлд орох магадлалтай хүмүүсийн аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалахад онцгой анхаарал хандуулна

- Хамтын ажиллагааны нөхцлүүд нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Палермогийн хуулинд заасан хүчин төгөлдөр олон улсын хэм хэмжээ, НҮБ-ын Хүний эрхийн конвенцийн ХХГХ болон Хүний эрхийн зарчмуудыг мөрдлөг болгоно
- Өөр хохирогчийн аюулгүй байдалд аюул учруулахгүй бол хохирогчийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг олон нийтэд задлах шаардлага үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавихгүй байх, буюу мэдээлэл хохирогчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөлд.

Хамтын ажиллагааны салбараас үл хамааран хууль хэрэгжүүлэгч байгуулагатай эдгээр таван үндсэн зарчмыг хамтын ажиллагааны гэрээ болгон ашиглана. Эдгээр зарчмууд нь мөн мэдээлэл солилцоход хүчин төгөлдөр нөхцөл болох төдийгүй мөн зохицуулалт болох техникийн хамтын ажиллагаа, чадварыг хөгжүүлэхарга зам, тухайлбал, семинар, хууль хэрэгжүүлэх талаархи сургалт, буюу олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл болон сэргээжлүүлэх аян зэргийг зохион байгуулахад ашиглаж болно.

#### **6.6.4 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙН АГУУЛГА**

Хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг дурьдсаны дараа Харилцан ойлголцлын санамж бичигт талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг нарийвчлан тусгах ба мөн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга замуудыг зааж өгнө. Харилцан ойлголцлын санамж бичгийг өргөн хүрээтэй сэдвүүдийг хамрахаар боловсруулж болох юм. Харилцан ойлголцлын санамж бичигт тусгаж өгөхөөр хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах хэд хэдэн салбарууд бий.

- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах салбар, харилцах арга
- Техникийн хамтын ажиллагаа, чадварыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаархи заалтууд, тухайлбал, мэргэжилтэн бэлтгэх сургалт, буюу техникийн дэмжлэг үзүүлэх тоног төхөөрөмжөөр хангах

- Урьдчилан сэргийлэх буюу мөрдөн байцаах зорилгоор ашиглах мэдээлэл солилцох
- Хохирогч-гэрчийг зөвхөн тээврийн хэрэгслээр хангах
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын халамжинд байгаа хохирогчтой харилцах боломж.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагад мэдээлэл хүргүүлэх, солилцох хамтын ажиллагааны гэрээ нь маш чухал юм. Хүн наймаалагчид бол онц аюултай гэмт хэрэгтнүүд бөгөөд зөвшилцсэн хүрээнд сайтар зохион байгуулалгүйгээр эрүүгийн хэрэгт холбоотой мэдээлэл тараах, солилцох нь хүний амь болоод байгууллагын түвшинд хор хохиролтой үр дагаварт хүргэж болзошгүй. Энэхүү бүлгийн 6.9.6-д эрсдэлийн хүчин зүйлсийн талаар дэлгэрэнгүй дурьдсан болно.

Мэдээлэл солилцох тухай харилцан ойлголцлын санамж бичгийн заалтууд нь дараах зүйлсийг багтаасан байх ёстой. Үүнд:

- Мэдээллийн эх сурвалж, агуулгын талаарх онцгой нууцлал
- Хохирогчдыг аврах зорилгоор буюу хохирогч болох эрсдэлтэй хүмүүсийг урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг тараагаагүй бол зөвхөн зөвшөөрөгдсөн мэдээллийг тараах
- Мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хүлээх үүргийн талаарх онцгой нууцлал
- Зөвхөн тусгайлан заасан хүрээнд мэдээллийг тараах
- Эх сурвалж болоод урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр байгууллагын шүүх хуралд гүйцэтгэх үүргийн талаарх мэдээллийг гаргахгүй байх
- Хохирогчид хэргийнхээ явцын талаарх мэдээлэл авах эрх.

Зарим улс орны хууль хэрэгжүүлэгч байгууллагууд зайлсхийх боломжтой гэж үзвэл Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцлүүдийг хүлээн зөвшөөрдөггүй болохыг байгууллагууд мэддэг. Цагдаагийн зарим байгууллагууд ийм төрлийн гэрээг тэдний эрхийг боогдуулж байна гэж үздэг учир байгуулах сонирхолгүй байдаг. Гэхдээ ийм төрлийн гэрээг байгуулах ёстой бодит шалтгаанууд бий. Учир нь байгууллага болоод цагдаагийн байгууллага чухал мэдээлэл тараах, солилцохтой холбогдон бодит эрсдэл гарч ирдэг. Харилцан ойлголцлын санамж бичгийн цар хүрээ болоод нөхцлүүд нь тэдгээр эрсдэлийг аль болох хязгаарлах зорилготой юм.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс эсэргүүцэл тулгарвал байгууллага ийм төрлийн мэдээллийг тараах үүрэггүй гэдгийг сануулах ёстай. Мөн байгууллагын халамжинд байгаа хохирогчдыг дэмжих, тэдэнд учирч болох хор хохирлыг тооцох, хамтран ажиллах эрмэлзэлтэй байгаагаа мэдэгдэхийн зэрэгцээ цагдаагийн байгууллагад тухайн байгууллага ач холбогдолтой, хувь нэмрээ оруулах боломжтой гэдгээ харуулах ёстай.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үндсэн үүрэг бол хохирогчдын аюулгүй байдал, сайн сайхан гэдгийг хууль хэрэгжүүлэгч байгууллагад сануулж албан ёсоор бичгээр баталгаажуулж буй нөхцлүүд нь тухайн байгууллага үүргээ гүйцэтгэж буй эсэхийг баталгаажуулна гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд бусад хүмүүсээс илүүтэйгээр үүнийг хүлээн зөвшөөрөх ёстай. Тэдний талаас гэрээ байгуулахгүй гэж байгаа нь тэдэнтэй гэрээ байгуулахгүй байх шалтгааныг тодорхойлж байгаа болно.

## 6.6.5 ЭРСДЭЛ

Цагдаагийн ажилтнууд хохирогчдод туслалцаа үзүүлэх зорилгоор үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай албан бусаар хамтран ажиллах ёстой бөгөөд энэхүү зохицуулалтыг хоёр зүйлээр тодорхойлж ойлгож болно. 1-рт, цагдаа хохирогчдод хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр сургадсан, 2-рт, ажил үүргээ гүйцэтгэж буй тэдний арга нь албан ёсны журмыг нарийвчлан мөрддөггүй. Үүний нэг жишээ бол цагдаагийн ажилтнууд ХХГХ-ийн хохирогчид хууль бусаар хил нэвтэрсэн болоод бусад үйл ажиллагаа явуулсны улмаас шийтгэл хүлээхээр заасан хуулийн заалтын дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хандаж, тусламж авахыг зөвлөх явдал юм.

Тиймээс тохиолдлын хамтын ажиллагааг албан болгож харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах нь хохиргчийн эрх ашгийг хамгаалж буйг нотолсон үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод хууль хэрэгжүүлэгч байгууллагын албан бус хамтын ажиллагаанд нөлөөлөх эрсдэл бий болгодог. Энэ асуудалд хариу өгөх нь хялбар биш юм. Байгууллагууд өөрсдийгөө хамгаалах зорилгоор цагдаагийн байгууллагатай

хамтран ажиллах хамтын ажиллагаагаа албан ёсны болгох уу, эсвэл хохирогчдод туслалцаа үзүүлэх албан бус боломжийг алдах уу гэсэн хоёр тулгамдсан асуудлыг хэрхэн тэнцвэржүүлэх вэ гэдэгтэй тулгардаг байна.

## 6.7 ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ НЭГЖҮҮДТЭЙ АЖИЛЛАХ

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага хууль хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагааны шаардлага ихэвчлэн үйл ажиллагааны дараах хүрээнд гарч ирдэг. Үүнд:

- Техникийн туслалцаа буюу чадварыг хөгжүүлэх, ө.х. семинар, мэргэжилтэн бэлтгэх буюу хууль хянах
- Хохирогчийг аврах, хохирогчтой хийх ярилцлага буюу хохирогчид өгөх зөвлөгөөтэй холбоотой мэдээлэл солилцох.

Дээрх хүрээний хамтын ажиллагааны найдвартай, тогтвортой байдлыг хангахын тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хууль хэрэгжүүлэгч байгууллагын хоорондын харилцааны арга замуудыг тодорхойлж, тогтоох шаардлагатай юм.

Хамтын ажиллагааны арга замуудыг Харилцан ойлголцлын санамж бичигт тусгана. Тухайн байгууллагын зүгээс хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах хүрээ, харилцах хүмүүсийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Харилцан ойлголцлын санамж бичигт хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай харилцахдаа зөвхөн тухайн хүрээнд эсвэл тодорхой нэг төлөөлөгчтэй харилцана гэж зааж өгнө.

Хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудтай харилцахдаа зааж өгсөн тодорхой ажилтантай хамтран ажиллахаа би ингэснээр үйлчилгээ үзүүлэгч байгууллага зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулах, үл ойлголцох байдлаас зайлсхийх боломжтой болдог. Учир нь олон ажилтантай харьцахад буруу зөвлөгөө өгөх, эсвэл тухайн байгууллага тохиромжгүй үйл ажиллагаа явуулах магадлал бий болдог. Бүх ажилтнууд болоод орон нутгийн хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудын ажлын харилцааг хязгаарлахгүй байхын зэрэгцээ оновчтой, тогтвортой ажил хийгдэж байгаа эсэхийг хянаж байх шаардлагатай бөгөөд ажлын

хүрээний харилцаа болоод техникийн хамтын ажиллагааны харилцааг зааж өгсөн холбоо барих хүнээр дамжуулан явуулж буй эсэхийг хянах нь зүйтэй.

Холбоо барих гол хүн нь үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод хууль хэрэгжүүлэгч байгууллагатай 24 цагийн турш холбоотой байх ёстай. ХХГХ-тэй хийж буй тэмцэл нь 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаа бөгөөд амьдралаас хараад хамтын ажиллагаа зайлшгүй шаарддаг яаралтай асуудлууд, тухайлбал, хохирогчийг аврах, хохирогчид туслалцаа үзүүлэх шаардлага өдөр, шөнийн алинд нь ч гардаг. Тиймээс үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод хууль хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа 24 цагийнх байвал илүү үр дүнтэй байдаг.

**Үйлчилгээ үзүүлэгч болоод хууль хэрэгжүүлэгч байгууллага 24 цагийн холбоотой байх хүнийг тусгайлан томилох ба төлөөлөгч нь зөвхөн тухайн зориулaltaар ашиглах гар утастай байна.**

---

## 6.8 Техникийн хамтын ажиллагаа ба ур чадварыг хөгжүүлэх

Техникийн хамтын ажиллагааны болоод байгууллагын чадварыг хөгжүүлэх тал дээр хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллахад мэдээлэл солилцох буюу хохирогчид тусlamж үзүүлэхээс хялбар байдаг.

Гэсэн хэдий ч ХХГХ-тэй тэмцэх арга зам нь олон улсын хэм хэмжээтэй уялддаггүй хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллахад зарим төрлийн эрсдэл гардаг байна. Хохирогчид үзүүлэх тусlamж болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой олон улсын хэм хэмжээг хангах тал дээр санаачлага бага гаргадаг буюу огт гаргадаггүй хууль хэрэгжүүлэгч байгууллагатай техникийн хамтын ажиллагаанд буюу чадварыг хөгжүүлэх сургалтын төслүүд дээр хамтран ажилладаг байгууллага шүүмжлэлд өртөх нь бий.

Нөгөө талаас санал гомдол гаргадаггүй хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хязгаарлагдмал хүрээнд хамтран ажиллах нь байгууллагын хувьд бусдын нөлөөнд автахгүй байх, хууль

хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх боломжийг олгодог байна. Тодорхой нөхцөлтэй хязгаарлагдмал хүрээний хамтын ажиллагаа нь хамгийн тохиромжтой, ерөнхий зарчмуудын дагуу хохирогчид үзүүлэх үйлчилгээг сайжруулах боломж өгдөг.

## 6.9 Удирдлага ба мэдээлэл хүргэх

Энэ хэсэгт хохирогч, түүний гэр бүл болоод ойр дотны хүмүүсээс авсан мэдээллийг үйлчилгээ үзүүлэгч байгууллага хэрхэн ашиглаж байгаа, авсан мэдээллийг хууль хэрэгжүүлэгч байгууллагад хэрхэн яж хүргэх талаарх асуудлыг авч үзнэ.

### АНХААРАХ ГОЛ ЗҮЙЛС

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үүрэг нь ХХГХ-тай холбоотой мэдээллийг баримтжуулах, ашиглах, хүргэх бөгөөд мөн ХХГХ-тэй тэмцэж буй мэргэжилтнуудын анхаарал татаж буй асуудал дээр хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах болно. Зарим тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллага цагдаагийн харьяанд орох магадлалтай гэсэн ойлголт гардаг бөгөөд үүний үр дүнд тухайн байгууллагын нэр хүнд унадаг. Мөн байгууллагын ажилтнууд дээрх асуудлуудыг зохицуулахын тулд давхар үүрэг хариуцлага хүлээх ёстай болдгийг санах хэрэгтэй.

Байгууллага ХХГХ-тэй холбоотой нууц мэдээллийг хууль хэрэгжүүлэгч байгууллагуд дамжуулахтай холбогдуулан өөрийн байр суурийг илэрхийлж, дотоод журмыг тогтоохдоо дараах зүйлсийг анхаарвал зохино.

- Байнга мөрдөх ерөнхий зарчмын дагуу бодит болон боломжит хохирогчийн хүний эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүндэтгэх
- Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажилласанаар үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийн эрхийг хамгаалах, ХХГХ-ийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үндсэн зорилгоо биелүүлэх боломжтой
- Хохирогч түгээмэл эрхийн нэг болох хууль эрхзүйн

байгууллагын туслалцаа авах, нөхөн төлбөр авах эрхтэй. Айдас болон бусад шалтгаанаар хохирогчид өөрсдийг нь хүчирхийлж, мөлжиж байсан хүн наймаалагчдын эсрэг мэдүүлэг өгөх эрхээ зэллэх боломжгүй байдаг ба тэдгээр хохирогчдод хүн наймаалагчид, бусад хохирогчид болоод хүнийн наймааны арга замын талаарх мэдээллийг цагдаад өгөх эрхтэй гэдгийг ойлгуулах ёстай. Хохирогчид гэрч болж эрсдэлд орохоос илүүтэйгээр өөрсдийг нь наймаалсан хүнийг шийтгүүлэх үүднээс байгаа мэдээллээ цагдаад өгөх хүсэлтэй байдгийг судалгааны явцад тогтоосон байна. Аливаа хохирогч хуулийн байгууллагад хандах эрхтэй ба байгууллагууд хохирогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны нэг болох сонголт хийх эрхийн талаархи зөвлөгөө хохирогчид өгөх ёстай.

- Байгууллагын ажилтнууд мэдээллийг цагдаагийн байгууллагад дамжуулахын тулд хохирогчийг хамтран ажиллахыг хүчлэх ёсгүй. Мэдээлэл дамжуулах тохиолдолд байгууллага хохирогчид хуулийн эрх болоод хийж болох сонголтуудын талаарх мэдээлэл өгч, үүний дараа мэдээллийг дамжуулах ёстай гэсэн журам гаргах нь зүйтэй юм.

### **6.9.1 ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА - ТОДОР-ХОЙЛОЛТ БОЛОН НӨӨЦ БОЛОМЖ**

ХХГХ-тэй тэмцэх мэдээлэл гэдэг нь энгийнээр ХХГХ-тэй холбоотой мэдээлэл юм. Хууль хэрэгжүүлэх ойлголтоор бол ХХГХ-тэй тэмцэх мэдээлэлд хүн наймаалагч, хохирогч, дамжуулан худалдах арга зам, гэмт хэргийн нөхцөл зэргийн талаарх янз бүрийн эх сурвалжаас авсан төрөл бүрийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг багтдаг.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ХХГХ-тэй холбоотой нууц мэдээллийг дараах эх сурвалжуудаас авдаг. Үүнд:

- Олон нийтийн эх сурвалж – хэвлэлд гарсан мэдээ, мэдээлэл, сэтгүүлчид, судалгаа, бусад
- Ижил үйл ажиллагаа явуулдаг байгууллагын бусад салбаруудаас
- Хууль хэрэгжүүлэгч байгууллагууд – цагдаа, цагаачлалын

- алба, хилийн ажилтнууд
- Засгийн газар хоорондын болоод ТББ-ын түншүүдээс
- ХХГХ-ийн хохирогчид, гэр бүлийнхэн, ойр дотныхон, найз нөхөд болон бусдаас.

## 6.9.2 НУУЦ МЭДЭЭЛЛИЙН ТӨРЛҮҮД БОЛОН ТҮҮНИЙГ АШИГЛАХ НЬ

Нууц мэдээллийг хоёр ангилалд хувааж болно.

- **Сэдэвчилсэн нууц мэдээлэл** - тодорхой хүн буюу болж өнгөрсөн үйл явдлыг нарийвчлан тодотгох боломжгүй мэдээллийн төрөл. Тухайлбал, хохирогчдыг элсүүлэх, эрэлтийн түвшин, буюу энэ төрлийн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдэгддэг арга замуудад нөлөөлөх өнөөгийн ХХГХ-ийн хандлага, улс төр, эдийн засаг-нийгүйн эсвэл соёл уламжлалын хэв маяг
- **Тусгай нууц мэдээлэл** - тодорхой хүн буюу болж өнгөрсөн үйл явдлыг тодорхойлох боломж олгох мэдээллийн төрөл. Тухайлбал, үйлдэгдсэн гэмт хэргийн тухай баримтууд, огноо, байршил, нэр, нас, хүний биеийн тодорхойлолт зэрэг хувь хүнтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг, эсвэл хохирогч буюу хүн наймаалагчдыг олж тогтоох боломжтой хаяг зэрэг.

Сэдэвчилсэн болон тусгай нууц мэдээллийг дотор нь мөн хувааж авч үздэг.

- **Элсүүлэх аргууд** - эрсдэлтэй бүлгүүдийг олж тогтоох, хүч хэрэглэх буюу өгөөш болгосон зар, эсвэл хувиараа элсүүлэх сүлжээ, аяллын болон хувийн баримт бичиг олж авах арга, орох болон гарах виз авах
- **Тээвэрлэх зам** - гарах хилийн боомт, ил буюу нууцаар тээвэрлэх, тээврийн хэрэгсэл, дамжин өнгөрүүлэх үе шатуудыг тогтоох, хил гарах тусгай буюу байнга ашигладаг цэгүүд, хүн худалдах үед авилгалын гүйцэтгэсэн үүрэг
- **Хүлээн авах аргууд** - очих газарт нэвтрэх цэг, хүлээн авах арга, баримт бичгийг хураан авах, нууцлагдмал байрны байршил
- **Мөлжлөг ба хүчирхийлэл** - мөлжлөгийн зорилгын

хэлбэр, байршил, ашгийн хэмжээ, мөлжлөг өртүүлж байгаа удирдлагын арга, хүч хэрэглэх, хянах арга, бие махбодийн, бэлтийн болоод сэтгэл зүйн хүчирхийлэл

Үйлчилгээ үзүүлэгч байгуулага болон хууль хэрэгжүүлэгч байгууллагууд олон аргаар ХХГХ-тай тэмцэх нууц мэдээллийг цуглуулж, солилцдог. Үүнд:

- Хохирогчдыг хүн наймаалагчдаас аврах зорилгоор хохирогчдын хэн болохыг тогтоож, байршилыг нь илрүүлэх
- Хохирогчдод тусламж, туслалцаа үзүүлэхээ мэдэгдэх
- Мөрдөн байцаалтад тус болох зорилгоор хүн наймаалагчдыг олж тогтоох, байршилыг нь илрүүлэх
- Стратеги, тактик боловсруулах
- Нөөц бололцоогоо хуваарилах
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг нарийвчлан тооцох, заавар чиглэл боловсруулах, тухайлбал олон нийтэд мэдээлэл түгээх аян
- ХХГХ-ийн талаар судалгаа хийх, үнэлэх.

### 6.9.3 ХОЁР ТАЛТ СОЛИЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ

Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай мэдээлэл солилцох нь нэг талт солилцоо биш гэдгийг байнга санаж байх ёстой. Мэдээлэл солилцоо нь ХХГХ-ийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх нэгэн зорилгын төлөө ажиллаж байгаа хоёр байгууллагын хамтын ажиллагаа юм.

Цагдаагийн байгууллагын нэгэн адил үйлчилгээ үзүүлэгч байгууллага ХХГХ-ээс сэргийлэх, хохирогчдод тусламж үзүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цагдаагийн газар үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажиллах хүсэлтэй байдгийн нэг шалтгаан нь юм. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуул хамгийн сайн мэдээлэлтэй түнш болдог (учир нь хохирогчид ихэвчлэн итгэл үзүүлэхгүй байх цагдаатай ярихаасаа илүү үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудтай ярилцдаг). Энэ хамтын ажиллагаа нь мэдээлэл солилцох нэг хэлбэр бөгөөд цагдаагийн байгууллага өөрийн эх сурвалжаас авсан мэдээллээ урьдчилан сэргийлэх аян, судалгаа, шинжилгээ, үнэлгээ болон стратегийн шийдвэр

гаргах үйлчилгээ үзүүлэгч байгууллагад өгдөг байна.

Хохирогчдод тэдний өгсөн мэдээлэл хэрхэн ашиглагдаж байгаа талаарх мэдээллийг байнга өгч байх нь нэн чухал юм. Хохирогчийн хэрэгт оролцсон хүмүүсийг баривчилсан, шийтгэсэн эсэхийг тэд мэдэж байх ёстой ба нэн ялангуяа мэдүүлэг өгсөн, баривчлагдсан хүн суллагдсан бол хохирогчийн гэмт этгээдүүдээс хамгаалах үүднээс дээрх бүх мэдээллийг өгөх ёстой.

#### **6.9.4 БУСАД ХОХИРОГЧ БУЮУ БОЛОМЖИТ ХОХИРОГЧДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ҮҮРЭГ**

Хохирогчид тусlamж үзүүлэх явцад хохирогч буюу түүний гэр бүл, наиз нөхөд бусдын эрхшээлд мөлжлөгт байгаа байгаа бусад хохирогчийн талаар болон наймаалагдах эрсдэлд орсон хохирогчдын талаар мэдээлэлтэй байх нь бий. Энэ нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад зайлшгүй шийдвэрлэх асуудал үүсгэдэг ба учир нь ихэнх тохиолдолд тухайн мэдээлэл зөвхөн ярилцлага авч буй хүн болоод ярилцлага өгч буй хоёр хүний хооронд хийгдсэн ярилцлага хийх явцад ил болдог. Тиймээс тухайн байгууллага тухайн нууцлалыг задлаж бусад хохирогчид болон хохирогч болох эрсдэлд ороод байгаа хүмүүсийн талаарх мэдээллийг хууль хэрэгжүүлэгч байгууллагад өгөх эсэхийг шийдэх ёстой болдог байна. Энэ нь оролцогт талуудад бэрхшээл үүсгэх ба талуудын аль нэг нь үүнийг шийдвэрлэх тодорхой журам гаргах шаардлагатай болно.

Хүн наймаалагчдын эрхшээлд байгаа бусад хохирогчид болон эрсдэлд ороод байгаа хүмүүсийн талаарх мэдээллийг тодорхой хүрээнд ил болгож, эн түрүүнд хохирогчдыг аврах, гарч болох гэмт хэргийг таслан зогсоох боломж олгох үүднээс хууль хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулах дотоод журам боловсруулан хэрэгжүүлэх шаардлагыг байгууллагад хатуу тавьдаг. Ихэнх тохиолдолд ийм төрлийн мэдээллийг нууцлалын зэрэглэлтэй ярилцлагаас авсан гэсэн тодотголтойгоор дамжуулдаг бөгөөд энэ тохиолдолд мөрдөх журам тодорхой байна. Хангалттай мэдээлэл байгаа тохиолдолд цагдаагийн байгууллага шаардлагатай арга хэмжээ авдаг. Зарим улс орнуудын хуулинд үүнтэй адил мэдээлэл өгөх тухай хуулийн заалт байдаг байна.

Ийм журмыг боловсруулахдаа байгууллагууд мэдээллийг ил болгох нь хохирогч, түүнийг гэр бүлийнхэн, найз нөхөд буюу байгууллагын ажилтнуудад хор хохирол урчуулах нөхцөл байдал үүсэхэд түүнийг зохицуулах бэлтгэлтэй байх ёстай. ХХГХ-тэй тэмцэх орон нутгийн хууль хэрэгжүүлэгч байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх боломж бололцоогүй нөхцөлд байгууллага мэдээллийг тодорхой хүрээнд ил болсгоноор хохирогчийг буюу мэдээллийн эх сурвалжийг аюулд учруулж болох эсэхийг тодруулна. Тийм тохиолдолд байгууллагууд мэдээллийг тодорхой хүрээнд ил болгох боломжит арга замуудыг мэдэж байх ёстай.

Ярилцлагчтай ил тод ярилцах үүднээс ярилцлага эхлэхийн өмнө хүн наймаалагчдын эрхшээлд байгаа бусад хохирогчид буюу хохирогч болох эрсдэлтэй хүмүүсийн талаар мэдээлэл өгч буй хүн авч буй хүнд хохирогч, түүний гэр бүлийнхэн, ойр дотны буюу найз нөхөд нь хаана байгааг тодорхой мэдээлэх ёстай ба ингэснээр байгууллага хохирогчдыг аврах, суллах буюу хохирогч болох эрсдэлтэй хүмүүсийг ХХГХ-ийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шаардлагатай мэдээллийг тодорхой хүрээнд ил болгох боломжтой юм.

Ярилцлага өгч буй хүнд үүсч гарах аюулын талаар анхааруулсны дараа эх сурвалж мэдээллийг ил болгохыг татгалзах эрсдэл байдаг хэдий ч энэ нь шударга хэлцэл юм. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага хохирогчийг аврахад шаардлагатай мэдээлэл авсны дараа ямарваа нэгэн арга хэмжээ авахгүй байхыг хүлээн зөвшөрдөггүй бөгөөд ярилцлага өгөгчийн хувьд байгууллагын журмын талаар мэдээлэл авалгүйгээр ямарваа нэгэн асуултанд хариулахгүй байх эрхтэй.

#### **6.9.5 ХОХИРОГЧ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ШУУД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ**

Энэ хэсгийн эхэнд хохирогчид өөрийн хуулийн эрх болоод эрүүгийн хуулийн дагуу эдлэх эрхийнхээ талаарх бүрэн мэдээллийг авдаг тухай дурьдсан бөгөөд хохирогчид цагдаагийн байгууллагад өөрөө мэдээлэл өгөх эрхтэй болох талаар мөн ойлгуулдаг. Хохирогч мэдээлэл өгөх зорилгоор цагдаагийн

байгууллагын мөрдөн байцаагч нартай уулзах хүсэлтэй байгаа тохиолдолд туслалцаа үзүүлж байгаа байгууллага хохирогчийн хийх гэж буй алхам нөхцөл байдалд тохирсон эсэх талаар ярилцаж, зөвлөгөө өгнө. Мэдээлэл өгөх эсэх нь цагдаагийн тухайн нэгжийн нөөц бололцоо, ур чадвар болоод аюулгүй байдлыг хэрхэн үнэлж байгаагаас шалтгаална.

Ийм төрлийн үнэлгээ хийхдээ цагдаагийн байгууллагын нэгж мэдээллийг зөв ашиглаж байгаа эсэх, хохирогчийн талаарх мэдээллийг мөрдөн байцаах болон шүүх хурлын гэх мэт бүх шатанд нууцалж байгаа эсэх зэрэг мэдээлэл дамжих бүх шатны үйл ажиллагааг багтаадаг. Хуулийн зөвлөгөө өгч буй ажилтан хохирогчтой анх удаа уулзаж зөвлөгөө өгөхдөө энэ бүхнийг мэдэж байгаа шаардлагатай юм. (Хуулийн зөвлөгөөний талаар 6.5.4 хэсгээс үзнэ үү)

Цагдаагийн байгууллага мэргэжлийн түвшинд, нууцлалыг хадгалан үйл ажиллагаа явуулах чадвартай гэж үзвэл дараагийн шатанд үйлчилгээ үзүүлэгч байгууллага цагдаагийн байгууллагын ХХГХ-тэй тэмцэх ажилтантай буюу холбогдох хэлтэстэй хохирогчийг уулзуулж шаардлагатай гэсэн мэдээллийг өгүүлнэ. Тухайн байгууллагыг мэддэг мөрдөн байцаагчтай аюулгүй, дундын газар уулзах нь хамгийн тохиромжтой юм. 1-р бүлэгт дурьдсанаар аюулгүй байдлын үүднээс уулзалтыг хоргоох байранд хийж болохгүй.

Уулзалтанд хуулийн зөвлөхтэйгээ байгаа эсэх талаар хохирогчоос урьдчилан асуух ёстой. Хохирогч шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд байгууллага уулзалтанд оролцох оролцох шаардлагагүй. Хохирогч хуулийн зөвлөх авах шаардлагатай гэвэл хуулийн зөвлөх уулзалтанд оролцох боловч идэвхтэй үйл ажиллагаа явуулах ёсгүй. Зөвхөн ажиглагчийн үргийг гүйцэтгэж хохирогчийн эрхийг хамгаалж байгаа эсэхийг хянана. Ярилцлагын явцад хөндөгдсөн сэдвүүд зөвхөн хохирогч болоод мөрдөн байцаагчийн хооронд үлдэнэ.

Хохирогч мэдээлэл өгөхд үйлчилгээ үзүүлэгч байгууллага хамтран ажиллах шаардлагагүй гэж ХХГХ-тэй тэмцэх хууль хэрэгжүүлэгч байгууллага үзэх тохиолдолд нөхцөл байдал илүү хүндээрдэг. Тухайлбал, цагдаагийн байгууллага хохирогчийн

талаарх мэдээллийг хэвлэл мэдээллээр олон нийтэд цацсан бол хохирогчид эн түрүүнд энэ тухай мэдэгдэж, үссэн нөхцөл байдалд цагдаагийн байгууллагатай холбогдоход гарч болох эрсдэлийн талаар ойлгуулна.

Ийм тохиолдолд гарч болох бусад эрсдэлүүдийн талаар мэдээлэл өгнө. Хохирогч болж өнгөрсөн үйл явдлыг мэдэж, ойлгож байгаа хэдий ч мэдээлэл өгнө гэсэн тохиолдолд байгууллага хохирогчийн энэ алхмыг зогсоо бус, харин хохирогчид холбогдох цагдаагийн байгууллага буюу ХХГХ-тэй тэмцэх нэгжтэй холбоо тогтооход шаардлагатай мэдээлэл өгнө. Дээр дурьдсанаар хохирогчид хуулийн зөвлөхийн туслалцаа үзүүлэх ба хохирогч хүсч байвал эрхийг нь хамгаална.

#### **6.9.6 МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХОД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛИЙГ ТООЦООЛОХ НЬ**

Хууль хэрэгжүүлэгч байгууллага мэдээллийн ач холбогдлыг үнэлж, зохих арга хэмжээ авах бол нууц мэдээллийг нээлттэй болгоход гарч болох эрсдэлийн түвшинг нарийвчлан үнэлэх шаардлагатай. Хохирогч буюу мэдээллийн бусад эх сурвалж баримт, нотолгоог ил болгосон тохиолдолд бодит эрсдэл гарч болох ба үүнд:

- Нууцлаг хэрэгтэй холбоотой мэдээлэл
- Хувийн мэдээлэл
- Хэрэгт холбогдолтой буюу хохирогч, хүн наймаалагч зэрэг зөвхөн хохирогчийн буюу бусад эх сурвалжийн мэдэж байгаа мэдээлэл.

#### **Нууцлаг хэрэгтэй холбоотой мэдээлэл**

ХХГХ-ийн нөхцөл, үйлдэгдсэн байдал зэрэгтэй холбоотой мэдээлэл нь жирийн мэдээлэл биш юм. Хохирогч үйл явдлын талаар дэлгэрэнгүй ярих гэж байгаа бол хохирогч хуулийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа талаарх мэдээлэл хохирогчийн хэн байхаас үл хамааран хүн наймаалагч нарт хүрэх эрсдэл гарч болзошгүй юм. Тухайлбал, хохирогч ашиглаж байсан

хуурамч баримт бичиг, гарч орсон он сар өдөр, аяллын зам, хүчирхийлэлд өртсөн байршил, он сар өдөр зэрэг мэдээллийг өгсөн бол хүн наймаалагч мэдээллийн эх сурвалжийг хүндэрэлгүй олох бололцоотой. Ихэнх хохирогчид энэ эрсдэлийн талаар мэддэг бөгөөд мэдээлэл өгөхийг зөвшөөсөн бол тэд зарим мэдээллийг бусдаас илүү дэлгэрэнгүй өгдөг. Хохирогчдоос мэдээллийг дэлгэрүүлэхийг хүссэн тохиолдолд тэд ямар мэдээллийг нээлттэй болгох, ямрыг нь ил болгохгүй байхаа хэлэх эрхтэй. Бусад хохирогчид өгсөн мэдээлэл нь ямар эрсдэл дагуулж болохыг мэдэхгүй байж болох ба туслалцаа үзүүлж байгаа байгууллага эрсдлийг үнэлэх үүднээс хохирогчидтой энэ талаар ярилцах ёстой.

## Хувийн мэдээлэл

Хохирогч хувийн мэдээллээ хууль хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулж өгөхийг хүсэхгүй нь тодорхой бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд тэдэнд ийм үйлдэл хийх талаар зөвлөхгүй байх ёстой. Хохирогчид ирээдүйд цагдаагийнхантай хамтран ажиллах хүсэлтэй байдаг учир зарим тохиолдолд хувийн мэдээллээ цагдааг өгөх нь бий. Ингэсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд хувийн мэдээллээ задруулсны улмаас гарч болох эрсдэлийн талаар хохирогчтой ярилцаж хохирогч үүсч болох нөхцөл байдлын талаар болоод хувийн мэдээлэл задарсан, эсвэл авилгалын түүний хамтын ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй байж болох талаар ойлгуулна.

## Зөвхөн хохирогч буюу ярилцагчийн мэдээлэл

Гарч болох гурав дахь эрсдэл бол тухайлбал, хохирогч буюу ярилцлага авсан хүн хүн наймаалагчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг, үүнд сорви, мэнгэ, шивээс зэрэг бие хүний талаарх мэдээлэл, эсвэл хувийн утас, банкны тооцоо зэрэг зөвхөн хохирогч буюу ярилцлага авсан хүний мэдэх мэдээллийг өгсөн бол эрсдэл гарах ба мөн хүн наймаалагч зөвхөн хохирогч, ярилцлага авсан хүн хоёр мэдэж байгаа гэдгийг мэдэх эрсдэл.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага энэ мэдээллийг цагдаагийн

байгууллагад өгч, цагдаагийн байгууллага үүн дээр үндэслэн хүн наймаалагчийн эсрэг хэрэг үүсгэсэн бол хүн наймаалагч мэдээллийн эх сурвалжийн талаар мэдээлэлтэй болдог. Хохирогч буюу ярилцлага авсан хүн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад мэдээлэл өгч, түүнийг цагдаагийн байгууллагад дамжуулсны үндсэн дээр цагдаагийн газар арга хэмжээ авдаг байна.

### Үнэлгээний бусад асуудлууд

Мэдээллийг тараахтай холбоотой үүсч гарах эрсдэлийг үнэлэхэд нөлөөлөх бусад хүчин зүйлүүдийг дурьдав. Үүнд:

- Байгаа мэдээллээс юу мэдэгдэж байгаа вэ? - тухайн хүнийг худалдсан гэмт хэрэгтнүүд хир аюултай вэ? Боломжтой байгаа мэдээллийн хүрээнд үнэлгээ хийж нөлөөлж буй хүчин зүйлүүдийг авч үзэх ба хохирогч хүчин зүйлүүдийн олонхийг дурьдсан байдаг. Тухайлбал,
  - Хүн наймаалагчдын хүчирхийллийн хэрцгийлэл
  - Тухайн сүлжээний ажилчдын тоо, үнэлгээ
  - Зэвсэгтэй эсэх
  - Урьд өмнө нь бусдаас өшөөгөө авч байсныг илэрхийлэх ул мөр
  - Ярилцлага авсан хүн зугтаж, ярилцлагынхаа тухай хэн нэгэнд ярьсан бол ярилцлага авсан хүнийг айлган заналхийлсэн эсэх
  - Энэ үнэлгээг хийхэд холбогдолтой бусад нэмэлт мэдээлэл
- Байгууллага энэ тохиолдолд ярилцлагын агуулгыг хянаж баримтуудыг нягталж дараахь асуултуудыг тавих ёстай.
  - Ярилцлага авсан хүн болоод хүн наймаалагчаас өөр хэн тухайн баримт, үйл явдлын талаар мэдэх вэ? Байгууллага зөвхөн боломжтой байгаа мэдээлэл дээр үндэслэн үнэлгээ хийнэ гэдгээ сайтар ойлгосон байх ёстай ба хүн худалдах бүлэглэлийн удирдлага цөөн хүнтэй байсан ч гэсэн энэ хэрэгт хүн наймаалагч, хохирогч, эсвэл жолооч, авилгал авсан албан тушаалтан, бичиг баримт хуурамчаар үйлдэгч зэрэг зуучлагч хүмүүс энэ хэрэгт оролцсон гэдгийг санаж байх ёстай. Тийм болохоор зөвхөн ярилцлага өгч буй хүнээс гадна олон хүн баримт, үйл явдлыг мэдэж байдаг.

- Өгч буй мэдээлэл үнэхээр ач холбогдолтой юу? Зарим мэдээлэл бусдаасаа илүү их ач холбогдолтой болох нь хурдан байдаг. Тухайлбал аялалд ашигласан хурамч бичиг баримт дээр нэр, эсвэл хүний хувийн мэдээлэл нь маш ач холбогдолтой байдаг.

Бодит эрсдэл их байдаг учир үйлчилгээ үзүүлэгч байгууллага мэдээллийг цагдаад дамжуулахаас өмнө хохирогчтой хамт байж үнэлгээ хийх ёстай. Ач холбогдол бүхий мэдээллийг хууль хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулахын өмнө байгууллага болоод хохирогч хууль хэрэгжүүлэгч байгууллагын гаргах шийдвэрт нөлөөлөх, авах арга хэмжээг хянах боломжтой байх ёстай гэдгийг санаж байх хэрэгтэй. Эцсийн үнэлгээ хийхдээ тухайн мэдээлэл буюу хүн наймаалагчийн зүгээс тулгарч болох аюул, аль эсвэл энэ хоёр хүчин зүйл хохирогч, ярилцлага авагч, гэр булийнхэнд, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болоод бусдад бодит, маш өндөр эрсдэл учруулж болно гэдгийг тооцоолж үзнэ. Хохирогч буюу ярилцлага өгөгч хууль хэрэгжүүлэгч байгууллагад мэдээллийг нээлттэй болгож болно гэсэн баталгаа өгсөн хэдий ч энэ журмыг мөрднө.

Мөн хууль хэрэгжүүлэгч байгууллагуудаас мэдээллийн эх сурвалжийн нууцлал, энэ талаар мэдээлэхгүй гэсэн баталгаа авах ёстай гэдгийг анхаарах ёстай. (Бүлэг 6.6-аас Харилцан ойлголцлын санамж бичигт оруулах ёстай нөхцлүүдийн талаар үзнэ үү)

### 6.9.7 ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай нууц мэдээллийг солилцохгүй байх нь зөв бөгөөд зөвхөн хийгдсэн гэрээний дагуу өгсөн мэдээллийг нууцлалын зэрэглэлтэй ашиглах, эх сурвалжийг нууцлах, буюу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын оролцоо болон эх сурвалж болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хоорондын гэрээнд бусдаар заагаагүй тохиолдолд дээрхийг мөрднө.

Цагдаагийн газрын ашиглах мэдээллийг нууцлалын баталгаагаагаар хязгаарлахгүй боловч цагдаагийн байгууллага болоод байгууллагын хооронд байгуулсан Харилцан ойлголцлын

санамж бичгийн нөхцлөөр ашиглана. Харилцан ойлголцлын санамж бичигт талууд мэдээллийн эх сурвалжийг нууцлана гэсэн заалт буюу эх сурвалжаас мэдээлэл авахад байгууллагын гүйцэтгэх үүргийг тодотгож өгнө.

Нууцлалын баталгааг гаргах гурван үндсэн шалтгаан:

- Хохирогчид буюу тэдний ойр дотныхон нууцлалын заалт оруулаагүй тохиолдолд мэдээлэл өгөхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага мэдээллийн эх сурвалж болон ажилтнуудынхаа өмнө хүлээж буй үүргийн дагуу дээрх баталгааг авах шаардлагатай
- Цагдаагийн байгууллага үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар дамжуулан авсан мэдээллийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх бол мэдээллийн эх сурвалж болоод үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үүрэг нь мөрдөн байцаалтын явцад хүнд асуудал болно.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар дамжуулан хохирогчийн өгсөн мэдээлэл дээр үндэслэн хүн наймаалагчдын эсрэг явуулах үйл ажиллагааг идэвхжүүлэхийн хирээр эх сурвалжийн буюу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудаас өшөө авах эрсдэл нэмэгдэж байгаа учир эхний шалтгааныг тайлбарлах шаардлагагүй юм.

### Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад учрах эрсдэл

Хоёр дахь шалтгаан мөн бодитой байж болох талтай. Гэхдээ үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудын хувьд энэ бас нэг төрлийн эрсдэл юм. Мэдээлэл хүлээн авч, ил болгоход байгууллагын ажилтнуудын гүйцэтгэсэн үүргийг олон нийтэд ил болгох нь үнээс илүү их хүндрэл учруулах ба үүний үр дүнд ажилтнууд хүн наймаалагчдын эсрэг мэдүүлэг өгөхөөр дуудагдах шаардлага гарч болох юм. Хүн наймаалагчид байгууллагын хууль ёсны статус, ажилтнууд, эсвэл тухайн байгууллага дипломат байгуулага бол байгууллагын эдлэх эрхийн талаар асуудал үүсгэж болох юм.

Хохирогчийн байгууллагад өгсөн мэдээллээс үүдэн гарах ба

байгууллага мэдээллийг цааш нь хохирогчийн зөвшөөрөлтэйгээр цагдаагийн байгууллагад дамжуулж, үүний үр дүнд гэмт хэрэгтнүүдийг баривчилж, шийтгэсэн тохиолдолд дээрх нөхцөл байдал үүснэ. Үүний дараа цагдаагийн байгууллага ажилтнуудаас мэдүүлэг авч, мэдээллийн эх сурвалжийн өгсөн анхны мэдээллийн талаарх нотолгоог авах хүсэлт тавина. Учир нь ийм төрлийн нотолгоо хэргийг шалгах явцад маш ач холбогдолтой байдаг. Цагдаагийн газрын хүсэлт ажилтнуудын аюулгүй байдлыг эрсдэлд оруулах ба үүнтэй холбогдон нарийвчилсан үнэлгээ, зөвлөгөө шаардлагатай болох эрхийн асуудал гарч ирнэ. Ийм тохиолдолд байгууллагууд ямарваа нэгэн шийдвэр гаргахаасаа өмнө хуулийн төлөөлөгчтэй уулзаж зөвлөгөө авах ёстай.

### Шүүх хурлын явцад гарах эрсдэл

Шүүн таслах хурлын явцад мэдээллийг ил болгосноор эрсдэл үүсдэг. Үүний үр дүнд өмгөөлөгч анхдагч эх сурвалж болон мэдээллийг бүрэн эхээр нь ил болгох хүсэлтийг анхны шатны шүүхэд тавьдаг байна. Энэ нь илүү их аюул учруулах магадлалтай төдийгүй их илүү мэдээлэлтэй болохын хирээр цагдаагийнхан мөрдөн байцаалтаа өргөтгөх боломжтой болж эрсдэл нэмэгддэг.

Үнэн мөнийг гүйвуулах гэсэн зорилгоор хохирогч тодорхойгүй, мэдээллийн эх сурвалжийг ил тод болгох ёстой гэсэн гомдол гардаг ба мэдээллийн эх сурвалжийг ил тод болгож гомдлыг үндэслэлтэй буюу үндэслэлгүй гэж баталснаар хохирогчид холбогдолтой хэргийг шударгаар шүүх боломжтой болдог. Өмгөөлөгч ямар ч арга хэрэглэсэн гэсэн өмгөөлөгч анхан шатны шүүгчийг эх сурвалжийг ил тод болгохын төлөө ажилладаг. Ингэснээр цагдаагийн байгууллага мөрдөн байцаалтаа баталгаажуулж, анхан шатны шүүх хурлыг явулахаас өөр аргагүйд хүрдэг байна. Үүний үр дунд байгууллага болоод эх сурвалж эрсдэлд орохын зэрэгцээ хохирогчийн нэрийг олон нийтэд мэдээлдэг. Тухайн улс орны хуулиас хамаарч аль аль талыг шалгах буюу талуудад хуулийн дагуу арга хэмжээ авч болох юм.

Цагдаагийн болоод шүүх байгууллагууд байгууллагатай урьдчилан ярилцлагүйгээр буюу Харилцан ойлголцлын

санамж бичгийн нөхцлийн дагуу мэдээллийн эх сурвалж болон байгууллагын гүйцэтгэсэн үүргийг ил гаргах эрхгүй бөгөөд гаргахгүй гэдгийг баталгаажуулах нь чухал юм. Цагдаагийн байгууллага энэ асуудлаар байгууллагад хандвал байгууллага мэдээллийн эх сурвалжтай ярилцах ёстой. Учир нь мэдээллийг ил болгосноор байгууллага болон эх сурвалж аль аль нь эрсдэлд орж байгаа юм. Цагдаагийн газар Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцлийн дагуу үйл ажиллагаа явуулж, байгууллагатай урьдчилан ярилцсан хэдий ч шүүх хурлын үеэр мэдээллийн эх сурвалжийг ил болгохыг шаардаж болохыг анхаарах хэрэгтэй.

Байгууллага эрүүгийн эрхзүйн системийн үйл ажиллагаанд ямарваа нэгэн онцын шаардлагагүйгээр оролцохыг хүсдэггүй ч эх сурвалж, түүний гэр бүлийнхэн болоод ойр дотны бусад хүмүүс, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудын талаарх мэдээллийг ил тод болгосноор үүсэх эрсдэлийг үнэлэх ёстой болдог. Анхан шатны шүүх хурлаас яллагдаж буй хүн наймаалагчид өшөө авах боломжтой буюу авч магадгүй гэж үзвэл аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах ба мэдээллийг ил гаргахгүй байх зөвшөөрлийг авна. Тухайн байгууллага өөрийн түнш төрийн байгууллага хоёрын харилцаанд бэрхшээл гарсан ч дээрх арга хэмжээг авна. Татгалзахыг хуулинд зөвшөөрдөггүй боловч үйлчилгээ үзүүлэгч байгууллага туслалцаа авч буй хүмүүс буюу бусад хоёрдагч эх сурвалжаас авсан мэдээллийг ил болгохыг зөвшөөрөхөөс урьд үүнийг анхаарч үзэх ёстой.

### 6.9.8 ХЯНАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Мэдээлэл солилцохтой холбогдсон зохицуулалтыг тогтмол хянаж, шалгаж байх ёстой. Хамгийн чухал нь энэ бүхэн нь Харилцан ойлголцлын санамж бичгийн нөхцлийн дагуу хийгдэх ёстой ба мэдээлэл солилцоо хоёр урсгалтай байх, мөн хохирогчтой холбоотой мэдээллийг байгууллагаас гаргах ёстой гэдгийг анхаарах ёстой.

Мөн мэдээлэл солилцохтой холбоотой үйл явдлын талаар байгууллага холбогдох бодитой мэдээлэл авч байгаа эсэхийг хянах ёстой. Цагдаагийн байгууллага эргээд холбоо барихгүй байх нь байж болшгүй зүйл боловч аюулгүй байдал, нууцлалын

ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ШУУД ТУСЛАМЖИЙН ГАРЫН АВЛАГА

талаар санаа зовж буй мэдээллийн эх сурвалжид энэ нь сөргөөр нөлөөлдөг. Учир нь мэдээллийн эх сурвалж хамтран ажилласныхаа үр дүнт үзэж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдэх эрхтэй юм.

Гэрээний үндсэн заалтуудыг зөрчсөн нь тогтоогдвол байгууллага хууль хэрэгжүүлэгч байгууллагад энэ тухай нэн даруй мэдэгдэх ёстой.

# Хавсралт

## Хавсралт I

### ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх болон ярилцлага хийхэд баримтлах ёс зүйн зарчмууд<sup>1</sup>

#### Үүрэг ба ур чадвар

Туслалцаа үзүүлж буй ажилтнууд ХХГХ-ийн хохирогчидтой ажиллахдаа дор дурьдсан үүргийг мэргэжлийн үүднээс хүлээнэ. Шинэ буюу мэргшээгүй ажилтнуудын хувьд дор дурьдсан мөрдөх ёстой зарчмуудыг суралцахад цаг хугацаа болон хүчин зутгэл хэрэгтэй. Эдгээр үүргийг гүйцэтгэх ур чадвартай болохын тулд эмзэг нөхцөл байдалд орсон иргэдтэй харилцах, тэднийг сонсох, тэдэнд туслах чин сэтгэлтэй байхын зэрэгцээ энэ бүхэнд суралцах хэрэгтэй.

Үндсэн үүргээс гадна үүргээ мэргэжлийн үүднээс чин сэтгэлээсээ хандах нь тухайн бие хүний өөртөө итгэх итгэлийг өгөхөд нэн чухал юм. Туслалцаа үзүүлэх ажилтнуудтай уулзах нь мөн нөхөн сэргээх эмчилгээний нэг хэсэг юм. Уулзалт зэрэг уур амьсгалтай болж өнгөрвөл бие хүн бусдад итгэх итгэл, өөртөө итгэх итгэл нь эргэн сэргэж, ирээдүйгээ харах үзэл бодол нь өөдрөг болдог. Эсрэг тохиолдолд бие хүн нэр хүндээ алдахаас айж, доромжуулж буй мэт сэтгэгдэл төрөхөөс гадна, ямар ч итгэлгүй болдог байна. Бүдүүлэг буюу хүндэтгэлгүй байдлаар харьцвал энэ нь эргээд ярилцлага авч буй хүний зорилго болоод ХХГХ-ийн хохирогчийн хувьд ямар ч үр дүнгүй болно.

Ямар ч тохиолдолд эдгээр зарчмуудыг үүссэн нөхцөл байдалд тохируулан мөрдөх ба дарамт шахалт, хүндрэл бэрхшээл, болоод тухайн бие хүний хувьд үүсээд буй нөхцөл байдалд тохируулан хандах ёстой. Эдгээр зарчмууд нь ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх ёс зүйн эмчилгээний заавар болдог ба ёс зүй болоод ёс суртахууны зөв аргыг ашигласнаар үүсээд буй нөхцөлд бие хүний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэнэ. Үндсэн зарчмууд нь:

1. Хохирол бүү учруул
2. Аюулгүй, тав тухтай байдлыг баталгаажуулах
3. Бусдын оролцоогүй байхгүй гэдгийг баталгаажуулах
4. Нууцлалыг баталгаажуулах

5. Мэдээлэл өгөх
6. Зөвшөөрөл авах
7. Тохиромжтой үед асуултаа ухаалгаар тавих
8. Ярилцаж буй хүнээ сайн сонсох
9. Ярилцлагын үеэр буюу эмчилгээний үеэр түр завсарлах шаардлагатай байгаа эсэхийг ажигла
10. Өөр үзэл бодолтой бол түүнийгээ нуух, дотроо бодох
11. Итгэ, битгий шүүж дүгнэ
12. Ярилцагч хүнээ хүндэтгэж, тэвчээртэй байж мэргэжлийн байдлаа харуулах
13. ХХГХ-ийн хохирогч өөрийгөө бие махбодийн болоод сэтгэл зүйн хувьд бүрэн хянаж байгаа эсэхийг баталгаажуул
14. ХХГХ-ийн хохирогчдод тэднийг буруутгах гээгүй гэдгийг сайтар ойлгуулах
15. ХХГХ-ийн хохирогчдод шүүх эмнэлгийн үзлэг болоод дүгнэлт гаргуулах эрхтэй гэдгийг хэлж ойлгуулах
16. ХХГХ-ийн хохирогчдод эрүүл мэндийн болоод эмнэлгийн үзлэг авах эрхтэй болохыг хэлж ойлгуулах
17. ХХГХ-ийн хохирогчдод тэдний давуу талыг сануулах
18. Орчуулагч өгөх

**18-аас доош насны хүүхдүүд болоод онцгой туслалцаа шаардлагатай (сэтгэцийн өвчтэй, сэтгэл зүйн хувьд онцгой шаналж буй гэх мэт) бие хүмүүст дээрх зарчмуудыг болон шаардлагатай бусад үйлчилгээг үзүүлнэ. (тухайлбал, асран хамгаалагчгүй томилж өгсөн асран хамгаалагч буюу хуулийн зөвлөхтэй ажиллаж байгаа)**

**ХХГХ-ийн хохирогч гэж бичсэн тохиолдолд заримдаа ХХГХ-ийн хохирогч нь асран хамгаалагчгүй насанд хүрээгүй хүүхэд эсвэл хуулийн дагуу асран хамгаалагч шаардлагатай насанд хүрэгчийг хэлэх ба үүнийг “хохирогч буюу түүний асран хамгаалагч” гэж ойлгоно.**

## 1. ХОХИРОЛ БҮҮ УЧРУУЛ

ХХГХ-тэй холбоотой онцгой эрсдэлд учирсан хохирогчдын ихэнх нь зовж шаналж байдгийн дээр тэдэнд учирсан хор хохирол нэмэгдэж байдаг учир энэхүү үндсэн зарчмын ач холбогдлыг хэтрүүлж байна гэж ойлгож болохгүй. Бие хүний байдлыг өмнөхөөс хүндрүүлж болзошгүй гэж үзвэл

хийх ярилцлагыг буюу хийгдэх эмнэлгийн үзлэг, эмчилгээг тухайн үед хийх ёсгүй. Хохирогчидтай ажиллаж байгаа хүмүүсийн авах гэж буй арга хэмжээ, үйлдлээс үүдэн гарч болзошгүй хор хохирлыг нарийвчлан үнэлэх нь ажилтнуудын ёс суртахууны үүрэг юм. Эсрэг нотолгоо гарахгүй бол гарч болох хор хохирол ач холбогдолтой гэж үзэж бие хүн бүрт туслалцаа үзүүлж, нөхцөл байдлыг үнэлэх хэрэгтэй.

## 2. АЮУЛГҮЙ, ТАВ ТУХТАЙ БАЙДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ:

Хохирогчтой ярилцахын өмнө хохирогч аюулгүй, тав тухтай байдалд байгаа эсэхийг нь баталгаажуулах нь чухал юм. Тухайн хүний бие муу байвал ярилцлага хийх шаардлагагүй. Бие хүний аюулгүй байдалтай холбоотой эрсдэлд өөр зорилгоор урьд өмнө нь үнэлгээ хийж байсан ч гэсэн туслалцаа үзүүлж буй ажилтан ярилцлага өгөх гэж буй хүнээс аюулгүй байдалд байгаа эсэх, аюулгүй байдлыг нь хангах үүднээс өөр ямар арга хэмжээ авах эсэх талаар асуух ёстой.

Үүний зэрэгцээ хохирогчдоос эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай эсэхийг заавал лавлаж асуух ёстой. (гэхдээ “та зүгээр үү?” гэж асуухгүй). Ямар нэг өвчтэй, шаналгаатай, тав тухгүй эсвэл эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай бол ярилцлага хийх, ямарваа нэгэн эмчилгээ хийх ёсгүй. Ажилтнууд авах гэж буй арга хэмжээнд (мэдээлэл цуглуулах, тусламж үзүүлэх) анхаарлаа хэт хандуулж хохирогчид эрүүл мэндтэй холбоотой асуудал үүсгэдэг сэргээл зүйн болоод бие махбодийн хувьд хохирол амссан гэдгийг мартах тохиолдол гардаг. Бие хүн дарамтанд (ярилцлага хийх буюу үйлчилгээ авах гэж байгаа бол) байгаа бол бие махбодийн болоод сэргээл зүйн шаналал нь илүү тодоор илэрдэг. Туслалцаа үзүүлж байгаа хүмүүс дараахь асуултуудыг заавал асууна.

- Таны биеийн байдал ямар байна?
- Ямар нэг шаналал байна уу, бие тань таагүй байна уу, эсвэл эмч, сувилагч дуудах уу? [Эмчлэгч эмчийн хувьд: “Ярилцлагаа эхлэхийн өмнө бие тань эвгүйрхэж байвал надад хэлээрэй”]
- Ярилцлага [эмчилгээ, арга хэмжээ] хийх нь танд ямар нэг хүндрэл бэрхшээл учруулахгүй биз?

Эрүүл мэндтэй холбоотой хүндрэл гарахгүй байх нь мөн чухал юм. Тухайлбал, хохирогчдын олонхийн толгой байнга өвддөг бөгөөд ярилцлага хийх үед ямарваа нэгэн шаналалгүй байлгах үүднээс эмчтэй зөвлөж тайвшируулах, өвчин дарах зэрэг шаардлагатай эм өгч болно.

Хэрвээ хохирогч яараптай болон эрүүл мэндтэй холбоотой ямарваа нэгэн гомдол хэлсэн бол эн түрүүнд тухайн хүний тав тухтай байдлыг анхаарах нь чухал юм. Тухайлбал, цай, ус өгөх, ариун цэврийн өрөө ашиглаж болно, эсвэл тухтай сандал тавьж өгөх эсвэл ярилцлага хийх нөхцлийг бүрдүүлэх өөр зохицуулалтыг хийж болно. Ярилцлага эхлэхийн өмнө суудлаа тодорхойлох нь маш чухал бөгөөд ярилцлага хийж буй хүн зогсохгүй, эсвэл ширээний ард суух ёсгүй. (энэ нь захиргаадалтын байдал болоод хоорондоо хэт их зйтай байгааг илтгэнэ) Суухдаа аль болох нэгн нэгнийхээ сонсох боломжтой байрлалаар суудлаа засна (хохирогч өөрийн тухай мэдээллээ чанга ярихгүй байх нөхцөл). Эрүүл мэнд, сайн сайхан болоод тохъ тухтай холбоотой асуудлууд нь тухайн хүний ажилтнуудтай харьцаж байгаа байдал, хариу үйлдэлд нөлөөлдөг.

---

**Анхааруулга:** Хохирогч өөрөө ярилцлага өгөх, хөтөлбөрийн арга хэмжээнд оролцох боломжтой гэж хэлсэн хэдий ч туслалцаа үзүүлж буй хүн тухайн хүнийг бэлэн биш байна гэж тодорхойлж болох юм. (тухайлбал, сэтгэцийн эрүүл мэнд, хэт их айдаст автсан, гутралд орсон гэх мэт). Ийм тохиолдолд туслалцаа үзүүлж буй хүмүүс нарийн үзлэг хийж тухайн хүний эрүүл мэндийн талаар сайн мэдэж байгаа анаагаа ухааны мэргэжилтнүүдтэй нэн яараптай зөвлөлдөх ёстой.

---

### 3. БУСДЫН ОРОЛЦОО БАЙХГҮЙ ГЭДГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Хохирогчидтой хийж буй бүх ярилцлага, эмчилгээг аюулгүй, хувь хүнд хандсан байдлаар хийх ёстой. Байгууллага жижиг болоод хэт их ачаалалтай ажилладаг, эсвэл хохирогчидтой ярилцлага хийхдээ гадаа хийж байгаа бол ганцаарчилсан, тусгаар байдлыг хангах ёстой. Ганцаарчилсан, тусгаар байдлыг хангах боломжгүй бол ярилцлагыг (эмчилгээ буюу арга хэмжээ) шаардлагатай нөхцлийг хангах хүртэл хийхгүй байх ёстой. Уулзалт хийхдээ замын буюу зүгээр ороод гарах газарт, эсвэл хохирогчдын анхаарлыг сарниулах, ярилцлага, уулзалтад саад болох газар явуулах ёсгүй. Анхны мэдээллийг авах буюу ярилцлага хийхдээ хонгил, хүлээн авах буюу олон хүн ажилладаг газар явуулахгүй байх ёстой.

---

**“Саад болохгүй байхыг хүсье”** (бусад ижил төстэй агуулга бүхий) гэсэн тэмдгийг ярилцлага, эмчилгээ буюу зөвлөгөө өгч байгаа газруудад гадны хүн орж, садаа болохоос сэргийлэн хаалганд өлгөнө. Үүнтэй адилаар хохирогчтой ярилцаж байх үед гар утсаа

унттраана. Учир нь ярилцлага хийж байх үед дээрх байдлаар саад болох нь соёлгүй бөгөөд хүний ярианд саад болох буюу хохирогч яриагаа таслах, ойлгохоо болих, эсвэл утсаар юу ярьсан талаар мэдэхийг хүсч санаа бодол нь сарних магадлалтай.

---

#### 4. НУУЦЛАЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ

Нууцлалыг хангах нь хохирогчидтой ажиллаж буй ажилтнууд болоод байгууллагуудын үндсэн үүргүүдийн нэг юм. Нууцлалыг хангах нь зөвхөн хохирогчийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой бус мөн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын зорилго, ажилтнуудын аюулгүй байдал, хохирогчийн үнэ бодит мэдээлэл өгөх хүсэлтэй шууд холбоотой. Нууцлалтай холбоотой үйл ажиллагааг онцгой анхаарах ба түүнтэй холбоотой журмыг хатуу мөрдөнө. Нууцлалыг хангах гэдэг нь хохирогчийн тухай болоод түүний өгсөн бүх мэдээллийг нууцална гэсэн үг. Мөн тухайн хүнд нууцлалыг хангах үүднээс шаардлагатай арга хэмжээ авсан тухай хэлнэ.

Нууцлалыг хангахын тулд бичгээр, амаар, электроноор, утсаар, видеогоор, фото зургаар буюу мэдээллийн бусад хэлбэрээр хохирогчийн талаарх бүх мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. (Энэ гарын авлагын бүлэг 1, 1.2 болон 1.5.5 хэсгийг үзнэ үү)

ХХГХ-ийн золиос болсон ихэнх хохирогчид эмч, төрийн албан хаагчид, хууль хэрэгжүүлэгчид болон бусад албан тушаалтнууд нууцлалын журмыг мөрддөггүй улс орнуудын иргэд байдаг. Хохирогчдын ярьсан бүхнийг тэдэнд хохирол учруулж болох, мэдээллийг үгүйсгэх эсвэл мэдээллийг ашиглан хохирогчдыг айлган сүрдүүлэх, мэдээллийг хууль бусар ашиглах хүмүүст өгөхгүй гэдгийг сайтар ойлгуулах ёстой.

---

**Хохирогчдын тухай мэдээллийг энгийн мэдээлэл шиг ашиглаж болохгүй. Мэдээллийг зөвхөн энэ хэрэгт холбогдолтой хүмүүсийн хооронд “мэдэх шаардлагатай” гэсэн хүмүүст хүргэнэ. Мэдээллийг бусадтай хуваалцаж, нэн ялангуяа мэдээллийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагын сүлжээнээс гадуур эрүүл мэндийн бусад байгууллагын ажилтнууд, туслапцаа үзүүлж буй бусад ТББ болон төр засгийнхан зэрэг гуравдагч талтай хуваалцаж байгаа бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Сайн санааны үүднээс**

хуваалцаж байгаа гэсэн ч мэдээллийг бусдад хүргэж байгаа арга замыг зөв зохион байгуулаагүй тохиолдолд мэдээлэл очих ёсгүй хүмүүст хүрч болох талтай. Энэ нь бие хүний үйлчилгээ, тусламж авах эрхийг зөрчиж байгаа хэрэг бөгөөд мөн хамтрагч байгууллага хохирогчийн талаарх эрүүл мэндийн онош зэрэг бусад мэдээллийг цагдаа, цагаачлалын алба эсвэл хүн наймаалагчдыг шүүх ажиллагаанд оролцож байгаа хуульчдад хохирогчийн зөвшөөрөлгүй очих ёсгүй.

---

Бодит хохирогчийн талаарх мэдээллийг бүрэн нууцалж, өөрчлөсний дараа олон нийтэд мэдээлэл хүргэх ёстой гэсэн журам мөн нууцлалд багтдаг.

ХХГХ-ийг үйлдсэн гэмт этгээдүүдийн талаар бичих гэсэн сэтгүүлчид болон бусад хүмүүс хохирогчтой ярилцах хүсэлт гаргасан бол шийдвэр гаргахад хэцүү байдаг. Хохирогчоос гадны хүнтэй ярилцах хүсэлтэй байгаа эсэхийг асуухдаа эн түрүүнд хүсэлтийг биелүүлэх шаардлагатай эсэх, хүсэлт гаргасан хүн итгэх хүн эсэх, ярилцлага хохирогчид ямар нөлөө үзүүлэх эсэхийг анхаарч үзэх ёстой. Хохирогчид хүсэлтийг уламжлах эсэхээ шийдвэрлэхдээ хохирогчийн эрх ашиг, эрүүл мэндийг онцгой харгалзан үзнэ.

## 5. МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

Хохирогчийн эдлэх эрхийн нэг үндсэн эрх бол мэдээлэл авах эрх юм. Өөрийн эрүүл мэнд, сайн сайхан, ирээдүйн төлөө хатуу шийдвэр гаргадаг, мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаар бодит хүлээлттэй байгаа хүмүүсийн хувьд хийж болох сонголтын тухай боломжит бүх мэдээллийг өгнө. Хохирогч хүнд сонголт хийх эрхийг нь өгөх арга замын талаар мөн мэдээлэл өгнө. Тухайлбал, авч болох тусламжийн талаар, үзүүлж болох туслалцааны хязгаарлалт, гарч болох эрсдэл болон эдлэх давуу талын талаарх мэдээллийг мөн ямарваа нэгэн арга хэмжээ авах, эмчилгээ хийхээс өмнө өгөх буюу хохирогчийн асуултанд хариулна. Энэхүү зарчмыг мөрдөсөнөөр тодорхой бус байгаа зүйлсийг амлахгүй байх нөхцлийг бүрдүүлэх юм. Мөн өгч буй мэдээлэл нь гарч болох үр дагаврын талаарх цогц мэдээллийн нэг хэсэг нь болно.

## Үйлчилгээ үзүүлэх талаар

Үйлчилгээ авах гэж буй хохирогчид үйлчилгээний талаарх цэгтэй, ойлгомжтой мэдээллийг өөртөө тохирсон байдлаар (боломжтой бол бичгээр) буюу албан ёсны бус, шаардсан эсвэл захирсан бус хэлбэрээр авах ёстой. Үйлчилгээний талаарх өрөнхий мэдээллийг өгөхдөө дараах мэдээллийг заавал өгнө. Үүнд:

- Оршил (туслалцаа үзүүлэх хүний нэр, албан тушаалаа, тухайн байгууллагатай ямар харилцаатай гэх мэт)
- Эмчилгээ, хөтөлбөрийн явагдах байр, цагийн хуваарь, үргэлжлэх хугацаа, байршил, ажиллах хүн хүч зэрэг нарийвчилсан мэдээлэл
- Үзүүлж болох үйлчилгээ, ашиглаж болох байр, өрөө, мөн байгууллагын буюу хамтран ажиллах байгууллагын хохирогчийн өмнө хүлээх үүрэг
- Байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, тусламж, туслалцааны хязгаарлалт
- Хохирогчид санал болгосон үйлчилгээ буюу хоргodoх байртай холбоотой үүсэн гарах хязгаарлалт, тогтоосон журам (байрны журам, шилжих хөдөлгөөнийг хязгаарлах, ёс зүй гэх мэт). Мөн хохирогчийн хүлээх үүрэг
- Хохирогчийн бусдын өмнө хүлээх үүрэг, хязгаарлалт (тухайлбал, цагдаа, элчин сайдын яам, цагаачлалын алба гэх мэт). Мөн хохирогчийн хүлээх үүрэг
- Байгууллагаас аюулгүй байдал, нууцлалтай холбоотой авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Хохирогчийн хийх сонголт, ө.х. хөтөлбөр, эмчилгээ буюу бусад арга хэмжээнд оролцох эсэх.

Бие хүний мэдээлэл авах эрхэд мөн өөрсдийн талаарх мэдээллийг тогтмол, нууцлалыг хадгалан авах эрх багтдаг. Нэн ялангуяа эрүүл мэндийн шинжилгээний хариу. Чухамдаа сэтгэлийн дарамтанд байгаа бие хүн өөрийн эрүүл мэндийн талаар анхаардаггүй гэдгийг санах ёстой. Хохирогчийн биеийн байдлын оношлогооны (хүсэлтээрээ буюу шаардлагаар өгсөн) үр дүн ээрэг, сөрөг байсан ч гэсэн гадны хүн бус (үүнд оношлогоо хийгдсэн лаборатори, хохирогчийг сайн мэддэггүй эмнэлгийн ажилтнууд), зөвхөн эрүүл мэндийг хариуцаж байгаа эмч, туслалцаа үзүүлж буй хүн энэ үр дүнг мэдэж байх ёстой гэдгийг санах ёстой.

---

## Оношлогооны болон эмчилгээний үр дүнг мэдээлэх:

**Оношлогооны буюу эмчилгааний үр дүнг өгөхдөө дараахь ерөнхий зүйлсийг мөрдөнө.**

- **Хохирогчид ямар оношлогоо, эмчилгээ хийгдсэн болон хийх болсон шалтгааны талаар мэдээлэх**
  - **Ярилцах үедээ гарсан үр дүнг шууд хэлэх. Учир нь яриаг үргэлжлүүлэх нь хохирогчийг сэтгэлийн дарамтанд оруулдаг. Үр дүн сэтгэл зүйд нөлөөлөхөөр байвал (тухайлбал, бие хүний тухайн үеийн эрүүл мэнд, ирээдүйн байдалд гэх мэт) түүнийг тайлбарлах, мөн Бүлэг 5-д заасан ХДХВ/ДОХ-ын талаарх зөвлөгөөг дагах, бие хүний сэтгэл зүй, бие махбодид нөлөөлөхөөр байвал оношлогооны өмнө нөхцөл байдлыг ойлгуулж, оношлогооны үр дүн гарсны дараа зөвлөгөө өгөх**
  - **Хийгдэх эмчилгээ, уух эм буюу авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярьж өгөх**
  - **Тухайн хүн асуулт асуух боломжийг бүрдүүлэх**
  - **Дахин оношлогоо хийлгэж болох эрхийг сануулах**
  - **Оношлогооны үр дүнг шалгах эрхтэйг сануулах.**
- 

## 6. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ

Хохирогчийн үндсэн эрхийн нэг нь мэдээлэл авах, тухайн мэдээллийг хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх эрх бөгөөд үйлчилгээ үзүүлэх явцад мэргэжлийн туслалцаа авах боломжийг олгох харилцаа тогтоох юм. Бүх үйлчилгээг авахдаа түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд тухайлбал,

- Эмнэлгийн оношлогоо болон эмчилгээ, үүнд бүх төрлийн эмчилгээ, оношлогоо (сэтгэл зүйн, цусны, рентген болон өвчтнөөс эд, эсийн шинжилгээ авах)
- Эрүүл мэндийн тухайн дүгнэлт
- Сайн дурын үндсэн дээр
- Судалгааны ажил, тухайн хүний тухай мэдээллийг ажилтнууд буюу хамтрагч байгууллагуудтай хуваалцах (хохирогч дахиад оношлогоо хийлгэх, дүгнэлт гаргуулах, эмчилгээ хийлгэх гэх мэт тохиолдолд)
- Нийгэмд дахин байр сууриа эзлэхэд нь туслах.

Бүрэн мэдээлэл авч, хүлээн зөвшөөрөхийн тулд олон саад бэрхшээлийг давж туулах ёстой ба үүнд хэл, соёл, нийгмийн ялгаа, хохирогчийн айdas буюу эрх мэдэл бүхий хүмүүсийг хэт хундлэх, гомдол гаргах нь маш хүндрэлтэй гэсэн ойлголт, бусдад таалагдах гэсэн хүсэл эрмэлзэл, ойлгохгүй байгаагаа харуулахыг үл хүсэх, эсвэл тодруулга хийсэн асуулт асуух, тав тухгүй, дарамт үзүүлж буй уулзалтыг хурдан дуусгах гэх мэт хүндрэл үүсдэг.

Мөн бие хүний нас, бие махбодийн болоод сэтгэл зүйн байдал, бие махбодид болоод сэтгэл санаанд учирсан хохирлын хэмжээ, бодит болон гарч болзошгүй аюулыг анхаарч үзнэ. Бие хүн мэдээлэл авч, хүлээн зөвшөөрөх ерөнхий журмыг даган мөрдөх эсэхийг тогтоох үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.

---

### Зөвшөөрөл авахын тулд өгөх мэдээлэл

Мэдээлэл авч хүлээн зөвшөөрүүлэхийн тулд өгч байгаа мэдээлэл болон өгч буй арга зам нь онцгой ач холбогдолтой.

### Зөвшөөрөл хүсэхийн өмнө өгөх мэдээлэл

Төрөл бүрийн эмчилгээ хийх, арга хэмжээ (эмч ярилцах, оношлогоо, эмчилгээ, зөвлөгөө өгөх зэрэг) авахын өмнө зөвшөөрөл авах үүднээс өгөх мэдээлэл ялгаатай байх боловч үндсэндээ дараах зүйлсээс бүрдэнэ.

- Оршил, нэр, албан тушаал, үзүүлэх үйлчилгээ талаар (энэ мэдээллийг өгөөгүй бол)
- Зөвшөөрөл хүсч байгаа зорилгоо (тухайлбал, ярилцлага, оношлогоо, эмчилгээ) дэлгэрэнгүй тайлбарлах, үүнд мөн арга хэмжээг шат бүрээр, явагдах хугацаа
- Ярилцлага, үйлчилгээ, эмчилгээний хийх шалтгаан, үр дүн (урт болон богино хугацааны)
- Ярилцлага, үйлчилгээ, эмчилгээтэй холбогдон үүсч гарах эрсдэл, аюул (урт болон богино хугацааны)
- Эмзэг сэдэв, оношлогоо, эмчилгээний үеэр хөндөх ёсгүй сэдвийг анхаарах
- Оношлогоо, эмчилгээний үр дүн хэзээ гарах
- Бие хүнтэй холбоотой өвчний түүх, хувийн баримт бичиг гэх

### мэт хувийн зүйлсийн талаарх эрхийг ойлгуулах

- **Бие хүний эрүүл мэндийн түүхийг нууцлана, тухайн хүн өөрөө хэзээ ч авч болно, үйлчилгээ үзүүлэх, судалгаа хийж гэж байгаа байгууллага буюу өөр хүн, хууль хэрэгжүүлэгч байгууллага түүнийг ашиглаж болох эсэхийг өөрөө шийднэ гэдгийг байнга сануулах.**
- 

Буруу зөв гэсэн хариулт, тохиромжтой, тохиромжгүй гэсэн зүйл байхгүй гэдгийг тухайн хүнд сануулж, ойлгуулах ёстой бөгөөд тавигдаж буй асуултууд нь хүн болгоноос асуудаг ерөнхий асуултууд гэдгийг ойлгуулах нь давуу талтай. Эмзэг нөхцөл байдалд ороод байгаа хүмүүс өөрсдийнх нь хувь заяа асуулт, хүсэлт бүрээс хамаарна гэсэн ойлголттой байдаг бөгөөд үүнийг байнга засч залруулж байх нь зөв үйлдэл болно. Хохирогчид “буруу” хариулт өгсөн, хяналтанд нь байсан хүнээ уурлуулсан нь тэдэнд хохирол амсуулсан гэж бодож байдаг учир тэдэнд дээрх бүхнийг давтан сануулж байх нь хэрэгтэй юм.

Зөвшөөрөл авах нь үйл явц боловч тийм үгүй гэсэн асуултын хариулт биш. Энэ үйл явцын үе шатууд нь:

343

- **Мэргэжлийн, энгийн байдлаар, хүнд хандсан өнгөөр ярих:** зөвшөөрөл авахын тулд дарамт үзүүлэх, эсвэл түүнд шаардлагатай гэсэн байдлаар харьцах болохгүй. Зөвшөөрөл авах зорилгоор өгч буй мэдээлэл, хүсэлтийг энгийн байдлаар ойлгуулах. Ингэснээр тухайн хүнд сонголтоо чөлөөтэй хийх боломжийг олгоно. Ямар ч сонголт хийсэн гэсэн хохирогчийн эсрэг ямарваа нэгэн үйлдэл хийж болохгүй.
- **Энгийн үг хэллэг хэрэглэх:** хохирогчид ойлгомжтой энгийн үг хэллэгээр хохирогчийн эрүүл мэндэд нэн чухал оношлогоо, эмчилгээг тайлбарлах. Ингэснээр хохирогч эрүүл мэндээ хянах боломжтой болно.
- **Дэмжих, урам өгөх асуултууд:** зөвшөөрөл авахын өмнө ажилтнууд мэдээлэл өгөх явцад хохирогч яриаг тасалдуулсан ч гэсэн ойлгоогүй зүйлээ асуух, тодруулах асуулт асууж болно гэдгийг ойлгуулах ёстой. Ажилтнууд зөвшөөрөл авахтай холбоотой мэдээлэл өгсний дараа хохирогчоос өгсөн мэдээллийн талаар асууж лавлах зүйл байгаа эсэхийг дахин асууж лавлана.
- **Тодруулах болон тодотгох:** Зөвшөөрөл авах явцад ажилтнууд хохирогч өгсөн мэдээллийг ойлгосон эсэхийг хохирогчийн үйл

хөдлөлөөс ажиглаж мэдэх ёстой. Ажилтнууд тэвчээртэй байж өгсөн мэдээллээ дахин давтах, тодотгох, мэдээллийг өөр үгээр тайлбарлахад бэлэн байна. Нэхцэлт байдлыг тооцон үзэж, нэн ялангуяа хэл, соёл, нийгмийн бэрхшээл хүндрэл гарч байвал хохирогчид мэдээллийн заримыг орхигдуулах, ойлгохгүй байх явдал гардаг.

- **Ойлгосон эсэхийг баталгаажуулах:** хохирогч өгсөн мэдээллийг сайн ойлгосон эсэхийг баталгаажуулахын тулд ерөнхий болоод чиглэсэн асуултуудыг асуух шаардлагатай. (Миний хэлсэн бүхнээс танд ойлгомжгүй зүйл байна уу? Давтаж ярих уу? гэх мэт) Тэдний ойлгоогүй, ойлгоход хэцүү зүйлс байгаа эсэхийг чиглэсэн асуултаар тодруулна.
- **Хохирогчийн тавьсан хүсэлтийг татгалзсан, эсвэл тэдэнд санал болгосон зүйлс сөрөг үр дагаваргүй гэдгийг хэлж ойлгуулах, баталгаажуулах:** хохирогчид сөрөг үр дагаврын талаар мэддэг. Ажилтнууд хохирогчдын хийсэн сонголтыг хүлээн авахад бэлэн байж, хохирогч зөвшөөрөл өгөхөөс татгалзах, хийсэн сонголтынх нь төлөө ямарваа нэгэн шийтгэл хүлээхгүй гэдгийг хохирогчид ойлгуулах нь чухал юм.
- **Зөвшөөрлийн хэлбэрүүдийг ашиглах:** хэл, нийгэм-соёл, хамтын ажиллагаа болоод хууль эрхзүйн бодит байдалд тохируулан уян хатан хэлбэрүүдийг ашиглах нь чухал.

### Зөвшөөрлийг баталгаажуулах

Зөвшөөрөл өгч байгаа баримтыг уншихын өмнө хүмүүсээс дараах зүйлсийг хянаж үзэхийг хүсдэг.

- Зөвшөөрөл өгч байгаа арга хэмжээ (ярилцлага, ярилцах үндсэн сэдвүүд, эмчилгээ болоод бусад арга хэмжээ, арга хэмжээ бүрийг нэг нэгээр нь жагсааж бичих ба тус бүрт нь зөвшөөрөл авна)
- Нууцлалыг хангах арга хэмжээ
- Ярилцаж тохирсон эрдэл, давуу тал
- Буруу, зөв гэсэн хариулт байхгүй, зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд үзүүлэх үйлчилгээ, эмчилгээнд энэ нь сөргөөр нөлөөлөхгүй.

### Зөвшөөрлийг баримтжуулах

Зөвшөөрлийг хохирогчийн гарын үсгээр баталгаажуулах ёстой. Гэхдээ заавал ингэж авах шаардлагагүй. Бичиг үсэг мэддэггүй хүмүүсийн хувьд

буюу албан бичигт гарын үсэг зурах нь онцгой үр дагавартай гэж үздэг улс орны (дарангуйллын дэглэм) иргэдийн хувьд зөвшөөрлөө амаар өгч, ажилтан үүнийг тэмдэглэж баталгаажуулна.

---

**Анхааруулга:** Насанд хүрээгүй хүүхэд, сэтгэцийн өвчтэй хүмүүс, сэтгэл зүйн эмгэгтэй хүмүүс болон зөвшөөрөл авах/өгөхөд оролцох боломжгүй хүмүүст зөвшөөрөл авах явцад хуулийн дагуух асран хамгаалагч буюу өмгөөлөгчийн тусгай туслалцаа хэрэгтэй байдаг. Хуулийн дагуух асран хамгаалагч нь хуулийн эрх бүхий өмгөөлөгч буюу бичгээр баталгаажсан итгэмжит төлөөлөгч байна. Байгууллагууд насанд хүрээгүй хүүхдээс буюу сэтгэцийн болоод бие махбодийн нөхцөл байдлын үүднээс хууль ёсны зөвшөөрөл өгөх боломжгүй хүмүүсээс зөвшөөрөл авахдаа хуульчаас зөвлөгөө авна.

---

## 7. Тохиромжтой үед асуултаа ухаалгаар тавих

Асуултын дараалал, асуултаа хэрхэн тодорхойлсон, асууж буй дууны өнгө зэрэг нь шаардлагатай мэдээлэл авах, тухайн хүн дарамтанд орох эрсдэлийг бууруулахад онцгой нөлөөтэй. Ярилцлага, өвчтний эмнэлгийн түүхийг бичих, оношлогоо хийх, зөвлөгөө өгөх явцад дээрх бүхэн онцгой нөлөө үзүүлдэг.

- **Давтсан асуулт асуухаас зайлсхийх:** Хохирогчтой ажиллаж байгаа ажилтнууд хохирогчийн өгсөн мэдээллийн (заримдаа олон удаа ярьсан) талаарх асуулт асуухаас зайлсхийх. Нууцлалын журмаар зөвшөөрсөн бол ажилтнууд тухайн хүнтэй уулзахаас өмнө нэгэнтээ баримтжуулсан мэдээллийн талаар асуухаас зайлсхийж тухайн хүний хэрэгтэй танилцах. Уулзалт хийхээс өмнө мэдэгдэж байгаа мэдээллийг бөглөх ёстой маягтанд бичих нь давуу талыг олгодог.
- **Асуултын дараалал:** Асуултуудыг дараалуулахдаа аль болохоор хүндрэлгүй хариулах асуултыг эхлээд тавих ба ингэснээр асуултанд хариулах нь хялбар байдаг. Ярилцлага, эмчилгээний үеэр асуулт асуух байгаа бол эхлээд тухайн хүний сайн сайхантай холбоотой (эрүүл мэнд, шаардлагатай байгаа үзлэг, эмчилгээ, аюулгүй байдал, биеийн байдал зэрэг) тухайн хүнийг итгэлийг төрүүлэх асуулт асууна. Үүний дараа ярилцлага авч буй хүн ердийн асуулт болох нэр, төрсөн газар, хийж байсан ажил гэх мэт асуулт асуух ёстой. Эмзэг асуултуудыг уулзалтын сүүлд асуувал илүү бодитой

хариулт авдаг. Учир нь ажилтан болоод хохирогчийн хооронд ярилцлагын үед нэлээдгүй бат бөх харилцаа үүсдэг. Хүн бүрийн тохиолдолд ямар асуулт илүү эмзэг болохыг – зарим хохирогчид эмзэг, хариулахад хүнд асуултууд бусад хохирогчид хариулахад хялбар байдаг- тодорхойлоход хүндрэлтэй боловч зарим сэдвүүд бүх хүмүүст хүнд хэцүү байдаг гэдгийг баталсан. Эмзэг, хүнд асуулт гэдэгт бэлгийн хүчирхийлэл (нэн ялангуяа наймаалагдахаас өмнө гэр бүлд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлэл), хүүхдүүд, гэр бүл, гэрийн хаяг, хууль хэрэгжүүлэгч байгууллагатай хийсэн уулзалт, хохирогчтой холбоотой хууль бус үйл ажиллагаа (хуурамч бичиг баримт, биеэ үнэлэх, хууль бусаар хил давах, сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэх гэх мэт) зэрэг багтдаг.

---

**Ярилцлагыг эмзэг бус асуултаар төгсгөх нь чухал бөгөөд ярилцсан хүнээ сэтгэлийн зовлонтой, дарамтанд орхиж болохгүй. Боломжтой бол тухайн хүний давуу талыг ярьж, түүнд урам өгч ярилцлагаа дуусгах нь чухал юм.**

---

■ **Асуулт тавих байдал:** Асуултыг хэрхэн асууж байгаа нь юу асууж байгаатай адил чухал юм. Санaa тавьсан, сонирхож буй байдлаар асуусан асуултанд дэлгэрэнгүй хариулт өгөх нь их байдаг бол дарамталсан, шахсан буюу тухайн хүнд итгэл төрүүлэхгүйгээр асуусан асуултанд хүмүүс хариулах дургүй байдаг. Тэдэнд хичнээн муухай хандсан, эргээд санаад хүнд асуулт асуухагүй байвал хохирогчид хүнлэг сэтгэл байдаг гэдэгт итгэх итгэл нь сэргээдэг байна. Асуултанд хариулахдаа бодож байж хариулж болно гэдгийг сануулах нь чухал бөгөөд эсвэл хариулахад хүнд асуултанд дараа нь хариулж болно гэдгийг сануулж болно.

## 8. ЯРИЛЦАЖ БУЙ ХҮНЭЭ САЙН СОНСОХ<sup>2</sup>

Идэвхтэй сонсогч байна гэдэг ярьж буй хүн болоод түүний ярианд нхаарлаа төвлөрүүлж, түүний хэлсэн бухнийг сонссон, сийлгосон гэдэгээ ойлгуулах гэсэн үг юм. Идэвхтэй сонсогч байхын тулд дараах аргуудыг ашиглана.

- **Ярихгүй байх:** Ярьж байхдаа хүний яриаг сонсох боломжгүй
- **Асуулт асууж, тодруул:** Хэлж ярьсныг нь ойлгоогүй санагдаж

байвал дахиад асуу эсвэл тухайн хүнийг өөрийгөө тэнэг, ойлгох чадваргүй гэж бодох эвгүй байдалд оруулалгүйгээр асуултаа хохирогчид ойлгогдох хэлбэрээр тавь

- **Асуултанд хариулахад хугацаа өг:** тухайн хүнд болж өнгөрсөн үйл явдлыг эргэн санах, сэтгэл хөдлөлөө гаргахыг нь зөвшөөрөх. Хариултаа яаруулах эсвэл хариулт авахын тулд дарамталж болохгүй. Дуугуй байна гэдэг муу зүйл биш. Удаан хугацаанд чимээгүй байна гэдэг бол тухайн хүн хүнд асуудлыг хэрхэн яж сайн тайлбарлах вэ гэж бодож байгаа хэрэг бөгөөд, өөрийн сэтгэл хөдлөлөө барихыг хичээж, эсвэл болж өнгөрсөн үйл явдалтай холбоотой онцгой зүйлсийг санаахыг оролдож байгаа гэсэн үг. Тухайн хүн дуугуй байж, эсвэл удаан хугацаагаар чимээгүй байснаас үүдэн дүгнэлт гаргах хэрэггүй.
- **Анхаарлаа төвлөрүүл:** Өөр зүйл хийхийг бүү оролд, бусад хэргүүдийн талаар, бусад асуудлуудын талаар бодох буюу тухайн хүнийг ярьж байхад юу хэлэхээ бод
- **Уриалаг бай:** тухайн хүний нүүрний хувирал, гар болон биеийн хөдөлгөөн, юу хэлэхдээ ямар өнгөөр хэлснийг нь ажигла. Заримдаа хүмүүсийн үйл хөдлөл үгээр илэрхийлснээс илүү ихийг өгүүлдэг. (Тухайн хүнийг хэтэрхий ойроос харж байхад хүн тавгүй байдалд ордог. Хэлж яриагүй зүйлийг нь анхаар. Түүнд хохирол учруулсан үйл явдал буюу тухайн үеийн бодол санаатай холбоотой зүйлсийг ярилцах, хохирогчийн ярилцахаас зайлсхийж байгаа сэдвүүд нь хохирогчийн ярьсан бүхнээ хавьгүй чухал юм. Ярилгүй орхисон сэдвийг боломжтой үед дахин хэнд)
- **Хэлсэн үгийг хүлээж авах:** Та ярьж буй хүнийг хэрхэн яж сонсч байгаа, ярьсан бүхнийг нь ойлгож байгаа, ярьж байхдаа гаргасан үйл хөдлөлийг хүлээн зөвшөөрч байгаа гэдгээ ярилцаж буй хүндээ мэдүүлэх нь чухал байдаг. Тухайлбал, нүүрний хувирал, толгой дохих, ойлгосон гэдгээ мэдэгдэх үг (тэгэлгүй яахав, би таныг ойлгож байна) болон тухайн хүний хэлснийг давтаж буюу баталгаажуулах. Гэхдээ тухайн хүний яриаг тасалдуулах эсвэл хэлж буй өгүүлбэрийг нь дуусгах, үг нэмж болохгүй. Тухайн хүн өөрөө бодол санаагаа чиглүүлэх боломжийг олгоно.

## 9. ЯРИЛЦЛАГЫН ҮЕЭР БЮОУ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮЕЭР ТҮР ЗАВСАРЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙГАА ЭСЭХИЙГ АЖИГЛА

ХХГХ-ийн талаарх асуулт буюу худалдагдсан талаарх мэдээллийг сайн

дурын үндсэн дээр буюу мэдээлэл шаардлагатай гэсэн үүднээс өгөх явцад нэгэнтээ дарамтанд орсон хохирогч бие махбодийн, сэтгэл зүйн болоод нийгмийн хүндрэлтэй нүүр тулдаг. Бие хүний сэтгэл санаа, сул байдлыг ойлгож хандах нь зөвхөн хүмүүнлэг төдийгүй мөн мэдээлэл авах, туслалцаа үзүүлэхэд ач холбогдолтой юм. Ядарсан, хүчирхийлэлд автсан гэсэн бодолтой хүмүүс хэт их сэтгэл хөдлөлд автсан буюу өнгөрсөн, ирээдүйнхээ талаарх бодолдоо хэт автсан хүмүүс мэдээллийг эргэн санах, ойлгох чадвар султай байдаг. Үүнээс гадна тэр бүх бодол санаа нь туслалцаа үзүүлэх гэж буй хүн болоод авах гэж буй туслалцааг бүрэн ойлгодогтүй. Тийм учраас тухайн хүнд зэлдэг хандах, ярилцлага өгч буй хүн түр завсралах, сэдвээ өөрчлөх, бодлоо төвлөрүүлэх эсвэл шууд ярилцлагыг зогсоох шаардлагатай эсэхийг илэрхийлсэн шинж тэмдгийг анхааралтай ажиглах ёстай. Урт болон богино хугацаанд дуугүй байсан хүмүүс өөрийн тухай ярихаас төвөгшөөх нь бий. Хүмүүс тэдэнд тохиолдсон зүйлийг эргэн санах, яаралгүйгээр тэр тухай бодох эсвэл бодол санааг нь сарниулалгүйгээр тэднийг яриулах нь чухал бөгөөд учир нь тэд огт өөр сэдвээр эсвэл туслалцаа үзүүлж буй хүний заваас шалтгаалан ярилцлага өгөх болдог.

## 10. ӨӨР ҮЗЭЛ БОДОЛТОЙ БОЛ ТҮҮНИЙГЭЭ НУУХ, ДОТРОО БОДОХ

ХХГХ-ийн үйл явц нийгэмд хүлээн зөвшөөрч болохгүй, эсвэл ёс зүйн хувьд байж болшгүй арга хэлбэрээр явагддаг. ХХГХ-т үндэстэн ястан, соёл, нийгэм эдийн засгийн болоод хувь хүний хувьд ялгаатай зан чанартай хүмүүс өртдөг. Туслалцаа үзүүлж буй хүмүүс хамт ажиллах хүний тухай сөрөг бодолгүй, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлгүй, тэднийг буруутгасан үзэл бодолгүй байх ёстай гэдгийг санах ёстай. Туслалцаа үзүүлэх ажилтнууд хохирогчдыг хүчирхийлэлд автсан (биээ үнэлэх, гүйлга гүйх зэрэг) гэж бодох ёстай бөгөөд хүчирхийллийн зарим хэлбэрийн золиос болсон (бэлгийн мөлжлэг), мөн өвчин, шаналалд автсан (ХДХВ, биений гэмтлээс болж эрүүл мэндээрээ хохирсон, полимелит болон бусад өвчтэй) хүмүүс, эсвэл нийгэм, соёл эсвэл бусдын шашин шүтлэгийн золиос болсон гэж үзэх ёстай.

Хохирогчтой адил нийгэм эдийн засгийн статустай ажилтнуудын үзэл бодол хэт туйлширдаггүй байдаг байна. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан, байнгын ажилтай, орлогын дундаж түвшинтэй ажилтнууд орон нутгийн иргэд буюу боловсрол багатай иргэдээс давуу талтай гэдгээ мэддэг байна. Энэ үзэл бодол нь ихэвчлэн сэтгэлээр илэрдэг

(тухайлбал эцэг эхийн ёсоор, халамж тавих зэрэг) бөгөөд туслалцаа авч буй хүнд тэднийг өрөвдөж байгаа гэсэн сэтгэгдэл төрүүлэхгүйгээр туслалцаа үзүүлэх ёстай.

## 11. ИТГЭ, БИТГИЙ ШҮҮЖ ДҮГНЭ

Туслалцаа үзүүлж буй харилцаа нь итгэлцэл дээр тогтдог. Туслалцаа үзүүлж буй хүний талаас итгэлцэл эхлэх ёстай. Туслалцаа авах гэж хүн нь тэдэнд үнэнийг ярина гэдэгт туслалцаа үзүүлж буй хүмүүс бүрэн итгэлтэй байх ёстай ба хохирогчийн зүгээс гарах үл итгэх байдлыг зөвхөн туслалцаа авахын төлөө тогтоож буй харилцаагаар сольж болохгүй. Хохирогчдын хэлсэн бүхнийг баталгаажуулах үүднээс шалгахгүй гэдгийг хохирогчид сайтар ойлгосон байх ёстай бөгөөд зөвхөн сайн санааны үүднээс туслалцаа үзүүлж байгаа, ө.х., хохирогчоос зөвхөн мэдээлэл авахын тулд туслалцаа үзүүлээгүй гэдгийг хохирогчдод ойлгуулах ёстай. Хохирогч худлаа ярьж байгааг батлах нотолгоо байхгүй л бол туслалцаа үзүүлж байх явцдаа ямар нэгэн дүгнэлт хийх шаардлагагүй юм.

Хохирогчид бусдад итгэхгүй байх, худал мэдээлэл өгөх, өнгөрсөн үйл явдлын талаар ярихдаа өөрчилж, зөвтгөж ярих шалтгаантай гэдгийг санаж байх ёстай. Тухайн хүн худал хэлж, эсвэл тодорхой зарим мэдээллийг өгөхөөс татгалзах, мартах эсвэл зохиож ярьж байгаа бол тухайн хүний өгсөн мэдээллийг бүхлээр нь худал гэж үзэх, эсвэл тухайн хүнд итгэхгүй байж болно гэсэн шалтаг биш юм.

## 12. ЯРИЛЦАГЧ ХҮНЭЭ ХҮНДЭТГЭЖ, ТЭВЧЭЭРТЭЙ БАЙЖ МЭРГЭЖЛИЙН БАЙДЛАА ХАРУУЛАХ

Мэргэжлийн байдлаар хандана гэдэг бол тухайн хүний хүндэтгэж, тэгш эрхтэй хандахыг хэлнэ. Эрх мэдлийн түвшинд (мэдээлэл, үйлчилгээ, бараа хянах) байгаа мэргэжлийн хүмүүс эцэг эхийн зүгээс мэт, эсвэл мэдлэг боловсрол, мэргэжлийн хувьд давуу талтай гэдгээ харуулж харьцах нь ховор байдаг бөгөөд энэ тохиолдолд туслалцаа авч буй хүн ямар ч чадваргүй, сул дорой мэт харагддаг. Энэ нь тусламж үзүүлж буй харилцааг эн тэнцвэргүй байдалд оруулдаг ба өөрсдийгөө эрх чөлөөтэй, бие даасан гэж бодох болсон хохирогчид сул дорой мэт сэтгэгдэл төрүүлдэг байна. Туслалцаа үзүүлж буй хүмүүс мэргэжлийн түвшний зай барьж харьцах ёстай хэдий ч тэвчээртэй байж хохирогчид санаа

тавих ёстай. Туслалцаа авч буй хүмүүс эн тэгш байдалтай байгаа гэдгээ мэдэрч тэдний шийдвэрийг хүндэтгэж байна гэж ойлгох ёстай. Мөн тэдэнд туслалцаа үзүүлж буй хүмүүс тэдний талаар анхаарал халамж тавьж, тэдний эрх ашгийг хамгаалж байгаа гэдгийг ойлгож байх ёстай.

### **13. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧ ӨӨРИЙГӨӨ БИЕ МАХБОДИЙН БОЛООД СЭТГЭЛ ЗҮЙН ХУВЬД БҮРЭН ХЯНАЖ БАЙГАА ЭСЭХИЙГ БАТАЛГААЖУУЛ**

Туслалцаа үзүүлэх үйл явцад хэн нэгэн зааварчилгаа өгч, удирдаж байх ёстай. Туслалцаа авч буй хүн болж буй үйл явцыг бүрэн хянаж өөрийн ирээдүйн талаар өөрөө шийдвэр гаргах ёстай гэдгийг анхаарна. Өмнө дурьдсанчлан хохирогчид бусад хүмүүс түүнээс юу хүсч байгааг байгаагаа мэдэх эрхтэй бөгөөд өөрсдийн оруулж буй хувь нэмрийг ойлгож байх ёстай. Нэн ялангуяа бие болоод сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эмчилгээ болоод тавигдаж байгаа асуултуудыг өөрсдөд нь хэт халдсан, эрхийг нь зөрчиж байна гэсэн ойлголт хохирогчид төрөх нь бий. Тухайн хохирогч хийж буй уулзалт ярилцлагыг хүчээр буюу албан шахалтаар хийж байна гэж бодох ёсгүй бөгөөд юу болж байгаа, цаашид арга хэмжээ аваадаа түүнээс зөвшөөрөл авах ёстай гэдгийг мэдэж байх ёстай. Туслалцаа үзүүлж буй хүн туслалцаа үзүүлэх явцад хохирогч нөхцөл байдлыг бүрэн хянах боломжтой гэдгийг ойлгуулах, тухайлбал боломжит сонголтуудыг тэвчээртэйгээр тайлбарлах, шийдвэрийг албадлагаар бус зөвхөн хохирогч өөрөө гаргана гэдгийг ойлгуулах, мөн сонголт хийхэд хангалттай хугацаа байгаа, сонголт хийгдсэн бол хохирогчийн шийдвэрийг үнэлэх ёстай.

### **14. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧДОД ТЭДНИЙГ БУРУУТГАХ ГЭЭГҮЙ ГЭДГИЙГ САЙТАР ОЙЛГУУЛАХ**

ХХГХ-ийн хохирогчид ихэвчлэн өөрийгөө буруутгадаг. Хохирогчид тохиолдсон зүйл тэдний буруу биш гэдгийг хохирогчид ойлгуулах ёстай. ХХГХ нь бол дэлхийн хүмүүст тохиолддог эрүүгийн гэмт хэрэг бөгөөд бусдын заль мэхэнд автсан, дарамтанд орсон хохирогч ямар нэгэн эрүүгийн буюу ёс суртахууны хариуцлага хүлээхгүй гэдгийг мөн ойлгуулна. Энэ бүхнийг ойлгуулсны дараа туслалцаа үзүүлж буй хүн хохирогч өөрийгөө буруутгах, шийтгэхээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авч, тэднийг хэн нэгэн буруутгах, шүүх гээгүй гэдгийг дахиг тайлбарлаж ойлгуулна.

## 15. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧДОД ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГ БОЛООД ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХ ЭРХТЭЙ ГЭДГИЙГ ХЭЛЖ ОЙЛГУУЛАХ

Хохирогчид хүн наймаалагчийн эсрэг буюу тэднийг хүчирхийлсэн, мөлжсөн этгээдүүдийн эсрэг гомдол гаргаж эрүүгийн буюу иргэний хэрэг үүсгэх зорилгоор шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах эрхийг нь мэдүүлж, ойлгуулах ёстай. Шүүх эмнэлгийн дүгнэлт нь мөрдөн байцаах явцад, нэн ялангуяа бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэгт нэн чухал нотолгоо баримт юм. Шүүх эмнэлгийн үзлэг гэдэг нь шүүх хурлын явцад ашиглах зорилготой нотолгоог гаргах мэргэшсэн эмч нарын гэмт хэргийн хохирогчид хийсэн үзлэгийг хэлнэ. Бэлгийн хүчирхийллийн хэргийн шүүх эмнэлгийн үзлэгт дараахь зүйлс заавал тусгагдана:

1. Бие махбодид учирсан хохирол
2. Хүч хэрэглэсэн эсэх
3. Өвчтөнтэй хийсэн ярилцлага
4. Баримт нотолгоог цуглуулах, үнэлэх<sup>3</sup>

Баримт нотолгоо цуглуулах, эмчилгээ (бэлгийн замын халдварт өвчин гэх мэт) хийх зорилгоор авах бусад нэмэлт арга хэмжээг хүчин төгөлдөр хууль, журам, туршлага дээр үндэслэн тодорхойлно. Эмнэлгийн дүгнэлт гаргуулахад цаг хугацааны хүчин зүйл маш ач холбогдолтой. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд анхны уулзалтын үеэр хохирогчид шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах эрхтэй гэдгийг мэдэгдэх ёстай бөгөөд дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан тохиолдолд ажилтнууд мэргэжлийн шүүх эмнэлгийн оношлогоо нэн даруй хийх ажлын зохион байгуулна. Мөн хохирогчид шүүх эмнэлгийн дүгнэлтийг гарсан даруйд нь өгөх ёстай бөгөөд нэн ялангуяа хөтөлбөр дуусч байгаа бол тэдэнд яараптай өгнө.

## 16. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧДОД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛООД ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГ АВАХ ЭРХТЭЙ БОЛОХЫГ ХЭЛЖ ОЙЛГУУЛАХ

Хохирогч бүр эрүүл мэндийн үзлэг болоод эрүүл мэндтэй холбоотой эмнэлгийн түүх, үүний дотор оношлогооны үр дүн, рентген, лабораторийн дүгнэлт, цаашид хийгдэх эмчилгээний талаарх мэдээллийг авах эрхтэй гэдгийг тэдэнд мэдээлэх ёстай. Анхны үзлэг хийсэн эмчийн үзлэгийн ерөнхий дүгнэлтийг хохирогчид эх хэлээр нь өгнө. Эмнэлгийн үзлэгийн дүгнэлтийг авах эрхтэй байна гэдэг нь хохирогчийн эрхийн нэг бөгөөд нэн ялангуяа а/ өөр эмч, эмнэлгийн байгууллага буюу хамтран ажиллаж

буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандах, б/ нөхөн сэргээлтийн үе, в/ тодорхой эмчилгээний эцэст гарсан өөрчлөлт, г/ хохирогчийн хүсэлтээр өвчтний түүхийг авч болно.

## 17. ХХГХ-ИЙН ХОХИРОГЧДОД ТЭДНИЙ ДАВУУ ТАЛЫГ САНУУЛАХ

Хохирогч бүрийн туулж өнгөрүүлсэн айдас хүйдэс, доромжпол болоод тэдэнтэй харьцаж байсан харьцаа зэргийг санаж байх ёстой бөгөөд үүссэн нөхцөл байдлыг хохирогч хэрхэн давж гарсныг сануулах нь чухал юм. Туслалцаа үзүүлж буй ажилтнууд хохирогчийн давуу тал, тэдний боломж бололцоог сануулж, ойлгуулах ёстой.

## 18. ОРЧУУЛАГЧ ӨГӨХ

Орчуулагч бол хохирогч болоод тэдэнд туслахыг оролдох буй ажилтнуудын хоорондын нэн чухал холбоо юм. Орчуулагч хэн нэгнийн хэлсэн үгийг шууд орчуулах биш мөн утга, агуулгыг ойлгуулах ёстой. Мэдээллийг хэрхэн хүргэж буй нь хохирогчийн эрүүл мэнд болоод ирээдүйд нэн чухал юм. Орчуулга сайн хийгдсэн бол энэ нь үзүүлж буй үйлчилгээнд маш нөлөөтэй. Хангалтгүй хийгдсэн бол энэ нь зарим тохиолдолд эргэж нөхөгдөхгүй хохирол учруулдаг. Орчуулагчийг сонгох, ажиллуулах нь нэн чухал юм. Орчуулагч өөрөө бие хүн төдийгүй төвийг сахигч байдаггүй гэдгийг ойлгох ёстой. Орчуулагч өөрийн үзэл бодол, хандлага, наиз нөхөдтэй, боловсролтой, бусдын “ам”, дуу хоолой болохоос гадна өөрийн гэсэн амьдралтай хүн. Өөрөөр хэлбэл орчуулагч авахдаа тухайн орчуулагчийг сайтар судлах ёстой гэсэн үг юм. Сайтар судлаагүй бол чадвар муутай орчуулагч нэн чухал мэдээллийг зөв дамжуулж чадахгүй байх талтай. Эсрэг тохиолдолд хохирогч, ажилтан болон бүх үйл явцыг нураах магадлалтай.

Орчуулагч тухайн байгууллагын ажилтан буюу гадны орчуулагч байхаас маш их зүйл шалтгаалах бөгөөд дараах зүйлсийг анхаарах ёстой.

Аюулгүй байдал. Хохирогчид орчуулгын үйлчилгээ үзүүлж буй бүх хүмүүсийг нарийн чанд шалгах ёстой. Орчуулга нэн яаралтай байгаа тохиолдолд сайн мэдэхгүй буюу аюулгүй байдлын шалгуурыг давж гараагүй сайн дурын орчуулагчийн үйлчилгээг авахгүй байх.

Сайн орчуулагч сонгох явцад орчуулагч үйлчилгээ үзүүлэх хүнхөхирогч буюу эмчийн эсрэг ямарваа нэгэн ялгаварлан гадуурхах үзэл агуулж байгаа эсэхийг шалгах ёстой. Орчуулагчийг сайтар шалгаагүйн улмаас орчуулагчийн зан ааштай холбоотой ямарваа нэгэн асуудлыг тодорхойлох боломжгүй байдаг. Улс үндэстний буюу үндэсний мөргөлдөөн гарсан, гарч буй улс орнуудад орчуулагч хөлслөхдөө түүний үзэл бодол, хандлагыг мэдэхгүйгээр орчуулагчийн үйлчилгээ авах нь онцгой эрсдэл үүсгэдэг. Орчуулагчийн зан төлөв зерэг байхаас гадна мөн хэтэрхий сөрөг байх магадлал бий. Ямар ч тохиолдолд орчуулагч ёгч буй мэдээлэлд нөлөөлдөг. Орчуулагчийг шалгах явцад зарим нэг онцгой асуулт асууж, үзэл бодлыг нь тандах ба орчуулагч орчуулга хийж байх үед түүний сэтгэл санааг мэдэх боломжгүй байдаг.

Орчуулагчийг сонгон шалгаруулах явцад тухайн орчуулагчийн мэргэжил боловсрол, харилцаанд анхаарах ёстой. Орчуулагч ихэвчлэн ярилцлага ёгч буй хүний нутгийн, зарим тохиолдолд нэг тосгоны, хотын хүн байдаг. Зарим хохирогчдын хувьд энэ нь тэдэнд таалагддаг бол заримынх нь хувьд өөрдсийнх нь тухай гэр бүлийнхэн, нутгийнхандаа ярих байх гэсэн айдастай байдаг учир дургүйцдэг байна. Нэг нутгийн хүмүүсийн хувьд, нэн ялангуяа мөргөлдөөнтэй байгаа бол орчуулагч өөрийнх гэр бүлд хохирол учруулсан хохирогчийг таних боловч ямар нэгэн шалтгаанаар үүнийгээ нуух эрсдэл гардаг. Аль ч тохиолдолд хохирогч өөрийн тухай болоод өөрт нь тохиолдсон үйл явдлын талаарх мэдээллийг бусдад ёгөх хүсэлгүй, шалтгаанаа тайлбарлахыг хүсдэггүй.

Орчуулагчийг сайтар шалгасны дараа хохирогчид орчуулга хийхээс нь өмнө шаардлагатай сургалтанд хамруулж, сэтгэл санааг нь бэлтгэх ёстой. Сургалтанд холбогдох үгийн сангийн томьёоллыг ёгөх ба үүнд:

- ХХГХ
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл (эмэгтэйчүүдэд орчуулга хийж байгаа хүмүүст)
- Хүүхдийн хүчирхийлэл (хүүхдэд орчуулга хийх хүмүүст)
- Эрүүл мэнд, эмчилгээ зэрэг ярилцах сэдвүүд, тухайлбал, бие маходийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэл зүй.

Сургалтын явцад орчуулагч нарт тэдний мэдэхгүй салбарын (тухайлбал анаагаах ухааны, эмнэлгийн) ойлголт, зарчмуудын талаар ойлголт, мэдээлэл өгөх ба тэдэнд орчуулга хийхэд яригдах зарим эмзэг, хувь хүнд хамааралтай сэдвүүдийн талаар ойлголт өгнө. Мөн орчуулагч нарт

ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ШУУД ТУСЛАМЖИЙН ГАРЫН АВЛАГА

хохирогчтой тэвчээртэй харьцах ёстой гэдгийг сайтар ойлгуулна.

---

**Хохирогч ямарваа нэгэн зовлон, шаналалтай байх, эсвэл  
орчуулагчид итгэхгүй байгаа нөхцлийг хэрхэн тодорхойлох вэ?**

Хохирогч сонгосон орчуулагчид таагүй хандаж байгаа эсэхийг тодорхойлох нь маш хүнд боловч нэн чухал асуудал юм. Ярилцлага нэгэнтээ эхэлсэн бол хохирогч орчуулагчид таагүй хандаж байгаа эсэхийг мэдэх нь ажилтны хувьд бэрхшээлтэй байдаг. Тухайн сонгосон орчуулагч хохирогчид тохирч байгаа эсэхийг шалгахад маш богино хугацаа зарцуулагдах хэдий ч урт хугацааны туршид цаг хугацаа болоод хун хүчээ хэмнэх боломжтой юм. Хохирогч бичиг үсэгт тайлагдсан бол тухайн хүний эх хэл дээр тийм үгүй гэсэн хариулт бүхий хуудсыг бэлтгэж тухайн орчуулагчийг авах эсэхийг тодорхойлж болох юм. Хүмүүсийг танилцуулсны дараа орчуулагч өрөөнөөс гарч, хуудсыг тухайн хүнд өгнө. Хуудсыг ярилцлагын эхэнд болоод шаардлагатай бол ярилцлагын үеэр хохирогчид өгч болно.

---

## Хавсралт II

### Ярилцлага хийхэд анхаарах зүйлс

ХХГХ-ийн хохирогчийн хувьд туслалцаа авах буюу туслалцаа авсан, хохирогч болох нь тогтоогдсон хүмүүсээс ярилцлага авах хүмүүс Хавсралт 1: ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх болон ярилцлага хийхэд баримтлах ёс зүйн зарчмуудыг үзнэ үү.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнуудын ярилцлага хийхэд ашиглаж болох ерөнхий заавар, анхаарах зүйлсийг дор өгсөн болно.

#### Нөхцөл

- Боломжтой газарт, бусад хүмүүс үймүүлэхээргүй, хаалттай газар ярилцлага хийгдэж байгаа эсэхийг анхаарах
- Ярилцлагад зөвхөн хохирогч, ярилцлага авах хүн (хүмүүс), шаардлагатай бол хэлмэрч, мөн шаардлагатай бол туслалцаа үзүүлэх мэргэжлийн хүн (хуулийн зөвлөх буюу сэтгэл зүйч)
- Ярилцлага явагдаж буй хэлийг тухайн хүн ойлгохгүй байх гэсэн эргэлзээ төрж байвал хэлмэрч авах бүх арга хэмжээ авах
- Гар утсыг бүрэн унтраана
- Тохиромжтой байр байгаа бол ярилцлагыг үймүүлэхээс сэргийлэн хаалган дээр “Чимээгүй бай, үймүүлэхгүй байхыг хүсье” гэсэн анхааруулга байрлуулах
- Тохиромжтой байр байхгүй бол ярилцлага авч буй хүн бусдад сонсогодохгүй байх нөхцлийг бүрдүүлэхийг хичээх ёстай
- Ярилцлага хийхдээ ямарваа нэгэн байдлаар дүгнэсэн, эсвэл үгүйсгэсэн байдлаар харьцахаас болгоомжил
- Ярилцаж буй хүндээ түүнийг болон үзэл бодлыг нь хүндэтгэж байна гэсэн сэтгэгдэл төрүүлж харилцаа тогтоохыг хичээх.

#### Оршил

- Ярилцлага авч буй хүн өөрийгөө танилцуулж, тухайн байгууллагад ямар ажил эрхэлдгээ тайлбарлах ёстай
- Ярилцлага өгч буй хүн аюулгүй, тав тухтай байгаа эсэхийг лавлах
- Ярилцлага өгч буй хүн ариун цэврийн өрөөнд орох эсэх буюу юм

шаардлагатай эсэхийг лавлах

- Ярилцлага өгч буй хүн таагүй буюу ямар нэг шаналгаатай, эсвэл тухайн хүнд эмнэлгийн яаралтай тусlamж шаардлагатай байгаа эсэхийг тодруулах
- Тухайн хүн эмнэлгийн яаралтай тусlamж хэрэгтэй гэвэл эмнэлгийн нарийн үзлэг хийх хүртэл ярилцлага хийж болохгүй
- Толгой өвдөх зэрэг бага зэргийн шаналгаатай бол эмчийн зааваргүй эм өгч болно (тухайлбал парацетамол, аспирин, ибупрофен зэрэг).

## Тайлбар

- ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлж байгаа байгууллагын үүрэг, зорилго, хийх гэж буй ярилцлагын зорилгын талаар ерөнхий ойлголт өгөх
- Ярилцлагын явцад хохирогчид тохиолдсон зүйтэй холбоотой асуулт гарч болох, ярилцаж буй зарим сэдвүүд таагүй сэтгэгдэл төрүүлэх, эргээд санаход хэцүү зүйлсийн талаар ярилцаж болзошгүйг ярилцлага өгч буй хүнд хэлж ойлгуулах
- Асуултанд бодож байж хариулах, шаардлагатай бол түр завсарлаж болно гэдгийг хэлэх
- Өгч буй мэдээлэл их байх тусам байгууллага хохирогчид илүү их тусlamж үзүүлэх боломжтой болно гэдгийг ойлгуулах. Байгууллагын үзүүлж болох тусlamж, туслалцаа хязгаарлагдмал гэдгийг тайлбарлан ойлгуулах (тухайлбал тухайн байгууллага зөвхөн ХХГХ-ийн хохирогчдод тусlamж үзүүлдэг бол хууль буй цагаач, хүүхдүүд зэрэг туслалцаал үзүүлэх боломжгүй)
- Тухайн хүн өөр шалтгаантай байвал байгууллага тусlamж үзүүлэх боломжгүй байх хэдий ч туслалцаа үзүүлэх боломжтой байгууллага, хувь хүнийг олоход туслана гэдгийг тайлбарлах

## Ярилцлага эхлэхийн өмнө анхаарах зүйлс

- Тухайн хүний өгсөн хариултуудыг нууцлана гэдгийг хэлэх
- Тухайн хүн хэзээ ч асуулт асуух эрхтэй буюу тухайн үед болж өнгөрсөн үйл явдлыг дахин тайлбарлах, ярих эсвэл давтаж ярьж болно гэдгийг ойлгуулах
- Тухайн хүн тайлбарлаж хэлсэн бүхнийг сайтар ойлгосон эсэхийг тодруулах
- Ярилцлага эхлэхийн өмнө асуулт байгаа эсэхийг лавлах
- Тухайн хүн ярилцлага өгөхийг зөвшөөрч байгаа эсэхийг лавлах

## Хавсралт III

### Үндсэн ойлголтуудын тайлбар

#### Хүчээр авах/булаах/элсүүлэх

Хэн нэгнийг хүчээр буюу итгүүлэн үнэмшүүлж хуuran авч явах үйлдэл. Мөн Хүүхэд хулгайлах, Элсүүлэх, Хүчээр авахыг харна уу

#### Хүүхэд

18-аас доош насын буюу хүүхэд гэсэн ойлголтыг тодотгох хуулийн дагуу заасан наснаас доошхи насын бие хүн. (1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенци, 1-р заалт) Хүүхэд наймаалахыг олон улсын олон хуулиар хориглосон бөгөөд “Хүүхдийн хөдөлмөрийг мөлжих зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах буюу хүлээн авахыг “хүн наймаалах” гэж нэрлэнэ гэсэн тусгай заалт байдаг.” (ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, 2000)

Дэлгэрэнгүйг <http://www.hrw.org/children/child-legal.htm>;  
[http://www.unodc.org/unocd/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unocd/en/crime_cicp_convention.html)

Мөн Хүүхдийн хөдөлмөр, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг үзнэ үү

357

#### Хүүхдийн хөдөлмөр

Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, биеийн болоод сэтгэц, сэтгэл зүй, ёс зүй буюу нийгмийн хөгжилд хохирол учруулах хүүхдийн эрхэлж буй хөдөлмөр (Хүүхдийн эрхийн конвенци, 32-р заалт, 1989 он) Улс орнууд хүүхдийн хөдөлмөр эрхлэх насын доод хязгаарыг зааж өгөх ёстой ба эрхэлж буй ажлын цаг, нөхцлийг зохицуулах үүрэг хүлээдэг.

<http://www.hrw.org/children/child-legal.htm>

Мөн Хүүхэд, Мөлжлөг, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг үзнэ үү

#### Хүүхэд-цэрэг

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглахыг хориглосон олон улсын хэд хэдэн хууль тогтоомж байдал. 1977 оны Женевийн дөрвөн конвенцийн нэмэлт заалтад зэвсэгт мөргөлдөөнд элсүүлэх,

оролцуулах хүүхдийн насны доод хязгаарыг 15 гэж зааж өгсөн. 1999 оны хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлох, хориглох конвенцийн 3-р заалтанд зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүүхдийг “хүчээр буюу албадан элсүүлэх”-ийг хориглосон. 2000 оны Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протоколд хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахыг хориглосон. (Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол)

### **Албадлага**

Хүчээр буюу биеийн хүч хэрэглэнэ гэж айлан дарамтлах, мөн Хяналт, Өрийн дарамт, Тусгаарлалт гэсэн хэсгүүдийг үзнэ үү

### **Хяналт**

Нэлөөлөх буюу нэлөөллийг хязгаарлах. ХХГХ-ийн үндсэн хүчин зүйлсийн нэг. Хүн наймаалагчид хохирогчдыг өрийн барьцаа, тусгаарлалт (тухайлбал, бичиг баримтыг нь хураан авах), айdas хүчирхийллээр (сэтгэл зүйн болон бэлгийн) хянаж дарамталдаг.

Мөн Албадлага, Өрийн барьцаа, Тусгаарлалт зэргийг үзнэ үү

### **Очих газар**

Нүүн суурьшиж буй хүний очих газар, хуулийн дагуу болон хууль бус нүүн шилжигсдийн очихоор зорьж буй улс орон

Ижил утгатай: Хүлээн авагс улс

Мөн Эх орон, Дамжин өнгөрүүлэх улс гэдгийг үзнэ үү

### **Эх орон**

Нүүн шилжсэн хүний эх орон, хуулийн дагуу болон хууль бус нүүн шилжих урсгалын эхлэл болсон улс

Ижил утгатай: Очих газар, Дамжин өнгөрөх улс

### **Дамжин өнгөрөх улс**

Нүүн шилжигчийн дамжин өнгөрч буй улс, хууль болон хууль бус нүүн шилжигсдийн дамжин өнгөрөх улс

Мөн Эх орон, Очих газарыг үзнэ үү.

## Өрийн барьцаа

“Зээл авагч өөрт нь үзүүлсэн үйлчилгээг төлнө гэсэн амлалт өгсөн нөхцөл буюу өрөөр барьцаалах. Тухайн хүний авсан үйлчилгээний төлбөрийг бодитойгоор үнэлээгүй бол энэ нь ер барагдуулах, эсвэл тухайн үйлчилгээ үзүүлэх хугацаа, төрөл хязгааргүй буюу тодорхой бус байдаг” (1956 он Боолчлол, бооплын наймаа болон боолчлолтой адил байгууллага, энэ төрлийн үйл ажиллагааг таслан зогсоо талаарх нэмэлт конвенц, Бүлэг 1) Зарим тохиолдолд ХХГХ-ийн хохирогчдыг бүрэн хяналтандаа байлгах зорилгоор өрийн дарамтыг ашиглах нь бий.

Дэлгэрэнгүй мэдээлэл <http://www.unhchr.ch/html/intlinst.htm>

Мөн Хяналт, Албадлага хэсгүүдийг үзнэ үү

## Гэр бүлийн мөлжлөгт хөдөлмөр

Боолчлол гэдгийг “зайлсхийх шалтгаант боломж” байхгүй “хамааралтай, эдийн засгаар дарамтлах хөдөлмөрийн мөлжлөгийн харилцаа” юм. Зарим тохиолдолд “гэр бүлд ажиллаж байгаа цагаач ажилчдын хөдөлмөрийг мөлжихийг мөлжлөг гэж тайлбарлаж” болно.

Мөн: Мөлжлөг, Өрөөр барьцаалсан мөлжлөг гэдгийг үзнэ үү

## Мөлжлөг

Хэн нэгний эрх ашгийн үүднээс түүнийг хянах эсвэл ямар нэгэн байдлаар барьцаалж хянах үйлдлийг хэлнэ. ХХГХ-ийн үндсэн хүчин зүйл бол “наад зах нь мөлжих ба бусдын биеийг үнэлүүлэн мөлжих эсвэл бэлгийн мөлжлөлгийн бусад хэлбэрийг ашиглах, хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, үйлчилгээ хийлгэх, мөн боолчлолтой дүйцүүлж болох хөдөлмөрийн аргуудыг ашиглах, эсвэл эрхтнийг авах”. (НҮБ-ын ХХГХ-ээс сэргийлэх, таслан зогсоо, гэмт хэрэгтнүүдийг шийтгэх протокол, 2000 он, 3-р зүйл) Хүн наймаалагчид хохирогчдоо өөрийн хувийн эрх ашгийн үүднээс тээвэрлэх, тэднийг мөлжиж их хэмжээний мөнгө олох эсвэл үнэгүй үйлчилгээ авах буюу хөдөлмөр хийлгэдэг.

Дэлгэрэнгүй мэдээлэл: [http://www.unodc.org/unodc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unodc/en/crime_cicp_convention.html)

Мөн Хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, Гэр бүлийн мөлжлөгт хөдөлмөр, Бэлгийн мөлжлөг, Элсүүлэх, Зөөвэрлэх зэргийг үзнэ үү

### **Хүчээр хөдөлмөр эрхлүүлэх**

“Ямар нэгэн шийтгэлээр айлган хэн нэгнээр ажил, үйлчилгээ хийлгэх, тухайн хүнд сайн дураар ажил үйлчилгээ гүйцэтгэх боломжгүй байх” (Хүчээр хөдөлмөр эрхлүүлэх тухай конвенци, 1930 он, 2-р зүйл). Төрийн хүлээх үүргийг 1957 оны Хүчээр хөдөлмөр эрхлүүлэхийг таслан зогсоо тухай конвенцид зааж өгсөн болно.

Ойролцоо утга: хүчээр ажиллах

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.unhchr.ch/html/intlinst.htm>

Мөн: Мөлжлөг үзнэ үү

### **Хүчээр гэр бүл болох**

Сайн дурын бус үндсэн дээр гэрлэх. 1962 оны Гэрлэх зөвшөөрөл, гэрлэх насны доод хязгаар, гэрлэлтийг бүртгэх тухай конвенцид зааснаар “Гэрлэлт нь зөвхөн гэрлэх хосын харилцан зөвшилцлийн үндсэн дээр баталгаажна”. Хүчээр гэр бүл болох нь боолчлолтой адил бөгөөд “татгалзах эрхгүй эмэгтэйг мөнгөн хэлбэрээр буюу бусад хэлбэрийн оронд эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл буюу хэн нэгэн хүн эсвэл бүлэглэлд өгнө гэж амлах буюу өгдөг.” “Эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсвэл түүний овгийнхон өгсөн мөнгөний дүн буюу өөр хэлбэрээр эмэгтэйг бусад шилжүүлэх эрхтэй” байdag буюу “нөхөр нь нас барсан тохиолдолд эмэгтэйг өөр хүн залгамжилдаг” байна. (Боолчлол, Боолын наймаа болон Боолчлолтой адил хэлбэрийн байгууллага, туршлагыг таслан зогсоо талаарх нэмэлт конвенци, 1с зүйл) Хүчээр гэр бүл болохыг мөн 1979 оны Эмэгтэйчүүдийн бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоо тухай конвенцид хориглосон байдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.unhchr.ch/html/menu3/b/63.htm>

<http://www.unhchr.ch/html/menu3/b/e1cedaw.htm>

<http://www.unhchr.ch/html/menu3/b/30.htm>

Мөн Мөлжлөг, Бэлгийн мөлжлөг үзнэ үү

### **Хүчээр цэрэг болгох**

Зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн 4-р конвенцийн дагуу “Эзлэн түрэмгийлэгч тал хамгаалагдсан иргэдийг өөрийн цэргийн буюу туслах цэрэгт алба хаахыг шаардах ёсгүй” (Дайны үед энгийн иргэдийг хамгаалахтай холбоотой Женевийн конвенц)

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.unhchr.ch/htm/menu3/b/92.htm>  
Мөн Хүүхэд-Цэрэг, Мөлжлөг үзнэ үү

### Хүний эрх

Хүн бүр өөрийн оршин буй нийгмээс орчин үеийн ёс зүй, үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх чөлөө, үр ашгийг эрх хэмээн шаардах эрхтэй. Энэхүү эрхийг Олон улсын эрхийн тухай хуулинд заасан бөгөөд 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхлаглалд нэгтгэн заасан. Мөн 1966 оны Эдийн засаг, Нийгэм, Соилн эрхий тухай олон улсын гэрээ, Нийгмийн болод улс төрийн эрхийн заалтанд зааж үүнээс үүдэн гарсан бусад гэрээнд тусгагдсан болно. (Тухайлбал, Эмэгтэйчүүдийн бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоо тухай конвенц, Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг конвенц)

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.unhchr.ch/udhr/index.htm>

### Биеийн байцаалт

Тухайн хүнийг тодорхойлох баримт бичиг

Мөн Паспорт, Аялах баримт бичгийг үзнэ үү

361

### Өрөөр барьцаалсан мөлжлөг

Мөлжлэгийг “зайлсхийх шалтгаант боломж” байхгүй “хамааралтай, эдийн засгаар дарамтлах хөдөлмөрийн мөлжлэгийн харилцаа” гэж ойлгож болно.

Мөлжлөг нь заримдаа өрөөр барьцаалан ХХГХ-ийн хохирогчдыг хянадаг өрийн барьцаанаас үүдэн гарч болдог.

Мөн Мөлжлөг, Өрийн барьцаа, гэр бүлийн мөлжлэгийг харна уу

### Мэдээлэл авч зөвшөөрөл өгөх

Ямар нэгэн зүйл хийх буюу ямар нэгэн зүйл болохыг хүлээн зөвшөөрсөн хэлцэл. Хэлцэл хийхдээ холбогдох бүхий л баримтыг мэдэж байдаг бөгөөд тухайлбал, гарч болох эрсдэл буюу бусад боломжийг мэдэж байдаг. Жишээ нь, эмч тухайн эмчилгээг хүлээн авахдаа буюу татгалзахдаа боломжит бүх эрсдэлийг өвчтөнд мэдээлсний дараа өвчтөн мэдлэгтэй байж зөвшөөрөл өгдөг.

## Дотоодын ХХГХ

Тухайн улс орон дотор хүн худалдаалах

### Ёс бус шилжилт хөдөлгөөн

Илгээх, дамжин өнгөрүүлэх буюу хүлээн авагч улс орнуудын хууль эрх зүйн хэм хэмжээнээс гадуур хийгдэж байгаа шилжилт хөдөлгөөн. Ёс бус шилжилт хөдөлгөөний нарийвчилсан, эсвэл олон нийтийн хүлээн зөвшөөрсөн нэгдмэл тодорхойлолт байдаггүй. Хүлээн авагч улс орны хувьд энэ нь хууль бусаар тус улсад нэвтрэх, амьдрах буюу ажиллах юм. Өөрөөр хэлбэл шилжин нүүдэллэж буй хүн цагаачлалын журам ёсоор тухайн улс оронд нэвтрэх, амьдрах буюу ажиллах шаардлагатай хууль ёсны баримт бичиггүй буюу шаардлагатай зөвшөөрлийг аваагүй байдаг. Гарч явч буй улс орны хувьд энэхүү ёс бус шилжилт хөдөлгөөн нь хүн хүчин төгөлдөр паспорт буюу аяллын баримт бичиггүйгээр олон улсын хилээр гарах буюу гарч явч буй улс орны захиргааны шаардлагыг хангахгүй гэсэн үг.

Ойролцоо утгатай үг: Хууль бус цагаачлал, Нууцаар цагаачлах/ шилжих Эсрэг утгатай үг: энгийн нүүн шилжилт, хууль ёсны цагаачлал/ шилжих хөдөлгөөн

Мөн: Цагаачдыг хууль бусаар хил давуулах харна уу

### Тусгаарлалт

Хүн наймаалагчид ихэнхдээ хяналт буюу албадах үүднээс бусдаас тусгаарладаг. Тусгаарлалт гэдэгт (зөвхөн үүгээр хязгаарлахгүй) аялах баримт бичгийг хураах, хохирогчдыг хэл усаар буюу нийгмээс тусгаарладаг.

Мөн Хяналт, Албадлага, Биеийн байцаалт, Аяллын баримт бичиг зэргийг үзнэ үү

### Хулгайлах

Бие хүн буюу бүлэг хүмүүсийг хууль бусаар хүч хэрэглэн хулгайлах эсвэл хорих. Ихэвчлэн хохирогчийг хулгайлах буву эсвэл гуравдагч талаас эдийн засгийн буюу улс төрийн ашиг хүртэх зорилгоор хулгай хийдэг. Хүн хулгайлах нь тухайн орны эрүүгийн хуулиар шийтгэгддэг ба ийм төрлийн зарим хэргүүдийг олон улсын хуулийн дагуу шийдвэрлэдэг. (тухайлбал, дээрэм)

Мөн: Хүчээр авах, булаах, эсэргүүцэх, Элсүүлэх, Хүч хэрэглэхийг үзнэ үү

### **Цагаач/ нүүн шилжсэн ажилчин**

“Тухайн улс орны үндсэн иргэн биш хүн улс оронд ажиллах гэж байгаа, ажиллах эсвэл ажиллаж байгаа хүн” (1990 оны Цагаач ажилчдын болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, 2-р зүйл)

Дэлгэрэнгүй мэдээллийг [http://www.unhchr.ch/html/menu/b/m\\_mwctic.htm](http://www.unhchr.ch/html/menu/b/m_mwctic.htm)

Мөн: Шилжилт хөдөлгөөнийг үзнэ үү

### **Цагаачлал/нүүн шилжих**

Шилжих хөдөлгөөн, олон улсын хилээр гарах буюу тухайн улс дотор. Энэ бол хүн амын шилжилт бөгөөд тухайн хүний шилжиж буй хугацаа, шалтгаанаас үл хамаарсан хүн амын хөдөлгөөний бүх төрлийг багтаана. Мөн дүрвэгсэд, нүүлгэн шилжүүлсэн хүмүүс болон эдийн засгаас шалтгаалан нүүсэн хүмүүсийг багтаана.

Мөн: Ёс бус шилжилт хөдөлгөөн, Энгийн нүүн шилжилт гэдгийг үзнэ үү

### **Зохион байгуулалттай гэмт хэрэг**

Төвөөс удирдан зохион байгуулдаг, хянадаг өргөн хүрээтэй гэмт хэргийн үйл ажиллагаа

Мөн Цагаачдыг хууль бусаар хил давуулах, ХХГХ гэдгийг үзнэ үү

### **Урьдчилан сэргийлэх**

Болох үйл явдлаас буюу болсон үйл явдлаас сэргийлэх үйл ажиллагаа. Энэ нь ХХГХ-тэй тэмцэх цогц стратегийн нэг хэсэг болно. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах зүйлс багтаж ч хязгаарлагдахгүй. Үүнд: мэдээлэл өгөх ба мэдлэгтэй болгох үйл ажиллагаа, судалгаа, семинар, сургалт, хамтын ажиллагаа болон орон нутгийн, үндэсний хэмжээний, бүсийн болон олон улсын сүлжээ харилцаа багтана.

Мөн: Шийтгэл, Хамгаалалт гэдгийг үзнэ үү

## Шийтгэл

Буруутгагдаж байгаа хүнийг шалгах шүүх үйл ажиллагаа. ХХГХ-тэй тэмцэх цогц стратегийн нэг хэсэг болохын хувьд шийтгэл гэдэгт дараах зүйлс багтас ба хязгаарлагдахгүй. Үүнд: хууль эрх зүй боллогыг сайжруулах, гэмт хэргийн ялыг нэмэгдүүлэх, чадварыг бэхжүүлэх, үндэсний болон үндэстэн дамжсан хамтын ажиллагаа (тухайлбал, ТББ болон хууль хэрэгжүүлэгч байгууллагын хооронд)

Мөн Урьдчилан сэргийлэх, Хамгаалалт гэдгийг үзнэ үү

## Биеэ үнэлэх

Бэлгийн харьцаанд орох, ихэвчлэн гэр бүл буюу найз нөхдөөс бусад хүмүүстэй бэлгийн харьцаанд орж мөнгө буюу бусад эд зүйлсийг төлбөрт нь авах

## Хамгаалалт

Хамгаалалт гэдэгт эрсдэлд орсон хүмүүст эрхийг нь эдлүүлэх, олон улсын конвенциэр тусламж үзүүлэх зэрэг тодорхой бүх арга хэмжээг багтаадаг. Хамгаална гэдэг нь тухайн хүн эрхтэй, бөгөөд тэднээс давуу эрх мэдэл бүхий байгууллага, бүтцууд эрх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх юм. Бие хүмүүсийн хуулийн дагуух эрх болоод тэдний оршин амьдрах хуулийн дагуух эрхийг хамгаална гэсэн үг. ХХГХ-тэй тэмцэх цогц стратегийн нэг хэсэг. Хохирогчийг хамгаална гэдэгт хоргодох байр, эмнэлгийн болоод сэтгэл зүйн тусламж, визийн тусламж үзүүлэх, сайн дураараа эргэн очих, нийгэмших, аюулгүй байдал болоод үндэсний болон үндэстэн дамжсан хамтын ажиллагааг багтас ч үүгээр хязгаарлагдахгүй.

Мөн Урьдчилан сэргийлэх, Шийтгэл гэдгийг үзнэ үү

## Элсүүлэх

ХХГХ-ийн үндсэн ойлголтын нэг. Элсүүлэх үйл ажиллагааг шууд хуурэн мэхлэх, хуурэн мэхлэх болон хүчээр (албадлага) гэж ялгадаг.

Мөн ХХГХ, Тээвэрлэлт, Мөлжлэг гэдгийг үзнэ үү

## Хүч хэрэглэн элсүүлэх

ХХГХ-ийн хохирогчдыг хүч хэрэглэн авч явах

Ойролцоо утгатай Албадлага  
Мөн Албадлага, Хүн хулгайлах гэдгийг үзнэ үү

### **Шууд хууран мэхлэж элсүүлэх**

ХХГХ-ийн хохирогчдыг ажид оруулах, санхүүгийн боломж олгоно  
гэж хууран мэхлэх нь хүн наймаалагчдын бодит зорилго байдаг.

### **Хууран мэхлэж элсүүлэх**

ХХГХ-ийн хохирогчид нь тодорхой ажил эрхэлнэ гэдгээ мэдэж  
байдаг ч нөхцөл байдлыг мэддэгтүй.

### **Энгийн шилжилт хөдөлгөөн**

Хүлээн зөвшөөрөгдсөн, хууль ёсны замаар хийгдэх шилжилт  
хөдөлгөөн.

Ойролцоо утгатай: Хууль ёсны шилжилт хөдөлгөөн, Зааврын дагуу  
хийгдэх шилжилт хөдөлгөөн

Эсрэг утгатай: Ёс бус шилжилт хөдөлгөөн  
Мөн Шилжилт хөдөлгөөн гэдгийг үзнэ үү

### **Эрсдлийн үнэлгээ**

Тухайн нөхцөл байдал, үйл явдалтай холбоотой эрсдэлийг  
тодорхойлж, үнэлгээ хийх үйл явц

### **Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Тухайн нөхцөл байдал, үйл явдалтай холбоотой, хүлээн  
зөвшөөрөгдхүйц түвшний эрсдэлийг бууруулах арга хэмжээг  
нэгтгэсэн төлөвлөгөө

### **Бэлгийн мөлжлөг**

ХХГХ-ийн хувьд бэлгийн мөлжлөг нь олон төрөл байдаг ба биеэ  
үнэлэх, садар самуун, энэ төрлийн бүжиг,екс аялал жуулчлал  
буую хүчээр гэр бүл болох зэрэг болно. Үүний золиос нь эрэгтэй,  
эмэгтэй хүмүүс мөн хүүхдүүд байдаг. Бэлгийн мөлжлөгийг  
Женевийн конвенцууд болон 1993 онд гарсан Эмэгтэйчүүдийн  
хүчирхийллийг таслан зогсоох тунхаг зэрэг олон улсын баримт  
бичгүүдээр хориглосон болно.

Мөн Мөлжлөг гэдгийг үзнэ үү

## Боолчлол

Хүнийг эрх мэдэлдээ байлгах, эзний харьцаагаар харьцах байдал. (1953 оны баримт бичгээр нэмэлт өөрчлөлт оруулсан 1926 оны Боолчлолын эсрэг конвенци, 1-р зүйл) Боолчлол гэдэг нь хэн нэгнийг өөрийн эзэмшилд байлгах, хянах бөгөөд мөн албадлагаар эсвэл хөдөлгөөнийг нь хорих, эznээ солих, орхин явах эрхгүй байхыг хэлдэг. (тухайлбал, уламжлалт боолчлол, албадсан хөдөлмөр, хамжлагат ёс, хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, зан заншлын буюу шашны зорилгоор боолчлох)

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://unhchr.ch/html/menu3/b/f2sc.htm>  
Мөн Өрийн дарамт гэдгийг харна уу

## Хууль бусаар хил давуулагч этгээд

Хэлцлийн дагуу хүмүүсийг хууль бусаар олон улсын хил давуулах үүрэг гүйцэтгэдэг зуучлагч

Мөн Цагаачдыг хууль бусаар хил давуулах гэдгийг үзнэ үү

## Цагаачдыг хууль бусаар хил давуулах

Шууд буюу шууд бусаар санхүүгийн болон бусад материаллаг ашгийн төлөө хүнийг хууль бусаар хил давуулах. Тухайн хүн нь тухайн улсын иргэн буюу байнгын оршин суугч байх албагүй. (НҮБ-ын Цагаачдыг газар, агаар, тэнгисээр хууль бусаар хил давуулахын эсрэг баримт бичиг, 3-р зүйл)

Дэлгэрэнгүй мэдээллийг [http://www.unodc.org/undoc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/undoc/en/crime_cicp_convention.html)

Мөн Ёс бус шилжилт хөдөлгөөн, НҮБ-ын Цагаачдыг газар, агаар, тэнгисээр хууль бусаар хил давуулахын эсрэг баримт бичгийг үзнэ үү

## Хүн наймаалагч

Албадлагаар, хүчээр буюу мөлжлөгийн бусад хэлбэрээр эдийн засгийн буюу бусад байдлаар ашиг олох зорилгоор хүн дамжуулан шилжүүлэх этгээд. Хүн наймаалагч нь тухайн хүнийг мөлжих, мөлжлөгөөс ашиг олох зорилготой байdag.

Мөн ХХГХ-ийг үзнэ үү.

## ХХГХ

Хэн нэгнийг “Айлган сүрдүүлж буюу хүчээр эсвэл албадлага, сүрдүүлэг, айлган, албан тушаалаар айлган сүрдүүлж эсвэл эмзэг байдлыг нь далимдуулах, хэн нэгний эрх ашгийн үүднээс төлбөр авч хяналтанд нь байлгах, мөлжих зорилгоор” элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авахыг хэлнэ. (2000 оны НҮБ-ын ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, хорих, шийтгэх тухай баримт бичиг, 3-р зүйл)

Дэлгэрэнгүй мэдээллийг [http://www.unodc.org/unodc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unodc/en/crime_cicp_convention.html)

Мөн НҮБ-ын ХХГХ-ээс, нэн ялангуяа Эмэгтэйчүүд болон Хүүхдийг урьдчилан сэргийлэх, хорих, шийтгэх тухай баримт бичиг

### Тээвэрлэлт

Тээвэрлэгч бараа бүтээгдэхүүн буюу хүнийг нэг газраас нөгөө рүү шилжүүлэн зөөвөрлөх. ХХГХ-ийн хувьд шилжилт хөдөлгөөн нь олон улсын чанартай (хоёр буюу түүнээс олон улс орон оролцсон) эсвэл тухайн улсын нэг бүсээс нөгөө бүс рүү (дотооддоо хүн наймаалах) шилжсэн байdag. Тээвэрлэлт нь хуулийн дагуу буюу хууль бусаар агаар, газар эсвэл тэнгисээр хийгддэг.

367

Мөн Элсүүлэх, Мөлжлөг, ХХГХ-ийг үзнэ үү

### Аяллын баримт бичиг

Өөр улс руу зорчих, тухайн улсад нэвтрэх зорилгыг тодорхойлсон, хүлээн зөвшөөрөгдсөн бүх төрлийн баримт бичгийг нэрлэх үндсэн томьёолол. Паспорт, виз зэрэг нь аяллын баримт бичиг болж түгээмэл хэрэглэгддэг. Мөн зарим улс орнуудын хувьд биеийн байцаалт болон бусад баримт бичгийг ашигладаг.

Мөн Биеийн байцаалтыг үзнэ үү

### Үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

Зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа болон үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зарим үйл ажиллагаа тухайлбал, мөнгө угаах, авилгал болон мөрдөн байцаалт, шийтгэл ногдуулахад гарах саад бэрхшээл зэрэг. Конвенцийн нэмэлт болгон онцгой анхаарал хандуулах ёстой үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн зарим

нэг төрлийг шийдвэрлэх хоёр баримт бичиг байдаг. (ХХГХ болон цагаачдыг хууль бусаар хил давуулах)

Дэлгэрэнгүй мэдээллийг [http://www.unodc.org/unodc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unodc/en/crime_cicp_convention.html)

Мөн НҮБ-ын ХХГХ-ээс, нэн ялангуяа Эмэгтэйчүүд болон Хүүхдийг урьдчилан сэргийлэх, хорих, шийтгэх тухай баримт бичгийг үзнэ үү

### **Цагаачдыг газар, агаар, тэнгисээр хууль бусаар хил давуулахтай тэмцэх НҮБ-ын баримт бичиг**

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт. Цагаачдыг хууль бусаар хил давуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн өсөн нэмэгдэж байгаа үйл ажиллагааг зохицуулдаг. Энэ нь цагаачдын хувьд маш өндөр эрсдэлтэй байдаг бөгөөд зохион байгуулагчдын хувьд их хэмжээний ашиг өгдөг.

Дэлгэрэнгүй мэдээллийг [http://www.unodc.org/unodc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unodc/en/crime_cicp_convention.html)

Мөн Цагаачдыг хууль бусаар хил давуулах, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц

### **ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын конвенц**

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт. Энэ нь хүмүүс амьдралаа сайжруулах зорилготой байдгийг зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд ашигладаг орчин цагийн боолчлолын асуудлыг зохицуулдаг. Цагаачдын эрхийг хязгаарладаг буюу цагаачдыг албадлагаар мөлжих, эсвэл дарамтлан, хүчээр ажил хийлгэх, ихэвчлэн бэлгийн мөлжлэгийн зорилгоор хүн наймаалах эсвэл аюул ихтэй хөдөлмөр эрхлүүлдэг. Үүнийг зохион байгуулж буй гэмт бүлэглэлүүд ийм төрлийн үйл ажиллагаанаас ихээхэн хэмжээний ашиг олдог.

Дэлгэрэнгүй мэдээллийг

[http://www.unodc.org/unodc/en/crime\\_cicp\\_convention.html](http://www.unodc.org/unodc/en/crime_cicp_convention.html)

Ойролцоо утгатай: Палермогийн баримт бичиг

Мөн ХХГХ, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенци үзнэ үү

## **Хохирогч**

Хүчээр буюу хүн наймаалагчийн дарамтанд байгаа, тодорхой нөхцөл байдалд (осол, гэмт хэрэг зэрэг) хохирсон, гэмтсэн, сэтгэл санаагаар унасан буюу золиослогдсон, дарамтанд, шахалтанд, айдаст автсан, хуурагдсан буюу мэхлэгдсэн хүн

## **ХХГХ-ийн хохирогч**

ХХГХ-ийн хохирогч болсон эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүд. Ойролцоо утгатай Наймаалагдсан хүмүүс

Мөн Хүүхэд, ХХГХ үзнэ үү

## **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд**

“Боолчлолын бүх хэлбэрүүд буюу хүүхдийг наймаалах, өрийн дарамт, золиос болох болон хүчээр хөдөлмөр эрхлүүлэх зэрэг, тухайлбал, зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр ашиглах, оролцуулах, хүүхдийн биеийг үнэлүүлэх зорилгоор худалдан авах, худалдах, садар самоуныг сурталчилсан үйлдвэрлэл эрхлэх буюу садар самоуун зугаа цэнгэлийн үйлчилгээ эрхлэх, ялангуяа олон улсын холбогдох гэрээ хэлцэлд тодорхойлсноор хууль бус үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор хүүхэд худалдан авах, худалдах, хар тамхи үйлдвэрлэх, наймаалах зэрэг боолчлолтой адил хөдөлмөр эрхлүүлэх. Эдгээр үйл ажиллагааны мөн чанар нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон ёс зүйд сөргөөр нөлөөлдөг.” (Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох, хориглох, яаралтай арга хэмжээ авах тухай конвенци, 1999 он, 3-р зүйл)

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.hrw.org/children/child-legal.htm>  
Мөн Хүүхэд, Хүүхдийн хөдөлмөр, Мөлжлөгийг үзнэ үү .

## Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын ХХГХ-тэй тэмцэх ажилтнуудын мөрдлөгө

Бид цагаачдыг бүх арга хэлбэрээр мөлжихийн эсрэг, ялангуяа ХХГХ-ийн хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцдэг. Бид өөрсдийн эрхэмлэн дээдэлдэг зарчим болоод олон улсын жишиг дээр тулгуурлан бид иргэний нийгмийн болоод төр засгийн байгууллагуудын түншүүийн ур чадварыг бэхжүүлж, тогтвортой үр дүнг хангахын тулд үйл ажиллагааны стандартыг тогтоон дараахь зорилгын төлөө ажиллаж байна.

- ХХГХ-ийн хохирогч болсон эмэгтэйчүүд, эрчүүд, охид хөвгүүдийг хамгаалах, нийгэмшүүлэх
- Энэ гэмт хэргийн талаарх мэдээлэл, мэдлэг олгох
- ХХГХ-ийн хохирогчдод шударга үнэнээр хандах.